

НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙГ СУДЛАХ  
ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭН

ДАНДИНЫ  
“ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛЬ”

*(Санскрит, төвд, хятад, англи, монгол бичиг,  
шинэ үсгээр)*

НЭГДҮГЭЭР ДЭВТЭР

“ЖИКОМ ПРЕСС” ХЭВЛЭЛИЙН ГАЗАР  
УЛААНБААТАР. 2021

ДАА 800  
ННА 84  
297

“Монголын уран зохиолын туурвил зүй ба Дандины  
“Зохист аялгууны толь”-ийн эхүүдийн харьцуулсан судалгаа”  
ШуСс 2018/26 суурь судалгааны төслийн хүрээнд бүтээв.

## ДАНДИНЫ “ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛЬ”

(Санскрит, төвд, хятад, англи, монгол бичиг, шинэ үсгээр)

### НЭГДҮГЭЭР ДЭВТЭР

Төслийн удирдагч: **Д.ПҮРЭВЖАВ** Доктор (Ph.D)

Эхүүдийг эмхэтгэж, харьцуулж эрдэм шинжилгээний тайлбар хийсэн:

**Д.СУМЪЯА** Доктор (Ph.D), дэд профессор

**ВАН МАНДУГА** Доктор (Sc.D), профессор

Редактор: **С.БАЙГАЛСАЙХАН** Доктор (Sc.D), профессор

Хэвлэлийн редактор: **Ж.ЕРӨӨЛТ**

Эх бэлтгэсэн: **Д.ГАНБОЛД** Доктор (Ph.D)

Хавтасны загварыг: **Б.БАЯРБААТАР**

ISBN 978-9919-9539-6-6

Цахим хаяг: [hasaa11@yahoo.com](mailto:hasaa11@yahoo.com)  
[gcompress2020@gmail.com](mailto:gcompress2020@gmail.com)

“Жиком пресс” ХХК-д хэвлэв. ©2021  
Утас: 7010-4224, 9908-4224

## ДАНДИНЫ “ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛЬ” НОМЫН ӨМНӨХ ҮГ

Монголчуудын бүтээсэн өв соёл нь нүүдэлчин монголчуудын гэх өвөрмөц онцлог тусгай өнгө төрхтэй атлаа бас дэлхий нийт, хөрш зэргэлдээ улс түмнүүдийн соёл иргэншилтэй харилцаа холбоонд оршиж тэдгээрээс суралцаж, эргээд тэдэндээ нөлөөлсөн тийм шүтэлцээнд оршиж иржээ. Энэ олон талтай, өргөн хөгжиж ирсэн өв соёлын нэг тодорхой жишээ нь Дандины “Зохист аялгууны толь” юм. Энэ бүтээл монголчуудын утга соёлын хүрээнд уламжлаад, улмаар өөрийнх нь утга зохиолын онол болтлоо идээшсэн байдаг.

“Зохист аялгууны толь” бол шүлэглэсэн хэлбэрээр бичигдсэн уран зохиолын онол найруулга зүйн ном. Өрнө дахин Аристотелийн “Туурвил зүй”-г баримталж ирсэн шиг Дорно дахиныхан Дандины “Зохист аялгууны толь”-ийг утга зохиолын туурвилын онолын гол бүтээлээ болгосоор иржээ.

“Зохист аялгууны толь”-ийг VII зуунд эртний Энэтхэгийн Дандин зохиожээ. Уг зохиолын бүрэн орчуулгыг XIII зууны үед Төвдийн их хэлмэрч шонтон Доржжалцан, Энэтхэгийн бандида их зохист аялгууч Лакшмикара нар төвд хэлээр орчуулж, XVIII зуунд Халхын Гэлэгжалцан монгол хэлээр орчуулж Монгол “Данжуур”-т хэвлүүлжээ. Англи хэлний бүрэн орчуулгыг В.Нараяана 1964 онд, хятад хэлний бүрэн орчуулгыг Бээжингийн Төвийн үндэстний их сургуулийн эрдэмтэн Жоо Кан хийж 1989 онд хэвлүүлжээ.

“Зохист аялгууны толь” нь гурван бүлэг, нийт 657 бадаг шүлэг

байна. **I бүлгийн** 105 бадаг шүлэгт уран яруу туурвихын эрдэмд суралцахын ач холбогдол зэрэг утга зохиолын онолын асуудлуудын тухай өгүүлжээ. **II бүлгийн** 365 бадагт зохиол бүтээл туурвихдаа утга санааг хэрхэн оновчтой уран тод дүрслэхийн арга ухааныг үзүүлжээ. Ингэхдээ утгын 35 чимгийн тодорхойлолтыг өгүүлж, ямар аргаар утгын чимгийг үзүүлбэл сая хүний сэтгэлийг хөдөлгөж чадах вэ гэдэг аргыг жишээ шүлгээр үзүүлжээ. **III бүлгийн** 187 бадаг нь дууны чимэг буюу зөв найруулж туурвихын эрдмийг өгүүлжээ. Ингэхдээ зөв уран найруулах эрдмээ утга уянга хэмнэл төгсийг эрхэмлэх “Хос төгөлдөр чимэг”, үг ба утгыг нуух “далдлахуй үгс”-ийн арван зургаан чимэг, зөв найруулгыг алдагдуулж болох “найруулгын арван гэм” гэсэн гурван зүйлээр өгүүлжээ.

Энэ судалгаагаар бид Дандины “Зохист аялгууны толь”-ийн олон зүйл эхүүдийг харьцуулан шинжлээд, санскрит, төвд, хятад, англи, монгол бичиг, шинэ үсгийн гэсэн зургаан эхийг зэрэгцүүлэн хавсаргаж 2 ботиор хэвлэж байна. Энэ ном эрдэм шинжилгээний **Удиртгал, Үндсэн эх** гэсэн хоёр хэсэгтэй.

1. “Монголын орчин үеийн утга зохиолын судлалын хүрээн дэх “Зохист аялгууны толь”-ийн судалгаа” гэсэн эрдэм шинжилгээний **удиртгалд**: Монгол утга зохиолын судлал дахь “Зохист аялгууны толь”-ийн судалгааны тойм, “Зохист аялгууны толь”-ийн бүтэц агуулга, “Зохист аялгууны толь”-ийн санскрит, төвд, хятад, англи, монгол бичиг, шинэ үсгээр буй эхүүдийн тухай, бар хэвлэлүүдийн харьцуулал, ялгаа зөрөө зэргийг өгүүлэв. Энэ нь зургаан зүйл хавсарсан Дандины “Зохист аялгууны толь”-ийн эхийг уншиж үзэж судлах хүмүүст гарын авлага танилцуулга үүдэл болох юм.

2. Дандины “Зохист аялгууны толь”-ийн санскрит, төвд, хятад, англи, монгол, монгол бичиг, шинэ үсгийн эхийг шад мөр татаж бадаглаж, дугаарлаж, шүлэглэсэн эхээ бадаг бадгаар нь зэрэгцүүлж, үгийн ба утгын эрдэм шинжилгээний 1000 орчим зүүлт тайлбар хийсэн **үндсэн эх**.

Дандины “Зохист аялгууны толь”-ийн зургаан зүйл эхийг зэрэгцүүлж харьцуулж бадаглаж, үгийн болон утгын эрдэм шинжилгээний зүүлт тайлбар хийхдээ Гэлэгжалцаны орчуулсан Монгол “Данжуур”-ын монгол бичгийн эх, Төвд “Данжуур”-ын төвд

эх, В.Нараяанагийн англи хэлээр бүрэн орчуулсан Санскрит-Англи (1964) эх, “Дандины “Зохист аялгууны толь” (1972), “Дандины Зохист аялгууны толь” (Ш.Бира, Х.Гаадан, О.Сүхбаатар нарын орчуулга.1982), Ван Мандуга оршил бичиж харгуулан тайлбарласан “Монгол хятад хоёр хэл хавсаргасан Дандины Зохист аялгууны толь”(2000) “Таван зүйлийн үсэг хадмал “Зохист аялгууны толь” (Хамтын бүтээл. Ван Мандуга, Л.Хүрэлбаатар, Д.Сумъяа. 2012), “Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины Зохист аялгууны толь” (2017) гэсэн эхүүд, мөн доктор(Sc.D), профессор Л.Хүрэлбаатарын “Эсэруагийн эгшиг дуун” (1999), Л.Хүрэлбаатарын “Дуун, утгын яруу зохист” (2005), “Судар шастирын билиг” (2002), С.Жамъянгарадын “Цаглахуй санааны найлзуур мод” (2011), “Дандины “Зохист аялгууны толь”-ийн гол нэр утгын тайлбар” (Хамтын бүтээл. 2017 болон холбогдох судалгааны бүтээлүүдийг эх эш хэрэглэгдэхүүн болголоо.

Боловсрол Соёл Шинжлэх ухаан Спортын яамны ШуСс<sup>1</sup>-2018/26 тоот “Монголын уран зохиолын туурвил зүй ба Дандины “Зохист аялгууны толь”-ийн эхүүдийн харьцуулсан” суурь судалгааг гүйцэтгэгч манай багийн хамт олон болон Монгол улсын ШУА-ийн гадаад гишүүн, БНХАУ-ын Бээжингийн Төвийн Үндэстний их сургуулийн профессор Ван Мандуга багшийн хичээнгүй судалгаа, хөдөлмөр зүтгэл, цаг зав, хөдөлмөр зүтгэлээ зориулсаны үр дүнд Дандины “Зохист аялгууны толь”-ийн олон зүйл эхүүдийг эрж хайж олж цуглуулж, санскрит, төвд, англи, хятад, монгол бичиг, шинэ үсгийн эхүүдийг харьцуулж тулгаж, хянаж нягтлаж, хөрвүүлж, харгуулан дугаарлаж, ялгаа зөрөөг тодруулж, хэвлэлийн эх бэлтгэхэд өөр өөр хэв тиг загвартай үсгүүд танигдахгүй ахин дахин олонтаа бичиж хувиргаж шүүж, тулгаж нэгтгэж энэхүү зургаан өөр хэв үсэгтэй эхийг нэгэн номд багтаан баринтаглаж уншигч олон, судалгааны ертөнцөд хүргэв.

Олон зүйл эхийг хянаж нягтлахад тусалсан НСИСОУХүрээлэнгийн захирал агсан доктор Д.Пүрэвжав, профессор Ван Мандуга, доктор Цай Юун, Гандантэгчилэн хийдийн лам гэвш Сайнхүүгийн Болдоо, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан докторант Ж.Ерөөлт, Б.Лхагважав, Г.Мөнхзаяа нартаа талархал илэрхийлж байна. Мөн олон зүйлийн үсэг бүхий эхүүдийг цаг заваа зориулж, сэтгэл зүтгэлээ гарган нэгтгэж хэвлэлийн эхийг бэлтгэсэн Соёл,

<sup>1</sup> Шинжлэх ухааны Суурь судалгаа

Шинжлэх ухаан, судлалын хөгжил Үндэсний төвийн тэргүүн, доктор Д.Ганболд танд ихэд баярлан талархаж байна. Цаашдаа ч утга уянга урлан туурвилын эрдэм болсон эл бүтээлийг хүсэн хүлээгч түмэнд нь түгээн дэлгэрүүлж байгаарай.

Шинэ хуучны уламжлал шинэчлэлд шимтэгч оюун билиг гиймэл зохион туурвигч, уншигч бичигч, эрдэмтэн судлаач, олон нийт Та бүхэндээ эрдэмт багш нар, эрхэм судлаачдынхаа ном бүтээлүүдийг нэгжин үзэж нэгтгэн найруулсан зургаан зүйл “Зохист аялгууны толь”-ийг хүргэж байна. Эндүү алдаа цалгай болсон аваас ариутган шүүж болгоогоорой.

Ном эрдмийн цагаан буян мөнхөд арвидан дэлгэрч байг ээ.

*Доктор, дэд профессор  
Доржпаламын Сумъяа*

*2021.10.05*

## **PREFACE OF THE BOOK “THE MIRROR OF POETRY”**

Although the cultural heritage created by the Mongols has a unique character of nomadic Mongols, it has also been in contact with the civilizations of the world and neighboring nations, learning from them and influencing them in turn. One clear example of this multifaceted and thriving heritage is Dandin’s “The Mirror of Poetry” (Dandin’s Kavyadarsha). This work was passed down through the Mongolian culture and became its own literary theory.

“The Mirror of Poetry” is a literary, methodological, and theoretical book written in the form of poems.

As in the Western world, they represent Aristotle’s Poetry, so in the East, we accept Dandin’s “The Mirror of Poetry” as the main theoretical fundament of literary works.

This work “The Mirror of Poetry” was written by the ancient Indian Dandin in the 7th century.

The complete translation of the text was translated into Tibetan in the 13th century by the great Tibetan translator Shanton Dorjjaltsan and the great Indian dialectist Lakshmikara, and in the 18th century by the Khalkha Gelegjaltsan into Mongolian and published in the Mongolian Danjuur.

The full English translation was made by B.Narayana in 1964, and the full Chinese translation was published in 1989 by Joo Kang, a scholar

at Peking Central National University.

In 105 poems of the first chapter, it is said about lyric poetry and the importance of the meanings of writing poetry, about subtlety and structure, about the nuances of compositions, and about ten knowledge in poems and other methodological aspects of poetry.

The 365 poems of the second chapter speak of 35 characters and entities for artistic expression, present specific examples of how the inner world of the human soul is revealed.

The 187 poems of the third chapter talk about the method of composing the song and their correct method of writing. At the same time, it is said about three important aspects in order to compose subtly and lyrically, firstly this is the full expression of the so-called “Double nuance”, secondly, this is about the hidden meaning of the words of sixteen subtleties, the so-called “hidden words”, in the third on the precautions of possible errors in the compositions, the so-called “thirteen errors in the compositions.”

In this study, we compare and contrast the many original sources of Dandin’s “The Mirror of Poetry” in Sanskrit, Tibetan, Chinese, English, Mongolian, and Mongolian script, and publish them in two volumes. This book has two parts: Introduction and Main source.

The study of Dandin’s “The Mirror of Poetry” in the field of contemporary Mongolian literary criticism includes an overview of the “The Mirror of Poetry” in Mongolian literary criticism, the structure and content of the “The Mirror of Poetry” Sanskrit, Tibetan, Chinese, English and Mongolian original scripts from “The Mirror of Poetry” sources in Mongolian language, as well as comparisons and differences between versions of the bar. This will be the subject of a handbook for those who read and study the original fonts of “The Mirror of Poetry”.

Dandin’s “The Mirror of Poetry” contains six original sources in Sanskrit, Tibetan, Chinese, English, Mongolian, and modern Mongolian scripts. All the original sources of the texts were collected, numbered and compared with the original verses and commented on about 1000 explanatory notes.

The six original articles are compared in parallel, and their scientific



notes and footnotes are based on the study of scholarly works such as Dandin's "The Mirror of Poetry" (1972), "The Mirror of Poetry" (1982) "Comparative Study of the Mirror of Poetry in Mongolian and Chinese" (2000) by Professor Wang Mandugi, " Subtitles for five items of the Mirror of Poetry" (2012) by Professor L.Khurelbaatar, D.Sumyaa, "The Mirror of Poetry in Tibetan and Mongolian Daanjuur" (2017) "Song Eserua" by Professor L.Hurelbaatar (1999), "The Song and the Meaning of Clarity" by Professor L.Hurelbaatar (2005), "The Wisdom Chronicle of the Sutra" (2002), "Shooting Tree of the Idea of Time" (2011), Zhamyangaarava, "Explaining the main meaning of the Mirror of Poetry" by Dandin (joint work, 2017).

Our team implemented the fundamental research project (ShuSs-2018/26) of the Ministry of Education, Science and Culture with great assistance and effort of the Peking Central National University Professor Wang Manduga, who is a foreign member of the Mongolian Academy of Sciences, As a result of his efforts, he searched and collected many sources from Dandin's "The Mirror of Poetry", compared, reviewed, translated, numbered, and clarified Sanskrit, Tibetan, English, Chinese, and Mongolian scripts. During the preparation of the text, the letters of different styles were unrecognizable, and many times they were rewritten, filtered, and compiled.

We would like to thank Dr.D.Purevjav, former Director of the Institute, Professor Van Manduga, Dr.Tsai Yun, Gandan Tegchilen Monastery Gevshe Boldoo Sainkhuu, and doctoral candidates J.Eruult, B.Lkhagvajav, and G.Munkhzaya. I would also like to thank Dr. D.Ganbold, Head of the National Center for the Development of Culture, Science and Research, for his time and dedication to compiling the originals. In the future, please spread this masterpiece of lyric art to the people who are waiting for it.

We would like to present to you, the "The Mirror of Poetry" a collection of books and works of our scholars, teachers, writers, and the public, who are immersed in the new and old traditions and innovations.

May wisdom and knowledge flourish forever.

***Dorjpalamyn Sumiya,***  
***Doctor and Associate Professor***

2021.10.05

## ПРЕДИСЛОВИЕ КНИГИ “ЛИРИЧЕСКОЕ ЗЕРКАЛО”

Культурное наследие, созданное монголами, имеет уникальный характер кочевых монголов, оно также находится в контакте с цивилизациями мира и соседних народов, учится у них и, в свою очередь, влияет на них. Ярким примером этого многогранного и процветающего наследия является “Лирическое зеркало” Дандина (Кавъяадарша Дандина). Это произведение прошло через монгольскую культуру и стало собственной литературной теорией.

“Лирическое зеркало” является литературно-методической и теоритической книгой написанной в форме стихотворений.

“The Mirror of Poetry” is a literary, methodological and theoretical book written in the form of poems.

Как на Западе представляют “Поэзию” Аристотеля так и на Востоке принимают “Лирическое зеркало” Дандина, как главное теоритическое произведение литературных сочинений.

А это произведение “Лирическое зеркало” было написано как раз древно-индийским Дандином в VII веке. This work “The Mirror of Poetry” was written by the ancient Indian Dandin in the 7th century.

Полный перевод текста был переведен на тибетский язык в 13 веке великим тибетским переводчиком и мыслителем шантоном Доржалцаном и великим индийским диалектистом и поэтом Лакшмикарой, а в 18 веке оно переведено халха-монголом

Гелегжалцаном на монгольский язык и опубликован на монгольском Данжууре. Полный английский перевод был сделан В. Нараяной в 1964 году, а полный китайский перевод был опубликован в 1989 году Джу Кангом, ученым из Центрального национального университета Пекина.

Произведение “Лирическое зеркало” в общем состоит из 657 куплет-стихотворений и трех глав. В 105 стихотворениях первой главы сказано о лирической поэзии и о важности значений сочинения поэзии, о тонкости и структуре, о нюансах сочинений и о десяти знаниях в стихотворений и о других методических аспектах поэзии.

В 365 стихотворениях второй главы говорится о 35 характерах и сущностях для художественного выражения, представляет конкретные примеры каким способом открывается внутренний мир человеческой души. В 187 стихотворениях третьей главы сказано о методике сочинений песни и их правильного метода написаний.

При этом, сказано о трёх важных аспектах, чтобы сочинять тонко и лирически, во первых это и есть полное выражение так называемой “Двойной нюанс”, во вторых это и есть о скрытом смысле слов шестнадцати тонкостей, так называемый “скрытые слова”, в третьих о предосторожностей возможных ошибок в сочинений, так называемый “тринадцать ошибок сочинений”.

В этом исследовании мы сравниваем и сопоставляем многие оригинальные источники “Лирического зеркала” Дандина из санскрита, тибетского, китайского, английского, монгольского и монгольского алфавита и публикуем их в двух томах. Эта книга состоит из двух частей: Введение и Основной источник.

В ведении изучения “Лирического зеркала” Дандина в области современного монгольского литературоведения включено обзор “Лирического зеркала” в монгольском литературоведении, структура и содержание “Лирического зеркала”, санскритские, тибетские, китайские, английские и монгольские оригинальные шрифты “Лирического зеркала”, а также сравнения и различия между версиями бара. Это будет предметом справочника для тех, кто читает и изучает оригинальные шрифты “Лирического зеркала”.

“Лирическое зеркало” Дандина содержит шесть оригинальных источников на санскритских, тибетских, китайских, английских, монгольских и современных монгольских шрифтах. Все оригинальные источники текстов были собраны, пронумерованы и сравнены с исходными стихами и прокомментировано около 1000 объяснительных заметок.

Шесть оригинальных статей сравниваются параллельно, и их научные заметки основываются в изучении научных произведений таких как, “Лирическое зеркало” Дандина (1972 г.), “Лирическое зеркало” (1982 г.) “Сравнительное изучение Лирического зеркала на монгольском и китайском языках” (2000 г.) профессора Ван Мандуги, “Субтитры для пяти предметов Лирического зеркала” (2012 г.) профессора Л. Хурелбаатара, Д. Сумъяя, “Лирическое зеркало в тибетском и монгольском Даанжууре” (2017г.) “Песнь Эсеруа” профессора Л. Хурелбаатара (1999 г.), “Песня и смысл ясности” профессора Л. Хурелбаатара (2005 г.), “Мудрость хроники Сутры” (2002 г.), “Съёмочное дерево идеи времени” (2011 г.) Жамьянгарава, “Разъяснение основного смысла Лирического зеркала” Дандина (совместная работа, 2017 г.).

Наша команда реализовала фундаментальный исследовательский проект (ШуСс-2018/26) Министерства образования, науки и культуры при большом содействии и усилии профессора Пекинского центрального национального университета Ван Мандуга, который является иностранным членом Академии наук Монголии. В результате своих усилий он провел поиск и собрал множество источников из “Лирического зеркала” Дандина, сравнил, проанализировал, перевел, пронумеровал и разъяснил санскритские, тибетские, английские, китайские и монгольские шрифты. Во время подготовки текста буквы разных стилей были неузнаваемыми, и много раз их переписывали и фильтровали.

Мы хотели бы поблагодарить доктора Д. Пуревжава, бывшего директора Института, профессора Ван Мандугу, доктора Цай Юна, гевша Болда Сайнхуизмонастыря Гандан Тегчилена, а также докторантов Еруулта, Б.Лхагваджава и Г. Мунхзая. Я также хотела бы поблагодарить доктора Д.Ганболда, руководителя Национального центра развития культуры, науки и исследования, за его приверженность в составлении

оригиналов. В будущем распространяйте этот шедевр лирического искусства среди людей, которые его ждут. Мы хотели бы представить вам “Лирическое зеркало”, который представляет собой сборник книг и работ наших ученых, учителей, исследователей и широкой общественности.

Пусть вечно процветают мудрость и знание

*Доктор и доцент  
Доржпаламын Сумъяа*

*2021.10.05*

## 《檀丁〈诗镜论〉》前言

蒙古人所创造的文化遗产，既有游牧蒙古人的独特风格，又有与国际社会，周边国家民众的人文联系，既有向他们学习借鉴的一面，又有影响促进他们的另一面，具有那种相互依存、相互交往影响的关系。这种多层面，共同发展而来的文化遗产中檀丁所著《诗镜论》是一个典型例子。此部著作在蒙古文学领域广泛传播和产生影响，并逐步融合到蒙古文学理论当中。

《诗镜论》是一部以诗歌体写成的文学理论著作。像西方人珍惜亚里士多德《诗学》著作一样，东方人将檀丁《诗镜论》一直作为文学理论的主要著作加以尊崇。

《诗镜论》于公元7世纪由古印度诗学家檀丁用梵文撰写。原著于13世纪由西藏大译师匈敦·多吉坚赞和印度班智达诗学家拉卡弥伽罗二人译成藏文。18世纪由喀尔喀固什葛力格扎拉森译为蒙古文，收录蒙文《丹珠尔》第105函出版。英文全译本由W·那日亚纳1964年出版，汉文全译本由北京中央民族大学学者赵康翻译、于1989年出版。

《诗镜论》共分三章，有657首诗。第1章有105首诗，主要论述学习文学与修辞学的重要性及其意义等文学理论问题。第2章有365首诗，主要阐释35种意义修饰，尽力回答用什么样的方式表达意义修饰才能够让人感动，把“修饰”一词解释为“将诗歌变得更加优美的技巧便是修饰”。可见，修饰是指能让诗歌变为更加优美的那种技巧。作者对35种意义修饰做了详细分类并逐一用例诗加以阐释。第3章有187首诗，分3个部分论述语音修饰，16种隐语修饰和10种诗病。语音修饰注重语句的重复（即重叠修饰），分为难作体和易作体两大类。隐语是指以相类似的隐语和异名来表达实物本意的一种修饰方法。文中列举“16种隐语修饰”，简单介绍“14种拙劣隐语修饰”。最后列举了在创作中常见的十种诗病，并指出解决办法。

基于上述分析理解和学术观点，我们对檀丁《诗镜论》的多语种版本进行认真对

比、校勘、编辑成两卷本梵、藏、汉、英、蒙、西里尔文等六种文《檀丁〈诗镜论〉》。这套书内容分两部分，即学术导论和六体合璧《诗镜论》。

1. 学术导论“蒙古现代文学研究领域中的《诗镜论》研究”，分别论述以下三个问题：一是蒙古文学研究中《诗镜论》研究概况，二是《诗镜论》的框架结构及内容，三是《诗镜论》梵，藏，汉，英，蒙，西里尔文等诸版本比较和相互差异等。导论部分可谓对阅读和研究该书的入门手册或介绍性引文。

2. 六体合璧版本将檀丁《诗镜论》的梵文原文、藏译文、汉译文、英译文、蒙译文、西里尔译文等六种文字的不同版本按其诗段诗行逐一进行认真对照、编号，并附近1000条词义释难和学术注释。在对照校勘时，我们分别参考和引用了蒙文《丹珠尔》第205函中葛力格扎拉森蒙译《诗镜论》（1847年）；藏文《丹珠尔》中《诗镜论》文本；W·那日纳亚的梵英版《诗镜论》（1964年）；B.仁亲作序，H.嘎丹写绪论的《檀丁〈诗镜论〉》（1972年）；X.毕拉，H.嘎丹，O.苏和巴特尔新译注释《檀丁〈诗镜论〉》（1982年）；王满特嘎编注《蒙汉两文合璧檀丁〈诗镜论〉》（2000年）；王满特嘎、L.胡日勒巴特尔、D.苏米娅校勘编注《五体合璧〈诗镜论〉》（2012年）；《藏蒙文〈丹珠尔〉中檀丁〈诗镜论〉》（2017年）等文献图书。同时也参照了博士（Sc·D）、教授L.胡日勒巴特尔著《妙音欢歌》（1999年）、《经书智慧》（2002年），《音与义之优雅和谐》（2005年）；S·嘉米扬嘎日布著《仪心幼嫩小树》（2011年），《檀丁〈诗镜论〉主要名词与意义注释》（合著、2017年）等学术著作以及相关专家的研究成果。

教育文化科学体育部的科学基础研究项目-2018/26号项目《蒙古文学写作学与檀丁〈诗镜论〉版本对比基础研究》课题组与蒙古国科学院外籍院士，中华人民共和国北京中央民族大学教授王满特嘎精诚合作，付出大量时间、精力和辛勤劳动，圆满完成了课题项目。经过反反复复、认认真真进行统一排序、对照校勘、正误补漏、录入排版等工作，最终付诸出版，呈送给广大读者与专家学者手中。

在编撰这部学术著作的过程中得到原游牧文明研究国际院院长D·普日布扎布博士，中华人民共和国中央民族大学教授王满特嘎博士、中央民族大学博士生彩云、甘丹德格其楞寺格西喇嘛赛音夫的宝力道、语言文学研究所科研人员博士生J·叶若乐图、B·拉格巴扎布、G.孟和扎雅等同志的鼎力相助，在此一并致谢。再有文化科学研究发展中心主任D·钢宝力德博士为出版这部著作付出了大量时间与精力，倾注了许多心血，在此也表示由衷的感谢。并希望为时刻期待精神食粮的广大读者提供更多优质的文学艺术精品。

今天特向广大乐于新旧革新的智者、读者、作家、学者们奉献这部历代文学大师、专家学者、大译师们智慧的结晶——《檀丁〈诗镜论〉》（梵，藏，汉、英，蒙、西里尔文六体合璧）文献图书。因学识水平有限，疏漏与谬误在所难免，还望各位专家不吝赐教，多多批评指正，以便日后进一步修改完善。

善愿经书智慧福泽具足，且永远兴盛！

博士、副教授道尔吉帕拉木·苏米娅

2021年10月05日

（王满特嘎汉译）











## МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН УРАН ЗОХИОЛЫН СУДАЛГААН ДАХЬ ДАНДИНЫ “ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛЬ”-ИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

**Зохист аялгуу** (ca: kāvyā, тө: snyan ngag) гэдэг нь Буддын арван их ухааны бага таван ухааны орны нэг. Зохист аялгууг мэдвээс үгсийн чимэгт үл мунхармуй хэмээн олон судар, түүний тайлбар сэлтэд өгүүлсээр иржээ. Энэ нь зөвхөн шүлэг зохиолго төдий биш, уран яруугаар найруулахын дээд эрхэм, урлаг гоо зүйн хам цогц сургаал, уран зохиолыг туурвин бичих тогтолцоотой онол, учир зүйн гаргалга шалтгаанаар давхар сэтгэх гүн ухаан юм. Өөрөөр хэлбэл, алив зохиол бүтээлийг утга, уянга, урлал төгс хэрхэн яаж бүтээх тухай онол туурвилын мэдлэг ухаан юм.

“Зохист аялгууны толь”-ийн судалгаа нь Монголын утга зохиол яруу найргийн онолын түүхийг бичих, өнөөгийн монгол яруу найргийн уламжлал холбоо, бүтээлч шинэчлэлийг тодруулах, бүр нарийсган авч үзвэл уран сайхны дүр бүтээх арга хэрэгслийн түүхэн хувьсал хөгжил, түүний нийгэм, гоо зүйн үүрэг зорилго, уран сайхны эрэл нээлтийг шүүн үзэх судалгааны зорилго чиглэлтэй бүрэн нийцсэн, Монголын уран зохиол судлалын чухал зангилаа асуудлын нэгэн юм” (Хүрэлбаатар, 1999. т.33).

**“Зохист аялгууны толь”** бол шүлэглэсэн хэлбэрээр бичигдсэн уран зохиолын онол найруулга зүйн ном. Өөрөөр хэлбэл, Дандины зохиосон “Зохист аялгууны толь” нь хүний оюун бодол, дотоод сэтгэлийн мөн чанарыг түүх шасдир, төр ёс, байгаль орчин, амьдрал аж төрөхүй,


шашин шүтлэг, зан заншлын өнгө хэлбэр дээр хэрхэн шүтэлцүүлэн уяж холбож уран яруугаар дүрсэлж хүн төрөлхтний мөн чанарыг илэрхийлсэн уран сайхны зохиол бүтээл туурвиж болохыг үзүүлсэн онол арга зүй үлгэрчлэл болсон ном. Өрнө дахинд Аристотелийн “Туурвил зүй”-г барьж ирсэн шиг Дорно дахиныхан Дандины “Зохист аялгууны толь”-ийг утга зохиолын туурвилын онолын гол бүтээлээ болгон барьж иржээ. “Дуун утгын яруу зохист аялгуу нь гурван ертөнцийг мөнхөд гэрэлтүүлэн гийгүүлдэг” (ДЗАТ. 1982. т.12) эрдэм тустай бүтээл учир “Зохист аялгууны толь” түүний судалгаа нь Дорно дахинд тасралтгүй хөгжиж иржээ.

Дандины “Зохист аялгууны толь” (ca: kāvyādarśa, тө: snyan ngag me long) нь уран яруу дүрсэлж, найруулж бичиж туурвихын эрдэм онолын ном учир Энэтхэг, Төвд, Монгол, Хятад, Балба зэрэг Дорно дахины олон улс орны соёлын хүрээнд өргөн уламжлан тархаж, эдгээр улс орны яруу найргийн онолын сэтгэлгээнд хүчтэй нөлөө үзүүлжээ.

## **НЭГ. МОНГОЛ УТГА ЗОХИОЛЫН СУДЛАЛ ДАХЬ “ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛЬ”-ИЙН СУДАЛГАА**

### **Монголын эртний уран зохиол дахь “Зохист аялгууны толь”-ийн судалгааны тойм**

XVII-XX зууны эх болтол Монголын олон эрдэмтэн мэргэд “Зохист аялгууны толь”-ийг сурч судлаж, түүнд утгын ба үгийн тайлбар хийж, жишээ шүлэг зохиож Монгол яруу найргийн онолын сэтгэлгээнд үнэтэй өвийг үлдээжээ. Тухайлбал, Халхын Зая бандид Лувсанпэрэнлэй\*, Сүмбэ хамба Ишбалжир, Цахар гэвш Лувсанчүлтэм, Алшаа Агваандандар лхаарамба, Равжамба Агваантүвдэн, Ханчин хамба Жамъянгарав нар “Зохист аялгууны толь”-д бүхэлд нь тайлбар хийсэн ба мөн олон эрдэмтэн мэргэд аль нэг бүлэг хэсэгт тайлбар хийжээ. Ер нь Монголын эрдэмтэй лам нар, Халхын гүүш Гэлэгжалцан, бичээч цорж Агваандорж, хамба номун Агваанхайдав, Зава Дамдин, Лувсандаш, Ишсамбуу зэрэг мэргэдийн туурвисан уран зохиолын онолд холбогдох зохиол бүтээлүүд, зохист аялгуу судлаачдын бичсэн тайлбар зохиол, жишээ шүлэг, онол шүүмжлэл бол Монгол уран зохиолын онол шүүмжлэлийн судлалын эх хэрэглэхүүн, үнэт өв юм.



Халхын гүүш **Гэлэгжалцан** (XVIII зуун) эртний Энэтхэгийн яруу найргийн онол, эвсэн найруулахын арга ухааны ном болох Дандины “Зохист аялгууны толь”-ийг анхлан Монгол хэлнээ орчуулж Монгол “Данжуур”-ын 205-р ботид хэвлүүлжээ (Цэрэнсодном, 1987. т.318). Монгол “Данжуур”-ын энэхүү Гэлэгжалцаны орчуулга нь төвд эхийг барьж үгчлэн хийсэн орчуулга байдаг. Гэхдээ энэ орчуулга нь “Зохист аялгууны толь”-ийг монгол хэлээр хэвлэж нийтэд хүргэж дараа үедээ уламжлан үлдээсэн ач холбогдолтой юм. Гэлэгжалцаны намтар түүх тун бага уламжлагдан ирсэн тул намтар бүтээл нь нэлээн бүдэг. Гэвч тэрээр Дандины “Зохист аялгууны толь” гэх зохиолыг орчуулснаас гадна, Сарважина Раднагаражантын зохиосон “Холбон найруулах эрдмээс гарахын орон” судрыг тайлбарын хамт монголчилжээ.

Монголын төвд хэлт утга зохиолыг үндэслэгчийн нэг Зая бандида **Лувсанпэрэнлэй**(1642-1715) нь уран зохиолын онол, яруу найргийн эрдэмд шимтэн суралцаж утгын чимгийн адилтгал туурвиж Төвд, Монголын эрдэмтдийн талархлыг хүлээж байжээ. Лувсанпэрэнлэй нь Халхчуудын дотроос хамгийн түрүүнд “Зохист аялгууны толь”-ийг судалсан хүн. Тэрбээр “Зохист аялгууны толь”-ийн утгын 35 чимэгт жишээ зохиожээ (Алтангэрэл, 1972. т.43). Түүний 1670 онд зохиосон “Утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүй урнаа Эсэруагийн хүүгийн баяссан эгшиг” хэмээх зохиол нь “Зохист аялгууны толь”-ийн II бүлэг болох Утгын 35 чимгийн ялгал бүрд зохицуулан жишээ шүлэг

зохиох аргаар бичсэн нийт 258 бадаг шүлгээс бүрдэж байна (МУЗТ, 1976. т.607). Энэ бүтээлдээ зохист аялгууны анхан чимэг “Өвөрчлөнг өгүүлэхүй” чимгээр Бурхан багшийг, Үлгэрийн чимэг буюу адилтгалаар Янжинлхамыг, Дандин нарыг голлон магтжээ.

Дээд Монголын буюу Хөх нуурын сүмбэ хамба *Ишбалжир* (1704-1788) нь “Зохист аялгууны толь”-ийн ихэнх чимэгт жишээ тайлбар бичсэн хоёр зохиол бичжээ. Эхнийх нь “Үгийн чимгийг өчүүхэн хураасан зохист аялгуунд орох үүд” (tsig rg- yan nyung dus snyan ngag `jug sgo) (1735) номыг зохиогоод эцэст нь “Зохист аялгууны толь”-ийн дотор гардаг ёгт нэрийн тайлбарыг хавсаргажээ. Энэ номын зорилго нь шинэ сурах хүмүүсийн тусын тулд Дандины “Зохист аялгууны толь”-ийн тайлбар, жишээг зохиожээ. Мөн “Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн үлгэр өгүүлэхүй жишээ одны үзэсгэлэн эрхсэл ба нэрийн ил өгүүлэхүй товч хураангуй чандмань унжлага” хэмээх зохиолдоо “Зохист аялгууны толь”-ийн гурван бүлгийн чимгүүдийн ялгалд жишээ бичиж тайлбарлахдаа зохист аялгууны амь, бие, чимэг гурваар үзүүлж бас яруу найргийн гэм арилгах сэдвийн хамт бүгд дөрвөн зүйлийг гол агуулга болгон өгүүлжээ (МУЗТ, 1976. т.612). Зохист аялгууны амь гэдэг нь эрт урьдын амаар дамжсан домог яриа, ахуй цагийн өөрийн чанар, есөн дүр, дөрвөн аймаг тэргүүтнийг өгүүлэгдэхүүнд үзүүлснийг заана. Зохист аялгууны өгүүлэгдэхүүний аль нэг утгыг үзүүлэгч нэр, үг, үсэг гурвын эзэн чанартын өгүүлэх аялгуу нь хэл бөгөөд үүнд шүлэглэсэн, үргэлжилсэн, тэр хоёрыг хавсарсан зэрэг гурав байгааг зохист аялгууны бие гэнэ гэжээ. Бас зохист аялгууны чимэг гэдэг нь өгүүлэгдэхүүн амьтай өгүүлэхүүний сайхан бие түүнийг үзэсгэлэн бөгөөд яруу сонсголт болгогч дуун утгын сайхан дүр байдал бүтсэн байгаа зүйлсийг хэлнэ гэж үзээд жишээ зохиохдоо Энэтхэгийн Өмнөдийн ба Дорнодын гэсэн хоёр чиглэлийн эрдэмтний тус тус ёсны нийт бусын чимгүүдийн жишээ, тэр хоёр чиглэлийнхний нийтэд таалдаг чимгүүдийн жишээг утгын чимэг, дуун чимэг, далд үгийн чимгээр авч үзүүлжээ. Ингэхдээ утгын чимгийн жишээ нь утга өгүүлэх ёсыг үзэсгэлэнжүүлэх, дуун чимгийн жишээ нь авиа буюу үсгийн байгуулалтыг үзэсгэлэнжүүлэх, далд үгийн чимгийн жишээ нь утгыг ухахад бэрх болгон нууж үзэсгэлэнжүүлэх явдал юм гэж бичсэн байна. Тэр “Үгсийн чимгийн товч, зохист аялгуунд орох үүд”(1777 он) гэдэг зохиолдоо: “Хэтэрхий эрдмийг эрхшээсэн мэргэд эрдэмтдээс эхлэн төгс хувьт залуу оюутныг хүртэлх бүхний



сэтгэлийн батыг булаагч “Зохист аялгууны толь”-оос энд утгын гучин таван чимэг, дуун чимэг тойм төдийхөнд бадаг бүрд нэг буюу хоёр үлгэрлэхүйг найруулан энэ яруу аялгуунд бишрэн сонирхогч шинэхэн оюутны орох хаалга болгон зохиосон бөлгөө” гэсэн бөгөөд зохиолдоо утгын гучин таван чимгийн тус бүрийн бэлгэ чанарыг цөөн үгээр тодорхойлж тохирох жишээг туурвин бичжээ(Ван Мандуга. 2017. т.57-58).

Цахар гэвш *Лувсанцүлтэм*<sup>1</sup> (1740-1810) нь “Зохист аялгууны толь”-оос “Дууны чимгийн тийн агуулал”, “Утгын чимгийн тийн агуулал” хэмээх зохиол бичсэн ба бусад зохиолдоо Дандины “Зохист аялгууны толь”-ийн онолыг бас хэрэглэсэн байдаг. “Утгын чимгийн тийн агуулал оршвой”, “Дуун чимгийн тийн агуулал оршвой” гэдэг хоёр зохиол бол Дандины “Зохист аялгууны толь”-ийн хоёр ба гуравдугаар бүлэгт хийсэн нарийн тодорхой тайлбар болно. “Утгын чимгийн тийн агуулал оршвой”-доо Утгын гучин таван чимгийг түүний бэлгэ шинж төрөл зүйлээр нь тус тус тоочин салгаж, заримд нь жишээ зохиож тайлбарлажээ. Энэ явцдаа яруу найрагт багаар ихийг үзүүлэх, хэсэг талаар бүхэл нийтийг харуулах онцлог чадавхи, ахуй амьдралыг дүр дүрслэлээр харуулж, авсаархан үгсээр үлэмж утгыг багтаах, санаа ахуйг бүтээх, холбон бодолт хийж уран санаа хэрэглэх, амьдралд байсан буюу байж болох зүйлийг бичих зэрэг утга зохиолын онолд холбогдох асуудлын тухай үзэл ойлголтоо дурджээ. “Дууны чимгийн тийн агуулал оршвой” зохиолдоо дууны чимгийг дотор нь Хос төгөлдөр чимгийн тийн ялгал, Үйлдэх бэрх бусад ялгал, Эгшиг магадлахуй ялгал гэх гурван үндсэн сэдэв болгож, түүндээ товч жишээ тайлбар хийсэн байна. “Утгын чимгийн тийн агуулал оршвой” зохиолдоо V далай ламын “Зохист аялгууны толийн бэрхийн тайлбар Эгшигтийг баясгах эгшиг дуу” хэмээх зохиолыг гол эх болгож бусад тайлбар эхтэй харьцуулан үзэж “Зохист аялгууны толь”-ийн утгын 35 чимгийг утгын талаар маш товч ялган дурдсан байна. Мөн “Богд эрдэнэ(жэ рин бо чэ)-ийг магтсан Самандбадраа хүрдэн<sup>2</sup> сайн амгалан бүхэн үүсэх нэрт оршвой” (Алтангэрэл, 1967. т.65).

Энэхүү самандбадраагийн хүрдний голд –rje, дөрвөн өнцөгт нь –blo, blo-гийн хоёр хажуу бүхэнд –bzang гэсэн үг байна. Энэ нь бүгд 13 үг байх ба 13 удаа Зонховыг дуудан магтаж байна. Үүнд: айлдал

<sup>1</sup> Судлаачид Лувсанцүлтэм, Лувсанцүлтим, Лувсанчүлтим гэх зэргээр бичиж үлдээснийг зохиогчийн бичсэнээр оруулав.

<sup>2</sup> Самандбадраа – хотолд сайн гэсэн утгатай санскрит үг


хэтэрхий болсныг сайшаасан “mkhyen” гэсэн үг 12, маш сайшаал “rab” гэсэн үг 20, дээд сайшаал “mchog” гэсэн үг 4 байна. Ийн 36 удаа сайшаан магтаж өгүүлээд урьдах 13-тай хамтад 49 удаа сайшаан магтаж байна.

blo ло	bzang сан	rab рав	mkhyen чэн	rab рав	bzang сан	blo ло
bzang сан	rab рав	mkhyen чэн	rab рав	mkhyen чэн	rab рав	bzang сан
rab рав	mkhyen чэн	rab рав	mchog чог	rab рав	mkhyen чэн	rab рав
mkhyen чэн	rab рав	mchog чог	rje жэ	mchog чог	rab рав	mkhyen чэн
rab рав	mkhyen чэн	rab рав	mchog чог	rab рав	mkhyen чэн	rab рав
bzang сан	rab рав	mkhyen чэн	rab рав	mkhyen чэн	rab рав	bzang сан
blo ло	bzang сан	rab рав	mkhyen чэн	rab рав	bzang сан	blo ло


Энэ хүснэгтийн дөрвөн тал алинаас нь ч уншихад адилхан эргэнэ. Өөрөөр хэлбэл  $49 \times 4 = 196$  удаад богд Зонховыг сайшаан магтаж байна.

Буддын гүн ухаантан, хэл шинжлэлтэн, яруу найргийн онолч Алшаа лхаарамба **Агваандандар** (1759-1842) нь Дандины “Зохист аялгууны толь”-ийг ихэд сонирхон уг номыг олон жил тусгайлан судалсан байдаг. Тэрээр “Зохист аялгууны толийн гурван бүлгийн жишээг өгүүлэх саруул оюутны хүзүүний чимэг үзэсгэлэн сувд эрих” (snyan ngag me long le`u gsum gyi dpel brjod blo gsal mgul rgyan mi thig phreng mdzes zhes bya ba) хэмээх тайлбар зохиолыг 1828 онд бичжээ. Энэ зохиолдоо “Зохист аялгууны толь”-ийн I бүлгийн нийт бусын чимэг, жишээг өгүүлсэн ба эртний Энэтхэгийн Дорно ба Өмнө гэх хоёр уран зохиолын урсгалын гол үзэл ялгааг үзүүлэхийг зорьжээ. II бүлгийн утгын 35 чимэг тус бүрээр жишээ гаргаж тодорхойлжээ. III бүлгийн дууны чимгийн жишээг гаргаад хос төгөлдөр чимгийн шүлэг зохиож жишээг харуулсан “Самандабадрын хүрд”-ийг зохиожээ. Мөн 1830 онд “Зохист аялгууны толийн II бүлгийн адилтган тодруулах дууны үүднээс өөрийн багшийг магтан адистидыг урих эгшиг аялгууны цэнгэл” (snyan ngag me long gi le`i gnyis pa`i `tsungs pa gsal byed kyi sgra`i sgo nas rang gi bla ma la bstod pa byin rlabs `bod pa`i dbyangs snyan rol ma) хэмээх зохиол бичсэн. Цаасны хэмжээ 52x8 см. Хуудасны

тоо 9. Үүндээ тэрээр өөрийн багш Лондол лам Агваанлуvsан (1719-1795)-аа магтан шүлэглэжээ. Түүний Зохиcт аялгуугаар зохиосон өөр нэг номын нэр нь үлгэрлэх чимгийн үүднээс магтсан “Магтаал эрдмийн далайд орох сүсгийн мөрөн” (dPe rgyan gyi sgo nas bla ma la bstod pa yon tan rgya mtso la gzhol ba'i dad pa'i chu bo zhes bya ba) хэмээх тайлбар зохиол. Мөн “Дара эхийн магтаал мэргэдийн зулайн чимгийн тийн номлол мэргэдийн орой дахь эрдэнэ шигтгээн чимэг хэмээх” тайлбар бичжээ.




Үүндээ анхдугаар далай лам Гэндэндүв “Дара эхийн магтаал мэргэдийн зулайн чимэг” зохиолдоо “Зохиcт аялгууны толь”-ийн ямар чимгийг хаана хэрхэн хэрэглэснийг тодорхойлж бүх шүлгийг дэс дараалан тайлбарласан нь уран зохиолын онолын чанартай бүтээл болжээ (МУЗТ, 1976. т.621-622). Алшаа Дандар лхарамба мөн “Зохиcт аялгууны толь”-ийн утгын болон дууны чимгүүдээр “Магтаал үг цэцгэн эрихсэн чимэг” нэртэй яруу найргийн зохиолоо туурвисан байна.



Халхын Их хүрээний бичээч цорж **Агваандорж** (XVIII зуун) нь 14 боть зохиолтой. Түүний зохиолууд нь судар тарнийн ба утга зохиолын онол тайлбарын ном байна. Тэрээр Дандины “Зохиcт аялгууны толь”-ийн товч, дэлгэрэнгүй хоёр тайлбар хийжээ. Дэлгэрэнгүй тайлбарын нэр нь “Зохиcт аялгууны толь”-ийн тогтоох данс дурслыг тодруулагч хэмээх” (snyan ngag me long gi zin tho dran pa'i gsal `debs zhes bya ba). Товч тайлбарын нэр нь “Зохиcт аялгууны толийн бие хийгээд чимгийн бэлгэ чанар ба ялгал, жишээнүүдийг дурсах данс зохиол” (snyan ngag me long gi lus dang rgyan gyi mtshan nyid dang dbye ba dper brjod rnamс


dran thor bkod pa)юм.

Халхын Их хүрээний Вангай аймгийн равжамба **Агваантүвдэн** (XVIII зууны сүүлч - XIX зууны эхэн) нь түүх, уран зохиол, намтар, уран зохиолын онолын тайлбар зэрэг олон төрөл зүйлийн зохиол бичжээ. Агваантүвдэн нь төвдийн олон мэргэдийн тайлбарыг шүүн тунгааж Дандины “Зохист аялгууны толь”-д тайлбар хийсэн Монголын нэрт зохист аялгуучдын нэг юм. Түүний туурвисан уран зохиолын онолын “Зохист аялгууны толийн тогтоосны тэмдэглэл дурдхалыг сэргээгч” гэдэг зохиол нь ихээхэн алдартай. Зохиолынхоо оршилд их таван ухаанд суралцахын ач тус, ялангуяа дууны ухаанд багтах “Зохист аялгууны толь”-ийн товчийг хураан бичжээ. Энэ зохиол нь оршлын хамт 374 хуудас бүхий том зохиол. Энэ зохиолдоо “Зохист аялгууны толь”-ийн гурван үндсэн сэдвийг багтаан үргэлжилсэн үгээр тайлбарлаж, чимгүүдийн бэлгэ чанарыг олон домгоос жишээлж тайлбарлажээ. Мөн Агваантүвдэн нь “Зохист аялгууны толийн бие чимгийн бэлгэ чанар, ялгал, жишээг дурдсан тэмдэглэл хэмээх оршвой” гэсэн зохиол бичжээ. Энэ нь “Зохист аялгууны толь”-ийн тайлбарыг судлахад хялбар болгохыг зорьсон уран зохиолын онолын тайлбар шинжтэй зохиол юм. Үүндээ “Зохист аялгууны толь”-д тайлбар хийсэн Агваанлуvsанжамц, Ринбунба, Мипамлха нарын тайлбаруудаас нэлээд хэдэн жишээг түүвэрлэн авч төрөл зүйл тус бүрээр зэрэгцүүлэн үзүүлж чимэг бүрийн бэлгэ чанар ялгалыг үзүүлжээ.




Агваантүвдэн нь уран зохиолын онолч, яруу найргийн эрдмийг судалж түүнээ уран бүтээлдээ чадамгай хэрэглэж чаддаг уран бүтээлч хүн байжээ. Тэрээр “Дара эхийг зохист аялгууны утгын 35 чимгийн үүднээс магтсан магтаал, буян хишигт шинэ баярын хурим удирдагч хаврын элчийн дуун эгшиг” гэх магтаал шүлэг бичсэн байдаг.

Агваантүвдэнгийн энэ номын цаасны хэмжээ нь 9.6x48 см, барын хайрцаг 6.2x37.2 см, нэг нүүрэнд 6-аар мөрлүүлсэн, 8 цаас, монгол модон барын судар. Зохиолын нэрийг санскрит, төвдөөр хадамлаж бичсэн.




“Тэтэлгэгч Дара эхийг зохист аялгууны утгын гучин таван чимгийн үүднээс магтсан шинэхэн сайн тэмдэг бэлгэт баярын хуримыг удирдагч хаврын элчийн эгшиг дуун” (Т.: rje btzun sgröl ma la snyan ngag don rgyan so lnga`i sgo nas bstod pa dge mtsan gсар ba`i dga ston `dren byed dpyid kyi pho nya`i glu dbyangs) хэмээх зохиол нь Агваан-Иштүвдэнгийн бүтээлийн хувьд төдийгүй Монголчуудын төвд хэлээр бичсэн бүтээлийн дотор онцгой байр суурийг эзэлдэг. Энэ бүтээл нь Монголчуудын “Дара эхийн магтаал” шүлгийн дотор зохих хүрээллийг олж, хойш цаашдын бурхдын магтаалын чиглэлтэй олон зохиолд үлгэр дууриал болсон юм. Зохиолд 140 шад шүлгийг “Утгын гучин таван чимгийн” жишээ болгож өгүүлээд, жишээ шүлэг болгоныхоо хойно агуулгын товч тайлбар чанартай зүйлийг өгүүлсэн байна.


Халхын Их хүрээний гавж **Лувсандаш** (XIX зуун) нь хоёр боть зохиолтой. Тэрээр V Далай ламын зохиолын хатуу үгийн тайлбар болох “Эгшигт тэнгэрийг баясгах дууны нэмэлт тайлбар зохист аялгуу бүхэнд орох үүд” (dByangs can dgyes glu`i mchan `grel snyan ngag kun gyi `jug sgo) бүтээл туурвижээ.



Ханчин хамба Сүрэнхорын **Жамъянгарав** (1861-1917) нь утга зохиолын онолч, яруу найрагч, соён гэгээрүүлэгч, бурханы шашны сонгодог боловсролтон бөгөөд тэрээр төвд хэлээр 14 боть зохиол туурвижээ.



Жамъянгаравын Дандины “Зохист аялгууны толь”-д хийсэн “Зохист аялгууны язгуурын тайлбарын ерийн утгыг сайтар гаргасан Эсэруагийн дуу эгшиг” (snyan ngag rtza `grel gyi spyi`i don rnam par bzhas pa tshangs pa`i sgra dbyangs) (1904 он. 560 гаруй хуудастай) тайлбар нь монголын уран зохиолын онолын судалгааны үнэт өв болж уламжлан үлджээ. Энэ “Эсэруагийн эгшиг дуун” гэдэг утга зохиолын онолын тулгуур бүтээл нь Төвд, Монголын номын мэргэдэд ихэд үнэлэгдсэн ба Төвдийн XIII далай лам Түвдэнжамц энэ бүтээлийн учир түүнд “Эрдэнэ мэргэн бандида” гэдэг их цол хүртээжээ (Чоймаа нар, 2000. т.449). Энэ зохиол нь бүлэг, зүйлчилсэн ангиллын хувьд бусад тайлбартай төсөөтэй боловч арга зүй, зохиомжийн хувьд ялгаатай. Энэ тайлбар зохиолын гол онцлог нь чойрын (онолын) ухааны дагуу дагсал хаялцах, учир шалтгааны ухаан (логик)-д тулгуурлан зохиогджээ. Нөгөө талаар энэ зохиолд Монголын түүх, хаадын олон үйл явдлаас товч сэдэв авч чимгийн жишээг зохиосон байдаг (МУЗТ, 1976. т.626).




**XX зуунаас өмнө үед Дандины “Зохист аялгууны толь” нь монгол мэргэдийн зохион бүтээж туурвих уран зохиолын гол онол байсан тухайд Ч. Алтангэрэл “Монгол зохиолчдын төвдөөр бичсэн зохиолын онол” (МУЗТ. II. 1977. т.597-632) өгүүлэлдээ дээр өгүүлсэн Лувсанпэрэнлэй, Ишбалжир, Лувсанчүлтэм, Алшаа Дандар, Жамъянгарав, Агваантүвдэн нарын намтар, Зохист аялгууны судалгааны гол бүтээлийг танилцуулжээ. Мөн зохист аялгуу судлаач Л.Хүрэлбаатар “Дандины “Зохист аялгууны толь”-ийн нөлөө**

нийтийн он тооллын XIV зууны үеэс эхлэн монгол уран зохиолд нөлөөлсөн. Монголчуудын эртний завсар үеийн шүлэг (шигтгэл шүлэг), дуулал, магтаал, залбирал, тахилын шүлэг, төгсгөлийн шүлэг... зэрэгт “Зохист аялгууны толь”-ийн нөлөө түгээмэл харагдаж байдаг гээд “Ялангуяа монголын нэрт орчуулагч гүүш нарын хийсэн орчуулгын төгсгөлийн шүлэгт энэхүү чимгийн зарчмыг ашиглан монгол хэлээр уран яруу шүлэглэсэн зүйл олон бий. Жишээлбэл: Чойжи-Одсэр (XIV зуун), Ойрадын Зая бандид Намхайжамц (1599-1662), Дай гүүш Агваандампил (1700-1780), Урад гүүш Билгийн далай (XVIII зуун), Буриадын Номтын Ринчен (1821-1907) зэрэг орчуулагч гүүш нарын орчуулгад хавсаргасан төгсгөлийн шүлгүүд; Өндөр гэгээн Занабазар (1635-1723), Бандид гэгээн Лувсанданзанжалцан (1639-1704), Намдиллингийн лам Агваанбалдан (1797-1864), Зуугийн лам Дагвадаржаа (1734-1803), Брагри Дамцагдорж (1781-1855), Шадавдандар (1835-1915), Агваанданзанням (1882-1937), Цүлтэмжамц (1889-1938), Дагважалцан (?-1936), Агваандагва (1814-1885), Балдансанжайжав (1837-1906), Агваангэндэн (XIX зуун ) зэрэг монголын төвд хэлт олон зохиолчийн хэдэн зуугаар яригдах бүтээлээс “Зохист аялгууны толь”-ийн нөлөөг хялбархан харж болно” (Хүрэлбаатар, 1999. т.25-26) гэсэн нь “Зохист аялгууны толь”-ийн судалгаа, хэрэглээ өргөн хүрээтэй утга зохиолын онолын гол бүтээл байсныг тодорхойлон өгүүлжээ.

### **Монголын орчин үеийн уран зохиолын судалгаан дахь “Зохист аялгууны толь”-ийн судалгааны тойм**

XX зууны II хагас буюу 1960-аад оноос орчин цагийн “Зохист аялгууны толь”-ийн судалгааг эхлүүлж Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Ш.Иштавхай, Ч.Алтангэрэл, Х.Гаадан, Ш.Бира, О.Сүхбаатар, Л.Хүрэлбаатар зэрэг эрдэмтэд “Зохист аялгууны толь”-ийн гэрэл зургийн буулгаврыг хэвлүүлэх, шинэчилсэн орчуулга хийх, хуучин орчуулгын алдаа мэдгийг ариутган шүүж засвар оруулах, Монголчуудын төвд хэлт тайлбар зохиолыг монголчлон нийтлэх зэргээр ажиллажээ. Эдгээр судалгааны хүрээнд Б.Ринчений оршил бичиж, Х.Гаадан удиртгал бичсэн Монгол Данжуурын “Зохист аялгууны толь” (1972), Ш.Бира, Х.Гаадан, О.Сүхбаатар нарын шинэчилсэн орчуулга тайлбар үйлдэж, шинэ үсэгт буулгаж хэвлэсэн “Дандины Зохист аялгууны толь” (1982), Х.Гаадангийн “Зохист

аялгууны толин дахь адилтгал зүйрлэл” (1986), Л.Хүрэлбаатарын “Эсэруагийн эгшиг дуун” (1999), “Таван зүйлийн үсэг хадмал Зохиист аялгууны толь” (Хамтын бүтээл. 2012), “Төвд, Монгол Данжуурын Дандины Зохиист аялгууны толь”(2017), “Дандины “Зохиист аялгууны толь”-ийнголнэр утгын тайлбар”(Хамтын бүтээл. 2017) зэрэг “Зохиист аялгууны толь”-ийн эх болон ганц сэдэвт судалгааны бүтээлүүд, мөн эрдэм шинжилгээний үнэ цэнэ бүхий олон судалгааны өгүүлэл гарчээ.



**Монгол улсад Дандины “Зохиист аялгууны толь”-ийн судлалаар гарсан эрдэм шинжилгээний өгүүлүүд. Ц.Дамдинсүрэн (1908-1986)**


“Монголын уран зохиолын тойм” (1 дэвтэр, 1957)-доо: Монголын бичгийн уран зохиолыг Монголд судалсан түүхийг “Монголын уран зохиол долоон зуун жилийн түүхтэй байхад Монголын уран зохиолын судлал лав гурван зуун жилийн түүхтэй юм” (Дамдинсүрэн, 1957. т.15) гээд 1740-1742 онд зохиогдсон “Мэргэд гарахын

орон” Төвд-Монгол толийн оршилд уран зохиолын судлалын зарим асуулт анх тавигдсан байна. “Мөн тэр үед Энэтхэгийн уран зохиолын нэрт онолч Дандины “яруу найргийн толь” гэдэг уран зохиолын онол, монгол хэлэн дээр орчуулсан Данжуурын дотор хэвлэгджээ. Энэ яруу найргийн тольд уран зохиолын онолын бүх асуултыг авч бичсэнгүй, гол төлөв шүлгийн онол, шүлэг бичих арга зүйг нягтлан бичжээ” (Дамдинсүрэн, 1957. т.15) гээд энэ утга зохиолын онолыг Дандар лхарамба, Цахар гэвш Лувсанцүлтэм, Зая бандида Лувсанпэрэнлэй, бичээч цорж Агваанцэрэн зэрэг эрдэмтэд судалж тайлбарлаж, жишээ зохиож байсан нь Монгол уран зохиолын судлал үүсэхийн чухал нөхцөл болжээ (Дамдинсүрэн, 1957. т.16) гэж Дандины “Зохиист аялгууны толь” нь Монголын уран зохиолын онолын хөгжлийн үүсэл эхлэл төдийгүй цаашдын хөгжилд ч үндсэн чиг болж байсныг тэмдэглэсэн байна.

Ц.Дамдинсүрэн Дорно дахины утга зохиолын онол Дандины “Зохиист аялгууны толь”-ийн судлалаар “Дандины зохиист аялгууны



толь ба түүний тайлбаруудын тухай товч мэдээ” (Монгол судлал, 1962. т.3-25) гэсэн томоохон өгүүлэл бичиж хэвлүүлжээ. Энэ өгүүлэл нь “Зохист аялгууны толь”-ийг Монголын орчин үеийн утга зохиолын судлалд тогтолцоотой судлах судалгааны үүдэл өгүүлэл болсон байдаг.




Энэ өгүүлэлдээ Дандины “Зохист аялгууны толь” нь Данжуураар дамжин Монгол утга зохиолд нэвтрэн ирсэн түүхийг өгүүлээд “Зохист аялгууны толь”-ийн тухай ойлголт, түүний жишээ шүлгүүдийг товч тайлбарлаад одоогоор Монгол улсад хадгалагдаж мэдэгдэж байгаа “Зохист аялгууны толь”-ийн тайлбаруудыг мэдээлжээ. Үүндээ, Дандины “Зохист аялгууны толь”-оос гадна, Төвдийн 6 зохиогчийн 8, Монголын 5 зохиогчийн 8, зохиогч нь мэдэгдэхгүй 1, нийт 17 тайлбар зохиолыг танилцуулжээ.

Мөн академич **Ш.Бира** нь Дандины “Зохист аялгууны толь”-ийг анхлан тусгайлан судласан эрдэмтдийн нэг. Тэрээр 1962 онд Олон улсын Дорно дахины судлаачдын XXVI их хуралд “Монгольские комментарии и Кавьядарше Дандина” илтгэл хэлэлцүүлсэн ба мөн “Зохист аялгууны толийн гурван бүлгийн агуулгын тойм”(БНМАУ-ын түүх, 1968. т.316-332)-доо, “Зохист аялгууны толь”-ийн Төвд, Монголд дамжин дэлгэрснийг түүхчлэн авч үзэж монгол зохиогчдын төвдөөр бичсэн тайлбар, жишээ шүлгүүдийг бүртгэн (Бира, 1977. т.338-351), “Зохист аялгууны толь”-ийн санскрит эх болон уламжлалт төвд орчуулга, орчин үеийн англи орчуулга, Данжуурт байгаа монгол орчуулгын ололт дутагдлыг шүүн өгүүлжээ (Бира, 1978. т.31-45). Мөн “Дандины Зохист аялгууны толийн нэгдүгээр бүлгийн монгол орчуулга, санскрит эх, төвд орчуулга болон товч тайлбарын хамт” (Studia Mongolica, 1980. т.1-18) хэвлүүлжээ. Тэрээр “Дандины “Зохист аялгууны толь”-ийг төвдөөр орчуулсан Лакшмикара, Шонтон Доржжалцантай холбогдох хоёр захиа” (Studia Mongolica. Tom. VII, fasc. 4. Уб., 1970. х.52-59.) өгүүлэлдээ Пагва лам Лодойжалцанаас “Зохист аялгууны толь”-ийг төвдийн



ДАНДИНЫ ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛЬ

хэлнээ орчуулсан Лакшмикара, Шонтон Доржжалцан нарт илгээсэн хоёр захидлыг судлан бичжээ.

Зохист аялгууч **Ш.Иштавхай** (1902-1972) “Зохист аялгууны толь”-ийн орчуулгыг Нартан барын Данжуурын төвд эх, Агваанлувсанжамц, Жамъянгарав нарын тайлбар, өөрийн багш нарын аман уламжлал дагуу харьцуулан тулгаж, уламжлалт төвд, монгол орчуулгад байсан алдаа эндүүрлийг зассанаас гарсан мадаг дөрвөн зуугаад мэдгийг нягтлан шүүж “Хуучин орчуулгын шинэ засвар” жагсаалтаар 1972 онд “Дандины Зохист аялгууны толь”-д хэвлүүлсэн.




Төвдөч эрдэмтэн Чулууны **Алтангэрэл** (1915-1972) нь Монголын утга зохиолын онолын сэтгэлгээний уламжлал Дандины “Зохист аялгууны толь”, түүний монгол тайлбаруудыг судлахад ихээхэн хувь нэмэр оруулжээ. Тэрээр “Дууны чимгийн тийн агуулал оршвой” (Алтангэрэл, 1967. т.17-51) өгүүлэлдээ Цахар гэвш Лувсанцүлтэмийн төвд хэлээр зохиосон “Зохист аялгууны толь”-ийн “Дууны чимэг”-ийн тайлбар зохиолыг шинжлэн үзэж “Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл”-ийнхээ нэгдүгээр дэвтэртээ хэвлэн гаргажээ.



Ингэхдээ Цахар гэвшийн тайлбар зохиолын доторх зарим шүлгийг

монгол хэлээр орчуулж, төвд эхийг галиглаж төвд шүлгийн дуудлагыг халх аялгуунд шинэ үсгээр тэмдэглээд, төвд галиг, монгол дуудлага, орчуулга гурваа хадмаллаад уг шүлгийн жишээ утгаа тайлбарлажээ. Жишээ нь: Эс завсардсан хос төгөлдөр чимэг 15 зүйл хэлбэр байна гээд түүний 15 дугаар зүйл болох анхан шадны тэргүүнд, бүх 4 шадны эхэн бүрт байх хос төгөлдөр чимгийг жишээлэн үзүүлжээ. Цахар гэвш нь Дандины “Зохист аялгууны толь”- ийн III бүлэгт гардаг дууны чимгийг дотор нь 3 үндсэн хэсгээр үзүүлэхдээ түүнээ дотроо бас дэд зүйлээр нарийвчлан гаргажээ. Үүнд: 1.Хос төгөлдөр чимгийн тийн агуулал. Үүнийг дотор нь 6 зүйлээр, 2.Үйлдэхүй бэрхийн ялгал. Үүнийг үхрийн шээсний мөр мэт үйлдэх, эргэх үйлдэх бэрх гэсэн 2 зүйлээр, 3.Эгшиг тэргүүтнийг магадалсан ялгал. Үүнийг дотор нь эгшиг магадлах, орох магадлах, гийгүүлэгч үсэг магадлах гэсэн 3 зүйлээр тус тус үзүүлжээ.

Ч.Алтангэрэл “Утгын чимгийн тийн агуулал оршвой” (Алтангэрэл, 1967. т.51- 65) өгүүлэлдээ мөн Цахар гэвшийн “Утгын чимгийн тийн агуулал оршвой” зохиолын 35 чимэг, тэрхүү чимгүүдийн доторх ангилал, товч тодорхойлолтыг жагсаан оруулжээ. Жишээ нь: Анхдугаарт өвөр чанарыг өгүүлэх чимэг нь: Өгүүлэхийг хүссэн бодитой аль нэгэн түүний ахуй ёсыг гүтгэх үгүй өвөр чанарыг шударга бодитой өгүүлсэн байж болно. Үүнд: язгуур, үйлс, эрдэм, эд – ийм дөрвөн байдлыг үзүүлнэ. Үүний анхдугаарын үлгэрийг өгүүлэх нь:



Богд Агжа<sup>3</sup> эрдэнийн гэгээн бээр  
Идэрийн цог бүрдсэн  
Ижилгүй цагаан царайт  
Ирмэх нүд нь зууван  
Ижлээр уруул нь улаан  
Дэлгэр товгор хөхт  
Дэгжин нарийн бэлхүүст  
Гандирын охины адил  
Гайхам яруу эгшигт (Алтангэрэл,  
1967. т.51) гэж өвөрчлөнгийн чимгээр  
магтсан энэ шүлгийг нь Ч.Алтангэрэл  
үгчлэх бус чөлөөт байдлаар толгой  
холбон монгол шүлгийн айзам хэмнэлт  
хэв намбаар орчуулжээ. Энд Богд Агжа эрдэнийн өөрийнх нь мөн

<sup>3</sup> Цахар гэвш Лувсанчүлтэмийн багш Агжа ринбүүчи Лувсандамбийжалцан.

чанарыг өгүүлжээ. Ийнхүү энэ өгүүлэлд Цахар гэвшийн хийсэн Утгын 35 чимгийн товч тодорхойлолт, чимгийн доторхи зүйл ангиллыг хийсэн. Энэ нь “Зохист аялгууны толь”-ийн утгын 35 чимгийн тухай товч тодорхой ойлголтыг өгөх боломжтой юм.

Мөн “Дандины зохист аялгууны толийн монгол тайлбарын тухай” (Алтангэрэл, 1973, 43-48) илтгэлээ 1972 онд Олон улсын монголч эрдэмтний II их хуралд хэлэлцүүлжээ. Үүндээ: Эртний монголын утга зохиол, түүний онолыг судлахад Дандины Зохист аялгууны толийн Монголчуудын тайлбарыг зайлшгүй анхаарах ёстой гэжээ. Монголын эртний мэргэдээс Зая бандид Лувсанпэрэнлэй, Сүмбэ хамба Ишбалжир, Цахар гэвш Лувсанчүлтэм, Алшаа Дандар лхаарамба, Равжамба Агваантүвдэн, Ханчин хамба Жамъянгарав нар “Зохист аялгууны толь”-д бүхэлд нь тайлбар хийсэн. Мөн аль нэг бүлэг хэсэгт тайлбар хийсэн зохиолчид олон байгааг дурьджээ. Энэ илтгэлдээ Лувсанпэрэнлэй, Жамъянгарав хоёрын зохиолоос гол төлөв иш татаж “Зохист аялгууны толь”-ийн чимгүүдийг тайлбарлажээ. Тухайлбал “Утгын 35 чимэг”-ийн 18 дахь Дүр төгөлдрийн 8 чимгийн жишээг авч үзжээ. Тухайлбал, Лувсанпэрэнлэйн зохиосон Үзүүрхэхийн дүрийн чимэг:

Эрдмээр хязгааргүй баялаг мэргэд

Эргэлзэх сэжиг даяарыг арилгаад

Эрдэмтний сайн номлолыг судлахаар

Эрхэмлэн сонссоноор мишээх нь тодорно – гэх мэтээр 8 жишээг орчуулжээ. Үүний дараа Жамъянгаравын дүр төгөлдрийн 8 жишээг дугаарлан тайлбарыг хийжээ. Ч.Алтангэрэл өгүүллийнхээ эцэст Ханчин хамба Жамъянгаравын бүтээлд таван зүйлийн үнэлэлт өгсөн байна.

Академич Далантайн **Цэрэнсодном** “Яруу найргийн онолч Жамъянгарав” (Хэл зохиол, 1975. т.240-243) хэмээх өгүүлэлдээ Ханчин хамба Жамъянгаравын намтар бүтээлийн тухай тоймчлон өгүүлж, “Жамъянгарав бол зөвхөн гүн ухаан, хэл бичиг, яруу найргийн онолоор үр бүтээлтэй ажилласан төдийгүй анагаах ухаан, одон орон, зурхай, урлахуй ухааныг ч сонирхон судалж, сүм дугандаа номын бар сийлүүлэх, бүжиг, цам, хөгжмийн урлагийг гойд сонирхон хөгжүүлж байв”, “дээр дурдсан олон ухааны зүйлээр 14 боть ном бичсэний дотор энэ зууны эхээр гарсан “Данзий” буюу “Шашны тоолол галт болор толь”, “Зохист аялгууны язгуур тайлбарын ерөнхий утгыг

сайтар гаргасан эсэруагийн дуун эгшиг” гэсэн зохиол нь түүх хэл бичгийн эрдэмтний анхаарлыг ихээхэн татаж байна” гэх мэдээнүүдийг дэвшүүлсэн. Бас Жамъянгаравын “Эсэруагийн дуу эгшиг” гэх тайлбар зохиол бол Энэтхэг, Төвдийн эрдэмтэд бандид нарын хийсэн олон тайлбарыг жишин үзэж гүн ухаан, учир шалтгааны ухаантай нягт холбон зарим нэгэн жишээ өгүүлэхүйг гаргахдаа монгол хаадын үе угсаа, түүхэн сурвалж бичгийг ашиглан бичив. Энэ талаараа Зохист аялгууны тольд тайлбар бичсэн бусад онолчдоос ялгаатай юм гэж үзжээ. Мөн өгүүлэлд, Жамъянгарав бол Дандины Зохист аялгууны толийн элдэв чимэг, адилтгалыг гүнзгий ухаарч тухайн үеийнхээ яруу найргийн онолын сэтгэлгээг урагш ахиулахад хувь нэмэр үзүүлсэн эрдэмтдийн тоонд зүй ёсоор орно гэж үнэлэн тэмдэглэсэн юм(Ван Мандуга. 2017, т.66)

Доктор, профессор, дуун хөрвүүлэгч Осорнамжимын **Сүхбаатар** (1944-2005) нь Дандины “Зохист аялгууны толь”-ийг 1982 онд Ш.Бира, Х.Гаадан нарын хамт орчин цагийн монгол хэлнээ орчуулж тайлбар хийж, эдүгээ цагийн монгол уншигч судлаач нарт хүргэжээ. Мөн “Дандины Зохист аялгууны толийн хос төгөлдөр чимэг” гэсэн томоохон өгүүлэл хэвлүүлжээ. Тэрээр “Дандины зохист аялгууны толийн хос төгөлдөр чимэг” (Хэл зохиол судлал, 1982. т.223-239) өгүүлэлдээ “Зохист аялгууны толь”-ийн гуравдугаар бүлгийг хос төгөлдөр чимэг, үйлдэхүй бэрх бусад ялгал, далдлахуй үгийн чимэг, зохист аялгууны гэмийг арилгагч гэж хувааж үзэж болно гээд үүнээсээ хос төгөлдөр чимгийн санскрит эхийн жишээ шүлгийг монголоор орчуулж, түүнтэй дүйх монгол жишээ шүлгүүдээр тайлбарласнаараа онцлог болсон. Жишээ нь: Хөлийн адгийн хос төгөлдөр чимэгт: хөлийн төгсгөлийн үгийг дараагийн хөлийн эхэнд шилжүүлэн хос төгөлдөр чимэг бүтээх нэгэн аргыг Дандин онцлон тэмдэглэсэн байна гээд иймэрхүү бүтэцтэй шүлэг орчин үеийн манай яруу найрагт цөөнгүй тохиолдож байгаа нь сонирхолтой гээд

Сарны туяа сайхан

Сайхан гэвч хүйтхэн

Сарны туяа саруулхан

Саруулхан гэвч хүйтхэн (Ч.Чимэд, 1964. т.113) гэсэн энэ шүлэгт нэг мөрнөөс нөгөө мөрөнд “сайхан, саруулхан” гэсэн үгсийг шилжүүлэн хэрэглэснийг санскрит жишээтэй харьцуулан үзүүлжээ.

Ийнхүү санскрит, монгол шүлэглэлийг харьцуулаад “Санскрит,

монгол хэлний урт, богино, хос эгшгүүд байдаг нь шүлгийн эгшиглэл зүйд нь төсөөтэй тал байна. Санскрит, монгол шүлгийн эх адаг хоёрыг барилдуулах зарчим нь монгол шүлгийн нэг мөрнөөс нөгөө мөрнөө шилжүүлэх ёстой адил байгаа бол шүлгийн хөлийг тонгоруулдаг нь гагцхүү санскрит шүлэгт байдаг өвөрмөц чимэг бололтой” (Сүхбаатар, 2014. т.91) гэж санскрит, монгол шүлгийн төсөөтэй, ялгаатай чанаруудыг харьцуулан шинжилжээ.


Доктор(Sc.D), профессор **С.Дулам** “Жамъянгаравын Эсэруагийн дуун эгшиг зохиол дахь яруу найргийн онолын зарим асуудал” илтгэл 1975 онд хэлэлцүүлжээ.

Доктор(Sc.D), профессор **Ц.Сүхбаатар** “Монгол хэлний найруулгазүйн нэр томъёоны тайлбар толь”. 2003. Энэ монгол хэлний найруулга зүйн тайлбар толь номдоо “Агуу их чанарт”, “Адилтгал”, “Адил тэгшийн адилтгал”, “Маш залуу найруулга”, “Маш тунгалаг найруулга”, “Магад бусын адилтгал”, “Номын адилтгал”, “Нотлох адилтгал”, “Сайшаах адилтгал”, “Самади”, “Тэнсэлдэгч бодын адилтгал”, “Хураахын адилтгал”, “Хураах, эс хураахын дүрст чимэг” гэх зэрэг Дандины “Зохист аялгууны толь”-ийн утгын болоод дууны, нийтийн болоод нийт бусын чимгийн найруулгын 70 шахам ур маягийн тодорхойлт, жишээ шүлгийг тайлбарлажээ.

Доктор(Sc.D), профессор **Д.Галбаатар** “Уран зохиол Нэвтэрхий толь”. 2021. Энэхүү Уран зохиол гэж юу вэ гэсэн цогцолбор том асуудлаас эхлээд хосмолжин өлмий гэж юу вэ гэх эгэл жижиг асуулт хүртэл хариу өгсөн энэхүү том нэвтэрхий тольд өрнө дахины сонгодог онол Аристотелийн “Туурвил зүй”, Америкийн “Шинэ шүүмжлэл”-ийн онолч Р.Уэллек, О.Уоррен нарын гээд дэлхий нийт, монголын уран зохиолын онол, түүх, шүүмжлэлийн бүхий л нэр томъёоны ойлголт орсон байдаг. Тиймээс Дандины “Зохист аялгууны толь”-ийн мөн олон чимэг нэр утгын тайлбар томъёолол байна. Тухайлбал: “Вайдарбха”, “Бритта”, “Болох бусын адилтгал”, “Гайхамшгийн адилтгал”, “Даяарын дүрст”, “Үлгэрийн дүрст чимэг”, “Зохист аялгууны толь” зэрэг “Зохист аялгууны толь”-ийн олон утга, чимэг, нэр томъёоны тайлбарыг хийжээ.

Доктор(Ph.D), профессор **Д.Бүрнээ** “Зая бандид Лувсанпэрэнлэйн нэгэн бүтээлийн тухайд” (Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, 2003:) гэх өгүүлэлд, Лувсанпэрэнлэйн

“Утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүй Эсэруагийн хөвгүүнийг баясгах дуун эгшиг” (Д.Бүрнээ. Эсэруагийн хөвгүүн гэж орчуулав) хэмээх зохиолын адилтгал чимгийн 32 жишээ шүлгийг орчуулан шинжлэв. Монголын Соёл урлагийн их сургууль, Соёл урлагийн судлалын хүрээлэнгээс эрхлэн бичсэн “Монголын соёлын түүх”-ийн “Уран зохиолын онол судлал” гэх хэсэгт төвдөөр зохист аялгууны тухай тайлбар ба жишээ шүлэг бичсэн монгол эрдэмтдийг товч танилцуулан, Жамъянгаравын яруу найргийн онол судлалын бүтээлч зүйлс, монголын яруу найргийн онолчдын зохист аялгууны ухагдахуун, үүрэг зорилго, уран сэтгэмж, найруулгын арга мэргэжил, жам хууль, өвөрмөц онцлог, уран зохиолын үйл явц, хөгжил хувьслын асуудлын тухай өвөрмөц үзэлт танилтыг нарийвчлан шинжлэв (Монголын соёлын түүх, 2010. т.79-96).



Доктор **Д.Сумъяа** “Дара эхийн магтаалын нээх утга”(2002) номынхоо IV бүлэгт Монголын “Вангай равжамба” (XVIII-XIX зуун) Агваан-Иштүвдэний зохиосон “Гэтэлгэгч Дара эхийн зохист аялгууны утгын гучин таван чимгийн үүднээс магтсан шинэхэн сайн тэмдэг бэлгэт баярын хуримыг удирдагч хаврын элчийн эгшиг дуун хэмээгч оршвой” хэмээх магтаал шүлгийг шинжлэн үзжээ. Энэ бүтээл нь Монголчуудын “Дара эхийн магтаал” шүлгийн дотор зохих хүрээллийг олж, хойшид бурхдын магтаалыг зохист


аялгууны утгын болон дуун чимгээр бичих чиглэлтэй олон зохиолд үлгэр дууриал болсон зохиол байдаг. Зохиолд 140 шад шүлгийг утгын гучин таван чимгийн жишээ болгон өгүүлсэн байхын дээр, жишээ шүлэг бүрийн хойно агуулгын товч тайлбар шинжтэй зүйлийг өгүүлжээ. Мөн доктор, профессор Ван Мандуга болон төвдөч эрдэмтэн Л.Хүрэлбаатартай хамтран “Таван зүйлийн үсэг хадмал Зохист аялгууны толь”-ийг харгуулан найруулав. Мөн Төвд, Монгол “Данжуур”-ын эхийг хөрвүүлж төвд, монгол, шинэ үсгийн гурван эхийг 900 орчим үг, утгын зүүлт тайлбартай “Төвд Монгол “Данжуур”-ын Дандины “Зохист аялгууны толь”(2017) ном

хэвлүүлжээ.



Доктор (Ph.D) **Д.Ганболдын** найруулан бичсэн “Бат сүжигт бандид хамба Жамъянгарав” гэх ном нь Гэгээнтний төрөл үеийн магтаал ба намтар, түүнд холбогдох өгүүлэл сэлт, Жамъянгаравын төвдөөр зохиосон зарим шүлэг, Жамъянгаравын судлалд холбогдох мэдээ эш илтгэл өгүүллүүд, гэгээнтнээс уламжилсан эд өлгийн дурсгал, гэгээнтний үр хойчис өв тээгчид зэрэг таван бүлгээр бүрдэж байна. Тус номд Ханчин хамба Жамъянгаравын намтар, уран бүтээл, тайлбар зохиол, үр хойчис, Жамъянгаравын намтар түүхэнд

холбогдох баримт материал оржээ.



ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс **Дандины “Зохист аялгууны толь”-ийн гол нэр утгын тайлбар** (Хамтын бүтээл. Д.Сумъяа, Б.Няммягмар, П.Ням-Очир, Ж.Ерөөлт, Б.Лхагважав). 28,8 хх буюу 346 нүүр. УБ. 2017) хэмээх судалгааны бүтээл хэвлүүлжээ.

Энэ “Дандины Зохист аялгууны гол нэр, утгын тайлбар”-ыг хийхдээ “Зохист аялгууны толь”-ийн өөрийнх нь уламжлалт зүйл хуваасан толийн арга зарчмыг баримтласан ба мөн өмнө үеийн “Зохист аялгууны толь”-ийн

судлаачид Ш.Бира, Л.Хүрэлбаатар, Ч.Алтангэрэл зэрэг номын багш нарын судалгааны бүтээлийг, арга зүйг баримтлан хийжээ. Үүнд үндсэн эш эхээр Дандины “Зохист аялгууны толь”-ийн Төвд “Данжуур”-ын төвд эх, Монгол “Данжуур”-ын Гэлэгжалцаны эх, Ш.Бира нарын шинэчилсэн орчуулга болох 1982 оны эхүүдийг барьж үндсэн




тодорхойлолт жишээгээ өгүүлээд араас нь бусад тайлбараас тохирох жишээ тайлбаруудыг оруулжээ. Гол нэр утгын толгой үгийг татахдаа “Зохист аялгууны толь”-ийн эхүүд болон зохист аялгууч Л.Хүрэлбаатар багшийн “Эсэруагийн эгшиг дуун”(1999), С.Жамъянгаравын “Цаглахуй санааны найлзуур мод”(2011), Ч.Алтангэрэлийн “Монгол зохиолчдын Төвдөөр бичсэн бүтээл” (1967) эдгээр ном бүтээлүүдэд Утгын болоод Дууны чимгүүдийг зүйл зүйлээр нь нэрлэж татсан тэдгээр судалгааг гол эш болгож бариад “Зохист аялгууны толь”-ийн гол гол нэр утга болох 500 шахам үгийг татаж толгой үг болгоод тайлбарыг хийжээ.

### Дандины “Зохист аялгууны толь”-ийг тусгайлан

#### судалсан эрдэмтэд

Монголын орчин үеийн утга зохиол судлаачдаас “Зохист аялгууны толь”-ийг тусгайлан судалж ганц сэдэвт зохиол бичиж Х.Гаадан (1923-2007) дэд доктор, (1976), Л.Хүрэлбаатар (1945-2010) шинжлэх ухааны доктор(Sc.D) (1993, х.508)-ын зэрэг хамгаалжээ.



Дэд доктор, Монголын бурханы шашны Гандантэгчэнлин хийдийн хамба Хархөвүүний **Гааданы** эрдэм шинжилгээний гол чиглэл нь Дандины “Зохист аялгууны толь”-ийн судалгаа юм. Тэрээр “Дандины Зохист аялгууны толь” (1972) (Монгол Данжуурын эх), “Дандины Зохист аялгууны толь” (1982) (орчин цагийн монгол хэлээр орчуулсан эх), “Дандины Зохист аялгууны толин дахь адилтгал, зүйрлэл” (диссертаци, 1976), “Зохист аялгууны толин дахин адилтгал зүйрлэл” (1986) судалгааны ном бичиж

хэвлүүлжээ. Мөн “Үлгэрийн чимэг” (1970), “Гийгүүлэгч чимэг” (1970), “Дүрслэх чимэг” (1970), “Хориглох чимэг” (1971), “Бус утгыг байгуулах чимэг” (1971), “Утгын гучин таван чимэг” (1974), “Шалтгаан заах чимэг” (1975), “Дандины “Зохист аялгууны толийн хураах ба гүтгэх чимэг” (1979), “Зохист аялгууны толь ба Монголын эртний уран зохиол” (1992) зэрэг 20 шахам эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлж,

мөн “Зохист аялгууны толь”-ийн чимгүүдээр түүхт хүмүүсийн амьдрал үйлсийг харуулсан жишээ олон шүлэг зохиожээ.

Х.Гаадан “Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл (Төвд хэлээрх сурвалж бичгийг баримталсан судалгаа) гэсэн сэдвээр хэлбичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг горилж нэг сэдэвт зохиол 1976 онд бичжээ. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч нь академич, хэл бичгийн ухааны доктор, профессор Б.Ринчен, шүүмжлэгч нь академич Ц.Дамдинсүрэн байв. Х.Гаадан диссертацийн оршилдоо “Зохист аялгууны толь”-ийг судлахын зорилгоо: “Манай энэхүү шинэ соёл бол үндэсний соёлын дэвшилтэт уламжлалыг баяжуулан, дэлхий дахины соёлын шилдэг ололтыг тусгаж, цааш хөгжих ёстой. Нөхөр Ю.Цэдэнбал: “Өнгөрсөн үеийн соёлын өв уламжлалын сангаас хамгийн шилдэг дэвшилтэтэй бүхнийг тунгаан авч, шинэ социалист соёлыг бий болгон хөгжүүлэхэд ашиглах хэрэгтэй гэж нам үзсээр ирсэн, одоо ч үзэж байна” (Гаадан, 1976. т.1-2) гэж Монголчуудын судар бичигт гүн ул мөр нөлөөллөө үлдээсэн оюуны соёлын өвийг сэргээн шинээр нээн судлан шинжилж, дараа үеийнхэнд сурган өвлүүлэх зорилтоо тодорхойлсон байна. Манай хуучин өв соёлын судлалд холбогдолтой сурвалж бичиг төвд хэлээр ихээхэн байдаг. Төвд хэл бол монголын түүх, соёлын хуучин өвийг судлахад чухал хэрэгцээтэй нэг хэрэглүүр нь болдог. Эдгээр ном бичгийн дотроос Дандины “Зохист аялгууны толь” бол монгол хэл бичиг соёлд тодорхой мөрөө үлдээсэн судалбал зохистой ном бүтээлийн нэг учир тусгайлан судалж буй гэдгээ удиртгалдаа дэлгэрэнгүй бичжээ.

Х.Гаадангийн энэхүү нэг сэдэвт зохиол нь удиртгал, үндсэн 3 бүлгээс бүрдэж байна. Диссертацийн I бүлэгтээ “Чимгийн шастир Зохист аялгууны толь бол яруу найруулгын тухай зохиол мөн” болохыг шинжлэн үзжээ. II бүлэгтээ “Зохист аялгууны толь дахь адилтгал, зүйрлэл”, III бүлэгтээ “Чимгийн шастирын тус эрдэм монголын уран зохиолын судлалд холбогдох” тухай шинжлэн үзжээ. Төгсгөлд нь үлгэрийн чимэг, дүрстийн чимгийн жишээ шүлгийг хавсаргажээ.

Тэрээр нэг сэдэвт зохиолынхоо төгсгөлд “Хуучны бичиг зохиол бол үүссэн анхныхаа шинж, хожим хойно тусгасан шашны үзэл бодлыг өөртөө багтаасан нэгэн зүйлийн бүхэл цогц судлагдахуун мөн болно” (Гаадан, 1976. т.154) гэж эртний өв соёл бол он цагийн түүхэн мэдлэг, хөгжил хувьслыг хадгалан тээгч болохыг тодорхойлжээ.

Мөн “Дандины толь монголын уран зохиолд нөлөө холбогдолтой байсан нь монгол эрдэмтэн мэргэд, чимгийн зарчмыг хэрэглэж, түүхийн сэдэв бүхий зохиол туурвин, уянгын яруу найраг зохиож, нутаг усны магтаал, сургаалын шүлэг бичиж байснаас илэрхий байна. Ийм баримт цөөнгүй байгаа нь XVII-XX зууны эхэн үед монгол уран зохиолын судлалд нэлээд өргөн байсныг харуулж өглөө” (Гаадан, 1976. т.155-156) гэжээ. Цааш нь “Дандины толийг шинэ үед улам дэлгэрэнгүй судалж, бүрэн утгыг нь гаргах талаар эрдэмтэн нөхөд хүч нийлүүлэн ажиллах юм бол хуучин уран зохиолын зарим нарийн утгыг тайлж, онох талаар нэлээд ахиц гарах нь гарцаагүй гэж үзэж байна” (Гаадан, 1976. т.156) гэжээ.



Х.Гаадан “Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл” (1986 он) судалгааны номондоо Дандины “Зохист аялгууны толь”- ийн утгын 35 чимгийн үлгэрийн буюу адилтгалын мөн дүрстийн гэх энэ 2 чимгийн 54 хувилбарыг авч төвд, монгол эрдэмтдийн тайлбаруудтай харьцуулан судалжээ. Ингэхдээ Дандины зохиолын төвд эх, төвдийн шүлэгч V далай лам Агваанлуvsсанжамцын “Зохист аялгууны толийн бэрхийн тайлбар Сарасватийг баясгах эгшиг дуун” хэмээх тайлбарыг судалж, энэ хоёрыг гол болгож, бусад олон тайлбарыг зэрэгцүүлэн тулгаж, чимэг бүрийн утга

санааг гаргажээ.

Энэ ном 4 хэсгээс бүрдэж байна. I хэсэгт “Зохист аялгууны толь” бол яруу найруулгын тухай зохиол болно гэдгийг эртний төвд, монгол хэлний бичиг зохиолын дотор түүний эзлэх байр суурь, “Зохист аялгууны толь”-ийн утгын шим чухам юу болох, “Зохист аялгууны толин” дахь уран дүрслэл, тэрхүү уран дүрслэл нь тухайн зүйлийн мөн чанарыг таниулж, зохиолчийн хэлэх гэсэн санааг бүрэн дүүрэн илэрхийлдэг болохыг өгүүлжээ.

II бүлэгт, “Зохист аялгууны толь” дахь адилтгалын тухай авч үзсэн. Үүнд “Адилтгалд гурван зүйлийн чухал махбод, үг байдаг. Энэ нь адилтгагдахууны чанар, адилтгаж чадах үг, адилтгалын холбоц

гишүүн гурав юм” (Гаадан, 1986. т.22) гээд адилтгалын бэлгэ чанар бол “аливаа нэг юмыг мөн тэр мэт юмтай нь адилтгаж илхнээ болгон ухааруулах арга” бөгөөд “энэ нь А бол Б шиг юм гэсэн томъёогоор томъёолон гаргаж болох зүйл юм” (Гаадан, 1986. т.25) гэж адилтгалын тухай онолын тодорхойлолт томъёоллыг өгчээ. Мөн энэ II бүлэгт адилтгалын 32 чимгийн тайлбар хийжээ. Ингэхдээ Дандины зохист аялгууны толийн тодорхойлолт, жишээ шүлгийг Агваанлуvsанжамцын жишээ шүлгээр давхар тайлбарласан нь уншигч судлагч хэн хүн бүхэнд ойлгоход хялбар дөхөм болсон байна.

Ийнхүү адилтгалын 32 хувилбарыг олон тайлбар жишээ шүлгээр тайлбарласны эцэст адилтгалын тухайд 5 зүйл дүгнэлтийг гаргажээ. 1.Энд гарсан адилтгалын бүх хувилбар бол сайныг гаргах гол арга болсон “Өвөр төрх өгүүлэх чимэг”-ийн зарчмыг хэрэгжүүлж, сайшаан өгүүлэх зүйлдээ язгуур 6, үйлс 8, эрдэм 8, эд 10-ыг гарган үзүүлж, дөрвөн талаас чимэглэдэг ёсыг журамласан байна. 2.Адилтгал болгож чадах анхны загварыг сонгож авахдаа нэг үгийн доторх сайхныг илтгэх өнгө аясыг авснаас гадна хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн үгийг сонгож авсан явдал бол уран санаагаар магтах юмаа сайхан болгоход найруулгын баялаг арга хэрэглэснийг гэрчилж байна. 3.Үг ашиглаж хэлний адилтгал зохиохдоо чанар учир шалтгааныг холбож, давхар зүйлийг ухааруулахаар найруулсан сонин тал энд бас харагдаж байна. 4.Адилтгалд илтгэцийн үүрэг гүйцэтгэдэг үг болгож шиг, мэт гэх зэрэг нэг үг сонгож авснаар зогсохгүй түүнээс гадна хэд хэдэн үг, тэр ч байтугай бараг өгүүлбэрийн бүтэц бүхий илэрхийллээр илтгэцийн үүрэг гүйцэтгүүлж зохиосон нь найруулга зүйн бас нэг сонин хэлбэр юм 5.Адилтгах арга нь: а/ адилтган гийгүүлэх үг хэрэглэх, б/ өгүүлбэрийн найруулгын аргаар адилтгах, в/ үгийг утга бүхий хэсгээр таслан найруулж адилтгах гурван зарчмыг баримталжээ (Гаадан, 1986. т.52-53) гэж адилтгалаар чимэх ёс журам, адилтгах арга, адилтгалын найруулга, адилтгаж буй юмсын учир холбоо чухам ямар буйг үзүүлжээ.

III бүлэгт, “Зохист аялгууны толь” дахь зүйрлэл буюу дүрстийн чимгийн тухай авч үзжээ. Уран дүрслэл нь өгүүлэх зүйлийнхээ сайхныг тодруулахдаа үгийн утгыг шилжүүлэн хэрэглэж, өгүүлэх санаагаа тод болгодог арга байна. Дүрслэх чимэг буюу зүйрлэлийн бэлгэ чанар нь тэр мэт, тийм юм гэхгүйгээр адилтгахуунаар нь

адилтгагдахууныг шууд нэрлэн илэрхийлж “үүлэн зардас”, “цаасан малгай”, “саран чавганц” гэх мэтээр өгүүлэгдэхүүн гишүүн юугаар дүрслэгдэхийг үзүүлдэг байна. Ийнхүү энэ номд адилтгал, зүйрлэл хоёрын адил болоод, ялгаатай талыг үзүүлсэн байна. Зүйрлэн өгүүлэх аргыг Зохист аялгуунд “дүрстийн чимэг” гэдэг бөгөөд тэрхүү чимгийн 20 хувилбарыг мөнхүү зохист аялгууны төвд эх, Агваанлувсанжамцын жишээ шүлгээр утгыг нь нээн тодруулан гаргажээ.

IV хэсэгт, “Зохист аялгууны толь”-ийн үлгэрийн болоод дүрстийн чимэг буюу адилтгал зүйрлэлийн төвд эх, түүний тайлбар, Агваанлувсанжамцын жишээ шүлгийг орчуулж, чимэг тус бүрээр нь хавсаргажээ.



Х.Гаадан нь Зохист аялгууны судалгаанаас гадна түүхт хүмүүсийн амьдрал үйлсийг харуулсан жишээ шүлэг зохиожээ. Шүлгүүдийг түүний “Мартуузай хэмээн өгүүлсэн элдэв зүйл” (2000) хэмээх номд нь эмхэтгэн оруулж хэвлэжээ. Тухайлбал: Өвөрчлөний чимгээр “Галдан хаан” (Гаадан, 2000. т.192-197), дүрслэхийн 20 зүйл чимгээр “Ойрадын Зая бандид Намхайжамц дүрслэхийн толинд гэрэлтсэн нь” (Гаадан, 2000. т.45), гайхамшгийг өгүүлэх чимгээр “Ленин”-ийг магтсан жишээ шүлэг зохиосон төдийгүй Б.Ринчен (Гаадан, 2000. т.47),

Ц.Дамдинсүрэн (Гаадан, 2000. т. 48) багш нартаа, ээждээ зориулсан магтаал өчил шүлэг (Гаадан, 2000. т.37), машид хольцогч чимгээр ханьдаа (Гаадан, 2000. т.127) зориулсан шүлэг зохиосон ба Өндөр гэгээн Занабазарын “Жанлав чогзолма - адистидын дээдийг хайрлагч эх” (Гаадан, 2000. т.128) хэмээх алдартай шүлгийг орчуулсан гэх зэрэг бүтээлч жишээ орчуулга хийжээ.

Өөрөөр хэлбэл, эрдэмтэн Х.Гаадан нь “Зохист аялгууны толь”-ийн уламжлалт монгол эхийг удиртгал тайлбар бичиж хэвлүүлжээ. Мөн орчин цагийн монгол хэлнээ орчуулж, утгын тайлбар хийж, судлан шинжилжээ. Бас хатуу үг, ёгт нэр, хуучирсан үгийг нь тайлбарлаж, утгын чимгүүдээр нь жишээ шүлэг бичжээ. Иймд Х.Гаадан бол зохист

аялгууг орчуулсан, тайлбарласан, судалсан, үндсэн эхийг хэвлэсэн, жишээ шүлэг бичсэн учир зохист аялгууг иж бүрэн цогцоор нь судалсан зохист аялгуу судлаач зохист аялгууч эрдэмтэн байна.

Монгол улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, доктор (Sc.D), профессор төвдөч эрдэмтэн Лхамсүрэнгийн **Хүрэлбаатар** нь “Дорно дахины уран сайхны сэтгэлгээний сонгодог уламжлал ба монгол яруу найргийн онол” гэсэн Хэл шинжлэлийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл<sup>4</sup>, “Эсэруагийн эгшиг дуун” (1999) хэмээх судалгааны ном, С.Жамъянгаравын “Цаглахуй санааны найлзуур мод”(2011) Зохист аялгууны жишээ шүлгүүдийг орчуулж судлан шинжилсэн ном, мөн “Таван зүйлийн үсэг хадмал “Зохист аялгууны толь” (2012. Хамтын бүтээл) хэмээх Дандины “Зохист аялгууны толь”-ийн олон эхийг найруулан хэвлүүлжээ.

Тэрээр мөн “Дандины “Зохист аялгууны толь”-ийн тайлбарт Жамъянгаравын хийсэн бүтээлч шинэчлэл” (ОУМЭХ, 1992. т.29-35), “Дандины “Зохист аялгууны толь”-ийн Төвд, Монгол тайлбаруудын харьцаа” (Монгол ба Энэтхэг, 1989. т.204-211), “Kavyadarsa of Dandin and Analogy of its Tidentan and Mongolian Commentaries” (The Tibet journal, 1990. т.52-58), “Яруу найргийн онолын өв” (Цог, 1989. т.82-88), “Зохист аялгууны толийн орчуулга, тайлбар” (Дорно дахин судлалын асуудал, 1976), “Найлзуур модны мөчрийн дэргэд – Монголын яруу найргийн онолч Сүрэнхорын Жамъянгарав”(Цог, 1991. т.78-107), “Яруунайргийн онолын өв”(Цог, 1989. т.82-88) зэрэг эрдэм шинжилгээний олон өгүүлэл бичжээ. “Зохист аялгууны толь”-ийн судалгааны эдгээр өгүүлэлдээ XVIII-XX зууны үеийн монгол мэргэд, тухайлбал Агваантүвдэн, Агваандандар, Лувсанпэрэнлэй, Лувсанцүлтэм, Жамъянгарав зэрэг эрдэмтдийн бичсэн “Зохист аялгууны толь”-ийн тайлбар, жишээ шүлгүүдийн монгол яруу найргийн онолын сэтгэлгийн өв уламжлалыг шинжлэн судалжээ. Ялангуяа Жамъянгаравын тайлбар, жишээ сэлтийн монгол яруу найргийн онолын сэтгэлгийн хөгжилтөд оруулсан нэмэр хандивыг нарийвчлан авч үзсэн. Тухайлбал, “Дандины “Зохист аялгууны толь”-д Жамъянгаравын хийсэн бүтээлч шинэчлэл” (1992) өгүүлэлд, зарим онолын тодорхойлолт ба үлгэр өгүүлэхүйг харьцуулах аргаар Жамъянгаравын бүтээлч үйлсийг тодруулан ялгаруулж, “Жамъянгарав уг номыг бичихдээ, *нэгд*, жишээ шүлгийн ихэнхийг

<sup>4</sup> Монгол улсын Үндэсний Төв номын сан. Гар бичмэлийн хөмрөг. Уб., 1993, х.508(хх. 32.12)

өөрөө шинээр зохиосон; *хоёрт*, хэд хэдэн тайлбарын зөрөө ялгалыг магадлан шүүж санаа баримтлалаа дэвшүүлсэн; *гуравт*, шүлэглэл зүйн нарийн тогтолцоог харьцуулан гаргахын үүднээс жишээ шүлгийг санскрит хэлээр нь нэмж оруулсан; *дөрөвт*, яруу найргийн онолын үндсэн зарчмыг авч үзэхдээ “Зохист аялгууны толь”-ийн үндсэн эх болон анхны санскрит тайлбарын утгыг харгалзан үзсэн; *тавд*, яруу найргийн онол-практикийн асуудлаар мадаг сэжигтэй олон зүйлийг нухацтай задлан шинжилсэн” (Хүрэлбаатар, 1992. т.29-35) гэж дүгнэсэн байна.



Төвдөч эрдэмтэн Л.Хүрэлбаатарын **“Огторгуйн цагаан гарди”** (1996) бүтээл нь төвд сурвалж судлалаар төвд хэлт монголын уран зохиол, монголын буддын шашны 10 гол төлөөлөгчийн намтар уран бүтээлийг шинжлэн бичсэн судалгааны зохиол. Энэ номд Монголын сүүлийн гурван зууныг дамнан гарч ирсэн Монголын номын их мэргэдийн тухай өгүүлсэн шинжлэх ухаан, уран сайхны арван хөрөг орсон. Үүнд: Өндөр гэгээн Занабазар, Зая бандида Лувсанпэрэнлэй, Хамба номун хан Агваанхайдав, Ханчин хамба Жамъянгарав,

Эрдэнэ мэргэн бандид Агваан-Ишсамбуу, Ноён хутагт Данзанравжаа, Цанид ловон Шагдар, Жалханз хутагт Дамдинбазар болон тэдний төвд хэлээр зохиосон ном бүтээлийг олж цуглуулаад, орчуулан буулгаад, утга зохиолын задлан шинжилгээг хийжээ. Ингэхдээ Монголчуудын утга зохиолын онол хийгээд Зохист аялгууны толийн судлал чиглэлээр “Найлзуур модны мөчрийн дэргэд” (Л.Хүрэлбаатар. 1996. т.238-286) өгүүлэлдээ Эрдэнэ мэргэн бандид, ханчин хамбо Жамъянгарав (1861-1918)-ын утга зохиолын онолтой танилцуулж, мөн “Ухааны таван орны ялгуусан бандид” хэмээн Зая бандид Лувсанпэрэнлэй(1642-1715)болон “Сонсголон алдрын цагаан банзад” хэмээн Хамба номун хан Агваанхайдав(1779-1838) хоёрын тухай тусгай судлалын зохиолд тэдний амьдрал ахуй, зохиол бүтээлийг шинжлэхийн зэргээр бас зохист аялгууны тухай онол үзэлт ба жишээ шүлгийг нь судалж шинжилсэн байдаг.

**“Судар шастирын билиг”** (2002) номын “Зохист аялгууны

шастир” (Л.Хүрэлбаатар. 2002. т.201-239) бүлэгт “Зохист аялгууны толь” нь Монголчуудын утга зохиол судлалын ертөнцөд нэвтэрч идээшсэн түүх, Монгол номын мэргэдийн төвдөөр туурвисан “Зохист аялгуу толь”-ийн тухай тайлбар зохиолууд, үлгэр өгүүлэхүйг тоймлон өгүүлж, тэдний онолын тогтолцоо, онолын зарим бүтээлч зүйлсийг өгүүлжээ.



Ингэхдээ Монголчуудын төвд хэлэн дээр туурвисан зохист аялгууны тухай зохиолуудыг онолын чанартай бүтээл ба үлгэр өгүүлэхүйн бүтээл гэж ялган салгаж үзжээ. Дандины “Зохист аялгууны толь”-ийг тайлбарлаж бичсэн Монголчуудын онолын чанартай бүтээлүүдийн дотор Сүмбэ хамба Ишбалжирын “Угийн чимгийн өчүүхэн хураангуй зохист аялгуунд орох үүд”, Цахар гэвш Лувсанцүлтэмийн “Утгын чимгийн тийн агуулал оршвой”, “Дууны чимгийн тийн агуулал оршвой”, равжамба

Агваантүвдэний “Зохист аялгууны толийн тогтоосон тэмдэглэл дурдлыг тодруулагч”, “Зохист аялгууны толийн бие хийгээд чимгийн бэлгэ чанарын ялгал үлгэр өгүүлэхүйнүүдийг тогтоосон тэмдэглэл дурдлыг тодруулагч”, Лувсандашийн “Эгшигтийг баясгах дууны нэмэлт тайлбар, зохист аялгуунд орох үүд”, Ханчин хамба Жамъянгаравын “Зохист аялгууны үндэс хийгээд тайлбарын ер утгыг сайтар агуулсан эсэруагийн эгшиг дуун” зэргийг дурдаж болно гэж үзээд, бас “Зохист аялгууны толь”-д судалгаа хийхийн дагуу түүний онолын зарчмаар жишээ шүлэг бичсэн хүмүүсээс Зая бандид Лувсанпэрэнлэй, Сүмбэ хамба Ишбалжир, Алшаа лхарамба Агваандандар нарын хэдэн бүтээлээс гадна равжамба Агваантүвдэний “Гэтэлгэгч Дара эхийг зохист аялгууны утгын гучин таван чимгийн үүднээс магтсан буяны бэлгэт шинэ баяр хуримыг удирдагч хаврын элчийн дуун эгшиг”, Хамба номун хан Агваанхайдав (1779-1838)-ын “Үйлдэхүйеэ бэрх дөрвөөр холбосон зохист аялгууны үзэсгэлэнт чимгийн сургаал”, Зава Дамдин хэмээх Лувсандаяны (1867-1937) “Хир үгүй номлол бүтээлийн шашны гарах орон Гандантэгчэнлин хийдийн сайшаалыг товч төдий



өгүүлсэн согтсон зөгийн яруу дуун” зэрэг бүтээлүүд байна гэж дурджээ. Тэр бас монгол эрдэмтдийн бүтээлч зүйлсийг үнэлэн шүүмжилж, монголын яруу найргийн онолчид “Зохист аялгууны толь”-ийн онолын уламжлал ба төвдийн эрдэмтдийн онол үзэл баримтлалыг уламжлан баяжуулан хөгжүүлсэн бөгөөд үүгээрээ уг онол нь царцанги биш, ерөнхий ба тусгайн хамгийн түгээмэл хууль зүй, салшгүй нэгдлийн шинжийг илтгэж байна” (Л.Хүрэлбаатар. т.20020.т.239) гэжээ.




Л.Хүрэлбаатарын **“Огторгуйн цагаан гарди”-II** (2008) номд орсон “Сэтгэлийн далайд эрдмийн лянхуаг дэлгэрүүлэгч” гэх Агваантүвдэний тухай тусгай зохиолд Агваантүвдэний намтар ба зохиол бүтээлийг танилцуулан өгүүлж бас түүний “Зохист аялгууны толийн тогтоосон тэмдэглэл дурдлыг тодруулагч” гэх бүтээлийг шинжилж, тус бүтээлийг бичихэд ашигласан төвд эрдэмтдийн ном бүтээл, номын хэвлэлд орсон, тус номын онцлог, судалсан арга зэргийг өгүүлжээ. Бас Агваантүвдэний зохист аялгууны амь, бие, чимгийн тухай

онол үзэлт, дуун чимэг, далдлахуй үгсийн чимгийн тухай бүтээлч өвөрмөц үзэлт зэргийг өгүүлж, бас зохист аялгууны арван гэмийн онолын эхний гурван гэм болох утга дорой, харш утгат, нэгэн утгатын тухай гэмийн онолыг нь бас шинжилсэн байдаг. Бас Агваантүвдэний “Зохист аялгууны толийн бие хийгээд чимгийн бэлгэ чанарын ялгал үлгэр өгүүлэхүйнүүдийг тогтоосон тэмдэглэл дурдлыг тодруулагч” онолын чанартай бүтээл ба “Гэтэлгэгч Дара эхийг зохист аялгууны утгын гучин таван чимгийн үүднээс магтсан буяны бэлгэт шинэ баяр хуримыг удирдагч хаврын элчийн дуун эгшиг” гэх зохист аялгууны үлгэр өгүүлэхүйн бүтээлийг нягтлан судалж, тоймчлон өгүүлж, орчуулан хэвлүүлжээ. Үүнээс гадна тус ном дахь “Хоёр дүрийн богдын номын ёнзин багш” гэх брагри лам Дамцагдорж(1782-1848)-ийн тухай зохиолд Дамцагдоржийн “Номлохуй тэмцэхүй туурвихуй”-н эрдмийг өгүүлж, түүний уран бүтээл ба зохиол туурвилын тухай зарим үзэлтийг дурдсан байдаг.



Л.Хүрэлбаатарын бэлтгэсэн **“Монгол уран зохиолын дээжис” (боть I)** “Сайн үгсийн сан”(1995)-д Агваантүвдэний “Тэтэлгэгч Дара эхийг зохист аялгууны утгын гучин таван чимгийн үүднээс магтсан буяны бэлгэт шинэ баяр хуримыг удирдагч хаврын элчийн дуун эгшиг”, Жамъянгаравын “Зохист аялгууны шигтгэл шүлэг”, Агваангэндэний “Үлэмжийн бурхан Янжинлхамыг утгын гучин таван чимгийн үүднээс магтсан магтаал адистидын наран гэрэл”, Зава Дамдин Лувсандаяны “Янжмаагийн магтаал, хадан цуурайн дуун эгшиг” (дүрст чимгийн үүднээс магтсан),

Эрдэнэ мэргэн бандид Ишсамбуу (1847-1896)-ийн “Зарлигийн ачит эцэг богд эрдэнэт багш Тойсомжамцын магтаал, наран сарны яруу чимэг” зэрэгт зохист аялгууны үлгэр өгүүлэхүйн монгол орчуулгыг оруулсан нь төвд хэлээрх монгол яруу найргийн судалгааны үнэт эх хэрэглэгдэхүүн болсон юм.



Төвдөч эрдэмтэн Л.Хүрэлбаатар нь шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан **“Дорно дахины уран сайхны сэтгэлгээний сонгодог уламжлал ба Монгол яруу найргийн онол”** (XX зууны эхэн үеийн Монголын яруу найргийн онолын дурсгал – “Эсэруагийн эгшиг дуун” буюу “Цанби даян”(1993) нэг сэдэвт зохиолдоо С.Жамъянгаравын “Цанби даян” бүтээлийг тусгайлан шинжлэн үзсэн. Энэ диссертаци нь: Удиртгал, Тэргүүн анги (2 бүлэг), Дэд анги (6 бүлэг), Дүгнэлт, Ном зүй, Дагалдуулал хэлхээ гэсэн хэсгүүдээс

бүрдэж байна.

**Удиртгал нь:** 1.Энэтхэг, Төвдийн буддын утга зохиолын уламжлал ба Монголын төвд хэлт утга зохиол. 2.Дандины “Зохист аялгууны толь”-ийн уламжлал ба монголчуудын яруу найргийн онолын сэтгэлгээ. 3.“Зохист аялгууны толь” ба түүний тайлбаруудын

судалгааны шинэ төлөв гэсэн 3 хэсгээс бүрдэж байна.

**“Дурсгалын эх бичгийн тодорхойлт”** болох тэргүүн анги нь: Жамъянгаравын намтар бүтээлийн товчоо, “Эсэруагийн эгшиг дуун” номын бүтцийг тодорхойлжээ.

**“Дурсгалын яруу найргийн онолын тодорхойлолт”** болох дэд анги нь “Утга зохиолын тухай сургаал”, “Найруулгын арван эрдэм”, “Утгын чимэг”, “Дууны чимэг” болон “Далдлах үгийн чимэг”, “Зохист аялгууны гэмийг арилгах” тухай сургаал, “Жишээ шүлэг”-т хийсэн шинэчлэл гэсэн 6 дэд бүлгээс бүрджээ.

Ханчин хамбо Жамъянгаравын яруу үгийн онолд хийсэн шинжлэл судалгааны бүтээл нь Монголын уран зохиол бол онол шүүмжлэлийн өндөр хөгжсөн сэтгэлгээтэй, утга зохиолын онолтой, онолчидтой байжээ гэдгийг гаргаж өгсөн. Мөн Монголын зохист аялгууч нар Зохист аялгууны Утгын болон Дууны чимэгт тайлбар, жишээ бичих төдийгүй, биеэ даасан монгол утга зохиолын онол туурвисныг Жамъянгаравын энэ бүтээлээр баталж өгсөн юм.



**“Эсэруагийн эгшиг дуун”**(1999).

Төвдөч эрдэмтэн доктор (Sc.D), профессор Л.Хүрэлбаатарын бичсэн Эрдэнэ мэргэн бандида, Ханчин хамба Жамъянгаравын яруу үгийн онолд хийсэн шинжлэл судалгааны бүтээл нь, буддын гүн ухааны марган хэлэлцэх аргаар бичиж, төвд хэлээр барлагдан дэлгэрч байсан 600 шахам нүүр судрыг анх удаа монгол хэлнээ орчуулж, судлан боловсруулаад, энэ нь монгол сэтгэгчийн, өөрийн утга зохиолын туршлага дээр шинээр боловсруулсан, Монгол яруу найргийн бие даасан онол

гэдгийг баталжээ.

Буддын сонгодог боловсролтон,зохиолч, яруу найрагч С.Жамъянгаравын намтар, бүтээлийн судалгааг Л.Хүрэлбаатар багш гол төлөв төвд сурвалжийн мэдээ сэлтээр хөөн гаргасан бөгөөд ялангуяа Видьяшанди буюу Цансрайгавилодойн 1918 онд төвд хэлээр бичсэн “Эрдэнэ бандид ханчин Жамъянгаравын намтар

цаглахуй санааны найлзуур модон хэмээгдэх” 51 хуудас намтар болон Жамъянгарадын төвд хэлээр бичсэн 13 боть зохиолыг эх хэрэглэгдэхүүн болгож С.Жамъянгарадын (Хүрэлбаатар Л. 1999. т.45) судалгаагаа хийжээ.

С.Жамъянгарадын намтар судлалын дараа Энэтхэгийн Дандины “Зохист аялгууны толь”, Төвдийн V Далай лам Агваанлуvsанжамцын зохиосон “Зохист аялгууны толийн бэрхийн тайлбар Сарасватийг баясгах эгшиг дуун” (188 нүүр), Монголын Агваан-Иштүвдэнгийн (XVIII-XIX) зохиосон “Зохист аялгууны толийн тогтоосны тэмдэглэл дурдлыг тодруулагч” (188 нүүр) – зэрэг уламжлалт алдарт “Зохист аялгууны толь” ба түүний тайлбаруудын харьцааг үзүүлж, Энэтхэг, Төвд, Монголын мэргэдийн туурвисан тайлбар зохиол, жишээ шүлгийн уламжлалыг задлан тайлбарлажээ.

Эдгээр уламжлалт зохист аялгууны зохиолуудын араас **Жамъянгарадын “Зохист аялгууны үндэс хийгээд тайлбарын ер утгыг сайтар агуулсан Эсэруагийн эгшиг дуун”** (282 хуудас) **зохиолын тодорхойлтыг** гаргажээ. Тухайлбал: Жамъянгарадын зохиолын нэрийн утга нь “Зохист аялгууны толь” гэдэг нь зөвхөн Дандийн нэгэн зохиолын тухайд бус, нийт зохист аялгуу буюу яруу найргийн онолын үндэс хийгээд түүний тухайд Энэтхэг, Төвд, Монголын мэргэдийн туурвисан тайлбар зохиол, жишээ шүлгийн уламжлалыг задлан тайлбарлаж, чухамдаа “Зохист аялгууны үндэс хийгээд тайлбар” нийтэд байгаа “ер утга” буюу ерөнхий утгыг хураан өгүүлснээ илэрхийлсэн санаа болно(Хүрэлбаатар Л. 1999. т.89) гэжээ.

Л.Хүрэлбаатар багш С.Жамъянгарадын “Цанби даян” номын бүтцийг маш нарийн тодорхой задалсан. Ингэхийн тулд төвд судрын хуудас болон мөрийн дугаарыг (1a1-6a4) гэж нэгд нэгэнгүй тавиад, түүнийхээ ард нийт зохиолын агуулгын гол утгыг толгой үгээр татаж 4 том хэсэгт бүлэглэн авч үзжээ. Үүнд:

( 1a1-6a4)      0.Тахилын 74 мөр шүлэг.  
( 6a6-6b3)      1.0.Нэрийн утга  
( 6b3-6b4)      2.0.Орчуулагчийн мөргөл

( 6b5-274b4)    3.0. Гол утга  
( 6b5-7b4)      3.1. Шастирт орохын үүд ...  
( 267b4-268b2) 3.IV.9. Завсрыг барилдуулахаас ангижирсан



( 268b2-274b4) 3.IV.10.Орон харшлал ... гэх мэт

( 275b5-278b2) 4.1. Ерөөлийн шүлэг

( 278b2-280b3) 4.2. Төгсгөлийн үг

( 280b3-282a3) 4.3.Хэвийн тэмдгийн ерөөлийн үг –

гэж 4 том ангид авч үзжээ. Үүнээс үзэхэд 0.Тахилын шүлэг, 1.Нэрийн утга, 2.Орчуулагчийн мөргөл, 4.Төгсгөлөөс гадна 3.Гол утга нь зохиолынх ихэнх хэсгийг (судрын 6b-274b ) эзэлж байна.



Л.Хүрэлбаатар багш Жамъянгаравын зохиолын **гол утгыг** “Зохиаст аялгууны толь”-ийн уламжлалт 3 бүлгийн хүрээгээр авахдаа 1-р бүлэгт 37 гол толгой утга татаж, 2-р бүлгийг 39 гол толгой утгад багцалж, 3-р бүлгийг 46 гол толгой үгээр багцлан авч үзжээ. Тухайлбал: “Эсэруагийн эгшиг дуун” зохиолын 1-р бүлэг нь уран зохиолын онолд хийсэн шинжлэл байна. Жишээ нь: “Зохиаст аялгууны амь” гэдэг ухаагдахууныг Жамъянгарав хэрхэн тайлбарласныг Л.Хүрэлбаатар багш “Эртний болсон цадиг, вед тэргүүтэн үгээс өгүүлэх.../бөгөөд/ түүний нөгөө талаар “дөрвөн аймагт” шүтсэн өгүүлэгдэхүүн ...нь түүний амь мөн” гэх буюу “утгыг хурааваас ... домог ба дөрвөн аймаг нь түүний өгүүлэгдэхүүн мөн”(Жамъянгарав, х.1262-3) гэжээ. Үүнээс үзэхэд “Зохиаст аялгууны амь” буюу “өгүүлэгдэхүүн” гэдэг нь үндсэндээ уран зохиолын дүрслэгдэхүүний асуудал болох нь илэрхий байна.

Иймд эртний вед шастир, үлгэр домог, цадиг намтар тэргүүтнээс ашиглаж өгүүлэхийг нэгд заасны дээр, хоёрт түүнийгээ “ном” (Т.; chos, S.; dharma), “утга” (Т.; don, S.; artha), “хүсэл” (Т.; `dod, S.; kāma), “гэтлэх” (Т.; thar pa, S.; moksa) гэдэг ертөнцийн хүний олох эдлэхийн үр болсон “дөрвөн аймаг” үзлийн үүднээс номнох ёстойг өгүүлжээ. Жамъянгарав энэ санааг тодотгож “төрөлхтний хүссэн хэргийн үр болох .... “ном”, “хэрэг”, “хүсэл”, “гэтлэх” лүгээ дөрвөн аймаг, түүний эрхэнд болсон ёсыг өгүүлсэн зохист аялгууны шастир буй(Жамъянгарав, х.1266-13a1) гэжээ. Угтаа энэхүү “дөрвөн аймгийн эрхэнд болсон зохист аялгуу” гэдгийг эртний Энэтхэг, Төвд, Монголын зохист аялгууны онолчид сайтар тайлбарласаар ирсэн уламжлалтай юм (Хүрэлбаатар Л. 1999. т.136-137) гэж шинжилжээ.

Жамъянгаравын Зохист аялгууны судалгааг шинжлэхдээ Л.Хүрэлбаатар багш уг номыг бүхэлд нь, жишээ шүлгүүдийг бүгдийг нь орчуулж, задлан шинжилсэн. Тухайлбал: “Зохист аялгууны толь”-ийн II бүлэг болох Утгын 35 чимэг, тэр нь дотроо салаалж зулзгалсан зүйл чимгийн жишээ нийт 246 бадаг шүлэг, “Зохист аялгууны толь”-ийн III бүлэг болох Дууны чимгийн нийт 130 бадаг шүлгийг орчин цагийн монгол хэлээр орчуулж жишээ шүлгүүдийг нь бүр ямар чимгийн ямар зүйл чимэг болохыг нэгд нэгэнгүй дугаарлаж нэрлэж үзүүлсэн. Энэ жишээ шүлгүүд нь “Цаглахуй санааны найлзуур мод”(2011) номд тусгайлан хэвлэгдсэн байгаа.

“Эсэруагийн эгшиг дуун”-нд “Зохист аялгууны толь”-ийн Утгын болон Дууны чимгүүдийг дэс дараалан нэрлэж, түүнээ дотор нь зүйл чимэг болгож түүний жишээ шүлгүүдийг үзүүлжээ. Үүнд:

### **2.1. Өвөрчлөнг өгүүлэхийн үлгэр**

- 2.1.1. Язгуурыг өгүүлэхийн жишээ
- 2.1.2. Үйлсийг өгүүлэхийн жишээ
- 2.1.3. Эрдмийг өгүүлэхийн жишээ
- 2.1.4. Эдийг өгүүлэхийн жишээ шүлэг

### **2.2.0. Үлгэрийн жишээ шүлэг**

- 2.2.1. Номын үлгэрийн жишээ
- 2.2.2. Бодын жишээ
- 2.2.3. Няцагчийн жишээ
- 2.2.4. Эсрэг тэсрэгийн жишээ
- 2.2.5. Магадалсны жишээ....
- 2.2.32. Үлгэрийн гэм эрдмийн жишээ...

гэх мэтээр маш нарийн нямбай дугаарлаад шүлгийг орчуулж, түүний утгын тайлбарыг хийжээ.

Доктор Л.Хүрэлбаатар багш С.Жамъянгаравын “Зохист аялгууны толь”-ийн шинжлэлд хийсэн судалгаа нь Монголын зохист аялгууч нар биеэ даасан монгол утга зохиолын онол туурвисныг Жамъянгаравын бүтээлээр баталж, энэ бүтээлдээ Жамъянгаравын хийсэн зүйлийг хураангуйлан 5 зүйлээр дүгнэсэн.

1. “Зохист аялгууны толь”-ийн үндсэн эх болон анхны Энэтхэг тайлбаруудын харьцааг маш нарийн шинжилсэн. Санскрит эхийн жишээ шүлгийг шинээр нэмж оруулсан. Ингэснээр энэтхэг, төвд, монгол шүлэглэл зүйн тогтолцоог шинжлэх боломжийг өгсөн.
2. Төвд, Монголын хэд хэдэн тайлбарын зөрөө ялгааг гаргаж өөрийн үзэл баримтлалаа дэвшүүлсэн.
3. Яруу найргийн онолын тодорхойлолтуудыг шинээр хийсэн.
4. Зохист аялгууны толийн чимгийн олон жишээ шүлгийг харьцуулж үнэлэлт өгсөн.
5. Зохист аялгууны олон чимэгт тохирох олон жишээ шүлгийг Жамъянгарав өөрөө шинээр зохиож оруулаад, онолын үүднээс нь задлан тайлбарласан. Жамъянгаравын жишээ шүлгүүд нь хийсвэр бурхадын магтаалаас ердийн бодит байдал руу, Энэтхэг, Төвдийн ахуйгаас Монголын ахуй, түүх, төр иргэний сэдэв рүү хандсан, бүтээлч дэвшилтэт хандлага болсныг онцлон шинжилжээ.

Сүрэнхорын Жамъянгарав **“Цаглахуй санааны найлзуур мод”(2011)**. С.Жамъянгаравын зохист аялгууны жишээ шүлгүүдийг Л.Хүрэлбаатар багш төвд хэлнээс орчуулж, эрдэм шинжилгээний боловсруулалт хийжээ. Энэ жишээ шүлгүүдийг Эрдэнэ мэргэн бандид, Ханчин хамбын мэндэлсний 150 жилийн ойд зориулж Жамъянгарав сангаас санаачлан хэвлэн гаргажээ. Энэ ном нь 1.Ханчин хамбо Жамъянгаравын эрдэм ухааныг нээн шинжилсэн “Найлзуур модны мөчрийн дэргэд” хэмээх Л.Хүрэлбаатарын бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл (5-48-р нүүрт), 2.Жамъянгаравын “Эсэруагийн эгшиг дуун” хэмээх зохист аялгууны онолын бүтээлийнх нь жишээ шүлэг. Ийм хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Жишээ шүлгүүдийн



тухайд “Зохист аялгууны толь”-ийн II бүлэг буюу Утгын чимгийн жишээ нь (49-113-р нүүрт), Дууны чимэг буюу III бүлгийн жишээ шүлэг (113-146-р нүүрт), адилтган гийгүүлэгчдийн жишээ (146-158 –р нүүрт), Жамъянгаравын бичсэн сул шүлгүүд (159-164-р нүүрт) оржээ.

Жамъянгаравын жишээ шүлгүүдийг төвд хэлнээс орчуулж, эрдэм шинжилгээний боловсруулалт хийхдээ Л.Хүрэлбаатар багш “Зохист аялгууны толь”-ийн Утгын болоод Дууны чимгийг

дотор нь зүйл бүрээр нь зулзгалуулан ангилан дугаарлаж, түүнд зориулсан жишээ шүлгийг нь орчуулж тавьсан нь Зохист аялгуу, түүний урлах аргатай танилцах, суралцах хүмүүст гарын авлага, арга зүй, туршлага жишээ болох туйлын ач холбогдолтой болсон. Жишээ нь:

## **2.0. “Өвөрчлөнг өгүүлэхийн” үлгэр**

### **2.1.1<sup>5</sup>. Язгуурыг өгүүлэхийн” жишээ шүлэг**

[Үнэн] сайн голди чуулганаар үүдсэний сүр жавхлан [маш] ихт  
[Үнэт] эрдэнийн сайн алтан өнгөөр өвчилдсөний баялаг эрхт  
[Өөрийн] лагшин сүүдэр нэгэн зуун насыг зооглосны  
Үл алзагч, сахаалогдадүүн орны цог байдал дүрт Ариун идээтийн  
хөвгүүн [х.7061-2]

### **2.1.2. Үйлсийг өгүүлэхийн жишээ шүлэг**


Өнө эртнээс дадан сурсан энэрэн нигүүлсэгчийн бусдын эрхээр  
Үргэлж зүг бүхнийг дүүрсэн гэгээн гэрлээр агуу заяанаас удирдан  
Үл тэсэх сахаалогдадүүн орны номхотгогдуунд сайтар гэтэлгэхийн  
мөрийг  
Үнэн дээд хувилгааны ёсоор увдислан Та тэтгэх ханиас хагацсан  
[х.7064-6]

<sup>5</sup> “Цаглахуй санааны найлзуур мод” номын жишээ шүлгүүдийн дугаар зааж буй эдгээр тооны учир нь: 2.1.1-ын 2 нь: “Зохист аялгууны толь”-ийн 2-р бүлэг. Утгын чимэг 1 нь Утгын 35 чимгийн хэд дэх чимэг болох дугаар. Ард буй 1 нь: Утгын 1 дэх чимгийн доторх зүйл чимгийн дугаарыг зааж байна.




**2.2.3. “Няцагчийн” жишээ шүлэг ...** гэх мэтээр Утгын болон Дууны чимэг түүний зүйл чимгүүдийг дугаарлаж жишээ шүлгийг орчуулан жагсаажээ.

Төвдөч эрдэмтэн Л.Хүрэлбаатар нь Зохист аялгууг судлах төдийгүй Монгол улсын орчин цагийн сургалтад Зохист аялгууны хичээл сургуулийг оруулж ирсэн багш юм. Дорно дахины болон хуучны өв уламжлалаас эргэж суралцах их өрнүүн үйлс дөнгөж эхэлж байсан 1990-ээд оны тэр үед Жамъянгаравын нэрэмжит Дорно дахины утга зохиолын дээд сургууль байгуулагдаж тэнд Л.Хүрэлбаатар багш Зохист аялгууны хичээлийг тусгайлан анх зааж, Данзан-Одсэр гавж зэрэг дээд багш нараасаа хүртсэн номын эш эрдмээ дараа хойч үеийнхэндээ уламжлуулж Монголын орчин үеийн утга зохиол судлалд “Зохист аялгууны толь”-ийн судлалыг хөгжүүлж, их дээд сургуульд Зохист аялгууны хичээл үзэж суралцах тэр их номын тэргэн замыг түүчээлсэн. Тэр цагаас хойш Их дээд сургуулийн мэргэжлийн ангид, магистр, докторантын сонгон сургалтын ангиудад Зохист аялгууны хичээл ордог болсон юм.



Х.Сүглэгмаагийн  
Зохист аялгууны хичээлийн  
тэмдэглэл



Д.Сумъяагийн Зохист аялгууны хичээлийн  
тэмдэглэл

## БНХАУ-ын Монгол үндэстний утга зохиол дахь

### Зохист аялгууны судалгааны тойм

XX зууны наяд оноос эхлэн Дандины “Зохист аялгууны толь”-ийг Дундад улсын Монгол үндэстний утга зохиол судлалын хүрээнд хэвлэн барлах, “Зохист аялгууны толь”-д хийсэн Монголчуудын тайлбар зохиолыг төвд хэлнээс монголчлон орчуулах, шинжлэн судлах ажлыг уран зохиолын онол судлаачид хийх болсон. БНХАУ-ын Монгол үндэстний утга зохиол дахь зохист аялгууны судалгааны тоймыг Ван Мандуга профессорын бичсэн ““Зохист аялгууны толь” жич монгол тайлбаруудын тухай судалгааны тойм” өгүүллийнх нь “Турав. XX зууны Дундад улс дахь судалгааны байдал” (Төвд судлал. 2017. т.71-80) хэсгийг гол эш болгон авч товч танилцуулав.

Профессор **Б.Гэрэлт** 1985 онд “Зохист аялгууны толь ба Монголчуудын онол судалгаа” (Гэрэлт, 1985. т.22-65) хэмээх судалгааны өгүүллээ бичин нийтэлж, Дандины “Зохист аялгууны толь”-ийн тойм агуулга хийгээд монгол эрдэмтдийн төвдөөр бичсэн “Зохист аялгууны толь”-ийн тайлбар, жишээ шүлгийг тоймчлон танилцуулжээ. Тус өгүүлэл нь 1.“Зохист аялгууны толь”-ийн ерөнхий танилцуулга, 2.“Зохист аялгууны толь”-д дэвшүүлсэн утга зохиолын онолын тухай хэдэн гол асуудал ба 3.“Зохист аялгууны толь” монгол зохиол ба монгол зохиолын онол судалгаанд өгсөн нөлөө гэх гурван хэсгээс бүрдэж байна. Мөн Б.Гэрэлт “Цахар гэвш Лувсанцүлтэмийн яруу найргийн ухаан” (Гэрэлт, 1985. т.66-69) гэх өгүүллийг бичиж цахар гэвш Лувсанцүлтэмийн намтар, түүний “Утгын чимгийн тийн агуулал оршвой”, “Дуун чимгийн тийн агуулал оршвой” хоёр зохиолын тухай шинжлэн өгүүлжээ.

Б.Гэрэлтийн дэглэн үйлдсэн “Нүднийг баясгахуй сувдын унжлага” хэмээх номд А.Эрдэнэбаярын монголчилсон “Зохист аялгууны толийн гурван бүлгийн жишээ үлгэрлэл оюуныг гийгүүлэгч хүзүүн чимэг үзэсгэлэнт сувдын эрих хэмээгдэх оршвой” (Агваандандар), “Үлгэрийн чимгийн үүднээс багшаа магтах магтаал эрдмийн далай уруу урсах сүжгийн мөрөн хэмээгдэх оршвой” (Агваандандар); Агваангэлэгжамъянжамцын монголчилсон “Гол мөрийн хязгаарыг шинжилсэн сүүлийн зохиол сансар нирвааны гоо сайхны өчүүхэн тайлбар цагаан лянхуан эрих хэмээгдэх оршвой” (гавж тойн Пэрлэй);

эрдэмтэн Ч.Алтангэрэлийн монголчилсон “Утгын чимгийн тийн агуулал оршвой” ба “Дуун чимгийн тийн агуулал оршвой” (Лувсанцүлтэм) зэрэг тайлбар зохиолуудыг түүвэрлэн хэвлэж эрдэмтэн мэргэдийн судалгаанд зориулан судалгааны чухал эх хэрэглэгдэхүүнийг гаргасан байна.

Профессор Б.Гэрэлт “Монгол зохиолын онол өгүүлэхүйн түүхэн шинжилгээ” гэх судалгааны номдоо Монголчуудын утга зохиолын онолын тогтолцооны үүднээс төвд хэл дээрх утга зохиолын онолыг Монголчуудын бүх онол шүүмжлэлийн гурамсан бүтцийн нэг нь болгож шинжилсэн байна. Энэ нь монгол онол шүүмжлэлийн судлалд үүдэн бүтээлч чанартай тун их ач холбогдолтой ажиллагаа болов. Монголчуудын төрөлх хэлээрх утга зохиолын онол шүүмжлэл, төвд хэлээр туурвигдсан онол шүүмжлэл, хятад хэлээр туурвисан онол шүүмжлэл нь Монголчуудын утга зохиолын онол шүүмжлэлийн үндсэн гурван бүрэлдэхүүн нь мөн бөгөөд үүнээс төвд хэлээрх онол шүүмжлэл нь нэн арвин бөгөөд түүнийг судлах явдал чухал шаардлагатай байгааг тус номд өгүүлсэн юм. Тэр номынхоо “Монголчуудын төвд хэлт онол өгүүлэхүйн хандив нэмэр хэмээх дэд бүлэг”-тээ:

1. Төвд хэлээрх үндэстний соёлын өв;
2. “Зохист аялгууны толь” болон түүний монгол дахь тусгал;
3. Монгол лам хуврагуудын онол өгүүлэхүйн онцлог ба агууламж;
4. Тогловор урлаг цам ба түүний судалгааны тухай;
5. Төвд хэлт монгол онол өгүүлэхүйн арга зүй

гэх зэрэг таван хэсгээр тусгай өгүүлжээ.

Монголчуудын нийгэм соёлын үзэгдлийг задлах ба төвд хэлээрх соёлын өвийг тоочин өгүүлж, мөн “Зохист аялгууны толь”-ийн нөлөөг гүнзгий, бүх талаар нь хураангуйлан, монгол лам нарын онол шүүмжлэлийн байр суурийг үнэлэн шүүмжилж, даруй монголчууд зохист аялгууны толийг сурч судлан онол жишээ бичихээр дамжиж “Монголчуудын утга зохиолын онолын сэтгэхүй хөгжөөнтэй шатнаа ороод, монгол утга зохиолын ухамсарсан шатанд орох явцыг түргэтгэв” (Гэрэлт, 1998. т.82) гэжээ. Тус номд Лувсанпэрэнлэй зэрэг зургаан утга зохиолын онолчийн онолын чанартай бүтээл ба үлгэр өгүүлэхүйг товч танилцуулан, монгол лам нарын төвд хэлээр


бичигдсэн онол шүүмжлэл ба үлгэр өгүүлэхүйг шинжлэхээр дамжиж, тэдний онол шүүмжлэлийн онцлог буюу амжилтыг хэдэн талаар хураангуйлан дүгнэв. Тухайлбал: баясган үйлдэх шүлгийн ухааны үзэлт бүрэлдэн тогтсон; монгол шүлгийн дүрэм болон шүлэглэхийн ёсны үндсэн зарчим боловсрогдсон; утга зохиолын дэг маяг төрөл зүйлийн тухай үндсэн ойлголт хөвөрсөн; чимгийн ухааны арга зарчим шүлэг найрагт бүх талаар найдваржих болсон зэрэг. Үүнээс гадна төвд хэлт монгол онол шүүмжлэлийн арга зүйг сүвэгчилж, жишээ шүлэг хадах судлалгааны арга тогтсон, шүлэг найраг задлан үнэлэхээр шүүмж судалгаа хийсэн; тайлал үлгэр бичих хүртээл шүүмжийн арга; харилцан маргаж ярилцах аргаар шүүмж өгүүлэл бичих зэрэг хэдэн талаар дүгнэсэн байна. Б.Гэрэлтийн шүүмжлэн тайлбарласан “Монгол зохиолын онол өгүүлэхүйн өв шүүлт” (Гэрэлт, 1998. т.82) гэх номын тэргүүн ангид Чойжи-Одсэр, Агваандандар, Ишбалжир, Лувсанцүлтэм, Намхайжамц, гавж тойн Пэрлэй, Лувсандамбийжалцан нарын тахил төгсгөлийн шүлэг, зохиолын гаргалга, шашны тайлбар зохиол зэрэг утга зохиолын онолтой холбогдох зүйлсийг түүвэрлэн оруулж, тайлбар хийсэн байна. Энэ нь төвд хэлээрх онол өгүүлэхүйн хүрээг улам нэг алхам тэлсэн явдал болов. Б.Гэрэлтийн дээрх судлалгааны амжилтыг энэ мэт хэдэн талаар дүгнэж болно. *Нэгд*, төвд хэлээрх утга зохиолын онолыг монгол онол өгүүлэхүйн гурамсан бүтцийн нэгийг нь болгож, цул утга зохиолын онолын үүднээс үнэлж шинжлэх болсон нь тус судалгаан дээр үсрэлтийн шинжтэй танилтыг буй болгожээ. *Хоёрт*, шүлгээр шүлгийг шүүмжлэх, монгол зохиолчдын зохиол бүтээлийг хэдэн урсгал бүлэг буюу хэдэн хэв намба болгон хувааж судлах зэрэг дурдлага нь хожмын судалгааны сэдвийн гогцоо болсон байна. Монголчуудын төвд хэлээрх онол өгүүлэхүйг зөвхөн “Зохист аялгууны толь”-ийн тайлбар зохиолд хязгаарласан биш, бусад төрлийн тайлбар зохиолоос бас утга зохиолын шүүмжлэл ба утга зохиолын онолын зарим асуудлыг сүвэгчилсэн нь судалгааны хүрээг тэлсэн байна.

Профессор **Сүерэ** оршил бичиж тайлбар зүүлт хадсан “Зохист аялгууны толь” гэх номыг 1986 онд хэвлүүлжээ. Тус номын оршлын I хэсэгт “Зохист аялгууны толь” нь шүлэглэл дэгээр бичигдсэн яруу найргийн тухай онолын ном мөн болохыг тодорхойлоод түүний бүтэц бүрэлдэхүүн, гурван бүлгийн агуулгыг товч танилцуулжээ. Тухайлбал: *нэгд*, зохист аялгууны бие, утгын чимэг, дуун чимгийн тухай гурван бүлгийн агуулгын тоймыг авч үзжээ. *Хоёрдугаар хэсэгт* “Зохист

аялгууны толь”-ийн бичигдсэнээс нааших Энэтхэг, Төвд, Монгол оронд дэлгэрч, олон зүйлийн бар хэвлэлээр тархсан, орчуулагдсан, судлагдсан байдлыг танилцуулжээ. Тэгээд “Зохист аялгууны толь” нь Монголчуудын дунд анх Юань улсын үе, XIII-XIV зууны үед төвдөөр дамжиж дэлгэрч эхэлсэн бололтой, Чойжи-Одсэр, Шаравсэнгэ нар зохист аялгууны онолыг сайн мэдэж байсан гэж таамаглаж болно гэж үзжээ. Дараа нь Лувсанпэрэнлэй, Ишбалжир, Лувсанцүлтэм, Агваандандар, Намхайжамц, Жамъянгарав зэрэг монгол эрдэмтэн лам нараас “Зохист аялгууны толь”-д утгын ба үгийн тайлбар хийж жишээ шүлэг хавсарган яруу найргийн ухааныг судалж байсан байдлыг танилцуулав. *Гуравдугаар хэсэгт* “Зохист аялгууны толь” Монголд дэлгэрсний дараа монгол яруу найргийн онол туурвилд нөлөөлсөн байдлыг өгүүлээд монгол сургаал шүлэг, зохиолын эхлэлийн залбирал, төгсгөлийн тайлбар шүлэг мэтийн хэлбэр, арга барил нь бараг “Зохист аялгууны толь”-ийн нөлөөнөөс болсон байх гэжээ. Тус номын ард Ш.Бирагийн 1982 онд хийсэн “Зохист аялгууны толь”-ийн шинэ орчуулгын эхийг уйгуржин монгол бичгээр хөрвүүлэн дагалдуулж, эрдэмтдийн харьцуулан судлахад зориулсан байна. Мөн профессор Сүегэ “Зохист аялгууны толь ба Агваандандарын шүлэг туурвил” (Сүегэ, 2014. т.256-260) хэмээх судалгааны өгүүлэл бичиж нийтлүүлжээ. Улаанхад хотын Ар хорчин хошууны V ёнзин гэгээн Агваангэлэгжамъянжамц (1920-1998) “Гучин хоёр үлгэрлэл чимгийн тухай” (Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 1991. т.58-72) хэмээх судалгааны өгүүлэл бичиж нийтлүүлжээ.


Профессор **Б.Бүрэнбэх** (1928-2009) “Монгол шүлгийн гоо зүйн түүхчилсэн төлөв” хэмээх онолын номдоо Дандины “Зохист аялгууны толь” Монголчуудын яруу найргийн онолын сэтгэлгээнд үзүүлсэн түүхт үйлдлийг үнэлэн чухал байранд гарган авч үзсэн юм.

Хэл бичгийн ухааны доктор, профессор **Ван Мандуга** эрдмийн зэрэг хамгаалсан ганц сэдэвт зохиол “Монгол уран зохиолын онол шүүмжлэлийн судалгаа”, мөн судалгааны бүтээл “Монгол уран зохиолын онол шүүмжлэлийн түүхэн найруулал”(1996)-аа хэвлүүлэв. Тус ном удиртгал, товч дүгнэлт, хавсралтаас гадна гол зохиол гурван бүлгээс бүрдэл болж буй. Нэгдүгээр, хоёрдугаар бүлэгт “Зохист аялгууны толь” ба түүний тайлбаруудын тухай нэлээд бүрэн тогтолцоотой нарийвчилсан судалгаа хийжээ. Зохиогч бээр урьдах хүмүүсийн судалгааны суурин дээр Монгол улсын эрдэмтэд



хийгээд Хятад улсын дотоодын монгол, төвд, хятад судлагчдын бичиж туурвисан судалгааны бүтээлийг ерөнхийлөн хураангуйлан тунгааж, “Зохист аялгууны толь”-ийн үндсэн агуулга, Монголчуудын бичсэн тайлбар зохиол, “Зохист аялгууны толь”-иос монгол уран зохиолын онол шүүмжлэлд үзүүлсэн нөлөө зэрэг үндсэн асуудлыг судлан өгүүлсэн байна. Тус номд Монголчуудын төвд хэлээрх утга зохиолын онол өгүүлэхүйг бүх монгол онол өгүүлэхүйн түүхэн дээрх чухал нэгэн бүрэлдэхүүнээр үнэлэн шинжилж,

Лувсанпэрэнлэй, Ишбалжир, Лувсанцүлтэм, Агваандандар, Агваантүвдэн, Жамъянгарав зэрэг зургаан онолчийн товч намтар, зохиол бүтээл, зохист аялгууны онолын тайлбар ба жишээ шүлгийг тус тусад нь нэлээд дэлгэрэнгүй өгүүлжээ. Түүний 2008 онд хэвлүүлсэн “Монгол уран зохиолын онол шүүмжлэлийн хөгжлийн тойм” номын “Зохист аялгууны тольд Монголчуудын хийсэн төвд тайлбар зохиол” гэх бүлэгт бас Лувсанпэрэнлэй зэрэг зургаан онолчийн товч намтар, зохиол бүтээл, зохист аялгууны онолын тайлбар ба жишээ шүлгийг тус тусад нь нарийвчлан өгүүлсэн.



Мөн Ван Мандуга оршил бичиж харгуулан тайлбарласан “Монгол хятад хоёр хэл хавсаргасан Дандины Зохист аялгууны толь”(2000) ном нь оршил, “Зохист аялгууны толь”-ийн гол зохиол, зүүлт тайлбар хийгээд хавсралт гэсэн хэсгээс бүрдэнэ. Гол зохиолын хэсэгт XVIII зууны үеийн Халх гүүш Гэлэгжалцаны орчуулга, Монгол улсын эрдэмтэн Ш.Бира, Х.Гаадан, О. Сүхбаатар нарын шинэчилсэн орчуулга хийгээд Жоо Кангийн хятад бүрэн орчуулга зэрэг гурван эхийг бадаг дараалан тохиолдуулан бичиж, бадаг

бүрийн утгыг монгол хуучин шинэ орчуулга хийгээд хятад

орчуулгатай нь харгуулан уншиж, утга санааг нь зөв ойлгож эзэмшихэд дөхөм болгож, зарим бэрх үг, нэр томъёо, үлгэр домогт зүүлт тайлбар хадав. Үүнээс гадна “Лувсанпэрэнлэй ба утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүй” (Үндэстний бүлгэмдэл, 1990:), “Ишбалжир ба Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн жишээ одны эрихэс” (Үндэстний бүлгэмдэл, 1990:), “Лувсанцүлтэм ба утгын чимгийн тийн агуулал оршвой тэргүүтэн” (Үндэстний бүлгэмдэл, 1990:), “Агваандандар ба түүний яруу найргийн тухай судлал шинжлэлийн зохиол” (Үндэстний бүлгэмдэл, 1990:), “Жамъянгарав ба Зохист аялгууны толийн үндэс тайлбарын ерийн утгыг сайтар агуулсан эсэруагийн дуун эгшиг”, “Агваантүвдэн ба Зохист аялгууны толийн тогтоосны тэмдэглэл дурдлын тусгал” (Үндэстний бүлгэмдэл, 1990:), “Зохист аялгууны толь ба монгол шүлгийн онол” (Монгол хэл утга зохиол, 1994:), “XVII-XX зууны эхний үеийн монгол уран зохиолын онол шүүмжлэл” (Монгол хэл утга зохиол, 1996:), “Зая бандид Лувсанпэрэнлэй ба түүний тайлбар зохиол дахь зарим жишээ шүлгийн тухай” (Ван Мандуга, 2014:), “Лувсанцүлтэм ба түүний Зохист аялгууны тольд хийсэн тайлбар зохиолын тухай шинжлэл” (хятад хэл), “Зая бандид Лувсанпэрэнлэй ба түүний тайлбар зохиол дахь зарим жишээ шүлгийн тухай” (шинэ үсгээр) (Төвд судлал сэтгүүл, 2014:), “Лувсанцүлтэм ба түүний Зохист аялгууны тольд хийсэн тайлбар зохиолын тухай шинжлэл” (хятад хэлээр) (Өвөр монголын Багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 2014:), “Алшаа лхаарамба Агваандандар хийгээд түүний тайлбар зохиол” (Улаанхадын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 2014:), “Агваандандарын зохиол бүтээл ба жишээ шүлгийн тухай” (Оюуны хэлхээ сэтгүүл, 2015:) зэрэг өгүүлэл зохиолыг нийтлүүлсэн байна. Бас “Монгол соёл судлалын цуврал бичиг, уран зохиолын онол шүүмжлэл” гэх номдоо Монголчуудын төвд хэлээрх онол шүүмжлэлийн тухай авч үзсэн байдаг.

Ван Мандуга профессор 2012 онд Л.Хүрэлбаатар, Д.Сумъяа нартай хамтран харгуулж найруулсан “Таван зүйлийн үсэг хадмал Зохист аялгууны толь” ном хэвлүүлэв. Энэ ном нь удиртгал, зохист аялгууны толийн эх, зүүлт тайлбар, хавсралт гэх дөрвөн хэсэг агуулгаас бүрдэж буй. Төвд Данжуур болон уламжлалт монгол орчуулгын эх, Ш.Бира нарын шинэчилсэн орчуулгын эх, Ван Мандугагийн харгуулан найруулсан “Монгол хятад хоёр хэл хавсаргасан Дандины Зохист



аялгууны толь” зэрэг олон эхүүдийг харгуулан харьцуулж, “Зохист аялгууны толь”-ийн эхийг бадаг мөр болгон шүлэглэсэн байдлаар, төвд үсэг, вали галиг, кирил үсэг, хятад үсэг, уйгуржин монгол бичиг (шинэ хуучин орчуулга) гэсэн таван зүйлийн үсэг (зургаан эх)-ээр хэвлэж, уншигч судлагчдад хүргэснээрээ шинэлэг болжээ. Номын сүүлд 305 зурвас нарийн тодорхой зүүлт тайлбар хийсэн. Мөн 1847 оны Бээжин барын Монгол “Данжуур”-т орсон “Зохист аялгууны толь”-ийн уул эхийн гэрэл зургийн буулгаврыг хавсаргажээ.

Доктор **А.Эрдэнэбаяр** нийтэлсэн “Заяа бандид Лувсанпэрэнлэйн утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүй Эсэруагийн охиныг баясгах эгшиг дуулал оршвой хэмээх шүлгийн чимгийн ялгалыг тодлох нь” (Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 1999:), “Агваандандарын зохиол туурвих үзэлт” (Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 1999:), “Туурвихуйд үзүүлсэн монгол төвд эрдэмтдийн өвөрмөц хувь нэмүүр - мэргэд орохын хаалга хийгээд сайн номлолын нарны гэрлийн харьцуулсан шинжлэл (нэг), “Зохист аялгууны амь, бие, чимгийн онол”, “Сүмбэ хамба жич түүний зохиол бүтээлийн судлал” (Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 2003:), “Зохист аялгууны нийтийн чимгийн тухай” (Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 2003:), “Зохист аялгууны гэм” (Монголын судлал сэтгүүл, 2004:), “Саж бандид Гунгаажалцаны Зохист аялгууны онол, үзэл баримтлал” (Төвд судлал, 2013. т.102-114) зэрэг өгүүлэлд монгол эрдэмтдийн зохист аялгууны онол үзэлт ба зохиол туурвихуйн онолыг шинжилж, Монголчуудын төвд хэлээр туурвисан бүтээлч оролдлогыг тодорхойлон үнэлжээ.

А.Эрдэнэбаярын 2002 онд докторын зэрэг хамгаалсан “Ишбалжирын зохист аялгууны үлгэр өгүүлэхүй хоёр зүйлийг орчуулж тайлбарлаж шүүмжлэх нь” гэх өгүүллийн засвар нөхвөр болсон “Ишбалжирын шүлэг зүйн судлал” гэх том бүтээл 2004 онд хэвлэгдэв. Тус бүтээл Ишбалжирын “Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн үлгэр өгүүлэхүй одон мичдийн үзэсгэлэнт эрихэс ба илт



өгүүлэхүй нэрийн товч хураангуй чандманийн унжлага хэмээгдэх оршвой”, “Үгсийн чимгийн өчүүхэн хураангуй зохист аялгууд орох үүд оршвой” гэх төвдөөр туурвисан хоёр зохиолыг бүрэн бүтэн орчуулж судалсан юм. Үүнд эхний зохиол нь мөргөл өгүүлэхүй шүлэг, зохист аялгууны амь, бие, чимгийн ухагдахуун жич зохист аялгууны арван мөрийн үлгэр өгүүлэхүйн тухай шүүмж тайлбар, утгын гучин таван чимгийн онол ухагдахуун ба үлгэр өгүүлэхүйн судалгаа, дууны чимэг, нууц үгсийн чимэг, гэмийг арилгагчийн онол үзэлт хийгээд үлгэр өгүүлэхүйн шинжлэлийг багтаав. Дараагийн хоёрдахь зохиол нь утгын чимгийн үлгэр өгүүлэхүйн шүүмж тайлбар, дууны чимгийн үлгэр өгүүлэхүйн шинжлэл гэх хоёр хэсгээс бүрдэж байна. Судалгаа нь орчуулах, тайлбарлах, шүүмжлэх гурван байдлаар хийгдэж, Ишбалжирын зохист аялгууны онол үзэлт ба жишээ шүлгийг нэгд нэгээр судлан шинжилсэн байдаг. Тус бүтээл Монголчуудын дунд өнө удаан хугацаанд оньсого шиг нуугдсан Ишбалжирын зохист аялгууны тухай онолын бүтээлийг олонд танилцуулсан ба бас гүнзгий задлан шинжилгээ хийж, Монголчуудын төвд хэлээрх утга зохиолын онолын судалгаанд нэг шинэ алхам болсон. Тус бүтээл нь: *нэгд*, Ишбалжирын зохист аялгууны тухай онол үзэлт ба үлгэр өгүүлэхүйг нэг нэгээр системтэй тайлбарлан өгүүлэв. *Хоёрт*, энэтхэг төвдийн бурхны шашны нэр томъёог нарийн тайлбарлав. *Гуравт*, одоо үеийн утга зохиолын онолын үүднээс Ишбалжирын онол үзэлтийг тайлбарлан өгүүлж, түүний өвөрмөц онцгой онолын үнэ цэнийг тодруулан өгүүлэв. *Дөрөвт*, Ишбалжирын зохист аялгууны онол үзэлтийг тайлбарлахдаа, зохист аялгууны толийн үндсэн онолын ухагдахуун ба жишээ шүлэгт тайлбар хийж, Дандины зохист аялгууны үлгэр өгүүлэхүйг ойлгомжтой болгон тайлбарлаад бас зохих шинэ үзэлт дурдав. Жишээлбэл зохист аялгууны мөрийн онолыг утга зохиолын урсгал бүлгийн онол гэж үзсэн нь хятад эрдэмтдийн үзэж байсан хэв намбын онол гэх үзэлтээс ялгагдах болов.

Профессор **С.Урсгалын** “Монгол шүлэг зүйн түүхэн тогтолцоо” гэх доктор зэрэг хамгаалсан өгүүлэлд шүлэг зүйн үүднээс Монголчуудын “Зохист аялгууны толь”-ийн тухай жишээ өгүүлэл тайлбар судлалыг ажиглаж, монгол лам нарын төвд хэлээр бичиж, судалсан зохист аялгууны онол үзэлт нь монгол шүлэг зүйн анхан шатыг бүрэлдүүлсэн бөгөөд энэхүү шат үе дахь монгол шүлэг зүй нь хэлбэрч хандаштай гэж дүгнэсэн байна. Энд Монголчуудын төвд хэлээр туурвисан зохист

аялгууны тухай онол ба жишээ шүлгийг монгол шүлэг зүйн анхан шат болгон үзсэн нь түүний өвөрмөц онцлог болов. Тус бүтээлд, монгол лам нарын шүлэг зүйн бүрэлдэл ба онцлогийг авч үзэхдээ Энэтхэг, Төвд, Монголын соёлын харилцааны нийгэм түүх соёлын үзэгдэл дунд тавьж, монгол лам нарын дурдсан амь, бие, чимгийн харьцаан дундах биеийн тухай хэсэг онол үзэлт, энэтхэгээс ирэлттэй чимгийн онол ба түүний тухай Монголчуудын зарим үзэлт дурдлагад бодитой задлан шинжилгээ хийсэн байдаг.

Доктор **Шү Лин** 2009 онд дэд эрдэмтний зэрэг хамгаалсан “Зохист аялгууны гэмийн онолын ерөнхийлсөн судлал” өгүүлэлдээ Дандины “Зохист аялгууны толь”-ийн гэмийн онолын эх ирэлтийг шинжлэн үзэж, “Зохист аялгууны толь”-ийн үндсэн арван гэмийн ухагдахуун ба жишээ шүлгийг нарийн шинжилж, гэмийн онолын Төвд орон дахь хөгжлийн байдлыг Тавдугаар далай ламын онол ба үлгэр өгүүлэхүйгээр жишээлэн өгүүлж, Монголчуудын гэмийн онолыг бүх талаар системтэй нарийн судалж шинжилсэн байдаг. Зохист аялгууны гэмийн онолыг зохист аялгууны бүх онолын тогтолцоо доторх чухал нэгэн бүрэлдэхүүн хэсгээр үзэж, гэмийн онолын тогтолцоо, монгол лам нарын гэмийн онолын тухай бүтээлч хөгжүүлэл ба өвөрмөц зүтгэлийг үнэлэн шүүмжлээд, тэдний онол өгүүлэхүйд агуулагдсан утга зохиолын онол ёсыг тодруулан өгүүлэв. Тус өгүүлэл нь бас Монголчуудын төвд хэлээрх утга зохиолын онол өгүүлэхүйн судалгааны чухал нэгэн бүтээл болсон юм. Шү Линий “Зохист аялгууны самадийн эрдэм” (нэг, хоёр) (Дундад улсын монгол судлал, 2008. т.2009:), “Зохист аялгууны гэмийн онол” (нэг, хоёр), “Агваантүвдэний зохист аялгууны гэмийн онолыг шинжлэх нь” (Шү Линь, 2009:), “Агваантүвдэний бүжгийн есөн дүрийн онол үзэлтийг ажиглах нь” (Дундад улсын монгол судлал, 2010:), “Зохист аялгууны утга дорой гэмийг шинжлэх нь” (Шү Линь, 2010:), “Зохист аялгууны харш утгатын гэмийг шинжлэх нь” (Шү Линь, 2010:), “Зохист аялгууны нэгэн утгатын гэмийг өгүүлэх нь” (Шү Линь, 2010:), “Утга зохиолын орон цагийн тухай нэгэн зүйлийн үзэлт - зохист аялгууны орон цаг лугаа харшлагч гэмийг өгүүлэх нь” (Өвөр монголын Үндэстний их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 2011:), “Монгол утга зохиолын онол өгүүлэхүйтэй холбогдох төвд сурвалж бичгийн тухай” (Шү Линь, 2013:), “Сажа бандид хийгээд Алшаа лхаарамбын туурвихуйн үзэл баримтлалын харьцуулал” (Шү Линь, 2013:), “Агваандандарын утга зохиол тайлбарлах арга

онолыг сүвэгчлэх нь” (Шү Линь, 2014:) зэрэг өгүүллүүдэд, монгол лам эрдэмтдийн зохист аялгууны гэмийн тухай бүтээлч онол үзэлт, тэдний онол өгүүлэлтэд агуулагдсан утга зохиолын онол ёс, бүжгийн есөн дүрийн өвөрмөц онцгой онолын үзэл баримтлал, тэдний судлал шинжлэлийн үнэ цэнийг тодруулан өгүүлжээ.

Профессор **Чулуу**(1947-2013) “Цахар гэвш Лувсанцүлтэмийн утга зохиолын онолын үзэлтийг нарийвчлан шинжих нь” гэдэг өгүүлэлдээ, Лувсанцүлтэмийн зохист аялгууны толийн тухай тайлбар зохиол нь шүлгийн урлагт хийсэн гоо сайхны тайлал болох төдийгүй Монголын лам эрдэмтдийн яруу найргийн тухай гоо сайхны хөөцөлдөл болно гэж дурдаад, Лувсанцүлтэмийн тайлбарласан тансаг чимэг, нарийны чимэг, таалалт чимэг зэрэг хэдэн чимгийн тухай тайлбарыг шинжилж, таалалт чимэгт “уран бүтээлчийн зохион бүтээх сэрэгдэл, зохион бүтээх өдлөг, гоо таашаал, гоо ухвар болон гоо дуршлыг өгүүлсэн” (Чулуу, 2009. т. 377-401) гэж үзсэн байна.

**Одончимэгийн** 2007 онд дэд эрдэмтний зэрэг хамгаалсан өгүүлэл нь “Агваандандарын зохион туурвих үзэл санаа - сайн номлолын нарны гэрлийн орчуулга шүүмж, тайлбар хийгээд судлал”-д Агваандандарын “Номлохуй, тэмцэхүй, туурвихуй - сайн номлолын нарны гэрэл хэмээгдэх оршвой” гэх зохиолыг орчуулан тайлбарлаж, бас одоо үеийн утга зохиолын онолын үүднээс Агваандандарын зохион туурвих үзэл санааг системтэй шинжлэн үзжээ.

**Дашийн** 2008 онд дэд эрдэмтний зэрэг хамгаалсан өгүүлэл “Зохист аялгууны толийн өгүүлэгдэхүүн утга хийгээд амийн тухай шинжлэл”-д толийн үндсийн өгүүлэгдэхүүн утга ба төвд эрдэмтдийн амийн онолд шинжлэлт хийсэн суурин дээр Монголчуудын зохист аялгууны амийн онолыг судалж, одоо үеийн утга зохиолын онолын хараанаас тайлбарлан өгүүлсэн байна.

Төвийн Үндэстэний их сургуулийн профессор **М.С.Өлзийгөөс** “Монголчуудын төвдөөр туурвисан уран зохиолын судлал” гэх номдоо Лувсанпэрэнлэй, Ишбалжир, Лувсанцүлтэм, Агваандандар, Агваантүвдэн нарын зохист аялгууны жишээ шүлгийг судлан шинжилж үнэлэн шүүмжилсэн юм.

**Мөнгөнчимэгийн** “Чимгийн онол Зохист аялгууны судлалд” (Монгол хэл бичиг, 2001:) гэх өгүүлэл ба Нарангоогийн “Зохист аялгууны толийн монгол үндэстний шүлгийн онолд өгсөн нөлөө” (娜

仁高娃 “ ‘诗镜论’ 对蒙古族诗论的影响” , “内蒙古师范大学学报” ,2003:) гэх өгүүлэлд бүр “Зохист аялгууны толь”-ийн монгол лам нарын онол ба шүлэг бүтээлгэд үзүүлсэн нөлөөг өгүүлэх явц дунд монгол лам нарын туурвихуйн тухай үзэлт, амь, бие, чимгийн тухай зарим онол ухагдахууныг дурдан өгүүлсэн байна.

Төвийн үндэстний их сургуулийн докторант **Цай Юнь** “Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн үлгэр өгүүлэхүй одон мичдийн үзэсгэлэнт эрихэс ба илт өгүүлэхүй нэрийн товч хураангуй чандманийн унжлага хэмээгдэх оршвой хэмээх тайлбар зохиолын онцлогийн тухай мөчид өгүүлэх нь” (Төвд судлал, 2014. т.148-155) өгүүлэлдээ Сүмбэ хамба Ишбалжирын тайлбар зохиол “Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн үлгэр өгүүлэхүй одон мичдийн үзэсгэлэнт эрихэс ба илт өгүүлэхүй нэрийн товч хураангуй чандманийн унжлага хэмээгдэх оршвой”-г задлан шинжилж, тус бүтээл нь “бурхан шашны уран зохиолын тахилын шүлгээр эхэлж, шашин номын дэлгэрэн хөгжих буюу сайн сайхан ололт олохыг хүсэн мөрөөдөж, өлзий өгүүлэх маягаар зохиолоо төгсгөдөг бүтцийн хэлбэрийг ашигласан бөгөөд бүхий л зохиолд шүлгийн толгой холбоцыг их чухалчилж, илт өгүүлэхүй нэрээ шүлгийн толгой холбоцын тойрондоо маш сайхан сонгон хэрэглэсэн бөгөөд “Зохист аялгууны толь”-д үргэлж хэрэглэгддэг уран найруулгын олон зүйрлэл, адилтгал, давталт мэтийн аргыг тохитой ашиглажээ” (Төвд судлал, 2014. т.148-155) гэж бичжээ.

## ХОЁР. ДАНДИНЫ “ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛЬ”-ИЙН БҮТЭЦ, ТОВЧ АГУУЛГА

**Зохист аялгууны толь.** Дандин (са. *kāvyaḍarṣa*, тө. *snyan ngag me long*). Үг чимгийн шастир Зохист аялгууны толь хэмээх оршив. Энэтхэгийн хэлээр “Кавьядарша”, төвдийн хэлээр “Нян-агжи мэлон”, монголын хэлээр “Зохист аялгууны толь”. “Зохист аялгууны толь” (*kāvyaḍarṣa*) хэмээхийн “Kavi” нь “зохист аялгуу” буюу “яруу найраг, шүлэг” гэсэн утгатай “a” нь “бүгд бүхэн”, “darsa” нь –“харагдах” гэсэн утгатай. Иймд сүүлийн хоёр үг нийлээд “бүгд харагдах буюу толь” гэсэн утгатай (ДЗАТ. 1982. т.11).

“Зохист аялгууны толь” нь нийтдээ 657 орчим бадаг шүлэг бүхүй гурван бүлгээс бүрддэг. Нэгдүгээр бүлгийн 105 бадаг шүлэгт: зохист аялгууг туурвих, түүний эрдэмд суралцах, утга зохиолын онолын зүйлийг өгүүлжээ. Хоёрдугаар бүлгийн 365 бадаг шүлэгт яруу найргийг урнаар дүрслэхийн уг чанарыг нээсэн утгын 35 чимгийг тодорхойлж, ямар аргаар утгын чимгийг илрүүлбэл сая хүний сэтгэлийг хөдөлгөж чадахыг харуулжээ. Энэ II бүлэгт өгүүлж буй утгын чимгийг Өрнө, Дорно хоёр урсгалын аль аль нь нийтдээ таалдаг. Утгын 35 чимэг нь “Зохист аялгууны толь” зохиолын гол зүйл болно. Гуравдугаар бүлгийн 187 бадаг шүлэгтээ найруулан туурвих дууны чимгийн эрдмийг өгүүлжээ. Ингэхдээ зөв урнаар найруулах аргыг Дуун чимэг, арван зургаан далдлахуй аялгуус ба шүлгийн арван гэм гэсэн гурван зүйлээр хуваан гаргажээ. Өөрөөр хэлбэл шүлгийн байгуулалт, айзам хэмнэл, найруулгын тухай өгүүлжээ.

Дандины “Зохист аялгууны толь”-ийн бүтэц, агуулга, утга санааг энд тоймлон өгүүлэхдээ “Зохист аялгууны толь”-ийн өөрийнх нь бүтэц, агуулгын дэс дарааллын дагуу чимгүүдийн тодорхойлт жишээг үндсэн эхээс нь эш татаж бичив. Ингэснээр “Зохист аялгууны толь” гэж юу болох түүний агуулга санаа юу болохыг үзүүлэхийг хичээв. Ингэхдээ “Зохист аялгууны толь”-ийн гол ухагдахуун, утгын болоод дууны чимгийн үндсэн ойлголт, жишээ зэргийг Дандины “Зохист аялгууны толь”-ийн үндсэн эхүүд үүнд: Ш.Бира нарын орчин цагийн монгол хэлээр орчуулсан “Дандины Зохист аялгууны толь” (1982), “Таван зүйлийн үсэг хадмал Зохист аялгууны толь” (Хамтын бүтээл.)

“Төвд, Монгол Данжуурын “Дандины Зохиист аялгууны толь”(2017) зэрэг эхүүд, мөн “Зохиист аялгууны толь”-ийн Утгын болоод Дууны чимгүүдийг зүйлчлэн жагсааж, шинжилсэн Ч.Алтангэрэлийн “Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл”(1967), Л.Хүрэлбаатарын “Эсэруагийн эгшиг дуун”(1999), С.Жамъянгарав “Цаглахуй санааны найлзуур мод” (2011. Жишээ шүлгийг орчуулж, шинжлэсэн Л.Хүрэлбаатар) судалгааны бүтээлүүд болон ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс гаргасан “Дандины “Зохиист аялгууны толь”-ийн гол нэр утгын тайлбар” (хамтын бүтээл. Д.Сумъяа, П.Ням-Очир, Ж.Ерөөлт, Б.Няммягмар, Б.Лхагважав. 2017) зэрэг судалгааны ном бүтээлийг гол эш эх болгон барьж найруулан Дандины “Зохиист аялгууны толь”-ийн агуулгыг танилцуулав.

### **Мөрийг сайтар ялгасан бүлэг<sup>6</sup>**

Мөрийг сайтар ялгасан бүлэг хэмээх нь Дандины “Зохиист аялгууны толь”-ийн нэгдүгээр бүлгийг ийн нэрлэдэг. Энэ 105 бадаг бүхий I бүлэгт Зохиист аялгууг туурвих, түүний эрдэмд суралцахын ач холбогдол, түүнд эс суралцахын гэм алдаа юу болох, мөн зохиист аялгууны бие гэж юу болох, зохиист аялгууг яруу уран дүрслэж найруулах зам мөрийн тухай онол аргын тухай өгүүлжээ. Үүнд эртний Энэтхэгийн уран зохиолын хоёр гол чиглэл болох Өмнийнхөн, Дорныхны урсгалын ялгаа болон нийтлэг талыг гаргажээ. Мөн зохиол нь шүлэг, үргэлжилсэн, холимог гэсэн 3 зүйлтэй гээд тус бүрийн онцлог шинжийг гаргажээ. Бас аливаа зохиолын зохиомж, хэлбэрийг номлосон.

Дандин бээр бас алив зохиол нь эхлэхдээ залбирал мөргөл өлзий өгүүлээд дараа нь юуны тухай бичихээ өгүүлдэг уламжлалын дагуу Зохиист аялгуугаа зохиохдоо эхлээд яруу найргийн охин тэнгэр Сарасватид хандан

Чатур мука-гийн нүүр дэх бадмын цэцэрлэг дэх

Галууны охин мэт цагаан

Сарасвати чи нь миний зүрхэнд

Насад суун соёрх (ДЗАТ. 1982. т.11)

гэсэн **залбирал мөргөл шүлэг** өгүүлжээ.

Залбирал мөргөл шүлгийнхээ араас Зохиист аялгууг номлохоо

<sup>6</sup> Мөрийг сайтар ялгасан бүлэг (“Дандины “Зохиист аялгууны толь”-ийн гол нэр утгын тайлбар”. Хамтын бүтээл. 2017. т.34-64)-ийг төвдөч эрдэмтэн П.Ням-Очир хийжээ.

амласан үгээ амлажээ. **Номлохыг амласан үг** (тө: btzams par dam bca' ba) нь зохиох зүйлийнхээ гол агуулга утга санааг хураангуйлан нэгтгэн зангидаж өгүүлэх шүлэглэл юм. Дандин бээр “Зохист аялгууны толь” зохиохын учраа:

Эртний шастируудад хураан найруулсан

Эрхэм бүхнийг үлгэрлэн жишиж

Чадах чинээгээрээ би

Зохист аялгууны бэлэг чанарыг өгүүлсүгэй (ДЗАТ. 1982. т.12)

гэсэн энэ амлалт шүлэг буюу номлохыг амласан үг нь Дандин бээр өөрөөсөө өмнө гарсан алдартай бүх шастируудыг хураан цуглуулж үзээд, түүний доторх эрдэм найруулгуудыг үлдээлгүй нарийн нягт судласан түүнийхээ үндсэн дээр яруу найргийн мөн чанарыг өгүүлье гэжээ. Ингээд зохист аялгууны бэлэг чанарын утга агуулга тодорхойлт жишээг гурван бүлэг 657 бадаг бүхий шүлгээр номлон “Зохист аялгууны толь”-ийг бүтээжээ.

**Эртний шастирууд** гэж "Вьяса (са: vyasa, тө: rgyas pa, мо: delger-inggüi/ аршийн (са: rṣi, тө: drang srong, мо: arasi/ зохиосон "Бхаарата" /"bharata"/ хэмээх бум илүү шүлэгт, Галчилан орогчийн охины (тө: me bzhin 'jug gi bu mo/ зохист аялгууны бясалгалын ном (тө: sGom pa'i chos), Валмийка (са: Valmīka, тө: gRog mkhar, мо: sirgyljin-u üliytü/ аршийн зохиосон Раамаяна (са: Rāmayana/ хэмээх хаан ба хатан Ролнэдмагийн /Rol snyed ma/ домгийг зохист аялгуунд найруулсан буман шүлэгт, Мааркандэяагийн (са: Mārkaṇḍeya/ үйлдсэн урьд гарсан 18 үе буюу "урьд үеийн ном" хэмээгч Вишнүгийн (са: Viśṇu/ орлого тэргүүтнийг үзүүлсэн, "Зохист аялгуу аштадааша-сура" (са: aṣṭadāśasura/ хэмээх бум илүү шүлэгт, Каалидаасын (са: Kālidāsa, тө: Nag mo'i khol po, мо: Qaqa цкин-ь jaradusan/ зохиосон "Зохист аялгуу залуу болсон" (са: Kumārāsambhava, тө: gShon nu 'byung ba, мо: jilayu boluysan), Раама Шарма (са: Rāma Śarma/ тэргүүтний зохиосон "Зохист аялгууны шастир-рагху-вамса (са: raghu-vamśa/" хэмээх 1080 шүлэгт тэргүүтэн" (Хүрэлбаатар, 1993. т.56-57) зохиолуудыг хэлж байна.

**Зохист аялгууг туурвихын хэрэг учир** (тө. brtsams pa'i dgos sogs) Дандин бээр эртний Энэтхэгийн яруу найргийн алдарт зохиолуудыг судлан үзсэний үндсэн дээр зохист аялгуу буюу яруу найргийн мөн чанарыг тайлбарлан өгүүлсэн(ДЗАТ. 1982. т.12). Үүндээ юуны хэрэг учирт зайлшгүй зохиох ёстойг Дандин “Зохист аялгууны толь”-ийн I

бүлгийн 3-9 дэх шүлгүүддээ 7 зүйлээр өгүүлсэн. Үүнд: Зохист аялгууны эрдэм гэж юу болох, Зохист аялгууг зохиохгүй байвал ямар гэм гарах юм, яагаад сайн зохиол бүтээл өнө мөнхөд оршдог учир мөн чанар нь юу болох, зохист аялгууг зохиогч нь эрдэм мэдлэгтэй мэргэн оюут байвал ямар сайн болох, зохист аялгуу зохиол бүтээл туурвилд алдаа буруу гаргавал ямар гэм орших юм, зохист аялгууны шашдир буюу энэхүү онол туурвилын ном эрдмийг эс мэдснээр ямар гэмд хүрч болох тухайд - гэх зэрэг Зохист аялгууны хэрэг учрыг өгүүлжээ. Энэ долоон зүйлээр өгүүлснийг төвдөч эрдэмтэн зохист аялгууч Л.Хүрэлбаатар “Зохист аялгууны шастир” (Л.Хүрэлбаатар. Судар шастирын билиг. 2002 он. т.201-257) өгүүлэлдээ ийн тайлбарлажээ. Үүнд:

**Зохист аялгууг туурвихын эрдэм** (тө. brtsams pa'i yon tan) нь хамаг багшийн заан сургасан эрдмийн ачаар төрөлхтнийг ертөнцийн ёсонд оруулах нь туурвихын эрдэм болно гээд

Энэ ертөнцөд насан үүрд дээдэс ч

Эрхэм дээдсийн тийн өгүүлсэн

Мөнхүү үгсийн хүчээр л

Мөн ертөнцийн ёсонд тийн орьюу (ДЗАТ. 1982. т.12) – гэж Зохист аялгуунд мэргэн болохыг хүссэн их дээд мэргэд, эртний багш мэргэдийн араас даган орж, тэдний сургаж үзүүлсэн шастир сургаалын сайн үгсийн ач эрдмээр сая ертөнцийн явдал ёсон, авах огоорохын учир утгыг хотол төгсгөн, хүссэн хэрэг зорилгыг сайтар бүтээж чадахыг өгүүлжээ(Л.Хүрэлбаатар. 2002 он. т.213).

**Зохист аялгууг эс зохиосны гэм** (тө. ma brtsams pa'i skyon) нь зохист аялгуу үгүй бол төрөлхтөнд ямар гэм болохыг

Хэрвээ дуу, утгын зохист аялгууны гэгээ

Орчлон дахинаа эс гэрэлтвээс

Энэ гурван ертөнц бүгдээрээ

Эгнэгт балай харанхуй больюу (ДЗАТ. 1982. т.12) гэсэн нь зохист аялгууг туурвиж байж, түүний ачаар хүн төрөлхтний оюун санааг гэрэлтүүлж байх учиртайг хэлжээ. Өөрөөр хэлбэл Зохист аялгууны чанарт шастир зохиолын гэгээгээр хорвоог хэдий чинээ орших хүртэл нь гийгүүлэн эс чадваас, тэнгэр лус хүмүүний гурван ертөнц даяараа сайн мууг эс ялгахын балай оюуны зузаан харанхуйд бүрхэгдсэн хэвээр байхын гэмтэй болохыг өгүүлжээ (Л.Хүрэлбаатар. 2002. т.213).



**Зохиол өнө үүрд оршихын учир** (тө. brtsams pa de ring du gnas pa'i rgyu mtshan) юу гэвэл зохист аялгууны чанарт толиноо туссан аялгуу нь өнө мөнхөд оршино гэсэн санаа юм.

Эртний хаадын дүрс  
Аялгууны мөн чанарт толинд тусваас  
Эдүгээ тэдгээр нь үл оршивч эс бууран  
өөрсдөө хэвээр оршихыг үзэгтүн (ДЗАТ. 1982.12)

гэсэн нь эртний хаадын баатарлаг үйл явдал, алдар нь яруу найргийн зохиолд тусаж үлдвээс л тэдгээр хаад одоо эс оршивч алдар суу нь эс бууран хэвээр эдүүгээ ч байгаа мэт байна гэж яруу найргийн хүч чадлыг магтжээ (ДЗАТ. 1982.12)

**Зохист аялгууг туурвигчийн мэргэн, мунхгийн ялгаа** (тө. rtsom byed mkhas rmongs kyi khyad par) гэдэг нь Зохист аялгууг туурвигч нь зохист аялгууны эрдэмд суралцаж, билэг оюунаа нээгдүүлэхийн чухлыг өгүүлжээ. Дандин:

Үнэхээр сайн найруулсан аялгууг мэргэд  
Аялгууны хүслийг хангагч хэмээн өгүүлэлдью  
Үнэнхүү түүнийг буруу найруулбаас  
Аялгуу найруулагч түүнийг үхэр хэмээюү (ДЗАТ. 1982. т.13)

Энэ шүлэгт зохист аялгуучийн сайн найруулсан бүтээлийг хүслийг хангагч хэмээж, харин сул дорой найруулахыг чухам үхэр хэмээнэ гэсэн нь зохист аялгуунд суралцсан эрдмийн үрээр бүтээх туурвигчийн мэргэн, мунхгийн ялгааг тодорхой өгүүлжээ.

**Туурвилын гэмийг тэвчих арга** (тө: rtsom pa'i skyon spong thabs) нь зохист аялгууг зохиож туурвихдаа зохиогчоос зохиолдоо өчүүхэн боловч гэм гаргаж болохгүй, гэмийг тэвчих ёстой учрыг өгүүлжээ.

Тийм учир зохист аялгуунуудад  
Өчүүхэн гэм гарсан ч үл ойшоон бүү үйлд.  
Бие хичнээн гоо сайхан ч  
Өчүүхэн гэмээр муу заяат больюю (ДЗАТ. 1982. т.13)

Энд зохиол бүтээлд аливаа гэмийг ч хэрхэвч гаргаж болохгүй гэсэн санааг бие үзэсгэлэнтэй ч ганц өчүүхэн төдий гэмээр муу хувьт болно гэж жишээлж туурвилын гэмийг тэвчих ёстойг өгүүлжээ.

**Шастирыг эс мэдсэний гэм** (тө. bstan bcos mi shes pa'i skyon).

Зохист аялгууны эрдэмд суралцах нь маш чухал болохыг:

Зохист аялгууны шастирыг үл мэдэгч нь  
Эрдэм, гэмийг нь хэрхэн ялгах билээ.  
Дүрсийн ялгааг олох чадал  
Сохор хүмүүст байж болох уу даа! (ДЗАТ. 1982. т.13)

гэж Зохиист аялгууны онол, сургаалыг судалж мэдээгүй хүн зохиол бүтээлийн сайн мууг ялгаж чадахгүй нь дүрсийн ялгааг үл ялгах сохор хүн мэт гэж зүйрлэжээ (ДЗАТ. 1982. т.13).

**Мэргэний сайны ялгаа** (тө: mkhas pa'i legs par dbye ba) нь зохиист аялгуунд суралцан мэргэн болвоос сайн үр үйлс гарахыг өгүүлжээ.

Түүний тулд мэргэд нь төрөлхтнүүдэд  
Сайн муугийн ялгалыг ойлгуулахыг илт сэтгэж  
Тйнхүү тодорхой мөр төгөлдөр  
Үгсийн ялгалын дүрмийг магад найруулжээ(ДЗАТ. 1982. т.13)

гэсэн нь Зохиист аялгууны сайн муугийн тийн ялгааг мэдье хэмээвээс шастир тийн ариунаас хамаарахын тулд урьдын багш мэргэдүүд бүх хүмүүсийн сэтгэлд сайн муу тэргүүтнийг ялган таниулахын билиг оюуныг арвитгахыг таалж, бие үзэсгэлэн бөгөөд дуун, утгын үзэсгэлэнт чимгээр сайтар дуртсан, мөр төгөлдөр яруу үгийн ухааныг мэдүүлэн үйлдэх дүрэм журам үүнийг найруулж, эцэс нэгнээ нотлон буулгасан (Л.Хүрэлбаатар. 2002. т.213) юм гэжээ.

“Зохиист аялгууны толь”-д зохиист аялгууны бие, тэдний ялгаа бүгдийг тодорхой заажээ. Үүнд: **Зохиист аялгууны бие** (са: Sarira, тө: lus) буюу яруу найраг гэж юу болохыг Дандин: “...утгаар бүлэглэн тасалсан үгсийн эрих мөн” (ТМДДЗАТ. 2017. т.22) гэсэн нь аливаа зохиогч зохиист аялгууны дүрэм ёсны дагуу илэрхийлэхийг таалсан зүйлийнхээ утгыг өгүүлбэр, үг, үсгээр холбон найруулсныг бие (ДЗАТ. 1982. т.13) гэдэг байна. Өөрөөр хэлбэл: Өгүүлэхийг хүссэн санаагаа үгсийн эрихээр холбон найруулсныг “Зохиист аялгууны бие” буюу яруу найраг хэмээнэ” (Хүрэлбаатар, 1999. т.120-121) гэжээ.

**Зохиист аялгууны биеийн ялгаа** (тө: lus kyī dbye ba) гэдэг нь уран зохиолын төрөл хэлбэр. Өөрөөр хэлбэл зохиолын санааг агуулах хэлбэр юм.

Түүнд үелэн тасалсан, үргэлжилсэн,  
Хавсарсан хэмээх чухамхүү гурав буй болой

Дөрвөн хөлөөр үелэн тасалсан түүнд

Бритта, зади хэмээх хоёр зүйл буй (ДЗАТ. 1982. т.14) гэсний эхний хоёр мөр нь зохист аялгууны биеийн тухай тодорхойлж, уран зохиолын төрөл хэлбэр нь яруу найраг, үргэлжилсэн, холимог гэсэн гурван хэлбэрээр байна гэжээ.

**Үелэн тасалсан** (са. paḍya, тө. tshigs cad) гэдэг нь санскрит хэлээр хөлөөр таслан шүлэглэхийг хэлнэ. Монгол хэлний “шүлэг” гэдэг үг санскрит хэлний “sloka” гэдгээс гаралтай. Үелэн тасалсан гэдгийг шүлэг гэж хэлж болно. Энэ нь төвдийн “tshigs bcad” гэдгийг махчлан орчуулсан үг. Шүлэг нь тус бүр найман үе бүхий дөрвөн хөлөөс, өөрөөр хэлбэл тус бүр 16 үе бүхий хоёр мөрөөс бүрдэнэ. Шүлэг гэдэг үгийг махчлан орчуулбаас “уйтгар, гашуудал” гэдэг утгатай аж. Эртний энэтхэгийн домог ёсоор анхны шүлгийг алдарт зохиол “Раамаяна”-г туурвисан Ваальмик арши бээр алагдсан шувууг харж гашуудахдаа зохиосон гэдэг” (ДЗАТ. 1982. 14).

**Дөрвөн хөлөөр үелэн тасалсан** гэдэг нь шүлэг. Шүлэг (са. śloka) нь тус бүр найман үе бүхий дөрвөн хөл (са. pāda)-өөс бүрэлдэнэ. Өөрөөр хэлбэл шүлэг нь тус бүр арван зургаан үе бүхий хоёр мөрөөс бүрэлдэнэ.

**Шүлэг** (са: śloka) нь: тус бүр найман үе бүхий дөрвөн хөл (са:pāda, тө: rkang pa)-өөс бүрэлдэнэ. Өөрөөр хэлбэл шүлэг нь тус бүр арван зургаан үе бүхий хоёр мөрөөс бүрэлдэнэ. Шүлэг гэдэг үгийг махчлан орчуулбаас “уйтгар, гашуудал” гэсэн утгатай бөгөөд үелэн тасалсан, шүлэг, хөл төгөлдөр, дөрвөн хөлт нь бүгдээрээ нэг утгатай нэр байна.

**Шүлгийг холбон найруулахын үүднээс ялгах.** Шүлэглэсэн зохиолын зүйлийг зохист аялгууг холбон найруулах шүлэглэл зүйн онолын үүднээс бритта (сан. vṛttā), зади (сан. jāti) гэж хоёр зүйл ангилна.

**Бритта** (са: vṛtti, тө: bridda) нь үеийн тодорхой тоог баримтлан шүлгийг зохиох ёс. Энэ нь тус бүр арван нэгэн үе бүхий дөрвөн мөр шүлгийн хэмжээг заасан нэр томьёо болно (ДЗАТ. 1982. т.14).

**Зад** (са. jāti, тө. ca-a-ti) шүлгийн үеийн агшны тоог баримтлан зохиохыг хэлнэ. Агшин нь эгшгийг дуудахад шаардагдах цагийн хэмжээ. Өөрөөр хэлбэл нэг богино эгшиг бол нэг агшинтай, нэг урт

эгшиг хоёр агшинтай тэнцэнэ(ДЗАТ. 1982. т.14).

**Агшин** (ca: Mātra, төвд. rhyi) нь эгшгийг дуудахад шаардагдах цагийн хэмжээ. Агшин нь шүлэг зохиоход хэрэглэх гол хэмжээс. Өөрөөр хэлбэл нэг богино эгшиг нэг агшинтай, нэг урт эгшиг хоёр агшинтай тэнцэнэ.

**Агуу их үелэн тасалсан** (ca: Mahākāvya) гэдэг нь их яруу найраг. Өөрөөр хэлбэл олон янз бүлгээр холбогдсон зохиол.

**Бүлгээр холбосон** (ca: sargabandha, төвд. bcing) гэх энэ нэр томъёо хэд хэдэн анги, бүлэг, хэсгээс бүрдсэн том хэмжээний шүлэглэсэн зохиолыг заадаг. Дандин “Бүлгээр холбосон нь их зохист аялгуу мөн” хэмээн “Зохист аялгууны толь”-ийнхоо 1.14-д заажээ. Бүлгээр холбосон том хэмжээтэй шүлэглэсэн зохиол нь тайлах, зохист, сан, хураах зэргийн холбох мөн чанар үүргийг өөртөө хадгалсан байдаг.

**Холбон найруулахын гол** (ca. chandoviciti, тө. sdeb sbyor gzhung) нь шүлгийн хэмжээний тухай онолын нэр. Энд шүлгийн хэмжээ, үеийн тооны тухай ухааныг ерөнхийд нь багтаана. Үүнийг Дандин:

Түүний дэлгэрэнгүй бүхнийг

Холбон найруулахын гол сударт магад номлож

Тэр ухаан нь зохист аялгууны гүн далайг

Гэтлэхийг хүсэгчдийн онгоц мөн (ДЗАТ. 1982. т.14) гэж тодорхойлсон. Холбон найруулахын онолоор олон алдартай зохиол байдаг. Үүнд Бингалагийн зохиосон “Чандо судар” (ca. chandosutra), Раднакарашантын зохиосон “Чандоратнакара” (ca. chandoratnakara) буюу “холбон найруулахын эрдэнэс гарах орон” зэрэг. Үүний сүүлчийн судрыг Халхын гүүш Гэлэгжалцан монголоор орчуулсан нь Монгол “Данжуур”-т хэвлэгджээ(ДЗАТ. 1982. т.14-15).

**Шүлгийг язгуурын үүднээс ялгах** гэдэг нь төрөл зүйлийн үүднээс шүлгийг ялгаж буй юм. Энэ нь дөрвөн мөр шүлгэнд утга агуулгыг багтаах агууламжийн байдлаар нь ангилах арга зарчим. Дандин бээр “Зохист аялгууны толь”-доо 4 зүйлээр ангилжээ.

Тайлах хийгээд зохист ба сан хийгээд

Хураах хэмээгч тэр мэтсээр – гэж 4 зүйлээр ангилжээ.

**Тайлах** (ca: Mukta, тө: grol). Шүлэг яруу найргийг зохиох нэг хэлбэр. Нэг бадаг шүлгээр өгүүлэх гэсэн санаагаа буюу утгыг бүрэн

илэрхийлэхийг хэлнэ (ДЗАТ. 1982. т.15).

**Зохист** (са: Kulaka, тө: rigs). Өгүүлж буй зүйлийнхээ нэг утгыг хэд хэдэн бадаг шүлгээр найруулан нэг өгүүлэгчээр эцэст нь илэрхийлэхийг хэлнэ (ДЗАТ. 1982. т.15).

**Сан** (са: kośa, тө: mdzod). Янз бүрээр шүлэглэн найруулахын үүднээс өгүүлэх нь олон зүйлийн тухай шүлэг, өгүүлэгчийн олон цөөнийг үл харгалзан өгүүлэхийг хэлнэ (ДЗАТ. 1982. т.15).

**Хураах** (са: saṃhāta, тө: ‘dus pa). Өгүүлэх зүйлийн нэг утгыг хэд хэдэн бадаг шүлэг, олон өгүүлэгчээр илэрхийлэхийг хэлнэ (ДЗАТ. 1982. т.15).

**Их зохист аялгуу** (са. mahākāvya, тө. snyan ngag che) нь шүлэг, яруу найраг болой. Дандин “Бүлгээр холбосон нь их зохист аялгуу мөн” (ДЗАТ. 1982. т.16) гэсэн нь хэсэг бүлгээс бүрдсэн том хэмжээний яруу найраг зохиолыг хэлжээ. Жамъянгарав “Их зохист аялгуу”-ны бэлгэ чанарыг тодорхойлохдоо: “Сарга хийгээд бүлгийг хоёроос дээш холбосон тэр нь их зохист аялгуу мөн” гээд мөн “учваса, анга, аарьяа - гийтийгээр холбосныг ч их яруу найрагт номлох болой” (Хүрэлбаатар, 1999. т.127) гэжээ. “Саргагаар холбогдсон “Их зохист аялгуу” бол нэхмэл хивс мэт “тайлах” тэргүүтэн дөрөв бол түүний чухалчлан авсан нэхээс туушин утас мэт бөгөөд тиймээс нэхээс туушин утасгүйгээр нэхмэл хивс бүтэхгүй мэт, тайлах тэргүүтэн олонтоо чуулснаас ангид их яруу найраг ч гэж үгүйн тул зохист аялгуу бүхний үргэлжлэл дор оршсон буюу хувь хүрээний өвөр чанар дор буй тэдгээрт үүний жишээ шүлэг ангид эс бүтсэн” гэж “их яруу найраг” хийгээд түүний дотоод бүрэлдвээр “тайлах” тэргүүтэн дөрвөн зүйлийн шүлгийн язгуурыг ерөнхий тусгайн харилцан шүтэлцэл холбоонд нь авч үзжээ (Хүрэлбаатар, 1999. т.122).

“Их зохист аялгуу” нь аливаа мөн чанарыг өгүүлэхдээ эхлээд түүнээ эхлэх ам буюу орох хаалга үүд хамгийн эхэнд байна. Хаалга, ам, үүд – бүгд их зохист аялгууг эхлэх үүдэл нэг утгатай.

**Үүд** (хаалга, ам) (са. mukha, тө. sgo) нь зохиол эхлэх, зохиол руугаа орох хаалга. Иймд зохиол эхлэхийн өмнө зохиогчоос бурхан, багш, дээдэс мэргэдэд хандан мөргөл, өлзий, мөн чанарыг магад өгүүлэх шүлэг. Дандин:

Өлзий өгүүлэх, мөргөл өгүүлэх, мөн чанарыг

магад үзүүлэх нь түүний ам (эхлэлт, оршил) болно (ДЗАТ. 1982. т.16) гэсэн энэ нь зохиолын эхлэлт, оршил гэсэн үг байна. Өлзий, мөргөл, номлолыг амлах шүлэглэл нь их яруу найргийн эхлэл хаалга юм.

**Өлзий өгүүлэх** (ca: āśīr, тө: shis brjod). Зохист аялгуу нь аливаа бурхан, тэнгэр, дээдэс мэргэд багш нарт сайн сайхныг хүсэн өлзий өгүүлэхээр эхэлдэг (ДЗАТ. 1982. т.15). Энэ бол Зохист аялгууч нь чадал хүчийг эрхшээсэн бурхан сахиус, номын багш мэргэдээс энэрч хайрлаж өлзий өршөөлөөр тэтгэхийг гуйж өгүүлсэн шүлэглэл.

**Мөргөл өгүүлэх** (ca: namskriyā, тө: phyag bya). Өлзий өгүүлсний дараа аливаа бурхан сахиус, багш мэргэдээ магтан сайшааж хүндэтгэл айлтгах мөргөл өгүүлнэ (ДЗАТ. 1982. т.15). Тухайн уран бүтээлчээс үйл хэргээ бүтээхэд хүч чадал хүссэн зорилгоо хэрэгжүүлэхэд туслахыг гуйсан үг шүлэглэл юм. Жишээ нь: “Ерөөлийн хаан”-ы мөргөл шүлэгт:

Арван зүгийн ертөнц бүхэнд  
Гурван цагийн орчил тутамд  
Билэгт хүмүүний арслан бологсдод  
Бие, хэл, сэтгэлээрээ мөргөө

гэх мөргөл шүлэг нь арван зүгийн гурван цагийн алив оронд оршиж буй хүмүүний арслан буюу бурхад нэг бүрт биеэр хүндлэн, хэлээр магтан, сэтгэлээр бишрэн мөргөө гэжээ. Энэ нь толгойгоо бөхийлгөх, алга хавсрах, таван гишүүнээ газар тулах зэрэг нь биеийн эрдмийг өгүүлж магтах нь хэлний эрдмийг нь олж авахыг хүсэх нь сэтгэлийн мөргөлүүд болно (Чүлтэмжамц. 2017. т.26-27)

**Магад өгүүлэх** (ca: vastunirdeśa, тө: dngos po nges par bstan pa). Зохиолд өгүүлэх зүйлийнхээ гол агуулгыг хураангуйлан өгүүлэх шүлэглэлийг мөн чанарыг магад өгүүлэх гэнэ (ДЗАТ. 1982. т.16).

**Аръяа-гийти** (ca: ārya-gīti, тө: ’rhags). Хутагт гэдэг нь шүлгийн нэгэн зүйл хэмжээ. Хоёр мөр шүлгийн хэмжээний нэр. Энэ нь эгшгийг дуудахад шаардагдах агшингийн хэмжээг баримталдаг зади-ийн ёсонд тулгуурласан, мөр бүр нь долоон өлмий хагас, хоёр мөр шүлгийн хэмжээний нэр томьёо.

**Вактра** (ca: vaktra) Хаалга, ам, нүүр, эхлэл гэсэн утгатай. Вактра нь 4 шад бүхий 8 үе шүлгийн хэмжээний нэр болно.

**Апаравактра** (ca: aparavaktara) Энэ нь дөрвөн мөр шүлгийн

хэмжлийн нэр. Эртний Энэтхэг, Дорно дахины орнуудад санскрит хэлний журамлал зүйг барьж бичсэн дөрвөн мөрт шүлгийн хэмжил зүйн нэр хэмээн Дандин “Зохист аялгууны толь” онолын бүтээлдээ тайлбарлажээ.

**Ламба** (ca: lambha) нь бүлэг, хэсэг, анги гэсэн утгатай байна. Гэхдээ үгэнд бүлэг анги гэх зүйл байхгүй, хэрэв байвал түүнийг ламба гэж нэрлэнэ.

**Учваса** (ca. ucchvāsa) Хүүрнэн өгүүлэхэд түр зогсох, мөн ном зохиолын бүлэг, хэсэг, анги зүйл гэсэн утгатай. Өгүүлэхийн түр зогсоц бүхий бүлэглэх бүтэц. Өөрөөр хэлбэл өгүүлэлд бүлэг анги байх бөгөөд түүнийг учваса гэнэ.

**Сарга** (ca: Sarga, төвд. bcing) нь үг, бүлэг гэсэн утгатай санскрит үг. Саргаар товчилсон гэдэг нь бүлэг хэсгээр холбосон том хэмжээний яруу найраг.

**Зохист аялгууны амь** (ca. kāvyanam jīvita - grāna, тө. snyan ngag gi srog). Зохист аялгууны амь буюу “өгүүлэгдэхүүн” буюу утга гэдэг нь уран зохиолын дүрслэгдэхүүний асуудал байна(Хүрэлбаатар, 1999. т.136). Дандин үүнийг “Зохист аялгууны толь”-ийнхоо 1.15-д тодорхойлохдоо:

Эртний болсон домгоос өгүүлэх буюу  
Мөн өөр сайн /үнэн/ зүйлд дулдуйдан өгүүлэх болой  
Дөрвөн төрлийн үрийн эрхээр болсон тэргүүтэнд мэргэн  
Сэтгэлд зохистой удирдагчид (ДЗАТ. 1982. т.16) юм гэжээ.

Иймд уран зохиолын амь гэдэг нь хүн төрөлхитний үүсэж хөгжиж оршиж тогтнож ирсэн шастир түүх, түүнийг өгүүлсэн үлгэр домог, намтар тэргүүтэн мөн хүн төрөлхитний аж төрөхүй буюу хүний олох эдлэхийн үр үзэл баримтлалын номлол байна. Дөрвөн төрлийн үрийн эрхээр болсон гэх нь Дөрвөн аймаг гэнэ.

**Дөрвөн аймаг** нь ном (ca. dharma, тө. chos), утга (ca. artha, тө. don), дурлал (ca. kāma, тө. ‘dod), гэтлэх (ca. moksa, тө. thar pa) - дөрөв бөгөөд ийм хүн төрөлхтөний үйл хэргийн дөрвөн гол зорилгын үрээр болсон гэх утгатай. Ном гэдэг нь ном ёс, хууль зүй, үнэн, шударга ёс гэх зэрэг утгатай Энэтхэгийн эртний шашин гүн ухааны өргөн утгатай үг. Утга гэдэг нь: ач тус, хөрөнгө баялаг, утга учир гм. Гэтлэх гэдэг нь сансар ертөнцийн хир буртагт хэмээх үйл явдлыг гэтлэн давж,

сэтгэл санааны амгалан дээд байдалд хүрэх буюу нирванд хүрэх гэсэн утгатай. Эртний Энэтхэгийн сургаал ёсоор хүн төрөлхтний амьдралын гол зорилго бол энэхүү дурдсан дөрвөн зүйлийг хичээж үр шимийг нь зөв эдлэхэд оршино(ДЗАТ. 1982. 16-17).

**Удирдагчид** (са: nāyaka, тө: ‘dren pa) нь зохиолын баатар. Хүн төрөлхтний амьдралын гол зорилго болох ном, утга, дурлал, гэтлэхүй дөрвөн зүйлийн үрийн үүднээс номлон сургасан эртний ухааны шастир номд мэргэн бөгөөд өглөг тэргүүтнээрээ амьтан бүхний таалал сэтгэлд зохист удирдагч тэргүүлэгчийг өгүүлж буй.

**Өвөрчлөнөөр үзэсгэлэнт** гэдэг нь өөрийн мөн чанараар үзэсгэлэнт гэсэн утга болно. **Өөрийн мөн чанараар үзэсгэлэнт** гэдэг нь зохиолч өөрийн сайн талын баатрыг магтах ерийн арга. “Зохист аялгууны толь”-д: Эхлээд удирдагчийн (баатар) эрдмийг зохион өгүүлээд, ингэснээрээ дайснаа муучлах энэ мөр (арга) нь өөрийн мөн чанараар үзэсгэлэнт болой” (ДЗАТ. 1982. т.17) гэжээ. Энэ нь Дандины өмнөх зохист аялгуучид Бхамаха нарын баримталдаг арга. Дандин энэ аргыг их эсэргүүцээгүй боловч шинэчлэгчийн хувьд өөрийн аргаа дэвшүүлсэн. Дандины энэ арга нь “Язгуур угсаа, эр чадал, эрдэм ном тэргүүтнээр дайсныг ч сайшаан өгүүлээд түүнээс удирдагч (баатар) нь үлэмж илүү хэтэрсэн болохыг өгүүлэх арга (мөр)-д би баясмуй” (ДЗАТ. 1982. т.17) гэсэн байдаг.

**Зохист аялгууны сэдэв** нь зохиолчоос тухайн зохиолыг бичих болсон үүдэл санааны товлогдсон хэлбэр, бичиж туурвихын шалтгаан болох сэдэв буюу өгүүлэгдэхүүнийг Жамъянгарав 18 сэдвээр хуваан түүнээ 6 хэсэгт бүлэглэж, тус тусын жишээ шүлгийг бичжээ. Энэ 18 сэдэв нь

- 1) 1. Хот балгад, 2. Далай, 3. Уул гурвыг сайшаасан.
- 2) 4. Цаг улирал, 5. Наран саран мандах, 6. Үүсгэмэл цэцэрлэг, 7. Усны цэнгэл наадам дөрвийг сайшаасан.
- 3) 8. Дарс уух, 9. Амраглахын баяр хурим, 10. Эр эмийн цаг болзооноос эс уулзалдсан гурвыг сайшаасан
- 4) 11. Бэр мордуулах, буулгах, 12. Залуус төрөх, 13. Өсөх гурвыг сайшаасан.
- 5) 14. Ажил үйлийг хийхээр эелэлдэн зөвлөх, 15. Элчийн одох ирэх, 16. Холын оронд зорчих гурвыг сайшаасан.
- 6) 17. Байлдаанд бэлтгэх ба 18. Удирдагч ба хааны агуу хүчин



дэлгэрснийг сайшаасан - эдгээр болно. (*Хүрэлбаатар, 1999. т.138*).

**Зохист аялгууны чимэг** (са: kāvyalamkāra, тө: snyan ngag gi rgyan). Зохиолын утга, ур, уянгыг тэгш тэнцүү уран яруу дүрслэх арга. Зохиол туурвилын утгын дүр дүрслэлийг гаргахдаа үг найруулгын яруу зохисыг бүрэн гүйцэд тохируулан хэрэглэж, утга төгс уран яруу тансаг болгох арга байдлыг хэлнэ. Тиймээс Дандин бээр *Зохист аялгууг үзэсгэлэн болгогч аргуудыг чимэг хэмээнэ* (ДЗАТ. 1982. т.37) гэж тодорхойлоод *дээд чимэг лүгээ төгссөн зохист аялгуу нь галав хүртэл орших болмуй* (ДЗАТ. 1982. т.36) гэсэн нь сайн бүтээл өнө мөнхөд орших үнэ цэнэтэй юм гэжээ. Чимэг тэдгээрийн найруулах, зүйл, ялгаа, цаашид зохиогч бүрийн уран саналга сэтгэмжээр тасралтгүй баяжин хөгжиж байх нийтлэг түгээмэл хэрнээ өвөрмөц тодорхой хууль зүйтэй болохыг Зохист аялгууны тольд нээж үзүүлээд дээд чимэг төгссөн зохист аялгуу нь мөнхөд орших үнэ цэнэтэй юм гэжээ. Энэхүү урлал дүрслэлийн аргууд нь эдүүгээд төдийгүй цаашдаа ч үргэлжлүүлэн судлах, шийдвэрлэх зохистой зүйл бөгөөд хүн төрөлхтний уран сайхны сэтгэлгээний боломж хязгааргүй олон, хувирч өөрчлөгдөж хувьсаж байдаг тул энэ уран дүрслэлийн аргуудыг ер нь бүрэн төгс эцэст хүртэл шийдвэрлэх нь бэрх юм гэжээ. Энэ чимэг гэдгийг үлгэрлэвэл залуу бүсгүй олны газар очихдоо биеийг гоё сайхан үзэгдүүлэх үзэсгэлэнгийн элдэв зүйлийн чимгээр биеэ чимээд, бусдын сэтгэлийг булааж чадах хээмсэг ганган байдал төрхийг гаргах мэт юм. Зохист аялгууны тольд урлах арга маяг чимгийг **нийтийн** болоод **нийт бусын чимэг** хэмээн үндсэн хоёр ангилалд авч үздэг. Үүнээс **нийтийн чимэг** нь **утгын чимэг, дууны чимэг** гэсэн хоёр зүйл байна.

Утгын чимэг нь өгүүлэгдэхүүн утгын дүр байдалд илүүтэй анхаарал хандуулна. Дууны чимэг буюу үгийн чимэг нь утгыг гаргагч үгсийн найрлага дээр голлон анхаарна. Далдлах үгийн чимэг нь өгүүлэхүүн бодит утгыг ил шууд өгүүлэлгүй, өөр үг утгасаар далдалж гаргахыг хэлнэ. “Зохист аялгууны толь”-ийн II бүлэгт Утгын чимэг, III бүлэгт Дууны чимэг буюу үгийн найралт зохирлын тухай өгүүлжээ.

**Нийт бусын чимэг** (тө. thun mong ma yin pa'i rgyan). Зохист аялгууны тольд утга зохиолын уран сайхны найруулгын хууль зүйг “Өмнийхний таалдаг найруулга” ба “Дорныхны таалдаг найруулга”

гэсэн хоёр чиглэл, өөр өөрсдийн таалдаг арга зүйгээр авч үздэг зарчим.

**Нийтийн чимэг** (тө. thun mong pa'i gyaan). Зохист аялгууны тольд утга зохиолын уран сайхны найруулгын хууль зүйг “өмнийхөн” ба “дорныхон” хоёулаа адил таалдаг уран сайхны найруулгын арга зарчим. “Нийтийн чимэг” гэх ухагдахуунд “утгын чимэг” болон “дууны чимэг” хоёр багтана. Гэхдээ утга зохиолын уран сайхны хууль зүйн зарчмаар бас “нийт бусын чимэг” ч бас “нийтийн чимэг”-т хамааралтай (Хүрэлбаатар, 1999. т.151-152). Ийн “Утгын чимэг”, “Дууны чимэг” хоёул зохиолын өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн хоёрын тансаг яруу сайхныг эрхэмлэх нь нийт уран сайхны найруулгын хууль зүйд нийцэх учир **“нийтийн чимэг”** болж байна.

**Вайдарбха** (са. Baidarbha) Өмнийхөн. Эртний Энэтхэгийн зохист аялгуу урлахуйн нэг гол чиглэл. Энэ нь Энэтхэгийн өмнөдийн уран зохиолын дэг сургууль. Зохиолын найруулгын арга зам маягаараа Гаудабатай эсрэгцдэг. Вайдарбха чиглэл нь найруулгын арван гол эрдмийг чухалчлан барьдаг. Үгийн ердийн алдаршсан утгыг эрхэмлэж, зөөлөн найруулгыг таалдаг. Зохист аялгууч Дандин өөрөө өмнө зүгийн сургуулийн аргыг баримталж байжээ(Галбаатар, 2012. т.98).

**Гаудаб** (са. Gaudia). Дорныхон. Энэтхэгийн дорно зүгийн уран зохиолын сургуулийн найруулга, дэг сургууль. Вайдарвхын эсрэг найруулга найруулга бүхий дэг. Дандин “Гаудия нь үгийн гарлын утгыг эрхэмлэн асар алдаршсан утгыг үл харгалзан таалмуй. Ихэд ширүүн найруулгатай” (Д.Галбаатар. 2012 . т.102) гэжээ. Өөрөөр хэлбэл энэ чиглэлийнхэн хатуу найруулгатай, далд утгатай найруулгыг таалдаг.

Нийтийн ба нийт бусын чимэгт Өмнийнхөн ба Дорныхны онцлог нь өгүүлэгчийн үг, мөр зэргээр онцлогтой байдаг байна.

**Өгүүлэгчийн үг** гэдэг нь тухай туурвигч зохиолчийн хэл.

**Мөр** (са: mārga, тө: lam) нь бүтээх арга, найруулга гэсэн утгатай.

**Үргэлжилсэн** (са. gadya, тө. lhug pa). Хүүрнэл зохиол буюу үргэлжилсэн үгийн зохиол. Хэлбэрийн хувьд шүлэглээгүй. “Зохист аялгууны толь”-д

Хөл үгүй залгаламжлалыг

Үргэлжилсэн хэмээмүй



ярьж байгаагаар дүрсэлдэг байна.

**Пракрит** (ca: prākṛita, тө: ran bzin) хөдөөгийн аялгуу, хэл гэсэн утгатай. Эртний Энэтхэгийн жүжгийн зохиолд голдуу эмэгтэйчүүд буюу доод хэмжээний баатрууд пракрит аялгуугаар ярилцдаг байжээ.

**Апабхарамса** (ca: Aṅabhramsa, тө: zur chag) – пракрит хэл аялгууны хамгийн буруу хэллэг. “Үхэрчдийн хэл” хэмээдэг

**Мишра за** (ca: misra, тө: ‘dres ma) холимог хэл аялгууны нэр

**Хэлний дөрвөн язгуур** гэдэг нь Санскрит (saṃskṛta), Пракрит (prākṛta). Апабхарамса (aṅabhramśa), Мишра (mīśra) - энэ дөрвөн хэл аялгууг баримтлан Зохист аялгуунд Энэтхэгийн бүх зохиолыг дөрвөн зүйлд хуваажээ.

**Чампу** (ca: cāmpu) үргэлжилсэн үг ба шүлэг хоёрыг тэнцүүхэн хавсарган хэрэглэсэн зохиол. Энэ нь жүжгийн төрлийн зохиолоос өөр төрлийн зохиол гэнэ.

**Скандака** (ca: skandhaka) Арьяа гэдэг хоёр мөр шүлгийн хэмжээний өөр нэг төрлийн нэр. Пракритаар скандака зэрэг шүлгийн хэмжээг баримтлан зохиол бичдэг.

**Осара** (ca: skandhaka) Шүлгийн хэмжээний нэр. Апабхарамса нь осара зэрэг шүлгийн хэмжээг баримтлан зохиол бичнэ.

**Бхута** – Бүднарын хэл. Жүжгийн зохиолд чөтгөрүүдийн ярьдаг тусгай хэллэгийн нэр. Гэвч энэ Бхута нарын хэлээр олон үлгэр туужийн эмхэтгэл болох үргэлжилсэн үгийн алдарт зохиол “Их үг” (ca: brhat-kathā төвд. gya che’i gtam) гэдэг зохиол зохиогдсон гэдэг.

**Жүжгийн зохиолын хоёр гол ёсон** гэдгийг Дандин:

Биелэх, дохио, байдал тэргүүтэн нь

Харах үзэхийн харъяат буюу

Бусад нь сонсохын мөн чанарт болой

Эдгээр нь хоёр ёсон мөн (ДЗАТ. 1982. т.22) гэжээ. Үүнд үзэхийн харъяат нь биелэх, дохио, байдал бөгөөд бусад нь сонсохын мөн чанарт болж байна.

**Зохист аялгууны арван эрдэм.** Зохиол бүтээлийг зөв зохистой, уран яруу найруулах арга зам. Найруулгын арга барилын онцлог чанараар нь барилдлага, маш тунгалаг, тэгш, яруу, маш залуу,

тодорхой утгат, агуу их, жавхлант, үзэсгэлэнт, самади гэсэн 10 зүйл эрдэм болгон үздэг. Энэ тухайд Дандин бээр:

Барилдлага, Маш тунгалаг, мөнхүү Тэгш ба  
 Яруу хийгээд Маш залуу ба  
 Тодорхой утгат хийгээд мөнхүү Агуу их  
 Жавхлант хийгээд Үзэсгэлэнт ба Самади  
 Эдгээр арван эрдэм нь Вайдарбхагийн  
 Мөрийн гол болгон өгүүлсэн мөн болой.  
 Эдгээрээс нөгөө олонхийг

Гауди-гийн мөр нүгүүддээ өгөх мөн буюу (ТМДДЗАТ.2017. т.53-54) гэж арван эрдмийг нэрлээд энэ найруулгын арван гол шинж чанар нь Вайдарвха буюу Өмнө зүгийнхний найруулгын шинж чанарын арван гол бөгөөд эдгээрээс урвуугаар байгаа олонх нь Гауда буюу Дорно зүгийнхний найруулгын шинж чанарыг илэрхийлнэ гэжээ.

**1.Барилдлага** (ca. śleṣa, тө. sbyar ba). Үгийг өөр хооронд нь нягт шүтэлцүүлэн найруулах ур маяг. “Барилдлагын эрдэм” гэдэгт ихэнх нь өчүүхэн амь үсэг байгаагаар сул чанартай гэж үзэхгүй. Бүх үсгийг өчүүхэн амьтаар бус, дийлэнхий нь өчүүхэн амьтаар найруулаад цөөвтөр хэсгийг нь их амьт үсгээр найруулсан нөхцөлд түүнийг “хүнд найруулга” буюу “барилдлага” гэдэг байна (Сүхбаатар Ц. 2003. т.21). Өөрөөр хэлбэл үсгийн чанга, сулыг харгалзан барилдуулсан найруулга. Зохист аялгууны найруулгын 10 эрдмийн нэг. Сул чанарт нь хийн түрэлт багатай үсгүүдийг олноор оруулан зохиосныг хэлнэ. Амьсгалын түрэлт багатай болбоос сул гийгүүлэгч буюу хийн түрэлт багатай мөн өчүүхэн амьт үсэг хэмээж буй юм. Гауда нь сул чанартыг эрхэмлэдэг бол Вайдарвха нь чанга барилдуулж шүлэглэхийг чухалчилдаг(ДЗАТ. 1982. 24)

**2.Маш тунгалаг** (ca. prasāda, тө. rab dwags) нь үгийн ертөнцөд дэлгэрсэн утга нь маш тодорхой гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл маш тунгалаг гэдэг нь нийтэд алдаршсан ердийн утгаар нь үгсийг найруулахыг хэлнэ. (ДЗАТ. 1982. т.24-25) Зохист аялгууны найруулгын 10 эрдмийн нэг. Энэ ерийн утгаар нь найруулахыг Вайдарбха таалдаг. Дандин:

Маш тунгалаг лугаа төгссөн нь алдаршсан утгат.  
 Сарны бэлэ удвалын  
 Өнгөөр үзэсгэлэнтэйеэ чимэгдсэн хэмээх

Ухахуйяа сайн хувь лугаа төгссөн үгс болой (ТМДДЗАТ. 2017. т.57) гэх энэ нь ухааж ойлгоход хялбархан үгс болно. Үүнийг Вайдарвха таалдаг. Харин Гауда нь аливаа үгсийг түүний илт өгүүлэх нэрээр найруулахыг таалдаг.

Маш цагаан бус уснаас ургасан  
Тэр мэтээр бэлгэтэй цагаан гэрэлт мэт

гэж илт өгүүлэх нэрээр Гауда найруулдаг. Үүний “маш цагаан бус” нь хөх өнгийн илт өгүүлэх нэр, “уснаас ургасан” нь удвал цэцгийн илт өгүүлэх нэр, “цагаан гэрэлт” нь сарны илт өгүүлэх нэр байна(ДЗАТ. 1982. т.25).

**3. Тэгш чанарт** (са. samatā, тө. mnyam nyid) нь зөөлөн хатуу үсгийн найруулга тэгш байхыг шүтсэн найруулгын хэв маяг. Зохист аялгууны найруулгын 10 эрдмийн нэг. Энэ тэгш чанарт найруулгыг Вайдарвха ёсныхон таалдаг. Харин Гаудагийн ёсныхон бол тэгш чанарт найруулгыг үл хайхран, зөвхөн үгийн утга, чимгийг эрхэмлэдэг байна.

**4. Яруу** (са. mādhyā, тө. snyan) нь адил дуудлагатай үсэг дараалан орсон учир яруу сайхан сонсогдох гэсэн утгатай. Ер нь үг зохистой, мөн утга санаа ч зохистой байхыг хэлнэ(ДЗАТ. 1982. т.23, 26). Зохист аялгууны найруулгын 10 эрдмийн нэг. Дандин:

Балыг эдлэгч балд баясах мэт  
Хэн оюун төгсөгсөд баясан үйлдмүй  
Дуу нь алин ба юуг бээр ч  
Алимад адилтгалд анхааран амссан  
Түүний дүрс тэргүүтний үгс лүгээ шадарлан

Даган удирдагч лугаа сэлт зохисыг төгсгөтүгэй (ТМДДЗАТ. 2017. т.63-64) гэсэн энэ шүлгийн утга нь: зөгий балд баясах адил ухаантан бүр мөн түүнд баясна. Дууны яруу нь (үсэг, үгийн) алинаар яаж найруулахад ойролцоо адил үсгээр яруу болгон мөн үсэг давтан хэрэглэж яруу төгөлдөр болгох юм гэжээ. Энэ нь дууны зохистой буюу яруу ямар чухал болохыг тодорхойлжээ. Үг, үсгийн дуудлагын адил төстэй байдал, нэг үсэг буюу ойр төрлийн үсгийг холбон давтах зэргээр яруу найруулгыг зохиож болно(ДЗАТ. 1982. т.26).

**5. Маш залуу** (са. sukumāratā, тө. shin tu gzhon pa). Ихэвчлэн зөөлөн үсэг хэрэглэдгээс ийн нэрлэжээ. Өөрөөр хэлбэл ширүүн бус буюу зөөлөн үсэг орсон найруулга. Зохист аялгууны найруулгын

10 эрдмийн нэг. Найруулгад ихэнх үсэг нь ширүүн бус зөөлөн үсэг хэрэглэхийг Вайдарвха дахин нь маш залуу гэнэ. Зөөлөн үсэг дагнан орвоос сул найруулгын гэм болдгийг бас анхааруулжээ (ДЗАТ. 1982. т.т.23, 30)

**6. Тодорхой утгат** (ca. arthavyakti, тө. don gsal ba). Үгийн утгыг тусгайлан шинжлэх хэрэггүй буюу хоёрдмол санаагүй туйлын тодорхой илэрхийлсэн найруулга. Зохист аялгууны найруулгын 10 эрдмийн нэг. Дандин:

Булаан үйлдэгчийн туурайгаар нухлагдсан  
Лусын цусаар улайсан усны сан (далай)-аас  
Газар дэлхийнүүд гарав.

Булаан үйлдэгч буюу Вишнү тэнгэр том бодон гахайн төрөл аваад далай дотор орж тэнд оршиж байсан луснуудыг туурайгаараа хэсэглэн нухачсан учир тэдгээрийн цус далайн усыг улаан болгож, тэр улайсан далайн уснаас ертөнц үүсэн (ДЗАТ. 1982. т.23, 31-32) гэдэг домогтой учир энэ шүлгийн утгыг тусгайлан бодох тайлбарлах хэрэггүй тодорхой ойлгож болох юм

**7. Агуу их** (ca. udāgavam, тө. gya che) Аливаа зарим нэг утга санааг илэрхийлэн өгүүлэхдээ үлэмж дээд эрдмийг ухуулан үзүүлэгчийг агуу их чанарт гэнэ. Энэ нь зохист аялгууны бүх мөрийн итгэл төгссөн дээд нь болой. (ДЗАТ. 1982. т.32). Зохист аялгууны найруулгын 10 эрдмийн нэг. Дандин:

Гуйлгачны өлөн харц түр зуур таны нүүрийн зүгт тусна  
Ээ, Тэнгэр (хаан)! Ингэж тэр бусдын нүүрийг  
дахин хэзээ ч харахгүй.

Энэ мэт аялгуугаар өглөгийн  
хэтэрхий үлэмж сайныг үлэж жиштүгэй  
Мөнхүү энэ мөрөөр (аргаар) бусдыг ч ухан адилтган  
үлгэр болготугай

гэх энэ шүлэг нь Вайдарвхагийнхны агуу их чанартын жишээ шүлэг. Энд хааны их өглөгч чанарыг харуулсан бөгөөд энэ мэтээр бусдыг адилтган жиштүгэй хэмээжээ.

Сайшаахад зохистын ялгал лугаа  
Төгссөнийг заримууд агуу ихэд таалмуй.  
Наадан цэнгэн баясагч(Вишнү тэнгэр)

уснаас ургагч(лянхуа)ийн нүүр ба

Алтан чимэг тэргүүтэн мэт (ТМДДЗАТ, 2017. т.91)

гэсэн энэ нь Гауда дахины агуу ихийн жишээ шүлэг (ДЗАТ. 1982. т.32) юм.

**8. Жавхлант** (ca. ojas, тө. brjid) Нийлбэр үгс олон учир хүч жавхлан төгөлдөр буюу хүчтэй гэсэн утгатай. Иймд хүнд, хөнгөн үсгийг олон цөөнөөр нь тохируулан холбож найруулсан нийлбэр үгс нь жавхлант болно. Зохист аялгууны найруулгын 10 эрдмийн нэг. Үргэлжилсэн үгийн зохиол дахь олон хураангуй үгс буюу холбоо үгсийг Вайдарвха дахин жавхлантын чимэг гэдэг. Харин Дорныхон үргэлжилсэн үг төдийгүй шүлэгт ч их хэрэгтэй хэмээн үздэг. Ийн найруулахдаа хүнд, хөнгөн үсэг олон, цөөн холбож өндөр нам уул, тал мэт болгон найруулахыг зохистойд тооцно (ДЗАТ. 1982. т.32-33), (ДЗАТГНУТ. 2017. т.59).

**9. Үзэсгэлэнт** (ca. kānti, тө. mdzes) нь ертөнцийн ердийн утгаас үл хэтрэн амьтан бүхнээ үзэсгэлэнтэй болсныг хэлнэ. Үзэсгэлэнт найруулга нь 2 зүйл байна. 1.Үгээр илтэд өгүүлэх, 2.Сайшаан тодорхойлох. Үзэсгэлэнт найруулгыг харилцан ярилцах, аливаа зүйлийг сайн тодорхойлон өгүүлэхэд хэрэглэнэ. Зохист аялгууны найруулгын 10 эрдмийн нэг. Дандин:

Та мэтийн бэрхийг бүтээгч даяанчийн  
Өлмийн ариун тоосон нугуудыг  
Үнэхээр хүртсэн аль бүгд  
Ямагт тэдгээр магад энэ гэртэн болой

Энэ шүлгийн утга нь хүндтэй зочин ирэхэд гэрийн эзний угтаж хэлдэг ердийн үг. Харин

Өөгүй гоолиг дүрст чиний  
Найлзуур модон мэт хоёр гарын хооронд  
Үлэмж төлжсөн хоёр хөх  
Зай олж яднам -

гэсэн шүлгийн утга нь сайшаан тодорхойлоход хэрэглэсэн үзэсгэлэнт найруулгын жишээ байна (ДЗАТ. 1982. т.33)

**10.Самади** (ca. samādhi, тө. ting nge 'dzin). Нэг юмны номыг нөгөө юманд ертөнцийн ёсыг дагаж шилжүүлэн байгуулаад, өөрөөр хэлбэл амьтай юмны шинж чанарыг амьгүй нөгөө юманд ердийн ёсыг дагаж



шилжүүлэн байрлуулаад аливаа үгийн найруулгад өгүүлэгч дууныг үнэхээр бариулах үүнийг самади хэмээнэ. Зохист аялгууны найруулгын 10 эрдмийн нэг. “Энд өгүүлж буй самадийн эрдэм нь гүнзгий санаа буюу бодол бясалгалын гүн сэтгэмж юм. Амьтайг амьгүйд, нэг шинжийг нөгөөд шилжүүлэн нэрийдсэний учир үг найруулгыг үзэсгэлэн буюу уран сайхантай болгох арга юм”(Хүрэлбаатар, 1999. т.228). Дандины жишээ:

Гүмүда нь нүдээ аниад  
Лянхуа бээр нүдээ нээмү хэмээн  
Нүдний үйлдвэрийг оршуулснаар  
Түүний өгүүлэгч аялгуунууд хүртьюү .

Энэ шүлэг нь нар мандахад гүмдаа цэцэг дэлбээгээ хумьж, бадам цэцэг дэлбээгээ нээнэ гэсэн утгатай. Ийнхүү амьтны нүдээ аних, нээх үйлийг амьгүй цэцгэнд шилжүүлэн хэрэглэсэн нь уран сайхантай болгожээ(ДЗАТ. 1982. т.34-35). Самади хэмээгдэх эрдэм нь зохист аялгуунд бүгдэд нь хэрэгтэй тул Дорныхон, Өмнийхөн гэх ялгаагүй зохист аялгуучин бүхэн дагадаг.

**Зохист аялгууны эрдмийг** Дандин бээр шинжилж Өмнийхөн, Дорныхны зохист аялгууны мөн чанарыг хоёр мөр болгон ялгасан боловч тэрээр бас Зохист аялгуучин тус бүрийн эрдэм найруулгын онцлогийг Сарасвати ч өгүүлж чадамгүй юм гэжээ. Үлгэрлэвээс чихрийн мод, сүү, чихэр тэргүүтэн нь амтаараа нэгэн янзын дээд амттай боловч амьтан тус бүрийн сүүнд өвөрмөц ялгаа их байдаг тэр мэтийг үзүүлж хаанаас чадах мэт болой гэж Зохист аялгууны найруулгын эрдмийн хязгааргүй нарийн гайхамшигтайг өгүүлсэн байдаг.

**Төгс сайн зохист аялгууны шалтгаан** юу болохыг Дандин бээр Мөрийн аймгийн бүлгийнхээ төгсгөлд: Төрөлх бүтсэн самбаа, Хир үгүй олон сонссон ба Мөхөс үгүй илтэд барилдах нь зохист аялгууны хотол төгсөх шалтгаан болно гэжээ. Өөрөөр хэлбэл: Яруу найрагч болоход зайлшгүй хэрэгтэй гурван чухал үндэс нь 1.Төрөлхийн авъяас билэг, 2.Эрдэм мэдлэг, 3.Их хичээл оролдлого буюу Уйгагүй хөдөлмөр (ДЗАТ. 1982. т.36) юм. Эдгээрийн үр дүнд төгс сайн зохист аялгуу бий болно гэжээ. Дандин бээр:

Тиймийн тулд алдрыг таалагчид бээр  
Залхай үгүйеэ зэргээр насад Сарасватийг шүттүгэй  
Зохист аялгуунд өчүүхэн төдий алжаагч хүмүүн бээр

Мэргэдийн хурал нугууддаа суух эрхт буюу (ТМДДЗАТ, 2017. т.117) гэсэн нь мэдлэг ухааны Охин тэнгэрт зөвхөн шүтэн мөргөхийг хэлсэн бус Зохист аялгууны эрдэм ухаанд шүтэж уйгагүй хичээнгүй суралцахын чухлыг хэлсэн ажээ.

### **Утгын чимэг**

Дандины “Зохист аялгууны толь”-ийн хоёрдугаар бүлэг. Энэ бүлгийг бүхэлд нь Утгын 35 чимэг эзэлж байна. Энэ Утгын чимгийн II бүлгийн 365 бадагт урнаар дүрслэхийн уг мөн чанарыг нээж, ямар аргаар утгын чимгийг илрүүлбэл сая хүний сэтгэлийг хөдөлгөж чадах вэ гэдэг аргыг тодорхойлж жишээгээр үзүүлжээ.

**Утгын чимэг** (тө: don rgyan) гэдэг нь өгүүлж байгаа зүйлсийнхээ утга санааг улам тодорхой, тансаг гоо сайхан болгохын тулд адилтгаж зүйрлэж үлгэрлэж ихэсгэж багасах зэрэг уран дүрслэлийн олон арга болгомжийг хэрэглэж буй аргыг “Зохист аялгуу”-нд Утгын чимэг гэнэ. Өөрөөр хэлбэл өгүүлэгдэхүүний утгыг сайхан болгодог өгүүлэмж. Утгын чимэг нь гучин таван зүйлд хуваагддаг.

Дандин бээр “Зохист аялгууны толь”-доо Утгын 35 чимгээ, мөн түүний доторхи зүйл чимгүүдийг дэс дараалан жагсааж тус тусаар нь тайлбарлаж бодит жишээгээр үзүүлжээ.

#### **Утгын 35 чимгийн зүйл ангилал:**

1. Өвөрчлөнг өгүүлэх чимэгт 4 зүйл,
2. Адилтгалын чимэгт 32 зүйл,
3. Дүрстийн чимэгт 20 зүйл,
4. Гийгүүлэгч чимэгт 12 зүйл,
5. Эргэгч чимэгт 3 зүйл,
6. Түртгэгч чимэгт 23 зүйл,
7. Бус утгыг байгуулах чимэгт 8 зүйл,
8. Урвалгат чимэгт 1 зүйл,
9. Бологч чимэгт 3 зүйл,
10. Хураах чимэгт 4 зүйл,
11. Хэтэрхий болсон чимэгт 4 зүйл,
12. Маш гүтгүүлэгч чимэгт 3 зүйл,
13. Шалтгааны чимэгт 16 зүйл,
14. Нарийны чимэгт 2 зүйл,

15. Хувьсын чимэгт 4 зүйл,
16. Зэрэгчлэн чимэгт 1 зүйл,
17. Баясгалангийн чимэгт 2 зүйл,
18. Зохистын чимэг 8 зүйл,
19. Сүр жавхлантын чимэгт 1 зүйл,
20. Зүйл өгүүлэлтийн чимэгт 1 зүйл,
21. Хамгаа тустын чимэгт 1 зүйл,
22. Ахуй ихийн чимэгт 2 зүйл,
23. Гөрлөгчийн чимэгт 3 зүйл,
24. Найралдагчийн чимэгт 9 зүйл,
25. Ялгамжитын чимэгт 5 зүйл,
26. Адилтган найруулахын чимэгт 2 зүйл,
27. Харшлагчийн чимэгт 6 зүйл,
28. Бус үесийг магтах чимэгт 1 зүйл,
29. Хуурмагаар магтах чимэгт 3 зүйл,
30. Магад үзүүлэхийн чимэгт 2 зүйл,
31. Хамтадган өгүүлэхийн чимэгт 3 зүйл,
32. Огоот арилжих чимэгт 1 зүйл,
33. Бахдах чимэгт 1 зүйл,
34. Маш хольцогч чимэгт 2 зүйл,
35. Таалсан чимэгт 1 зүйл. Нийт (194) 200 шахам чимэг байна.

Утгын 35 чимэг, түүний доторхи зүйл чимгүүдийн тодорхойлолт тайлбар жишээтэй товч танилцъя.

*Нэг. ӨВӨРЧЛӨНГ ӨГҮҮЛЭХ ЧИМЭГ*<sup>7</sup> “Зохист аялгууны толь”-ийн Утгын 35 чимгийн анхдугаар чимэг. Уран сайхны дүрийг гаргахдаа тухайн юм нь оршин байгаа байдлаараа бусдаас ялгарах онцлог, бусдад үгүй зөвхөн түүнд байдаг өвөрмөц шинж байдал дүр төрхийг өгүүлнэ. Ингэхдээ түүний *язгуур, эд, эрдэм, үйлс* нь ямар гол онцлог ялгаатайг тодруулан дүрсэлж үзүүлдэг арга.

Зохиолдоо гаргах дүр дүрслэлийг үзүүлэхдээ уг юмыг магтахгүй, муушаахгүй, энгийн байгаа байдлаар товч тодорхой, ил шуудаар өгүүлэх нь энэ чимгийн гол үүрэг зарчим. Энэ чимгийг Утгын гучин таван чимгийн доторх хамгийн эрхэм нь бөгөөд хаан төр мэт хэмээн үздэг. Хаан төр мэт гэж зүйрлэсний учир нь ихэнх зохиол туурвил

<sup>7</sup> Утгын чимэг - “Дандины Зохист аялгууны толийн гол нэр утгын тайлбар”. Хамтын бүтээл. 2017. т.65-169)-ийн Өвөрчлөнг өгүүлэхээс Няцалгат 8 чимгийг төвдөч гэвч, докторант Ж.Ерөөлт хийсэн. Үүнээс товчлон авав. (са: svabhāboki, тө: rang bzhin brjod, хя.直叙修饰).

энэхүү чимгийн үүднээс бичигдсэн байдаг.

Өвөрчлөн гэдэг үг нь монгол хэлэнд төвд хэлнээс ороод нэгэнт тогтсон “Араншин” хэмээх үгийн монгол орчуулга бөгөөд өөрийн төрөлх зан байдал, төрөлх чанар, уугуул зан, өөрийн нь жам ёс гэх мэтийн утгыг илэрхийлнэ. Жишээ нь: Галын араншин буюу өвөрчлөн нь халуун бөгөөд түлдэг, шорооны араншин буюу өвөрчлөн нь хатуу бөгөөд бат бэх, усны араншин буюу өвөрчлөн нь шингэн бөгөөд норгодог, нарны өвөрчлөн буюу араншин нь гэрэлтүүлж гийгүүлэх хийгээд халааж дулаацуулдаг, сарны өвөрчлөн буюу араншин нь хөргөж сэрүүцүүлдэг болон гэрэлтүүлж гийгүүлдэг төрөлх чанартай.

Өвөрчлөнг өгүүлэх чимэг нь дотроо: Язгуур өвөрчлөнг өгүүлэх, Үйлдвэр(үйл) өвөрчлөнг өгүүлэх, Эрдэм өвөрчлөнг өгүүлэх, Эд өвөрчлөнг өгүүлэх чимэг - гэсэн дөрвөн зүйлээр хуваагдана.

**1.1. Язгуур өвөрчлөнг өгүүлэх чимэг** (ca. jāti, тө: rigs). Өвөрчлөнг өгүүлэх чимгийн нэг зүйл. Энэ нь өгүүлэгдэх зүйлийнхээ язгуурын түгээмэл шинж чанар ялгамжааг тодорхой дурдаж, үүгээрээ тухайн өгүүлж буй зүйлийн язгуур төрлийг нийтээр нь тодотгон үзүүлж, түүнийг бусад язгуур төрөл зүйлийн юмсаас ялган тодруулж өгөх нь энэ чимгийн үүрэг юм. Өөрөөр хэлбэл, алив нэгэн бодис нь өөрийн язгуур төрөлтэй байдаг, тэр төрөл нь нийтээрээ бусад төрөл зүйлээс ялгарах онцлог шинж тэмдгээр түгээмэл байдаг, түүнийг нь энд илрүүлэн тодотгож гаргаж өгөхийг хэлж байна.

Язгуур гэдэг нь нэг хэсэг бүлэг юмс үзэгдэл, хүн, амьтанд байдаг түгээмэл нэг онцлог шинж юм. Энэ язгуур нь тухай зүйлийн бусад төрөл зүйлээс ангид юм гэдгийг далдуур заана. Мөн тухайн зүйлийн өөрийнх нь онцлог шинж чанарыг нээн гаргаж өгнө. Жишээ нь: Багана гэхэд түүний нийтлэг түгээмэл шинж нь тулж түших тулгуур болдог нийтлэг шинж үүрэгтэй бөгөөд баганын энэхүү тулгуур болдог шинж чанарыг өгүүлбэл нийт баганын язгуурыг өгүүлсэн хэрэг болно. Мөн үүгээрээ сав, суулга гэх мэт агуулж хадгалах үүрэг бүхий төрөл зүйлээс ангид гэдгийг далдуур ялгаж өгсөн байна.

Дандин энэ чимэгт тотъ шувууг жишээ болгож үзүүлсэн:

Эхийсэн улаан хошуут болоод  
Эелдэг ногоон жигүүрт ба  
Эрээлсэн гурван өнгийн хоолойт

Эдгээр уран аялгуу төгссөн тоть (ТМДДЗАТ. 2017. т.130)

гэжээ. Үүнд, тоть шувууны тухай өгүүлэхдээ түүний хошуу, жигүүр, хоолой, дуу гэсэн ийм дөрвөн зүйлийн шинжийг гаргасан. Тотийн хошуу нь өнгөний хувьд улаан, хэлбэрийн хувьд эхийсэн махигар, жигүүр нь өнгөний хувьд ногоон, хүрэлцэхүүний хувьд буюу биеэр хүрэлцвээс эелдэг зөөлөн, хүзүү хоолой нь цагаан, улаан, хөх гурван өнгө зэрэгцсэн, дуу авианы хувьд зөөлөн ийм шинжтэй бөгөөд энэ нь тотийн язгуурынхны түгээмэл нийтлэг шинж болох бөгөөд эдгээрийг дурдсанаар бусад шувуудын төрөл зүйлээс ялгасан хэрэг болно. Зөвхөн шувууны төрөл зүйл ч гэхгүй, тотиос л бусад зүйлсээс ялгаруулж өгч байгаа хэрэг.

Мөн бас энд онцлон дурдах нэгэн зүйл нь таван мэдрэхүйд өртөгдөх мэдрэмжийг гаргаж өгөх нь чухал байдаг. Нүдний эрхтэнд өртөх нь өнгө, хэлбэр хоёр бөгөөд чихэнд дуу авиа, хэлэнд амт, хамарт үнэр, биед хүрэлцэл оногдох. Эдгээр тав нь хүслийн таван эрдэм буюу тэгш таван хүсэл гэдгийн нэрийтгэлд хамаарах юм.

**1.2. Үйлдвэр өвөрчлөнг өгүүлэх чимэг** (ca. kriya, тө: bya). Үйлдвэр хэмээх нь үйл, үйлс, үйлийн үр дүнг өгүүлнэ. Энэ чимэг үйлийн эзэн бээр үйлийн орон байц алин нэгнээ үйл алиныг үйлдсээр байгаа буюу үйлдэж дууссан шинж байдлыг шулуун шударгаар нэмж хасалгүй дурдан өгүүлэхийг хэлнэ. Энэ чимэгт үйл үйлдлийн шинж чанарыг өгүүлэх ёстой учир үйлийн чиглэл заасан тийн ялгал, үйлдэхийн тийн ялгал зэрэг нөхцөл дагаврыг ашиглахаас гадна тухайн шүлэгт үйлдэгч эзэн, үйлдлийн орон, үйл ажил гурав дүрслэгдэх ёстой. Өвөрчлөнг өгүүлэх чимгийн нэг зүйл нь. Энэ чимэгт Дандины бичсэн жишээ:

Хоолой дотроо яруу дуугаар донгодон  
Хотолд нүдэн хувилгагч тагтаа шувуун  
Хурьцан наадахын тулд баясагч эм лүгээ  
Хошуугаа тохиолдуулж огоот эргэмүй (ТМДДЗАТ. 2017. т.131)

хэмээн үйлийн эзэн эр тагтаа бээр үйлийн орон баясгалант эмд (эм тагтаа) наадахыг хүссэн үйлдлийн онцлог нь хоолойн дотроос тодорхой бусын бүгт дуугаар донгодож, хүсэл тачаалд согтсон нүд нь улаан өнгө бүхүй болж, дүрлийн дүгрэглэж, эргэлдүүлэн хувилгах буюу хөдөлгөх байдлаар өөрийн баясгалант эм тагтааг тойрон эргэцэж, хошуугаа хошуунд нь нийлүүлэх үйлийг үйлдэн буй тачаасан

дүр төрхийг гаргажээ. Энэ шүлгийн дотор өгүүлэгдэж буй эр тагтаа, үйлдлийн орон эм тагтаа, үйлийн онцлог шинж уянгатайгаар донгодох, нүдээ хувилгах, наадах, тойрох, хошуу нийлүүлэх гэх мэт ийм үйл үгийг тодорхой гаргаж, үйлийн эзэн түүний үйл үйлдлийн шинж ёсыг хэтрүүлж хэлбийлгэлгүй, шулуун шударгаар өгүүлсэн. Үүнд: үйлийн эзэн: эр тагтаа, үйлдлийн орон: баясахуй эм буюу эм тагтаа, үйлийн шинж онцлог нь: бүгт дуугаар донгодсон, нүд нь зүйл бүрээр хувирсан, наадах байдал гаргасан, тойрч эргэцсэн, хошуугаа нийлүүлсэн гэх мэт шинжийг гаргажээ.

1.3. **Эрдэм өвөрчлөнг өгүүлэх чимэг** (ca. гуңа тө: yon tan). Энэ нь өгүүлэгдэх орны эрдэм чадлын өвөрмөц төрх үйлдэл буюу хариу үйлдлийг тодруулж гаргахыг эрдэм өвөрчлөнг өгүүлэх чимэг гэнэ. Энэ чимгийг гаргаж үзүүлэхэд үйлдэхийн тийн ялгалын нөхцөл дагаврыг ашиглана.

Энд үйлийн оронд үзүүлсэн үйлдэгчийн чадал эрдэм, нөлөөллийг тодруулж өгүүлдэг. Үйлдвэр өвөрчлөнг өгүүлэх чимэгт үйлийн эзний зүгээс үйлийн оронд үзүүлэх шууд үйлдлийг заасан бол энд түүний хариуд үйлийн орноос гаргах үйлдлийг үзүүлснээр ийм үйлдэл гаргуулах болсон үйлийн эзний эрдэм чадлыг тодруулах нь энэ чимгийн зорилго болно. Өвөрчлөнг өгүүлэх чимгийн нэг зүйл нь. Энэ чимэгт Дандины бичсэн жишээ

Баясгалант эхийн энэ биед хүрэлцсэнээр

Үсэн өрвийн дэлгэрэх ба

Сэтгэл амун үйлдэхүй лүгээ

Нүдэн нүгүүдийг алин үйлдээд орохуй (ТМДДЗАТ. 2017. т.132)

хэмээн орон Баясгалант эхийн биед хүрсэн хүртлийн чадал эрдэм үүгээр оронг эрд хүсэл төрж, биеийн шар үс өрвийн дэлгэрээд, сэтгэл нь амгалангийн хурц мэдрэмжээр дүүрч, хүсэлдээ согтуурснаас нүд нь анилдаад, хүсэл эдэлснээр амгалангийн мэдрэмжийг олж авна хэмээн эмийн биед хүрснээс үүссэн хүрэлцлийн эрдэм чадлын үйл үйлдвэрт найруулж шулуунаар өгүүлсэн байна.

1.4. **Эд өвөрчлөнг өгүүлэх чимэг** (ca: dravya, тө: rdzas). Өгүүлэхүүн бодис түүний онцлог эд зүйл, шинж тэмдгийг тодруулан гаргаж, түүний утга дүрийг онож мэдүүлэхийг эд өвөрчлөнг өгүүлэх чимэг гэнэ. Өвөрчлөнг өгүүлэх чимгийн нэг зүйл.

Энэхүү эд өвөрчлөнг өгүүлэх чимгийн эд хэмээхийн гол зарчим нь өгүүлэгдэх орон түүний бусдаас ялгарч харагдах өвөрмөц шинжийг заах бөгөөд тэрхүү шинжид дулдуйдан өгүүлэгдэж буй бодисын ганц өөрт нь байдаг өөрийнх нь өвөрмөц шинжийг гаргахаар барахгүй, түүнийг бусад язгуур эндүүрэхгүй байх онцлогийг гаргана. Жишээ нь:

Хөх хоолойтын гарт оршсон гавал  
Хийгээд сарны титэм ба бүхнийг бүрхсэн  
Улаан үст, сүргийн манлай дуазат энэ нь  
Бүхнээс ялгадаг болой (ДЗАТ. 1982. т.44)

Ванчиг буюу Хөх хоолойт хэмээх тэнгэр нь гартаа рашааны сав гавал барьсан нь бусад тэнгэрт байдаггүй эд. Мөн энэ тэнгэр оройдоо саран чимэгтэй, огторгуйг бүрхмээр тослог улаан үстэй, тэнгэрийн буянаар төрсөн заанаар туг хийсэн. Эдгээр нь Ванчиг тэнгэрийг бусдаас ялгаж өгсөн эд мөн тул үүнийг эддийг өгүүлэх чимгийн жишээ болж байна(ДЗАТ. 1982. т.44)

**Язгуурын чимэг.** Энэ нь Өвөрчлөнг өгүүлэх дөрвөн чимгийн онцлог чанарыг хэлж байна. Язгуур, Үйлс, Эрдэм, Эд буюу дүр, үйл, юм, чадал энэ дөрвийг гарган өгүүлдэг нь хаан хүнд төрийн эрх байдгийн адил урнаар дүрслэх аргын эн тэргүүнд уг чимгийг хэрэглэдэг дээд арга учир бүх чимэгт Хаан төр мэт юм гэж үздэг байна. Өвөрчлөнг өгүүлэхдээ бодис тус тусын ахуй ёсыг магтах, муулах зэргийг тэвчиж, уг мөн чанарыг байгаа байдлаар нь шулуун өгүүлэхдээ түүнтэй холбогдсон элдэв зүйлийн шинж олныг өгүүлдэг учраас “Язгуурын чимэг” хэмээдэг.

**Хоёр. АДИЛТГАЛЫН ЧИМЭГ** (са: uramā, тө: Dpe rgyan, хя. 比喻修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн хоёрдугаарх чимэг. Үлгэрийн чимэг ч гэдэг. Хоёр юмны үзэсгэлэнг адилтгахдаа үлгэр үлгэрт хоёрыг харилцан адилтган үзүүлэх арга.

Адилтгалын чимгийн чухал нь адилтгагдаж буй зүйл болон адилсуулж буй зүйл хоёрыг ямагт тусгаар найруулна. Өөрөөр хэлбэл, жишээ үлгэр болгон авч буй зүйлд ямар эрдэм чадал, шинж чанар буй тэр нь адилтгуулж буй (үндсэн утгын) зүйл дотор ч буйг зэрэгцүүлэн ижилсүүлж, түүнийгээ тодотгосон үг найрлагаар ил, далдын аль нэгээр гаргана.

Адилтгалд гурван зүйл чухал. Тэр нь адилтгагдахууны чанар, адилтгаж чадах үг, адилтгалын холбоц гишүүн гурав юм. Үүнд, адилтгал болон адилтгуулагч хоёрын харилцааг гаргахад хэрэглэдэг “Адилтган гийгүүлэгч үг” гэсэн жаран таван зүйл бий. Адилтгалын хамгийн чухал нь адилтгал болон адилтгуулагч хоёрыг тусгаарлан зааглаж, дээр өгүүлсэн “Адилтган гийгүүлэгч үг”-ээр тодотгон гаргаж өгөхийг адилтгалын чимэг хэмээнэ.

Дандин энэ чимэгт 32 адилтгал гаргасан нь зөвхөн нэг юмны олон төрлийн хувилбар биш юм. Юмыг онож мэддэг ба хэмжиж мэддэг мэдэл, тэрхүү мэдлийн үүднээс гадаад ертөнцөд байдаг бүх зүйл, түүний хэсэг, тэдгээрийн үйл, нөлөө тэргүүтнийг тухайн байдлаар нь гаргаваас зохихыг харуулсан учир адилтгал бол цаанаа юмыг үзэх, цэнэх нарийн тогтолцоог агуулсан зүйл юм. Адилтгалыг гаргахдаа 1.Өгүүлбэрийн бүтцийн арга, 2.Адилтгах үг хэрэглэж гаргах, 3.Үг таслах аргыг хэрэглүүр болгох. Ийм гурван аргыг түшиглэжээ.

Адилтгалын чимэг нь өгүүлэх зүйлийн дүр хувирлаас хамаарч хязгааргүй олон зүйл байж болохыг Дандин бээр заагаад “Зохист аялгууны толь”-доо 32 зүйлийн адилтгалын чимгийг авч үзжээ. Үүнд: Номын, бодын, няцахуй, эсрэг тэсрэгийн, магадласан, магадгүй, хураахын, тансаг болсон, маш гүтгэсэн, гайхамшигт, мунхарсаны, түүдгэрсний, магад, найруулах, тэгш, доромжлох, сайшаах, өгүүлэхүй дуршигч, харшлах, хаахуй, үзэсгэлэнт, мөнхүү түүнийг өгүүлэгч, ерөнхий бусын, болох бус, олон ялгамжтаныг тодруулагч, дүр хөрвүүлэгч, эрихийн, үгсийн утгын, тэнсэлдэгч бодын, найруулсан, шалтгааны адилтгал - эдгээр 32 зүйл болно.

2.1. **Номын адилтгал** (са: Dharmapama, тө: chos dpe). Аливаа юмны хэсгийн ялгааг бодитой ил өгүүлэх арга. Адилтгалын чимгийн нэг зүйл. Ном, номын хэмээх нь энэ чимгийн тухайд ямар нэгэн юмны салаа салбар, хэсэг гэсэн утгатай. Иймд номын адилтгал гэдэг нь магтан өгүүлэх зүйлийнхээ аль нэг гишүүнийг ижилсэж болох өөр бас нэг гишүүнтэй адилтгаж өгүүлэх арга юм. Энэ чимгээр найруулахдаа адилтгалын гийгүүлэгч үгийг шууд ил найруулах буюу адилтгал, адилтгагдахуун хоёрыг ижилсүүлж буй тэр утгыг шууд гаргаж өгнө. Дандины жишээ

Үзэсгэлэнт эх чиний гарын алга нь,



Уснаас төрөгч мэт хамгаа улаан

хэмээсэн энэ шүлэгт: Үзэсгэлэнт эх (бүсгүй) - ээ чиний зөөлөн бөгөөд залуу насны мах мариат гарын алга чинь уснаас төрөгч лянхуа цэцэг мэтээр бүхэлдээ улаан харагдаж байна гэж ижилсэж буй улаан өнгийг шууд гарган найруулжээ. Бүсгүй чиний гарын алга нь лянхуа цэцэг мэт гэж зэрэгцүүлэн адилтгасан бөгөөд юугаар чухам адил юм гэдэг нь харагдахгүй, харин бүхнээс улаан хэмээж, улаан өнгийг зааж гаргаж өгснөөр цэцгийн хэсэг болсон туурцагийн улаан өнгө, хүний жавхлангийн хэсэг болсон алганы улаан өнгө хоёр адилсаж, хэсгийн жавхланг наанаа өгүүлж улмаар бүхлийн жавхланг цаанаа сайхан гэж үзүүлж байна.

2.2. **Бодын адилтгал** (ca: vastoopama, тө: dnos pa'i dre). Алив нэг юмны ерөнхий бүхлийг ил найруулж сайхныг үзүүлэхдээ мөн түүний хэсэг гишүүний сайхныг ч далддаа хамт үзүүлдэг арга. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины жишээ:

Лянхуа мэт чиний нүүрт  
Хөх удвал мэт нүдэн

хэмээх энэ нь **бодын адилтгал** болно.

Номын адилтгал чимэгт бүхлийн доторх ижилсэж буй гишүүн хэсэг болох тэр зүйлийг илээр хэлж өгсөн бол энэ бодын адилтгал чимэгт тийм бус. Харин эсрэгээр чухам ижилсэж буй зүйлийг далдлаад, ижилсүүлгийг агуулж буй бүхэл хэсгийг “Бод” хэмээсэн нэрийн дор ил шуудаар гаргаж найруулсан нь энэ чимгийн утга ажээ. Өөрөөр хэлбэл, бүсгүйн нүүрийг лянхуатай, нүдийг нь хөх удвалтай шууд илээр зүйрлэж гаргаж ирсэн хэрнээ, юугаараа ижил вэ гэдгийг шууд хэлсэнгүй. Учир нь, лянхуа бол цагаан өнгөтэй байдаг, хөх удвал бол уртлаг зууван хэлбэртэй байдаг. Ингэхээр лянхуа шиг нүүр гэхээр бүсгүйн царайг цагаан юм байна, хөх удвал шиг нүд гэнгүүт уртлаг зууван нүдний хэлбэр уншигчид бууж ирэх ёстой ажээ. Чухамдаа цагаан өнгө, уртлаг зууван хоёр хэлбэрээр ижилсүүлж байгаагаа “Лянхуа мэт”, “Хөх удвал мэт” хэмээсэн үгсээр найруулж, “цагаан”, “уртлаг” гэх өнгө, хэлбэр хоёрыг далдалж найруулсан нь “Бод”-ын адилтгал болно.

2.3. **Няцагч адилтгал** (ca: viparyasopama, тө: grags pa bzlog pa'i dre). Үүнд адилтгагдахуун тэр адилтгалын адилсал номд нааш найруулах

учраас найруулах ёсны ухаарц няцалгатаныг няцалгатын адилтгал хэмээдэг. Өөрөөр хэлбэл нэгэнт хэвшил болсон адилтгах аргыг сөргүү хэрэглэх арга юм. Адилтгалын чимгийн нэг зүйл. Бодхайвын:

“Нарийн биет ээ, чиний нүүрийн адилаар

Эдгээр лянхуас нь үзэсгэлэнтэй еэ сайтар дэлгэрэх амуй

хэмээх шүлэг бол ертөнц дахинаа адилтгал үлгэрээр үнэн утгыг таниулж ойлгуулдаг журмаас няцаж, адилтгагдахуун буюу адилтуугалах зүйл болох бүсгүйн нүүр түүгээр адилтгал лянхуагаа тодруулж таниулж байна. Үүнд, Нарийн биет гэдэг нь эмэгтэй хүнийг нэрлэх ёгт нэр болно. Зүй нь, лянхуа цэцэгс мэтээр чиний нүүр машид дэлгэрэх амуй хэмээн хэлсэн бол ертөнц дахины зөв жишээ адилтгал болох байсан, гэтэл үүнээс няцаж буюу урвуулан чиний нүүр мэтээр лянхуа цэцэг сайхан дэлгэрэх болмуй хэмээн хэлсэн нь ертөнц дахины адилтгаж үлгэрлэх ёсоос гажиж зүйрлэсэн нь энэ чимгийн онцлог болно. Энэ чимэгт тайлбар хийсэн зохист аялгууч нар онцолж буй нэг зүйл нь, энд хэдийгээр хүүхний нүүрээр лянхуаг жишээд байгаа сөрвүү урвуу адилтгал гэж нэрлэж байвч, цаад чанартаа мөнөөхөн хүүхний нүүр, лянхуа хоёрыг ижилсүүлэн адилтгаж буй юм гэдгийг мэдэж байх хэрэгтэй гэжээ.

2.4. **Эсрэг тэсрэгийн адилтгал** (са: annyonyorama, тө: phan tshun dre). Адилтгал, адилтгагдахуун хоёрыг харилцан ээлжлэн нааш цааш, нэг нэгэнд нь адилтгал болгож, харилцан ижилсүүлж өгүүлэхийг эсрэг тэсрэгийн адилтгал хэмээнэ. Эсрэг тэсрэг хэмээх үгийг нааш цааш, харилцан гэх мэтээр ойлгож болно. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Чиний нүүр мэт уснаас төрөгч бөгөөд

Уснаас ургагч мэт чиний нүүр

гэх **эсрэг тэсрэгийн адилтгалын** жишээ шүлэгт адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхэн чиний нүүр мэтээр адилтгал уснаас төрөгч үзэсгэлэнтэй, адилтгал уснаас төрөгч мэтчлэн чиний нүүр ч үзэсгэлэнтэй хэмээжээ. Ингэж адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхний нүүр, адилтгал лянхуа (Уснаас төрөгч гэж лянхуаны ёгт нэр) цэцэг хоёрыг харилцан нааш цааш, эсрэг тэсрэг зүйрлэж адилтгаснаар адилтгал, адилтгагдахуун<sup>8</sup> хоёрыг харилцан таниулж ойлгуулах нь энэ чимгийн үүрэг юм.

<sup>8</sup> Адилтгал, адилтгагдахуун - үлгэр, үлгэрт хэмээн зарим зохист аялгууны номд бичсэн байдаг.

2.5. **Магадласан адилтгал** (ca: niyamopama, тө: nges pa nyid kyī dpe). Адилтгалын чимгийн нэг зүйл. Өгүүлж ойлгуулах гээд байгаа утга буюу адилтгагдахуун тэр маань онцгой нэгэн зүйл болохын эрхээр түүний адилтгалд зохиж дүйцэх зүйл ганцаас өөр байхгүй учраас тэрхүү ганц адилтгалтай нь зүйрлэж өгүүлэхийг магадласан адилтгал гэнэ. Өөрөөр хэлбэл, энэ утга өгүүлэмжид тохирч дүйх адилтгал ганц л байна хэмээсэн санаа. Дандины

Чиний нүүр нь ямагт лянхуа лугаа адил  
Бус ав алин лугаа ч адил бус

гэх шүлэгт бүсгүй чиний нүүр гагцхүү лянхуа лугаа адилсах биз ээ, түүнээс бусад адилтгал нь хаана ч байхгүй хэмээн, адилтган үлгэрлэх бусад зүйлийг хориглож, цор ганц (лянхуан) адилтгалд магадтайяа тогтоож өгч буй нь “Магадалсан адилтгал” болж байна.

2.6. **Магадгүй адилтгал** (ca: Anjyamopama, тө: nges med dpe). Адилтгагдахуун адилтгал хоёрыг харилцан ижилсүүлээд, дээрээс нь одоо бол адилтгал тэр мэт нэгэн байх аваас чиний адилтгалд зохистой болой хэмээж адилтгагдахуун түүнд адилтгал ганц буй гэж магадлалгүйгээр өгүүлэхийг “Магадгүйн адилтгал” хэмээнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Агваанлуvsсанжамцын жишээ шүлэгт:

Энэхүү Төвдийн зөөлөн итгэл хамгийг айлдагч Зонхов гэгээн  
Энэтхэгийн их тэргэн Нагаржуна лугаа сацуу буй за,  
Эгүүнээс бус өөр тэр адилын төгөлдөр авир ёстонууд  
Энэ сансарт байх аваас чамд тэнцэх хань болох нь зүйтэй

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.109)

хэмээн (адилтгагдахуун) зөөлөн итгэл лам Зонхов бээр (адилтгал) их тэргэн Нагаржуна лугаа сацуу бөгөөд өөр бас (адилтгал) итгэл Нагаржуна адил (нэгэн) энэ ертөнцөд байх аваас зөөлөн итгэл Зонхов ламын адилтгалд зохистой болно гэсэн утга юм.

2.7. **Хураахын адилтгал** (ca: samucchayopama, тө: bsdus pa'i dpe). Адилтгагдахуун түүний ялгалын ном буюу эрдмийн нэгэн зүг гагцхүү төдийг адилтгал түүн лүгээ ижилсүүлэх бус адилтгагдахуун түүний эрдэм (чадал) буюу ялгалын ном бусдыг ч хураагаад тэрхүү адилтгалд ижилсүүлэн найруулах бөгөөд адилтгагдахууны ялгалын ном хоёрыг хураагаад адилтгал лугаа ижилсүүлэн найруулах үгийг бодитой

шуудаар гаргахыг “Хураахын адилтгал” хэмээнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Ямагт чиний нүүрийн үзэсгэлэн нь  
Сарны хойноос одохуй бус амуй  
Баясгаланг төрүүлэгч үйлсээр

хэмээсэн **хураахуйн адилтгалын** жишээ шүлэгт (адилтгагдахуун) үзэсгэлэнт хүүхэн чиний нүүрийн үзэсгэлэн гагц нь (адилтгал) сарны хойноос одох буюу ижилсэх хэмээх бус бөгөөд эдүгээ үзэсгэлэнт чамайг үзсэнээр бусдад баяр баясгалан төрж үйлддэг үйл үйлдвэр тэргүүтэн эдгээрийг хурааснаар (адилтгал) сар лугаа ижил болой хэмээн (адилтгагдахуун) үзэсгэлэнгийн эрдэм чадал ба түүний үйлдэл баяр бахдалыг үүсгэж байдаг хоёрыг хураагаад (адилтгал) сар лугаа ижилсүүлж найруулсан ажээ.

2.8. **Тансаг болсон адилтгал** (ca: Atisayopama, тө: phul byung dre). Адилтгал хийгээд адилтгагдахуун хоёрт өөр өөрийн шүтээн буюу орон шүтээн тус тусын ялгаа бага зэрэг байх төдийгөөс бус бүх талаас ижил гэсэн үгээр тодорхойлж гаргах бөгөөд адилтгал хийгээд адилтгагдахуун хоёрт адилгүй ялгамж олон байвч ялгаагүй хэмээн их хүчилж (хэтрүүлж) өгүүлснийг “Тансаг болсон адилтгал” гэнэ. Мөн тэр нь ертөнцийн зүй тогтолоос давж өгүүлэх бөгөөд хэлэх ярихаас хэтэрсэн утгыг гаргах хэрэгтэй болдог. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Чиний нүүр нь мөн чамд  
Үзэгдээд саран нь огторгуйд үзэгдэхүй  
Ямагт мөн үүнээс өөр тус бүр үгүй

хэмээсэн **тансаг болсон адилтгалын** шүлэгт: (адилтгагдахуун) үзэсгэлэнт чиний нүүр нь чиний биеийн дээр үзэгдэх бөгөөд (адилтгал) саран нь огторгуйд үзэгдэнэ. Үзэгдэх орон ялгаатай болохоос өөр ялгаа үгүй хэмээн үзүүлжээ. Ер (адилтгал) саранд (адилтгагдахуун) үзэсгэлэнт бүсгүйн нүүрнээс үлэмж илүү ялгаа олон байдаг боловч ялгаа байхгүй мэтээр их хэтрүүлж өгүүлсэн ажээ. Зарим орчуулгад “Ялгамжаат адилтгал” хэмээн нэрлэсэн байдаг.

2.9. **Маш гүтгэсэн адилтгал** (ca: utreksopama, тө: rab brtag dre) нь өгүүлбэрийн найруулгын аргаар зохиосон адилтгал. Адилтгалыг машинд гүтгэсэн буюу гүтгэсэн үгээр адилтгагдахууны эрэмшлийг

өгүүлж омгоор чи ганцаар бус түүний адилтгалд зохистой хэмээн санах хэрэггүй чамаас өөр бусад адилтгал ч адилтгагдахуун түүний адилтгалд зохистой буй хэмээн үзүүлэх. Өөрөөр хэлбэл адилтгалд түүний санаа байхгүй боловч байгаа мэтээр гүжирлэх үгийг шууд илээр гаргасныг “Машид гүтгэсэн адилтгал” гэнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Түүний нүүрийн цогийг сар бээр  
 Мөнхүү надад буй хэмээн эрэмших хэрэгт бус  
 Лянхуад ч тэрхүү буй

хэмээсэн **машид гүтгэсний адилтгал** энэ шүлэгт сайхан хүүхний нүүрийн жавхлан надад байна гэж сар хөөрлөх хэрэггүй, тэр нүүрийн жавхлан бадамд бас бий гэснээрээ сар, нүүр, лянхуа гурав адил болохыг үзүүлж байна.

2.10. **Гайхамшигт адилтгал** (са: Adbhutorama, тө: rmad byung dre). Адилтгал түүнээ адилтгагдахууны эрдэм чадал буюу ялгалын ном зарим нэг нь эс бүрдсэн бөгөөд хэрвээ тэдгээр эрдэм чадлууд бүрдсэн бол чиний адилтгал болох зохистой билээ хэмээн адилтгагдахуун түүнийгээ адилтгалаас хол давсан бөгөөд гайхамшигтай гэдгийг үзүүлэх үүднээс тэр тодруулах үгийг ч ил шуудаар гаргасныг “Гайхамшигт адилтгал” гэнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Хэрвээ зарим лянхуа цэцэг маш  
 Хувилгаан нүдийг төгсөх болбоос  
 Сайхан хөмсөгт чиний нүүрийн цогийг баригч амуь за

хэмээсэн энэ нь **гайхамшигт адилтгалын** жишээ шүлэгт: гол өгүүлэгдэхүүн яагаад гайхамшигт болов гэвэл зүгээр нэг бадам биш, эргэлдсэн сайхан нүдтэй бадам байвал сая уг нүүртэй адил болно гэж буй тул нүүрний адилтгал болох ёстой бадам нь өөр дээр эрвэлзсэн хос нүдтэй байж сая адил болж чадна гэж сайхан бүсгүйн царайны гоо сайхан нь (адилтгал) лянхуагаасаа үлэмж хол хэтэрхий болсон нь гайхамшиг тансаг болжээ хэмээн үзүүлжээ.

2.11. **Мунхарсны адилтгал** (са: Mōhorama, тө: rmongs pa'i dre). Өгүүлэгдэхүүний адилтгагдахууныг үзсэнээр адилтгалд эндүүрч, адилтгалыг үзсэнээр адилтгагдахуунд эндүүрснээс тэр хоёулангийн харилцан адилсах буюу ижилсэх хувь их учраас ялгаж үл чадсан эндүүрлийн утга бүхий үгээр өгүүлэхийг “Мунхарсаны адилтгал”

гэнэ. Эндүүрэл гэдэгт адилтгагдахуун хийгээд адилтгал хоёулыг таниж мэдэхгүй байгаа төдий бус гол эрхэм нь адилтгагдахууныг адилтгалтайгаа эндүүрэх юм. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Нарийн биет чиний нүүрийг туулайт буюу хэмээн  
Сэтгэн шинжилснээр чиний нүүр нь  
Сарны хойноос гүйцвэй

хэмээх **мунхарсны адилтгалын** шүлэгт: (адилтгагдахуун) нарийн биет (бүсгүй) чиний нүүр хийгээд (адилтгал) туулайт (саран) хоёр хэтэрхий адил учраас хаанаас ч ажигласан ялгаж салгаж огт чадахгүйгээр барахгүй, адилтгагдахуун (утга) бүсгүйн нүүр нь адилтгал (үлгэр) сартайгаа их төстэйн шалтгаанаар үзэсгэлэнт бүсгүйн нүүр гэж сарыг эндүүрч тачаасны эрхээр арван тавны саран ургахад түүний хойноос даган нэхэв гэжээ.

2.12. **Тээнэгэлзэхийн адилтгал** (ca: Samsayopama, тө: the tshom dre). Адилтгагдахууны ялгалын шүтээн буюу өөрөөр хэлбэл бүхэл, түүний ялгалын ном буюу хэсэг хоёрыг тус тус түүдгэрэх буюу тээнэгэлзэн эргэлзэхийн үүднээс үлгэр, утга хоёрыг ижилсүүлэн найруулсан үгийг гаргаж, адилтгагдахуун бодит утга ба адилтгал үлгэр хоёрыг ялгаж чадахгүй эргэлзэж байгааг өгүүлснийг “Түүдгэрсний адилтгал” буюу “Тээнэгэлзсэн адилтгал” гэнэ. “Мунхарсны адилтгал” нь адилтгагдахууныг адилтгалдаа баттай эндүүрсэн байх ёстой бол энд адилтгалыг адилтгагдахуунд арай ч бүрмөсөн эндүүрч орхиогүй, эргэлзэж тээнэгэлзсэн байдлаар ижилсүүлнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Зөгийс лянхуан дотор эргэсэн буюу юун  
Чиний нүүр дэх нүдэн хөдөлсөн буюу юун хэмээн  
Би сэтгэлээ огоот хэлбэрүүлбэй

хэмээх **тээнэгэрч түүдгэрсний адилтгал** шүлэгт: цагаан царайд улаан өнгө туяа тогтсон (ялгалын шүтээн) машид үзэсгэлэнтэй нэгний дээр хөхөмдөг хар машид үзэсгэлэнтэй бодис сэтгэлийг булаагч нэгэн буй энэ нь, адилтгалын (ялгалын шүтээн) лянхуаны дээр ялгалын ном зөгий хөдөлсөн буюу мөн өөрөөр болбоос адилтгагдахууны ялгалын шүтээн үзэсгэлэнт бүсгүйн нүүрэнд ялгалын ном нүд хөдөлсөн алин нэг мөн болохыг миний сэтгэл нь тээнэгэлзээд сайтар хэлбэрэн хөдлөснөөс бус нэгэн чигт баталж чадсангүй хэмээн адилтгал ба адилтгагдахууныг ижилсүүлж далдуур үзүүлээд нотлон эс буулгасан

бөгөөд сэжгээ тасалж чадалгүй тээнэгэлзэхийн үүднээс өгүүлжээ. Өөрөөр хэлбэл нүүрэнд эргэлдэж буй нүд, бадам дээр эргэлдэж буй зөгий хоёрын жавхлан, сэтгэл хөдөлгөх чанар адил учраас ялгаж чадалгүй эргэлзэж байгааг өгүүлжээ.

2.13. **Магад адилтгал** (ca: Nirnayopama, тө: gtan la ‘bebs pa’i dpe). Нотлох шийдэх тогтоох гэсэн утгатай. Адилтгалын чимгийн нэг зүйл. Магад адилтгал нь адилтагдахуунаасаа өчүүхэн бага доорд учраас адилтгагдахуун тэр нь адилтгалаасаа ямар нэг эрдэм чадлаар илүү гэдгийг нотлосон буюу өөрөөр хэлбэл адилтгал адилтгагдахуун аль нь мөн бишийн эргэлзээг таслаад магадыг олсон учир шалтгааныг шийдэж тогтоосныг хэлнэ. Энэ чимэг нь өмнө гарсан “Гайхамшигтын адилтгал”-аас юугаар ялгарах вэ гэвэл адилтгал нь адилтгагдахуунаасаа доорд буюу дутуу гэдгийг үзүүлснээрээ ижил авч “Гайхамшигтын адилтгалын” үед адилтгалд тийм нэг эрдэм чадал байхгүй гэдгийг суурь болгоод хэрэв тийм нэг эрдэм чадал байсан бол адилтгагдахуунтайгаа ижилсэх байлаа гэж өгүүлдэг. Харин энд адилтгалд байхгүй тийм эрдэм чадал нь адилтгагдахуундаа байж байгааг магадлаж олоод эргэлзээг таслаж лавтайяа шийдэн тогтсон болохыг харуулдаг. Дандины

Сарныг мятуулагч үзэсгэлэнт энэ нь

Сараар гэсгээгдэгч лянхуа бус

Тиймийн тулд мөнхүү чиний нүүр болой

хэмээх **магад адилтгалын** шүлгийн утга нь үзэсгэлэнт бүсгүйн нүүр өөрөө машцагаан. Тэрцагаан нүүрэндээр бага зэрэг улаавтар туяатах нь маш үзэсгэлэнтэй юм. Лянхуа цэцэг бас цагаан өнгөтэй бөгөөд бага зэрэг улаан туяатай байдаг. Цагаан бөгөөд улаан туяат гэдгээрээ энэ хоёр адил юм. Гэтэл энэ шүлэгт одоогоор энэ бол нүүр гэж тодроогүй байгаа бөгөөд энэ үзэсгэлэнтэйг лянхуа гэж байна. Тэгтэл энэ нь бодит утгаараа бол лянхуа цэцэг биш юм. Яагаад гэвэл лянхуа шөнө сарны гэрэлд дэлбээгээ хумьдаг. Гэтэл энэ шүлэгт бол цагаан улаан өнгөөр гэрэлтэн байгаа тэр нь өдөр ч шөнө ч үзэсгэлэнтэй хэвээрээ байна. Тэгэхлээр энэ бол яах аргагүй үзэсгэлэнт бүсгүй чиний нүүр байгаа юм гээд адилтгал лянхуа нь сараар дарагддаг бол үзэсгэлэнт хүүхэн чиний нүүр нь сараар дарагдахгүй шөнө ч гэсэн гэрэлтэж сарыг ичээгээд байна. Иймээс сарыг ч мятруулах буюу ичээгч машид үзэсгэлэнтэй байгаа тэр нэг зүйл нь юу юм бэ хэмээвээс (адилтгал) лянхуа нь сараар гэсгээгддэг буюу дэлбээгээ хумьдаг бөгөөтөл чиний нүүр нь сараар

ч гэсгээгдэхгүй байгаа тул (адилтгагдахуун) үзэсгэлэнт бүсгүй чиний нүүр нь гагцхүү мөн гэж, тэрхүү адилтгал адилтгагдахуун хоёрыг сараар дарагдсан, дарагдаагүй гэсэн магадлал үгээр буулгажээ.

2.14. **Найруулах адилтгал** (ca: sleshopama, тө: sbyor pa'i dpe). Адилтгагдахуунд байдаг эрдэм чадлууд нь адилтгалд ч мөн адил байх бөгөөд тэдгээрийг хооронд нь үгээр болон утгаар холбон найруулж, зүйрлэн үлгэрлэж өгүүлэхийг найруулгын чимэг гэдэг. Ингэхдээ бадгийн төгсгөлд адилтгалын чимэг болохыг илэрхийлсэн “Адилтгалыг гийгүүлэгч үг” бичих хэрэгтэй. Мөн бас холбон найруулж буй зүйл нь хоёр буюу түүнээс дээш байх ёстой. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Сэрүүн туяат сарны эл дайсан ба  
Цог лугаа төгссөн сайн үнэрт  
Чиний нүүр нь лянхуа мэт

хэмээх **найруулах адилтгалын** жишээ нь: Үзэсгэлэнт хүүхний нүүрийн машид үзэсгэлэн (адилтгагдахуун) энэ нь (адилтгал) сэрүүн гэрэлт буюу сарны эл дайсан буюу тэмцэлдэгч болсон ба (адилтгал) лянхуа нь нарны садан буюу өөрөөр хэлбэл нарны гэрэлд дэлбээлдэг учраас сарны *дайсан болдог* хэмээсэн утга юм.

Мөн (адилтгагдахуун) хүүхний нүүр нь үзэсгэлэнгийн цог төгссөн учир хүсэлтэн ардад баяр жаргалыг өгдөг ба (адилтгал) лянхуа нь бас үзэсгэлэнгийн цог төгссөн тул хүсэлтэн зөгийст *баяр жаргалыг өгдөг* гэсэн үгээр найруулжээ.

Түүнээс гадна (адилтгагдахуун) үзэсгэлэнт хүүхний амнаас сайхан үнэр ханхалдгийг (адилтгал) лянхуан туурцгаас *сайхан үнэр анхилдаг* лугаа утгаар найруулжээ.

Тийнхүү адилтгал болон адилтгагдахууны ийм гурван (*тэнсэлдэх мөчөөрхөх, баяржаргалөгдөг, сайхан үнэр ханхалдаг*) эрдмийг адилтгал адилтгагдахуунд нааш цааш харьцуулан, үг утгаар найруулаад, эцэст нь “Үзэсгэлэнт хүүхэн чиний нүүр нь (адилтгал) лянхуа мэт ” хэмээн “Адилтгалын гийгүүлэгч үг”-г оруулан найруулжээ.

2.15. **Тэгш адилтгал** (ca: samanopama, тө: mnyam nid dpe). Нэг үг буюу нэг нэрийг дундуур нь тасалж, тасарсан хоёр хэсгийн нь утга хоёр юмыг адилтгасан байхаар найруулдаг арга. Өөрөөр хэлбэл, утга болон үлгэр хоёрын адилтгагдахуун болон адилтгал хоёрын ижил



чанар эрдмийг тодорхойлолт нэгээр гаргаж өгөх буюу нэг үгээр хоёр өөр утгыг илэрхийлж гаргаж ирэх байдлыг тэгш адилтгал гэнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Бодхайвын жишээ шүлэгт:

Асар удирдагч хэлний эрх баялагт Буддагийн өлмий  
Анабад далайн лусын эзний гайхамшиг мэт  
Хотол чуулсан бүхний эзэн тэрбээр эрхийн мөрний  
Хосгүй дээд дөрвөн урсгалыг буулгахад мэргэн болой.

(Бодхайв, 2000. т.450)

хэмээн (адилтгагдахуун) Брүмба Санжаадорж болон (адилтгал) Лусын хаан Анабад хоёрыг ижилсэл нэгэн үгсээр үзүүлсэн нь “Хотол чуулсан бүхний эзэн” гэсэн бөгөөд унших цагт хоёр тус тусад нь хамрагдах ойлголт болно.

Тэгэхээр адилтгагдахууны үед “Өөрийн хэргийг тэвчсэн хотол чуулган, бусдын хэргийг бодсон хотол чуулган гэсэн хотол чуулсан бүхний эзэн Санжаадорж буюу Буддабазар хэмээх тэр лам нь нууц тарнийн дөрвөн авшгийн усан урсгалыг шавь нарыг боловсруулан гэтэлгэхийн мөрд оруулахын тухайд буулгах буюу өршөөхөд мэргэн болой” хэмээн нэг уншигдах бөгөөд “Хотол чуулсан бүхний эзэн тэр дөрвөн авшгийн мөрний урсгалыг өршөөхөд мэргэн” хэмээн найруулжээ.

Харин адилтгалын үед, эмийн үр жимс ой шугуй тэргүүтэн ертөнц дэлхийд амар жаргалыг үүсгэж хотол чуулган болгодог эзэн Лусын хаан Анабад тэрбээр өөрийн эрхэнд оршдог дөрвөн их мөрөн болох Ганга, Синдхү, Вагчү, Сита лугаа дөрвөн их мөрнийг ертөнцөд буулгахдаа мэргэн болой хэмээн хотол чуулсан бүхний эзэн Анабад түүнд эрхшээгч мөрнийг эрхшээгч эзэн гэдэг талаас нь найруулж уншина.

Ингээд ирэхээр энэ шүлэг нь ижилсүүлэн адилтгасан нэг л үгсээр бичсэн атал унших цагт хоёр өөр утгаар гарч ирж байгаа тул энэ нь “Тэгшийн адилтгал” хэмээгдэх болох ажээ.

2.16. **Доромжлох адилтгал** (ca: nindopama. smad pa'i dpe). Адилтгал адилтгагдахуун хоёрыг ижилсүүлэн найруулахын дээр адилтгалын нэгэн багахаан гэмийг өгүүлж, адилтгалыг дооршуулан муушааж, адилтгагдахуунд тэрхүү адилтгалын гэм байхгүй бөгөөд ингэснээрээ адилтгагдахуун нь адилтгалаасаа онцгой болохыг тодруулж өгнө. Чингэхдээ адилтгалд буй тэр өчүүхэн гэмийг шуудаар өгүүлэх ба

мөн түүнийг бага зэрэг дооршоон доромжлох байр төрхийн үүднээс үзүүлсэн адилтгалын чимгийг “Доромжлох адилтгал” гэнэ. Ингэхдээ адилтгалын зүйл нь хоёрын зэрэг байх ёстой. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Лянхуан олон тоосон ба сар нь хомсдомуй  
Тэдгээр лүгээ чиний нүүрийг  
Адилтгахуйд үлэмж хэтэрнэ

хэмээх **доромжлох адилтгал**ын жишээний эхний адилтгал лянхуан туурцаг нь тоос ихтэй болдог ба хоёр дахь адилтгал сар нь хуучрахаараа буюу өөрөөр хэлбэл харын хувь нь ихсэхээр цагаан хэсэг нь хомсдож буурдаг учраас адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхэн чиний нүүрийг нь дээрхи адилтгал лянхуа, сар тэргүүтний үзэсгэлэнтэй дүйлгэж болох нь мэдээж боловч тэдгээрийн гэм чамд байхгүйгээрээ чи үлэмж илүү байна хэмээжээ.

2.17. **Сайшаах адилтгал** (са: prasamsopama, тө: bsngags pa'i dpe). Адилтгалынхаа онцгой эрдмүүдийг дурдаж сайшаан магтсаны үүднээс адилтгагдахууныг түүнтэй ижилсүүлэхийг “Сайшаах адилтгал” гэнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Лянхуа нь Эсэруаг дээдэд үүсгэн  
Саран нь амгаланг гаргагчийн оройн чимэг буюу  
Чиний нүүр нь тэдгээр лүгээ адил

хэмээсэн **сайшаах адилтгал**ын жишээнд: адилтгал Вишнүгийн хүйснээ ургасан лянхуагаас ертөнцийн өвөг Эсэруа төрсөн ба адилтгал саран нь Амгаланг гаргагч буюу Шива тэнгэрийн зулайн чимэг болсон хэмээн сайшаан магтаж өгүүлээд тэдгээр гайхамшигтай бодисууд нь адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхэн чиний нүүртэй ижил байна хэмээж байна.

2.18. **Дуршигч адилтгал** (са: acikhayaopama, тө: brjod pa'i dpe). Адилтгалд гэм болон эрдэм юу ч байлаа гэсэн түүнийг үл харгалзан, өөрийн санаагаар шууд адилтгагдахуунтай зүйрлэж өгүүлэхийг “Өгүүлэхүй дуршигч адилтгал” буюу “Өгүүлэхийг хүссэн адилтгал” гэнэ. Гэхдээ адилтгал, адилтгагдахуун хоёрын харьцаа хэвээр буйг мартаггүй байх хэрэгтэй. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандин:

Эрдэм лүгээ төгөлдөр ба гэмт боловч  
Саран нь чиний нүүр лүгээ адил

Хэмээн өгүүлэн дурших миний сэтгэлд буй

гэх **өгүүлэхүй дуршигч адилтгалын** жишээнд: адилтгал саран нь гиймэл, цагаан тэргүүтний эрдэм төгөлдөр ба бараан толбын гэмтэй байх алин боловч адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхэн чиний нүүр лүгээ адил юм хэмээн өгүүлэхийн хүсэл миний сэтгэлд байна гэж байна.

2.19. **Харшлах адилтгал** (ca: virodharama, тө: ‘gal pa’i dpe). Адилтгалын зүйл адилгүй хоёр төдийхнийг гаргаад адилтгал тэдгээр лүгээ адилтгагдахууны орон буюу шүтээн адилгүйн байдал дүр тусдаа буюу харшлах төдий харагдах боловч утгандаа адилтгал адилтгагдахуун хоёрт ерөөс ялгаа юу ч үгүй хэмээн ижилсүүлэн зүйрлэж өгүүлэх бөгөөд адилтгал утга хоёр нь харилцан дүр байдлаар харшлах авч утгаараа харшлахгүй адилхан хэмээн гаргасныг “Харшлах адилтгал” хэмээсэн байна. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Зуун талт хийгээд намрын саран ба

Чиний нүүр лүгээ гурав нь

Эсрэг тэсрэг огоот харшилмуй

хэмээсэн **харшлах адилтгалын** жишээ шүлэгт: адилтгал зуун талт буюу зуун дэлбээт лянхуа цэцэг лүгээ нэг, намрын саран лугаа хоёр, адилтгагдахуун үзэсгэлэнт чиний нүүр лүгээ гурвуул эдгээрийн орших орон, шүтээн газар тус тус өөр, байдал дүр нь харшлах төдийгөөс бус үзэсгэлэнгээрээ бүгд ижил хэмээн өгүүлжээ.

2.20. **Хаах адилтгал** (ca: pratishedhopama, тө: dgag pa’i dpe). Адилтгагдахуунтай тэнцэж чадахгүй адилтгал бол хаагдахуун буюу хоригдохуун юм. Хоригдон хаагдагч тэр адилтгалын гэмийг дурдаж, адилтгал нь адилтгагдахуунаасаа доорд учраас адилтгагдахуунтай адилсаж чадахгүй гэдгийг илээр өгүүлээд, харин далддаа адилтгалынхаа эрдэм болон үзэсгэлэн тэргүүтнийг үзүүлэх арга. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Хирт бөгөөд балар болсон

Саран нь чиний нүүр лүгээ

Тэнсэлдэхүй хүчин хэзээ бээр үгүй

хэмээх **хаахуй адилтгалын** жишээнд: хаагдахуун адилтгал нь саран. Хаагдагч саран тэр нь хиртэй, балар мунхаг учраас адилтгагдахуун үзэсгэлэнт чиний нүүртэй тэнсэлдэн ижилсэх чадал байхгүй гэж адилтгал саранд тэдгээр хар бараан толбо хир, бас ухаангүй гэсэн

гэмүүд байгаа учраас үзэсгэлэнт хүүхэн чиний нүүрийн гоо сайхантай мөчөөрхөн тэнцэх чадал хэзээ ч байхгүй гэж ил наанаа өгүүлээд харин далддаа сар чиний нүүртэй юугаараа ижилсэх вэ гэвэл цагаан өнгөтэй, бас гоёмсогоороо адилсана гэж гаргаж үзүүлжээ.

Өөрөөр хэлбэл, адилтгагдахууныхаа зарим гэмийг ил өгүүлж, ийм ийм гэмүүдээрээ адилтгагдахуунтайгаа тэнцэж чадахгүй гэх атлаа өөр нэгэн зүйлийн эрдэм чадлаараа адилтгагдахуунтайгаа тэнцэж чадна гэж далдуур хэлсэн байна. Дандины дээрх жишээг үзвэл дэлхийг гийгүүлж чаддаг сарны сүүн цагаан өнгөний эрдэм болон шөнийн харанхуйд огторгуйг чимэглэж байдаг үзэсгэлэнт байдал хоёроороо адилтгагдахуун хүүхэн чиний нүүрийн гоо үзэсгэлэнтэй тэнцэнэ гэдгийг далдуур өгүүлээд, харин сар бол бодол ухаангүй балай, мандалдаа бараан сэвх толботой байдаг гэмүүдээрээ сартай ижилсэж чадахгүй гэж сарыг муулж, хүүхний нүүртэй ижилсэх чадалгүй гэж наад талдаа хааж хориглож өгүүлсэн байна.

2.21. **Үзэсгэлэнт адилтгал** (са: caturama, тө: ngo bstod dre). Адилтгалд нь адилтгагдахуунаас онцгойрон хэтэрсэн олон зүйл байх боловч тэдгээрийг үгүйсгэж адилтгагдахуунтай нь ижилсүүлж өгүүлснээр адилтгагдахууныг үзэсгэлэнтэй болгож үзүүлэхийг “Үзэсгэлэнтийн адилтгал” гэжээ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины жишээ

Гөрөөсний нүдээр бэлгэт<sup>9</sup> чиний нүүр  
Мөнхүү гөрөөсөн бэлгэт саран  
Түүн лүгээ адил боловч энэхүү адилтгал бөгөөд  
Үлэмж хэтрэх бус хэмээх **үзэсгэлэнт адилтгал**

болох энэ шүлгийн утга нь сайхан эхнэр зөвхөн гөрөөсний нүдний жавхлант, гэтэл сар бүхэл гөрөөс хадгалсан тул бүхэл гөрөөсний жавхлантай боловч энэ хоёрыг адил гэж байгаа нь бага юмны үзэсгэлэн, их юмны үзэсгэлэн хоёрыг жишиж магтах зүйлээ сайшааж байна. Адилтгагч үг нь давуу чанартай байх ёстой атал хоёул адил болж байгаа нь адилтгагдахууны үзэсгэлэнг өргөмжилж байгаа хэрэг болно(ДЗАТ. 1982. т.50)

2.22. **Өгүүлэгч адилтгал** (са: tattvakhyanopama, тө: de nyid brjod pa). Адилтгал болон адилтгагдахууны ялгамжаа нь хоорондоо асар адилхан учраас ангид тусдаа биш юмуу гэж эндүүрмээр бөгөөд

<sup>9</sup> Янжинлхамын нүд нь гөрөөсний нүд шиг жавхлантай гэдгийг энд авчээ

хэрэв нарийвчлан үзвэл тэр хоёр нь хоорондоо ямар ч холбоогүй тусдаа зүйлээр барахгүй, өөр өөрийн ахуй ёс нь ч тус бүр өөр гэдгийг магадтайгаар илрүүлж өгүүлснийг “Мөнхүү түүнийг өгүүлэгч адилтгал” гэнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Агваанлувсанжамцын

Асар дуртмал өнгөт энэ нь эрхтийн нум лугаа  
Адилхан боловч солонго бус үхэлгүй тэнгэрийн хувцас  
Алимад яруу энэ нь зөгийн дуутай адил боловч  
Арайхан бус, Сарасватийн мутрын чавхдастын хөг эгшиг  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.148)

жишээ энэ шүлэгт: зүйл бүрийн үзэсгэлэнтэй өнгө ургасан энэ адилтгал нь эрхтийн нум буюу солонгын өнгө бус (адилтгагдахуун) Сарасватийн баримтаг тэнгэрийн сайн хувчид юм. Машид яруу энэ дуу нь адилтгал зөгийн дуу бус адилтгагдахуун Сарасватийн мутарт буй ятгын дуу юм гэж үзэсгэлэн хийгээд яруу тэргүүтэн нь харилцан нааш цааш маш ижил боловч адилтгал хийгээд адилтгагдахууны ялгаатайг тус тусад нь эндүүрэхгүйгээр утгын үнэн байдал ёсыг шулуухан ил гаргаж өгсөн байна.

2.23. **Ерөнхий бусын адилтгал** (ca: abadharanopama, тө: thun mon min pa'i dre). Үлэмж онцлогтой адилтгал нэгийг байгуулаад түүгээр ч адилтгагдахуунд жишигдэж очиж чадахгүй учраас адилтгал тэр өөрөө өөрийнхөө адилтгал болох зохистойгоос бус өөр адилтгал байхгүй хэмээн үгээрээ тов тодорхой илтээр гаргаж өгүүлэхийг “Ерөнхий бусын адилтгал” гэнэ. Өөрөөр хэлбэл, адилтгал түүнээ өөрөөс нь өөр адилтгал олдоогүй учраас “Ерөнхий бусын буюу Нийт бусын адилтгал” гэж хэлсэн хэрэг. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Саран ба лянхуа нугуудын  
Үзэсгэлэнгээс хэтэрсэн чиний нүүр  
Өөрөө өөр лүгээ адил больюу

хэмээх **ерөнхий бусын адилтгалын** жишээ шүлэгт: адилтгал ертөнцөд үзэсгэлэнтэй гэж алдаршсан саран ба лянхуануудыг үзэсгэлэнгээс ч давсан буюу ижилсэж үл чадах бөгөөд тэдгээрийн үзэсгэлэнгээс ч үлэмж хэтэрсэн адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхэн чиний нүүрэнд үлгэр адилтгал болох өөр юм байхгүй учраас өөрөө л өөрийнхөө адилтгал болох юм гэжээ.

2.24. **Болох бус адилтгал** (ca: abhutorama, тө: ‘byung min dpe). Адилтгалын хэсэг буюу эрдэм чадал нь энэ дэлхийд байшгүй хэтэрхий нэгээрадилтгагдахуунаа ижилсүүлэн гаргаж өгөх чимгийг “Болох бусын адилтгал” гэнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Агваан лувсанжамцын жишээ шүлэгт:

Олныг сонссон эрдмийн үүргээр машид хүндэрсэн  
Ухааны таван орны эцэст хүрсэн Радна-Дхармабадра нь  
Ончтой номлон, тэмцэж, туурвигч олон мэргэдийн  
Ухаан билиг бүгдийг нэг дор хураасан лугаа адил  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.151)

адилтгал Замбуутивийн мэргэн шидтэн олны номлох, тэмцэх, туурвих гурван ухаан билгийг бүгдийг нэг дор хураасан нэгэн байхгүй нь тодорхой бөгөөд тийм мэргэн хэрэв гарч ирэх бол тэр нь адилтгагдахуун сонсохуйн эрдмээр машид хүндэрсэн бөгөөд ухааны таван орныг эцэслэн дуусгасан Шалү хийдийн их хэлмэрч Дхармапалабадра түүний үлгэр адилтгалд зохих билээ хэмээжээ.

2.25. **Гарах бусын адилтгал** (ca: asambhava itrama, тө: srid min gyi dpe). Адилтгалаас урьд өгүүлсэн мэт тийм эрдэм чадал нэг дор хурсан нэгэн гарахгүйн адилаар адилтгагдахуунд ч тийм эрдэм чадал гарахгүйгээрээ адилтгал адилтгагдахуун хоёрыг зэрэгцүүлэн зүйрлэж өгүүлэхийг “Болох бусын адилтгал” гэжээ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандин:

Сарны дүрсээс хор мэт ба  
Зандан нугуудаас гал мэт  
Энэ нүүрээс ширүүн үгс

Хэмээх **гарах бусын адилтгалын энэ жишээнд**: адилтгал рашааны чанарт сарны дүрсээс хор болох маш сэрүүн, зандангаас галын мөн чанартай дулаан гарах гэж байхгүйн адилаар адилтгагдахуун чиний амнаас ширүүн үг хэзээ ч гарахгүй хэмээн гарахын тийн ялгалын нөхцөлөөр тодруулан зүйрлэж хэлжээ.

2.26. **Олон ялгамжтаныг тодруулагч адилтгал** (ca: bahurama, тө: mang ra’i dpe). Олон зүйлийн адилтгалыг нэг дор өгүүлээд, тэдгээрийн тус бүрийн эрдэм чадлаар ганц адилтгалыг тодруулж өгөхийг “Олон ялгамжтаныг тодруулагч адилтгал” гэнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Зандан, усан ба сарны гэрэл  
Саран болор тэргүүтэн мэт чамд  
Хүрэлцвээс сэрүүн буюу хэмээх

**Олон ялгамжтаныг тодруулагч адилтгалын** жишээ шүлэгт: Адилтгал болох зандан, цасны ус, сарны гэрэл, саран болор эрдэнэ тэргүүтний онцлог нь маш сэрүүн, сэрүүцүүлэгч чанартай түүгээр адилтгагдахуун баясгалант хүүхэн чиний биед хүрэхэд мэдрэгдэх сэрүүнийг тодруулж гаргасан бөгөөд тэдгээр адилтгалууд нь түүнтэй чанараараа ижил хэмээн өгүүлжээ.

2.27. **Дүр хөрвүүлэгч адилтгал** (ca: vikriyopama, тө: nam ‘gyur gyi dre). Адилтгагдахуун нь үлэмж ялгамжаат адилтгалаас илрэн гарсан мэтээр дүр төрхийг хувиргаж ахуй байдал нь тус тус өөр өөр төдийгөөс бус мөн чанараараа маш ижил хэмээн өгүүлэхийг “Дүр хөрвүүлэгч адилтгал” гэнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины

Сарны мандалаас гарсан мэт  
Нарийн биет чиний нүүр нь  
Лянхуан дотроос гарсан мэт

хэмээсэн энэ **дүр хөрвүүлэгч адилтгалд**: адилтгагдахуун нарийн биет чиний дуртмал нүүр нь адилтгал сарны мандалын дундаас эдүгээ нааш гарсан мэт хийгээд адилтгал дөнгөж дэлбээгээ нээсэн шинэхэн лянхуагаас сая даруй гарсан мэт болой хэмээн адилтгагдахуун охины нүүрийн үзэсгэлэн тэр нь адилтгал саран хийгээд лянхуасын үзэсгэлэнгийн чанар лугаа нэг болсон бөгөөд дүрээ хувиргасан ахуй байдлаараа ангид үзэгдэхээс бус утгандаа нэг л чанартай хэмээн өгүүлжээ.

Өөрөөр хэлбэл, дүр хувиргах буюу дүр урвуулах гэдэг нь жишээ нь уг чанартаа алт мөн атал түүнийг хувиргаж ээмэг, бөгж зэргийг хийхэд байдал дүрээрээ ээмэг, бөгж гэх мэт ангид тусдаа болох авч уг чанартаа алт юм. Түүнтэй адил дүр нь хувирсанаас бус, хүүхний нүүр нь уг чанартаа сар болон лянхуан үзэсгэлэнтэй нэг юм хэмээн өгүүлжээ.

2.28. **Эрихийн адилтгал** (ca: malopama, тө: phreng ba’i dre). Адилтгал болон адилтгагдахуун заримуудыг эрихлэн буюу жагсаан жигдрүүлж өмнөх өмнөх нь адилтгал, хойдох хойдох нь адилтгагдахуун болох, урьдах үг нь хойд үгэндээ харгалзахын үүднээс хойдох хойдохоо

тодруулж үйлдэх бөгөөд адилтгал адилтгагдахууныг хойно урд нь сөөлжүүлэн, эрх хэлхсэн мэт хэлхэж өгүүлэхийг “Эрихийн адилтгал” гэнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандин:

Нарны гэрэл бээр нарныг, наран нь өдрийг  
Өдөр болсоноор огторгуйг гийгүүлэх мэт  
Чандасыг дарахуй цогийг баригч чи бөгөөд  
Хэмээсэн тэр нь **эрихийн адилтгал**

гэх жишээнд: адилтгал нарны гэрэл бээр нарны мандалд сүр жавхланг барьсан мэт адилтгагдахуун өдрийн гэгээ түүгээр огторгуйг гийгүүлэх бөгөөд үзэсгэлэнгийн цогийг барьсан ба мөн бас адилтгагдахуун түүнийг адилтгал болгоод адилтгал өдрийн гэрэл гэгээгээр огторгуйг гийгүүлэх цогийг барьсан мэтээр адилтгагдахуун чандын эсэргүүцэгч бусад аймаг орныг сайтар дарагч хаан чи бээр хотол бүрдсэн цог жавхлан бүгдийг барьсан хэмээж байна.

2.29. **Үгсийн утгын адилтгал** (ca: vakyarthopama, тө: ngag don gyi dpe). Төвд хэлэнд үг гэдэг ухагдахуун нь тийн ялгалтай байх ёстой. Тэгэхлээр үгсийн утга илрүүлдэг 6 тийн ялгалаас (төвд хэл 8 тийн ялгалтай. Түүнээс 4,8 дахь тийн ялгалыг хасаад) үлдсэн зургаа нь (3 дахь үйлдэхийн т.я, 2 дахь үйлийн т.я хоёрыг голлоод) үгийн утгын адилтгал байгуулахыг хэлнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандины:

Чиний нүүр дэх нүд нь бат бус болоод  
Маш гийсэн шүдний гэрэл нь  
Шавраас ургаснаа зөгийс хөдлөхүй лүгээ төгссөний  
Туурцагуудаар гийсэн мэт үзэсгэлэнт

Лянхуан модон мэт нарийн биет эх  
Түүний нүүр нь лянхуа мэт  
Би бээр балыг эдлэхүй мэт  
Уун уусаар цэнгэмүй

гэх үгсийн утгын адилтгалын чимгийн жишээ үүний монгол орчуулгаас төвд хэлний тийн ялгалаар үзүүлсэн утгын адилтгал нь харагдахгүй.

2.30. **Тэнсэлдэгч бодын адилтгал** (ca: prativastupama, тө: zla bo dn-gos po'i dpe). Адилтгагдахууны нэгэн зүйл бодисыг урьдаар гаргаад түүнтэй эн зэрэгцэхүйц нэгэн адилтгалыг тэнцүү буюу үе зэргийн байдлаар дараа нь гаргаж, ингэхдээ тэр хоёрыг шуудаар адилтгаагүй



боловч далдуур адилтгах арга. Адилтгалын чимгийн нэг зүйл. Агваанлуvsанжамцын жишээ шүлэгт:

Энэхүү Зулт галавт олон бурхан заларсан ч гэлээ  
Эрхэм дээд Шагжийн төрөлт чиний адил тэнцүү нь үгүй  
Энгүй тэнгэрийн сайн номын хурлын газар  
тоолшгүй тэнгэрсийн дунд  
Эгнэгт хоёрдугаар Хурмаст тэнгэр хэмээгдэгчхэн нэгэн буй  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.168)

Бурхад заларсан энэ галавт нэн олон бурхан заларсан боловч Шагжамүни чамтай тэнцэх нэг ч үгүй хэмээх нь адилтгагдахуун хийгээд Сайн номт тэнгэрийн хурлын ордонд тоолшгүй олон тэнгэрс чуулан суухнаан ч тэдгээрийн дундах эрхэм Хурмаст тэнгэрээс өөр хоёр дахь Хурмаст тэнгэр гэж байхгүй хэмээсэн нь адилтгал бөгөөд адилтгагдахуун адилтгал хоёрыг зэрэгцүүлэн бичээд, адилтгалыг харин далдуур гаргаж үзүүлсэн болно.

2.31. **Найруулсан адилтгал** (ca: tulyayogopama, тө: mtshung sbyor gyi dre). Адилтгал эрдмээр илүү нэгэн ба адилтгагдахуун нь эрдмээр доорд хоёрын үйлдэл буюу эрдэм чадал нь ижил байвал түүнийг уг чадлын чанараар нэг дор хурааж харьцуулан ижилсгэн найруулж гаргахыг хэлж байна. Адилтгалын чимгийн нэг зүйл.

Энд нэг ижил төстэй үйлдлийг хамтад нь найруулсан байгаа учраас тус тус өөр өөр үйлдэлд найруулга хийх хэрэггүй байдаг. Дандины жишээ:

Бүломагийн дайсан өндөр язгууртныг ба  
Чи нь дэлхий дахиныг сахихуй үйлдэн  
Тэр нь омогт асури нарыг ба  
Чи нь хүний эзнийг дармуй

Бүлома гэж Асурийн нэр аж. Бүломагийн дайсан гэдэг нь Хурмаст тэнгэрийн нэр ажээ. Үүнд Хурмаст нь адилтгал, хүний хаан нь адилтгагдахуун. Уг чанараараа хүний хаанаас Хурмаст тэнгэр илүү боловч тэр хоёрын үйлдэл нь дарж номхотгодог, сахин хамгаалдаг чадал үйлдлээрээ нэг юм. Хурмаст тэнгэр Асури нарыг дарж, тэнгэр нарыг сахин хамгаалдаг. Хүний хаан нь буруу ёст хаадыг дарж, дэлхий дахиныг сахин хамгаалдаг. Энэ хоёрт дээд доордын ялгаа байгаа боловч хамгаалж сахих ба дайсныг дардаг тэргүүтэн үйлийн

ялгамжаагаар нь нэг дор хураангуйлж адилтган өгүүлжээ.

2.32. **Шалтгааны адилтгал** (са: hetupama, тө: rgyu dre). Адилтгагдахуунд байгаа онцгой зүйлийн учир шалтгааныг өмнө нь өгүүлээд адилтгагдахууны онцлог хэсэг түүнтэй ижилсүүлэн адилтгалыг дараа нь гаргаж, зүйрлэн өгүүлэхийг “Шалтгааны адилтгал” гэнэ. Адилтгалын чимгийн нэг зүйл. Дандин

Хаан чиний үзэсгэлэн нь саран ба  
Сүр жавхлан нь наран хийгээд  
Бат нь далайг даган үйлдмүй

хэмээх **шалтгааны адилтгалын жишээнд**: адилтгагдахуун хаан чи үзэсгэлэнтэйн учир шалтгаанаар адилтгал сарантай адил бөгөөд сүр жавхлан ихтэйн учраар адилтгал наран лугаа ижил, таалал бодол чинь гүн батын учир шалтгаанаар адилтгал далай лугаа адил гэжээ.

**Адилтган гийгүүлэгч үгс.** Адилтгал болон адилтгуулагч хоёрын харилцааг гаргахад Адилтгалын чимэгт хэрэглэдэг үгс. Эдгээр 65 “Адилтган гийгүүлэгч үг”-ийг адилтгалын чимгийн зарим нэг онцлог чимгээс бусдад нь найруулна. Аялгуусын адилтган гийгүүлэгч үг олон боловч Дандин 65-ыг тоолон нэрлэжээ. Үүнд: 1. Мэт *བཞིན* 2. Адил *ལྟར* 3. Ёсоор *ལྟ་བུ* 4. Ямарчлан, *ཇི་ལྟར* 5. Аялгуу зохилдох *སྒྲིམ་མཐུན* 6. Сацуу, *མཚོངས* 7. Санни бха хийгээд *ཡང་དག་མཚོངས* үнэхээр сацуу 8. Сацуу *མཉམ* 9. Санга ша хийгээд *ཡང་དག་གསལ* үнэхээр тодорхой 10. Нига ша *ངེས་བར* *གསལ* магад тодорхой 11. Дүрс адил, *གཟུགས་ཀྱི་ལྗོ་བོ* 12. Брадирубаса *རབ* *གསལ* машид тодорхой 13. Ерөндөг хийгээд *གཉེན་པོ* 14. Тэнгэцэхүйба *དག་ལྗོ* 15. Брадия нига, *སོ་སོར་རྫོག* тус тус онох 16. Харш ба адил, *འགལ་དང* *འདྲ* 17. Садиша хийгээд *བལྟ་བཅས* үзэхүй сэлт 18. Самбади *བསྐྱེལ* хуурах 19. Язгуур зохилдох, *རིགས་མཐུན* 20. Даган өгүүлэх ба *རྗེས་སུ་སྐྱེལ* 21. Дүрс хөрөг, *གཟུགས་བརྟན* 22. Брадизанда хийгээд *སོ་སོར་སྒྲེབ* тус тус нийлүүлмүй 23. Дүрс сацуу *གཟུགས་མཚོངས* 24. Сама, *མཉམ* тэгш 25. Санмида, *ཡང་དག་གཞལ* үнэхээр үлмүй 26. Бэлгэ чанар зохилдох мэт, *མཚན་ཉིད་མཐུན་འདྲ* 27. Эбха хийгээд *མཚོངས་བ* сацуу 28. Зохилдох зүг, *མཐུན་ཕྱོགས* 29. Үлгэрлэн үйлдэхүй, *དཔེར་བུས* 30. Үлгэр хийгээд *དཔེ* 31. Ухахуй *རྫོག* 32. Вишия хийгээд *དམན* доорд 33. Дишяа тэргүүтэн *ཚུང་བཅད་དམན* өчүүхэн доорд 34. Брагаая *རབ་ཏུ་སྐྱེ* машид өгүүлэх 35. Брадинидхи хийгээд *སོ་སོར་བརྫོག* тус тус няцахуй 36. Язгуур лугаа зохилдох *རིགས་མཐུན* 37. Сацуу үйлдэхүй, *མཉམ* *བུས* 38. Аялгуус ба *སྒྲིམ་དག* 39. Аль бас мөхөс бус утгат үгс, *གང་ཡང་དམན* *མིན་དོན་ཅན་ཚོག* 40. Туулай бэлэгтийн нүүрт тэргүүтэн *རི་བོང་མཚན་མའི་གདོང*



3.1. **Хураах дүрст** (ca: samasta rūpaḥa, тө: bsdus pa'i gzugs can). Адилтгагдахууныг адилтгалын мөн чанарт байгуулахдаа адилтгагдхуун болон адилтгал хоёрын завсарт харъяалахын тийн ялгалын нөхцөл хэрэглэх хэрэгтэй болох бөгөөд харин энд хэрэглэхдээ түүнийг илт гаргаж ирэлгүй утгаар нь хурааж үзүүлэхийг “Хураах дүрст” гэнэ. Үүнийг “Эс хураасан дүрстийн чимэг”-тэй харьцуулж үзвэл тодорхой ойлгогдоно. Дүрстийн чимгийн нэг зүйл. Дандин

Царвуу нь ороонго мод, гар нь  
Лянхуа, хөл нь гишүүн навч болой -

хэмээж адилтгагдахууны зүйл царвууг адилтгалын зүйл ороонго модны дүрстэд байгуулж, адилтгагдахуун гарыг адилтгал лянхуан дүрсэд байгуулж, мөн адилтгагдахуун гарын хурууг адилтгал лянхуан навч гишүүний дүрсэд байгуулжээ. Ингэж найруулахад, сарвууны ороонго мод, гарын лянхуа, хуруудын навч гишүү хэмээн хэлэхэд ашиглагдах харъяалахын тийн ялгалын нөхцөлүүдийг хураагаад, сарвуу ороонго мод, гар лянхуа, хурууд навч гишүү гэх мэтээр өгүүлж, адилтгагдахуунуудыг адилтгалуудтайгаа тусдаа биш мэтээр өгүүлсэн байна.

3.2. **Эс хураасан дүрст** (ca: asamasta, тө: ma bsdus pa). Адилтгагдахууны бүхэл болон хэсгийг адилтгалын бүхэл болон хэсэгтэй мөн чанар ялгалгүй хэмээн байгуулсан бөгөөд үлгэр утга хоёрын дунд харъяалахын тийн ялгалыг илээр оруулж өгсөн буюу хураалгүй өгүүлэгдсэн чимгийг “Эс хураасан дүрстийн чимэг” гэнэ. Дүрстийн чимгийн нэг зүйл. Дандин

Гар нь ориах модон, хурууд  
Гишүүн навч хумсны өнгө нь  
Цэцэг болсоноор хаврын цог мэт  
Чи хэмээвээс надад илтэд гүймүй

хэмээн (адилтгагдахууны хэсэг) гарыг (адилтгалын хэсэг) ороонго модны, (адилтгагдахууны хэсэг) хуруудыг (адилтгалын хэсэг) навч гишүүний, (адилтгагдахуун) хумсны өнгийг (адилтгал) цэцгийн, (адилтгагдахууны бүхэл) үзэсгэлэнт бүсгүйг (адилтгалын бүхэл) хаврын цогийн эрдмийн дүрсэд байгуулаад тийм үзэсгэлэн төгөлдөр чи нь бидэнд амгаланг өгөхийн учраар илт гүйнэ гэжээ. Үүний гарын ороонго мод гэх мэтийн харъяалахын тийн ялгалыг хураасангүй байна.

3.3. **Хураагаад эс хураасан дүрст** (ca. samasta vyasta rūpaḥ, тө: bsdus ma bsdus pa'i gzugs can). Адилтгагдахууны бүхэл ба зарим хэсгийг адилтгалын бүхэл ба зарим нэг хэсгийн дүрсэнд оруулаад хоорондох харъяалахын тийн ялгалын нөхцөлүүдийн заримыг хураагаад, заримыг хураахгүй чимгийг “Хураагаад эс хураасан чимэг” гэнэ. Дүрстийн чимгийн нэг зүйл. Дандин

Саран царайт сарны гэрэл мэт мөшилзөгч

гэсэн **дүрстнийг хураагаад эс хураасан** жишээний адилтгагдахууны бүхэл үзэсгэлэнт бүсгүйн дуртмал царайг адилтгалын бүхэл болох сарны дүрсэнд буулгаад, адилтгагдахууны хэсэг болох үзэсгэлэнт бүсгүйн ниугуурын мөшилзөлийг адилтгагдахууны хэсэг болох сарны гэрлийн дүрсэнд буулгаж, эхний саран мэт царайт хэмээхийн харъяалахын тийн ялгалын нөхцөлийг хураагаад, дараагийн сарны гэрэл мэт мөшилзөгч хэмээхийн харъяалахын тийн ялгалын нөхцөлийг эс хураажээ.

3.4. **Даяарын дүрст** (ca. sakalarūpaḥ, тө: mtha' dag gzugs can). Энэ чимэгт өгүүлэгдэж буй бүх юм дүрслэгддэг буюу өгүүлэгдэхүүн бүхнийг дүрсэлдэг арга. Өөрөөр хэлбэл, адилтгагдахууны гишүүн болон гишүүнт даяарыг адилтгалын гишүүн хийгээд гишүүнтийн дүрсэнд буулгаж, адилтгал адилтгагдахуун нэг атал нэг бус мэтээр бүхэл болон хэсэг даяарын үүднээс адилтгагдахууныг адилтгалын дүрсэд буулгаад тэр хоёулыг хослоход зохистой нэг оронд ижилсүүлж өгүүлэхийг хэлнэ. Дүрстийн чимгийн нэг зүйл. Дандин

Чиний өлмийн лянхуа дахь

Улаан хуруудын навчсын эрхис хийгээд

Хумсны гэрлийн туурцаг түүнийг тэр

Орныг тэтгэгч хаад оройдоо баримуй.

Даяарын дүрстийн энэ жишээнд: адилтгагдахуун болох их хаан чиний өлмий нь адилтгал болох лянхуан дүрсэд буулгаад адилтгагдахууны хэсэг улаан хуруудыг адилтгалын хэсэг улаан лянхуан навч дэлбээ хийгээд хумсны гэрэл буюу өнгийг нь лянхуан туурцагийн дүрсэнд буулгаснаар адилтгагдахууны хэсэг бүгдийг буюу даяарыг адилтгалын хэсэг бүгдийн дүрсэнд оруулж, адилтгагдахууны бүхэл болох хааны хөл үүнийг нь Орныг тэтгэгчид буюу хүмүүний олон жижиг хаад оройдоо барих буюу шүтмүй хэмээн өгүүлжээ.

3.5. **Хувьсын дүрст** (ca. avayāvīrūpaḥ, тө: cha shas gzugs can). Аливаа юмны их биеийг дүрслэхгүйгээр түүний хувь хэсгийг дүрслэхийг хэлнэ. Дүрстийн чимгийн нэг зүйл. Дандин:

Мөнхүү гэнэт зандалийн эх  
Чиний нүүр уруулын гишүүн навчис хөдлөн  
Хөлсний усан дусал  
Сувдын цоморлогийн гэрэлтэд баримуй.

Адилтгагдахуун машид догшин түрэмгий (зандали) бүсгүй түүний нүүр нь хувьст мөн учраас алины дүрсэнд ч эс буулгаж бүсгүй түүний нүүрийн хувь уруул хийгээд хөлсний усан дусал хоёрыг адилтгал навч гишүүн хөдлөх ба сувдан бөмбөлөг буюу сувдыг хэлхэн зүүсэн гэрлийн дүрсэнд оруулан дүрсэлжээ.

3.6. **Хувьстны дүрст** (ca. avayāvīrūpaks, тө: cha shas can gzugs can). Энэ чимэгт өгүүлэгдэхүүний зөвхөн их биеийг дүрслээд, үе гишүүн хэсгийг дүрслэлгүй санаагаа гаргана. Өөрөөр хэлбэл хувьс нь биш хувьсийг агуулж явдаг бүхэл хувьстанг дүрсэлдэг. Дүрстийн чимгийн нэг зүйл. Агваанлувсанжамцын жишээ шүлэгт:

Авралт Манзушрийн дуртмал царайны наран хот мандал нь  
Аливаа мэдэгдэхүүн бүхнийг үзэхийн уртлаг мэлмийтэй  
Аль бүхүй сайн номлолыг дуурсгахын нигуур гэгээн нь  
Аяндаа мөшилзсөнөөр сайн хувьт ардад уужралыг өршөөмүй  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.225)

хэмээн адилтгагдахууны хувьст Зөөлөн эгшигт буюу Манзушрийн царайг нь нарны мандалын дүрсэд оруулж, царай нүүрийн хувьс болсон уртлаг мэлмий, уруул амаа мишмэлзэх зэргийг ямар ч дүрслэлд оруулсангүй бөгөөд сайн хувьт төрөлхтөн даяарыг мунхарахын зовлонгоос салгаж уужим болгон амсхийлгэх буюу өөрөөр хэлбэл хамаг юмсыг мэдэж чадах торолтгүй ухааны дээдийг өгдөг хэмээжээ.

3.7. **Ганц гишүүний дүрст** (ca. ekāṅga gūpaḥ, тө: yan lag gcig pa'i gzugs can). Адилтгагдахууны нэг гишүүнийг адилтгалын нэгэн гишүүний дүрсэнд буулгаж, адилтгагдахууны үлдсэн гишүүдийг адилтгал гишүүн түүний ямар ч дүрсэнд буулгаагүй чимгийг “Ганц гишүүний дүрст” хэмээнэ. Хэрэв адилтгагдахуун гишүүнтийн таван зүйл гишүүн байх аваас тэдгээрээс хоёрыг нь адилтгал гишүүнтийн хоёр гишүүний дүрсэд буулгасан байвал “Хоёр гишүүний дүрст”

гэх ба адилтгагдахуун гишүүнтийн гурван гишүүнийг мөн адилтгал гишүүнтийн гурван гишүүний дүрсэд буулгасан аваас “Гурван гишүүний дүрс” гэх бөгөөд бусдыг жишиж мэдэж болно. Дүрсийн чимгийн нэг зүйл. Дандин:

Үзэсгэлэнт эх чиний  
 Согтоогч улаан нүүр хацар  
 Улаан удвалын нүдэт үүнийг бээр  
 Төрөлхтнөө улааны чанараа үйлдвэй

гэх **гагц гишүүний дүрсийн жишээ**: адилтгагдахуун гишүүнт үзэсгэлэнт хүүхний нүүр болон түүний гишүүдийн дотроос согтоогч улаан хацрыг юуны ч дүрсэд үл оруулж, тэдгээр гишүүдийн дотроос гагцхүү нүдийг улаан удвал цэцгийн дүрсэнд буулгаад үзэсгэлэнт хүүхний хүсэл дурыг хөдөлгөх байдал дүрд автсан эрийн царай нь улаан болж хувирахыг үзүүлжээ.

**3.8. Төгөлдөр дүрс** (са: yuktamrūpakam, тө: ltan pa'i gzugs can). Адилтгагч, адилтгуулагч хоёрыг хоёуланг нь төгөлдөр байдлаар дүрсэлдэг арга. Дүрсийн чимгийн нэг зүйл. Адилтгагдахуун алины шүтээн хийгээд шүтүүлэгч хоёрыг хамт нэгнээ нөхөрлүүлэх буюу төгөлдөр түүнтэй адилтгалын шүтээн хийгээд шүтүүлэгч хоёрыг ч харилцан нөхөрлүүлэх буюу төгөлдрийн дүрсэд байгуулаад адилтгагдахуун тэдгээрийг хамтад байрлуулахаар барахгүй адилтгалуудыг ч хамтад төгөлдөржүүлэх буюу нөхөрлүүлэхийн дүрсэд оруулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, нэг газарт байдаг төгөлдөр юмсыг бас нэг дор хамт байх төгөлдөр зүйлсээр дүрслэх юм.

Аливаа юм нь төгөлдөр болоод төгөлдөр бус байдаг тул төгөлдөр ба төгөлдөр бус нь тус тусдаа зүйл болно. Агваанлуvsанжамцын жишээ шүлэгт:

Эгшигт эхийн мутрын ороонго модын үзүүрт  
 Эгшиг ятгын хөхөөн яруу дуун дуурсаад  
 Эгнэгт тэргүүний хөхөмдөг огторгуйд  
 Эрдэнэсийн чимгийн хурц гэрэл цацрах амуй

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.231)

хэмээн Эгшигт эхийн мутрын үзүүр хийгээд ятга тэргүүн, түүний чимгүүдийг дараалан ороонго модны үзүүр, түүнд буй хөхөөний яруу дуун дуурсах, хөх огторгуйд нарны гэрэл цацрахын дүрсэд дараалан

буулгаад адилтгагдахуунуудыг хамтад нь байрлуулахаар барахгүй адилтгалуудыг ч хамт нэг дор нөхцөлдүүлэн төгөлдөржүүлэхийн дүрсэд буулгажээ.

**3.9. Төгөлдөр бусын дүрст** (ca: ayuktamgūrakam, тө: ltan min zhes pa'i gzugs can). Адилтгагдахуун алины шүтээн хийгээд шүтэгч хоёрыг адилтгалын мөн чанар эс зохилдох буюу хамт нэг дор төгөлдөржих бусын хоёр бодисын дүрсэд оруулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл адилтгуулагч төгөлдөр зүйлс нь нэг газар орших боловч адилтгаж буй төгөлдөр зүйлс нь нэг газар оршдоггүй тул адилтгагч нь бие биедээ нөхцөлдөөгүй тийм дүрслэлийн нөхцөлийг хэлж байна. Дүрстийн чимгийн нэг зүйл. Дандин:

Энэхүү нүүрийн мөшөөлөгч сарны гэрэл ба  
Гилгэрсэн нүдний удвалт  
Хэмээх сарны гэрэл удвал лугаа төгөлдөр бусын тулд  
**Төгөлдөр бус хэмээгч дүрст** болой

гэж адилтгагдахууны шүтээн үзэсгэлэнт хүүхний мишээсэн нүүрийг нь адилтгал сарны гэрлийн дүрсэнд оруулжээ. Адилтгагдахууны шүтэгч үзэсгэлэнт хүүхний нүүрэн дэхь нүдийг нь адилтгал удвал цэцгийн дүрсэд оруулж, адилтгал сарны гэрэл, удвал цэцэг хоёр хамт нэг дор төгөлдөржихгүй учраас (хослохгүй) “Төгөлдөр бусын дүрст” гэжээ.

**3.10. Тэгш бусын дүрст** (ca: vishamarūrakam, тө: mi mnyam pa'i gzugs can). Аливаа зүйлийн шүтээн гишүүнтийг<sup>10</sup> адилтгалын дүрсэд байгуулж, шүтэгч гишүүдийн<sup>11</sup> зарим нэгийг дүрсэд байгуулахаар барахгүй нэмэлт дүрстийг байгуулж, заримыг дүрсэнд огтоос байгуулаагүй нэгэн гишүүн буюу шүтэгчийн талаас тэгш бус буюу дээд доод буй мэт мөн учраас шүтэгч тэгш бусын дүрст хэмээн хэлдэг. Өөрөөр хэлбэл гишүүнт нь дүрслэгдээд, гишүүдийн зарим нь дүрслэгдэж, зарим нь эс дүрслэгдэх арга юм. Дүрстийн чимгийн нэг зүйл. Бодхайвын жишээ шүлэг:

Өнгөт тэнгэрийн ганц гүнж чиний нүүр үзвээс гоо  
Өнийн зуур завсарлах уруулын лянхуан давалгаа  
Үзэсгэлэн болгогч цахиурын туурцаг, галууны сүрэг  
Үнэхээр цагаан хотол бүрдмэл нэг дор төгс дэлгэрэх болмуй  
(Бодхайв, 2000. т.457)

<sup>10</sup> Гишүүнт – их бие буюу бүхэлийг хэлнэ. Иймд гишүүнтийн дотор ямар нэг юмны салаа мөчир гишүүн багтаж байдаг

<sup>11</sup> Гишүүн- их биений доторх салаа салбар юм



хэмээн шүтээн гишүүнт охин тэнгэрийн нүүрийг юуны ч дүрсэд үл байгуулан шүтэгч буюу гишүүн уруулыг лянхуан дүрсэд оруулж, түүнийг усны давалгааны дүрсэд оруулсан нь илүү нэмэлт дүрстэн, шүдийг туурцгийн дүрсэд оруулж, түүнийг галууны чуулгасын дүрсэд оруулсан нь илүүдэл дүрст болгосон ч гишүүн цагаан өнгийг юуны ч дүрсэнд үл оруулсан байна.

3.11. **Ялгалаар чуулагч дүрст** (ca: saviśeshana rūpakam, тө: khy-ad par dang bcas pa'i gzugs can) буюу Ялгал лугаа сэлтсийн дүрст. Адилтгагдахууны бодис түүнийг адилтгал ялгамжаат нэгний дүрсэд оруулж, адилтгагдахууны хэрэг буюу үйл ажил онцгой нэгэн болохыг заасан чимгийг “Ялгалаар чуулагч дүрст” гэнэ. Дүрстийн чимгийн нэг зүйл. Агваанлуvsанжамцын жишээ шүлэгт:

Алинхүү хамгийг айлдагч номын хаан Зонхов богдын  
Асар айлдлын илд огторгуйд эргэлдсэнээр  
Атаат дайсны цэргийн чуулганы аюулын сэжгээс хагацаад  
Алимад Цастын орны Чадагчийн шашныг баригч нар  
баясгаланг үүсгэнэ  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.239)

хэмээн адилтгагдахуун ялгуусан Зонхов гэгээний тааллын айлдал бэлгэ билгүүн түүнийг адилтгал ялгамжаат бодис илдийн дүрсэд оруулаад, айлдлын тэр илдийг далайж эргэлдүүлсний хэрэг буюу ялгамжаат үйл нь буруу өгүүлэгч гадаад тэрсүүтийн цэргийн чуулганаас айхын сэжгээс хагацуулах бөгөөд Цастын орон гэх Төвдийн орны Бурханы(Чадагчийн) шашныг баригч нарт баяр баясгаланг үүсгэх юм гэжээ.

3.12. **Харшлагч дүрст** (ca: viruddharūpaka, тө: ‘gal pa'i gzugs can). Адилтгагдахуун нэгэн зүйлийг адилтгал нэгэн зүйлийн дүрсэд оруулсан авч адилтгагдахуун нь адилтгалынхаа үйлийг, адилтгал нь адилтгагдахууныхаа үйлийг хийдэггүй, адилтгал, адилтгагдахуун хоёр нь үйлээрээ харшилдагийг гаргаж үзүүлсэн чимгийг “Харшлагч дүрст” чимэг гэнэ. Дүрстийн чимгийн нэг зүйл. Дандин

Чиний нүүрийн саран нь  
Лянхуануудыг үл хумбиулан  
Огторгуйгаар үл одон  
Ямагт миний амийг булаахыг шамдна

хэмээх **харшлагч хэмээхүй дүрстийн** жишээнд: адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхний нүүрийг адилтгал сарны дүрсэд буулгажээ. Адилтгал сарны үйлдэл юу байдаг гэхээр сар гарах цагт лянхуа цэцэг дэлбээгээ хумьдаг. Мөн сар өөрөө огторгуйгаар дэгддэг. Гэтэл адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхний нүүр нь адилтгал сарныхаа үйлийг үйлддэггүй. Хүүхний нүүрийг үзээд лянхуа цэцэг дэлбээгээ хумихгүй, хүүхний нүүр огторгуйгаар явахгүй. Мөн адилтгагдахуун хүүхний нүүрний үйлдлийг адилтгал сар үйлдэж чадахгүй. Хүүхний нүүр хүсэлтэн эрсийн хүслийн амийг булаадаг буюу сэтгэлийг нь бүрэн эзлэн авдаг үйлийг адилтгал саран үйлдэж чадахгүй юм. Ингэхээр адилтгал, адилтгагдахуун хоёрын үйлдэл харилцан харшилж байна.

3.13. **Шалтгааны дүрст** (ca: hetu gūpaka, тө: rgyu'i gzugs can). Энэ чимэгт яагаад, ямар учраас гэх шалтгааныг заавал тод илрүүлж байдаг арга. Адилтгагдахуун бодис түүнээ буй онцлог эрдэм чадлуудаас хамаарч тэрхүү онцлог эрдэм чадлынх нь учир шалтгаанаар тэдгээртэй эн зэрэгцэх адилтгал юмсуудын дүрсэд оруулах бөгөөд адилтгал болж байгаа зүйл нь адилтгагдахууны тухай тухайн гол эрдэм чадлуудтай шууд холбогдож байх ёстой юм. Харин адилтгалын тухайд заавал нэгээхэн адилтгал бодис байх албагүй, адилтгагдахууныхаа эрдэм чадал тус бүрээс болж өөр өөр адилтгалууд байж болно. Дүрстийн чимгийн нэг зүйл. Бодхайвын жишээ шүлэгт:

Чи нь тус ачлалаараа тэгшийн учир наран хийгээд  
Шимнусын үйл бүхнийг дардагийн тулд баатар бөлгөө  
Амьтдыг орчлонд үл унагадгийн учир тулахуй шүтээн бөгөөд  
Сэтгэлд эгээрэн хүссэнийг өгдөгийн тулд зэндмэнэ ч мөн  
(Бодхайв, 2000. т.458)

гэж адилтгагдахуун Бурханы таалал нь бүхнээ тэгш бөгөөд шимнусын үйлийг дардаг, амьтдыг орчлонд үл унагадаг, сэтгэлд горилон хүссэн бүхнийг амар хялбараар өгдөг учир шалтгаанаар дараалчлан наран, баатар, түшиг тулгуур буюу шүтээн, зэндмэнэ тэргүүтний дүрсэд оруулсан болно. Энэ чимгийн найруулж буй арга нь “Адилтгалын чимэг”-ийн доторх “Шалтгааны адилтгал”-тай найруулах байдлаараа ижил болно.

3.14. **Найруулсан дүрст** (ca: ślishtarūpakam, тө: sbyar pa'i gzugs can). Адилтгагдахууны бүхлийг адилтгалын бүхлийн дүрсэд буулгана.

Адилтгал утга хоёрын ижилсэх зүйлийг заримд үг дуунд найруулж, зарим үед нь утганд нь найруулж тус тусад нь гаргахыг Найруулгын дүрст гэжээ. Энэ нь үг найруулах, утга найруулах хоёр зүйл юм. Үг найруулах гэдэг нь хоёр утгатай нэг үгийг салаа утгаар нь хэрэглэх юм. Нөгөө утга найруулах гэдэг нь хоёр чанар бүхийг нэг үгийг ашиглаж хоёр үйлс гаргаж, дүрслэгч, дүрслэгдэхүүн хоёрын сайхныг өгүүлдэг байна. Дүрстийн чимгийн нэг зүйл. Дандин:

Ханьсагч эх чиний нүүрийн энэ лянхуаг  
 Ражахамса<sup>12</sup> бээр чухал эдлэхүй зохист  
 Сайхан үнэрийг зохисоор таалахуйяа зохист  
 Хэмээсэн энэ нь **найруулсан дүрст** болой.

Адилтгагдахуун ханьсагч эхийн нүүрийг адилтгал лянхуан дүрсэд байгуулсан бөгөөд хоёрдугаар мөрийн адилтгал утгын ижилсэх зүйлд үгээр найруулсан нь адилтгагдахуун үзэсгэлэнт бүсгүйн нүүрийг эгэл хүн бээр эдлэх зохистой бус бөгөөд Разахамса буюу хүмүүний хаан ямагт бээр шууд эдлэхүй зохистой хэмээсэн ба түүний адилтгал лянхуаг эгэл жигүүртэн бээр эдлэх зохистой бус бөгөөд Разахамса буюу галууны хаан бээр эдлэх зохистой болой хэмээн адилтгал адилтгагдахууны ижилсэх зүйл нийт болсон Разахамса нь хүмүүний хаан хийгээд галууны хаан хоёулд ордог учраас нэг дуунд буюу үгэнд адил бус хоёр утга бөгөөд дуу ижлээр найруулсан хийгээд гуравдугаар мөрөнд утгаар найруулсан нь адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхний нүүрийн үнэрийг хаан бээр эдлэх хийгээд адилтгал лянхуаны үнэрийг зөгий бээр дөтөд эдлэх бөгөөд товчилбоос адилтгал адилтгагдахуун хоёрын ижилсэх зүйл нийт болсон үнэр үнэртсэнийг хаан болон зөгий бээр эдлэх ёс адил учраас утганд найруулсан жишээ болно.

3.15. **Үлгэрийн дүрст** (са: upamāgūpakam, тө: dpe'i gzugs can). Энэ чимэгт эрхэм болж байгаа адилтгагчийн гол гишүүн нь эгэл адилтгуулагчийн гол гишүүнтэй ижилсэж, бусад гишүүд ч мөн ижилсэх байдлаар үлгэрлэж үзүүлэх арга. Эгэл адилтгагдахууны бүхэл суурь болон гол эрхэм адилтгалын гол бүхэл хоёуланд байдаг онцлогийг харилцан нааш цааш зохилдуулан адилтгал болон адилтгуулагч хоёрын харилцааг гаргахад хэрэглэдэг үгсийн хамтаар тодорхой өгүүлээд адилтгагдахуун түүнийг адилтгалын дүрсэд ч оруулсан

<sup>12</sup> Ражахамса - Галууны хаан- санскритаар Ражахамса гэх үгний нэг утга нь хүний хаан, нөгөө утга нь зөгий гэсэн хоёр утгатай.

нэгнийг Үлгэрийн адилтгал хэмээн нэрлэжээ. Дүрстийн чимгийн нэг зүйл. Агваанлувсанжамцын жишээ шүлэгт:

Бэлхүүс үе нарийн гуалиг огоот хурсан мод  
Бүхий л хүслийн навч дэлбээ хөдлөхүйн дүрт  
Бүрнээ амгаланг алинхүү өгөгч энэ нь  
Бүх талаар галбарваасан модон лугаа ёс ижил

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.249)

адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхний нарийн гуалиг бэлхүүс түүнийг адилтгал огоот хурсан модны дүрсэд байгуулж, адилтгагдахуун хүслийг дэвэлгэхийн дүр байдлыг адилтгал навч дэлбээ дэлгэрсэн дүрсэд буулгажээ. Адилтгагдахуун тэрбээр хүсэлтэн бүхнээ амгаланг өгдөг нь адилтгал галбарваасан мод лугаа ижил хэмээн “Тийгүүлэгч аялгуу”-г илтээр гаргаж өгүүлээд адилтгагдахууныг адилтгалын дүрсэд ч буулгасан байна.

3.16. **Няцалгат дүрст** (ca: vyatirekarūpaka, тө: ltog pa can kyī gzugs can). Энэ чимэг нь эхлээд бүхэл буюу гол зүйлийг харьцуулаад дараа нь ижилсэж чадахгүй онцлог хэсгийг тус тусад нь ялгаад өмнөхижилсэлээс нь няцуулж өгүүлэх арга. Өөрөөр хэлбэл, эхлээд адилтгагдахуунаа адилтгалын дүрсэд буулгаж, адилтгал адилтгагдахууны бүхэл буюу гол зүйлийг эсрэг тэсрэг харьцуулан жишиж гаргана. Түүний дараа ижилсэж чадахгүй онцлог буюу хэсгийг тус тусаар ялган гаргаж ирсэнээр өмнөх ижилсэлээс нь няцуулж өгүүлэх юм. Дүрстийн чимгийн нэг зүйл. Агваанлувсанжамцын жишээ шүлэгт:

Алинхүү гөрөөс чи нь тор саальд  
Торсоныг мэсээр таслан чадмуй за  
Адаг би бээр сайн хөмсөгтийг хүсэхийн тороор  
Хүлэгдсэн энэ нь таслагдахын чадлаас хагацжээ

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.252)

адилтгал гөрөөс тор сааль буюу урхинд орсныг нь хутга мэсээр торыг тасалж гаргаж болох юм. Адилтгагдахуун би нь сайн хөмсөгт буюу бүсгүйг хүссэн сэтгэлийн тороор хүлэгдсэн үүнийг мэсээр огтолж таслаж чадахгүй хэмээн адилтгал, адилтгагдахуун хоёр нь тор урхиар хүлэгдсэнээрээ ижил боловч мэсээр тасалж чадах, үл чадахын онцлог ялгамжаараа зохилдохгүй болж тус тус өөр өөр болсон нь ерөнхий байдлаараа ижилсэх атал өвөрмөц онцлогоороо ижилсэхээсээ буцсан зүйл болжээ.

3.17. **Хориглогч дүрст** (са: ākseparūpakam, тө: ‘gog pa’i gzugs can). Адилтгагдахууны нэгэн бодисыг адилтгал аль нэгний дүрсэд оруулсан тэр нь хоригдогч буюу тохирохгүй дүрсийн адилтгал болсон байх агаад түүнийг хоригч нь адилтгагдахуун өөрийнх нь үйлдэл буюу онцлог түүгээр адилтгалтайгаа зохицохгүй болохыг өгүүлж, аль зүйрлэн дүрсэлсэн тэр зүйлтэйгээ ижилсэхгүй гэдгийг хааж өгүүлэхийг Хориглогч дүрст буюу Муушаах дүрст гэнэ. Дүрстийн чимгийн нэг зүйл. Агваанлуvsанжамцын жишээ шүлэгт:

Удирдагч дээдийн тийн цагаан зохионгуйн саран бээр  
Усны матрын ялгуусан тэмдэг<sup>13</sup> аймаг сэлтээр муу гаслангийн  
Урхагт харанхуй нүхэнд оруулж л гэрлийн цогийг  
Уламжлан өгөгч хоёр төрөлтийн<sup>14</sup> хаан алинхүү мөн  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.254)

адилтгагдахуун тийн Удирдагч дээдийн манлай буюу Бурхан багшийн зохиол үйлсийг адилтгал сарны дүрсэд оруулсан нь зохисгүй болжээ. Учир нь Бурханы зохионгуй нь шимнусын аймгийг дарж харанхуйлдаг бол сар гэрэлтүүлдэг чанартай. Иймээс энэ хоёрын зүйрлэл буруу зохисгүй доорд муушаагдах зүйл болжээ.

2.18. **Тэгш агуулагч дүрст** (са: samādhānarūpaka, тө: mnyam ‘jog gi gzugs can). Адилтгагдахуун аливаа нэгнийг адилтгалын дүрсэд оруулсан нь өөрийнхөө мөн ахуй ёстой зохицохгүй болсон зохист бусын гэм, үйлдлийн уул оронд ч үесийн гэм буй буюу өөрөөр хэлбэл, өгүүлэгдэх орон болон өгүүлэх үйл хоёулд байгаа гэмийг ижилсүүлэн буюу тэгшитгэн үзүүлсэн чимэг. Дүрстийн чимгийн нэг зүйл. Агваанлуvsанжамцын жишээ шүлэгт:

Эрхэм Шон багшийн айлдлын гэрэл туяа бээр  
Эсэргүүцэгч муу санаатныг харанхуйд хашмуй  
Илэрхий ямагт гэмт номлолд сэтгэл хадангатгасан  
Энэ доорд муу хувьтны буруу үзлийн ч гэм  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.256)

адилтгагдахуун Шон багш Доржжалцангийн айлдал буюу ухааныг адилтгал нарны гэрлийн дүрсэд оруулжээ. Шон багшийн айлдал нь эсэргүү муугийн ухаанд юу ч үл ургах харанхуй мэт болгодог тэр нь нарны гэрэл бээр харанхуйг арилгадаг үйл лүгээ адилгүй буюу зохисгүй болсон гэм байгаа ч тэр гэм нь уул орон Шон багшийн айлдлын нарны

<sup>13</sup> Усны матрын ялгуусан тэмдэг – шимнусын аймаг

<sup>14</sup> Хоёр төрөлт - сарны илт өгүүлэх нэр.

гэрэл гийсэн гагцхүүгийн гэм биш, оронтон муу эсэргүүцэгч өөрийн буруу үзэл тэргүүтэн өөрийнх нь хувь муугийн гэм ч мөний тулд орон оронт хоёулын үйл үйлдэл буюу гэм тэгш байна гэжээ.

2.19. **Дүрстийн дүрст** (ca: rūpaka-rūpakam, тө: gzugs can kyi gzugs can). Адилтгагдахуун болох зүйлийг адилтгалыг дүрсэд буулгаж, адилтгал түүнийг ч өөр нэгэн адилтгалын дүрсэд найруулахыг Дүрстийн дүрст буюу давхар дүрст гэдэг. Учир нь цааш цааш нь уламжлан дүрслэх арга. Дүрстийн чимгийн нэг зүйл. Дандин:

Чиний нүүрийн балчигаас ургасан(лянхуа) энэ хүрээнд  
Хөмсөгний ороохуй модноо бүжигч эх  
Үзүүрхэн цэнгэлдэхүйгээр бүжиглэн үйлдмүй  
Хэмээсэн нь сэтгэлд зохист **дүрстийн дүрст**

Энэ шүлгийн адилтгагдахуун үзэсгэлэнт бүсгүйн нүүрийг адилтгал балчигаас ургасан буюу лянхуан дүрсэд буулгажээ. Тэрхүү лянхуаг ч хүрээ буюу бүжиглэх газар буюу хүрээний дүрсэд буулгажээ. Адилтгагдахуун нүүрийн онцлог хэсэг хөмсгийг нь адилтгал ороохуй модны дүрсэд буулгаж, мөн тэр ороохуй модыг бүжигч эхийн дүрсэд буулгаад түүнийг үзүүрхэн цэнгэлдэж бүжиглэнэ хэмээн өгүүлжээ.

Энэ чимэгт адилтгал болон адилтгагдахууны онцлогууд харилцан зэрэг дараагаар адилтгалын дүрсэд бууж, адилтгал түүнийгээ ч өөр нэгэн адилтгалын дүрсэд буулгаснаар асар гоёмсог бөгөөд сэтгэлд нийцтэй болдог учраас дүрстийн бусад чимгүүдээс үлэмж их манлай яруу бөгөөд үзэсгэлэнт чимэг хэмээдэг.

3.20. **Гүжирлэх дүрст** (ca: tattvapshnava rūpakam, тө: bsnon dor gzugs can). Адилтгагчийг цааш нь дүрсэлж, адилтгуулагчийг мөн ингэж цааш цааш нь ахиулан дүрсэлж, их бие болон үе гишүүний сайхныг гаргадаг арга. Дүрстийн чимгийн нэг зүйл. Дандин:

Энэ нь нүүр бус лянхуа бөгөөд  
Эдгээр нүдэн бус зөгийс буюу  
Эдгээр нь мөнхүү туурцаг буюу  
Энэ чиний шүдний гэрэл буюу.

Машид үзэсгэлэнтэй зүйл энэ нь адилтгалын суурь шүтээн үзэсгэлэнт хүүхний нүүр биш бөгөөд адилтгал лянхуа гарцаагүй мөн. Адилтгагдахууны онцлог хэсэг болсон нүд болон шүдний гэрэл нь адилтгалын онцлог хэсэг болсон зөгий хийгээд туурцагийн эрихс



найруулсан утгын гийгүүлэгч - гэсэн арван хоёр зүйл байна.

4.1. **Язгуур өгүүлэх анхны гийгүүлэгч** (ca: jātidīpakam тө: rigs brjod pa'i thog ma'i gsal byed). Язгуур эрдмийг эхэнд нь өгүүлсэн гийгүүлэгч. Өгүүлэхүүний язгуур алинхүү түүнийг эхэнд гаргаад язгуур түүнийг гийгүүлэгч үгээр дараагийн үг утгыг бүгдийг гийгүүлэх буюу тодруулж чадах нэгнийг “Язгуур өгүүлэхүй анхны гийгүүлэгч” хэмээнэ. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл.

Энэ “Язгуур өгүүлэхүй анхны гийгүүлэгч” болон утгын чимгийн анхны “Язгуур мөн чанарыг өгүүлэгч” чимэг *хоёрын ялгаа нь*: “Мөн чанарыг өгүүлэх чимгийн” үед, жишээлбэл, “Навч гишүү тэргүүтэн лүгээ төгөлдөр модны язгуурыг өгүүлээд тийм шинж чанар бүхий модны нийт язгуур даяарыг онцлон гаргаж, өөр бусад язгуур зүйлээс зааглан ангилж өгсөн бол, энд язгуур тэргүүтнийг алинхүү тодруулж өгүүлэх үгсийг бадгийн эхэн, адаг, дунд алинаа байрлуулсан түүгээрээ үлдсэн үгийн утга өмнө хойно бүгдийг тодруулж чадахаар барахгүй үйлдэгч язгуур түүний хэсэг болон үйл ажил тэргүүтнийг өгүүлсэн үгийн дүр байдал нь мөн чанарыг өгүүлсэн чимэгтэй харьцуулбал бага зэрэг явцуурсан байдалтай байна. Дандины жишээнд:

Өмнийн хийгээр ороонго модны  
Хуучин навчис унан үйлдмүй  
Бөхийсөн биетнүүдийн  
Дээрэнгүйг шинээр даран чадмүй

хэмээн язгуур мөн чанарыг өгүүлэхийн гийгүүлэгч үг болох “Өмнийн хий” буюу “Өмнийн салхиар” хэмээх үгийг эхлэж бичээд, дараагийн үг утгуудыг яаж гийгүүлж байна вэ гэвэл, язгуур /өмнийн салхи/ түүгээр ороонго модуудыг хөдөлгөснөөр хуучин навчис нь унах ба мөн бас тэрхүү язгуураар /өмнийн салхиар/ бүсгүйн бие сэрүүцэх болсноор идэр залуугаар бөхийсөн буюу дэлгэрсэн залуу бүсгүй тэрбээр амрагтаа үл бөхийх шинэ дээрэнгүйг даран чадна гэж эхлэн өгүүлсэн язгуур түүгээр хойших утгууд бүхнийг тодруулж өгчээ.

4.2. **Үйл өгүүлэх анхны гийгүүлэгч** (ca: kriyadīpakam тө: bya pa brjod pa'i brjod thog ma'i gsal byed). Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Өгүүлэгдэхүүн үйлийг өгүүлсэн үг буюу гийгүүлэгч түүнийг хамгийн эхний мөрийн тэргүүнд оруулаад, үйлийг тодруулан гийгүүлсэн тэрхүү үгээр дараах үг утга бүгдэд тусыг үзүүлэх буюу тодотгож өгөхийг “Үйл өгүүлэхүй анхны гийгүүлэгч” хэмээнэ. Найруулах ёс болон ялгаа нь



Язгуур өгүүлэх анхны гийгүүлэгч чимэгтэй адил. Дандин:

Бэдмүй, дөрвөн усан сангийн хөвөө дэх

Үүсгэмэл цэцэрлэгт соёот (заан) ба

Хүрээлсэн уулын дотор ч

Чиний эрдмийн цагаан гүнд (Иштавхайн орчуулга)

Үүнд, үйлийг тодруулан гийгүүлэгч үг нь бэдмүй хэмээн гүйх, одох, явахын утга бүхий үйл үг түүнийг мөрийн эхэнд байгуулаад, хойших үг утга бүгдийгээ тодруулж гийгүүлжээ. Хаана гүйсэн буюу бэдсэн бэ гэвэл дорно, өмнө, өрнө, умар гэсэн дөрвөн усан сан буюу дөрвөн их далайн хөвөөний үүсгэмэл цэцэрлэгт бэдсэн. Хэн бэдсэн бэ гэвэл, соёот буюу зүгийн найман их заан бөлгөө. Мөн бас эхэнд өгүүлсэн “Бэдмүй” хэмээсэн гийгүүлэгч үйл үг түүгээр их зааныг тэдгээр цэцэрлэгт бидэж явсаныг ойлгуулж чадах ба ертөнцийн орны төмөр уулаар хүрээлсний дотор ч хааны эрдмийн алдарын цагаан гүндаа цэцэг бидмүй (буюу хааны эрдэм алдар дуурсан явмуй) гэж анхны мөрийн эхний тэр “Бэдмүй” гэсэн үгээр урлаж байна.

Энд гарч буюу зүгийн найман заан гэдэг нь “Мөнх сан” хэмээх шастирт өгүүлсэн нь “Газрыг сахигч хүү, цагаан лянхуа, зүүнээ хүлсэн, нүдний эм, газарт баясагч, цэцгэн соёот, газар бүхнээ, газрын үзэсгэлэн гэсэн зүгийн найман их заан” болой. Зарим орчуулгад, Зүгийн найман их заан гэхгүй зөвхөн заануудын хаан заан гүйж явсан буюу бидсэн гэж өгүүлсэн байна.

4.3. **Эрдэм өгүүлэх анхны гийгүүлэгч** (са: gunadīrakam тө: yon tan bya pa thog ma'i gsal byed). Өгүүлэгдэж буй зүйлийн эрдэм чадлыг илэрхийлсэн гийгүүлэгч үгийг бадгийн эхэнд гаргаж, тэрхүү гийгүүлэгч үгийн чадлаар хойдох үг утганд гарах чадал эрдмүүдийг гийгүүлэх тустай чимэг. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Дандин:

Хөхөмдөг болой, зүг бүр нь

Зуны үүлсийн эрхисээр бас

Хөхөмдөг болой, шинэхэн ногооны эрхисээр

Газар дэлхий мину (ДЗАТ. 1982. т.63)

Хөх болой хэмээх тунарсан өнгө заасан үгээр үзэсгэлэнгийн эрдмийг өгүүлсэн гийгүүлэгч үгийг эхэнд нь байгуулаад дараа хойдох үг утгуудын эрдмийг гийгүүлэн үзүүлжээ. Огторгуйн эн бүгд нь зунаас төрсөн үүлсийн эрих жигдрэн тунарснаар хөх өнгөтэй болжээ. Газар дэлхийн эн бүхэн ч маш шинэ ургасан хөх ногооны эрихсээр хөх

өнгөтэй болжээ хэмээн хамгийн эхэнд өгүүлсэн эрдмийг гийгүүлэн тодруулагч тэр үгээр дараах үг ургуудыг гийгүүлжээ.

4.4. **Эдийг өгүүлэх анхны гийгүүлэгч** (ca: dravya-gūṛaka, тө: rdzas brjod thog ma'i gsal byed). Өгүүлэхүүн өвөрмөц эд түүнийг өгүүлэгч үг буюу түүнийг гийгүүлэгч үгийг эхэнд нь буулгаад гийгүүлэгч үг түүний чадлаар тэр үгээс хойших үг утга бүгдэд тустай бөгөөд гийгүүлж чадах нэгнийг хэлнэ. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Агваанлувсанжамцын жишээ шүлэгт:

Гөрөөсөөр бэлгэт саран бээр

Их далайг сайтар дэлгэрүүлнэ

Хүсэлтэн нугуудын хүслийг арвитгана

Хоёр төрөлт(бярман) олны баясгаланг үүсгэнэ

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.270)

хэмээн бодит эд болох гөрөөсөөр бэлгэдсэн саран хэмээх эдийг гийгүүлэгч үгийг хамгийн эхэнд буулгаад, тэр үгийн чадлаар хойдох үгүүдийг тодруулжээ. Саран бээр далайг дэлгэрүүлдэг, мөн тэрбээр хүсэлтний хүслийг нэмүүлнэ, мөн тэрбээр хоёр төрөлт буюу бярман нарын сэтгэлд баяр бахдалыг үүсгэдэг хэмээжээ.

4.5. **Язгуур өгүүлэх дундын гийгүүлэгч** (тө: rigs bar gyi gsal byed). Өгүүлэхүүн утгын язгуур түүнийг дундын мөрөнд гаргаж, тэрхүү гийгүүлэгч үгийн хүчээр өмнө ба хойдох үгсийн бүх утгыг гийгүүлж тодруулахыг хэлнэ. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Дандин:

Низүүла-гийн өвөрт бүжиглэн үйлдээд

Дууныг дуулмуй тогос шувуун

Баясахуйгаар дэлгэрсэн нүдэн нүгүүдээ

Усан баригчдаа өгөн үйлдмүй

Низүүлаа нь бургасын нэр бөгөөд тэрхүү модны өвөрт яруу дууг аялгуулагч болой. Аялгуулан дуулагч нь юун хэмээвээс өд сүүлт буюу тогосын язгуурыг өгүүлсэн гийгүүлэгч үгийг мөрийн дунд байгуулаад тэрбээр луун дуун гэх тэнгэрийн дуунд сэтгэлээ тушаасан баясал дэлгэрсэн нүдээ ч усан баригч буюу үүлнээ өгөн үйлдсэн буюу өөрөөр хэлбэл ширтэн харсан ажгуу. Хэн, алин харсан хэмээвээс өд сүүлтэн болой хэмээн дундын язгуур өгүүлсэн гийгүүлэгч үгээр өмнө хойт үг утга бүхнийг тодруулсан ажээ.

4.6. **Үйл өгүүлэх дундын гийгүүлэгч** (ca: kriyadīṛaka, тө: bya pa'i

gsal byed). Өгүүлэхүүний гол үйлдлийг илтгэн гаргасан үйл үг буюу гийгүүлэгч үг түүнийг шүлгийн бадгийн дунд оруулаад тэрхүү үйл үгийн чадлаар өмнө болон хойд үгсийн утгыг гийгүүлэн туслах юм. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Агваанлуvsанжамцын жишээ шүлэгт:

Мэдэл ухаантан нарыг сайн номлолоор хийгээд  
Мөхөс үгээгүй ядуусыг эд өлгөөр  
Машид баясган үйлдмүй, хүсэлтэний  
Мишээхүй идэр цогийг дэлгэрүүлэгч сайн хөмсөгт эх бээр  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.275)

хэмээн мэргэд билиг ухаан төгссөнийг сайн номлолоор баясган үйлдэх бөгөөд үгээгүй ядуу дордыг идээ эдийн зүйлийг өгч *баясган үйлдмүй* хэмээх үйлийг өгүүлсэн гийгүүлэгчийг шүлгийн дунд байрлуулж, баясуулахын утгыг тодруулан гийгүүлсэн бөгөөд мөн бас хүсэлт ардуудын идэр цогийг дэлгэрүүлэн бадраагч сайн хөмсөгт(сайхан бүсгүй) бээр баясган үйлдэнэ хэмээн “Баясган үйлдмүй” хэмээх үгээр өмнө хойно байрласан үгсийн утгыг тодотгожээ.

4.7. **Язгуур өгүүлэх эцсийн гийгүүлэгч** (тө: rigs tha ma'i gsal byed). Өгүүлэхүүн утга язгуур түүнийг сүүлийн мөрөнд байгуулж, хамгийн эцсийн мөрөнд байгуулсан гийгүүлэгч үг түүгээр өмнөх мөрүүдэд байгаа үг утга бүхнийг тодруулан гийгүүлэхийг хэлнэ. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Дандин:

Усан баригч(Үүл)ийн маш сацарсан усан  
Гэр дэх өрвөлгө төгссөний<sup>15</sup> чуулган  
Гилбэлгээний шижимийн хөдлөхүй ч  
Цэцэг нумтуудын өмөг

Цэцгэн нумт гэж шимнусын нэр. Шимнусын өмөг хэмээсэн нь язгуурыг гийгүүлэгч үг мөн. Өмнөх гурван мөрийн үг утга бүхнийг энэхүү сүүлийн Цэцгэн нумтуудын өмөг буюу Шимнусын өмөг гэсэн үг тодруулж гийгүүлж байна. Хэрхэн тодруулж гийгүүлж байна гэвэл, зуны цагийн хурын үүлээс машид буусан үргэлжилсэн намираа бороо, гэрт буй өрвөлгөт буюу тогос шувуудын чуулгасыг баясгаж үйлдэх ба гилбэлгээний цалам гялалзан гялалзан хөдлөх тэргүүтэн нь хүсэлт ардын сэтгэлд хүсэл шуналыг төрүүлж орхихын шалтгаан болдог тэр нь цэцгэн нумтан буюу тэнгэрийн хөвгүүний шимнусын өмгийн хүч мөн болой хэмээн язгуур өгүүлэхүйг адагт байрлуулсан гийгүүлэгч

<sup>15</sup> Өрвөлгө төгссөн – тогос, энд эхнэр гэсэн утгаар оржээ.

үгээр урьдах үг утгасаа тодруулжээ.

4.8. **Үйл өгүүлэх эцсийн гийгүүлэгч** (ca: kriya-dīpakam тө: bya pa brjod tha ma'i gsal byed). Өгүүлэхүүн утга буюу үйлийг гийгүүлэгч үгийг адгийн мөрөнд байгуулаад тэрхүү үйл үгээр өмнөх үг утгасаа тодотгон гийгүүлэхийг хэлнэ. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Дандин:

Чиний чихэн дэх удвал  
Амармагийн сумыг нумнаа үзүүлсэн  
Үхэн завдагч миний сэтгэл  
Энэ гурван нь сацуу болбой

Энэ шүлэг нь “болбой” буюу “сацуу болбой” гэсэн үйл үгээр өмнөх үг утгасыг гийгүүлсэн бөгөөд үзэсгэлэнт хүүхэн чи бээр чихэндээ удвал цэцгийг чимэг болгон зүүсэн ба Амармагийн тэнгэр буюу Шимнус Гааравванчиг бээр хүслийн сумыг нь цэцгийн нум буюу сумыг үзүүлэгчид гүйлгэсэн хийгээд тэр хоёр шалтгаанаар үзэсгэлэнт хүүхэнд дурласан хүсэл сэтгэл төрөөд үхэхүйд тулсан энэ гурван үйл зэрэг болов хэмээн хамгийн сүүлд “болов” хэмээх үйл үг буюу гийгүүлэгч үгийг байрлуулжээ.

4.9. **Эрихсийн гийгүүлэгч** (ca: māla-dīpakam тө: phreng pa'i gsal byed). Өгүүлэхүүний утгыг тодруулан гийгүүлэгч үгийг эхэн, дунд, адгийн аль ч хамаагүй мөрөнд байгуулна. Гэхдээ тэрхүү гийгүүлэгчийн хойд хойдын үг утга нь өмнөх өмнөх үг утгастаа хамаарсан байгааг үзүүлсэн учраас гийгүүлэгч хойш хойшихын утга гийгүүлэгч өмнөх өмнөхийн утгаа гийгүүлсэн тэдгээрийг зэрэг дараалан хэлхсэн буюу өөрөөр хэлбэл эрихний хэлхээ мэт бие биедээ харгалзсан нэгийг хэлнэ. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Дандины

Цагаан зүгээр арвитгагч цагаан гэрэлт  
Тэрбээр таван сумтыг  
Тэрбээр тачаангуйг тачаангуйгаар ч  
Залуу эхсийн баярлахуй баяр хуримын цог болой

хэмээх **эрихсийн гийгүүлэгч** шүлгийн **арвитгагч** хэмээх нь гийгүүлэгч үг болно. Цагаан зүгт буюу шинийн цагаан гэрэлт сарны мандал нь улам зэргээр тунгалагшин нэмэгдэж буюу арвидаж байдаг. Тэр нь таван сумт буюу Амармагийн тэнгэрийн нэрээр заагдсан хүсэлт ардуудын хүслийг арвитгаж байдаг. Хүсэл тэр нь идэр залуусын нүүрэнд улаан туяа бутруулж хүслийн байр төрхийг арвитгаж байдаг. Тэрбээр эхнэрүүдийг баясгах баяр хурим буюу хүсэл цэнгэлийг

арвитгаж байдаг гэжээ.

Тэгэхээр *арвитгагч* хэмээх энэ үгээр гийгүүлэгдсэн энэ бадаг шүлгийн хоорондоо хэрхэн уялдаж эрихэн хэлхээ болж буйг үзүүлбэл, шинийн нэгнээс арван таван хүртэлх цагаан зүгийн хоног нь сарны мандалыг улам улмаар нэмэн арвитгаж байдаг, тийнхүү нэмэн арвидагч тэр сар нь хүсэлт ардын хүслийг арвитгаж байдаг. Хүсэлт ардын хүсэл нь нүүрнээ илрэх хүслийн шинж тэмдгийг арвитгаж байдаг. Тэрхүү нүүр царайны байдал төрх нь эхнэрүүдийн цэнгэл хуримыг арвитгаж байдаг хэмээн хойдох хойдох нь өмнөх өмнөхдөө харгалзаж арвидаж байгааг үзүүлсэн бөгөөд харин тэгэхдээ бадгийн хоёрдугаар мөрөнд байгуулсан арвитгагч хэмээх үгээр бүгдийг гийгүүлж байгаа хэрэг болно.

4.10. **Харш утгын гийгүүлэгч** (ca: viruddharthâdīpakam тө: ‘gal pa’i don gyi gsal byed). Гийгүүлэгч нэгэн үгээр гийгүүлэгдэхүүн харш утгатай үйл хоёрыг нэг дор гаргаж үзүүлэхийг хэлнэ. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Агваанлуvsанжамцын жишээ шүлэгт:

Эрхин сайн хөмсөгт бүсгүй тэрбээр хүсэхүйгээр  
Энэлэгдсэн шаналалыг төрүүлэх болоод  
Учралдан амраглахын жаргалыг шүтүүлснээр  
Уламжлан хүслийн баясгаланг дэлгэрүүлдэг

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.286)

Сайн хөмсөгт хэмээх гийгүүлэгч үгээр гийгүүлэгдэхүүн хүсэл шунал төрүүлэх, тэрхүү хүсэл шуналаар нэрвэгдэн шаналсан зовлонг үүсгэх, мөн түүнээс амраглан золгосны жаргалыг үүсгэх тэргүүтэй хоёр харш үйлийг нэг дор өгүүлснээр харш утгатай болов хэмээжээ.

4.11. **Ганц утгын гийгүүлэгч** (ca: ekârtha-dīpakam тө: don gcig gi gsal byed). Гийгүүлэгч нэг үгээр нэгэн зүйлийн ахуй төрхийг илрүүлэн гаргахын тулд олон зүйлийн үйлийг зааж үзүүлсэн чимгийг “Ганц утгын гийгүүлэгч” чимэг гэнэ. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Дандин:

Энэ усан баригч нугуудын эрихсээр  
Зүг нүгүүдийн чөлөө завсарыг булааж  
Оддын чуулган нугуудыг бариад  
Эдүгээ бас миний амин нугуудыг авмуй

гэх **гагцхүү утгыг гийгүүлэгчийн** жишээний гийгүүлэгч үг нь “Усан баригчийн эрхис” хэмээх үгс болно. Тэр үгсээр огторгуйн уудмын

энг булаасан буюу өөрөөр хэлбэл тэнгэрийг битүү үүлээр хучсан, харанхуй бүрхэгээр сайтар дүүргэсэн, тэрбээр машид гийгч оддын чуулгасыг ч гянданаа барьж хорьсон мэт гүйх явах замыг хаагаад үзэгдэхгүй болгосон, янаг амрагаас хагацсан хүсэлтэнүүдийг хүслээр хүчтэй энэлүүлэн шаналгаж амийг нь авах буюу үхэлд тулгаж зовоосон хэмээн “булааж”, “бариад”, “авмуй” хэмээх үгсүүдээр гол гийгүүлж гаргах учиртай янагаасаа хагацсан хүсэлтэнд хүсэл нь арвижиж байгаа ганц утгыг тодруулж гийгүүлж өгч байна.

4.12. **Найруулсан утгын гийгүүлэгч** (ca: ślishtārta-dīpakam тө: sbyor pa'i don gyi gsal byed). Найруулагдах зүйл нь хоёр байх бөгөөд тэдгээрийн нийтлэг зүйлүүдийг үг болон утга алин болохын үүднээс ангид тусад нь найруулах бөгөөд гийгүүлэгч нэгэн үгээр найруулагдах зүйл ба найруулж буй зүйл хоёрын гийгүүлэгдэх ахуй байдал нэгэн буюу үйл үйлдвэрээр ижилсүүлэн холбох арга юм. Гийгүүлэгч чимгийн нэг зүйл. Дандин:

Үзвээс дуранд зохист үнэрийг хөлөглөгч  
Цэгүүхэн хөх Дамала цэцгийн өнгөт  
Үүлс нь огторгуйгаар бядан үйлдмүй  
Заан нь эдгээр газарт болой

Найруулах суурь үүл хийгээд заан хоёрын найруулах нийтлэг зүйл болсон Гандхахава. Гандха нь үнэр хийгээд Хава нь уналга буюу хөлөг. Эдгээр нь хоёр утганд орох тул үүл нь үнэрийн уналга салхи лугаа ялгалгүй гүйснээр үнэрийн уналга хэмээн утганд найруулснаар тэр мэтээр нэрийдсэн бөгөөд зааны шанаанаас анхил үнэр гардаг учраас үнэрийг олсон хэмээх үгээр найруулжээ. Үүл огторгуйд оршихуйгаар өндөр хийгээд зааны дүрс овор өндөр болон Дамала<sup>16</sup> модны өнгө мэтийн цэгээн хөх өнгө түүнийг хурын үүл ба заан хоёуланд байдгаар утганд найруулжээ. Гүйгч буюу бядагч гэсэн нь гийгүүлэгч үг мөн тул найруулах зүйлсийг харилцан ижилсүүлж найруулах шүтээн үүл нь огторгуйд гүйх хийгээд заан нь газарт гүйдэг хэмээн ялгамжааны суурь хоёрын ялгамжаа ангид боловч завсарын үйл үгээр гүйхийн үйлээр ижилсгэн найруулжээ.

*Тав. ЭРГЭХ ЧИМЭГ* (ca: avrtti, тө: bskor pa, хя: 重迭修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 5 дахь чимэг. Үг болон утга, үг утга

<sup>16</sup> Дамала - хэмээх мод нь далайн ойр ургадаг цэгээн хөх навчтай нэгэн зүйл мод гэжээ.



дахин дахин давтан эргэлдүүлэхийг “Аялгуугаар эргэх” хэмээнэ. Эргэх чимгийн нэг зүйл. Агваанлувсанжамцын жишээ шүлэгт:

Үзэмжит цагаан гэрэлт бээр гүнд цэцгийг дэлгэрүүлнэ  
Үнэхээр ялгуусаны нигүүлсэхүй бээр амьтны тусыг дэлгэрүүлнэ  
Үзтэл, Эгшигт эх бээр миний оюун билгийг дэлгэрүүлнэ  
Үнэн сайн номлолын үгсээр саруул ухаантны баясалыг дэлгэрүүлнэ  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.297)

Саран, бурхан, Эгшигт эх, сайн номлолын үгс тэргүүтэн үйлдэгч болон үйлийн орон ангид өөр боловч дэлгэрүүлнэ хэмээсэн үйлийн ижил үгээр дахин давтан эргэлдүүлсэн ажээ.

5.3. **Утга, аялгуу (үг) хоёулаар эргэх** (ca: ubhāyavrtti, тө: gny-is ka bskor pa). Энэ нь үг ба утга хоёулангаар эргэх. Өөрөөр хэлбэл, Эргэгдэхүүн орон түүнээ түүний үйлийг тодруулагч утга ангид өөр боловч үгийн өгүүлэх ёс нэгийг дахин давтан үгээр эргэлдүүлэх хийгээд үг утга өмнөхийн утгыг бас дахин давтаад өөр утгыг үзүүлэх бөгөөд үг утга хоёулыг хамтад давтах буюу эргэлдүүлэхийг хэлнэ. Эргэх чимгийн нэг зүйл. Дандины

Энэ өдөр чи бүхнийг ялж  
Хатад бүхэн лүгээ цэнгэлдэн үйлдмүй  
Чиний дайсан нь өндөр язгууртнаа одож  
Охин тэнгэрс лүгээ наадан үйлдвэй

Энэ шүлэг нь Үг болоод утга хоёуланг эргүүлсэн жишээ байна. Жишээ шүлгийн “наадан үйлдмүй” гэдэг нь үг эргүүлж/олон утгатай нэг үг/ байна. “ялж” гэдэг нь нэг утгатай олон үгийг төлөөлөн буй тул утга эргүүлж байна. Иймд энэ шүлгийн утга нь дайнд ялж, хатагтай нарыг булаан авч тэдэнтэй цэнгэсэн байхад бас ялагдсан хаад нь үхээд тэнгэрт төрж, охин тэнгэр нартай наадсан байдлыг харуулж байгаа учраас үг, утга хоёрыг нэгэн илэрхийлэлд багтааж эргүүлсэн жишээ болно/ДЗАТ. 1982. т.68/

**Зургаа. ХОРИГЛОХ ЧИМЭГ** (ca: āksepa, тө: ‘gog pa, хя: 否定修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 6 дахь чимэг. Түртгэгч чимэг ч гэдэг. Энэ чимэг нь алив нэг хэрэг үйлийн болж бүтэж хэрэгжих байдлыг хориглож болиулж зогсоох арга ухаан юм. Аливаа нэгэн зүйлийг хорих, хаах, хориглох утгыг гаргахын тулд бус, үгүй, үл



одоо, хаанаас тийм болох гэх мэтийн хааж хорих үгсийг хэрэглэн зүйл бүрээр хориглож бичихийг “Түртгэгч чимэг” буюу “Хориглох хаах чимэг” гэнэ.

Хориглогч буюу түртгэгч нь өнгөрсөн, ирээдүй, одоо гурван цагт болсон, болох, болж байгааг илтгэсэн 3 зүйл байна. Хааж хориглох арга янз байдал хязгааргүй олон. Дандин бээр түртгэж хориглох аргыг 23 зүйлээр авч үзжээ.

Түртгэгч чимэг нь: Болсныг түртгэгч, илт болсныг түртгэгч, ирэхүй болохыг түртгэгч, номыг түртгэгч, номтоныг түртгэгч, шалтгааны түртгэл, үрийн түртгэл, даган соёрхохуй түртгэл, эрхээр түртгэхүй, үл таалахуйгаар түртгэх, өлзий өгүүлэхээр түртгэх, ширүүнээр ятгаж түртгэх, нөхцөлөөр түртгэх, шамдалаар түртгэх, бусдын эрхээр түртгэх, аргаар түртгэх, хилэнгээр түртгэх, гаслахуйгаар түртгэх, гэмшилээр түртгэх, түүдэрлийг түртгэгч, найруулснаар түртгэх, бус утгыг түртгэх, шалтгаанаар түртгэгч - гэсэн хорин гурван зүйл байна.

6.1. **Болсныг түртгэгч** (ca: vrttiksepa, тө: byun bkor). Эрт урьд болж өнгөрсөн, хүн итгэхэд бэрх ямар нэгэн гайхамшигт үйл явдлыг үнэхээр тийм гэж үнэмшихгүй байгааг хорьж, түүнээ итгүүлэхийг оролдож, ингэхдээ хааж хорьсон үгсийг хэрэглэн, буруугаар ухаж ойлгосон санааг арилгах үүрэг бүхий чимгийг “Өнгөрсөнг түртгэгч” буюу “Болсныг түртгэгч” гэнэ. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл.

Өөрөөр хэлбэл, энэ чимгийн үүрэг нь, одоо цагаас өмнө болсон үнэмшихэд бэрх нэгэн явдлыг үнэмшихгүй байгаа мэт үгээр нийтэд нь тодорхойлоод, эцэст нь үнэмшихээс өөр аргагүй буюу үнэн гэсэн ойлголтыг өгөх ёстой болж байна. Дандин:

Биегүйтний<sup>17</sup> цэцгийн  
Таван сумаар<sup>18</sup> хамгийг ялах болбой  
Хэмээсэн нь үл болох зүйл ба эс бөгөөс  
Бодын хүчийг сайтар тодотгогч

**болсныг түрдгэгч** энэ шүлгийн утга нь: Биегүй гэж Амармаг тэнгэрийн цэцгэн сум гэж байдаг, тэр сум нь зөөлөн, таван тооноос ихгүй байтал тэр нь гурван сансарын амьтан бүхнийг эрхэндээ оруулж, тэдгээрийг сайтар ялдаг хэмээсэн эртний тэр түүхэнд өгүүлсэн нь

<sup>17</sup> Бие үгээгүй – биегүйтэн – чөтгөр гэсэн үг

<sup>18</sup> Цэцгийн таван сум -сэтгэлийг ховсдох мэт татах

худлаа бизээ гэдэг бодлыг хорихын тулд гэвч тийм байж болох бөгөөд аливаа бодисуудын чадал хүчийг хэмжихэд бэрх байдаг хэмээх үгээр хориглож хаасан байна. Өөрөөр хэлбэл, Амармагийн тэнгэр нь тавхан сумтай, тэр сум нь цэцгээс бүтсэн учраас зөөлөн мятархай атал бүх дэлхий ертөнцийн амьтныг тэр таван сумаар эзлэн барьсан гэдэг түүх худлаа буй за гэж үнэмшихгүй байгаа бодлыг хорихын тулд бодисын чадал хүч хэмжиж дүгнэхэд маш бэрх байдаг, тиймээс тэр түүх үнэн гэж хариу хааж өгүүлсэн байна. Сэцан:

Дэлхийд алдар нь бадарсан Гэсэр хаан бээр  
Дэндүү баатарлагаар догшин дайсны цэргийг  
Даран сөнөөсөн тэр түүх худлаа буй за, гэвчиг  
Дайчин баатар хүмүүний хүчин чадлыг хэлж баршгүй  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.304)

Гэсэр мэргэн хаан ганцаар Шарайголын хаадыг даран сөнөөсөн гэдэг түүх худал байхаа гэсэн нь хоригдохуун бөгөөд түүнийг хориглогч үг нь гэвч дайчин баатарлаг, зориг цөс ихт хүний хүч чадлыг бараглахад бэрх хэмээсэн ажээ.

6.2. **Илт болсныг түртгэгч** (ca: vartāmanvksepa, тө: mngon gyur ‘gog pa) буюу Одоог түртгэх. Эдүгээ одоо үйлдэж буй дэмий үйлийг хориглож, жинхэнэ зөв зүйлийг онцлон өгүүлэхийг хэлнэ. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Яруу аялгуу нугууд чихэн дэх  
Удвалд юуны тулд ормуй  
Энэ үйлд өнцөглөхүй нүднүүдийг  
Огоот төгссөн бус хэмээн сэтгэх нь юун

Зарим нэгэн цагаан бус удвалыг  
Чихнээ үйлдээд амрагууд бээр  
Тэр мэтийг магтаж түртгэн үйлдэх  
Энэ хэмээвээс **илтэд болсон түртгэл** болой

Энэ шүлгийн утга нь яруу аялгуут буюу бүсгүй чи бээр юунд чихэндээ удвал цэцэг хатгана вэ? Түүнээс үзэсгэлэнтэй бөгөөд сэтгэлийг булаах төрөлхөөс өнцөглөсөн нүдээ хөдөлгөх тэргүүтэн үзэсгэлэн гоогийн онц ялгамжууд чамд бүрдэн төгссөн байхад хэмээжээ.

Үүнд нэгэн бүсгүй чихэндээ удвал цэцэг зүүж буй одоогийн

тэр үйлдэл нь хоригдохуун, хориглогч үг нь өөр нэгэн нөхөр тэрхүү үйлдлийг нь үзээд тэр бүсгүйд чиний нүүрнээ хөдлөх өнцөглөсөн нүд тэргүүтэй үзэсгэлэн цөм бүрдээд байсаар атал одоо чихэндээ удвал зүүж юу хийнэ вэ, чамд одоо үзэсгэлэн бүрэн бүрдээгүй байгаа юм уу хэмээн өгүүлж тэрхүү бүсгүйг чихэндээ удвал зүүж байгаа эдүгээгийн тэр үйлийг хориглон түртгэж байна.

6.3. **Ирэх болохыг түртгэгч** (ca: bhavishyadvksepa, тө: 'byun 'gyur 'gog pa) буюу ирээдүйг түртгэх. Энэ нь ирээдүйд болж болох зүйлийг хориглож хаах утга юм. Өөрөөр хэлбэл, ирээдүйд болох нэгэн үйлдлийг хоригдохуун буюу түртгэгдэхүүн болгож, тэрхүү үйлдлээс үр дүн нь маш бэрх хэцүү гэм буйг хааж түртгэж өгүүлэхийг хэлнэ. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Эрхэм ээ үнэн өгүүлмүй би  
Бусад лугаа озон егүүдсэн  
Энгэсгэн мэт улаан үүнийг чи нь  
Нүдээр үзэхүйеэ болох бус

Энэ жишээнд: Эрхин буюу эзэн чи бээр бусад бүсгүй лүгээ үнсэлдсэнээс уруулын өнгө чинь өөрчлөгдөж энгэсэг мэт улаан болсон нь түртгэгдэхүүн, түртгэгч нь чиний энэ байдлыг би нүдээрээ олж үзэх нь надад зовлон авчирч би үхэх учраас намайг чи бээр хэзээд үзэхгүй болно гэж өгүүлсэн энэ нь Эрхин бээр өөр бүсгүй лүгээ ханилбаас ирээдүйд өөрт хорлол ирэх болохыг өгүүлсэн хэрэг.

6.4. **Номыг түртгэгч** (ca: dharmvksepa, тө: chos 'gog pa). Энэ нь сайхан бүхэл юмны аль нэг хэсэг гишүүнийг эсрэг утгаар хааж өгүүлж, сайхныг магтах найруулга. Бодис аль нэгний ялгал буюу ном хийгээд номтон хэмээн хоёр ялгасны ном тэр нь түртгэгдэхүүн, түртгэгч нь ном тэр лүгээ харшилсан нэгэн гэмийг бүтээгч болгон байгуулаад түртгэсэн нэгийг хэлнэ. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Нарийн биет чиний гишүүн нүгүүд  
Мөнхүү зөөлнөө оршсон нь худал  
Хэрвээ үнэн зөөлөн бөгөөс  
Гэнэт намайг юунд энэлгэх

хэмээх **номыг түртгэгчийн** жишээнд: нарийн биет буюу бүсгүй чиний гишүүд зөөлнөөр оршигч гэдэг нь худал юм. Хэрвээ зөөлөн гэдэг нь

үнэн байсан бол гэнэт намайг хүсэн согтуурахын ширүүн энэллээр юунд шаналгана хэмээн бүсгүйн биеийн онцлог зөөлөн тэр нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч нь онцлог зүйл болох зөөлөн гэдгээс няцаж надад ширүүн энэлэл үүсгэж байна хэмээсэн ажээ. Өөрөөр хэлбэл, бүсгүйн бие зөөлөн гэдгийг өөрт энэлэл өгч буй бүсгүйд татагдах хүслийн шаналлаар түртгэж байгаа хэрэг болно.

6.5. **Номтныг түртгэгч** (ca: dharmayvksesa, тө: chos can ‘gog pa). Алив нэгэн бодисын хуваагдах суурь буюу бүхлийг номтон хэмээж нэрлэдэг. Тэрхүү бүхлийг түртгэж, түүн лүгээ харшлалтай нэг гэмийг гаргаж ирэхийг хэлнэ. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Тэр нь гоо буюу юу бус хэмээн  
Ялгахуй энэ нь юунаас төрмүй  
Түүнээ мөнхүү гэрлийн төдийгөөр хөдлөхийг  
Үзсэн амуй за, шүтээнийг бус

**номтныг түртгэхүйн** Жишээ нь: өгүүлэхийг хүссэн бүхэл нь бүсгүй тэр нь үзэсгэлэн гоо буюу үзэсгэлэнгүй хэмээн шинжлэх тэр нь ямар шалтгаанаас үүсэв хэмээх нь түртгэгдэхүүн, түртгэгч нь тийм бодол үүсэх нь зохисгүй бөгөөд яагаад тэр вэ гэвэл тэр нь гэрэл хөдлөх төдий нэгэн үзэгдэх нь тэрхүү бүсгүйн бодит бие бус учраас огт байхгүй нэгэн зүйлийг ажиглаж суух нь зохихгүй хэмээн бүхэл суурь буюу нарийн биет буюу бүсгүйн бодит шүтээнийг үзэхийг түртгэсэн болно.

6.6. **Шалтгааны түртгэл** (ca: karanvksesa, тө: rgyu'i ‘gog pa). Гадна дотно бодис алин ч байж болохын үр дагаварыг үүсгэдэг гол шалтгаан тэр нь түртгэгдэхүүн, түртгэгч нь үр дүнг үүсгэдэг гол шалтгаан тэр нь байхгүйн учир шалтгааныг гаргаж ирж түртгэхийг өгүүлэх арга. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандины

Чиний нүдэн улаан болоод  
Уруулын гишүүн навч хөдлөх ба  
Хөмсгөөн мөхөрөхүй тэр мэт болбоос бээр  
Над гэм үгүйн тулд үл аймуй.

**шалтгааны түртгэл** болох энэ жишээнд: амраг хүүхэн айх буюу дагжих шалтгаан нь өөрөө бус эр лүгээ холбогдсон гэм буюу алдалыг далдуур үзүүлсэн нь түртгэгдэхүүн, түртгэгч нь эзэн чиний нүд улаан болж, уруул хөдлөх ба хөмсөг мөхөөрөхүй буюу тахиралдан зангираад

уурлан хилэгнэхийн дүр байдлыг үзүүлэх тэргүүтэн эзэн чи уурлахын шалтгаан намайг өөр эр лүгээ ханьцсан гэм надад үгүй учраас би үл аймуй хэмээн амраг хүүхний айх гол шалтгаан нь өөр эр лүгээ нийлэлдсэн гэх гэмийг түртгэж байна.

**6.7. Үрийн түртгэл** (ca: k̄aγv̄k̄sepa, тө: ‘bras bu ‘gog pa). Үүсэн буй болох үр дүнг түртгэж, түүнийг үүсгэж болох олон зүйлийн шалтгааныг байгуулаад тэдгээр шалтгаан цугласан авч тэрхүү үрийг үүсгэж чадахгүйг өгүүлэхийг хэлнэ. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Амраг нугууд холд ахуй ба  
 Явахуй төгөлдөр усан баригч үүл энэ нь ирээд  
 Низула мод бээр дэлгэрснийг үзвээс  
 Миний үл үхэх энэ нь юун.

**үрийн түртгэл** болох энэ шүлгийн санаа нь амраг хань нь алсын аянд явсан уйтгартай үед низулай мод нь навчаа дэлгэн, сэрүүцүүлэн амрагч үүлэн ирэхэд нөхрөө санах, сэрүүцэн тачаал хөдлөх зэргээр үхэхийн маш олон шалтгаан энэ бүгд чуулсан атал өдгөө би үхэхгүй, өнө удаан зовлонгийн суулга болж энэлж байгаа энэ нь юуных вэ хэмээн үр болон ирэх үхэл тэр түртгэгдэхүүн, үрийг үүсгэгч нь шалтгаан амраг лугаа хагацсан тэргүүтэн үхэхийн шалтгаан болсон нөхцөлүүд чуулсаар атал би үхэхгүй байна хэмээн өгүүлснээр үрийн түртгэл үхэл түүнийг шууд түртгэсэн байна.

**6.8. Даган соёрхох түртгэл** (ca: anujñāk̄sepa, тө: rjes gnang gis ‘gog pa). Бусдын хүслийг дагах юм шиг атлаа өөрийн үл хүсэх хүслийг илтгээд гарах үр дүнг өөрчилж чадах арга. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Хэрвээ ажирахуй болбоос ажран соёрх  
 Чи одсоноор над  
 Үүрд зовлон болох үл болмуй  
 Үүнд чи нь сэжиглэн үл үйлдтүгэй.

хэмээх **даган соёрхох түртгэл** болох жишээнд: Гэрийн эзэн өрхийн тэргүүн чи хэрвээ өөр оронд ажрахыг хүсвээс ажрагтун. Чи өөр оронд ажирсанаар хүүхэн надад хүслийн энэлэл өнө удаан үл болох бөгөөд би түргэн гэгч нь үхэх юм хэмээжээ. Үүний түртгэгдэхүүн нь эзэн нь өөр газарт зорчих ба түртгэгч нь бүсгүй өөрөө үхэхийгээ өгүүлээд

түртгэсэн байна. Угтаа бол нөхрөө явбал яваа гэж даган зөвшөөрч хэлэх мөртлөө нөгөө утгандаа бүү яв гэж, явбал ийм үр дүн гарах юм гэж үхэхийгээ зөвшөөрсөн үгийн өнцгөөр далдлан өгүүлж нөхрийн явахыг хааж хориглож байна.

6.9. **Эрхээр түртгэх** (ca: prabhutvbksepa, тө: dbang gis 'gog pa). Нөхцөлийн зайлшгүй шалтаануудыг сайтар тоочно. Тэгэхдээ өөрийн гарцаагүй эрхийг зааж уг болох үйлийг хориглох арга. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Олон эд нь олохуй болоод  
Замд ч амаад(амар) баясан  
Миний аминд ч сэжиг үгүй  
Боловч амраг чи үл одтугай.

**эрхээр түртгэхүй** болох жишээнд: Эзэн чи өөр зүгт одвоос олон эдийг олох бөгөөд замд амар сайхан зорчих, амраг би ч чамайг явсны хойгуур үхэх тэргүүтний зовлон үл болох бөгөөд эдгээрт эргэлзэн тээнэглээх хэрэггүй. Гэвч чи явж бүү үйлд хэмээн эзнийг өөр газарт явах нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч үг нь чи өөр газарт явбаас өлзийгүй зүйл үгүй бөгөөд хүссэн хэрэг тань амархан бүтэх тэргүүтэнд эргэлзэх хэрэггүй боловч чи бүү явагтун хэмээн их эрхийн үгээр түртгэжээ.

6.10. **Үл таалахуйгаар түртгэх** (ca: snādarvbksepa, тө: ma gus pa 'gog pa). Өөрийн хүсэхгүй байгаа нэгэн зүйл нь түртгэгдэхүүн, түртгэгч нь өөрт бодогдож буй сайн муу ямар нэгэн зүйлийг өгүүлж тухайн зүйлийг түртгэж хорихдоо түүнд дурлахгүй байгаа утга бүхүй үгээр илэрхийлнэ. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Би нь амьдыг эгээрэхүй хүчин лүгээ төгсмүй  
Эдийг сэтгэхийн тул хүчин лүгээ төгссөн бус  
Амраг аа, ажрах буюу суумуй  
Өөрийн ахуй учрыг өгүүлсэн болой  
Алины тулд энэ нь тачаангуй төгөлдөр эх бээр  
Амрагийн явдлыг ятган үйлдээд  
Үл таалан бөгөөтөл үгсийг найруулсан  
Энэ нь **үл таалахуйгаар түртгэх** болой

Бүсгүй нь өөрийн эзэн нөхрийг эдийн төлөө өөр газарт явах болсонд таалахгүй байгаа үгийг өгүүлжээ. Би нь эзэн чам лугаа ханилаад амьдрах хүсэл эгээрэл хүч төгөлдөр байна, эдийг бүтээхийн хүсэл хүч төгөлдөр бус учраас нөхөр чамтай хамт амьдарч байх нь

миний бидний хүсэл зорилго гэсэн санаагаа шууд ил өгүүлээд гэвч эзэн чи явах явахгүйгээ өөрөө шийд гэж тааламжгүй буюу дургүй байгааг илэрхийлсэн үгсээр өгүүлж байна. Энэ шүлгийн утга нь өөрийн нөхөр нь өөр газарт эд олохоор явах гэсэн нь түртгэгдэхүүн, түртгэгч үг нь миний санаа бол тийм бус, чи өөрөө явах суухаа өөрөө шийдэж, аль дураараа бол гэсэн тааламжгүй үгээр өгүүлсэн байна.

6.11. **Өлзий өгүүлэхээр түртгэх** (ca: āsīrvacanvksepa, тө: shis brjod kyis ‘gog pa). Өөрийн хүсэхгүй байгаа үйлд наана илдээ бүтэх ерөөл хэлж буй боловч цаана далдаа энэ үйл болохыг хориглох арга. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Амраг аа, хэрэв ажирах болбоос одтугай  
 Чи нь замд өлзийт болтугай  
 Алин чиний ажирсан тэр оронд  
 Мөнхүү би ч төрөх болтугай.

хэмээн **өлзий өгүүлэхүйгээр түртгэх** жишээнд: Амраг аа чи хэрвээ явахаар шийдсэн бол түргэн явагтун. Чиний зам нь өлзийтэй бөгөөд амар сайн төгөлдөр болтугай. Гэхдээ би ч чам лугаа хагацсанаас энэлсэн зовлонгоор магадтай үхэх учраас чиний хаана очсон тэр газарт төрөх болтугай гэжээ. Үүнд, амраг нь өөр газарт одохыг далдуур үзүүлсэн нь түртгэгдэхүүн, чиний зам нь өлзийт болтугай хэмээсэн хийгээд би ч тэнд төрөх болтугай гэх мэтийн ерөөл хийгээд өлзий өгүүлэхийн үг тэр нь түртгэгч болж байна.

6.12. **Ширүүнээр түртгэх** (ca: parushvksepa, тө: rtsub mos ‘gog pa). Өөрийн хүсэхгүй байгаа үйл юмны нөхцөлийг шууд ил чанга хатуугаар хэлж уг үйл болж бүтэхийг хориглох арга. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Хэрвээ чиний одох үнэн бөгөөс  
 Чи бээр өөр бус нэгнийг эртүгэй  
 Би нь чөлөө эрэхүй үхлээр  
 Мөнхүү энэ өдөр түрдэх болмуй

гэх **ширүүнээр ятгах** жишээнд: хэрвээ эзэн чи өөр оронд явах чинь үнэн болбоос, чи бээр өөр нэгэн эхнэрийг эрэгтүн, би нь чамаас хагацсан зовлонгоор өөртөө чөлөө эрэх бөгөөд амиа хорлож өнөөдөр үхнэ хэмээсэн үүний түртгэгдэхүүн нь нөхөр нь бус оронд явах гэсэн явдал, түртгэгч үг нь чи бээр өөр эхнэрийг эр, би өнөөдөр үхлээ гэсэн

ширүүн үг болно.

6.13. **Нөхцөлөөр түртгэх** (ca: sacivvksepa, тө: grogs nid ‘gog pa) буюу нөхөрсгөөр түртгэх. Өөрийн хүсэхгүй байгаа үйлээ ил наанаа зөвшөөрсөн юм шиг боловч тодорхой нөхцөл шалтгаан өгүүлж, далддаа уг үйлийг болохыг хориглох арга юм. Өөрөөр хэлбэл, өөрийн хүсээгүй үйл буюу зүйл нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч нь өөрөө бээр тэр үйлийг бүтээхэд нь нөхөр хамжаа болох ёсыг үзүүлсэн ч гэлээ утгандаа тухайн үйлийг бүтээхийг хориглож түртгэхээр барахгүй, бусдаар ч түртгэн өгүүлнэ. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандины

Хэрвээ ажрах бөгөөс түргэнээ одтугай  
Хойноос ураг төрлүүд хямрахуй үгсээр  
Бархиран дуудваас чиний явдалд  
Тотгор болон чихнээ хүрмүй

энэ **нөхцөлөөр түртгэх** жишээнд: Хэрвээ эзэн чи явахаар шийдсэн бол эргэлзэж эргэцэлгүй түргэн явагтун. Хоромхон түдвээс чи явж үл чадмуй. Чиний бусад нөхөд болон ураг садан чинь зовж хямраад уйлан гингэнэх дууг гаргахыг чи сонсвоос чиний явдалд саад тотгор болно гэж байна. Энд түртгэгдэхүүн амрагийн явах үйл, түртгэгч үг нь өөрөө бол амрагаа явахыг дэмжсэн мэт өгүүлэх атал цаагуураа бусад нөхөд болон ураг садан чинь явахыг чинь хорино гэж шуудаар өгүүлээд утгандаа өөрөө амрагийн явахыг далдуур хорьсон хэрэг болжээ. Яагаад гэвэл чамайг явахад би хурдан үхнэ ингэхэд чиний хамаатан садан уйлалдан дуу шуу болж чамайг явахад саадтай болно гэж наанаа зөвшөөрөөд цаанаа хориглож байна.

6.14. **Шамдалаар түртгэх** (ca: yatnvksepa, тө: ‘bad pas ‘gog pa). Өөрийн хүсээгүй зүйлийн болж бүтэх үйлсэд сайныг ерөөвч өөрийн цаад хүсэхгүй байгаа мөн чанараар хичээнгүйлэн зориудаар өөрийн эрхгүй мэт болгон өгүүлж уул үйлийг бүтэхийг хориглох арга. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандины

Од хэмээн чамайг баясгахуйг өгүүлэхүй еэ таалавч  
Мөнхүү өөрийг баясгаж үйлдэхүй үгс  
Бүү од хэмээн амнаас  
Гарах болсноо юун үйлдмүй би.

**шамдлаар түрдгэх** энэ жишээнд: түртгэгдэхүүн нь амраг нь өөр газарт



одох болсон, түртгэгч үг нь “Бүү од” хэмээсэн үгийг амнаас алдсан, тэр нь бодож санаад хэлсэн бус бөгөөд чиний хүссэн дагуу “Яв” хэмээн хэлэхийг хичээсэн ч хичээл шамдал маань хэрэггүй болох аж хэмээн ойлгож “Бүү од” хэмээн өгүүлж түртгэсэн буюу хориглосон ажээ.

6.15. **Бусдын эрхээр түртгэх** (ca: paravāsvksepa, тө: gzhan dbang ‘gog ra). Өөрийн хүсэхгүй байгаа нэгэн үйлийг тэрхүү ард бээр бүтээхийг хичээх нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч нь өөрөө түртгэх үгийг илээр үл хэлэвч бусдын эрхийг голлож өгүүлээд далдуур хориглох юм. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандины

Нэгэн эгшин үзэхийг тотгордогч  
Сормуусаан хөдлөхүйгээр хилэгнэн  
Амраг чи бээр одохуйг өгүүлтүгэй  
Би нь түүний дуршсаныг таалмуй

**бусдын эрхээр түртгэх** жишээ үүнд: Тэрбээр амраг нь хатуужилд одох нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч үг нь “Надаас асууж юу хийх вэ, чамд зүрхнээс сормуусаа хөдлөхөд ч хилэгнэн уурласан байдлыг үзүүлэгч хайртай өөр нэгэн амраг байгаа түүнээсээ асуу, түүний хүссэнээр би ч таалмуй” хэмээн өөрөө хориглосон үгийг илээр өгүүлэлгүй бусдын эрхээр түртгэсэн мэт болж үзүүлээд далдуур өөрөө явуулахыг хүсэхгүй байгаагаа хэлж түртгэсэн мэт болой.

6.16. **Аргаар түртгэх** (ca: uraувksepa, тө: thabs kyis ‘gog ra). Өөрийн хүсээгүй үйл бүтэх болоход ямар нэг бэрх нөхцөл дурдан өгүүлж уг үйлийн бүтэхийг хааж хориглох арга юм. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандины

Итгэлээс хагацахуйг хүлцэн үйлдмүй  
Надад хүслээр тусахуйд алин бээр  
Нүднээ халдваас үл үзэгдэгч  
Үзэхүй бус нүдний эмийг надад өгөгтүн

гэх **аргаар түртгэх** Жишээ нь: Итгэл буюу эзэн чамаас хагацахыг янаг би бээр тэсэж болох буй за. Гэвч чамаас хагацсаны сүүлд намайг Амармагийн тэнгэр бээр сумаар оносоноос болсон хүчтэй хүслээр энэлэх учраас Амармагийн тэнгэр бээр үл үзэх эд нүдний эмийн<sup>19</sup> шидийг чи надад өгөгтүн гэжээ.

Түртгэгдэхүүн нь эзэн нөхөр явах үйл, түүнд түртгэгч үгийг шууд

<sup>19</sup> Нүдний эм- хэмээх нь “Үрэл, нүдний эм, газрын доорхи, илд, огторгуйд нисэх, үл үзэгдэх, үл үхэх, өвчнийг дарах гэсэн нийтийн найман шид гэдгийн доторх нүдний эм хэмээхтэй нэгэн ижил утгатай.

хэлээгүй боловч бүтээхэд бэрхтэй нийтийн найман шидийн нэгэн болох нүдний эмийн шидийг өг хэмээн олоход бэрх нэгэн аргыг бүтээх хэрэгтэйн үгийг шууд хэлж амрагийн явахыг түртгэсэн болно.

6.17. **Хилэнгээр түртгэх** (ca: ураувксепа, тө: thabs kyis ‘gog pa). Өөрийн хүсээгүй зүйлийг бүтэж болоход шууд хилэнт байдлаар ширүүн үйл өгүүлж уг үйлийн бүтэхийг хориглох арга. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандины

Эрхин чиний амнаас би  
Одсугай хэмээх үгс магад болмуй  
Доорд амраг чи эдүгээ  
Үл зорчих болбоос юун

гэх **хилэнгээр түртгэх** энэ жишээнд: Эрхин буюу эзэн чиний амнаас амрагтаа хайргүйгээр би өөр газарт одлоо хэмээх зохисгүй энэ үгийг магадтай гаргасан учраас надад энэрэл хайргүй доорд амраг чи одоо өөр газарт явалгүй суусан ч надад хэрэг юу байх хэмээн эзэн бус оронд зорчих нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч үг нь өөрөө эзэндээ янаг хайр ихтэйн учраар эзний явахад тэсвэрлэхгүй хилэгнэсний эрхээр үгээ хянаж чадалгүй эзэнд ширүүн үгийг өгүүлсэн бөгөөд хилэгнэсний дүр байдлын үүднээс явахыг түртгэсэн байна.

6.18. **Гаслахуйгаар түртгэх** (ca: anukrosāksepam, тө: myan gyis ‘gog pa). Хэрэглэж эдлэх зохист зүйлс нь өөр бусдын шалтгаанаар үрэгдэж үгүй болсонд сэтгэл гаслан харамсаж уг үйлийг хааж хориглох арга. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандины

Үнэрлээгүй, чихний ээмэг хийгээгүй, архинд оруулаагүй  
Хөх удвал дайсны бүрдэнд хуучрах болов

Энэтхэгчүүд цөөрмийн удвал цэцгийн үнэрийг үнэртэж, охидын чихэнд зүүж, сайхан үнэр оруулахын тулд архинд хийх зэргээр хэрэглэдэг байна. Тэгтэл тэдгээр зохист хэрэг үйл юуг ч үйлдэх боломжгүй болж дайсны аймгийн үйлийн эрхээр цөөрмийн хөх удвал тэдгээр нь хэрэглээгүй байхад өөр аяндаа хуучирч, хагдрах болов хэмээн гасалсан санаа юм. Энэ нь төр улс доройтож мөхөөд удвал цэцгийн цөөрмийг ч эдлэгч үгүй болсонд сэтгэл гансарч эмгэнэх буюу гаслахын ёсоор өгүүлсэн санаа.

6.19. **Гэмшлээр түртгэх** (ca: anusayvksepa, тө: ‘gyod pas ‘gog pa). Өөрөө бээр бүтээх зохистой нэгэн үйл нь түртгэгдэхүүн, түүнийг

түртгэгч үг нь өөрөө тийн алгасралын эрхэнд автагдаад тэдгээр үйлийг бүтээж чадахгүй болж хэрэггүйгээр хүний насыг өнгөрөөж буйгаа өгүүлсэн бөгөөд гол нь гэмшихийг үзүүлсэн байх нэгийг хэлнэ. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандин:

Нэгэн бээр туст чуулганыг эс үйлдээд  
 Нэгэн ухааныг эс бүтээгээд  
 Нэгэн хатуужлыг ч хураалгүйеэ  
 Бүх насаа барах болов.

Худалдаа ба тариалангийн үйл тэргүүтнийг бүтээж төгс эдлэлийг арвитгаж дэлгэрүүлэх үйлийг ч хийсэнгүй, дохио найруулга тэргүүтэй ухааны гол шастирсыг ч бүтээсэнгүй буюу судалж суралцсангүй, бэрх хатуужилт даяан бясалгалыг ч бүтээж үйлдэлгүйгээр хүний бүхүй л насыг өнгөрөөсөндөө гэмшмүй гэж зохист үйлүүдийг түртгэхүй үгээр түртгэж гэмшлийг голлон үзүүлжээ.

6.20. **Эргэлзээгээр түртгэгч** (ca: samsayvksepa, тө: the tshom ‘gog ra). Эргэлзээг няцааж бодит үнэнг нээх арга. Өгүүлэгдэхүүн орон адил бус хоёр зүйлийг ялгаж эс чадан эргэлзэх буюу түүдэрхэхүйгээр суурь болгосон нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч нь бодьтой буй үнэн оновчтой учир шалтгаанд тулгуурлаж орныг тус тусад нь магадлаж олохын үүднээс эндүүрэх нөгөө нэгэн орныг тэр орон бодит мөн хэмээн түртгэх нэгийг хэлнэ. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандины

Энэ нь намрын усан баригч буюу юу  
 Эсвээс галууны чуулган буюу юу юун  
 Дуун нь бөлзөгийн дуун мэтийг сонссоноор  
 Тэр нь усан баригч бус буюу.

**түүдрэлийг түртгэгч** энэ жишээнд: Огторгуйд явагч цагаан өнгөтэй бөгөөд үзэсгэлэнт энэ нь намрын цагаан үүл юм уу эсвэл галууны чуулган нисэн хөөрч буй юмуу хэмээхийн тээнэгэлзлийг суурь болгосон нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч нь хөлийн бөгж буюу бөлзөгийн дуу жингэнэх мэтийг сонссоноор цагаан агаад гоёмсог энэ нь галуудын чуулган мөн байхаа, усан баригч үүл биш хэмээн тээнэгэлзлийг түртгэж байна.

6.21. **Найруулгаар түртгэх** (ca: ślishtvksepa, тө: sbyar pa’i ‘gog ra). Үг болон утгаар нь хоёр зүйлийн адилыг ижилсүүлсэн найруулаад гол

зүйлийнхээ сайн сайханг илүү болгон үзүүлэх арга. Дандин:

Рашааны чанарт лянхуад  
Уринлаад гилгэрсэн цагаан үрт  
Чиний нүүрийн саран үүнийг буй бөгөөтөл  
Бус сарнаар юунаа үйлдэх.

Энд гол нь бүсгүйн нүүрний үзэсгэлэнг сараас илүү эрхэм гэж өгүүлжээ. Иймээс энд өгүүлэгдэж буй гол эрхэм зүйл нь сар бөгөөд тэр нь сэрүүн төгөлдөр рашааны чанартай, дагалдан өгүүлэгдэж буй бүсгүйн гоёхон нүүр нь үзсэн төдийгөөр сэтгэлийг баясгаж, жаргалыг үүсгэж байдаг. Тиймээс энэ хоёрыг Рашааны чанарт гэж нэгэн дуугаар ижилсүүлсэн буюу өөрөөр хэлбэл нэг үгээр найруулжээ.

Сар нь лянхуа цэцгийг хумиулдаг нь “Лянхуад уринласных” ба бүсгүйн нүүрийн гоо сайхан нь лянхуа цэцгийн үзэсгэлэнтэй мөчөөрхдөг учир мөн бас лянхуад уринласан гэсэн үгээр бас найруулжээ. Энэ мэтээр үг утгаар ижилсүүлэн найруулаад бүсгүйн нүүрийг сарны дүрсэд оруулж, тийнхүү нүүрийн сарны үзэсгэлэн байсаар атал түүнээс өөр огторгуй дахь сараар юугаа хийх вэ, хэрэггүй аж хэмээн гол бодис болох сарны үзэсгэлэнг түртгэгдэхүүн болгож, түүнийг түртгэсэн нь үзэсгэлэнт хүүхний нүүр чинь сар мөн болой хэмээжээ.

6.22. **Бус утгаар түртгэх** (ca: arthvntarvksepa, тө: don gzhan ‘gog pa). Гайхам хэтэрсэн зүйлийг гайхан бишрэхдээ өөр үзэгдлийн бас гайхам чанарыг өгүүлж өмнөх зүйлийн гайхам чанарыг гайхаад байх бусыг өгүүлэх арга. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандины

Чи нь хамгийг дарваас бээр  
Тийн дарахуйд ханах үгүй гайхамшгийг  
Бас ч бадрангуй түлш идэгч(гал) дор  
Хэзээ нэгэн ханахуйг үзмүй.

Хаан чиний буян хийгээд өмөг хүчээр хамаг амьтныг сүрээр дарж болох, одоо ялах аргаар тийн дарсан атал санаа сэтгэл чинь ханаагүй байгаа энэ нь гайхмаар юм хэмээсэн нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч нь “Гэвч тэрхүү үйлд гайхаад байх зүйл юу байнам. Бадрангуй түлш идэгч буюу машид бадармал гал ч түлш модыг хичнээн хийвч ханаж цадахыг нь эс үзэв” хэмээж түүн лүгээ ижил өөр нэгэн зүйлийг гаргаж ирээд тэрхүү үйлд гайхсан оюуныг хаасан байна.

6.23. **Шалтгаанаар түртгэгч.** Магтахын шалтгааныг магтаж хэрэггүй гэж хориглоод уг юмаа сайн гэж магтах арга. Түртгэгч буюу хориглох чимгийн нэг зүйл. Дандины

Хүний эрхт хаан чамайг өглөгч хэмээн  
Хэзээ ч үл магтмуй  
Учир нь гуйлгачин бээр чиний эдийг  
Мөнхүү өөрийн юм хэмээн сэтгэж авмуй

хэмээсэн **шалтгаанаар түрдгэгчийн** шүлэг нь: албат иргэн бүхэндээ эд эдлэлийг ойр хол гэлтгүй өгдөг хаан чамайг “Өглөгч” хэмээн үл магтах бөгөөд гуйланч нар бээр чиний тэрхүү эдийг өөрийн эд гэж бодож авдаг юм хэмээн хааны өглөгийн үйлийг магтахыг магтах нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч нь хаан бээр хураасан тэр эдийг авагч нар өөрийн эд гэж бодож хэмээн хааны өглөгийн үйлийг түүний учир шалтгаан тусгаар болгож хааныг магтахыг түртгэсэн байна.

*Долоо.* **БУС УТГЫГ ЗОХИОСОН ЧИМЭГ** (ca: arthāntara-nyāsa, тө: don gzhan ‘gog pa, хя: 论证修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 7 дугаарх чимэг. Бус утга гэдэг нь өөр утга гэсэн үг. Энэ чимэг нь өгүүлэхийг хүссэн зүйлээ урд нь өгүүлээд, түүний хойноос урьдахыг дууриах чадалтай өөр нэг бодыг өгүүлж санаагаа гаргах арга. Энэ нь өгүүлэхийг хүссэн үйл буюу зарим нэгэн бодисыг бүтээгдэхүүн болгож урьдаар зохиогоод түүнээс агуу их бөгөөд чадалтай нэгэн бодис буюу өөр утгыг бүтээгч болгох ёсоор зохиосныг “Бус утгасыг зохиосон чимэг” гэнэ.

Тэр нь дотроо: Хамгаа түгээмэл бус утгыг зохиосон, ялгамжтайяа оршсон бус утгыг зохиосон, барилдлагат бус утгыг зохиосон, харшлалт бус утгыг зохиосон, зохист бусын бус утгыг зохиосон, зохистын бус утгыг байгуулсан, зохистой бөгөөд зохистой бусын бус утгыг зохиосон, зохисгүй бөгөөд зохистойн бус утгыг зохиосон чимэг - гэсэн найман зүйл болно.

7.1. **Бүхнээ түгээмэл бус утгыг зохиосон чимэг** (ca: viśvayārī, тө: kun khyab). Энэ нь аливаа юм эхлэж төгсөж байдаг. Нар мандаж шингэж байдаг шиг зүйл гэсэн утгыг зэрэгцүүлэн байгуулж үзүүлдэг арга. Бус утгасыг зохиосон чимгийн нэг зүйл. Агваанлуvsанжамцын жишээ шүлэгт:

Дээд бинт эхэд татагдсан Эсрүн бээр  
Дээд тэргүүнээ дөрөв болгосныг хэн бээр муулнаас  
Дээд нирвааны замд эс орсон амьтан даяараа  
Дэндүү хүслээр нэрмэгдэж орчлонд унадгийг үзэгтүн  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.363)

Их тэнгэр Эсрүн нь тэнгэрийн охин Дээд бинт хэмээгчийг хүсэмжлэх сэтгэл төрөөд дөрвөн нүүртэй болсон энэ тухайд шоолж муулах хэрэггүй гэдэг нь бүтээгдэхүүн буюу батлагдахуун, түүний бүтээгч үг буюу батламжит үгс нь Бурханы шашны их бага хөлгөн алины ч зам мөрд үл орсон буюу хутагтын мөрийг сэтгэлдээ үл төрүүлсэн ардууд нь мунхгийн эрхээр нисванисын хүсэлд автаж орчлонд дахин дахин эргэдэг ёсыг харагтун хэмээн бүхнээ түгээмэл батламжийг гаргаж ирсэн ажээ.

**7.2. Ялгамжтай оршсон бус утгыг зохиосон чимэг** (ca: viśeshastha, тө: khyab par la gnas pa). Бүтээгдэхүүн өгүүлэхийг хүссэн бодисын үйлдэл ялгамжаат нэг зүйлийг бүтээгч болгож түүнтэй ижил өөр зүйл бодисын үйлдлийн ялгамжаат байдлыг буулгаж ирэхийг хэлнэ. Бус утгасыг зохиосон чимгийн нэг зүйл. Дандины

Эдгээр усан баригч биетний  
Огоот энэлэхүйг булаан үйлдмүй  
Би бээр олсон бус буюу ихэсүүд  
Бусдын зовлонг устгахын тулд болой

Энэ шүлгийн гол санааг Агваанлуvsсанжамц тайлбарлахдаа. т.ялгалтай байхыг харуулсан бус утга байгуулах гэдэг нь бодь сэтгэл ологчнууд бусдын зовлонг арилгахын тулд байдаг шиг ухаан бодолгүй үүл амьтны халуун энэллийг дарахын тулд болой гэсэн үг гэжээ (ДЗАТ. 1982. т.77).

**7.3. Барилдлагат бус утгыг зохиосон чимэг** (ca: śleshavidha, тө: sbyar pa'i don gzhan bkod pa) барилдлагат гэдэг нь найрлага, найруулгат гэсэн үг. Энэ нь найруулах замаар бус утгас байгуулах арга. Ингэхдээ зэрэгцэх адил утгыг олон утгат нэг үг хэрэглэж найруулах юм. Өөрөөр хэлбэл, өгүүлэхийг хүссэн бодис нэгний ахуй ёсыг бүтээгдэхүүн болгож, түүний бүтээгч болгож түүн лүгээ язгуур ижил бус нэгэн утгыг үгээр найруулахаар барахгүй, тэрхүү нэг үгийг ч олон утганд найруулж болох нэгийг байгуулахыг хэлнэ. Бус утгасыг зохиосон чимгийн нэг зүйл. Дандин:

Малаяагийн хийгээр (салхиар)  
Ертөнцсийн баясгаланг төрүүлэн үйлдмүй  
Хотол төгссөн Дагши наая нь  
Хамгийн зүрхнээ гоо бус буюу юу

Малаяа уулын салхи маш сэрүүн учраас ертөнцийн амьтан бүгдийг баясган үйлдэнэ гэсэн нь батлагдахуун. Батлагч нь Дагши наая. Энэ үг нь өмнөдийн салхи, баруун зүг, даган нийцэх гэсэн олон утгыг илэрхийлдэг учир өмнөөс хөдөлсөн салхи төгссөн хийгээд түүн лүгээ бусдын бодол санаа нийцэх болсон учир хамаг амьтны зүрхнээ гоо бус буюу юу хэмээн нэгэн үгээр олон утгыг үзүүлж найруулсан болно.

**7.4. Харшлалт бус утгыг зохиосон чимэг** (ca: virodhavān, тө: ‘gal ra’i don gzhan bkod ra). Алив нэгэн бодисын үйлтэй нь нийцэхгүй харшлах нэгэн үйлийг өөр нэгэн бодисын мөнхүү үйлтэйгээ харшилдаг нэгэн үйлдлээр жишээлэн буулгах арга. Бус утгасыг зохиосон чимгийн нэг зүйл. Агваанлувсанжамцын жишээ шүлэгт:

Үзэсгэлэн гоо, хүслийг төрүүлэгч Сарасвати бээр  
Үүрд шуналаас ангижирсан билиг ухааныг өршөөмүй  
Идэр залуу хэлбийсэн Шон хэлмэрч багш  
Ид ухаантан нарын зүрхнээ гуа сайхан амуй

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.371)

Гоо үзэсгэлэнт охин тэнгэр Сарасвати бээр бусдыг шуналаас хагацуулж, билиг оюуныг өгдөг хэмээн үзэсгэлэн гоогийн дүрс төгөлдөр болон бусдад хүсэл шуналыг үл төрүүлдэг хоёр нь харшлах аж. Идэр залуу нас нь өнгөрч хөгширсөн Шон багш Доржжалцан нь мэргэдийн зүрхнээ гуа сайхан хэмээн нас хөгширсөн хийгээд зүрхнээ гуа санагддаг хоёр харшлах гэсэн бус нэгэн утгаар батлаж гаргажээ.

**7.5. Зохисгүйн бус утгыг зохиосон чимэг** (ca: virodhavān, тө: ‘gal ra’i don gzhan bkod ra). Зохистой нэгэн зүйлийн үйлдлээс зохисгүй үр дүн гарахыг илэрхийлэн гаргахын тулд өөр нэг зохист бодосын зохисгүй нэг үйлдлийг гаргаж ирж баталгаа болгохыг хэлнэ. Бус утгасыг зохиосон чимгийн нэг зүйл. Дандины

Балыг уугчийн яруу хоолойгоос  
Гарсан зөгийн аялгуу нугуудаар  
Мөнхүү чихнээ ширүүн болсон  
Хүсэл төгөлдөрүүдийн хилэнцэс энэ мэтийг

Энэ нь яруу сайхан дуу хоолойн эгшиг нь сонсогч зарим нэгэнд нэрмээс болж энэлгээ болж байгаагаараа зохисгүй юм гэсэн бөгөөд түүнийг бус нэгэн утгаар батлахдаа хүсэл төгөлдөр хүнд зөөлөн дуу ч ширүүн, халуунаас ангижруулагч сэрүүн салхи ч зовлон болж байна гэж амрагаа хүссэн зарим нэгэн хүнд зохистой зүйлсүүд ч зохисгүй үр дүнг үзүүлдэг гэдгийг үзүүлжээ.

**7.6. Зохистын бус утгыг байгуулсан чимэг** (ca: yuktât mā, тө: ‘os pa’i don gzhan bkod pa). Зохистой нэгэн үйлээс зохисгүй үр дүн гардагийг үзүүлэх бөгөөд чингэхдээ зохистой нэгэн төгс үйлтнийг жишээнд авч гаргаж ирэх арга. Бус утгасыг зохиосон чимгийн нэг зүйл. Дандин:

Уснаас ургагч навчисын энэ ор дэвсгэр бээр  
Миний биеийг энэлгэн үйлдэх нь  
Түлэхүйн чанарт түлш идэгч лүгээ  
Адилын тулд **зохист бус** буюу юу

Энэ нь цэцгэн ор дэвсгэр дээр би зовж байна, энэ зовлон нь галд түлэгдэх адил юм гэж хоёр утга зэрэгцүүлэн үзүүлж байна. Учир нь цэцгэн зөөлөн суудал дээр суух буюу ор дэвсгэр дээр хэвтэхэд бие энэлдгийн учир бол бие нь амарч сайхан болоход хүсэл нь хөдөлж зовохыг хэлж байгаа бөгөөд нөхцлийн зохистойг өгүүлсэн тул зохистойн бус утга байгуулсан жишээ болж байна.

**7.7. Зохистой ба зохисгүй бус утгыг зохиосон чимэг** (ca: vira-  
gya ya, тө: ‘os dang mi ‘os ltog). Зохистой үйлдэл болон зохисгүй үйлдэл хоёрыг дараалан гаргаж ирээд түүнийг батлахдаа ч мөн зохистой хийгээд зохисгүй бус нэгэн зүйлсийг гаргаж үзүүлэхийг хэлж байна. Бус утгасыг зохиосон чимгийн нэг зүйл. Агваанлувсанжамцын жишээ шүлэгт:

Саруул оюунтан мэргэдэд баясах нь зохист буй за  
Саар мунхаг ардууд бээр тэр ёсоор бус  
Сайхан яруу дууг сонсох сонорын эрхтэн  
Сац төгссөнүүд яруу гэх буй, дүлийс бээр бус

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.378)

Саруул сайн ухаантан нар мэргэдэд баясах нь зүйн хэрэг. Мунхаг бөгөөд мулгуу ардууд мэргэдэд баясахгүй байдаг зохисгүй хэрэг. Жишээлбэл: яруу сайхан гоё эгшиглэнт аялгуу нь чихний эрхтэн бүрэн нүгүүдэд зохист агаад чихний эрхтэн бүрэн бус дүлий нарт зохисгүй



болмуй хэмээжээ.

**7.8. Зохисгүй ба зохистойн бус утгыг зохиосон чимэг** (са: vira-  
гуауа, тө: ‘os dang mi ‘os ltog). Зохисгүй үйлдэл хийгээд зохистой  
үйлдэл хоёрыг зэрэг дараагаар гаргаж түүнийг батлан жишихдээ  
зохисгүй болоод зохистой нийт утганд түгээмэл байдаг харш нэгэн  
зүйлийг гаргаж ирэх арга. Бус утгасыг зохиосон чимгийн нэг зүйл.  
Дандины

Гүмүда төгөлдөр саран ч түлэн үйлдэхгүй атал  
Лянхуа гаран орон наран яагаад үл түлэх вэ  
Сараар нэвтлэгдсэнүүд нь ширүүн байхад  
Наранд баригдсанууд нь зөөлөн үл болмуй

Энэ нь зохисгүй ба зохистойн бус утгыг байгуулсан жишээ юм.  
Учир нь сар сэрүүн атлаа шатаадаг нь зохисгүй юм. Нар халуун тул  
ягаад шатааж энэлгэхгүй байх билээ гэдэг нь зохистойн утга юм гэсэн  
байна. Ингэхлээр үүний гол утга бол сар сэрүүн ч гэсэн тачаал хөдөлгөж  
халуун энэллээр энэлгэдгийн нэгэн адил нар яагаад зовоохгүй байх  
билээ гэж зэрэгцүүлсэн утга гаргаж, чингэхдээ урьдах утгы нь зохисгүй  
гэж нэрлэн, хойтохы нь зохистой гэж нэрлэжээ (ДЗАТ. 1982. т.79)

**Найм. НЯЦАЛГАТ ЧИМЭГ** (са: vyatireka, тө: bzlog pa can, хя: 辨异  
修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 8 дахь чимэг. Энэ нь  
эхлээд хоёр зүйлээ адилтгаснаа, дараа нь түүнээсээ буцаж, адилсахгүй  
шинжүүдийг дурдана гэсэн санаа юм.

Адилтгалын үгээр бодитой баригдсан буюу утгын хүч болон үеийг  
олсон алин нэгэнд шүтээд өгүүлэхийг хүссэн хоёр бодисыг зарим нэг  
шалтгааны үүднээс харицлан ижилсүүлж өгүүлээд бас дахин бодис  
өөр өөрт оршсон нийт бусын онцлог ялгаа заримыг өгүүлснээр адил  
бус болохыг үзүүлэх бөгөөд адилтгалаас няцаж өгүүлдгийн учир  
“Няцалгат” хэмээнэ. Мөн “урвалгат чимэг” ч гэж нэрлэдэг.

Няцалгат чимэг нь дотроо 10 зүйл болж хуваагдана. Тэдгээр  
нь: нэгэн няцалгат, хоёр бүрийн няцалгат, найрлагатын няцлалгат,  
түртгэхийн няцалгат, нот үестийн няцалгат, ялгалын төдийнхний  
няцалгат, илүүг үзүүлсэн няцалгат, жич бас адил бус няцалгат, үйлдэх  
адилын ялгалт няцалгат, адил няцалгат, язгуур зохилдсон няцалгат -  
гэх 10 болно.

8.1. **Нэгний няцалгат** (ca: eka vyatireka, тө: gcig gi ltog pa can). Олон зүйлээр адил боловч нэг зүйлээр онцгой ялгаатай адил бусыг үзүүлэх арга. Үлгэр буюу адилтгал, үлгэрт буюу адилтгагдахуун хоёуланд байгаа чадал эрдмийг урьдаар гаргаж, түүний дараа адилтгагдахууны онц нэгэн эрдмийг гаргаж ирээд түүгээрээ өмнөх адилсах зүйлээс нь урвуулж, адил болохоос няцуулахыг нэгэн няцалгат хэмээн өгүүлжээ. Няцалгат чимгийн нэг зүйл. Дандин:

Бат ба их эзэн чанар хийгээд  
Лаваняа тэргүүтний эрдмээр  
Чам лугаа далай адил буюу тус бүр нь  
Чиний бие мөнхүү энэ мэтсээр болой

Лаваняа хэмээх үг нь үзэсгэлэн хийгээд гүн, давсны амт гэсэн 3 янзын утгаар ордог учир хааны тухай өгүүлэх хэсэгт үзэсгэлэнтэй болоод таалал бодол гүн тэргүүтнээр найруулж, далайн тухай өгүүлэх үед ёроол гүн, амт давслаг тэргүүтнээ найруулах ажээ. Эдгээр эрдмүүд адилтгал, адилтгагдахуун хоёуланд нийтлэг байдаг учраас адилтгагдахуун хаан чи нь адилтгагдахуун их далай лугаа адил гэж өгүүлээд гэтэл дараа нь хаан чи нь хүний биеэр үзэгдэгч, сайн эрийн шинж тэмдэг төгөлдөр үзэсгэлэнтэйгээр адилтгал далайгаасаа ангид ялгагдах нь үлгэр утга хоёрын ижилсэлээс нэгэн зүйлээр няцаж байгаа хэрэг болж байна.

8.2. **Хоёулангийн няцалгат** (ca: udhaya vyatireka, тө: gnyis ka'i ltog pa can). Хоёр зүйлийн онцлог эрдмүүдийг нэгэн зүйлээр адилсуулаад тэгэх атлаа тэдгээрийн тус бүрийн нэг нэг онцлог шинжийг гаргаж ирснээр хоёр зүйлээр адилтгаснаасаа няцуулж өгүүлэхийг “Хоёр бүрийн няцалгат” хэмээжээ. Няцлагт чимгийн нэг зүйл. Дандин:

Чам лугаа усан цогцос далайнууд нь  
Савандаа багтан ядах гүн бөгөөд  
Энэ нь тас хар нүдэн лүгээ адил бөгөөд  
Чи нь алтан гэрэлт болой

Далай нь усны захаас үл давах ба хаан нь дээдсийн явдал ёсоос үл давмуй. Мөн бас далай нь ёроол хэмжихүй бэрх учраас гүн агаад хаан нь ухаанаараа жишихүй еэ бэрх гүн ажгуу гэх мэтээр хаан ба далай хоёрыг тус бүр хоёр зүйлээр ижилсүүлэн өгүүлээд түүний дараа далай нь нүдний эм мэт хар өнгөтэй атал хаан чиний бие нь алтан өнгө төгөлдөр буюу. Тийнхүү энэ хоёрын адилсах онцгой хоёр зүйлээс тус

бүрт буй нэг нэг онцгой шинжээр няцуулж өгүүлжээ.

**8.3. Найруулгатын няцалгат** (ca: sahetu vyatireka, тө: sbyar pa can). Адилтгал адилтгуулагч хоёуланд адил утгатай үг хэрэглэж адилтгах тул найруулгат хэмээнэ. Өөрөөр хэлбэл хоёр зүйл бодисыг гурван зүйлийн онцлог эрдмүүдээр адилтгах үгээр найруулсан бөгөөд бодис өөр өөрийн нийт бусын ялгамжаа нэжгээдийг гаргасны үүднээс адилтгахаас буцаж няцах арга. Няцалгат чимгийн нэг зүйл. Дандины

Чам лугаа далай дурваа үрин<sup>20</sup>

Махасадва<sup>21</sup> жавхлан лугаа сэлтэс

Энэ бээр та хоёрын ялгавар аму.

Тэр хэмээвээс усны эзэн, чи нь мэргэн болой.

Хаан хийгээд далай хоёрт дурваароо, махасадва, дэза гэсэн гурван зүйлийн үүднээс адилтгах үгийг найруулсан бөгөөд Дурваароо нь буцаахад бэрх, давст хоёуланд ордог учраас хаан нь бусад бодгалаар хариулахуй бэрх, далай нь давстын мөн чанарт, махасадва гэдэг нь чин зориг, их биет амьтан хоёр утгыг илэрхийлэхийн учирт хаан нь их чин зоригтой, далайд матар загас хэмээх том амьтан оршдог. Дэза хэмээх нь сүр жавхлан хийгээд гал гэсэн утгыг илэрхийлдэг тул хаан нь их сүр жавхлан төгөлдөр бөгөөд далайд галын тэнгэрийн гал<sup>22</sup> гэж морин нүүртийн гал гэж алдаршсан тэр байдаг учраас үлгэр утга хоёул гурван зүйлийн эрдмээр адилсах атал эргээд хоёр зүйлийн онцлогоор өмнөх адилтгалаас урваж няцсан байгаа нь далай бол сэтгэл ухаан гэж үгүй буюу амьгүй усны чанартан агаад хаан чи нь мэдэл ухаан төгөлдөр учраас мэргэний эрхэт хэмээн өгүүлжээ.

**8.4. Түртгэхийн няцалгат** (тө: 'gog pa'i ltog pa can). Энэ чимэгт зорилго, бод хоёрыг үзүүлнэ. Ингэхдээ адилаг нотлож хэлээд дараа нь няцаагдах учрыг хэлнэ. Өөрөөр хэлбэл үлгэр утга хоёрын зарим нэгэн онцлогийн үүднээс ижилсэх боловч адилтгал үлгэр тэр нь адилтгагдахуунтайгаа тэнсэлдэх нь түртгэгдэхүүн, түүнийг түртгэгч буюу ялгагч нь адилтгалын зарим нэгэн гэмийг өгүүлж тэрхүү адилтгал нь адилтгалтай тэнцэж чадахгүйг өгүүлж гаргах арга. Няцлагт чимгийн нэг зүйл. Дандины

<sup>20</sup> Дурваа – дурвас гэж няцаахад бэрх, муу ус гэсэн утгатай

<sup>21</sup> Махасадва – гэдэг нь их хүч, их сэтгэлт амьтан /тэнгэр ч байж болох/ гэсэн хоёр утгатай

<sup>22</sup> Галын тэнгэрийн гал: Галын тэнгэр нь төмөр уулын зүгийн морин хоншоортын галын нэр бөгөөд энэ чулуун нүүрсний мөн чанар орчин тойрны уул далайн өндөр лүгээ сацуу морины хоншоорын хэлбэр мэт бадарсаны тул морин хоншоорын гал хийгээд гүүний амны гал хэмээмүй. Энэ нь далайг хатаан үйлдмүй. (Суматирадна толь бичиг. 428-р тал)

Төр лугаа төгсөөд бат ба  
Эрдэнэ гарахын орон мөн боловч  
Хир лугаа төгссөн матрын орон  
Чам лугаа тэнсэлдэх бус

Хаан далай хоёрыг гурван зүйлээр ижилсүүлжээ. Үүнд хаан нь ертөнцийн сайн журам ёс буюу төр лүгээ төгөлдөр, далай нь давалгаагаа хэмжээнээс үл давуулах ёс төгөлдөр, хаан нь бусдын хов үг тэргүүтнээр автахааргүй бат, далай нь салхиар хөдлөхгүй бат, хаан нь гуу сан тэргүүтэн хүссэн бүх зүйл бүрэн баялаг бөгөөд далай нь шүр сувд тэргүүтэй эрдэнэсийн гарах орон мөн гэсэн ийм гурван зүйлээр Хаан, Далай хоёрыг ижилтгэж болох боловч, далай нь хаан лугаа бүх зүйлээрээ ижил тэнцүү хэмээн үзэж хараахан болохгүй, учир нь далай нь давс тэргүүтний хир гэм төгөлдөр бөгөөд хорт матар загас тэргүүтний орших орон болдог тэргүүтнээрээ хаан лугаа зүйрлэгдэхээс няцаж байгаа болно.

8.5. **Нотлох няцалгат** (ca: sādrsya-vyatireka, тө: sgra ‘jug par mtshungs pa’i ldog pa can). Энэ нь нотлон няцаах арга юм. Өгүүлэхийг хүссэн хоёр зүйл бодисын тус бүрийн үйлдлийг харьцуулан ижилсүүлээд, түүний дараа тэр хоёр зүйлийн адилгүй нэгэн нотолгоо баталгаа бүхүй чанарыг гаргаж ирж ижилсэхээс няцуулах аргыг “Нот үесийн няцалгат” хэмээнэ. Няцалгат чимгийн нэг зүйл. Дандин:

Уул хойг далай лугаа сэлт  
Хамгаа газар эзэлсэн боловч  
Гараар явагчдаас илүү эрхэн болсны тулд  
Чамаас мөхөс буюу

Энд Хаан ба Лусын хааныг адилтгажээ. Уул, Сүмбэр уул, хүний дөрвөн тив, дөрвөн далай сэлт дэлхий даяарыг эзлэн оршдоогоороо Лусын хаан нь хүний хаан лугаа адил боловч Лусын хаан нь гараар явагчид гэх адгуусын аймагт харьяалагдах агаад лусуудын эрхин ноён болох тул мунхаг бөгөөд тэнэг араншинтай. Харин хүний хаан нь хүний эрхин болсон бөгөөд ухаан саруул, мэргэн арга төгссөний тулд Лусын хаан нь Хүмүүний хаанаас хувь доорд буюу хэмээн нэгээхэн учир шалтгааныг нотлон үзүүлж адилаас няцаасан байна.

8.6. **Орон шүтээний няцалгат** (тө: ’gog pa’i ldog pa can). Адилтгаж болох хоёр сайхан юмны ялгалыг үзүүлж няцаах арга. Өөрөөр хэлбэл өгүүлэхийг хүссэн ямарваа хоёр зүйлийг шүтээн, шүтэгдэхүүн гэж

хоёр ангилсны шүтэгдэхүүний эрдмийн үүднээс харилцан адил болохыг далдуур үзүүлээд шүтээний үүднээс харилцан адилгүйг илээр үзүүлж адилтгахаас шуудаар няцуулахыг хэлнэ. Няцалгат чимгийн нэг зүйл. Дандин:

Чиний нүүр ба лянхуа лугаа  
Энэ хоёрын ялгалд  
Лянхуа нь уснаас ургах ба  
Чиний нүүр чамд шүтсэн болой

Үзэсгэлэнт хүүхэн, лянхуа хоёрын ялгаа нь лянхуа уснаас ургасан ба хүүхэн чиний нүүр нь бүсгүй чамд өөрт чинь шүтсэн ажгуу гэж нүүр хийгээд лянхуа хоёрын шүтэгдэхүүн болон үзэсгэлэнгийн ялгамжаа тэргүүтнийг ижилтгэхийг илээр үл өгүүлэн далдуур мэдүүлээд тэдгээр хоёр зүйлийн тус тусын түшиглэх зүйлийг илээр хэлж адилтгахаас няцсан байна.

**8.7. Үлгэрээс үлгэрт нь илүү няцалгат** (тө: dpe las dpe can lhag pa'i ltog pa can). Үлгэрт буюу адилтгагдахууныг илүү эрхэм болгож үзүүлэх арга. Адилтгал адилтгагдахуун хоёроос адилтгагдахуун тэр нь эрдмээр илүү бөгөөд адилтгалд адилтгагдахууны тэр эрдэм чадал нь байхгүйг гаргаж өгүүлснээр адилтгагдахаас няцуулах арга. Няцалгат чимгийн нэг зүйл. Дандин:

Гөрөөсний нүднээ үзүүрхэг хөмсгөн хийгээд  
Согтоогч улаан өнгөөр хүрэлцэх үгүй  
Чиний энэ хоёр нүдэн  
Мөнхүү тэдгээр эрдмээр чимэгдсэн буюу

Адилтгал гөрөөсийн нүднээ хөмсгөө сайтар хөдөлгөхийн хээмсэг аальгүйтэл хийгээд хүсэл сэтгэлээр согтуурч улайх гэх мэтийн зүйл үгүй байдаг. Адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхэн чиний хоёр нүднээ тэдгээр эрдэм буюу чадлууд байдаг болой хэмээн адилтгал адилтгагдахуун хоёрын ижилсэл болох гөрөөсний нүд, бүсгүйн нүд хоёрыг далдуур ижилсүүлэх хэрнээ илээр бол адилтгагдахуун бүсгүйн эрдэм болох хээмсэг байдал болон хүслээр улайх тэргүүтэн чадал байхгүйг үзүүлж адилтгалаас адилтгагдахуун илүү хэмээн үзүүлжээ.

**8.8. Ерөнхий няцалгат** (тө: mtshungs chos dang 'byed byed mtshungs pa'i ltog pa can). Энэ нь адил бус няцалгат юм. Хоёр зүйлийн бодисын харилцан ижилсэх зүйл болон ялгарах зүйлийг шууд илээр хоёулангийг

нь нэг үгээр гаргаж үзүүлдэг няцалгат арга. Няцалгат чимгийн нэг зүйл. Дандины

Чиний нүүр ба цагаан лянхуа хоёр  
Дэлгэрээд сайн үнэр төгссөн амуй  
Лянхуад зөгийс эргэюү  
Чиний нүүр дэх нүдэн сайтар хөдөлмүй

Үзэсгэлэнт хүүхний нүүр хийгээд цагаан лянхуа хоёрын ижилсэх зүйл нь машид дэлгэр агаад сайхан үнэр ханхалдаг гэдгийг илээр өгүүлсэн байна. Мөн түүний дараа ялгарах зүйл нь лянхуа цэцгэнд зөгийс эргэлдэж, хүүхэн чиний нүүрнээ нүд сайтар хөдлөх болой хэмээн ялгарах онцлогийг шууд илээр өгүүлж адилтгагдахаас няцсан байна.

8.9. **Адилыг няцаасан няцалгат** (ca :sādrsya-vyatireka, тө: mt-shungs pa'i ldog pa can). Хоёр зүйл бодисын ижил чанар эрдмийг шууд илэрхийлэлгүй далдуур мэдүүлээд, харин ялгарах зүйлсийг нь илээр шууд гаргаж адилтгахаас няцуулах арга. Няцалгат чимгийн нэг зүйл. Дандин:

Энэ саран нь огторгуйн чимэг  
Энэ галуу нь усны чимэг  
Энэ огторгуй бэдэхүй оддын эрихт  
Энэ усан дэлгэрсэн гүмдаат.  
Үүнээ сар ба галуунуудыг  
Мөнхүү цагаан тэргүүтэн ухахуй хийгээд  
Огторгуй ба усыг тунгалаг хэмээн  
Ухан **үйлдэх адилын ялгал** үйлдээд

Саран хийгээд галуу хоёрын ижилсэх зүйл нь цагаан өнгө, үзэсгэлэн тэргүүтэн олон байвч түүнийг үгээр шууд гаргалгүй далдуур мэдүүлээд ялгарах онцлог нь сар нь огторгуйн чимэг, галуу нь усны чимэг мөн учраас адилгүй гэдгийг илээр шууд үзүүлжээ. Дараагийн хоёр мөрөөр ч огторгуй болон ус хоёр нь машид тунгалаг хийгээд өнгө хөх тэргүүтнээрээ ижил боловч түүнийг үгээр гаргалгүй ялгарах зүйлс нь огторгуй нь од гарагсийн эрихэт, ус нь гүмүда цэцгийн эрихэт болно хэмээн ялгарах чадлаараа хоорондоо ижилгүй хэмээн үзүүлжээ.

8.10. **Язгуур зохилдсон няцалгат** (ca: sajāti-vyatireka , тө: rigs mthun ldog pa can). Хоёр зүйлийн бодисын язгуур нийцэлтэй бөгөөд

үйл үйлдлийн талаас ижил ч гэлээ язгуур угсаа түүний төрөлх чанар буюу эрдмийн талаасаа харилцан ижилсэж чадахгүй байгааг үзүүлэх арга. Няцалгат чимгийн нэг зүйл. Дандин:

Эрдэнийн гэрлээр үл булаагдаад  
 Нарны гэрлээр үл няцахуй  
 Залуу эхийн идрээс болсон  
 Харанхуйгаар үзэхүүнийг түрдгэн үйлдмүй.

Үүнд идэр залуу насны хүсэл сэтгэлийн үүднээс согтуурч мунхарсан мангуу зангийн харанхуй болон ертөнцийн харанхуй хоёр нь харанхуй гэдэг үүднээс ижилсэж болох юм. Гэвч хүслээс үүдэлтэй харанхуй нь ухааны харалган харанхуй мөн учраас түүнийг эрдэнэсийн гэрлээр булааж буюу арилгаж болохгүй бөгөөд нарны гэрлээр ч гийгүүлж чадахгүй. Харин ертөнцийн харанхуйг нарны болоод эдрэнэсийн тэргүүтэн гэрэл гэгээ болгоноор арилгаж чадах учиртай.

*Ес. БОЛОХУЙТ ЧИМЭГ*<sup>23</sup> (ca: vibhāvanā, тө: srid pa can, хя: 存在修飾). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 9 дэх чимэг. Аливаа юм үзэгдлийн онцлог эрдмийн үр дүн нь шалтгаангүйгээр өөрөө аяндаа бий болж гарч ирсэн мэтээр үзүүлдэг арга. Өөрөөр хэлбэл, ертөнцөд машид алдаршсан буюу бүрэн алдаршсан шалтгааныг няцаагаад алдаршаагүй гадаад дотоод шалтгаан өчүүхэн төдийгөөр үүссэн үр дүн ба алдаршсан алдаршаагүй хоёуланд харгалзалгүй үр өөрийн мөн чанар төдийг үзүүлсэн чимгийг “Болохын чимэг” гэнэ.

Энэ чимгийн өгүүлэгдэхүүн нь уг шалтгаан үрийн хуулиас хамаарахгүй мэтээр үзүүлсэн боловч ямар ч зүйл уг шалтгаангүй жамаараа бий болдог гэж байхгүй учраас тухайн шалтгаан нөхцөл нь ил шууд харагдах аргагүй учир байдлаас шалтгаан нөхцөлийн жам ёсыг гажсан мэтээр харагдаж байгаа учраас “Болохуйт” буюу “болж болох” гэсэн утгаар энэ чимгийг нэрлэсэн ажээ.

Болохуйт чимэг нь дотроо: гадаад өчүүхэн шалтгааны үрийг үзүүлсэн болохуйт, дотоод өчүүхэн шалтгааны үрийг үзүүлсэн болохуйт, алдаршсан, эс алдаршсан хоёр шалтгааныг няцаагаад үр өөрийнх нь мөн чанар төдийг үзүүлсэн болохуйт – гэсэн гурван зүйл

<sup>23</sup> Утгын чимэг - “Дандины Зохист аялгууны толийн гол нэр утгын тайлбар”. Хамтын бүтээл. 2017. т.65-169)-ийн Болохуйтаас –Машид нэрийдэгч 4 чимгийг Ж.Ерөөлт, Д.Сумъяа нар хийсэн. Үүнээс товчлон авав.

болж задардаг.

9.1. **Гадаад өчүүхэн шалтгаанд дулдуйдсан болохуйт** (тө: rhyi'i rgyu la ltos pa'i srid pa can). Ертөнцөд алдаршсан буюу нийтийн жам ёсны шалтгаан нөхцөлийг үгүйсгэж гадаад шалтгаан нөхцөл өчүүхэн төдийг далдуур үзүүлээд түүнээс бүтсэн үр дүн өөрийн мөн чанарыг үзүүлэх арга. Болохуйт чимгийн нэг зүйл. Агваантүвдэн:

Арчиж цэвэрлэсэн нь үгүй атал, хирээс хагацсан  
лагшин биеийн нь эн бүхэнд  
Алаглуулж хээлсэн нь үгүй атал, тэмдэг  
үлгэрийн зураг хээ машид дуртсан  
Айлтгаж гуйсан нь үгүй атал, амьтан олонд амгаланг өгөн зохиогч  
Амьтан бүхний ижилгүй гагц янаг Та мөн.  
(Сайн үгсийн сан, 1995. т.363)

Энэ шүлгэнд Дара эх бурханыг магтахдаа арчиж цэвэрлээгүй байтал хирийн гэмээс хагацсан, хээлж зурсангүй атал тэмдэг үлгэрийн зураг алагласан, айлтгаж гуйгаагүй атал амьтны тусыг өөрөө бүтээсэн хэмээн шууд нөлөөлөх шалтгаангүй боловч ерөнхийдөө болдог үзэгдлийг гаргасан байна. Энэ нь гадаад холын шалтгааныг түшиглэж гарсан үрийг мөн чанар болгож үзүүлсэн болохуйт чимэг болно.

9.2. **Дотоод өчүүхэн шалтгаанд дулдуйдсан болохуйт** (тө: nang gi 'ga' zhih la ltos pa'i srid pa can). Нийтийн жам ёсоос гажсан мэт болдог нь тухайн бодисын дотоод өчүүхэн шалтгаанаас болж тийнхүү үзэгдэж буйг үзүүлэх арга. Болохуйт чимгийн нэг зүйл. Дандины

Эм эс түрхсэн цагаан бус нүдэт  
Дарал үгүйеэ дорой хөмсөгт  
Будаг түрхэл үгүйеэ улайсан  
Гоо эх чиний энэ уруул буюу

энэ шүлэгт: хар байхын шалтгаан нь нүдний эм түрхсэнээс болдог атал тиймгүйгээр цагаан бус хав хар нүд, жирэвгэр байхын шалтгаан нь дарагдахаар шалтгаалдаг атал тийм бусаар нумарсан нарийн сайхан хөмсөг, улаан болохын шалтгаан нь будаг түрхсэнээс болдог атал тиймгүйгээр улааран харагдах уруул эдгээр гурван зүйл нь дотоод шалтгаан нөхцөл болох бүсгүй чиний залуу сайхан насны боловсорсноос болсон болохыг далдуур үзүүлсэн байна.

9.3. **Алдаршсан, эс алдаршсан хоёр шалтгааныг няцаагаад үр**



**өөрийнх нь мөн чанар төдийг үзүүлсэн болохуйт** (тө: ngo bo nyid kyi srid pa can). Нийтлэг жам ёсны ч бай үгүй ч бай гадаад дотоод шалтгаан нөхцөлүүдийг цөм үгүйсгээд тэдгээрийг ил далд алинаар ч үл илэрхийлэн ямар ч шалтгаан нөхцөлд харгалзалгүй үр дүн нь өөр аяндаа гарч ирсэн мэтээр үзүүлэх арга. Болохуйт чимгийн нэг зүйл. Дандины

Сүрчилгүйеэ амны сайхан үнэр  
Засдаггүй гоо бие  
Шалтгаангүйгээр тэнсэлдэгч дайсан  
Учир шалтгаангүйгээр нөхцөлдөгч тэдгээр

энэ жишээнд сайхан үнэртэй байхын нөхцөл нь сайн үнэртнийг зориуд сацаж сүрчихээс болдог атал тийм бусаар амнаас сайхан үнэр ханхалах бөгөөд үзэсгэлэнтэй байхын нөхцөл шалтгаан нь гар хуруугаар илбэж засаж арчилж чимэг зүүлтээр гоёж үйлддэг учиртай атал бие нь зүйл бүхнээр үзэсгэлэн гоо бөгөөд дайсагнах болохын шалтгаан нь өс хонзонгоор өдөөгддөг атал сар нь бүсгүй лүгээ дайсан бололцсон, бусдад хэрэгтэйг нь өгч тусалснаар нөхөр болдог атал тиймгүйгээр өөр аяндаа нөхрийг олж авдаг энэ мэтээр үзэсгэлэнт хүүхний ийм дөрвөн шинж чанар нь гадаад дотоод ямар ч нөхцөлөөр өдөөгдөлгүй өөрөө аяндаа ийм үр дүн гарч ирж байгааг үзүүлжээ.

Арав. **ХУРААН ӨГҮҮЛЭХ ЧИМЭГ** (ca: samāsokti, тө: bsdus brjod kyi rgyan, хя: 影射修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 10 дахь чимэг. Өгүүлэх үлгэрт буюу магтах зүйлээ хурааж түүнтэй адил үлгэрийг өгүүлэх арга. Өгүүлэхийг хүссэн бодис нэгийг санаж, санагдахуун түүн лүгээ адил бус өөр юм нэгийг адилтган магтаж нэгэн утганд хурааж өгүүлэх аргыг хураан өгүүлэхийн чимэг гэнэ.

Хураах чимгийг дотор нь: ерөнхий хураан өгүүлэх, ялгалын шүтээн<sup>24</sup> өөр тусдаа атлаа ялгалын ном нэгийг ижилсүүлэн хурааж өгүүлэх, ялгалын шүтээн ангид бөгөөд ялгалын ном ангид хийгээд ангид бусыг хураан өгүүлэх, урьд үгүйг хураах - хэмээн дөрөв ангилна.

10.1. **Ерөнхий хураан өгүүлэх** (тө: sbyi'i bsdus brjod). Тухайн нэгэн зүйлийн ерөнхий чанарыг санасны үүднээс түүнтэй адилтгах адилтгал нэгэн бодисын ахуй чанарыг гаргаж өгүүлээд түүнд түшиглэж уг гол зүйлийнхээ бодит ахуй чанарыг мэдүүлэх арга. Хураан өгүүлэх

<sup>24</sup> Ялгалын шүтээн – ялгалын орон, ялгалын суурь

чимгийн нэг зүйл. Дандины

Зөгий ямар мэт хүссэнээрээ  
Дэлгэр лянхуа дахь балыг уумуй  
Сайхан үнэр дэлгэрсэн бус боловч  
Эсхүү эгнэсэн цэцэгт найралдан ахуйг үзэгтүн

энэ жишээнд зөгийс хэр хүссэнээрээ сайтар дэлгэрсэн лянхуагаас бал шимийг хүртдэгээр барахгүй түүгээр үл ханан шим бал нь дэлгэрээгүй боловч дэлбээгээ дөнгөж нээсэн цэцгэн дээр сууж хошуугаа нааж байдгийг үзэгтүн хэмээн хураагч адилтгалыг шуудаар дурдаад тэндээсээ адилтгагдахууны бодисыг хураагаад

Тачаангуйтан идэр хатагтай лугаа  
Баясан наадахуйгаар хүлэгдсэнүүд  
Зарим охидуудад  
Хүсэл нэмэхүйг үзүүлэн үйлдмүй

хэмээх дөрвөн мөрөөр хүсэлт зарим эрс идэр залуу бүсгүй лүгээ шадарлаж баясал цэнгэлийг амссанаар үл ханан идэр залуу нас нь боловсроогүй буюу нас биед хүрээгүй нялх охидыг ч үнсэх тэргүүтнээр хүсэл арвижсан шинж байдал байдгийг үзүүлжээ.

**10.2. Ялгалын шүтээн ангид атлаа ялгалын ном нэгийг ижилсүүлэн хурааж өгүүлэх** (ca: bhinnabhinnaviseshana, тө: khyad gzhi tha dad khyad chos mtshungs pa'i bsdus brjod). Хоёр зүйл бодис өөрсдийн уг чанараар өөр өөр атал тэр хоёрын нийтлэг нэгэн зүйлийг хурааж далдуур үзүүлэх арга. Хураан өгүүлэх чимгийн нэг зүйл. Дандины

Бат үндэст үрсийн үүргээр  
Гуйлгач нугууд насад дэлгэрүүлэн үйлдээд  
Сүүдэр тусагч галбарваасан  
Үүнийг би бээр үнэхээр олов

гэх энэ шүлэгт: голлон өгүүлэхийг зорьсон их хаан хийгээд ижилтгэл үлгэр болсон санааны найлзуур модон буюу галбарваасан мод хоёр нь уг сууриараа ангид тусдаа бөгөөд тэр хоёрын нийтлэг нэгэн онцлогийг илэрхийлсэн үг нь адилтгагдахуун хаан нь бусдын үгээр хувирахгүй бөгөөд санаа зүрх баатарлагийн чанартай буянт сайн санааны үндэс баттай агаад найлзуур модны үндэс нь машид бат суурилан оршдог хоёр зүйлийн нийтлэг онцлогтой учраас “Бат үндэст” хэмээх үгээр хураасан байна. Тэрчлэн хаан нь эд таваар хотол бүрдсэн үрийн

үүргээр гуйланч нарын сэтгэлийг баясгах онцлогтой бол галбарваасан мод буюу найлзуур мод нь амтлаг сайхан жимсний үрийн үүргээр бөхийж ардуудын сэтгэлийг баясгаж байдаг онцлогоор ижил, мөн бас их хаан бээр албат нарыг амьжиргааны зовлонгоос авардаг бөгөөд тус амгалангийн нүнжигтэй сүүдэр төгөлдөр, галбарваасан модноо халуунаар энэлсэн ардуудыг халууны зовлонгоос авардаг сэрүүн нүнжигт сүүдэр болдог байдлаараа ижилсэх ажгуу. Үүнийг би бээр сайтар олов хэмээн санагдахуун хэрэг хааны ялгамжаа болон адилтгал үлгэр санасныг биелүүлэгч галбарваасан мод хоёрын онцлог ижилсэлийг нааш хурааж өгүүлсэн бөгөөд уг суурь болон үлгэр утга хоёрыг ангид харуулсан байна.

**10.3. Ялгалын шүтээн ангид бөгөөд ялгалын ном ангид хийгээд ангид бусыг хураан өгүүлэх.** Санагдахуун адилтгагдахуун болон адилтгалын бодис хоёрын уг суурь ангид тусдаа, тэр хоёрт нийтлэг ижилсэх ялгамжаа болон нийтлэг бус буюу ижилсэхгүй ялгамжаа хоёр зүйл байгааг үгээр илэрхийлээд тэгэхдээ ганцхан адилтгалын суурь болон ялгамж онцлогийг байгаагаар нь ил шууд үгээр гаргаж, гол утгынхаа ялгамжаануудыг хурааж, адилтгалынхаа дотор агуулж өгүүлэхийг хэлж байна. Хураан өгүүлэх чимгийн нэг зүйл. Дандин

Гишүүний чинээн нь өчүүхэн бус бөгөөд  
Цэцэг үрс хотол төгссөн,  
Дээд бат, сэрүүн сүүдэр лүгээ төгссөн  
Энэ модон миний заяагаар олдвой.

Хоёр зүйлд ч зарим төрөлхтөн  
Мөнхүү галбарваасан модоор жишээлэн сайшааж  
Хамгаа номууд урьд нь  
Ерөнхий бөгөөд нөгөө нь хоёр зүйл болой

Эхний шүлэгт хоёуланд нь ижил үе гишүүн байгаагаар харуулсан бол удаах шүлэгт үлгэртийн нэгэнд нь үе гишүүн байхаар нөгөөд нь эс байхаар хоёр зүйл болгон найруулсан байна.

**10.4. Урьд үгүйг хураан өгүүлсэн чимэг** (тө: sngon med bsdus brjod). Энэ нь урьд огт гараагүй үзэгдлийг өгүүлж, хэлэх санаагаа хурааж, өөр зүйл өгүүлж хураасан санаагаа илэрхийлэх найруулгын арга. Хураан өгүүлэх чимгийн нэг зүйл. Дандин:

Лустай нөхөрлөхөөс хагацаад

Өөрийн мөн чанараар амтатын дотор  
Аяа энэ усны сан нь  
Цагийн эрхээр огоотод ширгэх больюу

Шүлгийн үндсэн санаа нь хаан хүн муу явдлыг тэвчиж, дээдсийн ёс журмыг баримтлан явж эцэс хүрэх ёстой гэдэг утгыг өөр маягаар найруулж, лустай эс нөхөрлөн, давсгүй байтлаа гашуун болсон энэ далай цагийн эрхээр хатах болов хэмээн байхгүй, болдоггүй зүйлээр үлгэрлэн өгүүлжээ. Ингэж өөр маягаар хэлсэн учир урьд гараагүйг өгүүлэх арга гэж байна. Энд Лустай эс нөхөрлөсөн, давсгүй далай ширгэнэ гэдэг нь лусгүй далай байхгүй, давсгүй далай байхгүй, бас далай ширгэхгүй – ийм гурван байхгүйг өгүүлж байж далд утгаараа лустай, давстай далай мөнх байна гэсэн утга илэрхийлсэн чамин найруулгын нэг байна (ДЗАТ. 1982. т.86).

*Арван нэг. ТАНСАГ БОЛСОН ЧИМЭГ* (ca: atisayokti, тө: phul byung, хя: 影射修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 11 дэх чимэг. Өгүүлэх утгынхаа онцгой нэгэн эрдмийг гаргаж ирэхдээ ертөнцийн ахуй ёсоос давсан байдлаар хэтэрхий дээд манлай болгож илтгэх ёстой аж. Иймд энэ чимгийг бусад чимгүүдийн дотроос манлай болсон дээд чимэг хэмээн нэрлэнэ. Энэ чимэг нь дотроо: Үлэмж хэтэрхий тансаг болсон, эргэлзэхийн тансаг болсон, магадлахын тансаг болсон, гайхамшигийн тансаг болсон чимэг гэж дөрвөн зүйл байна. Мөн “Хэтэрхий болсон чимэг” гэх мэтээр нэрлэнэ.

11.1. *Үлэмж хэтэрхий тансаг болсон* (тө: khyad ‘phags phul byung). Илэрхийлэн тодруулагч жишээ бодисын чадал эрдмээс илэрхийлэгдэгч гол утгын зүйлийн эрдэм чадал асар хэтэрхий бөгөөд энэ ертөнцийн ахуй журмаас давсан гэж харуулж хэтрүүлсэн дэвэргэсэн үгсээр гайхамшигтай хэтэрхий болохыг үзүүлэх арга. Тансаг болсон чимгийн нэг зүйл. Дандин:

Малигайн эрихсийн чуулгант  
Хамгаа биед түгээмэл зандангаар чийгдсэн  
Цагаан хувцаст урьд явагч  
Сарны гэрлээр зүйрлэхүй бус

Энэ шүлэг нь малигай цэцгийн эрихээр чимсэн, цагаан зандангийн үнэрт усыг сүрчсэн, цагаан өнгөтэй нимгэн цагаан хувцаст энэ

үзэсгэлэнт бүсгүй сарны гэрэлтэй ч зүйрлэхгүй юм гэсэн нь үлэмж хэтэрхий тансаг болсны жишээ байна.

11.2. **Эргэлзэхийн тансаг болсон** (тө: the tshom phul byung). Энэ чимгийг мөн түүдэрхүйн тансаг болсон чимэг ч гэдэг. Ертөнцийн жам ёсонд байх боломжгүй эргэлзэн гайхам зүйлийг хэтэрхийлэх буюу гайхах үгээр илэрхийлэн өгүүлэх арга. Тансаг болсон чимгийн нэг зүйл. Дандины

Баясгалант эх чиний хөх ба  
Сүүжний завсраа бэлхүүсэн нь  
Байна уу, үгүй юу хэмээн түүдэрсэн  
Миний эдүгээ няцах эс болов.

Баясгалант эх буюу үзэсгэлэнт эх чиний хос хөх хийгээд ташаан толгой хүртэлх энэ хооронд бэлхүүс байна уу? үгүй юу хэмээгээд би бээр өнө удаан ажигласаар авч өнөө болтол эргэлзээгээ арилгаж чадаагүй байна хэмээн өгүүлжээ. Энэ нь хүүхний хөх болон ташаа хоёрын хооронд бэлхүүс нуруу байх эсэх тухайд хүний жам ёсоор бол гайхаад байх хэрэггүй боловч гагцхүү энэ үзэсгэлэнт хүүхний бэлхүүс маш нарийн болоод биеийнх нь цээж бэлхүүс асар үзэсгэлэнтэй зохицон нийцэж харагдаж буй тэр чадал эрдэмд эргэлзсэн мэтээр илэрхийлэн гаргасан байна.

11.3. **Магадлахын тансаг болсон** (тө: nge ra phul byung). Сэтгэлийг хоёрдуулаад байсан тухайн зүйлийг батлан шинжлэн нотлох ухаанаар шийдэн буулгаснаар тухайн зүйлийг нэгэн мөр эргэлзээгүйгээр хэтэрхий гайхамшигтай болохыг лавлан шийдсэнийг харуулах арга. Тансаг болсон чимгийн нэг зүйл. Агваанлуvsсанжамцын бичсэн жишээ:

Амраг бүсгүй лүгээ учран цэнгэж, тэврэлдэхийн цагт  
Алинхүү товгор хөх бус эелдэг зөөлөн нэгэн бээр  
Амраг эрийн нуруунаа хүрэлцэж амгаланг өгсөн  
Аяа, тэр нь амраг бүсгүйн бэлхүүс мөн хэмээн магадлалыг олбой  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.447)

Амраг эр бээр өөрийн бүсгүй лүгээ тэврэлдэн наадах цагт товойсон хос мээмнээс ангид нэгэн машинд эелдэг таатай зүйл бээр амраг эрийн биенээ хүрч, амгалан тааламжийг хүртээмжлүүлсэн энэ нь магадтайяа нарийн биет бүсгүй чиний бэлхүүс мөн хэмээн магадлаж мэдвэй гэж өмнөх эргэлзээг таслаад магадтайяа бэлхүүс мөн болохыг учирлан

нотолж өгүүлсэн амуй.

11.4. **Гайхамшигийн тансаг болсон** (тө: ngo mtshar phul byung). Алинхүү өгүүлэгдэж буй тэр зүйл нь энэ ертөнцийн зүйрлэх хэмжилээс хол хэтийдсэн бөгөөд хэтэрхий тансаг болохыг үзүүлэх арга. Тансаг болсон чимгийн нэг зүйл. Дандин:

Орныг тэтгэгч чиний алдаршсан  
Цогцыг хэмжиж чадах бус боловч  
Энэ гурван сансарын дотор  
Багтсан нь аяа асар агуу

Орныг тэтгэгч буюу хаан чиний эрдэм чадлаас үүдэлтэй яруу алдарын цогц нь бусдаар хэмжиж жишихэд бэрх хэмжиж чадахгүй авч харин энэ сансар ертөнцөд багтаж оршдог тань маш хэтэрхий гайхамшиг уужим юм аа хэмээн гайхамшиг тансаг нь хэтэрсэн болохыг үзүүлжээ. Өөрөөр хэлбэл Хааны чиний алдар нэр чинь санааны савнаас хэтэрсэн бөгөөд юунаа багтахуй бэрх, зүйрлэх зүйл олдошгүй агуу их боловч харин хаан чи бээр энэ хүний сансар ертөнцөд багтаж чадсан нь гайхамшиг бөгөөд байж боломгүй гайхамшиг тансаг нь хэтэрсэн нэгэн ажээ гэж өгүүлсэн байна. Алдар нэр чинь сансар ертөнцөөс хэтэрсэн байтал харин энэ сансар ертөнцөд багтаж байгаа нь тансаг хэтэрсэн гэж сайшаан магтжээ. Мөн энэ чимгийн “Алдар хэтэрхий болсон”, “Тансаг хэтэрхий болсон” чимэг гэх мэтээр нэрлэдэг.

**Арван хоёр. МАШИД НЭРИЙДЭГЧ ЧИМЭГ** (са: utpreksa, тө: rab rtog gi rgyan, хя: 浪漫修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 12 дахь чимэг. Үүнийг мөн Сайтар ухах (ДЗАТ. 1982), Машид атгаглагч чимэг ч гэж нэрлэдэг. Энэ нь өгүүлэх санаагаа гаргахдаа үзэгдэл юмсын учир байдлыг гажуудуулан хэлэх арга. Бас машид гүтгүүлэгч чимэг ч гэдэг.

Амьтай буюу амьгүй алив нэгэн зүйлийн байдал ёсыг тэр ёсоор нь үл өгүүлж, өөр нэг зүйл рүү хөтлөн аваачиж гөрдөн гүтгэж гажуудуулан өгүүлэх бөгөөд түүндээ “Сайтар ухахуй” буюу “Машид атгаглах” (Машид хардан сэжиглэж, таамаглан гүтгэх) үгийг оруулж илэрхийлэх аргыг “Машид атгаглагч” буюу “Сайтар ухах” чимэг хэмээжээ. Энэ нь дотроо: Амьтайн маш нэрийдэх, амьгүйн маш нэрийдэх, самадийн маш нэрийдэх - гэсэн 3 зүйл байна.

12.1. **Амьтайн маш нэрийдэх** (тө: sems ldan rab rtog). Амьтай алив нэгэн бодисын үйл ажиллагааны ахуй ёсыг буй тэр янзаар үл өгүүлэн бус нэгэн утга үйлд гүтгэн атгаглаж гулзайлган өгүүлэхийг хэлнэ. Маш нэрийдэгч чимгийн нэг зүйл. Дандин:

Заанууд нь үдийн нарнаар  
 Энэлэн нуурт ормуй,  
 Нарны нөхөр болсон лянхуануудыг  
 Дарахуйяа таалах мөн буюу хэмээн сэтгэмүй.  
 Угаах хийгээд уух ба лянхуан үндсүүдийг  
 Идэхийн тулд заан уснаа орохуй  
 Түүнийг өшөөгөө авахын тулд буюу хэмээн  
 Зохист аялгуучин бээр маш нэрийдэн өгүүлмүй.

Үд дундын халуун цагт их заанууд нарны халуунаар энэлсний шалтгаанаар лянхуат нуурт орох тэр нь заануудад нарыг хорлох боломж олж үл чадсан тул нарны садан болсон лянхуа цэцэгсийг гишгин нүхчиж хөнөөхийг хүссэн хэрэг мөн хэмээн машид атгаглах үгээр зааны сэтгэлийн ахуй ёсыг гүжирдэн гүтгэж өгүүлсэн хэрэг. Зүй нь заан байгалийн жамаар сэрүүцэх гэж усанд орсон атал тэдгээрийг сэрүүцэх гэсэн бус нарнаас өс хонзон авч байгааг сэтгэж бодсон хэмээн гажуудуулан өгүүлсэн хэрэг ажээ. Үүнд анхаарах нь өгүүлэгдэж буй бодисын үйл байдал нь энэхүү чимэг үүсэхийн үндэс болох бөгөөд түүнд түшиглэн түүний ахуй байдлыг өөрөөр дэвэргэн гаргаж өгүүлэхийг “Амьтан буюу сэтгэлтнийг сайтар атгаглах” гэж хэлжээ.

Энд заан халууны энэллийг арилгахын тулд нуурт угаал үйлдэх хийгээд ус уух болон лянхуан үндэсийг иддэг ахуй жам ёсыг энэхүү “Машид атгаглах чимэг”-ийн үндэс хөрөнгө болгож аваад тэрхүү ахуй ёсыг өөр байдлаар тайлан өгүүлсэн нь нарнаас өс авч авах аргыг эрэлхийлсэн болгож өгүүлсэн нь Зохист аялгуучны ур чадвар мөн гэж үзжээ.

12.2. **Амьгүйн маш нэрийдэх** (тө: sems med rab rtog). Сэтгэл оюунгүй буюу амь үгүй алив нэгэн бодисын ахуй ёс түүнийг өөр утганд гулзайлган өгүүлж, хэдийгээр тэрхүү бодист санаа оюун гэж үгүй боловч байгаа мэтээр гүтгэж өгүүлэхийг хэлнэ. Маш нэрийдэгч чимгийн нэг зүйл. Дандины

Энэ хэмээвээс өөрийн хол нугуудыг<sup>25</sup>  
Түрдгэгч гүтгэгч чихний чимэг хэмээх бөлгөө.  
Чиний нүдэн нь чихний  
Удвалуудаас түривлэхүй мэт.  
Нүдний өнцөгийн хор нь унаснаар<sup>26</sup>  
Нүдний гэрлийн удвалд  
Хүрэх буюу бус боловч зохист аялгуучин  
Тэр мэт сайтар нэрийдэж өгүүлмүй.

Нарийн биет буюу бүсгүй бээр өөрийгөө гоо сайхан харагдуулахын тулд чихний омогт хавчуулсан энэхүү удбал цэцэг нь өөрийн уртлаг зууван нүдний эрдэм чадлыг үгүйсгэн түртгэхийн тулд чихэндээ чимэг болгон зүүсэн хэрэг хэмээн үзэсгэлэнт хүүхний нүд бээр чихэн дэх удбал цэцэг рүү буландан харах нь түүн лүгээ тэнсэлдэн өрсөлдөж байгаа хэрэг гэж хэдийгээр нүдний харцаа чихэнд зүүсэн удбал цэцэг тийш хяламхийн харах нь жирийн жам ёсны зүйл бөгөөд түүнээ элдэв санаа сэжиг үгүй боловч, тэрхүү үйлийг шалтгаан болгож, сэтгэл бодолгүй нүдний эрхтэн, удбал цэцэг хоёрын хооронд тэр мэт өрсөлдөөн байгаа мэтээр үзүүлснийг өгүүлж байгаа хэрэг болно.

12.3. **Самадийн маш нэрийдэх** (тө: ting nge ‘dzing rab rtog). Амьгүй зүйлийг амьтай зүйлийн үйлийг үйлдсэн мэтээр гүжирдэж өгүүлэх бөгөөд ингэхдээ “мэт” хэмээх үгийг хэрэглэж санаагаа гаргах арга. Маш нэрийдэгч чимгийн нэг зүйл. Энэ чимгээр Агваанлуvsанжамцын бичсэн жишээ:

Үзэсгэлэнт залуу саран мандан гарахуйг  
Үзэн баясаад бас бас мишээх мэт, гүмүд цэцэг.  
Үнэнхүү төгөлдөр шимүүдийг авах вий хэмээн  
Үймэлзэн дагжиж чичрэх мэт, лянхуа цэцэг.

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.458)

Гүмүда цэцгийн дэлбээ нээгдэх, лянхуа цэцгийн туурцаг салхиар хөдлөх нь машид атгаглахын үндэс болсон бөгөөд амьгүй гүмүд цэцгийн дэлбээ дэлгэрэхийг амьтай хүний уруул мишилзэн нээгдэхтэй зүйрлэж, амьгүй лянхуан туурцаг салхинд ганхах нь амьтай хүмүүн айн дагжиж чичрэх үйлэнд найруулж, гүжирдэн атгаглаж өгүүлжээ. Түүндээ “мэт” гэсэн үгийг хэрэглэсэн байна.

<sup>25</sup> Өврийн хол нугуудыг – өөр зуураа ойр ч зай багтаамж их том гэсэн агуулга. Чихэнд зүүсэн удвал ээмэг нь нүдний зууван уртыг богиносгож дарах гэсэн хэрэг гэж гүтгэж, цаад ухаандаа нүдний зууван сайхан чанар ээмэгний жавхланд дарагдахгүй юм гэж өгүүлж байна.

<sup>26</sup> Нүдний өнцөгийн хор нь унаснаар – хялавхийн харах утга



**Маш нэрийдэхийн гийгүүлэгч аялгуус.** Энэ “Маш нэрийдэхийн гийгүүлэгч аялгуу үгс” нь адилтгалын чимгийн “Адилтган гийгүүлэгч аялгуу үгс”-ээс зарчмын өвөрмөц ялгаатай.

“Мэт” хэмээх үгийг “Адилтгалын чимэг”-т адилтгагдахуун утга, адилтгал үлгэр хоёрыг эрдэм чадал, үйл ажлаар нь ижилтгэн тэгш авч үздэг бол энд тийнхүү харилцан ижилсэхгүйгээр үл барам хаа хамаагүй хоёр өөр зүйлийг нэг дор гүжирдэн оруулж өгүүлдэгээрээ ялгаатай. Тухайлбал:

“Адилтгалын чимэг”-т “Чиний нүүр лянхуа мэт үзэсгэлэнтэй” хэмээн адилтгагдагч утга нь хүүхний нүүр, адилтгал үлгэр лянхуа цэцэг, тэр хоёрын ижилсэх зүйл “үзэсгэлэн” гэсэн гурван үгийн үүднээс харилцан ижилтгэж зүйрлэн найруулдаг бол, энэ “Самадийн маш нэрийдэх чимэг”-т “Харанхуй нь биед сүрчигсэн мэт” хэмээн адилтгал хийгээд адилтгагдахууны тухай ойлголт огт үгүйгээр бодит утгандаа харанхуйг биедээ түрхэнэ гэж үгүй боловч, шөнийн түнэр харанхуйд өөрийн биеэ ч харж чадахгүй болох байдлыг харанхуйг биедээ түрхсэн буюу нөмөрсөн мэт хэмээн зүйрлэн хэлэхээр ижил боловч харилцан бие биеэ илтгэн тодруулах зүйл юу ч үгүй, зөвхөн нэг талыг барьж гаргаснаараа онцлог болно.

*Арван гурав. ШАЛТГААНЫ ЧИМЭГ* (ca: hetu, тө: rgyu'i rgyan, хя: 因由修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 13 дугаар чимэг. Өгүүлэхийг хүссэн юмс үзэгдэлд ямар нэг ялгамжаатай гойд шалтгаан байгааг үзүүлнэ.

Үүсгэгч шалтгааны зарим нэгэн онцлогт түшиглээд үүсгэгдэхүүн үрийн ахуй үе адилгүй зарим нэгэн ил буюу далдуур хэрхэн гарсаныг тодруулан гаргаж ойлгуулах яруу зохист үгийн найруулгыг “Шалтгааны чимэг” хэмээнэ.

Шалтгааныг үзүүлэхэд аль нэг үйлдэгч үйл буюу ажлыг явуулснаар үр гарах ёс бүтдэг нь ямар нэг юм цогцлохын шалтгаан юм. Уулын цаанаас утаа гарахыг хараад тэнд гал байна гэж мэдэхийн утаа нь мэдлийн дотор гал бодогдохын шалтгаан болно (ДЗАТ. 1982. т.90).

Шалтгааны чимэг нь үгсийн чимгүүдийн манлай чимгийн нэг. Шалтгааны чимэг нь дотроо: Үүсгэн гаргагч, бууруулан үйлдэгч, дүр хувилгах, байдлын, олохын, гадаад мэдлийн, дотоод мэдлийн,

урьд байгаагүйг үзүүлэх, эвдэрч өнгөрөн дуусахыг үйлдэх бодгүйн шалтгаан, харилцан бие биед байхгүйг үзүүлэх бодгүйн шалтгаан, тэвчиж үгүйссэн бодгүйн шалтгаан, шалтгаангүйгээс үргүйг үүсгэн үйлдэх бодгүйн шалтгаан, гайхамшигтийн шалтгааны хол үрийн шалтгаан, гайхамшигт шалтгааны шалтгаан үрийг хамтатгах шалтгаан, гайхамшигтын шалтгааны урьд үрийн шалтгаан, гайхамшигтын шалтгааны зохист бусын шалтгаан, гайхамшигтын шалтгааны зохистын шалтгаан – гэх 16 зүйл чимэг болж салбарлана.

13.1. **Үүсгэн гаргагч (дэгжүүлэгч) шалтгааны чимэг** (тө: skyed byed kyi rgyu). Үйлдэгч шалтгааны зүйлээс үр дүнгийн зүйл нь баясгах буюу сэтгэлд таатайг үүсгэх зохист үйл ажлын онц шалтгааныг тодруулан гийгүүлсэн үгсийг хэлнэ. Шалтгааны чимгийн нэг зүйл. Бодхайвын бичсэн жишээ:

Хамаг ардын сэтгэлийг хөдөлгөх чимэг зүүлтийг  
Хамгаас сайтар зүүж, хамгаас таван гишүүн төгссөн  
Ханьцашгүй шинэхэн цэнгэлийн наргианд даллан дуудагч  
Хамаг ардад баясгаланг үүсгэх бүжгийг бүжмүй, тэр.

(Бодхайв, 2000. т.478)

Биеийг гоёмсог болгогч чимгүүдээр сайтар чимсэн бүжигчин бүсгүй нь үйлийн эзэн буюу үйлдэгч шалтгаан, тэрхүү бүжигч хүүхний урлаг төгс бүжиг нь үйл явдал, тэрхүү үйлээс үүсэх үр дүн нь хамаг бүгдэд баярыг төрүүлэх явдал болно.

13.2. **Бууруулан үйлдэгч шалтгаан** (тө: nyams byed kyi rgyu). Үйлдэгч шалтгааны зүйлээс алив нэгэн зүйлийг доройтуулан бууруулах үр дүн гаргах шалтгааны үйл ажиллагааг үзүүлэх чимэг. Шалтгааны чимгийн нэг зүйл. Дандин:

Малаяа бээр усны урсгалд хүрээд  
Занданы ой хөдөлснөөс  
Энэ хий бээр зочидуудыг  
Бууруулан үйлдэхийн тулд чухал оршмуй .  
Тэр мэт болсон хий бээр  
Хагацахуйн зэргээс болсон төрөлхтөн бээр  
Сэтгэлд тааламжит эхэд хурьцахуй  
Дурныг бүтээн үйлдэхүйг чадмуй

Малаяа уулын сугаас урсан буусан голын уснаа хүрэлцсэн бөгөөд

зандан модны шугуйг хөдөлгөн шуугиулснаар анхилуун сайхан үнэртэй хамт ирсэн энэ салхи нь эхнэрээсээ холдоод өнө удсан жуулчин хүмүүст гэргийг нь санах сэтгэлийг үүсгэж, баяр баясгаланг нь бууруулаад маш ихээр шаналгах болсноор тэднийг санахуйн өвчнөөр үхүүлэхийн тулд шадар орших авай хэмээжээ.

Малаяа уулын салхи нь үйлдэгч буюу үүсгэгч шалтгаан, зочид жуулчдын баяр буурах нь үүсгэгдэхүүн үр дүн мөн юм. Тэгэхээр “Шалтгааны чимэг”-ийн эхнийн хоёр энэ чимэгт үүсгэгч зүйл нь салхи бөгөөд тийм нэгэн шалтгаанаас үр дүн нь хоёр өөр гарч байгааг харуулжээ. Халуунд бүгчимдсэн ардад сэрүүнийг өгөхөөс гадна зандан модны таатай үнэрээр цэнгүүлж баяр баясгаланг өгөх таатай зохистой үр дүнт нэгэн зүйл байх бол, мөн энхрий янаг амрагаас салаад өнө холд жуулчлан явагч нарт энэхүү зандангийн сэрүүн салхи нь баяр төрүүлэхээс гуниг төрүүлэх нь илүү болж буй тул баярыг бууруулж, гунигийг нэмэгдүүлсэн таатай бус, зохимжгүй үр дүнг гаргажээ.

13.3. **Дүр хувилгах байдлын шалтгаан** (ca: vikārya hetu tō: rnam gyur gyi rgyu). Сэтгэлд таатай шалтгаанаас тааламжгүй буюу зохимжгүй үр дүн гаргаж ирэхийг хэлэх бөгөөд уг шалтгаан нь үр дүнтэйгээ харшилж, хувирсаныг үзүүлж буй тухай өгүүлэх арга. Шалтгааны чимгийн нэг зүйл. Дандины

Сая ургасан навчин ой цэцэрлэг хийгээд  
Шавраас ургасан маш дэлгэрсэн бүрдэт  
Дэлгэр сарыг хүссэнээр  
Зочдыг үзэхийн хор болон үйлдмүй .

энэ шүлэгт шинэхэн навч ногоо бүхүй ой цэцэрлэг, машид дэлгэрсэн лянхуа бүхүй нуур цөөрөм, тэргэл дүүрэн сарны мандал гэсэн сэтгэлд таатай энэ гурван зүйл болбоос хувирагдахуун болно. Хэрхэн хувирсан буюу хувирч таагүйн шалтгаан болсон гэвэл энэ гурван зүйлийг үзсэнээс шалтгаалж өөрийн бүсгүйгээс хагацан салсан амрагууд тэдгээр хайрт бүсгүйгээ хүсэмжлэн үгүйлэх сэтгэл нь улам нэмэгдэж байх бөгөөд түүгээр барахгүй түүнээс болж дээрх гурван зүйлийн тааламж өгдөг зүйлс маань хүсэшгүй хор мэт санагдах сэтгэлийг төрүүлэх үр дүнг авчирчээ. Хувирагдахуун уг чанараараа сэтгэлд таатай зүйл нь хувиргагч хүслийн сэтгэлийн энэлэл шаналалыг авч ирснээр үр дүн нь таагүй хүсэшгүй болж хувирахыг хэлж байна.

13.4. **Олохын шалтгаан** (ca: kriyâ peksa-hetu, тө: thob bya'i rgyu). Олохын шалтгаан гэгдэх түүний арга билгийн үйл ажил элдэв зүйлд шүтээд өөрийн зорьж буй үр дүнг эцэст нь олж болохыг далдуур үзүүлсэн үгсийг хэлнэ. Шалтгааны чимгийн нэг зүйл. Дандин:

Дээрэнгүйг дадан үйлдэх хэмээх нүгүүдийг  
Амрагийн орноо байгуулахуйд  
Охин хөмсгөө мөхрүүлэн нүдээ сэлмүүнээр ширтэн  
Уруулаа хөдөлгөн үзэн үйлдмүй .

Нэгэн идэр залуу эр, нэгэн үзэсгэлэнт бүсгүйг үүрдийн хань болгоё гэж санаснаас түүн лүгээ хамт сууж баясгалантай тааламжтай үгсийг ярилцан суухуй цагт тэр үзэсгэлэнт бүсгүйн найз арга бачтай нэгэн хүүхэн бээр тэр үзэсгэлэнт хүүхэн, залуу хоёрыг уулзан учирч буйд атаархаж уурлаж, гэвч түүнийгээ дотроо нуугаад тэр хоёр дээр ирж, өөрийгөө хүүхний найз хэмээн танилцуулаад, зүрхний үгийг ярих тэргүүтнээр мөнөөх залуугийн сэтгэлийг татсанд, залуу бээр “Бид нартай хамт энд суугтун” гэж хэлсэнд нөгөө үзэсгэлэнт бүсгүйн уур атаа төрж хөмсгөө атируулан, найз хүүхнээ ширвэн харж, муушаах үгийг өгүүлж, уруулаа хөдөлгөн, уурлахын байдал төрхийг үзүүлэхийг нөгөө залуу үзээд “Энэ хүүхэнд надтай ханьсах санаа буй аж. Тиймээс миний санасан бүтэх нь ээ” хэмээн санасан хэрэг нь бүтэх боломжтой байгааг мэджээ.

Энд залуу эр тэрхүү аальгүй хүүхнийг ирэхээс өмнө өөрийн дурласан бүсгүй нь түүнд талтай эсэхийг мэдэж чадахгүй байсан. Гэтэл тэр найз хүүхэн нь ирээд мань залууд олон зүйлийн найртай үгийг хэлээд эхлэхээр залуугийн дурласан хүүхэн уурлаж найз хүүхнээ загнасан. Ийнхүү үзэсгэлэнт хүүхэн тэрбээр найз хүүхнээ загнаж байгаа нь “Олохын шалтгаан” гэгч болох бөгөөд тэр шалтгаан буюу уурлахыг үзсэн залуугийн сэтгэлд “Энэ ингэж найз хүүхнээсээ намайг харамлаж байхыг үзвээс надад сайн юм байна. Тиймээс миний энэ хүүхэнтэй ханилах хүсэл биелэх юм байна” гэсэн хүссэн үр дүнгээ олж авах боломжтой болж буйг далдуур харуулжээ.

13.5. **Гадаад мэдлийн шалтгаан** (тө: phyi shes byed kyi rgyu). Гадаад мэдлийн шалтгаан нь гадаад дүрс бөгөөд дөрвөн улирал тэргүүтэн гадаад дүрс өнгө болох ахуй үесийг илтгэсэн шалтгаануудыг өгүүлсэнд шүтээд мэдэгдэхүүн цаг мөч тэргүүтний ахуй байдлыг ойлгуулж чадах сэтгэлд таатайн дүр төгөлдөр үгсийн найрлага. Шалтгааны чимгийн

нэг зүйл. Энэ чимгээр Агваанлуvsсанжамцын бичсэн жишээ:

Ургамал найлзуур модны навч мөчир  
алтан өнгийг барьсан бөгөөд  
Угтай боловсорсон охь жимс нь үүрэг хүндээр бөхийсөн  
Усны тэнгэрийн охины мандал илт тодорхой гийсэн  
Урсан үргэлжлэх голын ус нь эрүүл энхийн рашаан болмуй  
(Сэцан Лувсанбалдан, 1996. т.477)

Модны навч шар өнгөтэй болох, үр жимс нь сайтар боловсрох үе буюу монголын наймдугаар сар болох намрын дунд сард Рихи гэдэг од ургасан сарны гэрэл голын уснаа туссанаар усны хор арилаад голын ус рашаан болж хувирдаг гэсэн түүх яриатай холбож шүлэглэжээ.

13.6. **Дотоод мэдлийн шалтгаан** (тө: nang shes byed kyi rgyu). Дотоод дүрс буюу шүтээний биеийн эрхтэнээр ахуй байдал алиныг илтгэснийг ажиглаж шинжлээд таамаглан мэдэх шалтгааныг өгүүлснээр түүндээ дулдуйдаж дотоод санаа бодлын байдлыг илрүүлэн мэдүүлэх учиртай учир шалтгааны найруулга. Шалтгааны чимгийн нэг зүйл. Дандины

Нөхөр чинь сэтгэл хүслээр нэрвэгдсэнийг  
Сарны гэрлээр няцуулах бус бөгөөд  
Занданы усаар үл тэсдэхүйг  
Биеийн илч хэмээн хялбар ухмуй

Хүрэлцэхүүн машид сэрүүн сарны гэрлээр ч мөн зандангийн маш сэрүүн усаар ч арилгаж үл чадах амраг нөхөр чиний илч бадарсан биеэр энэлийг барьсан энэ нь биеийн эрхтний ахуй байдлыг илтгэсэн энэ нь “Дотоод мэдлийн шалтгаан” болох бөгөөд тэр шалтгаанд дулдуйдаад биеийн ахуй байдал түүнийг ажиглан шинжилж бодвоос үр дүнд нь өөрийн амраг зүрхний хайрт янаг түүнийгээ хүсэн мөрөөдсөн дотоод сэтгэлийн байдлыг үзүүлж буй юм.

13.7. **Урьд байгаагүйг үзүүлэх шалтгаан** (тө: ngon med pa'i byed kyi rgyu). Энэ нь зориуд хийсэн юм байхгүй байхад нь муу үр аяндаа гарчихсныг харуулах чимэг. Өөрөөр хэлбэл, үйлдэх ёстой зүйлийг өмнө нь эс үйлдсэн буюу урьд байгаагүй шалтгаан түүнээс үр өөр нэгэн зүйл үүсэхийг өгүүлнэ. Шалтгааны чимгийн нэг зүйл. Дандины:

Ухаануудыг эс дадуулсан ба  
Оюутнууд лугаа эс нөхцсөн ба

Эрхтнүүдийг эс боосноор  
Хүмүүс маш зовох больюу.

Ухааны орнуудыг эс сурсанаар түүнээ дадлага үгүй бөгөөд ухаантан мэргэд лүгээ эс нөхөрлөснөөр тэдгээрээс сайн номлолыг сонсоогүй агаад бие, хэл, сэтгэл гэсэн гурван үүд хаалгаа бөхлөөгүй учраас үйл явдал, санаа бодол, үг хэл алмай болж алгасарахуйгаар цагийг нөгчөөсөн тэргүүтнээр мэргэн болох үйлийг өмнө эс үйлдсэн тэр нь өмнө буюу урьд байгаагүй шалтгаан хэмээгдэнэ. Тийм шалтгаанаас үр дүн нь юу ирэх вэ гэвэл: эрдэм сураагүйдээ гэмших энэлэл сэтгэл төрөх болохыг өгүүлсэн ажээ. Ер нь урьд өмнө нь байгаагүй шалтгаанаас үр дүн юу ч ирэхгүй боловч энэ чимгийн хувьд урьд байгаагүй гэдэг нь үгүйсгэх үг төдий бөгөөд судар номын дотор байдаг “Тосыг хүсээд усыг бүлэх” гэдэгтэй дүйцэх зүйл юм. Өөрөөр хэлбэл эрдэм номд мэргэжих үйлийг урьд хийгээгүй хүнээс хожим гэмшил гомдол ирэхээс бус эрдмийн алдар ирэхгүй юм.

13.8. **Эвдэрч өнгөрөн дуусахыг үйлдэх бодгүйн шалтгаан** (тө: zhig nas med pa'i byed rgyu). Өмнө нь өөрт байсан нэгэн зүйлийг доройтуулсан буюу эвдэлснээс үгүй болсон нэгэн шалтгаан нь өөр нэгэн зүйлийг үүсгэх учиртай болсныг өгүүлсэн өгүүлэмжийг хэлнэ. Шалтгааны чимгийн нэг зүйл. Сэцан Лувсанбалданы бичсэн жишээ:

Элэнц хуланцын хадгалж хураасан эд хөрөнгө аажмаар барагдав  
Эцэг эхийн өршөөж хайрласан эд малыг ч ашиггүй үрэв  
Энэ биеэр зүдэрч олсон идээ эдлэл ч бүрэн дуусав  
Эдүгээ одоо үгүйрэл хоосролын зовлонт болов

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.486)

Үүнийг хоосон ядуу нэгэн хүмүүний өгүүлэх байдлаар найруулан гаргасан бөгөөд тэрбээр эрт цагийн элэнц хуланц, өвөг эмгийн үеийн хурааж хуримтлуулсан болон эцэг эхийнх нь өөрт тасалж өгсөн мал ахуй, хөрөнгө зоорийг ч хэрэггүй үрж дуусгасан байна. Өөрийн энэ биеэр зүтгэж олсон хөрөнгө нь ч барагдсан эдгээр нь “Эвдэрч өнгөрөн дуусахыг үйлдэх бодгүйн шалтгаан” болох бөгөөд тэрхүү одоо буй бус болсон зүйлсийн шалтгаанаар үр дүн нь юу болсон хэмээвээс өлсгөлөн ядуу байдалд орсон байна хэмээжээ.

13.9. **Харилцан бие биед байхгүйг үзүүлэх бодгүйн шалтгаан** (са: etaretarbahāva, тө: phan tshun med pa'i byed rgyu). Хоёр өөр зүйлийн юмс нэг нэгэндээ байхгүйг илтгэж, тэр шалтгаанаар өөр нэгэн үр дүнг

гаргаж байгааг үзүүлсэн өгүүлэмжийг хэлнэ. Шалтгааны чимгийн нэг зүйл. Агваанлуvsанжамцын бичсэн жишээ:

Гэрэлт саран энэ нь нарийн биетийн нүүр бус  
Гөрөөсийн тэмдэгт нь хээмсэг бүсгүйн нүд бус  
Жихүүн сэрүүн туяа энэ нь хөлсний дусал бус  
Зүй тиймийн тулд аглагч нар нь сэтгэл баясгалантай

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.487)

Сарны үзэсгэлэн энэ нь үзэсгэлэнт бүсгүйн нүүр бус бөгөөд гөрөөсийн дүрсийн тэмдэг энэ нь үзэсгэлэнт хүүхний нүүрэн дэх нүд бус, сарны сэрүүн гэрэл туяа энэ нь хүсэл цэнгэлийн хөлсний дусал бус ажгуу. Тиймийн тулд бүсгүй хүмүүнд татагдах сэтгэлийг няцуулсан аглагч гарч даяан хийгч эд нар бээр сарыг үзсэнээр сэтгэл маш ихээр баясана хэмээжээ.

13.10. **Тэвчиж үгүйссэн бодгүйн шалтгаан** (ca: atyantābhāba, тө: spang nas med pa'i byed rgyu). Алимад нэгэн зүйлийг ашидаас үгүйсгэн тэвчсэн буюу байхгүйн шалтгаанаар үр дүндээ харин ч хотол сайн нэгэн зүйлийг бий болгох тухай өгүүлсэн өгүүлэмжийг хэлнэ. Шалтгааны чимгийн нэг зүйл. Агваанлуvsанжамцын жишээ:

Сэрэмжгүй залихай явдлын намтар цадиг хийгээд  
Сэргэмжгүй мунхгийн муу авирыг өнөд тэвчсэнээр  
Сэтгэлд эрдмийг өгөгч Сарасватид даган баригдсанаар  
Сэрж бүтээх, номлож, туурвихын самбааг олбой

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.489)

Сэрэмжгүй явдал хийгээд хамаг мунхарсан авир ёс даяарыг өнөд үүрд тэвчсэн буюу үгүй болгосон тэр шалтгаанаар үр дүнд нь Эгшигт охин тэнгэр Сарасватигаар даган баригдаад өөрт номлох, тэмцэх, туурвихын самбааг амар хялбараар олж авна гэсэн утгыг өгүүлсэн ажээ.

13.11. **Шалтгаангүйгээс үргүйг үүсгэн үйлдэх бодгүйн шалтгаан** (ca: abhāvabhāva, тө: rgyu med pa las 'bras bu med pa). Үгүйсгэсэн үгийг хоёр хэрэглэж утгаараа бодгүйн шалтгаан түүгээр үр дүн нь ч бодгүй нэгэн зүйлийг үүсгэхийг үзүүлсэн өгүүлэмжийг хэлнэ. Шалтгааны чимгийн нэг зүйл. Дандины

Үүсгэмэл цэцэрлэгийн Амарын модонд  
Хонгорцог эс ургасан бус болбоос

Зочдуудын хатагтай нь

Хүнцэд лүгээ сэлт алгаар ус өгөн үйлдэх больюу.

таримал цэцэрлэгт ургасан Сахагара буюу Амарын мод гэж алдаршсан модонд хонхорцог эс ургах нь бус хэмээн үгүйсгэх (эс, бус) үгийг давхарлан хэрэглээд эн тэргүүнээ хонхорцог эс ургасан байна хэмээснээр хонхорцог эс ургасныг үзүүлсэн хийгээд түүний дараа бус болбоос хэмээн дахин үгүйсгэх үг оруулснаар утгандаа “Хонхорцог ургасан” гэсэн утгыг илэрхийлэн гаргаж “Болбоос” хэмээх үгийг хэрэглэснээр хэрэвзээ Амар жимсний модонд хонхорцог ургасан болбоос эр нөхөр нь хол газар жуулчлан одсоны гэрт үлдсэн эхнэр бээр өөрийн нөхрөөс хагацсан энэллээр тэрхүү хонхоруусыг үзсэнээс шалтгаалж үхэх шахах болох бөгөөд нөхрөө санаж хүсэх сэтгэлээр муужиран унах буюу үхэх болох болбол хүнцэд бүхүй алга дүүрэн усыг өгөх болмуй хэмээсэн бөлгөө. Тэр нь ч яг тухайн үед үхэх эс болсон ч ирээдүйд үхнэ гэсэн үг учраас бодгүй үр дүнг үзүүлсэн хэрэг юм.

13.12. **Гайхамшигтийн шалтгааны хол үрийн шалтгаан** (ca: dūrakārya, тө: ring ‘bras). Тухайлсан тэрхүү зүйлээс өнө холд оршсон бодит шалтгаанаар өнө холын бодит үрийг үүсгэхийг үзүүлсэн гайхамшигт үгс нэгнийг хэлнэ. Шалтгааны чимгийн нэг зүйл. Дандины:

Биет чиний нүдний өнцөг хэмээгч

Ялаад үйлдэгч биегүй нүгүүдийн мэс буюу

Аль түүнийг бусдад сайтар туссан

Түүгээр миний сэтгэл ч дарагдав.

Биетэн чиний нүдний өнцөг хэмээгдэх амьтан бүхнээс ялгуун үйлдэгч энэ нь биегүйн мэсэн нэгэн бөгөөд тэр мэтийн хүслийн мэс үүнийг холын шалтгаан гэсэн байна. Бас чиний нүдний өнцөг мэс үүгээр чиглүүлсэн алин байнд тусваас тэдгээрийг нэвтрэн гарахаар барахгүй “миний” хэмээснээр тухайлан зорьсон орон бусын өнө холд оршсон “миний сэтгэл ч дарагдав” хэмээсэн нь үр дүн мөн. Өөрөөр хэлбэл ойрын шууд үр дүнгээр холын бусад үр дүнг ч гаргаж буй юм.

13.13. **Гайхамшигт шалтгааны шалтгаан үрийг хамтатгах шалтгаан** (ca: sahaḥa, тө: lhan gcig skyes). Үүсгэгч шалтгаан хийгээд үүсгэгдэгч үр дүн хоёрыг цаг өмнө хойдын зэрэг дараалал үгүйгээр хамтдаа гарахыг үзүүлсэн тансаг болсон өгүүлэмж. Шалтгааны чимгийн нэг зүйл. Агваанлуvsанжамцын жишээ шүлэгт:



Тоос манангаас ангижирсан намрын огторгуйд  
Тов тодоор гэрэлт наран мандан ургах лугаа  
Түүн лүгээ хамтад цагаан лянхуа цэцэгсийн  
Төгс дэлбээний чуулгас дэлгэрэн мишээх болмуй

(Сэцан Лувсанбалдан, 1996. т.498)

Агаарт дэгдэх тоос тортог, манан арилсан намар цагийн хиргүй цэлмэг огторгуйд нарны мандал урган гарах нь шалтгаан, тэрхүү шалтгаан лугаа хамт нэгэн зэрэг түүний үр дүн болох цагаан лянхуа цэцгийн навч дэлбээ дэлгэрэх бөгөөд энэ хоёр зүйл нь өмнө хойно бусаар нэгэн зэрэг болдог учир шалтгаан хийгээд үр хоёр нь зэрэг үүсдэг хэмээжээ.

13.14. **Гайхамшигтын шалтгааны урьд үрийн шалтгаан** (ca: kāryānannareja, тө: ‘bras ma thag skye). Үрийн дараа шалтгаан нь бүтэн гэж үгүй боловч Зохист аялгууч нар өгүүлэх хүслийн эрхээр үр нь урьдаар бүтэж дууссаны дараа түүний уг шалтгааныг сууриас үүсэж бий болж буйг үзүүлсэн үгийг гайхамшиг болгож өгүүлсэн өгүүлэмж. Шалтгааны чимгийн нэг зүйл. Дандины

Гөрөөсөн нүдтийн тогтоосон  
Далай дэлгэрэхүй болмогц  
Маш цацарсан гэрэлт  
Сарны мандал ургав

энэ жишээнд: гөрөөсөн нүдэт гоо эхнэрийн хүслийг далайн дүрсээр дүрсэлж, дэлгэрсэн үрий нь урьд нь өгүүлсний дараа сарны мандлыг дараа нь ургуулж үр дүн нь урьд нь гарсан байх шалтгааныг энд харуулсан байна./ДЗАТ. 1982. т.96/

13.15. **Гайхамшигтын шалтгааны зохист бусын шалтгаан** (ca: ayuk-takārya, тө: rigs min). Нийцтэй шалтгаанаас эсрэгээр нийцгүй зохисгүй үр дүн үүсэхийг үзүүлсэн гайхамшигийн үгийг өгүүлж санаагаа гаргах арга. Шалтгааны чимгийн нэг зүйл. Дандин:

Гагцхүү тэнгэр чиний хоёр өлмийн  
Залуу улаан наран хүрснээр  
Хаануудын гарын лянхуа  
Хумбин үйлдэх юун.

Үүнд: нар гармагц бадам навчаа дэлгэдэг ёсыг урвуу байдлаар өгүүлж, зохисгүй шалтгаант чанарыг үзүүлсэн байна. Энэ бол тэнгэр

нь хөлийн нарыг гаргахад хааны лянхуа дэлгэрэх ёстой атал харин хумичихсан гэж өгүүлээд зохистой шалтгаанаас зохисгүй үр гаргаж байна. Тэнгэрийн өлмийн наран ургах гэдэг нь шалтгаан, хаан гарын бадам хумина гэдэг нь үр болно гэжээ (ДЗАТ.1982. т.96)

13.16. **Гайхамшигтын шалтгааны зохистын шалтгаан** (са: yuk-takārgya, тө: rigs pa byed). Нийцтэй шалтгаанаас үр нийцтэй буюу зохистой зүйл үүсэж буйг үзүүлсэн гайхамшиг тансагийн өгүүлэмжийг хэлнэ. Шалтгааны чимгийн нэг зүйл. Дандин:

Чиний өлмийн хумсны хиргүй  
Гүмда мэт сарны гэрлүүдээр  
Орныг тэтгэгчүүдийн гарын  
Лянхуаг хумбиулан үйлдэхүйд эрхт болой.

Хаан чиний машид үзэсгэлэнтэй өлмийн хумс нь сарны гэрэл машид цагаан гүмда цэцгийн хиргүй өнгийг цацраах мэтийн дүрсэд оруулсан нь шалтгаан бөгөөд үр нь бага хаадууд бээр гараа хавсрахыг хумисан лянхуаны дүрсэд оруулсан нь шалтгаанаас зохистой үр дүн гарч байгааг харуулсан өгүүлэмж болжээ.

*Арван дөрөв. НАРИЙНЫ ЧИМЭГ*<sup>27</sup> (са: ingita, тө: phra mo'i rgyan, хя: 隱微修飾). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 14 дэх чимэг. Энэ чимгийн санскрит үгийн утга нь дохио гэсэн утгатай ажээ. Энэ чимэг нь өгүүлэх зүйлээ ил хэлэлгүй биеийн намжир намба, дуу дохио зэрэг төрөл бүрийн арга байдлаар илтгэж утгаа гаргадаг арга.

Энэ нь биеийн намжир намба байдал тэргүүтэн дохионы дүр урвахуй нарийнаар бусдад утгыг мэдүүлнэ. Нарийн чимэгт: завсар найруулах, бэлгэ чанар гаргах, үлгэр өгүүлэх гэсэн гурван зүйл байна. Нарийны чимэг нь дотроо: Өнцгийн нарийн, дүрийн нарийн гэсэн хоёр зүйлтэй.

14.1. **Өнцгийн нарийны чимэг** (са: akāra, тө: zur phra). Энэ нь ямар нэг далд битүү дохиогоор санаагаа ойлгуулах арга. Нарийны чимгийн нэг зүйл. Дандин:

Хэзээ нэгэн бид ханилах болму хэмээн  
Чуулснаа өгүүлэн эс чадсан

Амрагийг ухаж хатагтай бээр

<sup>27</sup> Утгын чимэг - “Дандины Зохист аялгууны толийн гол нэр утгын тайлбар”. Хамтын бүтээл. 2017. т.182-240)-ийн Нарийны чимгээс Таалалтын чимгийг Д.Сумъяа хийсэн. Үүнээс товчлон авав.

Наадан баясахын лянхуаг хумбин үйлдмүй.

Нэгэн эрэгтэй нэг эмэгтэйд сэтгэл татагдаж олны дунд хэзээ нэг учрахаа олны дунд хэлж чадахгүй буйг ухаалаг гоо эмэгтэй мэдээд чихнийхээ бадам чимгийг хуруугаараа имрэн хумьж, шөнө бадам хумихлаар уулзъя гэсэн битүү дохио өгч, санаагаа ойлгуулсан нь нарийны утга болж байна (ДЗАТ. 1982. т.96).

14.2. **Дүрийн нарийны чимэг** (тө: nam pa'i phra mo). Энэ нь санаа зорилгоо ил тод шууд илтгээгүй боловч уг санаагаа нүүр нүд үс зүс зэрэг гадаад дүр төрхийн аль нэг гишүүн хэсгийн байдлаар илтгэх арга. Нарийны чимгийн нэг зүйл. Дүрийн нарийны чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ

Их эзэн(Чингис) өөрийн орноо тэтгэсээр  
амгалангийн цогоор илт өндөрт гарсан ч  
(Эцэст) уйтгарын дүр байдалд (бүрнээ эзлэгдээд)  
Эргэцэн хурах шадар нөхөд сэлтдээ  
Төвдийн шашны түүхийг өгүүлсэнд  
Их хөмсөгт эх(хатан) нь найгалзан баясаад,  
шүдний эрихсээ яралзуулан үзүүлэв  
(С.Жамъянгарав, 2011. т.94)

Энэ шүлэгт дүрийн нарийны чимгээр үзүүлэхдээ: Чингис хаан бээр өөрийн орноо тэтгэсэн тэр нь амгалангийн цогийг олсон байна. Гэвч тэр эцэст уйтгарын дүр байдалд эзлэгдсэн гэдэг нь төрийн ёсыг тэтгэсэн боловч одоо номын ёсон үгүйлэгдсэн дүрийн байдлыг үзүүлжээ. Ингээд Төвдөд шашин ном дэлгэрсэн түүхийг сонсоод хатны хамт баясал төрж сүслэн биширсэн байдлыг үзүүлэхдээ хатны найгалзан баясах байдал, ихэд тааламжит инээмсэглэхэд шүдний эрихс нь яралзан буй тэргүүтнээр дүрийн нарийныг үзүүлжээ.

*Арван тав. ХУВЬСЫН ЧИМЭГ* (са: lava, тө: cha, хя: 遁词修饰).  
Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 15 дахь чимэг. Энэ нь ямар нэг юмны хувь хэсэг эсвэл үйл явдлын зарим хувийг өгүүлж, бодит шинжий нь халхалж үлгэрлэх аргаар санаагаа гаргах арга.

Хувьсын чимэг нь магтах мэтээр өгүүлж доромжлох ба доромжлох мэтээр өгүүлж магтах хувь хоёуланг өгүүлнэ. Энэ чимэг нь дотроо: Нуухад зохистойн хувьсийн чимэг, нуухад зохисгүй хувьсийн чимэг,

муушаан магтах хувьсийн чимэг, магтан өгүүлэх хувьсийн чимэг - гэх 4 зүйл байна.

15.1. **Зохистойн хувьсийн чимэг** (тө: 'os pa'i cha). Энэ нь нуухад зохистой нуугдахууныг нуух үйл явц. Жинхэнэ үнэнг зөв нуух ёстой нөхцөл цаг үед нь нууж өөр үг өгүүлэх буюу өөр үйлдэл үзүүлэх арга. Хувьсийн чимгийн нэг зүйл. Дандин:

Хааны охинд тачаагч нар  
Үсээн өрвийлгөснийг сахиулчин  
Мэдэх болуузай гэж  
Аяа гайхамшигт сэрүүн салхитай юм гэнэ

Энэ нь зохистойн хувьсийг үзүүлэх чимэг болж байна. Учир нь цэцэрлэгт яваа хааны охиныг хараад хүсэл нь бадарсан эрийн үс нь өрвийж босч ирэхэд боссон шар үсээ сахиулчнаас нуухдаа сайхан салхи хөдөлж үс босов гэж хэлэх нь жинхэнэ үнэнээ нууж салхинаас болж үс өрвийв гэж өөр үг хэлсэн нь нуухад зохистойн хувьсийн чимэг болж байна.

15.2. **Зохисгүйн хувьсын чимэг** (тө: mi 'os pa'i cha). Энэ нь алив нэг зүйлээс болж зохисгүй үйл гарахыг нууж өгүүлнэ. Хувьсийн чимгийн нэг зүйл. Нуухад зохисгүйн хувьсыг үзүүлэх чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ

(Эрт) Годан хаан Сажа бандидыг урин залаар  
Элч болгож дүүгээ Төвдөд илгээтэл  
(Элмэг) дүү нь чадалтайрхан Төвдөд цэргийг илгээгээд  
(Ирэхэд нь харин) өөрийн биенд өвчин чилүүр болсны  
ёсыг үзүүлэв  
(С.Жамъянгарав, 2011. т.95)

Хөх нуурын хавийг захиран сууж байсан Өгөөдэй хааны хоёр дахь хүү Годан ноён бээр Сажа бандидыг залахаар дүүгээ элч болгожээ. Тэгэхэд төр ёсны ухаанд алгуу тэрбээр омгорхож Төвдөд цэрэглэсэн түүх байдаг. Энэ нь амгалан сайхан үйлсийн эхлэлийн элч болох атал харин дайсагнасан муу энэ нь зохисгүйн хувьсын жишээ болж байна.

15.3. **Муушаан магтах хувьсийн чимэг** (ca: ninda - leśa, тө: zol gyis dmad pa'i cha). Энэ нь муушаан магтах байдлаар үнэнийг гаргах арга. Өөрөөр хэлбэл, зарим яруу найрагч магтах мэт болж муушаах эсвэл муушаах мэт болж магтах явдлыг хувь хэмээн нэрлэжээ (ДЗАТ. 1982.

т.97). Хувьсийн чимгийн нэг зүйл. Муушаан магтах хувьсыг үзүүлэхийн чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

(Онц) ялгуусны хөвгүүн Годан (Годан)  
баатарлах байлдаанд баясан хөхөөд  
(Огоот) баяжихын арга хийгээд  
цог учралын хотол чуулганыг таалан эгээрээд  
Олон баатрыг өмнөө жагсааж  
чадал хүчнээр тэнцэлдэх мэт (болоод)  
Онох мэс, өмсөх хуяг элдэв зүйлийг бэлдсэн  
түүнээ биширвээс зохистой  
(С.Жамъянгарав, 2011. т.95)

Энэ жишээ шүлэгт Чингис хааны ач хүү Годан нь байлдаанд баясан хөөрөөд баяжих тэргүүтэн олз олборыг таалаад, ихэрхэн омог байдал үзүүлж олон цэрэг эрсийг жагсаагаад өмнө нь чадал сүр хүчийг үзүүлэн баатарлах байдал төгөлдөр жавхалзаж зэр зэвсэг хуяг дуулга өмссөн байдлыг их л хөөргөн хөвсөргөн чанартаар муушаах мэт өгүүлэвч цаад утгандаа Их гүрний их хааны сүр хүчин үнэхээр ийм л болой биширвээс зохистой хэмээн магтжээ.

15.4. **Магтан өгүүлэх хувьсийн чимэг** (ca: stuti, тө: zol gyis bstod ra'i cha). Зохистой хувиас зохистой үр гарсныг зохистойд нь магтан өгүүлэх арга. Хувьсийн чимгийн нэг зүйл. Магтан өгүүлэх хувьсыг үзүүлэхийн чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ

Өөрийн орноос(гарч) Хятад, Төвдийн завсар (газар) одоод  
(Өнө эртийн) Ланжүсийн хотод бэрх хэцүүг ихээр бүтээсэн  
(Үнэн) язгуур нь нэгэн хүмүүн Сажа бандидад мөргөөд  
Үйл үйлдвэрийн нь араас даган орсон нь Годан хаан буюу юун.  
(С.Жамъянгарав, 2011. т.96)

Чингис хааны ач Годан хаан (1237-1251) Төвдийн Сажа хийдийн тэргүүн сажа бандид Гунгаажалцанг урьж түүнийг Хятад, Төвд, Монгол гурван улсын заагт орших Ланжу хотод залсан тухай түүхээс сэдэвлэн бичсэн шүлэг байна. Энэ нь Монгол оронд бурханы шашны хоёрдахь дэлгэрэлтийн үе төдийгүй Монголын их хаадын орд өргөө хүрээнд Сажагийн ёсны номын ёсон дэлгэрч, энэхүү ёсыг Годан хаан тэргүүтэн бээр даган барьсан нь магтан өгүүлэх хувьсын жишээ болжээ.

Арван зургаа. **ЗЭРЭГЧЛЭНГИЙН ЧИМЭГ** (ca: yathasamkhyam, тө:

rim pa rgyan, хя: 次第修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 16 дахь чимэг. Зэрэг дарааллын чимэг ч гэдэг. Энэ чимэг нэг зүйл байна. Энэ нь аль нэг бодыг өмнө нь өгүүлж түүнтэй жишигдэх зүйлийг хойноос нь дараалан өгүүлэх арга. Агваантүвдэнгийн энэ чимгээр бичсэн шүлэг:

Оюуны хөхийн зохионгуйт Ялж төгс нөгчсөн Эх ба  
Одсэржанма хийгээд Ралжигмаан бие нь  
Онц маргад эрдэнэ ба алт хийгээд бэндэръяа  
Огоотыг хураах модны үзэсгэлэнг ялан үйлдмүй  
(Сайн үгсийн сан. 1995. т.362)

гэж Дараэх хийгээд нөхөрсэлт гурав хэмээн алдаршсан Жомдан даймаа, Одсэржанмаа, Ралжигмаа гурвыг урд нь өгүүлээд, ард нь тэр гурвын бие лагшны өнгөтэй зохилдох маргад, алт, бэндүръяа эрдэнийн гурван өнгийг дараалан гаргаж, Дара эх нөхөд сэлт гурвын бие лагшны өнгийг дүрслээд, эл гурвуул “огоотыг хураах” хэмээх тэнгэрийн орны галбарваасан модны үзэсгэлэнг ялан зохионо хэмээн өгүүлжээ.

Тухайлбал, Жомдандойма хэмээх Ялж төгс нөгчсөн эх-Дара эх, Одсэржанма хэмээх Алтангэрэлт эх, Ралжигма хэмээх Гагц үст эх гурвын бие лагшны өнгө нь тус бүрдээ гурван өөр, Ногоон Дара эх нь маргадын өнгөтэй, Одсэржанма нь алтны өнгөтэй, Ралжигма нь бэндүръяагийн өнгөтэй тул, дээрхи гурван Дара эхийн нэрийг дараалан өгүүлээд, ард нь маргад, алт, бэндүръяагийн өнгийг дараалан өгүүлжээ. Ингэснээрээ эл гурван Дара эхийн бие лагшны өнгийг яруу найргийн хэллэгээр магтах нэг зүйл уран арга болжээ. Эл гурвын үзэсгэлэнг нэгтгэн зангидаж, тэнгэрийн орны галбарваасан модны үзэсгэлэнг сүрээр ялагдуулж зохиохыг өгүүлжээ.

Арван долоо. **БАЯСГАЛАНГИЙН ЧИМЭГ** (са: прауа, тө: dga' pa'i rgyan, хя: 欢喜修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 17 дахь чимэг. Энэ нь үйлдсэн шалтгаанаас хүссэн үр дүнгээ олсноор баясгалан болсныг үзүүлэх арга. Үүнийг чимгийн дээд бөгөөд үлэмж ялгал бүхий дүр төгөлдөр, сүр жавхлан омог болохын үүднээс баясгалан гэж нэрлэсэн аж. Баясгалангийн чимэг нь: бодтой олсны баясгалан, дүр төгөлдрийн баясгалан гэж 2 зүйл байна. Баясгалангийн чимгээр Агваантүвдэнгийн бичсэн жишээ:



утгаа “бид нь тэнгэр чамайг яахин үзэх” гэж эрхэм хүндлэлээ өгүүлж байна.

Арван найм. **ДҮР ТӨГӨЛДРИЙН ЧИМЭГ.** (ca: sringāra, тө: nyams ldan gyi rgyan, хя: 姿态修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 18 дахь чимэг. Энэ нь өгүүлж байгаа юмаа сэтгэлд их тааламжтай буюу огт тааламжгүй байдалтай болгож дүрслэх арга юм. Энэ чимгийг Зохистын чимэг ч гэж нэрлэдэг. Монгол Данжуурт энэ чимгийг Дурлахуй лугаа төгссөн гэж орчуулжээ. Дүр төгөлдрийн чимгээр Агваантүвдэний бичсэн жишээ шүлэг:

Үлэмж амирлуулахын жаран эгшигт зарлигаар ч  
Үнэн хувьт номхотгогдохуунд амьсгал өгөн зохиохыг сонсоод  
Үзтэл сарны гэрэл унахад уснаас төрсөн залуу нялх баясах мэт  
Үнэн сүсгээр гарын арван хурууг зүрхэн тусдаа хумбивай.

(Сайн үгсийн сан. 1995. т.364)

Дара эхийн зарлигийн сайхныг санахад сэтгэлд сүсэг тааламжтай байдал төрсөн биеийн дүр байдал алгаа нийлүүлэн зүрхэн тус газраа залбирч буйг өгүүлээд Дара эхийн жаран эгшигт зарлиг нь хувь төгс шавийн сонорын тосгуурт унаж зовлонгийн энэллээс гэтэлгэх амьсгал болон зохиодогтой нэгэн адил сарны гэрэлд лянхуа цэцэг дэлбээ цомгоо хумбих мэт, сүсэг сэтгэл төрөөд мутрын арван хурууг зүрхэн тусдаа хумбин залбирсан уран дүр байдлыг өгүүлжээ.

Дүр төгөлдрийн чимэг нь дотоод сэтгэлийн өөрчлөгдөх байдлыг 8 шинжээр өгүүлж, түүнийг дагаж илрэх гадаад байдлын өөрчлөлтийг мөн 8 янз байдлаар өгүүлдэг. Иймээс энэ чимэг нь дотроо: Үзүүрхэхийн дүр төгөлдөр, догшины дүр төгөлдөр, баатарлагийн дүр төгөлдөр, нигүүлсэхүйн дүр төгөлдөр, үзэмжгүйн дүр төгөлдөр, тансаг гайхамшигт дүр төгөлдөр, аймшигт дүр төгөлдөр – гэсэн 8 зүйл чимэг байна.

18.1. **Үзүүрхэхийн дүр төгөлдөр** (тө: sgeg pa'i nyams). Энэ нь бусдаас үлэмж илүү эрдэм чадлаас шалтгаалж дотоод сэтгэлийн ихэд баяссан долгисол байдлыг гадаад дүр төрх дээр үзүүлэх найруулга, арга. Дүр төгөлдрийн чимгийн нэг зүйл. Жамъянгаравын “Үзүүрхэхийн дүр төгөлдөр” - ийн жишээ шүлэг:

Хоёр хэлийг өгүүлэгчийн (эрхт) Чойжү-Одсэр тэргүүтэн



(Хор) Монголын үсгийг нотлон буулгаад  
зарлиг номыг орчуулахын цагт  
(Хоёр) нүдээ өнцөгдөн хөдөлгөөд, номын үсгийг яруухан дуудаж  
(Хосгүй) тунгалаг мишээл (тодруулан) гэгээнээ нээсэн Хүлэг хаан  
(С.Жамъянгарав. 2011. т.97)

Энэ шүлэгт хоёр хэлийг өгүүлэгчийн эрхэн Чойжи-Одсэр бандидын монгол үсгийг зохиож, ном судрыг орчуулсанд Хайсан Хүлэг(1308-1311) хааны баясан таалсан байдлыг өгүүлжээ. Хүлэг хааны номын эрдэм баясгаланд шүтсэн дотоод сэтгэлийн баяслыг нүдээ өнцөгдөн хөдөлгөөд үсгийг яруухан уншихдаа нүүрээ өнгөт сайхнаар мишээж инээсэн Хүлэг хаан гэж дотоод сэтгэлийг их тааламжтай байгаа байдлыг түүний гадаад дүр байдлын үзүүрхэх цог жавхлангаар үзүүлжээ.

18.2. **Догшины дүр төгөлдөр** (тө: drag shul gyi nyams). Энэ нь сэтгэлийн дотоод уур хилэн оргилж гадаад байдал нь этгээд догшин болохыг үзүүлэх найруулга арга. Дүр төгөлдрийн чимгийн нэг зүйл. Энэ чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

(Эртний) Хятадын их гүрнийг машид сүрээр даран бөхийлгөгч  
Эзэн хаан Тогоонтөмөрийг түшмэл албадтай нь  
гэсгээн цээрлүүлэхээр  
Эзлэгдсэн цагаас сэмээр бэлтгэсэн  
цэргийн чуулганыг гэнэт босгож  
Их хамаг улсыг дүүргэн алах мэсийг огторгуй тулцуулав  
(С.Жамъянгарав. 2011. т.97)

шүлэгт Монголчуудын их цэргийн сүр хүчинд дарагдан бөхийсөн Хятад гүрэн улсын дотоод хилэн нь оргилон оргилсоор Тогоонтөмөр хааныг түшмэл албадтай нь гэсгээн цээрлүүлэхээр сэмээр бэлтгэсэн цэргийн их хүч Жүгэ ноёноор толгойлуулж боссон хийгээд тэдний зэр зэвсэг мэсийн тулаан нь тэнгэр огторгуйд тулах хэмжээний догшин ширүүн болсныг гадаад байдалд нь дүрсэлжээ.

18.3. **Баатарлахын дүр төгөлдөр** (тө: dra' ba'i nyams). Энэ чимэг нь доторх омогшин үл айхын шалтгаандаа дулдуйдан гадна байдал нь эрэлхэг сүрлэг баатарлаг дүр байдалтай болсныг өгүүлэх арга. Дүр төгөлдрийн чимгийн нэг зүйл. Баатарлахын дүр төгөлдөр чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ

Тэр мэтийн дайралт довтолгооноос аль амраар гаталж гараад  
(Тэмдэгтэйеэ) хаан, хөвгүүн, хатан, түшмэл сэлтээр  
цэрэгт нэхэгдэвч  
(Тэрхүү) замд нь хасбуу тамгын ормыг агуулсан мөрөн хөлдөж  
(Түүдгэрэл үгүй) өөрийн газраа ирээд төр улсыг тэтгэн суув  
(С.Жамъянгарав. 2011. т.97)

Энэ шүлгээ Монголын түүхээс сэдэвлэжээ. Хятадын цэргийн гэнэтийн их хүчит довтолгооноос Тогоонтөмөр хаан, хатан түшмэл сэлтээр Дайду хотоос зугтаж мултран гараад, араасаа нэхэн хөөгдөвч хасбуу их тамгаа хадгалж нууцлаад, хүнд нөхцлөөс гараад хаан тэрээр нутагтаа ирж төрөө төвшитгөн суув гэж их хааны баатарлаг дүр төрхийг үзүүлжээ.

18.4. **Өрөвчийн дүр төгөлдөр** (тө: snying rje'i nyams). Энэ нь сэтгэлд бий болсон үл тэсвэрлэм нигүүлсэнгүй нь гадна дүр байдалд илрэх найруулга. Дүр төгөлдрийн чимгийн нэг зүйл. Энэрэнгүй өрөвчийн дүр төгөлдрийг үзүүлсэн Дандины

Алимад зөөлөн биет лянхуан  
Ор дэвсгэрүүдийг ч ширүүн хэмээгч  
Тэр охин тэнгэр нь үхдлийн байшингуудад  
Түлш идэгч гал лугаа хамт яахин хэвтмүй

гэх энэ шүлэгт: залуу зөөлөн биет түүнд бадам дэвсгэр засахад ширүүн байна гэдэг хааны хатан тэрээр эзнээ үхэхийн цагт хүүрний байшинд хамт галд шатаалгах болов. Бадам дэвсгэр ширүүддэг зөөлөн бие нь одоо хатуу зовлон амсах нь хэцүүеэ<sup>28</sup> гэж гадна байдалдаа сэтгэл зовсон нигүүлсэхүйг үзүүлжээ. Энэ чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ шүлэг:

Элбэг хааны гоо хатан элдэв бачит уран аргаар  
Эсэн тайшийг архиар согтоож, исэр орон дээр унагаж орхиод  
Эр нөхөртөө очихын зуур нүүрээ шалбачин, үсээ задчиж  
“Энэ надтай цэнгэхийг хүсэвч, эс дагасанд маажив” хэмээв  
(С.Жамъянгарав. 2011. т.97)

Монголын түүхэн сурвалжаар уламжлан ирсэн Элбэг нигүүлсэгч хааны хатан Эсэн тайшийг хуурч архиар согтоож, нөхрийн өшөөг авсан тухай түүхэн домгоос эшлэн бичсэн шүлэг байна. Энэ домогт:

<sup>28</sup> Эрт цагт Энэтхэг Балбад хаан ба сайн язгуурын эр нь үхвэл эмийг нь хамт амьдаар нь шатаадаг ёс байжээ.

Элбэг хаан нэгэн өдөр ан хийж яваад цасан дээр дуссан туулайн цусыг үзээд “Энэ мэт цасан мэт цагаан нүүртэй, цусан мэт улаан хацартай эм байна уу” гэсэн Ойрадын Хуухай Таюу “Чиний дүү Харгачүг Дүүрэн хун тайжийн гэргий Өлзий бэйжийн өнгө гэрэл нь үүнээс үлэмж буй” гэсэнд Элбэг хаан бээр тэгвэл чамайг чансан болгож Дөрвөн Ойрадыг мэдүүлнэ хэмээн амлаж, түүгээр Өлзий бэйжийг авчруулжээ. Хожим нэг өдөр Өлзий бэйж Элбэг хааны эзгүй хойгуур Хуухай Таюуг чансан цолоо авахаар ирэх үед Хуухай Таюуг дуудаж хүндлэх мэт архи барьж дайлж согтож унагасны хойно үсээ задчиж, нүүр амаа холтчоод уйлан сууж. Хаан учрыг асуухад “Тийн барьсан сархадад минь Таюу согтоод чалчиж намайг татсанд эс болов хэмээн намайг ийн болгов хэмээн хэлжээ. Ийн хүч мөхөсдсөн Өлзий бэйжийн дотор сэтгэлд нөхрөө алуулсан гомдол хорсол хэдий их асахын хэрээр, түүнээ нуун далдалж гэмгүй асрах энэрэхийн дүр байдлыг гаднаа үзүүлж уран аргаар шийдсэн санааг өгүүлжээ.

18.5. **Жигшүүртийн дүр төгөлдөр** (ca: bibhātsa, тө: mi sdug pa'i nyams) Сэтгэлийн дотоод гоо бус, үзэмжгүй, тавгүй таагүй эвгүйг гаднах дүр байдалд найруулах арга. Дүр төгөлдрийн чимгийн нэг зүйл. Жамъянгаравын энэ чимгээр бичсэн жишээ шүлэгт:

Гайхамшиг гоо, цог төгөлдөр, Харгучаг ноёны хатан (тэрбээр)  
(Галт) мэсээр хатгалдан тэмцэлдсэн

хүмүүний цуснаа юунд хутгалдав!

(Гайт) шулмын хуурмаг явдлаар нөхөр юүгий нь хөнөөж алсан  
Гайхал мунхаг Элбэг хааны хатан ингэхэд яаж болов!

(С.Жамъянгарав, 2011. т.98)

Ихэс дээдсийн үүх түүхэнд өнгө мөнгөнд шунах явдлаас үүдэн бий болдог жигшүүр хэрэг явдлын нэгээс үүдсэн шүлэг байна. Гоо үзэсгэлэнгээс болж өөрийн нөхрөө алуулсан Өлзий хатан Элбэг хаанд өөрийг нь зааж өгч чансан цол авч хэргэм зэрэг ахисан Хуухай Таюуг хуурч унагаад Элбэг хаанд мэдүүлсэнд хаан Хуухай Таюуг алж арьсыг нь хуулсанд, хатан бээр Элбэг хааны шархадсан чигчийн цус, Таюугийн хуульсан арьсны тосыг долоож эрийн өшөөг өшилжээ. Энэ шүлэгт Хаан бээр өөрийн дүүгээ алаад эхнэрийг нь хатан болгож авсан ийм жигшүүрт явдлыг энэ жишээгээр үзүүлжээ.

18.6. **Инээдэмтийн дүр төгөлдөр** (ca: hasya, тө: bzhad gad kyi nyams). Дотроо инээд хүрээд тэр нь гадаад байдалдаа хошигносон



нарын эхнэрүүд нь айсандаа умай дахь ургаа унагадаг гэнэ. Үзүүртээ галтай очир нь Асури нарт тийм хэмжээний аймшгийг бий болгодог гэсэн нь аймшгийн дүр төгөлдрийн чимэг болж байна.

*Арван ес. СҮР ЖАВХЛАНТЫН ЧИМЭГ* (ca: ūrjasvīṭe: gzi brjid can gyi rgyan, хя: 威武修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 19 дэх чимэг. Бусдаас илүү баатар нь сүрт үг өгүүлж, сүр жавхлант омог төгөлдөр байдлаараа бусдаас давуу байдлыг харуулах арга. Энэ чимэг нэг зүйл байна. Сүр жавхлантын чимгээр Жамъянгаравын бичсэн:

Тэр мэт хатан (Мандухай) Ойрадыг эрхэндээ оруулаад  
Тэд бүгдийн явдал үйлийг цаазаар гэсгээн цээрлүүлэх  
(Тэрхүү) хааны цаазанд хэн биширсэн, хэн бөхийсөн түүнийг би  
(Тэтгэж) хайрлахаас бус, “хорлохгүй алахгүй” хэмээн зар тархаав  
(С.Жамъянгарав. 2011. т.99)

жишээ шүлэгт: их хүчээр эрх сүр дороо сөгдүүлсэн Мандухай хатан бээр төр түмнийг төвшитгөх хууль цаазыг гаргаж, энэ цаазыг дагасан биширсэн, бөхийсөн хэн хүнийг хайрлан тэтгэнэ. Эс дагасанг цээрлүүлнэ хэмээн их хааны сүр жавхланг үзүүлснийг уг шүлэгт өгүүлжээ.

*Хорь. ЗҮЙЛ ӨГҮҮЛЭХ ЧИМЭГ* (ca: paryayoktam, тө: rnam grangs bzod pa'i rgyan, хя: 托词修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 20 дахь чимэг. Энэ чимэг нэг зүйл. Зүйл өгүүлэх чимэг нь өөрийн хүссэн утгаа үл өгүүлж, түүнээ бүтээхийн тулд өөр бодтой ерөнхий агуулга өгүүлж тэр утгаа гаргах арга. Дандины жишээ:

Сахакарагийн хонгорцгийн тэжээл  
Үүнийг бусад бээр идэн үйлдмүй  
Түүнийг би-бээр ятган үйлдсүгэй  
Та хоёр өөрийн зоргоор суун үйлд.

шүлгийн утга нь бөглүү нэгэн газар эр эм хоёр болзон уулзаж байхад тэнд бас өөр нэг хүн ирж тэднийг олж үзчихээд би модны хонгорцог идэх хөхөөг хөөх юм. Та хоёр зоволтгүй өөрсдийнхөөрөө бай гэж өөр зүйлийг өгүүлж буй нь зүйл өгүүлэхийн жишээ болжээ. Тэр хүн болзсоныг мэдсэн ч мэдээгүй царайлж, өөр үгээр аргалан та хоёр өөрийн зоргоор суу гэж байна. Зүйл өгүүлэх чимгээр Жамъянгаравын

бичсэн жишээ шүлэг

Мутартаа лянхуат Содномжамц (Далай ламтанд)  
Бараа бологчид нь “Итгэлт Та эндээ аль амгалангаар морилон  
зохиож хайрла  
Ба бүрэн ордон харшийн үйл бүгдийг гүйцэлдүүлээд  
(Бас) Төвдийн шашныг барин тэтгэж сууя” хэмээн өгүүлэв  
(С.Жамъянгарав, 2011. т.99)

Үүнд Далай лам Содномжамц гэгээнийг урт наслаж, өлмий бат эсэн энх суугтун гэсэн санааг далдуур илтгэж, ил шуудаар “Амгалангаар оршин суу” хэмээж орд харш барьж өгсөн хийгээд Төвдийн төрийг барьж сууя хэмээн хэлсэн зэргийг өгүүлсэнийг гаргаж үзүүлжээ.

*Хорин нэг. ХАМГАА ТУСТЫН ЧИМЭГ* (ca: samahīnam, тө: kun tu phan gyi rgyan, хя: 良缘修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 21 дэх чимэг. Энэ нь нэг юмыг бүтээх гэж үйл үйлдэхэд түүнээс илүү сайн нөхцөл гарч тэр үйлс тусалж үйл бүтээхийг хамгаа туст чимэг гэнэ. Энэ чимэг нь 1 зүйл байна. Дандины жишээ:

Дээрэнгүйг дарахын тулд түүний  
Хөлүүдэд мөргөснөөр  
Өөрт туслахын тулд баясагч  
Луун дууныг дуурсгах болов

Нөхөр нь эхнэрийнхээ хөлд сөгдсөн ч омогт эхнэр үл энэрэхэд эртний буянаар гэнэт бороо орж тэнгэр луун дууныг нүргэлэн дуугарснаар эхнэрийг сэрүүцүүлж эхнэр нь амраг эрдээ сөгдөв гэсэн нь өөр нөхцөл тусалсныг харуулжээ. Жамъянгаравын энэ чимгээр бичсэн жишээ:

Алтан хааны өлмий (тулай өвчтэй тул) хүчтэй чилээд  
Адууны халуун сэвсэнд дүрснээр сая сэвхийж байтал  
(Аз) буяны (асар) үнэ өртгөөр, гэнэт харин  
(Ачит) ялгуусан (Содномжамц) гуйлгачны дүрээр  
залран ирсэн лүгээ учрав  
(С.Жамъянгарав, 2011. т.99)

Энэ нь Монголын түүхэн домгоос сэдэвлэн бичжээ. Алтан хааны хөл нь тулай өвчний улмаас тэсэхүйеэ бэрх өвдөх тул гүү алж түүний халуун сэвсэнд дүрвээс хөлийнх нь өвчин түр намдах боловч, Алтан

хаан бээр амьтны амь таслав хэмээн сэтгэлд нь сэв болдог байв. Ийн цаг үед далай лам Содномжамц нь ядуу тойны дүрээр үзэгдэн учирч түүний өвчнийг оргүй болтол нь эдгээж эмчилсэн гэдэг. Тэгэхлээр Алтан хааны хөл өвдсөн муу нөхцөл нь далай ламтай уулзуулж Алтан хаан төдийгүй цааш цаашдаа Монгол түмнээ бурханы шашныг мандан дэлгэрүүлэх сайн нөхцөлийн үүдэл болсныг өгүүлжээ.

*Хорин хоёр. АГУУ ИХИЙН ЧИМЭГ* (са: udattam, тө: rgya che ba'i rgyan, хя: 宏伟修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 22 дахь чимэг. Энэ нь тэнцэлгүй их санаа, учралыг өгүүлэх арга юм. Энэ чимгийн бэлгэ чанар нь оюун бодолд багтамгүй санаа агуу их буюу учрал агуу их болсон нь тэнцэлгүй чанартай тул агуу ихийн чимэг гэжээ. Агуу ихийн чимэг нь дотроо: Санаа агуу ихийн чимэг, учрал агуу ихийн чимэг- гэсэн хоёр зүйл байна.

22.1. *Санаа агуу их* (тө: bsam pa rgya che ba). Энэ нь тухайн үйлсийн утга санаа нь хэмжээлшгүй их болохыг харуулсан утга илтгэдэг арга. Агуу ихийн чимгийн нэг зүйл. Дандин:

Раванагийн толгойг огтлох  
 Үйлсийн их үүргийг хүлцэгч  
 Алимад Эрхтийн хөвгүүн<sup>29</sup> тэрээр  
 Ламын зарлигаас даван эс чадав.

Эртний Энэтхэгийн алдарт “Рамаяна” туулийн үлгэрээс сэдэвлэсэн шүлэг. “Рамаяна”-ы үлгэрээр бол: Ланка арлын хаан Равана мангас нь Брахма тэнгэрийг шүтэж мөргөн тахиж арван толгойноосоо тайрч гал мандал өргөж бацаг барьж гуйсан учир олон хүчит шидийг олжээ. Тэрээр хүн болоод тэнгэрийн алинд ч хорлогдохгүй шидийг олжээ. Бас дүрсээ олон янзаар хувилгаж чадна. Аймшигт арван толгойтой дүрстэй. Иймд түүнийг Дашагрива буюу арван толгойт гэж нэрлэдэг болжээ. Тэр хорин гартай, зэс улаан нүдтэй, гялалзсан арзгар шүдтэй, уулнаас том биетэй. Бүх мангас хор хөнөөлтэй боловч Равана нь тэд бүгдээс хэдэн хувь илүү ажээ. Тэр шид чадлынхаа хүчээр тэнгэр нарыг зарц болгож байв. Ийм хор хөнөөлтэй учир тэнгэр нар энэ зовлонг тэсвэрлэх аргагүй болж Вишнү тэнгэрээс аврал гуйжээ. Ингээд

<sup>29</sup> Рахугийн хөвгүүн –бол баатар Рама болно. Арван толгойт мангас бээр түүний эхнэр Ситаг нь булаасанд Хэу ван сармагчны хаан Сүгривын тусламжаар гүүр тавин тэнгисийг гэтлээд Ланка аралд очиж мангастай хатуу ширүүн тэмцэлдэж арван толгойтын гол тэргүүнийг нь цавчин авсан гэдэг.

Вишнү дэлхий бууж Дашаратха хааны хүү болж төрөхөөр шийджээ. Хааныг тахил өргөж үрийн хутаг гуйхад Вишнү тэнгэр ирээд тэд нарт бумбатай рашааныг өгч “Хатаддаа уулга” гэжээ. Их хатан рашааны талыг уусан учир түүнээс төрсөн Рама хүү хагас буян хутагтай төрөөд, удаах хоёр хатан нь үлдсэн хувийг хувааж уусан тул тэр хоёр хатны хүүхдүүд нь дөрөвний болоод наймны нэг хувийн буянтай төржээ. Ийн тэнгэр нарын хүсэл авралаар төрсөн Рама хүү бол мангасын хааны толгойг таслах их үүргийг гүйцэтгэж ганц чадагч нь байв. Ийм учир тэрээр цус урсгасан байлдааныг олон удаа хийж эцэст нь Ланкийн нийслэлийг эзэлж Равана мангасыг алж Сита хатнаа мангасын гараас аварч бүгдээрээ амар сайхан жаргадаг Рамааны туулийн нэг хэсгийн өгүүлэмжийг энд жишээ болгожээ. Ингэхдээ Рама хичнээн их чадалтай байлаа ч гэсэн сэтгэлийн нигүүлсэхүй агуу ихээс болж ламынхаа зарлигийг давж эс чадав гэж сэтгэлээр агуу ихэд итгэсэн учир хичнээн их чадалтай байлаа ч гэсэн сэтгэлийн агуу ихээс болж ламынхаа зарлигийг давж үл чадахыг харуулсан байна. Санаа агуу ихийн чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

Итгэлт (Содномжамц) тэрбээр хуучныг  
үндэснээс (нь) хориглон чадсан ч  
(Эгнэгт) бясалгалыг агуулаад, онгод хүүрийг тахих ёсыг тасалсан  
(Их) гэлүмбагийн шашны тулд  
Гомбо (Махагалыг) тахих цааз хуулийг гаргаж  
Эрдэнэ зууг бүтээх орон газрыг бошголсон  
(С.Жамъянгарав, 2011. т.100).

III далай лам Содномжамц бээр Түмэдийн Алтан хааны лагшин биеийг илааршуулан эдгээсэн төдийгүй урьдын шүтээн тахил болох онгод сахиусуудыг Махагалын их галд мандал болгон өргөн бадрааж, хожим хойчдоо тахин шүтэх бурхан сахиусыг болгоон адислаж, Их монголын нийтийн шашин номын тулд Эрдэнэзууг бүтээн босгох газар орныг ч бошиглон үйлдэв гэж хожим хойчдийн их тэргэн мөрийг болгоосон агуу их санааны их үйлийг ийн магтжээ.

22.2. **Учрал агуу их** (тө: 'byog ra rgya che). Энд гайхан бишрэм тансаг баян учрал тохиоллын агуу ихийг харуулж үзүүлэх арга. Агуу ихийн чимгийн нэг зүйл. Дандины

Эрдэнийн туурганаа туссан  
Зуун дүрс өнгөөр хүрээлүүлсэн



Ланкагийн эрхт түүнийг ямагт  
 Анзын хөвүүн<sup>30</sup> бэрхээр танимумй.

энэ жишээ шүлэгт мангасын хаанаас өөр ямар ч хаанд байдаггүй, элдэв эрдэнээр давхарлан бүтээсэн тансаг ордонд мангасын хааны дүрс зуун хувь болон харагдаж, Ланкагийн эзэн буюу мангасын хаан танигдахгүй болсон байхад түүний жинхэнэ бие ба хоосон дүрс хоёрыг ялган мэдэгч нь ганцхан Анзын хүү Хануманда болно. Гэвч Анзын хүү бээр Ланкагийн хааны жинхэнэ бодит биеийг арайхийн бэрхээр танив гэж мангасын ордон өргөөний элдэв тансагийг, мөн мангасын хааны дүрс зуун хувь болж харагдах зэрэг сонин гайхам учралыг дүрсэлжээ.

Учрал агуу ихийн чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

(Агуу их) учралын садан өмөг төгөлдөр Абудай (сайн) хаан бээр  
 Аяндаа өөсөөн бүтсэн тариан төмс хийгээд

эд агуурст Вачирт суурины

Асар их бодь (лугаа) адилаг бүтээгээд зуун суваргаар тойруулж  
 (Ачит) ном төрийг тэтгэж зохиосон нь санаанд багташгүй

(С.Жамъянгарав, 2011. т.100)

аяндаа өөсөө бүтсэн мэт нандин шүтээн эд эдлэл бүхий Очирт суурины тансаг гайхам бүгдийг агуу их учралын садан Автай сайн хаан бээр яг түүний мэт адилаар Эрдэнэзуугийн шүтээнийг бүтээж, бодь суварга тэргүүтэн зуун суварга тойруулан босгож Монгол түмний ном төрийг тэтгэсэн агуу их учралын санаанд багташгүй үйлсийг энэ шүлэгт өгүүлжээ.

*Хорин гурав. ГҮЖИРЛЭХ ЧИМЭГ* (са: arahnuti, тө: bsnyon dor gyi rgyan, хя: 歪曲修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 23 дахь чимэг. Энэ нь гүтгэх маягаар магтах зүйлийнхээ сайхныг гаргах арга.

Гүжирлэх чимгийн тухайд өгүүлэгдэхүүний ахуй ёсон бодитойг гүтгэж энэ бол биш гээд өөр утгыг өгүүлэх арга гэжээ. Энэ чимгийг хүчирлэх чимэг (Ч.Алтангэрэл), гөрлөгч чимэг (Л.Хүрэлбаатар) зэргээр олон янзаар нэрлэж иржээ. Дандин бээр жишиж гүжирлэхийн ялгалууд агуу их буйг улам улам цааш гаргах хэрэгтэй гэсэн нь энэ гүжирлэх чимэг нь цаашид гүжирлэхийн олон боломж зүйл байж болно гэсэн үг юм. Гүжирлэх чимэг 3 зүйл. Үүнд: Номд гүжирлэх,

<sup>30</sup> Анзын хөвүүн – бол “Рамаяна” дахь Хэу ван Шүжэ либугийн хамгийн цэцэн сэргэлэн бөгөөд хамгийн эрэлхэг баатарлаг их сайд Хануман болно. Бас Бүрүхануман гэдэг

оронд гүжирлэх, өөрийн чанарт гүжирлэх - гэсэн гурван зүйл болно.

23.1. **Ялгалт гишүүний номд гүжирлэх** (тө: khyad chos bsnyon dor). Энэ нь алив нэг юмны гишүүн хэсгийг орших ёсноос нь зориуд ондоогоор өгүүлж, өөр утга илэрхийлж санаагаа гаргах арга. Гүжирлэх чимгийн нэг зүйл. Дандины жишээ:

Амармагийн таван суман  
Бус буюу мянган өд лүгээ төгссөн буй  
Хүслийн таван сумны<sup>31</sup>  
Гурван ертөнцийг дарагч чадал нь

сумандаа бус мянган өдөндөө байдаг гэсэн нь угтаа таван суманд байгаа чадлыг өдөнд нь буй гэж гүтгэсэн хэрэг байна.

Энэ чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

(Эрдэнэт гэгээн) Жэвзүндамбаданбижалцан энэ бээр  
Их Хор (монголын) гав гагц итгэл бус  
Энэтхэг, Балба, Төвдөөс наашхи ном төрийн цог учрал бүхнийг  
(Эгнэгт) нэгэн мөсөн булаан авсан их хулгайч нэгэн мөн

(С.Жамъянгарав, 2011. т.100)

гэж гүтгэх маягаар магтах зүйлийнхээ сайхныг гаргахдаа Монголын анхдугаар богд, Өндөр гэгээн Дамбижалцаны шашин төрийг тэтгэсэн тэр нэг гайхамшигт үйлийг нь ихэд гүжирлэн хэлбийлгэж, Энэтхэг, Балба, Төвдийн ном төрийн хамаг сайн ёсыг бүгдийг нь хамж хурааж авснаараа нэг ёсондоо хулгайч мөн гэсэн уран хэтрүүлгийн санааг гаргажээ (Л.Хүрэлбаатар, 1999. т.427-428).

23.2. **Орныг гүжирлэх** (са: vishaya-nihnuti, тө: yul la bsnyon dor). Энэ нь ямар нэг юм үзэгдлийн орон болсон зүйлийн мөн чанарыг гүжирдэн өгүүлж, цаанаа сайхныг өгүүлж санаагаа гаргах арга. Гүжирлэх чимгийн нэг зүйл. Дандины

Зандан ба сарны гэрэл өмнийн этгээд дэх  
Дөлгөөн үнэр хөлөгтөн салхи эдгээрийг  
Бусдын ялдраа сэрүүн хэмээн алдаршивч  
Галын чанарт хэмээн дуршмуй.

жишээ шүлэгт гүтгэгдэж буй орон (юм) нь зандан, саран, өмнө зүгийн салхин энэ гурав нь угтаа бол сэрүүн зүйл болно. Гэвч энэ гурав нь хүнийг сэрүүцүүлснээрээ хүслий нь өдөөж халуун энэлэл өгдөгөөрөө

<sup>31</sup> Хүслийн таван сум – амармагийн таван сум

галын чанартай болой гэжээ (ДЗАТ. 1982. т.104-105). Орныг нь гүжирлэхийн чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

(Их) богд (Жэвзундамба) түүний оршин суусан орон ширээ энэ нь  
(Эгэл хөдхи) дагшин бусын орон хэмээн хамгаа алдаршсан боловч  
(Илт) билгүүний бурхан мэдэлт зарим нэгэн ард дор  
(Эрхэм) ариун дагшин орны цог лугаа төгөлдөр нь илт  
(С.Жамъянгарав, 2011. т.100)

Энэ шүлэгт Халхын Өндөр гэгээн Занабазарын оршин суугаа орон хийд сүм дуган энэ нь эгэл дагшин бус хөдхи орон юм гэлцдэг. Энэ нь худал юм. Илт билгүүний мэдэлт зарим нэгэн нь бол эрхэм ариун дагшин орны төгс хамаг шинж бүрэн байдаг гэсэн нь Жавзандамбын орныг эгэл хөдхи гэдэг нь худал харин ариун дагшин орон мөн болохыг билгүүн мэдэлтнүүд мэдэрсэн юмаа гэсэн нь орны гүжирлэх чимэг болж байна.

23.3. **Өвөр чанарыг нь гүжирлэх** (ca: svarūpāhnuti, тө: rang bzhin bsnyon dor). Энэ нь өгүүлж буй зүйлийнхээ үндсэн төрөлх мөн чанарыг нь гүтгэж, энэ бус тэр мөн хэмээн өөр нэгнийг өгүүлэх маягаар найруулж санаагаа гаргах арга. Гүжирлэх чимгийн нэг зүйл. Дандины

Ба бүрэн бид сарыг рашаан  
Цуварсан гэрэлт хэмээн таалавч  
Утгадаа энэ нь бус чанарт  
Хор цуварсан гэрэл лүгээ төгссөн бөгөөд

жишээ шүлгээр бол сарыг бид рашаан цуварсан гэрэлт гэж байгаа байдлаар нь таалдаг боловч үнэн утгандаа бол хүсэл бүрдсэн хүнийг энэлгэж үхүүлэх шахдаг тул энэ нь рашаан бус хор цувруулсан гэрэлт сар юм гэж сарны чанарыг гүтгэж байна. Энэ чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

Үзэх, сонсох, дурдахын цогийг барьсан гэтэлгэгч Та бээр  
(Өтөл) хүмүүний эрхтийн дээд хөвгүүн бус  
(Өдөт) галууны хаан болж, Төвдийн зүг дор нисэж ажирсныг  
Үнэн шударгын ёст өвгөн эмгэн хоёр харсан  
(С.Жамъянгарав, 2011. т.101).

Энэ чимгийн жишээнд Өндөр гэгээн Занабазар бараа бологчдийнхоо хамт долуул, Төвдөд морилж явахдаа долоон галуу болж нисэж явсан, түүнийг нь хэдэн ямаагаа харж байсан өвгөн эмгэн

хоёр таниад, цай барьж өргөн хүндэлсэн тухай аман ба бичгийн нэгэн домгийн өгүүлэмжийг ашиглажээ. Энэ домогт:

Өндөр гэгээн нь Эээр засагчийн XII он модон хонин жилийн намар цаг 21 сүүдэртэйдээ Төвхөн шивээт уулнаа ном үзэн бясалган суух ахуй үедээ тэндээс зургаан (заримд галуу гэдэг) хүмүүний хамт долуул Төвдийн орноо явж хүрсэн тухай домог бий. Сайн ноён аймгийн Хөх хэмээх өвгөн хэдэн хонь ямаагаа хариулан явтал долоон ангир шувуу дээгүүр нь нисэн баруун урагш зүгт явахад тэр өвгөн зуны цаг явдаг шувуу бөгөөтөл өвөл явах нэг учиртай буй за хэмээн хэдэн хонь ямаагаа гаднаа хөөж аваачин. т.- Эмгэн чи нэг таваг идээ, нэг домбо цай бэлд гэснийг эмгэн бэлдэж, өвгөн түүнийг аван баруун урагш зүгт үдэш болтол явсанд нэгэн тал говь газарт долоон хүн сууж байхыг үзээд тэр өвгөн учраа хэлж та долоо тоо нийлсэн тул танд цай идээ барьсугай хэмээн барьсанд тэд нар мөн бусыг эс мэдэвч бид нар хүлээж авъя, бэлэгтэй болов хэмээн айлдаж зооглоод, бид аяны хүн тул гээд саванд зооглосон гурилаасаа нэгэн морины дүрс бүтээж хийгээд өвгөнд чи үүнийг даллагын саванд хийсүгэй. Үрийн үрд их баян болтугай хэмээн ерөөл айлдсанаар эдүгээ хүртэл Хөх өвгөний үр сад нь баян явдаг гэсэн домог байдаг. Мөн Өндөр гэгээнийг Төвдийн оронд тийнхүү газар товчлон заларсан учрыг Халх бүгдээр хожим хойно мэдэж сонсоод “Манай богд гэгээн минь маш их гайхамшигт шидтэй” хэмээн улам ихэд биширсэн гэдэг.

Иймд энэ шүлэг нь Өндөр гэгээнийг “хүмүүний эрхт” Түшээт хаан Гомбодоржийн хүү бус, харин өдөн галуут шувууны хаан байна. Тийн нисэж явсан нь үнэн бөгөөд түүнийг олж харсан нь үнэн шударга өвгөн эмгэн хоёр байна хэмээн нотлон өгүүлж гүтгэсэн нь рид хувилгааны ид шидийг олсон “хутагт” мөн гэж уран сайхны аргаар зориулд хэлбийлгэсэн гүтгэх чимгийн жишээ болжээ.

*Хорин дөрөв. **НАЙРУУЛАХ ЧИМЭГ*** (ca: slishtam, тө: sbyar pa'i rgyan, хя: 双关修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 24 дэх чимэг. Энэ нь ганц үг хэрэглэж олон утгат янз бүрийн санаагаар найруулах арга. Энэ нь нэгэн үг хэлж, түүнтэй адил утга бүхий үг хэрэглэх газар мөн үгээ хэрэглэж, алив юмс үзэгдлийг үзүүлэхдээ найруулахын суурь, найруулгын үе гишүүн олныг гаргаж ирэх арга юм.

Найруулах чимэг нь дотроо: Утга тусгаар бус нэг үгээр найруулах,

утга тусгаар нэг үгээр найруулах, үйлс тусгаар бус найруулах, үйлс харшгүйн найруулга, үйлс харшлагч найруулга, магадтын найруулга, магад түрдтгэх найруулга, харшлалгүйн найруулга, харшлалтын найруулга – гэсэн 9 зүйл байна.

24.1. **Утга тусгаар бус нэг үгээр найруулах** (тө: tha dad min pa'i sb-yaг ба). Энэ нь олон утгатай нэг үг хэрэглэж найруулах арга. Найруулах чимгийн нэг зүйл. Дандин:

Мандаад оршсон үзэсгэлэнт  
 Мандалд тогтсон энэ хаан нь  
 Зөөлөн гувчуураар ертөнц дахины  
 Дурыг сайтар булаан үйлдмүй.

Мандах мандал гэдэг үг нь ургах дэлгэрэх гэсэн хоёр утгатай. Найруулагдах ёстой суурь үг нь хаан, сар хоёр юм. Түүнд холбогдох гишүүн нь хаан төр дэлгэрэх, сар мандаж гарах хоёр байна. Энэ хоёр хоёулаа үзэсгэлэнтэйн дээр хаан нь хүний мандалд, сар нь огторгуйн мандалд оршино. Хаан нь хүний хаан, сар нь хоёр төрөгч буюу бярмань хаан. Зөөлөн гувчуур гэдэг үг нь зөөлөн алба гэдэг утганд орохоос гадна бас зөөлөн гэрэл гэдэг үгэнд орно гэнэ. Хаан зөөлөн албаар жаргаадаг, сар нь зөөлөн гэрлээр сэрүүцүүлэн жаргадаг болно (ДЗАТ. 1982. т.106) гэжээ. Өөрөөр хэлбэл,

Нэг үг нь: Мандах. Энэ нь ургах дэлгэрэх гэсэн хоёр утгатай

Найруулагдах суурь нь: Хаан, сар хоёр юм

Гишүүн утга нь:

- мандах (хаан төр дэлгэрэх, сар мандах)
- хоёул үзэсгэлэнтэй
- мандалд орших (хаан нь хүний, сар нь огторгуй)
- хоёул хаан (хаан нь хүний, сар нь бярмань)

Зөөлөн гувчуур гэдэг нь – зөөлөн алба, зөөлөн гэрэл гэсэн 2 утганд орно. - Зөөлөн албаар хаан жаргаадаг, зөөлөн гэрлээр сар сэрүүцүүлэн жаргаадаг. Ийн ганц үг хэрэглэж олон утгат янз бүрийн аргаар найруулжээ.

24.2. **Утга тусгаар нэг үгээр найруулах** (са: bhinnapadapraya, тө: tha' dad tshig sbyar pa). Энэ нь ганц үгийг өгүүлэгдэхүүний олон утганд найруулах арга. Найруулах чимгийн нэг зүйл. Дандин:

Хаан язгуурын мөрт бас кша тра<sup>32</sup>

Хаан язгуур (на кша тра)<sup>33</sup> нь хаасан мөний тулд үл оршигч

Хааны гэмүүд гарахын орон лугаа

Нөхцөж олон гэмүүдээр ба бүрнийг<sup>34</sup> баясгах үгүй энэ мэт яахин үл зовмуй.

Энэ жишээнд, кша тра нь хаан язгуур гэсэн үг. На кша тра нь жугар одны нэр гэнэ. Кша тра гэсэн нэг аялгуут үг боловч утга ангид хоёр үгийг найруулж санаагаа гаргажээ. Үүнд кша тра гэдэг үгээр муу үйлстэнтэй нэгдэж албатныг баясгахгүй байгаа хааны тухай өгүүлжээ (ДЗАТ. 1982. т.106)

24.3. **Үйлс тусгаар бус найруулах** (ca: awkinna kelys, тө: bya ba tha dad min pa'i sbyar ba). Энэ нь хоёр юмыг адилтгахдаа бусад юмыг нь биш, ганцхан үйлс адил болохыг дурдаж найруулах арга. Найруулах чимгийн нэг зүйл. Дандин:

Гунхсан сайхан таалахуй авирт

Тачаангуйг тодорхой үзүүлэгч

Гоо эхийн дурдгах нүдэн лүгээ

Элчийн<sup>35</sup> амраглан ирэх

Энэ чимэгт нүд нь суурь болж жавхлан болох зууван урт байдал, өгөх дохио, дур татам байдал нь гишүүн юм. Ингэж нэг суурь дээрх олон ялгал буюу гишүүн нь тус тусдаа бус амрагийг өдөх ганцхан адил үүрэгтэйг найруулж уг чанартаа нэг суурь дээрх олон ялгал нь нэг адил үүрэг гүйцэтгэсний харуулж байна (ДЗАТ. 1982. т.107).

24.4. **Үйлс харшгүйн найруулга** (тө: bya ba 'gal ba min pa'i sbyar ba). Хоёр юмыг жишиж үзүүлэхдээ түүний үйлс нь хоорондоо харшгүй болохыг үзүүлэн найруулах арга. Найруулах чимгийн нэг зүйл. Дандины

Дурнаа зохист тачаангуйг нэмүүлэгч

Зөөлөн согтоогч яруу аялгуут

Хөхөөн дууныг сонсон үйлдэж

Цагаан бус нүдэт<sup>36</sup> нүгүүдийг тэвэрмүй.

Энэ нь харш бус хоёр үйлсийг нэгэн юмны сайхныг гаргахад

<sup>32</sup> кша тра – гэж хаан язгуур гэсэн үг.

<sup>33</sup> на кша тра – жугар одны нэр

<sup>34</sup> Ба бүрэн – бид

<sup>35</sup> Элчийн – нүдний дохио

<sup>36</sup> Цагаан бус нүдэт – хар нүдэт

хэрэглэсэн найруулга байна. Найруулагдах үе гишүүн ялгал нь сэтгэлд зохист байдал, тачаал арвижуулагч чанар, зөөлөн бөгөөд согтоогч яруу дуу гурав байна. Найрагдах суурь нь хөхөө, хар нүдэт эм хоёр. Шүлгийн сүүлийн хоёр мөр нь хөхөөн дууныг сонсоод хар нүдэт эмийг тэврэв гэсэн утга юм. Ингэхлээр энэ жишээ шүлэгт хөхөөн дуу, сайхан эмийн хөгжмийн яруу дуу хоёрыг адилтган найруулж, хөхөөн дуу, хөгжмийн дуу хоёр харш бусыг үзүүлжээ.

24.5. **Үйлс харшлагч найруулга** (тө: ‘gal ba’i las can gyi sbyar ba). Энэ нь харьцуулах хоёр үйлэнд харш утгатай үг хэрэглэж өгүүлэх санаагаа гаргах найруулах арга. Найруулах чимгийн нэг зүйл. Дандины

Цума<sup>37</sup> лугаа хавсрахуй нэмснээр  
Улааныг маш үзүүлэн үйлдээд  
Халуун гэрэлт наран шингэхүй болсонд  
Төлжсөн биетэн нүгүүд огоот дэлгэрмүй.

Цума гэдэг нь баруун зүг ба эмийн бэлгэ гэсэн хоёр утгатай. Баруун зүгийн тухай ярихад шингэж буй нарны тухай өгүүлнэ. Эмийн бэлгийн тухай ярихад хурьцалыг өгүүлнэ. Энэ хоёрын найруулагдах ялгал нь арвижин ихэдсээр улаан болдог наран шингэх үеийн гэрэл, хүслийн намбыг дэлгэрүүлсэн байдал хоёр юм. Үйлийн харшлал нь юу вэ гэвэл наран шингэхдээ улаан болдог, бэлгэ эрхтэн хурьцлын үед бас улаан болдог хоёр эсрэг чанар юм гэжээ. Ингэхдээ хоёр улаан юмны нэг нь эхлэхдээ улайдаг, нөгөө нь дуусахдаа улайдаг хоёр харш чанарыг үзүүлж байгаа хэрэг (ДЗАТ. 1982. т.108).

24.6. **Магадтын найруулга** (тө: nges can gyi sbyar ba). Энэ нь хоёр утгатай үгсээр ямар нэг ижил зүйлийг хэлээд тэр нь биш, энэ нь гэж нотлон өгүүлж найруулах арга. Найруулах чимгийн нэг зүйл. Дандин:

Мөнхүү илднээ нь дримша<sup>38</sup> мөнхүү  
Нуманд нь муруй<sup>39</sup> бөгөөд  
Мар гана<sup>40</sup> хүний эрхт үүний  
Мөнхүү сумнуудаа орших мөн буюу

Чимгийн найруулагдах уг суурь нь хаан. Найруулагдах ялгал нь драмша, муруй, маргана гэсэн хоёр утгатай үгс юм. Драмша гэдэг

<sup>37</sup> Цума – баруун зүг ба эмэгтэй хүний бэлгийг заана. Баруун зүгийн тухай ярихад шингэж буй нарыг хэлнэ. Эмийн бэлгийн тухай ярьж байхад хурьцалыг хэлнэ

<sup>38</sup> дримша – санскрит үг. Хутга, уур гэсэн хоёр утгатай

<sup>39</sup> Муруй – гэдэг нь нум, башир хуурамч зан гэсэн хоёр утга байна

<sup>40</sup> Мар гана – сум, гуйлгачин гэсэн хоёр утгатай

санскрит үг нь хутга, уур гэсэн хоёр утгатай. Муруй гэдэг нь нум, башир хуурамч зан хоёрт орно. Мар гана гэдэг нь сум, гуйлгачин гэсэн хоёр үгийг илтгэнэ. Дээрх үгсийг хэрэглэхэд энэ хааны дуун нь нум, сум хоёрт тохирох тул өөр бусад нь биш юм гэж магадтай нотлож байна гэжээ. Ингэж найруулагдах нэг суурин дээр найруулагдах ялгал олныг хэлж өгүүлэх журам юм (ДЗАТ. 1982. т.108).

24.7. **Магад түртгэх найруулга** (тө: nges med kyi sbyar ba). Энэ нь магад нотлогдох зүйл биш болохыг үзүүлж найруулах арга. Найруулах чимгийн нэг зүйл. Дандины

Чи бээр сахихуйд өргөс нь  
Мөнхүү лянхуан эш болмуй.  
Тийм атал тачаангуйтан хурьцаад  
Эвчихүй нүгүүдэд бээр үзэгдмүй

Найруулагдах уг суурь болох хаан газар дэлхийг сахидаг байхад найруулагдах үе гишүүн болох ширүүн өргөс нь лянхуагийн ишинд л байх юм гэж найруулна. Гэвч хаан баясагч эмийг тэврэхэд өвчүүн доорхи үс нь босно гэжээ. Ингэж бадмын ишинд өргөс байх ба биеийн үс босох хоёр утгыг найруулснаар нөгөө бадмын үс босдог ганцхан чанарыг няцааж, өөр бас босдог үс байна гэж бадмын үсний магад босдгийг няцааж байна.(ДЗАТ. 1982. т.108).

24.8. **Харшлалгүйн найруулга** (са: virodhi, тө: ‘gal med kyi sbyar ra). Энэ нь адилтгагч адилтгагдахуун хоёрт нэг нэр хэрэглэж болох харшгүй нэрийг олж чимж найруулах арга. Найруулах чимгийн нэг зүйл. Дандин:

Газрыг эзлэгч катака<sup>41</sup> олон бөгөөд  
Сүр жавхлан лугаа төгсөн магад дэлгэрсэн  
Хэлэх төрөлхтний эзэн болсон  
Мэргэд ноёд хүчийг баригч<sup>42</sup> тэд ч

Катака гэдэг санскрит үг нь бага хаан, бага уул гэсэн хоёр утгатай, баригч гэдэг нь их хаан, их уул хоёуланд орно. Хаан ба уул хоёр нь найруулж болох уг суурь үг юм. Найруулагдах үе гишүүн нь хаан төр ба уулын үйлс юм. Ингэхлээр энэ шүлэгт катака гэдэг үгээр хаан ба уул хоёрын үйлсийг адилтгаад, цаашаа сүр жавхлан, хүчийг баригч бусад нь ч бүгд ийм байдаг гэсэн санаа гаргаж байна.

<sup>41</sup> Катака – санскрит үг. Бага хаан, бага уул гэсэн хоёр утгатай.

<sup>42</sup> Баригч – баригч гэдэг үг нь их хаан, их уул хоёуланд нь орно.



24.9. **Харшлалтын найруулга** (тө: ‘gal ba can gyi sbyar ba). Энэ нь найруулагдах суурь адил байдлаа найруулагдах үе гишүүн нь харшилж байх ёстойг үзүүлж найруулах арга. Найруулах чимгийн нэг зүйл. Дандины

Буурах үгүй мөн боловч номыг таслах бус  
 Хаан мөн боловч барагдахуйг үл мэдмүй.  
 Эрх баялаг тэнгэр мөн боловч гараар явагч үгүй хэмээн  
 мэдэх болой  
 Тэнгэр боловч мэргэнээс ангижирсан бус<sup>43</sup>.

Хаан болоод Чамжүг хэмээх Вишнү тэнгэр хоёр хутаг олсон ба хаан төр нь буурахгүйн хувьд адил. Гэхдээ хаан нь үхэр тэргүүтнийг алдаггүй тул буяныг таслахгүй байж чаддаг. Харин Вишнү нь өөр эсрэг үйлстэй болно. Хаан, сар хоёр эрхэмсэг зүйлээрээ адил. Гэхдээ хаан нь 15-наас хойш хомсддоггүй байхад сар нь хомсддог. Хаан Ванчиг хэмээх тэнгэр хоёр жаргаагч чанараараа адил. Гэхдээ хаан нь гараар явагч могойгоор чимэг хийдэггүй. Бас хаан тэнгэр хоёр Лхамин /тэнгэр бус хэмээх нэг төрөл амьтан/ боловч хаан нь нойрсдог байхад тэнгэр нойрсдоггүй /мэргэнээс ангижраагүй/ болно гэжээ. Энэ тайлбараас үзвэл: ижил хоёр суурийг ижилсгэе гэтэл тэр суурь дээрх ялгалт гишүүд нь ижил бус байж суурийг адилтгахыг няцаадаг тул харштны найрлага болж байгаа юм. Иймд энэ найруулга бол хоёр зүйлд байдаг ижил чанарын нэгий нь хаантай холбож үзүүлснээрээ найруулах арга нь илэрч байна (ДЗАТ. 1982. т.108).

*Хорин тав. ЯЛГАМЖТАЙГ ӨГҮҮЛЭХ ЧИМЭГ* (ca: viseshokti, тө: khyad rag brjod pa'i rgyan, хя: 特叙修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 25 дахь чимэг. Энэ нь магтах зүйлээ бусдаас үлэмж болгон үзүүлэхийн тулд шалтгааны ялгамж эс бүрдсэн ч үйлс үйлдэж чадна хэмээн үзүүлэх арга. Ялгамжтайг өгүүлэх чимгийн бэлгэ чанар нь: аливаа юм үзэгдлийн онцлог ялгамжийг үзүүлдэг өвөрчлөнгийн чимгийн дөрвөн үндсэн язгуур шинж, тэгээд тухайн юм үзэгдлийн шалтгааны ялгамжийг өгүүлэх чанар байна. Ялгамжтайг өгүүлэх чимгээр Агваантүвдэнгийн бичсэн жишээ

Алагчаалал үгүй амьтан дор тус ямагт нэгнийг таалж  
 Асар бат хуягийг өмсөж, хурц мэсийг барьсан нь үгүй авч

<sup>43</sup> мэргэнээс ангижирсан бус - ༄མ་སང - хэзээд сэрүүн гэж тэнгэрийн ёгт нэр. Тэгэхлээр тэнгэр нь хэзээд мэргэн гэсэн утга байна

Аймшигт найман аюул тэргүүтэнтэй эсэргэлцэхийн байлдаанаас  
Ашид ялахын арга Танаас өөр хэнийх байх вэ?

(Сайн үгсийн сан. 1995. т.363)

Энэ шүлэгт, чанадсын байлдаанд ялахын ялгамжаат хуяг мэс тэргүүтэн эс бүрдсэн боловч, Гэтэлгэгч Дара эхийн түүнийг ялан дийлж чадсан үйлийг өгүүлжээ. Ялгамжтайг өгүүлэх энэ чимэгт магтах зүйлээ бусдаас үлэмж давуу болгон үзүүлэхийн тулд шалтгааны ялгамж эс бүрдсэн боловч, үйл үйлдэж чадах байдлаар нь үзүүлдэг энэ аргаар Дара эхийн ийм үйл үйлдэж чадах илүү давуу зэргийг магтахдаа биедээ хуяг өмсөж гартаа мэс бариагүй боловч найман аюул тэргүүтэнтэй байлдаж дийлсэн тийм их хүчин чадал гагц танаас өөр хэн нэгэнд буй гэж, шалтгаан нь бүрдээгүй боловч үр нь бүтсэн явдлыг өгүүлжээ. Ингэж найруулах аргыг уг магтах зүйлийнхээ хэтэрхий хүч давуу байдлыг илэрхийлж гаргахад зохистой арга гэж үздэг байна.

Ялгамжтайг өгүүлэх чимэг нь дотроо: Эрдэм эс бүрдсэний ялгамж өгүүлэх, язгуур эс бүрдсэний ялгамж өгүүлэх, үйлс эс бүрдсэний ялгамж өгүүлэх, эд эс бүрдсэний ялгамж өгүүлэх, шалтгааны ялгамж өгүүлэх – гэсэн 5 зүйл байна.

25.1. **Эрдэм эс бүрдсэний ялгамжтайг өгүүлэх** (тө: yon tan ma tshang pa'i khyad par brjod pa). Энэ чимэгт эрдэм эс бүрдсэн боловч ялгамжаатайг үзүүлдэг арга. Ялгамжтайг өгүүлэх чимгийн нэг зүйл. Дандины

Цэцэг нумтнуудын мэс нь

Ширүүн бус хурц ч бус

Тэр мэт боловч энэ бээр

Гурван орон дахин нугуудаас ялах болов.

гэх жишээнд: цэцгэн нумтан Гандира нар хатуу хурц сумгүй боловч тийм сумны чадал бүрдсэн мэтээр гурван орныг эзэлж ялж чаддаг гэжээ. Учир нь төвлөрөн тогтсон төвшин сэтгэлийг чөтгөр үймүүлж, бясалгал алдагдуулдаг чадлыг хэлж байна. Өөрөөр хэлбэл, Гандирва нарын сум нь хатуу хурцын эрдэм бүрдээгүй боловч гурван орныг ялдаг гэж эрдэм эс бүрдсэний ялгамжийг үзүүлжээ.

25.2. **Язгуур эс бүрдсэний ялгамжтайг өгүүлэх** (тө: rigs ma tshang pa'i khyad par brjod pa). Энэ нь язгуур эс бүрдээгүй, язгуургүй боловч язгууртайн адил эрдэм үзүүлж үйлс бүтээж чадахыг үзүүлдэг арга.

Ялгамжтайг өгүүлэх чимгийн нэг зүйл. Дандины

Эдгээр нь тэнгэрийн охин бус  
Гандирын<sup>44</sup> язгуураас ирсэн ч бус  
Тэр мэт атал Эсэруагийн  
Хатуужлыг дарахыг бүтээн чадмуй.

Энэ жишээ шүлэгт үнэр идэштний охин нь тэнгэр язгуургүй боловч тэрээр гоо сайхан учраас Эсэруа тэнгэрийн сэтгэлийг татаж бясалгалыг нь үймүүлсэн гэжээ. Өөрөөр хэлбэл Гандурын охин нь тэнгэр язгуургүй боловч язгууртайн адил үйл бүтээж чадсанг үзүүлжээ (ДЗАТ. 1982. т.110).

**25.3. Үйл эс бүрдсэний ялгамжтайг өгүүлэх** (тө: bya ba ma tshang pa'i khyad par brjod pa). Энд үйлийг эс үйлдээгүй боловч үйлийг үйлдсэн мэт үр дүн үзүүлж ялгамжтай буюу эрдэм давуу болохыг үзүүлэх арга. Ялгамжтайг өгүүлэх чимгийн нэг зүйл. Дандины

Хилэн уурлалуудыг эсхүү хураагаад  
Шүдний бүрхүүлийг ч эс хөдөлгөөд  
Нүдээ улаан болголгүй  
Дайсны язгууртныг бууруулан үйлдвэй

энэ жишээ шүлэгт хилэгнэн уурлаж нүүрэндээ элдэв атираа үзүүлээгүй, шүдээ хавирч ярзалзуулаагүй, хөмсгөө зангидаж нүдээ улайлгаж их уур бухимдлын байдал үйл үйлдлийг үзүүлээгүй боловч энэрлийн зөөлөн шалтгаанаар дайсны омгийг бууруулсан чадлыг харуулжээ.

**25.4. Эд эс бүрдсэний ялгамжтайг өгүүлэх** (тө: rdzas ma tshang pa'i khyad par brjod pa). Энэ нь тухайн өгүүлэгдэхүүнд хүчтэй эрдэмтэй эд эдлэл нь үгүй боловч ялгамжтай давуу болохыг үзүүлэх арга. Ялгамжтайг өгүүлэх чимгийн нэг зүйл. Дандины

Тэргэн үгүй заан бээр үгүй  
Морин үгүй явган үгүй боловч  
Хатагтайнууд мөнхүү өнцөглөхүй нүдээр  
Гурван амьтнуудаас ялгуусан

энэ жишээнд тэрэг үгүй, заан үгүй, морин болон явган цэрэг үгүй боловч эхнэрүүд гурван ертөнцийг ялж чаддаг гэжээ. Өөрөөр хэлбэл хүчтэй зэвсэг эд эдлэл үгүй байтлаа гурван ертөнцийг эрхэндээ хураадаг чадалтай гэж эд эс бүрдсний ялгамжтайг жишээлжээ.

<sup>44</sup> Гандур –Гандира – нь 1.Үнэр идэшт (цөтгөрийн хаан ). 2.Тэнгэрийн хөгжимчин

25.5. **Шалтгааны ялгамжтайг өгүүлэх** (тө: rgyu ma tshang pa'i khyad par brjod pa). Энэ нь аливаа үйлсийг бүтээх нөхцөл бүрдээгүй боловч шалтгааны эрхээр үйл бүтээсэн байдлыг харуулах арга. Ялгамжтайг өгүүлэх чимгийн нэг зүйл. Дандины

Гагц хүрдэт тэргэн наран ба  
Жолоодогч нь буурсан тэгш бус морьт  
Тэр мэт болбоос бээр сүр жавхлант  
Наран нь гурван амьтныг сүрдүүлмүй

энэ жишээнд: Нар нь нэг хүрдтэй тэрэг эзэмшдэг, жолоо баригч нь буурсан, тэгш бус морьт буюу долоо гэсэн сондгой тоотой учир хэрэг бүтээж чадахгүй боловч өөрөө сүр жавхлантайн шалтгаанаар тэнгэр, лус, хүмүүн гурван төрөлхтнийг сүрдүүлэх (ДЗАТ. 1982. т.110) буюу дагуулж бишрүүлж захирч чадна гэсэн утгатай.

*Хорин зургаа. АДИЛТГАН НАЙРУУЛАХ ЧИМЭГ* (ca: tulyayogita, тө: mtshungs pa sbyor pa, хя: 牽合修飾). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 26 дахь чимэг. Ямар нэг зүйлийн тухай өгүүлэхдээ ялгал бүхий эрдмээр нь адилтган магтах буюу доромжлох маягаар магтаж санаагаа өгүүлэх арга. Өөрөөр хэлбэл адилтган найруулах чимгийн бэлгэ чанар нь өгүүлэхийг хүссэн зүйлийнхээ ялгалыг нэр болоод бусад олон зүйлээр нь адилтган магтаад заримыг муушаахыг адилтган найруулах гэжээ. Энэ чимэг нь: магтан адилтгаж найруулах, муушаан адилтгаж найруулах гэсэн 2 зүйл байна.

26.1. **Магтан адилтгаж найруулах** (ca: stuti, тө: stod pa'i mtshungs par sbyor pa). Энэ нь зөвхөн магтах юмандаа л байдаг үлэмж ялгалыг нь өгүүлээд тэр ялгаатай байдлаараа бусад нь бүхэлдээ цөм сайн болохыг харуулдаг арга. Адилтган найруулах чимгийн нэг зүйл. Дандин:

Эрлэг, муу биет, усан тэнгэр хийгээд  
Мянган нүдэт<sup>45</sup> лүгээ мөнхүү чи бээр  
Ертөнцөсийг асармуй хэмээх үг дуу  
Бус орноо огоот үгүй хэмээн баримуй.

Энэ шүлэгт буй эрлэг, муу биет, усан тэнгэр, мянган нүдэт эдгээр дөрвөн зүгийн эзэн ба хаан чи бээр асран тэтгэнэ гэсэн энэ үгийг өөр

<sup>45</sup> Мянган нүдэт – Хурмаст тэнгэр, бас дорно зүгийн эзэн гэдэг. Хурмаст нь 33 тэнгэрийн орны эзэн. Замбутивийн зүүн зүгийг тэтгэгч нь Хурмаст бус, гэвч Хурмастын нэрийг зээлдсэн. རྩེན། зуун өглөгт нэрээр ижил

юманд хэрэглэж болохгүйг сайтар баримтлан адилтгасан байна гэжээ. Дээр гарсан тэтгэнэ гэдэг үгийг өөр юманд хэрэглэж болдоггүйг энд ашиглажээ (ДЗАТ. 1982. т.111). Магтан адилтгаж найруулах чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

Хутагтын оронд Лүдэв, Тогмид (хоёр) ба  
(Хувьт) Төвдийн оронд Мармэзад, Зонхова (хоёр)  
Хор Монголын оронд Чойжиням итгэл (Та бүгд)  
(Хосгүй) Чадагчийн шашны их журмыг нээхүйд  
тэнцэх ханиас хагацсан  
(С.Жамъянгарав, 2011. т.105)

Энэ шүлэгт эрдмээр нь адилтган найруулжээ. Энэтхэгийн оронд их багш Нагаржуна, Тогмид, Төвдийн оронд Адиша, Зонхов, Монголын оронд VIII богд Жавзандамба хутагт Чойжиням аль нь ч адилхан эрдмийнхээ хувиар Бурханы шашны их зам мөрийг залгамжлан арвижуулж нээснийхээ хувиар энэ Замбулингийн тэнцэх ханиас хэтэрсэн мэргэд болохыг адилсгаж, нэг талын эрдмээр нь найруулжээ (Л.Хүрэлбаатар. 1999. т.422).

26.2. **Муушаан адилтгаж найруулах** (тө: smad pa'i mtshungs par sbyor pa). Энэ ямар нэг юмны гэмтэй талыг адилтгаж, сайн сайхныг хүсэн мөрөөдөх далд санаа гаргах арга. Адилтган найруулах чимгийн нэг зүйл. Дандин:

Гөрөөсөн нүдэт лүгээ нөхцөх ба  
Гилбэлгэний наадан цэнгэлүүд хийгээд  
Үүлний туурвилуудын өврийн чанараар  
Хоёр агшнаа<sup>46</sup> үл оршмуй.

Энэ нь муушаан адилтгаж найруулсан байна. Энд гөрөөсөн нүдэт лүгээ амгаланг эдлэх, цахилгааны гилбэлгээний баясал, үүлний нүүх байдал төрх энэ гурав нь хурдан замхарч хувирдаг гэж гурван гэмээр нь адилтган найруулжээ. Ингэж гурван юмны гурван гэмийг адилтгасан нь цаанаа бол сайхныг хүссэн далд санааг илэрхийлж байна.

Энэ чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

Арга бачит эхнэрийн өнгө, архинд шунах  
Адаг явдалт хааны ардын сэтгэлийг шантлах  
(Ариун) хувраг тойдын цааз сахилыг цалгардуулах

<sup>46</sup> Агшин, эгшин – гэж идэр настай хүн түргэн гэгч хуруу инчдэх төдий хугацааг хэлнэ.

(Аяа энэ гурав) шашин төрийг эвдлэх

(С.Жамъянгарав, 2011. т.105).

Энэ шүлэг нь мөн муушаан адилтгасан байна. Аливаа нийгмийн доройтол буурал болох төрийн эзэн, түшмэд хар шар олон, эгэл ардын цалгай муу явдлууд юм гэж тэдний ав адил юм гэж адилтган шүүмжилжээ. Үүнд, хаан, хувраг, эхнэр гуравт архи өнгөнд шунах, доордсыг дарамтлах, цааз хуулийг цалгардуулах нь шашин төрийн эвдэхэд хүргэдэг гэж энэ гурван гэм нь муу үр дүнд хүргэдэг ижил гэмтэй гэдгийг шүүмжилж адилтган найруулсан учир “муулахын адилтган найруулах” чимэг болсон байна.

*Хорин долоо. ХАРШЛАХЫН ЧИМЭГ* (са: savirodha, тө: ‘gal pa’i rgyan, хя: 矛盾修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 27 дахь чимэг. Олон төрлийн биедээ харш үзэгдлийг нэгэн дор байрлуулан нөхцөлдүүлж сайныг үзүүлэх арга. Ингэхдээ харш үзэгдлийг бүтээхийн тулд бодын ялгал ба ялгалт гишүүн, үйлдвэр тэргүүтэн харш зүйлүүдийг нэгэн хамт нөхөр болгон үзүүлнэ.

Харшлагч нь суурь, үйлс, ном эд, найруулга гэх мэтийн олон арга боломжоор найруулж уран дүр дүрслэлийг бүтээж болох харшлагч чимгийн олон хувилбар боломж хязгааргүй байж болохыг Дандин тэмдэглэжээ. Харшлагч чимэг нь дотроо: Тусгай суурийн үйлс харшлагч, ганц суурийн үйлс харшлагч, ганц суурийн ном харшлагч, ганц суурийн эд харшлагч, ганц суурийн үйл харшлагч, ганц суурийн найрлага харшлагч хэмээх 6 зүйл байна.

27.1. *Тусгай суурийн үйлс харшлах* (тө: gzhi tha dad pa’i bya ba ‘gal ba). Энэ нь өөр ондоо суурь юмны үйлдэх үйлс нь харшлахыг үзүүлнэ. Харшлах чимгийн нэг зүйл. Дандин:

Галууны хаануудын

Согтохуй яруу аялгуусын цуугиан нэмэхүйд

Тогосуудын аялгуус нь

Мөнхүү дуран зохисоос ангижиран буурму

Суурь болох галуу, тогос хоёр нь тус тусдаа амьтан. Тэдний үйл болох галууны согтуу яруу дуун арвижихад, тогосын дууны яруу буурч байна. Иймд ондоо хоёр суурийн ондоо хоёр үйлс нэг нь арвижиж байхад нөгөө нь буурч харшилж байна (ДЗАТ. 1982. т.111).

27.2. **Ганц суурийн үйлс харшлах** (тө: gzhi gcig gi byed pa 'gal ba). Ганц суурь дээрх үйлс нь харш болохыг харуулна. Харшлах чимгийн нэг зүйл. Дандин:

Зун төрсөн усан баригчууд бээр  
Огторгуйд муу орон мэт яваад  
Тогтсоноор  
Амьтны сэтгэл нь бүхнээ тачаах больюу.

Зун цагийн усан баригч үүл гарах нь муу, сайн хоёр үүрэг гүйцэтгэх нь харш үйлс болно. Үүл огторгуйд тогтох тул суурь нь огторгуй. Үүл бол огторгуйн орныг үл баясгасан муу явдал мэт болохын хамт сэрүүцүүлж, тачаал ивэлгэн амрагийг мөрөөдөх, сэтгэл хөдөлгөдөг тул эсрэг тэсрэг үйлстэй болой гэжээ (ДЗАТ. 1982. т.111-112)

27.3. **Ганц суурийн ном харшлах** (тө:gzhi gcig gi chos 'gal ba). Энэ нь нэг суурийг бүтээж буй олон ялгалт гишүүд хоорондоо харшлахыг үзүүлэх арга. Харшлах чимгийн нэг зүйл. Дандин:

Нарийн цээжит болоод бүдүүн бөгст  
Улаан уруулт, цагаан бус нүдэт  
Богино хэвлийт, өндөр хөхт  
Хатагтайн бие бээр хэнийг үл дарна.

Нэг суурийн олон ялгалт гишүүд хоорондоо харшиж байвч тэдгээр нь суурьтаа зохицсон, уг суурийнхаа сайхныг үзүүлэхэд чиглэнэ. Энэ шүлэгт суурь болох эхнэрийн биед байдаг ялгалт гишүүн нь нарийн бэлхүүс, бүдүүн бөгс, улаан уруул, хар нүд, хүйс нь хонхор, хөх нь товгор энэ бүсгүй нь хүсэлтэн бүхнийг дарна гэнэ (ДЗАТ. 1982. т.112).

27.4. **Ганц суурийн эд харшлагч** (тө: gzhi gcig gi rdzas 'gal ba). Энэ нь нэг суурийн дээрх эд харшлахыг харуулах арга. Харшлах чимгийн нэг зүйл. Дандин:

Лянхуан үндсэн гарт, гадил модон гуят,  
Лянхуа нүүрт хийгээд удвал нүдэт  
Чиний бие бээр ба бүрнийг  
Энэлгэн чадах бус буюу юу биет эх

Суурь болох эхнэрт байдаг эд нь бадмын үндэс мэт зөөлөн гар, гадил модон мэт чийрэг гуя, бадам мэт цагаан нүүр, удвал мэт зууван нүд болно. Ийм эхнэрийн дүрсийг үзээд бид энэлэхгүй байж яахин чадах вэ гэжээ.

27.5. **Ганц суурийн үйл харшлагч** (тө: gzhi gcig gi las ‘gal ba). Энэ нь нэг суурийн дээрх үйл харшилж нэг талаар сайн, нөгөө талаар муу байдалтай болохыг үзүүлэх арга. Харшлах чимгийн нэг зүйл. Дандин:

Хий бээр маш хөдөлсөн үүсгэмэл цэцэрлэг дэх  
Зуда замбагын тоосон  
Хүрсэн бус боловч зочдын  
Нүднээс нулимсыг маш цувруулан үйлдмүй.

Үүний суурь нь зуда модот цэцэрлэгийн дундах замбага цэцэг байна. Харшлаад буй үйлүүд нь юу вэ гэвэл: цэцгийн тоос нүдэнд хүрэх хэрэгтэй боловч хүрээгүй байхад түүнийг үзсэн даруйдаа зочид нулимс гоожив гэжээ. Уг утга нь бол тоосноос болж нулимс гараагүй, их хүссэн сэтгэлээс болж нулимс гарав гэсэн үг болгож тоосноос болсныг ийнхүү нуужээ (ДЗАТ. 1982. т.112).

27.6. **Ганц суурийн найруулга харшлах** (тө: gzhi gcig gi sbyar ba ‘gal ba). Энэ нь гагц үгийн салаа утгыг хэрэглэх арга юм. Харшлах чимгийн нэг зүйл. Дандин:

Яруу аялгуут эх чиний нүдэн  
Хар, цагаан хязгаартаа улаан болбоос бээр  
Чихнүүдээ шүтсэн нь  
Мөнхүү хэний сэтгэл батдах болмуй.

Энэ шүлгийн санскрит жишээнд нь A-za-na гэсэн нэг үг хэрэглэж цагаан ба орчлон бүтээгч гэсэн хоёр утга гаргасан байдаг. Энэ шүлэг нь уртлаг совхин зууван цагаан хар нь тодорхой алагласан сайхан нүд итгэл төрүүлж бишрүүлэх атлаа тачаал гижигдэн зовоож байгааг өгүүлж нүдний эрдэм харш үүрэг гүйцэтгэснийг харуулжээ.

Хорин найм. **БУС ҮЕСИЙГ МАГТАХ ЧИМЭГ** (са: aprastuta-prasamsa, тө: skabs min gyi stod pa’i rgyan, хя: 非时赞扬修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 28 дахь чимэг. Энэ нь магтах орон цаг үе нь болоогүй байхад ямар нэг юмыг нөхцөлөөр өөрийн сэтгэлд магтахын үүднээс сайшаах нь бус үесийн магтаал болно. Бус үесийг магтах энэ чимэг нь 1 зүйл байна. Дандин:

Бусдыг үл шүтэгч гөрөөснүүд бээр  
Хичээлгүйеэ хялбар олдох эд  
Усан ба өвсөн ногоо тэргүүтнээр



Ойд амар амьдармуй.  
Хааныг дагагсад нисванисаар  
Гансарахуй сэтгэл лүгээ төгөлдрийн тул  
Мөн үйлсэд эс хүрсэн энэ  
Гөрөөдийн явдал ёс эдгээрийг сайшаав.

Дээрх хоёр бадгийн эхнийх нь жишээ шүлэг бөгөөд удаах нь жишээний тайлбар байна. Энэ жишээнд хэн нэгэн хүн муу хааны улмаас сэтгэл гансарч магтах хэрэггүй гөрөөсийг магтаж, бусдыг шүтэлгүй ус өвсөөр хоолож явдаг амар юм гэснээрээ далд санаандаа хааныг сайн байгаасай гэсэн утга болж байна. Энэ нь ойд байгаа гөрөөсийг магтах цаг үе нөхцөл үгүй байхад түүнийг амар сайхан гэж магтсан нь муу хааны тухай бодохдоо амар амгалан гөрөөдийн тухай магтсан нь бус үесийг магтаж уул санаагаа илэрхийлсэн хэрэг болж байна. Энэ чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

Газрыг тэтгэгч эзэн хаан төрийг бариад  
(Гар дорхи) албат иргэд нь цааз хуулийг эс даваад  
(Гайхамшигт) шашны үйлс нь үзсэн сонссоны  
сонин сайхан үзмэр болоод  
(Газрын их) Оросын хаант улс илтэд амгалантай  
(С.Жамъянгарав, 2011. т.107)

Энэ шүлэгт төрийг бат бариад, цааз хуулийг хатуу сахиж, шашны үйлсийг дэлгэрүүлж буй Оросын хаант улсын тухай өгүүлжээ. Энэ шүлгийн утга нь, ХХ зууны эхэн үеийн Монгол улс үндэстний төр ёс, цаг үе, нийгмийн байдал ороо бусгаа байсан байдлыг зохиогч санаандаа нэг агуулаад, хөрш зэргэлдээ орших Орос улсын төр, цааз, шашин нь өөр харь ангид боловч тэдгээр нь өөрийн өвөрмөц чанд бөгөөд бас онцлог сонирхолтой, ард улс нь ч илт амгалан байна гэж бус үесийг магтсан байна.

*Хорин ес. ХУУРМАГААР МАГТАХ ЧИМЭГ* (са: vyajastuti, тө: zol gyis bstod pa rgyan, хя: 隱贊修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 29 дэх чимэг. Энэ нь өгүүлэгдэхүүн юмаа доромжлох мэтээр магтаж далд ухаанаараа сайныг гаргаж өгүүлэх арга. Өөрөөр хэлбэл, дүр нь гэм ба доромжлол мэт үзэгдэвч мөн чанараар эрдэм хэтрэхийг үүсгэж магтах арга байна. Ийнхүү аливаа юмс үзэгдлийг доромжлох мэт магтаж, унагах мэт өргөх хуурмагаар магтах уран

сайхны сэтгэлгээний боломж арга хязгааргүй олон гэж Дандин бээр тодорхойлжээ. Энэхүү олон боломжоос 3 зүйлийг онцлон авч үзжээ. Үүнд: Хүч бүрэн төгссөний, баатарлаг бүрэн төгссөний, чадал бүрэн төгссөний – гэсэн 3 зүйл байна.

29.1. **Хүч бүрэн төгсийг үзүүлэх** (тө: mthu phun sum tshogs pa'i zol bstod). Энэ нь хүч чадал бүрэн төгсийг үзүүлдэг арга. Хуурмагаар магтах чимгийн нэг зүйл. Дандин:

Рамана нь хатуужлаар  
Энэ ад бүднэрийг баригчаас ялгасны тулд  
Хаан чи бээр мөнхүү түүнээ  
Энд омгорхон үл үйлдэхүй, хаан чи

Рама хааныг магтахын тулд өөр зүйлийг өгүүлж хуурмаглаж буй жишээ байна. Рамана өнө удаан хугацаанд хатуужил хийж Брахма тэнгэрт уйгагүй тахил мандал өргөсний үрээр газар дэлхийг сайтар ялах хүчийг олсон гэдэг. Тэгэхдээ Рамана чи энэ дэлхийг гагцаар захирагч биш юм. Чи нь омгорхох хэрэггүй гэж дэлхий ялагч Раматай тэр хааныг адилтгасан нь Рама хааны хүч чадал бүрэн төгс болохыг үзүүлсэн хэрэг юм.

29.2. **Баатарлаг төгсийг үзүүлэх** (тө: dra' ba phun sum tshogs pa'i zol bstod). Энэ нь баатарлаг явдал бүрэн төгссөнийг харуулах арга. Хуурмагаар магтах чимгийн нэг зүйл. Энэ чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

Ба бүрний цог төгөлдөр багш дээдсийн чуулган  
(Басхүү) энэ зүг дор шашны төгс төгөлдөр дор  
оюун баясан үйлдэх  
Шар малгайтын хувраг эс өгснийг авсан энэ  
(Шамдаж) буян төгөлдрийг даган орсон  
нэрийн үлэмж дор болох буюу  
(С.Жамъянгарав, 2011. т.108)

Энэ нь Богд Зонховын үндэслэсэн шар малгайтын шашин нь Бурхан буддагийн номлолын оньсыг бүрэн бүрдүүлсэн гэдгийг үзүүлэхийн тулд Бурханы шашныг гардаж аваагүй тул эс өгсөнийг авсан хэмээх доромж муушаалын үгээр ил наанаа илэрхийлсэн боловч цаана нь Богд Зонхов гэгээний баатарлаг бүрэн төгссөн байдлыг хуурмагаар магтсан жишээ байна.

29.3. **Чадал бүрэн төгссөнг хуурмагаар магтах** (тө: stobs phun sum tshogs pa'i zol bstod). Энэ бол магтах юмныхаа хүч чадал төгс болсныг харуулах арга. Хуурмагаар магтах чимгийн нэг зүйл. Дандин:

Чиний хатад газар орон  
Гараар явахуйн эд нугуудаа тачаахуйд нь  
Юуны тулд чиний омог нь  
Дээдийн эцсээ хүрэхүй болбой

Энэ шүлэгт хаан чи нь гараар явагч гэх луугийн эд эдлэлд тачааж юуны учир дээд омогт хүрнэ вэ гэж хааныг муушаах боловч уул утгандаа бол луугийн эд эдлэлийг эдэлдэг тансаг хатантай учраас луу ба лусыг захирч суудаг чадал эрхтэй болохыг нь харуулсан хэрэг болж байна (ДЗАТ. 1982. т.114).

Гуч. **МАГАД ҮЗҮҮЛЭХ ЧИМЭГ** (са: nidarsanam, тө: nges par bstan pa, хя: 确定修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 30 дахь чимэг. Энэ нь хоёр юмыг жишихдээ өөр нэг магад үзүүлж чадах зүйлийг орлуулан өгүүлж хоёр юмны чанар адил байх үр гаргаж хэлээд туст дээд, хорт муу хэмээн үзүүлэх ёстой. Өөрөөр хэлбэл магадлан үзүүлэгч аль нэг үлгэрийг түүнтэй адил магад үлгэртийг дээд буюу тус, дээд бус буюу хорлол болохоор үзүүлдэг арга. Ингэхдээ үлгэр болдог зүйлээ урьдаар зохиох аргаараа бус утгасыг байгуулах долдугаар чимгээс ялгаатай. Энэ чимэг нь дотроо. Дээдийн магад үзүүлсэн, дээд бусын магад үзүүлсэн гэж хоёр зүйл байна.

30.1. **Дээд магадыг үзүүлэх** (тө: mchog gi nges bstan). Өөрийн тус ивээлээр бусдад туслах сайн чанарыг гаргах арга. Магад үзүүлэх чимгийн нэг зүйл. Дандины

Мөнхүү наран мандсанаар  
Лянхуанууд цогийг өгөн үйлдмүй.  
Хотол төгссөн бүхний үрүүд нь  
Нөхдийг даган барихуйяа үзүүлсний тулд болой

гэх энэ жишээ нь наран ургахад бадам мандана гэж өгүүлээд энэ нь ерөөсөө нар мандахад амьтан бүхэнд хотол буяны цогийг өгдөгийг үзүүлжээ.

30.2. **Дээд бус магадыг үзүүлэх** (тө: mchog min nges bstan). Муу талыг нь өгүүлэх маягаар сайхныг нь гаргах арга. Магад үзүүлэх

чимгийн нэг зүйл. Дандины

Сарны гэрэл тусваас л  
Харанхуйн эрхисийг сөнүүлэх больюу.  
Хаан лугаа харшлагчууд даруй дээр  
Муугийн эцэс болон арилан үйлдэх буюу

энэ шүлэг нь сарны гэрэл гийхэд харанхуйн эрхисүүд үгүй болдог. Үүн шиг тэнэг хаан өөртэй нь харшигч өчүүхнийг алах цөлөх шийтгэх зэргээр туйлдуулдаг гэжээ. Үүний санаа бол хаан сайны гэрлийг эзэмшээсэй гэсэн утга байна.

*Гучин нэг. ХАМТ НЭГНЭЭ ӨГҮҮЛЭХ ЧИМЭГ* (са: paṅṅiti, тө: lhan gcig brjod pa'i rgyan, хя: 并叙修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 31 дэх чимэг. Энэ нь өгүүлэгдэхүүний эрдэм үйлүүдийг хамт өгүүлэх арга. Хамтатган өгүүлэхийн чимэг ч гэдэг. Өөрөөр хэлбэл, нэг төрлийн үүрэг гүйцэтгэж чадах зүйлүүдийг хамт өгүүлж болох арга. Өвөрчлөнгийн чимэгт гардаг дөрвөн чимгийн дотроос зөвхөн эрдэм, үйлс хоёрыг нэгэн дор хамтатган өгүүлнэ. Хамт өгүүлэгч энэ чимэг нь дотроо: Эрдмийг хамт өгүүлэх, үйлс тусгаарыг хамт өгүүлэх, нэгэн үйлсийг хамт өгүүлэх чимэг – гэсэн 3 зүйл байна.

31.1. *Эрдмийг хамт өгүүлэх* (тө: yon tan lhan gcig brjod pa). Энэ нь эрдмүүдийг хамт өгүүлж уран санаагаа гаргадаг арга. Хамт нэгнээ өгүүлэх чимгийн нэг зүйл. Дандин:

Эдүгээ нь эдгээр шөнө бүхэн миний амьсгал лугаа  
Хамт нэгэн урт буюу,  
Сарны чимэг лүгээ төгссөнүүд ч  
Мөнхүү миний бие лүгээ нэгэн хамт нэгэн цагаан болой.

Эхнэрээ санасан хүнд шөнө урт байв, амьсгаа гарах урт байв. Энэ хоёр урт нэг хамт тохиолдох нь хүлцэшгүй болов хэмээсэн нь уртын эрдмийг үзүүлжээ. Мөн сартай шөнө цагаан, эхнэрээ санасан хүний нүүр мөн цонхигор цагаан, энэ мөн давхцав гэж цагааны эрдмийг үзүүлжээ.

Энэ чимгээр жишээгээр Жамъянгаравын бичсэн шүлэг:

Айлдагчийн сан Манзушрийн илд лүгээ сацуу  
(Асар) цогт багшийн язгуур, ир лүгээ төгөлдөр  
(Ашид) Вишнүгийн орны сан лугаа нэгэн хамт  
(Ачтан) Таны тийн цагаан (буян) барагдахыг мэдэхгүй сан

(С.Жамъянгарав, 2011. т.109)

Манзушри бурханы илдний хурц ир лүгээ адил цогт дээд багшийн язгуур ухааны ир адил болохыг хамт үзүүлсэн, Вишнү тэнгэрийн эдийн баялаг барагдашгүй лугаа адил таны буян мөн адил барагдашгүй гэжээ. Үүнд Манзушри бурханы ухааны эрдэм, багшийн ухааны эрдэм хоёр ав адилхан, Вишнү тэнгэрийн эдийн сан, эрдэмт багшийн буяны сан хоёр барагдашгүйгээрээ мөн адил хэмээн хамт нэг дор өгүүлжээ.

31.2. **Үйлс тусгаарыг хамт өгүүлэх** (тө: bya ba tha dad pa'i lhan gcig brjod pa). Энэ нь үйлс тусгай чанарыг хамт өгүүлэх арга бөгөөд өөр өөр чанарын үйлс хамт тохиолдсоноор сэтгэл баяссан байдлыг гаргана. Хамт нэгнээ өгүүлэх чимгийн нэг зүйл. Үйлс тусгаарыг нэгэн хамт өгүүлэхээр Жамъянгаравын бичсэн жишээ:

Сэрүүн төгөлдрийн наадан баярлахын уулын үснирт дор

(Сэтгэл зохист) үзэсгэлэн лүгээ хамт нэгэн

Таны өлмийг оройдоо авсан

Усан сан сайтар арвижсан лугаа хамт нэгэн дор

(Угаас) миний сонсож гарсан оюун машид арвижив

(С.Жамъянгарав, 2011. т.109)

Сэрүүн төгөлдөр буюу саран уулын оройд мандан гийх нь үзэсгэлэнтэй лүгээ хамт багш тантай уулзан мөргөх ажгуу. Усан сан буюу далайн ус нэмэгдэх лүгээ хамт өөрийн оюун билэг ухаан арвижин нэмэгдмүй гэж саран тэргэл болох лугаа хамт далайн түрлэг нэмэгдэх эдгээр лүгээ зэрэгцэн үлгэрлэж багш лугаа уулзах цагт хамт нэг шавийн оюун ухаан нэмэгдэн мандахыг заан үзүүлжээ.

31.3. **Нэгэн үйлсийг хамт өгүүлэх** (тө: bya ba gcig pa'i lhan gcig brjod pa). Энэ нь нэгэн төрлийн үүрэг гүйцэтгэж чадах зүйлүүдийг хамт өгүүлэх арга. Хамт нэгнээ өгүүлэх чимгийн нэг зүйл. Дандин:

Сайн хувьт хөхөө шувууны донгодохуй ба

Сайн үнэрт ой модны хий хийгээд хаврын өдөр

Идэр төрөлхтний хамаг баясгаланг

Хамт нэгнээ арвитгах больюу

Энд хөхөө донгодох, сайхан үнэрт ойн үнэр, хаврын өдөр ирэх эдгээр бол бүгдээрээ бүхний сэтгэлийг баясгана гэж нэгэн төрлийн сайн үүрэг бүхий зүйлүүдийг хамт өгүүлжээ.

Гучин хоёр. **ОГООТ АРИЛЖИХ ЧИМЭГ** (ca: parivrtti, тө: yongs su rjes pa'i rgyan, хя: 交换修饰). Утгын 35 чимгийн 32 дахь чимэг. Дотроо 1 зүйл байна. Энэ нь өгүүлэгдэхүүний эрдэм үйлсийг нааш цааш сольж үзүүлдэг арга. Дандины жишээ

Газраа явагчдын хаадыг мэсээр тусган  
Өгөгч чиний гар нь  
Тэдгээрийн алдаршсан өнө үүрд бүтээсэн  
Цагаан гүмдааг<sup>47</sup> булаамуй.

энэ шүлэг нь баатар эр хааныг мэсээр даран сөнөөж, гараараа тэдэнд үхэл өгөөд тэдний алдрын цагаан лянхуаг гараараа булаасан болой гэж алдар эрдэм хоёрын солигдсоныг өгүүлжээ гэжээ. Тэгэхдээ утгуудыг солилцуулах буюу өгүүлэгдэхүүний эрдэм үйлсийг нааш цааш сольж үзүүлдэг энэ чимгийн арга зарчмаар баатар хүн хүчээ өгөөд хааны алдрыг нь солин авсныг өгүүлжээ.

Огоот арилжихын чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:  
Цог төгөлдөр багш бээр зарлиг шастирын увдисын оньсыг  
Цолт хоосон үгүй хувь төгөлдөр номхотгогдохуун дор номлосноор  
(Үнэн) хөвгүүн сэлт ялгуусны яруу алдар хийгээд  
Өнө эртнээс тухайлан бүтээсэн эрдмийн чуулган бүгдийг булаав  
(С.Жамъянгарав, 2011. т.109)

Энэ шүлэгт Өндөр гэгээн Занабазар тэргүүлэн Монголын номын багш нарын сэдвээр бичжээ. Цог төгөлдөр багш Жавзандамба нь бурханы шашны хамаг ном шастирын увдис оньсыг хувь төгөлдөр шавь нартаа номлосноор Ялгуусны хөвгүүний яруу алдар ном эрдмийн чуулган бүгдийг булаасан мэт болов гэжээ. Тэгэхлээр энэ жишээ шүлэг нь мөнхүү Ялгуусны хөвүүн буюу Бурхан Шагжалигийн ном эрдмийн чуулганыг шавь нартаа номлосны үрээр түүний алдрыг Жавзандамба огоот олж, ном эрдмийн арвин өв санг авсан мэт хэмээн өгүүлжээ.

Гучин гурав. **ӨЛЗИЙ ӨГҮҮЛЭХ ЧИМЭГ** (ca: āsih, тө: shis brjod pa'i rgyan, хя: 祝愿修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 33 дахь чимэг. Энэ чимэг нь сахих буюу бүтээхэд зэтгэр саадгүй байхыг хүсэх болой. Бахдах буюу өлзий өгүүлэх чимэг нь нэг зүйл байна. Өөрөөр

<sup>47</sup> Цагаан гүмдаа – энд энэ нь хураасан эд баялаг гэсэн утгатай байна

хэлбэл, аль нэг сайн сайхныг илт хүсэх бодыг сахин бодож, түүнийгээ бүтээхэд саад бүү учраг гэж ерөөх нь өлзий өгүүлсэн хэрэг юм. Өлзий өгүүлэх чимгээр Агваантүвдэний бичсэн жишээ:

Энэ мэт магтсанаар би хийгээд амьтан бүхэн  
Эргэх төрөл бүхэнд машид гарсан сайн шүтээнийг олоод  
Эгнэгт Гэтэлгэгч эхээр насад даган өршөөгдөж  
Ээрч түдэл үгүй бүхнийг айлдагчийн  
хутгийг олохын өлзийг хайрла  
(Сайн үгсийн сан. 1995. т.364)

Энд “Өлзий өгүүлэх” чимгийн зарчмаар Дара эхийг магтан шүлэглэхдээ энэ мэт магтсаны буянаар би хийгээд амьтан бүхэн төрөл бүхэндээ чөлөөт сайн шүтээнийг олоод, Гэтэлгэгч Дара эхээр насад даган өршөөгдөж, дээдийн хутгийг түргэнээ олохын өлзий хутгийг хүсэн ерөөсөн байна.

*Гучин дөрөв. МАШИД ХОЛЬЦОГЧ ЧИМЭГ* (ca: samkiranam, тө: rab spel gyi rgyan, хя: 间杂修饰). Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн 34 дэх чимэг. Энэ нь өмнө гарсан чимгүүдээс олон зүйл чимгийг хослон өгүүлж, хольж найруулж нэг утга гаргах арга. Үүнийг бас арвитгагч чимэг ч гэдэг. Машид хольцогч чимэг нь дотроо хоёр зүйл байна. Үүнд: 1. Нэгд нөгөө нь дулдуйдсан чимэг, 2. Хүч адилхныг хольцсон чимэг. Нэгд нөгөө дулдуйдсан чимэг нь аль нэг чимэг нь тэргүүлж, нөгөө чимгүүд нь гишүүн болж чимгүүдийн аль нэгийг нөгөөд нь түшиглүүлж найруулах арга. Хүч адилхныг хольцсон чимэг нь шүлэгт орох чимгүүд нь тэгш гишүүн байдалтай найруулагдана.

Машид хольцогч чимгээр Агваантүвдэний бичсэн жишээ:

Гайхамшигт лагшин найргийн цогоор  
сүр жавхлан үзэсгэлэнт лагшинт  
Гайхамшигт Гандирсын ятга мэт уянгат яруу зарлигт  
Гайхамшигт айлдал энэрлийн наран сарны  
гэгээн гэрлийг сацруулагч таалалт  
Гайхамшигт өлзий бадруулагч эхийн өлзий орших болтугай  
(Сайн үгсийн сан. 1995. т.364).

Энэ шүлэгт өвөр чанарыг өгүүлэх чимэг, үлгэрийн чимэг, дүрстийн чимэг гэсэн ийм гурван чимгийг хослон өгүүлжээ. Үүнд Гэтэлгэгч Дара

эхийн биеийг нь “лагшин найргийн цогоор сүр жавхлант” гэж өвөр чанарыг өгүүлэх чимгээр, зарлигийг нь “гандирсын ятга мэт уянгат” гэж үлгэрийн чимгээр, тааллыг нь “айлдал энэрлийн наран сарны гэгээн гэрлийг сацруулагч” гэж дүрстийн чимгээр найруулж, Дара эхийн бие, зарлиг, тааллын эрдмийг гурван чимгээр магтжээ.

34.1. **Нэгд нөгөө нь дулдуйдсан хольцогч чимэг.** Олон зүйл чимгийг хольж найруулахдаа аль нэг чимэг нь нөгөөдөө дулдуйдсан, аль нэг нь тэргүүлж бусад чимгээ дагуулсан байдалтай найруулах арга. Машид хольцогч чимгийн нэг зүйл. Энэ чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ:

(Өгүүлэхүй) утгын чимгийн нийт утгын галабингын эгшиг  
(Үнэн) яруу үг даяарыг нэгнээ хураасан  
Өгүүлэхүйн утга гурван мянгын эн хэмжээнээс хэтэрсэн тэр  
(Өтөл) миний(энүүхэн)оюунд багтаж орсон нь аяа гайхамшиг  
(С.Жамъянгарав. 2011. т.110)

34.2. **Хүч адилхныг хольцсон чимэг** (ca: anga, тө: dper brjod). Шүлэгт орж буй чимгүүд нь тэгш эрх бүхий найруулгатай байна. Машид хольцогч чимгийн нэг зүйл. Дандин:

Үзэсгэлэнт хүүхэн чиний нүүрийн цогийг  
Лянхуас бээр хориглон үйлдмүй  
Сан хийгээд иш хотол чуулсан  
Үүнээ үйлдэх бэрх юу нэгэн баймуй.

Энэ шүлэгт, адилтгалын чимгээс бүтсэн хоёр мөр, бус утгасыг байгуулах чимгээс бүтсэн нэг мөр, хуурмаглан магтах чимгээс бүтсэн нэг мөр оруулжээ. Шүлгийн анхны хоёр мөрөөр өгүүлэгдэхүүн үзэсгэлэнт хүүхэн чиний гишүүн нүүрийн цог үзэсгэлэн энэ гишүүнт лянхуа нугуудаар хориглож үйлдмүй хэмээсний далдуур адилтгагдахуун үзэсгэлэнт хүүхний царай лугаа адилтгал лянхуа ижлийг тодруулж үйлдсэнээр эхний хоёр мөр *адилтгалын чимэг*, мөн түүний бүтээгч сан хэмээн лянхуа түүнээ туурцаг болон хулсан иш хотол бүрэн байгаа учраас лянхуа түүнийг үзэсгэлэнт хүүхний нүүртэй тэнсэлдэн чадна хэмээн *бус утгасыг байгуулсан чимэг* хийгээд үзэсгэлэнт хүүхний нүүр үүнд лянхуа бээр тэнсэлдэн чадахад бэрх юу байх билээ, байхгүй шүү дээ хэмээн лянхуаг хуурмагаар магтах *хуурмагаар магтах чимэг* ийм



гурван чимгийг нэг дор нэг утгыг өгүүлэх үүднээс найруулжээ.

Гучин тав. **ТААЛАЛТЫН ЧИМЭГ** (ca: bhavikam, тө: dgongs pa can gyi rgyan, хя: 完满修饰). Утгын 35 чимгийн сүүлийнх буюу 35 дахь чимэг. Энэ нь зохист аялгуучин анх зохиол бүтээл туурвиж эхэлснээс бүрэн төгсөх хүртэл юу өгүүлэхээр сэдэж санаж хадгалж бодсон тэр бодлын илэрцийг “Таалалтын чимэг” хэмээн нэрлэжээ. Дандин:

Зохист аялгуучны сэтгэснийг **таалал** хэмээн хэлмүй  
Зохист аялгуу бүтэх инар алин оршсон  
Чимгийн орноо буй эрдэмтэн  
Түүнийг **таалалт** хэмээн өгүүлмүй – хэмээн тодорхойлжээ.

Энд таалал, таалалт хэмээх хоёр ойлголт байна. Зохист аялгуучин тэрбээр өгүүлэгдэхүүн түүнийг өгүүлэх ёс, зохист аялгууны чимэг аль байдлаар өгүүлэхийг хүссэн бодол буюу санааны үргэлжлэл түүнийг “**таалал**” хэмээж байна. Өөрөөр хэлбэл, таалал хэмээхийг нь бодол, санаа, онгод, хөглөл, төлөвлөгөө ч гэж хэлж болно.

Зохист аялгууг туурвихаас эхлээд төгсгөлийг бүтээж дуусах хүртэлх туурвих санаа анхан, дунд, эцэс гуравт орших чимгүүд мөн шастирын бие, шүлэглэсэн, үргэлжилсэн, хавсарсан алин ч болох, үгс тэдгээрээр өгүүлэх ёс, сэтгэлд зохистой дүр байдал төгөлдөр бүтээх энэ бүхэн нь таалалтын чимэг болно. Өөрөөр хэлбэл, зохист аялгуучин бээр сонин гайхамшигт чимэг чанар бүхий туурвилыг оюун санаандаа бодож олоод бүтээж гаргасан тэр үр дүнг “**таалалт**” гэж байна.

Өөрөөр хэлбэл, найрагчийн сэтгэл яруу найраг бүтээх гэж эхлэх нь таалал. Яруу найраг бүтээж дуусгах хүртэл бүх үеийн турш дахь санаа нь чимгийн шалтгаан юм. Яруу найргаа сайтар найруулаад шүлэг, үргэлжилсэн үг, салаавчилсан болон урьдах бүх чимгийн утгыг хурааж өгүүлсэн нь таалалт болно.

**Таалалтын чимгийн дөрвөн онцлог.** Зохист аялгуучны өгүүлэхийг хүссэн санаа бодлоос үүдэлтэйгээр өгүүлэгдэх ёс сэтгэлд нийцтэй, тансаг чимгийг хэр зохисоор оруулсан буюу бүтээсэн таалалт үүнд ямар мэт эрдэм байна гэвэл нэн олон хэдий ч товчлон хураавал дөрвөн зүйл онцлог байна.

Нэгд, Зохиолын буюу өгүүлэгч үгсийн зүйлс нь яруу тансаг байхаас гадна хоорондоо холбоо барилдлагатай байх бөгөөд нэг үг нь нөгөө

үгээ дэмжиж буюу утга санаагаа тодруулж байх үүрэгтэй. Хэрэв нэгэн бадгийн дотор буюу нэгэн хэсгийн доторх үгс нь хоорондоо холбоо барилдлагагүй болбол, найруулгын арван зүйл гэмийн анхдугаар утгыг доройтуулах гэм болох учраас тэвчих хэрэгтэй хэмээжээ.

*Хоёрт*, Зохиолынхоо утгыг тодотгож өгөхдөө тухайн үед огт хэрэггүй, үе цаг нь тохироогүй олон үгсээр булингартуулаагүй, утга бүрэн төгс байж, тухайн нөхцөлд нийцсэн зохимжит үг найруулгаар бичих ёстой.

*Гуравт*, Өгүүлэгдэхүүний буюу зохиолын доторх дүрийн онцлог чадлыг тодорхойлсон хүчтэй үгсийг гаргаж ирэх хэрэгтэй.

*Дөрөвт*, Тухайн утгыг гаргаж ирэх үгс нь найруулга тодорхой, ойлгоход энгийн байх хэрэгтэй юм.

Ийн өөрийн өгүүлэхийг зорьсон утгасыг дээрх дөрвөн зүйлээр эвлэг сайхан найруулан гаргаж тов тодорхой сэтгэлд буутал илтгэн харуулж, зохиолын бүхүй л үед гаргаж ирэхийг “Таалалт” хэмээх ажээ. Тиймээс энэхүү **“Таалалт”-ын чимэг** нь бүх чимгүүдийг ургуулан гаргах уг орон мөний тулд **“Зохист аялгуу”-ны нийт чимгийн гол амин мод мөн** хэмээн үздэг байна.

Таалалтын чимгээр тусгай жишээ шүлэг бичих хэрэгтэй, бичих шаардлагагүй гэсэн хоёр үзэл байдаг. Учир нь зохист аялгууг эхэлсэн цагаас дуусах хүртэлх бүх шүлгийн дотор энэхүү таалалтын чимэг явж байгаа учраас тусгайлан жишээ бичих хэрэггүй юм гэж зарим нь үздэг бол, Агваанлувсанжамц тэргүүтэй зарим зохист аялгуучид тусгаар шүлэг бичих хэрэгтэй гэж үзжээ. Таалалтын чимгээр Агваанлувсанжамцын зохиосон шүлэг:

Тунгалаг толь лугаа ижил толийн<sup>48</sup> гол ёсоос  
Торолтгүй мэргэдийн номлосон мэт мэргэний хутгийг  
Тодорхой ил болгохын тулд л илэрхий болохын омгийг  
Туйлаас тэвчиж буруу бодлыг тэвчээд туурвисан нь энэ болмуй  
(Агваанлувсанжамц)

гэж ихээс ихэд дүрсийг тодруулагч толь лугаа адил “Зохист аялгууны толь”-ийн гол утга үүнийг урьдын эрдэмтэн мэргэд болон өнөө цагийн эрдэмтдийн алдаа гажуугүй өгүүлэл номлолоор тодруулж бичсэн “Зохист аялгуу Сарасватийг баясгах эгшиг дуун” хэмээгдэх

<sup>48</sup> Толийн: Дандины Зохист аялгууны толь.

үүнийг нь **оюун төгс нарт** ухааны орон бүхнээ судалж, чанадад хүрсэн мэргэний хутаг зэргэмжийг өмнөө илт болгохын тулд буюу олохын тулд зориулж, мөнхүү өөрөө нэр цол, яруу алдрыг хүсэх санаа болоод туурвил зохиолдоо омгорхон бардах санаа тэргүүтэй буруу атгаг муу бодлыг бүгдийг тэвчээд, хамаг ардад туслахын эгээрэл горилоор “Зохист аялгуу”-ны утгыг тайлсан энэ шастирыг бичлээ хэмээн анх энэ зохиолоо бичихээс авахуулаад алинхүү одоо төгсгөж буй энэ хүртэлх хугацаанд баримталж байсан үзэл бодол, тааллаа илэрхийлсэн байна.

### Дууны чимэг

**Дууны чимэг** (ca: śabdalamkāra, тө: sgra rgyan, мо: daṅun-u ċimeg, üge-yin ċimeg) хэмээх нь Дандины “Зохист аялгууны толь”-ийн гуравдугаар бүлэг буюу **үгийн чимэг** юм. Энэ III бүлгийн 187 бадаг шүлгийн утга нь зөв найруулан туурвихын тухай юм. Үүнд дууны буюу үгийн чимгийн мөн чанар жишээ тэргүүтнийг өгүүлж, зохиогч нь хэлэх гэсэн санаагаа хэрхэн зөв оновчтой найруулах эрдмийг өгүүлжээ. Ингэхдээ зөв уран найруулах эрдмээ утга уянга хэмнэл төгсийг эрхэмлэх “Хос төгөлдөр чимэг”, үг утгыг нуух “Далдлахуй үгс”-ийн 16 чимэг, зөв найруулгыг алдагдуулж болох “Найруулгын арван гэм” гэсэн гурван том зүйлээр, түүнээ дотор нь мөн тусгай жижиг зүйлээр зүлзгалуулан салаалуулж авч үзжээ.

“Зохист аялгууны толь”-ийн III бүлгийн 1-77 дугаар бадагт “Хос төгөлдөр” чимгийн тухай, 78-82 дугаар бадагт “Үйлдэхүйеэ бэрх бусад ялгал”-ын тухай, 83-95 дугаар бадагт “Эгшиг тэргүүтнийг магадлахуй ялгал”-ын тухай, 69-124 дүгээр бадагт “Далдлах үгс”-ийн 16 чимэг, 125-185 дугаар бадагт “найруулгын арван гэм”-ийг үзүүлжээ. Үүний “Хос төгөлдөр”, “Эгшиг тэргүүтнийг магадлах”, “Далдлах үг”-ийн чимгүүд нь Зохист аялгууг яруу тансаг болгоход юуг анхаарвал зохихыг, “Найруулгын арван гэм”-д зохист аялгууг зохисгүй болгодог гэмүүдийн тухай өгүүлжээ.

Нэг. **ХОС ТӨГӨЛДӨР ЧИМЭГ**<sup>49</sup> (ca: yamaka, тө: zung ldan) нь утгын хувьд ялгаатай, дуудлага ойролцоо үе буюу үгсийг бадаг шүлгийн дотор нэг дор буюу эсвэл өөр өөр газарт дахин давтаж найруулах арга. Өөрөөр хэлбэл үе буюу үгийг давтах арга.

Хос төгөлдөр чимэг нь эс завсардсан болон завсардсан байдлаар шүлгийн нэгэн мөрийн эхэнд, дунд, адагт мөн шүлгийн дотор заавал нэг мөрт хэмээлгүй мөр хооронд ер нь хаана ч тохиолдож болно. Хос төгөлдөр чимэг нь дотроо олон зүйлд задардаг. Дандин Зохист аялгууны тольдоо 15 зүйлээр жишээлэн өгүүлжээ. Хос төгөлдөр чимгийг бүтээх хэдэн үндсэн арга байна.

1. Ижил нэр, үг, үеийг давтах. Энэ нь хэлбэр, бичлэг ижил буюу ойролцоо, адилхан дуудагддаг боловч утга өөр үгс болно.

2. Тухайн нэгэн үгийн өмнө хойно нь орсон үгсийн эхний буюу эцсийн үе, үгсийн оролцоотойгоор зориудын ижил үг үүсгэх.

3. Тухайн нэг үгтэй ижилсэх өөр нэг үгийг хоёр үгийн эх төгсгөлийн үсэг буюу үеийн оролцоотойгоор бүтээнэ.

4. Тухайн нэг үгийн эхний буюу эцсийн үе болон утгат хэсэг нь өөр нэг үгтэй адил болсон байх.

“Хос төгөлдөр чимэг”-ээр шүлэг зохиол бичиж туурвиж байсан монгол зохист аялгуучид олон байжээ. Алшаа лхарамба хэмээн алдаршсан Агваандандарын нэг шүлгээр жишээ өгүүлье.

Авралт гурван эрдэнэ<sup>50</sup> бүгд өөрөө хурсан тул  
Аврал эгээрлийг бусдаас эрэхийг огоот тавиад<sup>51</sup>  
Авралт нэгэн дээд багш танд л  
Аврал одуулмуй, энэрэн тэтгэнэ үү (Агваандандар, 1b)<sup>52</sup>

Энэ шүлэгт “Аврал” гэдэг үгийг дөрвөн хөлийн эхэнд давтаж, монгол шүлгийн толгой холбох аргаар найруулжээ. Тэгэхдээ “аврал” гэдэг үг нь зөвхөн толгой холбож тэгшлэхэд төдий бус тухайн мөрийнхөө гол утгыг тодруулах үүргээр “авралт гурван эрдэнэ”, “аврал

<sup>49</sup> Хос төгөлдөр, Үйлдэхүйеэ бэрх бусад ялгал -“Дандины Зохист аялгууны толийн гол нэр утгын тайлбар”. Хамтын бүтээл. 2017. т.241-288)-ыг докторант Б.Лхагважав хийсэн. Үүнээс товчлон эшлэж авав

<sup>50</sup> Гурван эрдэнэ - Гурван эрдэнэ – Гончигсум (ca: triratna, тө: dkon mchog gsum). Чухаг дээд гурав. Бурхан (ca: buddha тө: sangs rgyas), ном (ca: dharma тө: chos), бурсан хувраг (ca: sangha тө: dge 'dun)

<sup>51</sup> Огоот тавиад – гэдэг нь болиод, орхиод гэсэн утгаар оржээ.

<sup>52</sup> Энэ шүлгийг Агваандандарын “Номлол хэлцэл туурвил гурвын тийн агуулга сайн номлолт нарны гэрэл” (‘chad rtsod rtsom gsum gyi mnam gzhag legs bshad nyin byed snang ba zhes bya ba bzhuugs so) номоос авав.

эгээрэл”, “авралт багш”, “аврал одуулмуй” гэж орсон нь хос төгөлдөр чимгийн жишээ болж байна. Энэ мэт найруулгыг “Зохист аялгууны толь”-д “Хос төгөлдөр чимэг дөрвөн хөлийн эхэнд завсардсан” гэж хэлнэ.

1.1. **ЭС ЗАВСАРДСАН хос төгөлдөр чимэг** (ca: avyapeta, тө: bar mo chod). Энэ нь давтаж байгаа хоёр үг болон үеийн дунд өөр үг оруулахгүйгээр дараалуулан холбон бичиж давтах арга. Санскрит болон төвдийн хэлнээ үеэр давтах арга нэлээд түгээмэл. Монголын хэлнээ ч мөн үг давтах арга нь түгээмэл дэлгэрчээ. Жишээ нь:

Нар аа! нар аа! наашаан

Сүүдэр сүүдэр цаашаан

(М.Цэдэндорж. 1988. т.106)

Энд, нар аа!, сүүдэр гэх үгсийг дараалуулан давтсан нь эс завсардсан хос төгөлдөр чимэг болж байгаа бөгөөд энэ нь уг шүлгийн гол санаа болох нартай тунгалаг, сүүдэргүй дулаан байхыг хүссэн утгыг тодруулж өгч байна.

**Хос төгөлдөр чимэг хөлийн тэргүүнд эс завсардсан.** Энэ нь бадаг шүлгийн мөрийн тэргүүнд ойролцоо дуудлагатай үе болоод үгийг давтах арга. Ингэхдээ давтаж буй үг болоод үеийн хооронд ямар нэг үг өгүүлбэр огт орохгүй шууд давтана. Үүнийг Дандин бээр 15 зүйл хэлбэрээр жишээлэн үзүүлжээ.

**Хос төгөлдөр чимэг тэргүүн хөлийн эхэнд эс завсардсан** (тө: rkang ba dang po'i thog ma na yod ra). Адил буюу ойролцоо дуудлагатай үе болон үгсийг мөрийн эхэнд завсаргүй давтах арга. Үүнд тохирох монгол шүлгийн Жишээ нь:

Уужран уужран цэлмэн цэлийн цэнхэртээд

Уран найраг ухаан тэлэн жигүүрлэмээр

(Л.Дагвадорж. Миний нутаг сайхан)

хэмээсний “уужран уужран” хэмээсэн нь тэргүүн хөлийн эхэнд эс завсардсан хос төгөлдөр чимэг болно.

**Хос төгөлдөр чимэг хоёрдугаар хөлийн эхэнд эс завсардсан** (тө: rkang ba gnyis pa'i thog ma na yod ra). Хоёр дахь мөрийн эхэнд адил дуудлагатай үг болоод үе эс завсардан орж давтах арга. Цахар гэвш Лувсанчүлтэмийн нэгэн шүлгээр жишээ өгүүлье.

Үлгэр лагшны үзэгдэл барагдашгүй гайхамшиг  
Үзэсгэлэн үзэсгэлэн идэр цог нэгэнд хурсан  
Урьд байгаагүй удирдагч баяр хуримт  
Хэлний эрхэт охин тэнгэр мөргөлийн орон  
(Ч.Алтангэрэл, 1967. т.19)

хэмээсний "үзэсгэлэн үзэсгэлэн" хэмээсэн нь хоёрдугаар хөлийн эс завсардсан хос төгөлдөр чимэг болно.

**Хос төгөлдөр чимэг гурав дахь хөлийн тэргүүнд эс завсардсан** (тө: rkaṅ ba gsum pa'i thog ma na yod pa). Энэ нь III мөрийн эхэнд адил дуудлагат үе үгийг давтах арга байна. Энэ чимгээр Агваандандарын бичсэн шүлэг:

Их нигүүлсэнгүй сэтгэлээр өргөсөн дашрамаар  
Дээд доод бүхэнд алагчлал үгүйд  
Яруу яруу номлолын үг нийлүүлэх нь  
Хувь төгөлдөр хотол баясгалангийн баяр  
(Агваандандар 23a-24b)<sup>53</sup>

Энэ шүлэгт “яруу” хэмээх үгийг гуравдугаар мөрийн тэргүүнд давтжээ. Учир нь энэ яруу хэмээх үг нь номлолын утга агуулгыг илүү тодруулах үүднээс юм. Шүлгийн агуулга нь дээд доодгүй бүхэнд алагчаалалгүй нигүүлсэнгүй сэтгэлээр их яруу номлолыг нийлүүлэх нь хувь төгөлдөр бөгөөд хотол их баяр баясгалан юм гэсний гол мөн чанар нь номлолыг нийлүүлэхэд оршиж байна. Тиймээс тэр номлол нь яруу болж байна.

**Хос төгөлдөр чимэг дөрөвдүгээр хөлийн тэргүүнд эс завсардсан** (тө: rkaṅ ba bzhi pa'i thog ma na yod pa). Энэ нь бадаг шүлгийн сүүлчийн мөрийн толгой үг буюу үеийг давтах арга. Үүнийг монгол шүлгээр жишээ өгүүлбэл:

Хар-Ус нуурын шагшуурга  
Намрын салхинд исгэрнэ  
Харахад нэг л уйтгартай  
Намс намс бөхөлзөнө  
(Б.Явуухулан. 1985. т.295)

Энэ шүлгийн IV мөр дэх “намс намс” хэмээх үг нь IV хөлийн эхэнд

<sup>53</sup> Үүнээс хойших жишээ татсан Агваандандарын шүлгүүдийг “Зохист аялгууны толийн гурван бүлгийн жишээ өгүүлэл оюун тодорхойн хоолойн чимэг үзэсгэлэнт сувд эрх” зохиолоос авсан болно.

эс завсардсан хос төгөлдөр чимэг болж байна. Намс намс гэх үг нь уг бадгийн үндсэн утга болох намрын байдлыг өгүүлэхэд гол үүрэг болжээ. Ингэхдээ салхинд бөхөлзөх зэгс шагшуурганы нэгд, үйл хөдлөлийн байдлыг хоёрт, ерөөсөө зөөлөн уян хийгээд их өндөрт цоролзон дүрэлзэх бус намдуу байдал намбыг өгүүлжээ.

**Хос төгөлдөр чимэг эхний хоёр хөлийн тэргүүнд эс завсардсан** (тө: rkang ba dang po gnyis kyi thog ma na yod pa). Адил дуудлагатай үг болоод үеийг шүлгийн нэг ба хоёр дахь мөрийн эхэнд эн зэрэгцүүлэн давтах арга. Энэ давтах арга нь монгол шүлэгт элбэг байдаг. Цахар гэвшийн жишээнд:

Бас бас хичээнгүйн салхиар сургагдаад  
Алгуур алгуур энэтхэгийн эрдэмтдийг шүтэхийн тул  
Зориглон амт үнэрээр нь огоот зорчсон  
Хэлмэрч Бан багшид ухаант хэн үл сүсэглэх

(Ч.Алтангэрэл, 1967. т.19)

Үүний I хөлийн эхэнд “бас бас”, II хөлийн эхэнд “алгуур алгуур” гэсэн үгийг эс завсардуулан давтан хэрэглэжээ.

**Хос төгөлдөр чимэг нэг болон гуравдугаар хөлийн эхэнд эс завсардсан** (тө: rkang ba dang po dang gsum pa'i thog ma na yod pa). Бадаг шүлгийн I болон III мөрийн эхний үгийг давтах арга. Ийм жишээ монгол шүлэгт ихээхэн түгээмэл тохиолдоно. Жишээлбэл:

Гурий гурий дууджээ  
Гурван удаа дууджээ  
Дүүрий дүүрий дууджээ  
Дөрвөн удаа дууджээ (Т.Баясгалан. 2008. т.164)

хэмээсний I хөлийн “гурий гурий”, III хөлийн “дүүрий дүүрий” нь эс завсардсан хос төгөлдөр чимэг болно. Энэ нь гурий гэж дуудах байдлаа тодруулж өгсөн төдийгүй гурий, дүүрий гэдэг үгийг давтсанаар шүлгийн үеийг тэгш болгож эгшиглэнтэй айзам хэмнэлтэй болж байна.

**Хос төгөлдөр чимэг нэг болон дөрөвдүгээр мөрийн эхэнд эс завсардсан** (тө: rkang ba dang po dang bzhi pa'i thog ma na yod pa). Бадаг шүлгийн эхний болоод сүүлийн мөрийн эхэнд адил дуудлагат үе үгийг давтах арга. Энэ чимгээр Агваандандар лхаарамбын зохиосон жишээ шүлэгт:

Хүр хүр дуугарах луун дуу лугаа  
Адил дуугарсан чанга үгээр  
Бүхүй л сэтгэлийг ханган үйлдэгч энэ нь  
Чим чим дуслах хур лугаа тэнсмүй

(Агваандандар, 23b)

Агваандандарын энэ шүлгийн эхний мөрийн эхэнд “хүр хүр”, дөрөв дэх мөрийн эхэнд “чим чим” хэмээх үгсийг эс завсардан давтжээ. Энд “хүр хүр” гэх нь луун дуугийн үргэлжлэн нүргэлэн дуугарах дууны байдлыг өгүүлж, хур борооны дуслын дахин дахин давтах байдлыг “чим чим” дуслах гэж тодруулан өгчээ. Ийн луун дуун мэт зарлиг нь бүхний сэтгэлийг хангахдаа хурын дусал мэт, гэхдээ үргэлжлэн бага багаар нэмэгдэн далай болох мэт юм гэжээ.

**Хос төгөлдөр чимэг хоёр болон гуравдугаар хөлийн эхэнд эс завсардсан** (тө: rkang ba gnyis pa dang gsum pa'i thog ma na yod pa). Энэ нь бадаг шүлгийн II болон III мөрийн эхэнд орсон үгийг давтан хэрэглэх арга. Энэ нь монгол яруу найрагт нэлээд түгээмэл бадгийн дундах хоёр мөрийн толгойг эн зэрэгцүүлэн холбоод, холбосон үгээ давтах арга байна. Энэ чимгээр Агваандандар лхаарамбын зохиосон жишээнд:

Орчлонгийн урвагч няцагч үзмэрүүд нь  
Үйл, үйлийн үр гарсны ёсоор болой  
Эндүүрэл, эндүүрэлгүйд үзэх чи бээр  
Энэ хойтод аврал одуулбал зохистой

(Агваандандар, 23b)

Энэ шүлгийн хоёр болон гуравдугаар хөлийн эхнээ буй “үйл, үйл”, “эндүүрэл, эндүүрэл” гэсэн үгс нь эс завсардсан хос төгөлдөр чимэг болж байна. Орчлон ертөнц амьдралын урваж хөрвөх энэ олон үйл явдал нь үйл үрийн шалтгаанаар болж буй гэдэг санааг тодруулахдаа “үйл үйл” гэж давтан хүч оруулж байна. Ингээд үүнийг эндүүрэлгүй үзэж энэ болоод хойтод аврал одуулах чухлыг өгүүлэхдээ “эндүүрэл, эндүүрэлгүй” гэж давтан тодруулжээ.

**Хос төгөлдөр чимэг хоёр ба дөрөвдүгээр хөлийн тэргүүнд эс завсардсан** (тө: rkang ba gnyis pa dang bzhi pa'i thog ma na yod pa). Энэ нь тухайн бадаг шүлгийн хоёр болоод сүүлчийн мөрийн эхний үгийг давтах арга. Энэ нь монгол шүлгийн салаавчлан холбох аргатай ойролцоо. Энэ чимгээр Агваандандар лхаарамбын зохиосон жишээ:



Өнө эртнээс зуурдад төөрсөн намайг  
Сайн сайны замд хөтлөхийн тулд  
Багш таны өлмийд цаг үргэлжид  
Сүслэн сүслэн биширснээр яахин үл барах  
(Агваандандар, 23b)

Шүлгийн хоёр болон дөрөвдүгээр хөлд буй “сайн сайн”, “сүслэн сүслэн” хэмээсэн үгс нь эс завсардсан хос төгөлдөр чимэг болой. Энэ шүлэгт сайнаас сайн замд баттай хөтлөх учраас л багшид холбиrolтгүй нэгэн үзүүрт чин сэтгэлээр бишрэхээс өөр аргагүй гэдгээ тодруулж буйгаа сүслэн сүслэн гэж давтан өгүүлж байна.

**Хос төгөлдөр чимэг гурав, дөрөвдүгээр хөлийн тэргүүнд эс завсардсан** (тө: rkaṅ ba gsum pa dang bzhi pa'i thog ma na yod pa). Энэ нь бадаг шүлгийн сүүлийн хоёр мөрийн эхний үгийг давтах арга байна. Энэ нь монгол шүлгийн эн зэрэгцүүлэн давтах аргатай ойролцоо. Дандины зохиосон жишээ:

Үзэсгэлэнт шинэ гишүүн навчит  
Галбарваасан модноо татагдсан залуусыг  
Лянхуад илтэд зүглэгч зөгийс-бээр  
Нүднээс барьж ирүүлмүй.

Шүлгийн санскрит эхэд гурав, дөрөвдүгээр хөлд хос төгөлдөр чимэг эс завсардаж орсон байгаа. Гуравдугаар хөл дэх taruna (мод), tarunā (залуус), дөрөвдүгээр хөлд krshtān (татагдсан) гэдгийн эцсийн n-нь ар дахь alino (зөгий)-тай нийлж nalino болоод үүнтэй nalino (лянхуа) гэсэн үг ижилсэн давтагдсан байгаа. Монгол орчуулгаас харагдахгүй байгаа.

**Хос төгөлдөр чимэг эхний гурван хөлд эс завсардсан** (тө: rkaṅ ba dang po gsum ka'i thog ma na yod pa). Бадаг шүлгийн эхний гурван мөрийн толгойн үг ба үеийг давтах арга. Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ шүлэг:

Аюулт аюулт орчлонгийн их далай мэт  
Мэлтэлзэн мэлтэлзэх зовлон алины дунд  
Уйтгарлах, уйтгарлахгүйгээр орших мэт  
Бусад хэрэг ямарчлан сэтгэснээр болох  
(Агваандандар, 24a).

Шүлгийн эхний гурван хөл дэх “аюулт аюулт”, “мэлтэлзэн

мэлтэлзэн”, “уйтгар уйтгар” гэсэн үгс нь эс завсардсан хос төгөлдөр чимэг болно. Орчлон нь ямар их “аюулт” болох, түүний зовлон нь хярхаг хязгааргүй далайн эн мэт их болохыг “мэлтэлзэн мэлтэлзэх” гэж дүрсэлжээ. Тийм аюулт, хярхаг хязгааргүй зовлонтын дунд огт уйтгарлахгүй орших болохыг тодруулахдаа “уйтгарлах уйтгарлахгүй” гэж давтжээ.

**Хос төгөлдөр чимэг нэг ба хоёр хийгээд дөрөвдүгээр хөлд эс завсардсан** (тө: rkang ba snga ma gnyis dang bzhi pa'i thog ma na yod pa). Энэ чимгээр Агваандандар лхаарамбын зохиосон жишээ:

Муруй муруй замд төөрсөн хөгшин эх нүгүүд  
Бас бас зовлон амсахын ёст  
Хүлцэнгүй, нигүүлсэнгүй эх бээр  
Алжаал алжаалыг умартан хөтлөх энэ гайхамшиг  
(Агваандандар, 24а)

Шүлгийн нэг, хоёр болон дөрөвдүгээр хөлийн эхнээ буй “муруй муруй”, “бас бас”, “алжаал алжаал” гэсэн үгс нь эс завсардсан хос төгөлдөр чимэг үүсгэжээ.

**Хос төгөлдөр чимэг нэг, гурав, дөрөвдүгээр хөлд эс завсардсан** (тө: rkang ba phyi ma gnyis dang dang po na yod pa). Энэ нь адил буюу ойролцоо дуудлага үе, үгсийг нэг болон гурав, дөрөв дэх мөрөнд давтах арга. Энэ чимэгт нийцүүлэн Агваандандар лхаарамба жишээ шүлэг зохиосон байна.

Дэлхий, дэлхийн адил ертөнц нүгүүд  
Нэгэн агшинд хөдлөх болсны тул  
Гайхамшиг гайхамшигт үзмэрт сэтгэлээ үл алгасан  
Бас бас номлон магадлахад сонс  
(Агваандандар, 24а)

Шүлгийн нэг, гурав болон дөрөвдүгээр хөл дэх “дэлхий, дэлхий”, “гайхамшиг гайхамшиг”, “бас бас” хэмээсэн үгс нь эс завсардсан хос төгөлдөр чимэг үүсгэжээ.

**Хос төгөлдөр чимэг хоёр, гурав, дөрөвдүгээр хөлийн тэргүүнд эс завсардсан** (тө: rkang ba phyi ma gsum pa'i thog ma na yod pa). Энэ нь чимэг болох үе, үгийг бадаг шүлгийн сүүлийн гурван мөрийн эхэнд давтах арга. Дандины жишээ:

Чиний нүүр намайг ялгах бөгөөс

Усны чимэг болсон үг үгүй.  
Зөгий бүхүй навчит лянхуа нь  
Хэрхэн үл ялганам, баясгагч эх мину.

Шүлгийн хоёр, гурав, дөрөвдүгээр хөлийн эхэнд хос төгөлдөр чимэг эс завсардан орсон нь санскрит эхдээ харагдана. Хоёрдугаар хөлд *asmanakatham na katham jitam*, гуравдугаар хөлд *kamalam kamalam*, дөрөвдүгээр хөлд *kurvadalimaddalamatpriye* гэсэн хос төгөлдөр чимгүүд орсон байна.

**Хос төгөлдөр чимэг дөрвөн хөл тус бүрийн тэргүүнд эс завсардсан** (тө: *rkang ba bzhi ka'i thog ma na yod pa*). Бадаг шүлгийн дөрвөн мөрийн эхний толгой үгийг давтах арга. Энэ чимэгт тохируулан Агваандандар лхаарамбын зохиосон шүлэгт:

Гүн гүн шүтэж гарсан хоосны утга  
Бэрх бэрх боловч итгэлт чи бээр  
Аядуу аядуу номлолоор дохио учруулах цагийг  
Мэргэн мэргэн зарим нэгэн ухах ч болно

(Агваандандар, 24а).

Шүлгийн хөл тус бүрийн эхнээ буй “гүн гүн”, “бэрх бэрх”, аядуу аядуу”, “мэргэн мэргэн” хэмээсэн үгс нь дөрвөн хөлийн тэргүүнээ буй эс завсардсан хос төгөлдөр чимгийг үүсгэжээ.

1.2. **ЗАВСАРДСАН хос төгөлдөр чимэг** (са: *vyapeta*, тө: *chod pa'i zung ldan*). Энэ нь чимэг болж буй үгийг шүлгийн хөлийн<sup>54</sup> эхэн, дунд, адаг аль нэг газарт тасалдалтайгаар буюу өөр газар давтан хэрэглэх арга. Өөрөөр хэлбэл давтан хэрэглэх үг болон үеийн дунд өөр үг, үе орох эсвээс хоёр хөлд давтан хэрэглэх нь завсардсан чанарт болно. Жишээ нь:

*Ай нар аа!, алтан нар аа!*

гэхэд “нар аа” гэдэг хоёр үгийн дунд “алтан” хэмээх үг орсон нь завсардсан хос төгөлдрийн жишээ болж байна. Нар аа гэх үгийн дунд “алтан” гэх үг найруулахын учир нь наранд хандах яруу хандлыг тодруулахын тулд Ай нар аа! гэж нэг дуудаад, ахиад Алтан нар аа! гэж

<sup>54</sup> Хөл – шүлгийн хөл (са: *pada*, тө: *rkan*). Санскритын нэгэн мөр шүлгийн тэн хагас буюу нэг шад болно. Санскритын хоёр мөр шүлэг нь дөрвөн хөлөөс бүтэх бөгөөд тэр нь монгол, төвдийн нэг бадагтай ойролцоо юм. Санскритын хоёр мөр шүлгийг бадаг гэж нэрлэдэггүй, шүлэг (*loka*) гэж нэрлэдэг.

бас арай өөрөөр яруу хандан өгүүлжээ.

**Хос төгөлдөр чимэг хөлийн тэргүүнд завсардан орсон чимэг.** Энэ нь хос төгөлдөр чимэг шүлгийн бадгийн мөрүүдийн тэргүүнд хоорондоо үг өгүүлбэр үеэр завсардсан байдалтай орох найруулгын арга. Үүнийг Дандин бээр 13 зүйлээр үзүүлжээ.

**Хос төгөлдөр чимэг анхны хоёр хөлийн тэргүүнд завсардсан** (тө: rkang ba dang po gnyis kyi thog ma na yod pa). Утгыг тодруулагч чимэг болох ойролцоо утгат үг ба үеэ эхний хоёр хөлийн тэргүүнд давтах арга. Энэ нь чимэг болох ойролцоо дуудлагат үгс нь заавал дараалан оролгүй дундаа үг өгүүлбэр оруулж утгаа тод илэрхийлэх арга. Цахар гэвш Лувсанчүлтэмийн энэ чимгээр бичсэн жишээ:

Оюун илт дэлгэрсний тийн ажиглалаар  
Оюун ихтэй гэж алдаршсан сайн хувилгагч  
Олонд дээрэнгүйг булаах алдартын эгшиг  
Сансрын оройд цууриатсан нь аяа гайхамшиг

(Ч.Алтангэрэл, 1967. т.21)

хэмээсний эхний хоёр хөлийн тэргүүнд буй “оюун” хэмээх нь эхний хоёр шадын тэргүүнд орсон завсардсан хос төгөлдөр чимэг болно.

**Хос төгөлдөр чимэг нэг ба гутгаар хөлийн тэргүүнд завсардсан** (тө: rkang ba dang po gsum pa'i thog ma na yod pa). Чимэг болох ойролцоо дуудлагат үг ба үеэ нэг ба гурав дахь хөлийн тэргүүнд салаавчлан орж давтаж утгаа тод томруулан илтгэх арга. Үүнийг Цогт хун тайжийн шүлгээр жишээ өгүүлбэл:

Дээр тэнгэр ханы аху хийгээд  
Дэлхий дэх хан богдсон аху газар хийгээд  
Дээр дорын ялгал болбоос бээр  
Жаргал хайрлал хоёрын агаар нэгэн буй

(Сайн үгсийн сан. 1995. т.38)

хэмээх мэт бөгөөд нэг болон гуравдугаар хөлийн эхний “дээр” хэмээх үгс нь нэг болон гуравдугаар хөлийн эхний завсардсан хос төгөлдөр чимэг болно.

**Хос төгөлдөр чимэг нэг болон дөрөвдүгээр хөлийн тэргүүнд завсардсан** (тө: rkang ba dang po dang bzhi pa'i thog ma na yod pa). Шүлгийн гол утга чимэг болох ойролцоо дуудлагат үг буюу үеэ бадаг

шүлгийнхээ эхний болоод болоод сүүлийн хөлийн тэргүүнд давтаж санаа утгаа илэрхийлэх арга. Энэ чимэгт дүйх монгол шүлэг олон бөгөөд Саган сэцэний “Авах гээхийн сургаал шүлэг” хэмээх шүлгийн нэгэн бадгаар жишээлэн өгүүлье.

Сурахыг таалагчин нэгэн хэдэн дүүнэр хүүхэд  
Сургаал болгон сайн, муу, хольцонгуй гурван  
Суртахуй явдлыг шүлэгт холбон бичтүгэй  
Сурах оюунд авсугай хэмээсэнд шүтэж ийн

(Сайн үгсийн сан. 1995. т.62)

хэмээн шүлэглэсний нэг болон дөрөвдүгээр хөлийн эхэнд буй “сурах” хэмээх үг нь нэг болон дөрөвдүгээр хөлийн эхний завсардсан хос төгөлдөр чимэг болно. Хэлэх санаа гол өгүүлбэрийн гол хоёр гишүүнд “сурахыг хүсэгчид сурах” гэсэн утгаар илрэх бөгөөд үүнээ “сурах” гэсэн үгээ давтаж санаагаа тодруулсан. Үүнээ цааш нь сайн муу дунд зэргийг холбон бичих гэж бусад үйлстэй холбон өргөжүүлжээ.

**Хос төгөлдөр чимэг хоёр, гутгаар хөлийн тэргүүнд завсардсан** (тө: rkang ba gnyis pa dang gsum pa'i thog ma na yod pa). Энэ нь чимэг болох ойролцоо дуудлагат үе болоод үгээ бадгийн дундах хоёр хөлөнд эн зэрэгцүүлэн давтах арга юм. Энэ чимгийг Данзанравжаагийн зохиосон “Наадмын шүлэг”-ээр жишээ өгүүлбэл:

Өр шир, өвс унгас, будаа гурил бодож явсаар  
Өнөө маргаашийн болзоогүй үхэл ирэхийн цагт  
Өнөөх их хямгадаж явсан тэр чинь тээр болохгүй юу?  
Өнгөрөөд гарах хүний орныг юунд төдий тэвээрлэнэм

(Сайн үгсийн сан. 1995. т.98)

хэмээх шүлгийн II хөлийн эхний “өнөө” гэдэг үг болон III хөлийн эхний “өнөө+х” гэсэн үгтэй дуудлага ижил тул хоёр, гуравдугаар хөлийн эхний завсардсан хос төгөлдөр чимэг үүсгэжээ.

**Хос төгөлдөр чимэг хоёр ба дөрөвдүгээр хөлийн тэргүүнд завсардсан** (тө: rkang ba gnyis pa dang bzhi pa'i thog ma na yod pa). Чимэг болох ойролцоо дуудлагат үе болон үгээ хоёр ба дөрөв дэх хөлийн тэргүүнд салаавчлан давтаж хэрэглэх арга. Үүнийг Агваанхайдавын “Бандида урт үст Цэрэнпил хэмээгдэхийн тэмцлийн бичиг оршвой” хэмээх зохиол дахь нэгэн бадаг шүлгээр жишээ өгүүлбэл:

Өтөл би анхааран авалгагүй нохой тул  
Үнэнийг ямар мэт номловч хүн үл итгэмүй зэ  
Өөрийн нөхөр их бясалгагч Бүшүн лугаа  
Үнэн номын үгсийг өгүүлэлцвээс тэрбээр итгэмжлэх бөлгөө.  
(Сайн үгсийн сан. 1995. т.347)

Энэ шүлгийн хоёр болон дөрөвдүгээр мөрийн толгойн үг болох “үнэн” хэмээх үг нь завсардсан хос төгөлдөр чимэг болж байна.

**Хос төгөлдөр чимэг гурав болон дөрөвдүгээр хөлийн тэргүүнд завсардсан** (тө: rkaṅ ba rhyi ma gnyis ka'i thog ma na yod pa). Энэ нь чимэг болох ойролцоо дуудлагат үе болон үгээ бадгийн сүүлийн хоёр мөрийн тэргүүнд эн зэрэгцүүлэн давтаж найруулах арга болно. Үүнийг Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Гал тэнгэрийг тахих зан үйл баясгалан гарахын орон” хэмээх зохиолоос нэгэн шүлгээр жишээ өгүүлбэл:

Илт эдлэхүйеэ зохист шүр сувд тэргүүтний хишиг  
Ямагт ард бүхэнд хэрэгт элдэв эрдэнэсийн хишиг  
Ялангуяа алт мөнгө хийгээд зоос тэргүүтний хишиг  
Ялангуяа эрдэнэсийн хишгүүдийг хотол төгсгөн соёрх.  
(Сайн үгсийн сан. 1995. т.314)

Энэ шүлгийн 3 болон 4 дүгээр хөлийн эхний “ялангуяа” хэмээх үг нь завсардсан хос төгөлдөр чимэг болж байна. Уг шүлгийн эд эрдэнэс гэх утгыг тодруулахдаа “ялангуяа” гэх үг нь чухам юуг гэсэн утгаа тодруулж байна.

**Хос төгөлдөр чимэг нэг ба хоёр, гуравдугаар мөрийн тэргүүнд завсардсан** (тө: rkaṅ ba snga ma gsum gyi thog ma na yod pa). Бадаг шүлгийн эхний 3 мөрийн толгой болох үгс нь дуудлага ойролцоо үе болоод үгээр давтаж бүтэх арга. Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Гал тэнгэрийг тахих зан үйл баясгалан гарахын орон” хэмээх зохиолоос нэгэн шүлгээр жишвэл:

Хэзээд үл эвдрэх бат эд таваарын хишиг  
Хэзээд үл эцэх тарган сүрэг малын хишиг  
Хэзээд үл дутах элбэг идээ ундааны хишиг  
Хэдий бүх хэрэгтний хишгийг над дор төгсгөн соёрх  
(Сайн үгсийн сан. 1995. т.314)

хэмээх лүгээ бөгөөд эхний гурван хөлийн тэргүүнээ буй “хэзээд” хэмээх үг нь завсардсан хос төгөлдөр чимэг болно.

**Хос төгөлдөр чимэг нэг, гурав, дөрөвдүгээр хөлд завсардсан** (тө: rkang ba dang po dang phyi ma gnyis kyi thog ma na yod pa). Энэ нь хоёр дахь мөрөөс бусад гурван өрөөл мөрийн эхний үгс нь дуудлага ойролцоо үг буюу үеэр давтагдах арга. Лувсандондов гүний “Хөхий уулын шил” шүлгээс жишээлэн үзүүлбэл:

Хол газрын аяндаа  
Хонгор зээрдээ унаарай  
Холын бяцхан чамтайгаа  
Холдолгүй суун жаргая аа

(Сайн үгсийн сан. 1995. т.188)

хэмээх мэт бөгөөд нэг, гурав болон дөрөвдүгээр хөлийн эхний “хол, хол+ын, хол+долгүй” гэсэн үгс нь завсардсан хос төгөлдөр чимэг болно.

**Хос төгөлдөр чимэг хоёр болон гурав, дөрөвдүгээр хөлийн тэргүүнд завсардсан** (тө: rkang ba phyi ma gsum ka’i thog ma na yod pa). Бадаг шүлгийн сүүлийн гурван мөрийн тэргүүн буюу эхэнд орж буй толгой үгс буюу үе нь дуудлага ойролцоо үгээр давтах арга. Үүн лүгээ Жамъянгаравын “Монголын түүхийн жишээ шүлэг” хэмээхээс жишээ татвал:

Хурмастын хүчит их хаан заларч ирснээс ч болсон бус  
Хувилгааны хүчит их баатрын чадал хүчнээс ч болсон бус  
Хувилай сэцэн хаан таны шашин төрийг тэтгэснээр  
Хувьт амьтны амар жаргал, нас буян

баясгалангийн цогийг олов.

(Сайн үгсийн сан. 1995. т.441)

гэх мэт бөгөөд сүүлийн гурван мөрт “хуви+лгааны, хуви+лай, хувь+т” гэсэн дуудлага ижил үгс орсон нь завсардсан хос төгөлдөр чимэг үүсгэнэ.

**Хос төгөлдөр чимэг дөрвөн хөлийн тэргүүнд завсардсан** (тө: rkang ba bzhi ka’i thog ma na yod pa). Энэ нь бадаг шүлгийн дөрвөн мөрөнд орж байгаа толгой үгсийг ижил дуудлагат үе ба үгсээр давтан найруулах арга. Үүн лүгээ монгол шүлгийн жишээ ихээхэн түгээмэл бөгөөд XIX зууны үеийн яруу найрагч, зохиолч, орчуулагч Сүнвэйданжүний нэгэн шүлгээр жишээ өгүүлье.

Намрын өвс цэнхэр бөгөөд намрын өвс хувхай  
Намрын зул будангуй болоод намрын шөнө урт  
Намрын гэгээвчинд өнгийн үзвээс намар юунаа төгсөх мэт  
Намрын хур, намрын салхинаа үнэхээр юутай гунилтай.

(Сайн үгсийн сан. 1995. т.148)

хэмээх мэт бөгөөд дөрвөн хөл тус бүрийн эхнээ буй “намрын” хэмээх үг нь завсардсан хос төгөлдөр чимэг болж байна. Энэ чимэгт Цахар гэвшийн зохиосон жишээ шүлэг:

Ялгуусан бүхний гурван нууц хоцролгүй  
Ялгуусан хөвүүн залуугийн дүрсээр ургасан  
Ялгуусан бага хаадын зулайнаа хээмсэрлэхүй  
Ялгуусан их хаан Сронзангомбо нь төвдийн богд

(Ч.Алтангэрэл. 1967. т.21-22)

хэмээх нь хөл тус бүрийн эхнээ буй “ялгуусан” хэмээх үг нь дөрвөн хөлийн тэргүүнээ завсардан орсон хос төгөлдөр чимэг болж байна.

**Хос төгөлдөр чимэг нэг ба гурав, хоёр ба дөрөвдүгээр хөлд завсардсан** (тө: rkang ba dang po gsum pa dang gnyis pa bzhi pa dang ‘dra ba). Бадаг шүлгийн нэг ба гурав, хоёр ба дөрөвдүгээр мөрийн толгой үгс нь адил буюу ойролцоо дуудлагат үг ба үед завсардан орох арга. Энэ чимгээр Цахар гэвшийн зохиосон жишээ шүлэг:

Цагаан зөөлөн сарны дүрсэд тэнцэлдэх  
Үзэсгэлэн гуа тийн дэлгэрсэн цогт  
Цагаан гэгээн царайгаар ханасан дээрэнхүйт  
Үзэсгэлэн төгөлдөр бүхний батыг асар булаахуй

(Ч.Алтангэрэл. 1967. т.22)

Энэ шүлгийн нэг болон гуравдугаар мөрт орсон “цагаан”, хоёр болон дөрөвдүгээр мөрт орсон “үзэсгэлэн” хэмээх үгс нь завсардсан хос төгөлдөр чимэг болно.

**Хос төгөлдөр чимэг эхэн адаг хоёр хийгээд дундах хоёр хөлийн тэргүүнд завсардсан** (тө: rkang ba thog tha’ gnyis dang bar ba gnyis ‘dra ba). Бадаг шүлгийн эхний болоод сүүлчийн, мөн дундах хоёр мөрийн толгой үгсийг адил ойролцоо дуудлагатай үгсээр завсардан найруулах арга. Энэ чимгээр Цахар гэвшийн зохиосон жишээ:

Дууны чимэг яруу үг өгүүлэхдээ  
Аюултгүй эрхэн дээд самбааг



Аюулаас ангижирсан билгээр олмогц  
 Дууны чимэг туурвихдаа далайгаас болсон мэт.

(Ч.Алтангэрэл. 1967. т.23)

Энэ шүлгийн нэг, дөрөвдүгээр мөрийн тэргүүнээ буй “дууны” хэмээх үг, хоёр болон гуравдугаар хөлийн тэргүүнээ буй “аюул+тгүй, аюул+аас” хэмээсэн үгс нь хос төгөлдөр чимэг болно. Далайгаас болсон мэт гэдэг нь Сарасватиийн илт өгүүлэх нэр учир шүлгийн утга нь дууны чимэг өгүүлэх эрхэм арга самбааг олбоос зохиол туурвил нь Сарасвати мэт яруу тунгалаг болмуй гэсэн санааг илтгэжээ.

**1.3. Хос төгөлдөр чимэг ЭС ЗАВСАРДСАН ба ЗАВСАРДСАН**  
 (са: аvуарета-vуарета, тө: chod cing ma chod pa'i zung ldan). Энэ нь хөлийн эхнээ буй эс завсардсан хос төгөлдөр чимгийг дараагийн аль нэгэн хөлийн эхнээ давтах арга юм. Энэ чимгийг Дандин бээр 3 зүйл хэлбэрээр үзүүлжээ. Ийм шүлгийг Агваандандар лхаарамба “завсардсан бөгөөд эс завсардсан хос төгөлдөр чимэг” (Агваандандар, 25b) хэмээн бичжээ.

**Хос төгөлдөр чимэг нэг ба хоёр, гурав ба дөрөв дэх хөлийн тэргүүнээ завсардсан хийгээд эс завсардсан** (тө: phyed snga phyi gnyis 'dra ba). Энэ чимгээр Агваандандар лхаарамба жишээ зохиожээ.

Өөр өөрийн хүссэн тогтсон таалал нугууд  
 Өөр өөрийн шуналын нүүрт хамгийг нийцүүлэх  
 Олон олон мэргэд бээр эс ялгав  
 Олон олныг айлдагч чи бээр сайтар ялга.

(Агваандандар, 25b)

Шүлгийн эхний хөлд “өөр өөрийн” гэсэн үгсээр эс завсардсан хос төгөлдөр чимэг үүсгэсэн бөгөөд хоёрдугаар хөлийн эхнээ дахин давтсанаар завсардсан хийгээд эс завсардсан хос төгөлдөр чимэг болжээ. Гурав болон дөрөвдүгээр хөлд “олон олон” гэсэн үгсээр дээрхийн адил чимэг үүсгэжээ. Энэ нь завсардсан хийгээд эс завсардсан хос төгөлдөр чимгийн анхдугаарх нь болно.

**Хос төгөлдөр чимэг нэг болон дөрөв, хоёр болон гуравдугаар хөлийн тэргүүнээ завсардсан хийгээд эс завсардсан** (тө: thog tha' gnyis dang bar ba gnyis 'dra ba). Энэ чимэгт Цахар гэвш Лувсанчүлтэмийн зохиосон жишээ:

Намс намс хөдөлсөн голт цагаан лянхуанаа  
Мэхэс мэхэс илт хувилах бэлхүүст  
Мэхэс мэхэс сэмээр харах удбал нүдэт  
Намс намс шанх дээрээ шинэдийн цагаахан сарт.

(Ч.Алтангэрэл. 1967. т.24)

Энэ шүлгийн нэг ба дөрөвдүгээр хөлийн эхний “намс намс”, хоёр ба гуравдугаар хөлийн эхний “мэхэс, мэхэс” хэмээсэн үгс нь завсардсан хийгээд эс завсардсан хос төгөлдөр чимэг үүсгэжээ. Энэ нь завсардсан хийгээд эс завсардсан хос төгөлдөр чимгийн хоёрдугаарх хэлбэр болно.

**Хос төгөлдөр чимэг дөрвөн хөлийн эхэнд завсардсан болон эс завсардсан** (тө: rkang ba bzhi ka ‘dra ba). Энэ нь бадаг шүлгийн дөрвөн мөрийн толгой үгсийг эс завсардаж, мөн завсардаж давтах арга юм. Цахар гэвш Лувсанчүлтэмийн энэ чимгээр бичсэн жишээ нь:

Жигд жигд сайтар номлох хэлгүй байж  
Жигд жигд хуурч бусдын толгой эргүүлэгч  
Жигд жигд шүдээ яралзуулан мэх адармаат  
Жигд жигд сүндэрлэсэн хад шиг утгаар хоосон

(Ч.Алтангэрэл. 1967. т.25)

Хөл тус бүрийн тэргүүнээ буй “жигд жигд” хэмээх үг нь хөл тус бүрдээ эс завсардсан хос төгөлдөр чимэг болж мөн нийт шүлэгтээ завсардсан хос төгөлдөр чимэг болох тул завсардсан болон эс завсардсан холимог хос төгөлдөр чимэг болох аж. Энэ нь мөн чимгийн гуравдугаар хэлбэр болно. Үүгээр завсардсан хийгээд эс завсардсан хос төгөлдөр чимгийн үлгэрийг үзүүлж дуусч байна.

**Хөлийн тэргүүний хос төгөлдөр чимэг** (ca: avyapeta pādādiyama-ka, тө: bar mo chod rkang dang po zung ldan). Шүлгийн хөлийн буюу мөрийн толгой үгсийг ойролцоо дуудлагат үг болон үеэр давтах арга. Энэ чимэг нь олон зүйл байна гээд түүнээс 30 хэлбэрийг Дандин жишээгээр тайлбарлажээ. Үүнд:

1. Хөлийн тэргүүнд эс завсардсан хос төгөлдөр чимгийг 15
2. Хөлийн тэргүүнд завсардан орсон хос төгөлдөр чимгийг 12
3. Хөлийн тэргүүнд эс завсардсан ба завсардсан хос төгөлдөр чимгийг 3 зүйл хэлбэрээр үзүүлжээ.

Тэргүүн хөлийн хос төгөлдөр чимгийг хэрхэн бүтээх тухай Дандин дурдаж жишээлж үзүүлсэн ба мөн тэргүүн хөлийн хос төгөлдөр чимэг бүтээх зарим аргын тухай дурдалгүй орхисон тухайгаа өгүүлжээ. Зарим аргыг орхисны учраа “Ягштал дэлгэрүүлэхээс айсны тул” хэмээн тайлбарласан нь **тэргүүн хөлийн хос төгөлдөр чимэг бүтэх арга** нь олон бөгөөд тэр бүгдийг өгүүлж нуршихаас сэрэмжлэсэн утга болно.

**1.4. ҮЙЛДЭХҮЙ БЭРХ хос төгөлдөр** (ca: dushkara, тө: bya dka' ba'i zung ldan). Хөлийн дунд болон адагт хос төгөлдөр чимэг найруулах нь Үйлдэхүй бэрх хос төгөлдөр чимэг болно.

**Хос төгөлдөр чимэг дөрвөн мөрийн дунд ЭС ЗАВСАРДАН ЗАВСАРДСАН** (тө: rkang ba bzhi ka'i dbus na yod cing chod la ma chod pa). Энэ чимэг нь ойролцоо дуудлагат үе болон үгс мөрийн дунд эс завсардаад бас завсардан орох арга юм. Энэ чимгээр Цахар гэвш Лувсанчүлтэмийн зохиосон жишээ:

Алин нэгэн булаагч булаагч тэргүүтний  
 Дээрэнгүйг булаагч булаагч айлдал энэрлийн сан  
 Цаст уулын булаагч булаагч ямар байх мэт  
 Бусдын хүчийг булаагч булаагч зөөлөн эгшиг

(Ч.Алтангэрэл. 1967. т.25)

Шүлгийн хөл тус бүрийн дунд орсон “булаагч булаагч” хэмээсэн хос төгөлдөр чимэг бөгөөд энэ нь дөрвөн мөрийн дунд эс завсардаад мөн завсардан оржээ.

**Хос төгөлдөр чимэг хөл тус бүрд завсардсан** (тө: rkang ba bzhi ka'i dbus na yod cing chod pa). Ойролцоо буюу ижил дуудлага бүхий үе ба үгс мөрийн дунд завсардан орох арга. Энэ чимэгт Цахар гэвшийн зохиосон жишээ:

Сайтар үүдсэн хэтэрхий болсон Цаст уулаас буусан  
 хүч дорвио хэтэрхий болсон Ганга мөрний урсгал  
 Тунгаамал алтан хэтэрхий болсон хүрднээс бүтсэн  
 торолтгүй хэтэрхий болсон урвуулагчийн хүч нь  
 Хүч дорвио хэтэрхий болсон зөнгөөрөө сайтар бүтсэн  
 төгс төгөлдөр хэтэрхий болсон зочинд ирүүлэх  
 Дөрвөн аймгийн хэтэрхий болсон зуун хаалгыг нээх газар

эдлэгч хэтэрхий болсон хүрдэн орчуулагч  
(Ч.Алтангэрэл. 1967. т.26).

Шүлгийн хөл тус бүрд “хэтэрхий болсон” хэмээх үгийг завсардуулан давтсанаар хос төгөлдөр чимэг бүтээжээ.

**Хос төгөлдөр чимэг хөл бүрийн эцэст завсардсан** (ca: sarveshu padeshu misram vyavahitamantabhaga yamakam, тө: rkang ba'i mtha' na yod cing chod pa). Чимэг болох ойролцоо дуудлагат үе болоод үгс нь мөр бүрийн эцэст завсардан орно. Өөрөөр хэлбэл монгол шүлгээр бол мөрийн сүүл холбох аргын хэлбэр байна. Үүнийг Цахар гэвшийн нэгэн жишээ шүлгээр үзүүлбэл:

Алт мөнгөтний дунд гуйранчин мэт үзэгдэнэ  
Эрдэмтний дунд мунхаг мэт үзэгдэнэ  
Тэнэгчүүдийн дунд эрдэмтэн мэт үзэгдэнэ  
Шүдтэний дунд жигүүртэн мэт үзэгдэнэ  
(Ч.Алтангэрэл. 1967. т.27)

Шүлгийн хөл тус бүрийн адагт буй “үзэгдэнэ” гэсэн үгээр хөл бүрийн эцэст завсардсан хос төгөлдөр чимэг бүтээжээ.

**Хос төгөлдөр чимэг хөл бүрийн эцэст завсардсан, эс завсардсан холимог** (тө: rkang ba'i mtha' na yod cing chod la ma chod pa). Энэ нь адил буюу ойролцоо дуудлагат үе болон үгсийг эхлээд эс завсардуулан давтаад түүнээ эн зэрэгцүүлэн бүх мөрийн сүүл холбон давтах арга. Үүнийг Цахар гэвшийн нэгэн монгол жишээ шүлгээр өгүүлбэл:

Нүдний эмэн өнгөт<sup>55</sup>үс нь найган найган  
Сүргийн манлай<sup>56</sup> охьт дуаз гуалиг найган найган  
Харвасан зэвт шулуун сум эрчилж найган найган  
Тэнгэр хүний өвөг чуулган чичрэн найган найган  
(Ч.Алтангэрэл. 1967. т.27)

Энэ шүлгийн мөр тус бүрийн эцэст “найган найган” хэмээх үгс эс завсардаад мөн завсардан орж холимог хос төгөлдөр чимэг болжээ. Шүлэгт тас хар өнгийн үстэй, зааны дүрст туг намируулсан баатар нь дайснаа айлган бүхүйг дүрсэлжээ.

<sup>55</sup> Нүдний эмэн өнгөт – хар өнгөтэй гэсэн үг байна

<sup>56</sup> Сүргийн манлай - заан, үхэр, гарди, бурхан, буянтан, цагаагчин могой жил гэх мэтийн амьтан ба юмны ёгт нэр. Энд зааныг өгүүлсэн байна. Шашны ёсонд зарим бурхан, тэнгэр, сахиус, баатар хүчтэн нь заан зэрэг амьтны дүрст туг эсвэл арьсаар хийсэн туг хэрэглэсэн байдаг. Энэ нь ялгуусан хүчтэний нэг тэмдэг мөн.

**Хос төгөлдөр чимэг хөл бүрийн дунд болон адагт завсардсан** (тө: rkang ba'i bar mtha' gnyis na yod cing chod pa). Адил буюу ойролцоо дуудлагат үгсийг тухайн мөрийнхөө дунд ба эцэст завсартайгаар давтан найруулах арга. Энэ чимэгт Агваандандарын бичсэн жишээ:

Нэн олон эрдэмтний шавь олон  
 Мэргэд олноор хэлэлцэх газарт оюун үүсгэгч олон  
 Худалдаа олноор дэлгэх цагт үзэгч олон  
 Мунхагууд олноор зөвшилцөхөд зэргэцэн инээгч олон.  
 (Агваандандар, 25b)

Шүлгийн мөр бүрийн дунд болон адагт буй “олон” хэмээх үг нь хос төгөлдөр чимэг үүсгэжээ.

**Хос төгөлдөр чимэг хөлийн дунд ба адагт эс завсардсан** (тө: rkang ba'i bar mtha' gnyis na yod cing chod la ma chod pa). Энэ нь чимэг болох ойролцоо буюу адил дуудлагат үе болон үгийг мөрийн дунд завсаргүй нэг оруулаад ахиад мөрийн сүүлд мөн завсаргүй давтах арга. Цахар гэвш Лувсанчүлтэмийн зохиосон нэгэн жишээ:

“Хүзүүндээ чимэг хангинуулан хангинуулан дуугаргасан эгшигт эх бээр тэвэрч сайн номлолын дуун хангинуулан хангинуулан”

(Ч.Алтангэрэл, 1967. т.29)

Энэхүү нэгэн мөр шүлгийн дунд болон адагт “хангинуулан хангинуулан” хэмээсэн эс завсардсан хос төгөлдөр чимгийг тасалдалтайгаар давтсанаар холимог хос төгөлдөр чимгийг бүтээжээ. Үүн лүгээ адилаар үлдсэн гурван мөрийг мөн ийнхүү давтсанаар энэхүү шүлэг бүрэн болох юм.

**Хос төгөлдөр чимэг бүх хөлийн дунд, адагт эс завсардан, завсардсан холимог** (тө: rkang ba bzhi ka'i bar mtha' na yod cing chod la ma chod pa). Чимэг болох ойролцоо буюу адил дуудлагат үе болон үгийг бүх мөрийн дунд ба сүүлд тасалдалгүй болон тасалдалтайгаар давтан найруулах арга. Агваандандар лхарамбын жишээ:

Цаст уулын цагаан цагаан сайн цогийг  
 дэлгэрүүлэхийн өнгө цагаан цагаан  
 Тэр мэт цагаан цагаанд адилсах дунгийн өнгө цагаан цагаан  
 Сарны цагаан цагаанаас үлсэн эгшигт эхийн нүүр цагаан цагаан  
 Алиныг цагаан цагаанд үзэхийн цагт

сүсэгтний сэтгэл цагаан цагаан

(Агваандандар, 25b-26a)

Шүлгийн хөл тус бүрийн дунд болон адагт “цагаан цагаан” гэсэн үгс орж хос төгөлдөр чимэг үүсгэжээ.

**Хос төгөлдөр чимэг дөрвөн хөлийн эхэн болон дунд завсардсан** (ca: vyaretaādīmadhyayamakam). Чимэг болох ойролцоо буюу адил дуудлагат үе ба үгсийг мөрийн тэргүүн болон дунд нь давтах арга. Агваандандарын жишээ шүлэг:

Сайн мууг ялгасан сайн оюун төгөлдрийн чуулган  
Сайн чуулган гарсан сайн номлолыг увдислагч мэргэдийн  
Сайнаас сайн мөрт сайн үзүүлэн зохиогч итгэл  
Сайн шүтвээс сайны дээдийг олох болой

(Агваандандар, 26a)

Шүлгийн мөр тус бүрийн эхэн болон дунд буй “сайн” хэмээх үгс нь дээрх хос төгөлдөр чимгийг үүсгэж байна.

**Хос төгөлдөр чимэг дөрвөн хөлийн эхэн ба дунд эс завсардан, завсардсан** (ca: pādādimadhya avyapeta-vyapeta yamaka). Чимэг болох дуудлага ойролцоо үе ба үгс нь дөрвөн хөлийн тэргүүн ба дунд тасалдалгүй болон дундаа үг оруулсан тасалдалтайгаар орж найруулах арга. Цахар гэвшийн нэгэн жишээ шүлэг:

Үзэсгэлэн үзэсгэлэн нүд буландаж хөдлөхөд  
дүр нь үзэсгэлэн үзэсгэлэн  
Үзэсгэлэн үзэсгэлэн идэр цог хангалуун үзэсгэлэн үзэсгэлэн нар  
Үзэсгэлэн үзэсгэлэн хээнцэр охины дэргэд  
дүр нь үзэсгэлэн үзэсгэлэн  
Үзэсгэлэн үзэсгэлэн үүгээр ч  
хүсэл төгөлдөр нь үзэсгэлэн үзэсгэлэн болно.

(Ч.Алтангэрэл. 1967. т.29)

Шүлгийн нэг болон гуравдугаар хөлд “үзэсгэлэн үзэсгэлэн” гэсэн үгс эхэн болон адагт орсон бол хоёр болон дөрөвдүгээр хөлд эхэн болон дунд орсноор хос төгөлдөр чимэг бүтээжээ.

**Хос төгөлдөр чимэг хөл бүрийн эхэн болон адагт завсардсан** (ca: adyanta ekaṅgā vyapeta yamaka). Үүн лүгээ таацуулан Агваандандар лхарамба зохиосон жишээ шүлэг:

Мэргэн үйлийн орон нугууд сайтар арилснаар мэргэн  
Мэргэн бусад үйл ёсон түүгээр үлэмж мэргэн  
Мэргэний чуулганд увдис номлоход мэргэн  
Мэргэн нүгүүд боловсруулан гэтлэх мөрт хөтлөхөд мэргэн.  
(Агваандандар, 26а)

Санскрит шүлэгт хоёр хөл нь нэг мөр шад болдог. Иймд энэ жишээ нь монгол шүлэгт бол дөрвөн мөрийн эхний дөрвөн үг, сүүлийн дөрвөн үг нь хос төгөлдөр чимэг үүсгэх юм. Иймд энэ жишээ шүлгийн хөл тус бүрийн эхэн адагт буй “мэргэн” хэмээх үг нь хос төгөлдөр чимэг болно.

**Хос төгөлдөр чимэг хөл бүрийн эхэн болон эцэст эс завсардсан** (са: Pādadyamta vyapeta yamaka). Чимэг болох адил буюу ойролцоо дуудлагат үг нь эс завсардан орохдоо мөр бүрийн эхэнд ба адагт завсардан давтах арга юм. Энэ чимгээр Агваандандарын зохиосон жишээ:

Тодорхой тодорхой усан болор адилын бие тодорхой тодорхой  
Тодорхой тодорхой луун дуун мэт номлол тодорхой тодорхой  
Тодорхой тодорхой таалалд ахуй ёсон бүхэн тодорхой тодорхой  
Тодорхой тодорхой нүдэнд ургасан дүрс тодорхой тодорхой  
(Агваандандар, 26а)

Энэхүү нэгэн мөр шүлгийн эхэн болон адагт буй “тодорхой тодорхой” хэмээсэн үгс нь “хөлийн эх, адгийн эс завсардагч хос төгөлдөр чимэг” болно.

**Хос төгөлдөр чимэг хөл бүрийн эхэн, дунд, адагт завсардсан** (тө: rkang ba'i gnas gsum ka na yod cing chod pa). Энэ нь чимэг болох үг ба үеийг мөрийн эхэн, дунд, адаг гэх гурван орноо завсартайгаар давтан найруулах арга. Энэ чимгээр Цахар гэвш Лувсанцүлтэмийн зохиосон жишээ шүлэг:

Оюун сайн дэлгэрсэн оюун саруулчуудын оюун  
Оюун ухаан нь Манзуширийн оюун мэт торохгүй оюун  
Оюун төгс бүхний хүсэх оюун ихэд таарсан оюун  
Оюун дээд эрхэм манлай оюун нут батадсан оюун  
(Ч.Алтангэрэл. 1967. т.30)

Мөр тус бүрийн эхэн, дунд болон адагт “оюун” хэмээх үг тасалдалтайгаар орж завсардсан хос төгөлдөр чимгийг бүтээжээ.

**Хос төгөлдөр чимэг хөл бүрийн эхэн, дунд, адагт эс завсардсан**

(тө: rkang ba'i gnas gsum ka na yod cing ma chod pa). Чимэг болох үе болоод үгсийг дөрвөн мөрийн эхэн, дунд, адагт тасалдалгүй давтан найруулах арга. Энэ чимгээр Цахар гэвш Лувсанчүлтэмийн зохиосон жишээ:

Цагаан цагаан цасан уул ямар мэт  
цагаан цагаан туулайт<sup>57</sup> нь цагаан цагаан  
Цагаан цагаан лянхуагийн үндэс мэтэд  
цагаан цагаан ялгуусны таалал цагаан цагаан  
Цагаан цагаан сүүн далай ямар мэт  
цагаан цагаан нарийхан биет<sup>58</sup>-ийн нүүр цагаан цагаан  
Цагаан цагаан цог охины сайхан төрсөн мэтэд  
цагаан цагаан үүлэн эрхэс л цагаан цагаан  
(Ч.Алтангэрэл. 1967. т.31)

Энэ шүлгийн мөр тус бүрд “цагаан цагаан” хэмээх үгс нь эхэн, дунд, адаг гэх гурван орноо давтан орж холимог хос төгөлдөр чимгийг бүтээжээ.

**1.5. Хос төгөлдөр чимэг хөлийн ЭЦЭС БА ТЭРГҮҮНИЙГ БАРИЛДУУЛАН холбосон** (тө: rkang ba'i mtha' thog sbyar ba'i zung ldan). Энэ нь шүлгийн хоёр мөрийн сүүл болоод толгойг холбон найруулах арга. Энэ хос төгөлдөр чимэгт багтах боловч бусад “Хос төгөлдөр” чимгүүдээс онцлог ялгаатай. Ялгаа энэ нь мөрийн төгсгөлийн үгийг дараагийн мөрийн эхэнд давтдаг. Ханчин хамба Жамъянгаравын жишээ шүлэг:

Ивээлт амьтанд ч урьд үгүй их баясгалан үүсгэгч  
Жалцавжамгон ялгуусан  
Ялгуусны эх усны их сангаас магад утгын гол ёсны эрдэнийн их  
Их хатны тийн шинжлэл сарны хүрээнээс хагацсан  
эш ухааны тэрэг Та удирдагч  
Удирдагч дээд сартваахи чухал амарлингуйн өргөл  
хотлоор арилгахын цогт  
Цогт итгэл болсон Лүдүв хэмээх гэгээнтний өмнө  
гурвантаа мэхийн сөгдмүй  
(Д.Ганболд. 2015. т.211)

<sup>57</sup> Туулайт - сарны илт өгүүлэх нэр.

<sup>58</sup> Нарийхан биет - эмэгтэй хүний илт өгүүлэх нэр.



Энэ шүлэгт нэг мөрийн сүүлийн үгийг дараагийн хөлийн тэргүүний үгтэй хамсаж хөлийн эцэс ба тэргүүнийг найруулсан хос төгөлдөр чимэг үүсгэжээ.

Хос төгөлдөр чимгийн энэ арга нь монгол аман зохиолын "Жороо үг" болон зарим нэг оньсоготой хэлбэрийн хувьд адил юм. "Жороо үг"-ийн нэгэн жишээ үзүүлье.

Хоёр уулын хооронд  
Хоргой цэцэг  
Цэцэгт нь цэгээ алт  
Алтанд нь арван хэлхээ  
Хэлхээнд нь хээ хуар  
Хуарт нь хунтар илжиг  
Илжгэнд нь эгэл боол  
Боолд нь бор галуу  
Галуунд нь газар ус  
Усанд нь уул Монгол.

Энэхүү "жороо үг"-ийн бүтэц нь нэг мөрийн төгсгөлийн үгийг дараагийн мөрийн эхэнд давтан хэлж буй "хөлийн эцэс ба тэргүүнийг барилдуулсан хос төгөлдөр чимэг" болж байна.

**1.6. БҮХНЭЭ ХОС төгөлдөр чимэг.** Үүнд Хос төгөлдөр чимгийн Хагасаар дахих, Хөлөөр дахих аргууд орно. Эдгээр аргууд мөн дотроо хэдэн зүйл байна.

**Хагасаар дахих** (ca: ardhābhyāsa тө: phyed zlas pa). Энэ нь хөлийн буюу шадын хагасыг давтаж хэрэглэх арга. Энэ чимэг нь 3 зүйл байна. Үүнд: 1. Нэгийг гуравт ба хоёрыг дөрөвдүгээр мөрөнд салаавчлан давтсан, 2. Нэгийг хоёрт ба гурвыг дөрөвт эн зэрэгцүүлэн давтсан, 3. Нэгийг дөрөв дэх мөрт ба хоёр гуравдугаар мөрийг хооронд нь энэ зэрэгцүүлэн холбон давтах – ийм гурван хэлбэрийг Дандин бээр жишээлэн үзүүлжээ.

**Хөлийн хагасаар нэгийг гуравт ба хоёрыг дөрөвт салаавчлан дахих** (тө: rkang ba dang bo gsum pa dang gnyis pa bzhi bar). Энэ чимгээр Цахар гэвш Лувсанчүлтэмийн зохиосон жишээ:

Тунгаасан болгомол алтны гэрэл маш тийн бадарсан нь  
Чандмань баригчийн толгой дээр тийн үзэсгэлэн

Тунгаасан болгомол алтны гэрэл маш тийн бадарсан нь  
Чандмань баригчийн толгой дээр тийн үзэсгэлэн  
(Ч.Алтангэрэл. 1967. т.32)

Үүний I шад нь алтан сүмбэр уулыг, II шад нь дэлхийг, III шад нь унжлага чимгийг, IV шад нь Намсрай тэнгэрийг тус тус заан үзүүлсэн ажээ.

**Хөлийн хагасаар нэгийг хоёрт ба гурвыг дөрөвт эн зэрэгцүүлэн эс завсардан дахих** (тө: rkang ba dang po gnyis pa dang gsum pa bzhi bar bzlas pa). Энэ чимгээр Цахар гэвш Лувсанчүлтэмийн бичсэн жишээ:

Үснирт сарын шинэдээр үзэсгэлэнтэй  
Үснирт сарын шинэдээр үзэсгэлэнтэй  
Билиг төгөлдөр нарын баясгалангийн цог  
Билиг төгөлдөр нарын баясгалангийн цог  
(Ч.Алтангэрэл. 1967. т.32)

Энэ шүлгийн эхний хоёр хөл яг ижил боловч нэгдүгээр нь эгшигт эх Янжинлхамыг, хоёрдугаар нь Эрх баялаг тэнгэрийг тус тус заан өгүүлжээ.

**Хөлийн хагасаар нэгийг дөрөвт ба хоёрыг гуравт дахих** (тө: rkang ba dang po bzhi pa dang gnyis pa gsum par bzlas pa). Үүн лүгээ Агваандандарын зохиосон жишээ:

Мутартаа очир барин далайгч  
Эс эвлэсэн зүгүүдийг дарахуйяа баатар  
Эс эвлэсэн зүгүүдийг дарахуйяа баатар  
Мутартаа очир барин далайгч  
(Агваандандар, 26б)

Энэ шүлэгт нэгдүгээр хөлийг дөрөвдүгээрт, хоёрдугаар хөлийг гуравдугаарт дахиж хос төгөлдөр чимэг үүсгэжээ.

**Хөлөөр дахих** (са: pādabhyāsa, тө: rkang pa bzlas pa). Энэ нь шадыг дараа дараачийн хөлд хэвээр нь давтах арга. Энэ давталт нь олон зүйл байна гээд үүнээс 10 зүйл хэлбэрийг Дандин бээр жишээлэн үзүүлжээ.

**Тэргүүнийг хоёрдугаар хөлд дахих** (са: prathamadcitīya pādāv-abhyasta, тө: rkang ba dang bo gnyis par bzlas pa). Энэ нь шүлгийн эхний мөрийг дараагийн мөрөнд давтаж хэлэх санаагаа тодруулж гаргах арга. Энэ чимэгт таацуулан Агваандандарын бичсэн жишээ:

Намайг энэрэхүйгээр тольдон соёрх  
 Намайг энэрэхүйгээр тольдон соёрх  
 Буяны садан дээд лам танд  
 Цаг үргэлжид аврал одуулмуй

(Агваандандар, 27а)

Шүлгийн нэгдүгээр хөлийг хоёрдугаарт дахиж хос төгөлдөр чимэг үүсгэжээ. Ингэж шүлгийн нэгдүгээр мөрийг хоёрдахь мөрөнд давтах учир нь “намайг энэрэхүйгээр тольдон соёрх” гэсэн залбирал үгээ давтан өгүүлж, багш лам бурхандаа дотоод сэтгэлийн өчил бодол гол хандан хэлж буй санаагаа анхааруулан тодотгож байна.

**Тэргүүнийг гуравдугаар хөлд дахих** (ca: prathamatritīyau abhyasta, тө: dang po sum par bzlas pa). Энэ нь чимэг болж буй тэргүүн хөл нь гуравдугаар мөрд давтах арга. Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ:

Цагаан бөгөөд үзэсгэлэнгийн цог төгөлдөр  
 Эгшиглэнт охин тэнгэрийг би бээр шүтмүй  
 Цагаан бөгөөд үзэсгэлэнгийн цог төгөлдөр  
 Рашааны гарах орон сар нь бүхнээ тодорхой

(Агваандандар, 27а)

Шүлгийн нэгдүгээр хөлийг гуравдугаар дахисан бөгөөд нэгдүгээр хөл нь Эгшигт охин тэнгэрийг магтсан бол гуравдугаар хөл нь сарыг магтжээ.

**Тэргүүнийг дөрөвдүгээр хөлд дахих** (ca: prathamacaturthyau pādāv-abhyastāviti, тө: dang po bzhi bar bzlas pa). Бадаг шүлгийн эхний мөрийг дөрөвдүгээр мөрөнд хашиж давтах арга. Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ шүлэг:

Үгүйрлийн зовлонг няцаадаг тул  
 Чандманийг эрхийн хаан хэмээн магтана  
 Эрдэнийн сайн бумба хэмээх нь ч  
 Үгүйрлийн зовлонг няцаадаг тул

(Агваандандар, 27а)

Шүлгийн нэгдүгээр хөлийг дөрөвдүгээрт дахисан бөгөөд нэгдүгээр хөл нь “чандмань” эрдэнийг магтсан, дөрөвдүгээр хөл нь эрдэнийн бумбыг магтжээ. Өөрөөр хэлбэл хоёр өөр зүйлийг адил юм шиг атал өөр өөр зүйлийг заан нэрлэж буй өөр утга бүхий илт өгүүлэх

нэрээр нь магтан өгүүлж байна. Жишээ нь

Ойрад түмний оройн чимэг

Халх түмний хамаг итгэл

Буриад зоны буяны титэм

Зая бандида - гэхэд Зая бандида гэсэн нь нэг үг боловч цаад утгандаа Халхын Зая бандид, Ойрадын Зая бандид, Буриадын Зая бандид гэх гурван өөр хүнийг нэрлэж байна.

**Хоёрдахийг гуравдугаар хөлд дахих** (ca: dviṭyātritīyāvabhyastāvitī, тө: gnyis pa gsum par bzlas pa). Энэ нь дундах хоёр мөрийг эн зэрэгцүүлсэн байдлаар хоёрдугаар мөрийг гурав дахь мөрөнд давтах арга. Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ:

Сайн мөрийг үзүүлбээс дээд багш

Сонссон даруйд баясгалан төрөх

Сонссон даруйд баясгалан төрөх

Сүсэгтэнд сайн алт ч юун

(Агваандандар, 27а)

Шүлгийн хоёрдугаар хөлийг гуравдугаарт дахиж хос төгөлдөр чимэг үүсгэжээ. Ингэхдээ хоёрдугаар мөрийн “Сонссон даруйд баясгалан төрөх” хэмээх нь дээд багшийн тухайд, гуравдугаар мөрийн “Сонссон даруйд баясгалан төрөх” хэмээх нь алт болон үнэт эд эдлэлийг үл хэрэгсэх сайн сүсэгтний тухай өгүүлсэн утга байна.

**Хоёр дахийг дөрөвт дахих** (ca: dviṭyācaturtāvabhyastāvitī, тө: gnyis pa bzhi bar bzlas pa). Энэ нь шүлгийн хоёр дахь мөрийг дөрөв дэх мөрөнд салаавчилсан байдалтай давтах арга. Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ:

Цагийн хүрдний язгуур үндсийг номлогч нь

Хаан Даваасамбуу мөн

Шамбалын орноо дэлгэрүүлэгч нь

Хаан Даваасамбуу мөн

(Агваандандар, 27а)

Энэ шүлэгт хоёрдугаар хөлийг дөрөвт давтсан байна. Өөрөөр хэлбэл нэг болон гуравдугаар хөл нь хоёр болон дөрөвдүгээр хөлийн өгүүлэгдэхүүнийг магтжээ. Магтсан утга нь бол Цагийн хүрднийг

номлогч Даваасамбуу, нөгөөх нь Шамбалын Даваасамбуу ийм хоёр өөр юм.

**Гуравдугаар хөлийг дөрөвт дахих** (ca. tritīyācaturthavabhyastāviti, тө: gsum pa bzhi bar bzlas pa). Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ:

Алин нэгэн сонсвоос үл зохилдохгүй  
Нүднээ гайхамшиг өгөхийн цог  
Далайгаас төрсөн цагаан үзэсгэлэн  
Далайгаас төрсөн цагаан үзэсгэлэн

(Агваандандар, 27а)

Шүлгийн гурав дахь хөлийг дөрөв дэх хөлд давтаж хос төгөлдөр чимэг үүсгэжээ. Давтсан хоёр хөлийн эхнийх нь сарыг магтаж буй бол удаах нь лянхуаг магтжээ.

**Анханг хоёр ба гуравдугаар хөлд дахих** (ca: prathamadvitīya-tritīyapādānāmabhyāsa, тө: rkang pa dang po gnyis pa dang gsum par bzlas pa). Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ:

Газар дэлхий бүгдийг бүрхэн үйлдэгч  
Газар дэлхий бүгдийг бүрхэн үйлдэгч  
Газар дэлхий бүгдийг бүрхэн үйлдэгч  
Мэргэний алдар хийгээд нар, сар гурав

(Агваандандар, 27а)

Шүлгийн нэгдүгээр хөлийг хоёр болон гуравт дахисан нь дээр дурдсан хос төгөлдөр чимгийг үүсгэжээ. Үүний нэг дэх хөл нь мэргэний алдрыг, хоёр дахь нь нарыг, гурав дахь нь сарыг тус тус магтжээ.

**Анханг хоёр ба дөрөвдүгээрт дахих** (ca: prathamadvitīyacaturthabhyasta, тө: rkang pa dang po gsum pa dang bzhi par bzlas pa). Энэ нь эхний мөрийг хоёр болон дөрөвдүгээр мөрөнд дахих арга. Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ шүлэг:

Зарлигийн ачит үлэмж нигүүлсэнгүйтэн  
Танд насад итгэмүй.  
Зарлигийн ачит үлэмж нигүүлсэнгүйтэн  
Зарлигийн ачит үлэмж нигүүлсэнгүйтэн

(Агваандандар, 27б)

Шүлгийн нэгдүгээр хөлийг гурав болон дөрөвт дахиж дээрх хос

төгөлдөр чимгийг үүсгэжээ.

**Хоёрдугаар хөлийг гурав, дөрөвт дахих** (ca: dvitīyatritīyācatur-thapādānāmabhyāsa, тө: rkang pa gnyis pa gsum pa dang bzhi par bzlas pa). Энэ чимгээр бичсэн Агваандандарын жишээ:

Алс хол орших хэдий ч  
Олон бүгдэд тусыг үйлдэгч  
Олон бүгдэд тусыг үйлдэгч  
Олон бүгдэд тусыг үйлдэгч (Агваандандар, 27б)

Шүлгийн хоёрдугаар хөлийг гурав болон дөрөвдүгээр хөлд давтсан бөгөөд энэ гурван хөл нь тус бүрдээ өөр өөр зүйлийг магтсан байна. Хоёрдугаар хөл нь “нар”, гуравдугаар хөл нь “багш”, дөрөвдүгээр хөл нь “бурхан”-ыг тус тус магтжээ. Эдгээр гурав нь хэдий хол байвч хамаг бүгдэд ямагт тус үйлдэж байдаг гэсэн санааг илтгэжээ.

**БҮХ ХӨЛИЙГ дахих** (ca: sarva eva pāda abhyastā, тө: lan gsum bzlas pa). Энэ нь эхний хөлийг дараагийн хөлүүдэд давтах арга. Ийн бичлэг дуудлага адил эдгээр хөлүүд нь дараагийн мөрүүдэд давтагдсан ч тэдгээр мөр бүр нь өөр өөр утга санаа нэршил зааж байдаг. Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ шүлэг:

Яруу бөгөөд сонсголонтой тул баясгалан төрөх  
Яруу бөгөөд сонсголонтой тул баясгалан төрөх  
Яруу бөгөөд сонсголонтой тул баясгалан төрөх  
Яруу бөгөөд сонсголонтой тул баясгалан төрөх

Энэ шүлэгт эхний мөрөө дөрөв давтсан мэт харагдавч эдгээр хөл нь тус бүрдээ өөр өөр утга зааж буй. Нэгдүгээр хөл нь “зохист аялгуу”, хоёрдугаар хөл нь “эгшигт биваа хөгжим”, гуравдугаар хөл нь “залуу бүсгүйн дуу”, дөрөвдүгээр хөл нь “багшийн номлол”-ыг тус тус заан өгүүлжээ.

**ШҮЛГЭЭР дахих** (ca: ślokābhyāsa, тө: tshigs bcad bzlas). Энэ нь эхний дөрвөн мөр шүлгийг дараагийн бадагт давтах арга. Энэ шүлгээр дахих чимгээр Агваандандарын бичсэн жишээ шүлэг:

1. Их сүр жавхлангийн биет бөгөөд  
Бүхний дээр илт хэтийдсэн  
Сарны титэмт хэмээн алдаршсаныг  
Хэн бээр шүтвээс шид бүтээл өгөх

2. Их сүр жавхлангийн биет бөгөөд  
Бүхний дээр илт хэтийдсэн  
Сарны титэмт хэмээн алдаршсаныг  
Хэн бээр шүтвээс шид бүтээл өгөх

(Агваандандар, 276)

Энд нэг бадаг шүлгийг дахин давтсан мэт харагдах ч эхний шүлэг нь Дэмчиг бурханыг магтсан бөгөөд хоёрдугаар бадаг нь Эрх баялаг тэнгэр Ванчигийг (dbang phyug chen po) магтжээ. Эхний бадгийн хоёрдугаар хөлд “Бүхний дээр илт хэтийдсэн” хэмээсэн нь бүх бурхадын дээр заларсан гэсэн утгыг илтгэж буй, гуравдугаар хөлд буй “Сарны титэмт” хэмээх нэр нь Дэмчиг бурханы илт өгүүлэх нэрийн нэгэн бөгөөд дөрөвдүгээр хөлд “Хэн бээр шүтвээс шид бүтээл өгөх” гэсэн нь “Дэмчиг бурханыг шүтсэн хэн бүхэн бурханы хутгийг олно” гэсэн санаа юм.

Харин хоёрдугаар бадгийн хоёр дахь хөл нь хүний ертөнцийн бодгаль бүгдийн дээд гэсэн санааг илтгэх бөгөөд гутгаар хөлийн “Сарны титэмт” хэмээх нь Эрх баялаг тэнгэрийн илт өгүүлэх нэр болно. Дөрөвдүгээр хөлд өгүүлэн буй утга нь “Эрх баялаг тэнгэрийг шүтсэн хэн бүхэн энэ ертөнцөд эд баялгийг олох болно” гэсэн санаа юм.

**ИХ хос төгөлдөр чимэг** (ca: mahāyamaḥa, тө: zung ldan chen po). Утга ондоо боловч дуудлагыг нь ижилсүүлсэн үгсээр шүлэг бүтээх арга. Энэ нь хос төгөлдөр чимгийн нэг зүйл. Их хос төгөлдөр чимэгт хөлөөр бус үгээр дахиж утга илтгэх бөгөөд энэ нь хос төгөлдөр чимгийн дээд хэлбэр болно. Энэ нь өмнөх шүлгүүдэд дахисан хөл тутмаар тус тусад нь утга илтгэсэн бол энд нэгэн хөлд хоёр утга илтгэнэ. Үүнийг хос төгөлдрийн үйл<sup>59</sup> хэмээнэ. Их хос төгөлдөр чимгээр Агваандандарын бичсэн жишээ шүлэг:

Машид цагаан бөгөөд машид цагаан  
Машид цагаан бөгөөд машид цагаан  
Машид цагаан бөгөөд машид цагаан  
Машид цагаан бөгөөд машид цагаан

(Агваандандар, 276)

Энэ шүлгийг харвал нэг дэх хөлийг гурвантаа дахисан нь эхний мөрийг дараагийн 3 мөрөнд дахидаг “бүх хөлийг дахиx” чимэгтэй

<sup>59</sup> - ca: yamaḥa kriya, тө: zung ldan bya ba

хэлбэрийн хувьд адил боловч “бүх хөлийг дахих” чимгийн адил хөл тус бүрээр утга илтгэсэнгүй. Харин энэ “Их хос төгөлдөр” чимэгт хөл тус бүрийн эхэн, сүүлд буй “машид цагаан” гэх үг тус бүрээр өөр өөр утга илтгэж нийт найман зүйлийг магтжээ. Дурдвал Цагаан манзушир, цагаан лянхуа, эгшигт эх, сар, цагаан зодбү<sup>60</sup>, цаст уул, сайхан сэтгэл, цолмон од - эдгээр 8 болой.

**1.7. ХОЛИМОГ хос төгөлдөр чимэг** (тө: ‘dres pa’i zung ldan). Энэ чимэгт өмнө өгүүлсэн хос төгөлдөр чимгийн дахих давтах олон хэлбэр маягуудыг нэгтгэн хэрэглэх арга. Ийм хос төгөлдөр чимэг үүсгэх аргуудыг нэгтгэн хэрэглэсэн Холимог хос төгөлдөр чимгээр Агваандандарын бичсэн жишээ:

Сайн мөрийг үзүүлэгч дээд дээд болсон буяны садан сайн  
Сайны журам сайтар сахихыг зохион зохион, бас  
Бас бас амьтныг удирдан явсан алин  
Алинд итгэн шүтсэн нүгүүдийн хувь заяа дэлгэрмүй  
(Агваандандар, 276-28а)

Энэ шүлэгт хос төгөлдөр чимгийн 7 янз хэлбэрийг багтаажээ. Үүнд:

- а) Нэг дэх хөлийн эхэн болон адагт “сайн” гэдэг үг орж “хос төгөлдөр чимэг хөлийн эхэн адагт завсардсан”.
- б) Нэг дэх болон хоёр дахь хөлийн эхнээ буй “сайн” гэдэг үг нь “хос төгөлдөр чимэг эхний хоёр хөлийн тэргүүнд завсардсан”.
- в) Нэг дэх хөлийн дунд буй “дээд дээд” хэмээсэн нь “хос төгөлдөр чимэг хөлийн дунд эс завсардсан”
- г) Хоёр дахь хөлийн эхэн болон дунд буй “сайн, сайтар” гэсэн үгс нь “хос төгөлдөр чимэг хөлийн эхэн, дунд завсардсан”
- д) Хоёр дахь хөлийн адагт “зохион зохион” хэмээн давтсан нь “хос төгөлдөр чимэг хөлийн адагт эс завсардсан”
- е) Гурав дахь хөлийн эхнээ “бас бас” хэмээн давтсан нь “хос төгөлдөр чимэг хөлийн эхнээ эс завсардсан”
- ё) Нэг дэх хөлийн адагт “сайн”, хоёр дахь хөлийн адагт “бас”, гурав дахь хөлийн адагт “алин”, хоёр дахь хөлийн эхэнд “сайн”, гурав дахь хөлийн эхэнд “бас”, дөрөв дэх хөлийн эхэнд “алин” гэж тус тус орсон нь “хөлийн эцэс тэргүүнийг

<sup>60</sup> Бурханы манлайд байх (хоёр хөмсгийн дунд) цагаан үсийг хэлж буй.



найруулсан хос төгөлдөр чимэг” болох юм.

**1.8. Хос төгөлдрийн ёсноос НЯЦАХУЙ** (са: pratilomam yamakam, тө: ldog pa'i zung ldan). Энэ нь дахих зүйлээ тонгоруулж давтах нэгэн зүйлийн өвөрмөц арга юм. Үүнд: Хөлөөр тонгорох, хөлийн хагасаар тонгорох хийгээд шүлгээр тонгорох гэсэн гурван зүйлийн ялгал бий. Өөрөөр хэлбэл шүлэгт хос төгөлдрийн ёсноос няцахуй гэдэг нь хос төгөлдөр чимгийг бариад шүлгийг хөлийн хагасаар, бүтэн хөлөөр, бүтэн шүлгээр эргэж тонгоруулж уран дүрслэл бүтээж болох арга юм.

**Хос төгөлдрийн ёсноос няцаж хөлөөр эргэх** (са: Pādāgocaram pratilomayamakam, тө: rkang pa ldog pa). Энэ нь шүлгийн нэг мөрийн үгсийг дараагийн мөрөнд байрлуулахдаа үгсийг араас нь тонгоруулж найруулах арга. Хос төгөлдрийн ёсноос няцахуйн нэг зүйл. Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ:

Алимад эдгээр алжааснаар эргэн эргэх  
 Эргэн эргэхүйгээр алжаасан эдгээр алимад  
 Ялгуусан бүхний эх, дээд хутагт эх, гэтэлгэн зохиогч, аврагч  
 Авран зохиогч, гэтэлгэгч эх, хутагт дээд эх, бүхнээс ялгуусан.  
 (Агваандандар, 28а)

Шүлгийн нэг дэх хөлийг хоёрдугаарт, гуравдугаар хөлийг дөрөвдүгээрт дахихдаа хөлийн үг тус бүрийг тонгоргож дахисан бөгөөд үүнийг хөлөөр тонгорохуй хэмээнэ.

**Хос төгөлдөр чимгийн ёсноос няцаж хөлийн хагасаар тонгорох** (са: pratilomamyamakam ślokārdhaviṣayam, тө: tshigs bcaḍ phyed ldog pa). Шүлгийн хөлийн тэн хагас нь дараагийн аль нэг хөлд давтахдаа үгс нь тонгорч дахих арга. Хос төгөлдрийн ёсноос няцахуйн нэг зүйл. Энэ чимгээр Агваандандарын бичсэн жишээ:

Сайтар номлол, эрхэм зарлиг айлдагч  
 энэрэн нигүүлсэнгүйт уужим маш  
 Яруу номлол алин үйлээс ном номлоход сайтар мэргэн  
 Мэргэн бээр сайтар номлосон номын  
 үйл алинаас номлох нь яруу  
 Маш уужим нигүүлсэнгүй энэрэн айлдагч,  
 эрхэм зарлигийг номлох сайн.  
 (Агваандандар, 28а)

Шүлгийн нэгдүгээр мөрийн эхний үг “сайн номлол” гэдгийг

дөрөвдүгээр мөрийн эцэст “номлох сайн” гэж, хоёрдугаар мөрийн эхний “яруу номлол” гэдгийг гуравдугаар мөрийн эцэст “номлох нь яруу” гэж тус тус дахихдаа хөлийн үг тус бүрийг тонгоргож хөлийн хагасаар тонгоргон дахижээ.

**Хос төгөлдрийн ёсноос няцаж шүлгээр тонгорох** (ca: ślokago-saram, тө: tshigs bcad rangs bo ldog pa). Бүтэн бадаг шүлгийн үгсийг дараагийн бадагт эргүүлэн тонгоруулж үгсийг байрлуулж найруулах арга. Хос төгөлдрийн ёсноос няцахуйн нэг зүйл. Энэ шүлгээр тонгорох чимгээр Агваандандарын бичсэн жишээ шүлэг:

Бурханы шашны үзүүлэхүй дээд зохионгуй нь тус хийгээд буян  
Буяны ёсны номын цагийг үзвэл баясгалан төрж амуух  
Цаглашгүй зоригдлын орныг бясалгаснаар сонсохын хаан  
Сонсох олон мэргэдийн номлол алинаар дээд хөвгүүн ялгуух

Ялгуугч хөвгүүн дээд бээр алиныг номлоход

мэргэд олноор сонсох

Хаан сонссоноор бясалгалын орон зоригдолгүйг цаглах  
Амгалан төрж баясгаланг үзэх цагийн номын ёсоор буян  
Буян бөгөөд тусын зохионгуй нь

дээдийг үзүүлэгч бурханы шашин.

(Агваандандар, 28а)

Шүлгийн нэг дэх хөлийг найм дахь хөлд, хоёр дахь хөлийг долоо дахь хөлд, гурав дахь хөлийг зургаа дахь хөлд, дөрөв дэх хөлийг тав дахь хөлд тус тус тонгоргож давтаж шүлгээр тонгорохуйн жишээг үзүүлжээ. Ингэж тонгоргоход “цаглашгүй зоригдлын” гэсэн үг тонгорохоороо “зоригдолгүйг цаглах” болж “цаглашгүй”-н хойно буй “үгүй” нь зоригдлын ард “үгүй” болж орж байна.

**Хоёр. ҮЙЛДЭХҮЙЕЭ БЭРХ БУСАД ЯЛГАЛ** (тө: bya dka' ba'i rgyan). Энэ нь тун өвөрмөц аргаар шүлэг бүтээх ур маяг юм. “Хос төгөлдөр чимэг”-ийн аргуудтай адил нэгэн үе ба үгийг завсардсан болон эс завсардан давтахгүй. Өөр өвөрмөц ур маяг хэрэглэж шүлэг бүтээдэг. Энэ нь дотроо гурван ялгал буй. Үүнд: 1. “Үхрийн шээсэн” хэмээх нь “үйлдэхүйеэ бэрх”-ийн нэгэн ялгал. 2. “Хагас эргэхүй” болон “Бүхнээ сайн” нь “үйлдэхүйеэ бэрх”-ийн мөн нэгэн ялгал юм. 3. “Эгшиг, орон хийгээд үсэг магадлахуй” нь бас “үйлдэхүйеэ бэрх”-ийн нэгэн ялгал

юм.

2.1. “Үхрийн шээсэн” хэмээх “үйлдэхүйеэ бэрх”-ийн чимэг (Ca: gomutrika, тө: ba lang gcin). Энэ чимэг нь явж буй үхрийн шээс хоёр тийш солбин дусагнаж газарт тахирласан мөр үлдээх түүнийг дуурайлган шүлэг бүтээх арга. Бас зааны явдлаар үлгэрлэн бичсэн шүлэг ч нэрлэдэг байна. Монголчуудын хувьд бол ханан хээ болон шөргөн хашааны хөл дагуулан бүтээх маягтай юм. “Үхрийн шээсэн” хэмээх нь “үйлдэхүйеэ бэрх”-ийн нэгэн ялгал мөн. Сүмбэ хамба Ишбалжирын энэ “Үхрийн шээсэн” хэмээх аргад таацуулан бичсэн жишээ:

нөхөр	үгүй	ялгуусан	нугууд	гурван	ертөнцөд	чимэг
нөхөр(-өөс)	хагацсан	ялгуусан	хөвгүүд	энэ	ертөнцөд	чимэг
тус	амгалан	сайн	чуулганыг	хотол	-д	соёрхном
тусын	төлөө	сайн	номлолыг	хотол	-д	соёрхном

“Үхрийн шээсэн мөр”-ийн жишээ болох дээрх дөрвөн шад шүлгийг эхний мөрөөс арагш нь туушдаа уншвал дөрвөн мөр бүхий бадаг шүлэг болж байна. Хэрвээ нэг хоёрдугаар шад ба гурав дөрөвдүгээр шадыг тус тусад нь заасан сумын дагуу явж байгаа үхрийн шээсэн мөр мэт муруйлгаж уншвал дөрвөн мөрт бас нэгэн шүлэг бүтнэ. Үүнийг шууд харуулбал:

Нөхөр үгүй ялгуусан нугууд гурван өртөнцөд чимэг  
 Нөхөр (-өөс) хагацсан ялгуусан хөвгүүд энэ ертөнцөд чимэг  
 Тус амгалан сайн чуулганыг хотолд соёрхном  
 Тусын төлөө сайн номлолыг хотолд соёрхном.

Энэ дөрвөн хөл шүлэг нь тууш уншиж бүтсэн бөгөөд үүнийг үхрийн шээсэн мэт мөрийг дагаж уншвал дараах шүлэг бүтнэ.

Нөхөр хагацсан ялгуусан хөвгүүд гурван ертөнцөд чимэг  
 Нөхөр үгүй ялгуусан нугууд энэ ертөнцөд чимэг  
 Тус төлөө сайн номлолыг хотолд соёрхном  
 Тусын амгалан сайн чуулганыг хотолд соёрхном

(Ван Мандуга, 2015. т.142)

хэмээсэн шүлэг бүтэж нэгэн бадаг шүлэгт хоёр бадаг шүлэг багтаажээ.

2.2. **Хагас эргэх чимэг** (ca: ardha-bhramana, тө: phyed bzlos). Бадаг шүлгийн хагасыг эргүүлж давтах маягаар урлах арга. Агваандандар хагас эргэсэн хэмээхийг хэрхэн унших аргыг: "Хагас эргэх нь нэг шүлгийн өмнөд хагасыг өмнөөс хойш, дээрээс доош хийгээд хойд хагасыг сүүлчээс буцаан унших хийгээд дээрээс доош уншваас нэгэн утгат болох" шүлэг юм хэмээн тайлбарлажээ. Хагас эргэх чимгээр Жамъянгаравын бичсэн жишээ шүлэг:

зөөлөн	цогт	эгшиг	шид	айлдагч	та	удирдагч	эцэг
цогт	төгөлдөр	сайн	бүтээл	машид	сайн	тойн	удирдагч
эгшиг	сайт	сан	бүхүй	дээд	мэргэн	сайн	та
шид	бүтээл	бүхүй	олсон	тодорхой	дээд	машид	айлдагч

Шүлгийн эхний хэсгийн хагасыг дээрээс доош нь уншвал, мөн бас өмнөөс хойш уншваас

Зөөлөн цогт эгшиг (-ийн) шид  
 Шид бүтээл бүхүй (-г) олсон  
 Зөөлөн цогт эгшиг (-ийн) шид  
 Шид бүтээл бүхүй (-г) олсон

гэсэн дөрвөн хөл шүлэг гарах болой. Шүлгийн хойд хагасыг өмнө өгүүлсэнчлэн өмнөөс хойш, дээрээс доош болон сүүлчээс буцаан уншвал:

Айлдагч та удирдагч эцэг  
 Айлдагч машид дээд тодорхой  
 Айлдагч та удирдагч эцэг  
 Айлдагч машид дээд тодорхой

гэсэн дөрвөн хөл шүлэг гарч байна. Иймд энэ шүлэг нь хагас эргэх чимгийн жишээ болж байна.

2.3. **Бүхнээ эргэх** (ca: sarvatobhadra, тө: kun tu bzang bo). Бүхнээ сайн гэх энэ чимэг нь бадаг шүлгийг хагасаар биш бүгдээр нь эргүүлдэг арга юм. Бүхнээ эргэх энэ аргыг монголчууд Самандабадраагийн хүрд гэж нэрлэдэг. Энэ нь Монголчуудын дунд их дэлгэрсэн үгийн сүлжээ юм. Бүхнээ эргэхүй нь дотроо бас олон зүйл байж болно. Үүнээ таацуулан Жамъянгаравын зохиосон нэгэн жишээ шүлгийг доор үзүүлье.

мэргэн	тойн	сайн	эрхэт	зөөлөн	итгэлт	удирдагч	итгэлт	зөөлөн	эрхэт	сайн	тойн	мэргэн
тойн	сайн	эрхэт	зөөлөн	итгэлт	удирдагч	та	удирдагч	итгэлт	зөөлөн	эрхэт	сайн	тойн
сайн	эрхэт	зөөлөн	итгэлт	удирдагч	та	машид	та	удирдагч	итгэлт	зөөлөн	эрхэт	сайн
эрхэт	зөөлөн	итгэлт	удирдагч	та	машид	мэргэн	машид	та	удирдагч	итгэлт	зөөлөн	эрхэт
зөөлөн	итгэлт	удирдагч	та	машид	мэргэн	номлол	мэргэн	машид	та	удирдагч	итгэлт	зөөлөн
итгэлт	удирдагч	та	машид	мэргэн	номлол	хэлцэл	номлол	мэргэн	машид	та	удирдагч	итгэлт
удирдагч	та	машид	мэргэн	номлол	хэлцэл	туурвил	хэлцэл	номлол	мэргэн	машид	та	удирдагч
итгэлт	удирдагч	та	машид	мэргэн	номлол	хэлцэл	номлол	мэргэн	машид	та	удирдагч	итгэлт
зөөлөн	итгэлт	удирдагч	та	машид	мэргэн	номлол	мэргэн	машид	та	удирдагч	итгэлт	зөөлөн
эрхэт	зөөлөн	итгэлт	удирдагч	та	машид	мэргэн	машид	та	удирдагч	итгэлт	зөөлөн	эрхэт
сайн	эрхэт	зөөлөн	итгэлт	удирдагч	та	машид	та	удирдагч	итгэлт	зөөлөн	эрхэт	сайн
тойн	сайн	эрхэт	зөөлөн	итгэлт	удирдагч	та	удирдагч	итгэлт	зөөлөн	эрхэт	сайн	тойн
мэргэн	тойн	сайн	эрхэт	зөөлөн	итгэлт	удирдагч	итгэлт	зөөлөн	эрхэт	сайн	тойн	мэргэн

Шүлэгт "мэргэн тойн сайн эрхэт зөөлөн итгэлт удирдагч" гэсэн хагас хөл дээр дурдсанчлан наймантаа дахижээ. Энэ дөрвөлжин хүснэгтийн дөрвөн өнцгийн "мэргэн" гэдэг үгээс эхэлж уншина. Эхний баганын эхний мөрийн толгой "мэргэн" гэдэг үгийг дээрээс доош нь, баруунаас зүүн тийш нь, мөн эхний баганы хөлийн эхэнд байгаа "мэргэн" гэдэг үгээс эхлэн доороос дээш нь, бас зүүнээс баруун тийш уншина. Мөн арын баганын дээд толгойд байгаа "мэргэн" гэдэг үгээс эхлэн сүүлээс урагш нь, баруунаас зүүн тийш уншина. Мөн энэ арын баганынхаа хөлийн "мэргэн" гэдэг үгээс эхэлж дороос дээш нь, араас нь урагш нь уншина. Ингэж 8 удаа уншихад тус бүр" мэргэн тойн сайн эрхэт зөөлөн итгэлт удирдагч" гэсэн мөр гарна.

Гурав. **ҮЙЛДЭХҮЙЕЭ БЭРХ ДУУНЫ ЧИМЭГ** (ca: dushkarasya sabâlamkara, тө: bya bka' ba'i sgra rgyan). Энэ чимэг нь шүлгийг бүтээх эгшиг, гийгүүлэгч үсэг авиа тэдгээрийн эр эм, сул чанга, дуутай дуугүй, анирт, хамжих шүргэх, хэлний, хоолойн, тагнайн, шүдний, орой гэх мэт гарах авианы байдлыг харгалзан давтан найруулах арга юм.

Энэ чимгийг Агваандандар "магадлах чимэг" хэмээн нэрлэсэн байна. Энэ чимэг нь "эгшиг магадлах", "орон магадлах", "үсэг магадлах" хэмээх 3 зүйл байна. Эдгээр гурвын товч ялгаа нь "эгшиг магадлах"-д

нэг төрлийн эгшгийг давтах, “орон магадлах”-д нэг орны авиаг давтах, “үсэг магадлах”-д нэг үгсийг давтах аргаар шүлгийн хөг аялгуу хэмнэлийг тэгш зохист болгох арга юм. Эдгээр гурван зүйлийн чимэг нь дотроо тус бүр дөрөв дөрвөн өөр ялгал зүйлтэй болж салаалж хуваагддаг.

**3.1. Эгшиг магадлахуй** (ca: svaraniyama, тө: dbyangs nges pa). Энэ чимэг нь шүлгийн мөрийг нэг ижил эгшгээр найруулан бичих арга. Ийн нэг дуудлагат эгшгээр найруулж бичих нь шүлгийг эгшиглэнтэй сонсголонтой яруу сайхан болгодог бас нэг арга юм. Ер шүлгийн хөг аялгууг сонсголонтой болгоход эгшиг авиа онцгой үүрэгтэй. Эгшиг магадлах ёс нь зөвхөн санскрит шүлэгт байдаг бус, монгол шүлэгт ч бас хамааралтай болохыг монголын зохист аялгуу судалачид тэмдэглэсээр иржээ. Үйлдэхүйеэ бэрх дууны чимэг буюу магадлах чимгийн нэг зүйл.

Эгшгээр магадлах чимэг нь дотроо “дөрвөн эгшгээр магадлах” (ca: catuhsvaraniyama, тө: dbyangs bzhir nges pa), “гурван эгшгээр магадлах” (ca: trisvaraniyama, тө: dbyangs gsum par nges pa), “хоёр эгшгээр магадлах” (ca: dvisvaraniyama, тө: dbyangs gnyis par nges pa), “нэг эгшгээр магадлах” (ca: ekasvaraniyama, тө: dbyangs gcig tu nges pa) хэмээсэн дөрвөн зүйл ялгалтай.

Монгол ардын аман зохиолд “эгшиг магадлах” аргатай ойролцоо шүлэглэл элбэг. Жишээлбэл, “Эрийн сайн Хан харангуй”-н туульд:

Алтан цалам  
Амьдын улаан үрэл  
Алтан пял тавгаа  
Авч хайрлав (Б.Түвшинтөгс. 2016. т.82)

хэмээсэн шүлэгт "а" эгшиг түлхүү оржээ. Мөн түргэн хэллэгт ч энэ мэт жишээ олон олдох бөгөөд жишээлбэл:

Арын уулын  
Арван таван тарваганы  
Тав нь яасан  
Тарган тарвага вэ

хэмээсэн үүнийг "а" эгшгээр магадлан бичсэн гэж үзэж болмоор байна. Агваандандарын төвд хэлээр “дөрвөн эгшгээр магадлан” бичсэн нэгэн төвд шүлгийг галиглаж үзүүлье.

di phyi gnyis kyi srid zhir 'jigs  
 phul 'byung sku gsum dus rgyun du  
 bshes gnyen bsten tshe dge legs 'phel  
 mgon mchod gsol lo chos 'khor skor

(Агваандандар, 31а)

Энэ шүлэгт эхний хөлийг "i" эгшгээр, хоёр дахь хөлийг "u" эгшгээр, гурав дахь хөлийг "e" эгшгээр, дөрөв дэх хөлийг "o" эгшгээр тус тус магадлан бичжээ. Энэ мэтээр дөрөв, гурав, хоёр болон нэг эгшгээр магадлан бичиж болох ажээ.

**3.2. Орон магадлахуй** (ca: sthānaniyamah, тө: gnas dan nges pa). Шүлгийг бүтээж буй авианы гарах орны ялгал байдлыг харгалзан найруулах арга юм. Үйлдэхүйеэ бэрх дууны чимэг буюу магадлах чимгийн нэг зүйл.

Энэхүү орон магадлах арга нь Монгол яруу найрагт бас нэлээд хэрэглэдэг чимэг юм. Монголын эртний хэлзүйн бичгүүдэд дурдсанаар үсэг төрөх орон, махбод нь тус бүр тав байх бөгөөд арван наймдугаар зууны үеийн нэрт хэл шинжлэлч Данзандагвын "Зүрхний толтын тайлбар огторгуйн маань" хэмээх хэлзүйн бичгээс эшилбэл, "үсгийн махбодыг энэтхэгийн ёсоор ялгахуйд огторгуй, хий, гал, ус, шороо таваас "а, э, нг эхлэн га, ха төрлөөрөө огторгуйн махбод", "и эхлэн жа, ша төрлөөрөө хийн махбод", "ра, йа, ча төрлөөрөө гал махбод", "о, у эхлэн ма, ба, па хийгээд ва, вэ усан махбод", "да, та, на, ла, са эдгээр төрлөөрөө шороо махбод" болой. Огторгуй махбод болсны учир шалтгаан нь үсэг тэдгээрийг дуудах цагт хоолойн орноос төрөхийн тул болой. Юуны тул хийн махбод хэмээвээс үсэг тэдгээрийг дуудахад хэлний үзүүр, шүд танлайгаас гарах болой. Юуны тул гал махбод хэмээвээс үсэг тэдгээрийг дуудахад орой хөдөлж гарах болой. Юуны тул усан махбод хэмээвээс үсэг тэдгээрийг дуудахад уруул хумбихын орноос гарах болой. Юуны тул шороо махбод хэмээвээс үсэг тэдгээрийг дуудахад хэлний үзүүр, шүднээс гарах болой"<sup>61</sup> (Монгол хэл шинжлэлийн дурсгал, 1997. т.15) хэмээсэн байх агаад Дандин усан махбодтой буюу уруулын орны үсгүүдийг орон магадлах чимгийн жишээ болох 4 шүлэгтээ оруулаагүй бөгөөд мөн энэ орны тухай дурдаагүй байна. Гэсэн хэдий ч Агваандандар, Лувсанчүлтэм нарын энэ чимгээр зохиосон жишээ шүлэгтээ уруулын орны үсгүүдээр шүлэг бичсэн байна. Мөн Б.Явуухулан "Хар-Ус нуурын шагшуурга" шүлэгтээ

<sup>61</sup> Эхээс засаж найруулан авав.

с, ш шүргэх авиаг түлхүү хэрэглэж намар цагийн зэгс шагшуургын шүргэх шуугианыг илэрхийлсэн байдаг.

**3.3. Үсэг магадлах** (ca: varṇaniyama, тө: yī ge nges). Энэ нь шүлэгт нэг буюу хэд хэдэн гийгүүлэгч үсгийг давтаж найруулах арга. Үйлдэхүйеэ бэрх дууны чимэг буюу магадлах чимгийн нэг зүйл.

Үсэгт магадлахуй нь дотроо дөрвөн ялгалтай бөгөөд дөрвөн үсэгт магадлах, гурван үсэгт магадлах, хоёр үсэгт магадлах болон нэг үсэгт магадлах эдгээр болой. “Үсэг гэдгийг Дандин гийгүүлэгч (үсэг) гэсэн утгаар хэрэглэжээ. Ер үсэг магадлах гэдгийг авиа давтах (аллитерация) үзэгдэлтэй холбон тайлбарлаж болох бөгөөд энэ нь аль ч орны уран зохиол, ардын яруу найрагт дэлгэр хэрэглэгддэг” (ДЗАТ. 1982. т.145). Монгол аман зохиолын нэгэн төрөл болох түргэн хэллэгт авиа давтах үзэгдэл нэлээд түгээмэл тохиох бөгөөд ганц нэгэн жишээ татвал:

Манай хааны мянган лангийн мянган мөнгөн бөмбөгийг  
Манай хааны мянган лангийн мянган мөнгөн бөмбөг биш гээд  
Өөр хэний хааны мянган лангийн мянган мөнгөн бөмбөгийг  
Манай хааны мянган лангийн мөнгөн бөмбөг гэх юм бэ

хэмээсэн энэ түргэн хэллэгт “м”, “н” гэх гийгүүлэгч их давтагдаж байна. Энэ нь хэдийгээр үсэг магадлах чимэгт бүрнээ нийцэхгүй боловч тун адил жишээ болох юм. Агваандандар “Үсэг магадлах” үүнээ нийцүүлэн жишээ шүлэг бичсэнээс нэгэн жишээг доор галиглаж үзүүлье.

dga' dga' dgyes dgur mgu gang gus  
sdong sdum de 'dra dad ldan dor  
rang rigs re rab rang ris rig  
so so'i bsam pa so sor song (Агваандандар, 31a)

хэмээсэн энэ шүлгийн 4 хөлийг “g”, “d”, “r”, “s” зэрэг үсгээр тус тус магадлан бичсэн бөгөөд энэ нь 4 үсэгт магадлан бичсэн жишээ болно. Энэ мэтээр гурав, хоёр болон нэг үсэгт магадлан бичиж болох юм.

**Дөрөв. ДАЛДЛАХ ҮГИЙН ЧИМЭГ**<sup>62</sup> (ca. prahelikas, тө. gab tshig). Өгүүлэх гэсэн санаагаа нууцлан далд ёгтоор илэрхийлэх уран дүрслэлийн арга. Дандин нууц үгийг хаана хэдийд хэрэглэж болохыг хурал наадам зэрэг олон хүнтэй газарт ярихдаа бусдад сэжиг **төрүүдэхгүйн үүднээс, бас яруу найрагт хэлэх гэсэн санаагаа нуухыг**

<sup>62</sup> Далдлах үгийн чимэг, Найруулгын 10 гэм (“Дандины Зохист аялгууны толийн гол нэр утгын тайлбар”. Хамтын бүтээл. 2017. т.289-331)-ийг доктор Б.Няммыгмар хийжээ.



хүсвэл утгыг дав дээр ойлгогдохгүй болгож далдлахад нууц үгсийг хэрэглэнэ гэжээ. Нууцлах буюу Далдлах үгийн чимгийг Дандин бээр 16 зүйл болгож тодорхойлолт болон жишээ бүрийг үзүүлжээ. (ДЗАТ. 1982. т.146.)

**Бүхнээ чуулсан** (ca. samāgata prahelika, тө. kun tu tshogs pa'i gab tshig). Үгсийн хоорондын завсрыг нийлүүлж бичсэнээр утга нь нуугдаж ондоо утгатай болохыг Бүхнээ чуулсан далдлахуй үг гэдэг. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Завсар барилдуулах буюу завсрыг нийлүүлэх гэдэг нь санскрит хэлний сандхийн дүрэм гэнэ. Энэ дүрмээр бол өгүүлбэрт зэрэгцэн орсон хоёр үгийн эцсийн болон эхний үсэг бие биедээ ижилсэн татагдах нөхцөлд уул хоёр үгийг нийлүүлэн бичдэг арга. Түүнийг сандхи буюу уулзвар, холбоо гэнэ. Сандхийн дүрмээр үгийн завсрыг барилдуулан холбож, улмаар шүлгийн утгыг нууж хэлэх аргыг өгүүлнэ. Дандин:

Маяагорааг сэтгэлээр

Мэдсэнгүй бөгөөд юуны тулд хилэнлэмүй

Бүхнээ улаан нүдэт эх ээ

Орон бус дор ухилах үүнээр юуг үйлдэх буй (ТМДДЗАТ. 2017. т.596). Энэ жишээ шүлэгт “маяагора” гэсэн хэллэг нь “би бээр хорлохуйн гүн амтат сэтгэлийг мэдсэнгүй” хэмээсэн утгатай. Гэвч энэ утга нь халхлагдаж “би үхрийн гүн амтат сэтгэлийг мэдсэнгүй” гэх буюу “би бээр сүүн сэтгэлийг мэдсэнгүй” гэсэн утга илэрхийлжээ. Ингэснээр эндүүрүүлэх шалтгааныг үүсгэжээ (ДЗАТ. 1982. т. 146)

**Хуурагч** (ca. vaṅśita. тө. slu byed). Хуурагч нь аливаа үгийн бодтой, нийтээрээ мэдэх хялбар утгыг нуугаад, өөр утгаар нь эндүүрүүлэгч нууц үгс юм. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Өөрөөр хэлбэл, аливаа үгийг салаа юм уу шилжсэн утгаар нь хэрэглэсэн юм шиг атлаа үндсэн утгыг нь нууцаар илэрхийлэх арга. Дандин:

Кубжа-г шүтэгч чиний

Баясгалан хэр мэт арвидах болмуу

Үхэлгүйн хатагтай лугаа тэнсэлдэгч

Хүний эхнэрийг эдлэгч бээр тэр мэт бус (ТМДДЗАТ. 2017. т.609). Энэ шүлгийн хуурагч үг нь кубжа болно. Санскрит хэлнээ энэ үг Кааньякубжа хотын эмэгтэй хийгээд бөгтөр эм гэсэн хоёр утгатай. Цаагуураа үзэсгэлэнт эмэгтэйг магтаад байгаа хэрнээ тэр нь мэдэгдэхгүй, харин бөгтөр эмийг магтсан юм шиг сэтгэгдэл төрүүлж

байгаа энэ нь хуурагч нууц үгийн чимгийн жишээ болж байна. Кааньякубжа хот нь эртний Энэтхэгийн том хотын нэр. Энэ хот Ганга мөрний нэгэн салаа Каали голын эрэг дээр байсан. Энэ нэрийн домог нь Ригвээдэд гардаг. Домгийн ёсоор бол Кушанаабха хааны үзэсгэлэнт зуун охин, Салхины тэнгэрийн оргилсон шунал тачаалыг хангахгүй гэж тэрсэлсэн учир салхины тэнгэр хилэгнэн тэднийг бөгтөр болгосон аж. Үүнээс тэдний хотыг Каньяакубжа/бөгтөр охин/ гэх болжээ (ДЗАТ. 1982. т.147). Тэгэхлээр наад өнгөн дээрээ бөгтөр эмэгтэй магтаж байгаа юм шиг боловч ерөөсөө цаад утгандаа үзэсгэлэнт эмэгтэйг магтаж буй юм.

**Дарааллаас ангижирсан** (са. vyutkrānta. тө. gim pa bral ba). Далдлах үгийн чимгийн гуравдугаарх. Энэ чимэг нь найруулга зүйн тогтсон журмыг эвдэж, үгсийг зориуд замбараа алдуулан урьд хойно нь оруулж, хооронд нь утга авцалдаагүй мэт болгож, тогтсон зөв хэв журам зэрэг дарааллаас ангижруулах нэгэн зүйл уран сайхны найруулгын арга. Дандин:

Ишийг озмуй, лянхуагийн  
Галуус ширүүн өргөст  
Амнаасаа яруу дууныг дуурсган  
Биеэ чичиргэн хушуугаараа (ДЗАТ. 1982. 148)

Санскрит жишээ шүлэгт нийлэмж үгсийн эрэмбэ дарааг зориуд сольж андууруулсан нь нуух арга хэлбэр болжээ. Шүлгийн зөв дарааллаар бол “Ишийг озмуй, лянхуагийн” гэсэн мөр адагт орох ёстой атал эхний мөрөнд оржээ (ДЗАТГНУТ, 2017. т.292).

**Маш дарагч** (са. pramushitā, тө. rab bcom). Шууд ухагдахад бэрх утгатай үгсийн эрихийг маш дарагч гэнэ. Зохист аялгуучин хүн хэлэх гэсэн санаагаа шууд хэлэхийн оронд тойруулж илэрхийлэхэд оршино. Иймд энэ чимгийг тойруулал ч гэдэг. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Дандин:

Охин чиний үзэсгэлэнт хөл дэх  
Бэлзэгийн дэлгэрэнгүй яруу дууныг дуурсахуй  
Мөнхүү илтэд болсон дорыг энд  
Миний амин батдах бус (ТМДДЗАТ. 2017. т.599)

Санскрит жишээ шүлэгт үзэсгэлэнт охины хөлийн бугуйвчны дууг сонсоод явж буй хүн түүнийг өөрийн хүсэлт хүүхэн мөн болохыг

мэдсэн цагт хүслээр энэлээд үхэх байдалд хүрч байгаа шиг санааг маш тойруугаар өгүүлсэн хэрэг (ДЗАТ. 1982. 148).

**Зохилдогч дүрст** (ca. samānarūpa, тө. mthun pa'i gzugs). Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Энэ нь аливаа үгийг жирийн үндсэн утгаар нь хэрэглэсэн юм шиг атлаа түүгээр өөр утга илэрхийлдэг онцлогтой. Өөрөөр хэлбэл, нууж байгаа юмныхаа дүр байдалтай утга зохилдох юмыг өөр бусдад шилжүүлэн нэрийдэж, тэрхүү эгэл буюу нэрийдсэн нэрийн зөвхөн үлгэр, бод хоёрыг өгүүлснээр жинхэнэ бодтой утга нь халхлагдаж, ухаарахад бэрх утгатай болгон найруулах арга юм. Гол нь нуугч үгийн үндсэн утга ба үүсмэл утга хоёрын хооронд уншигчийг төөрүүлж буй арга. Дандин:

Хэний гишүүн салаа навчис  
Тост цэцгийн хонгорцог мэт  
Таван гишүүт оръяах модны  
Үүсгэмэл цэцэрлэгийг энд би бээр үзэв (ТМДДЗАТ. 2017. т.600)

Энэ зохиолдогч дүрстийн жишээннд “Улаан дэлбээтэй цэцэг бүхий таван салаат ороонгон модыг энэ үүсгэмэл цэцэрлэгт би үзлээ” гэсэн энгийн утгатай мэт санагдавч үнэн хэрэгтээ зохиолч ороонгон мод үзсэн тухайгаа хэлэх гээгүй. Харин залуу эмэгтэйг үзсэн тухайгаа нуун хэлсэн ажээ. Энд гарч байгаа “таван гишүүт ороонго модоор залуу эмэгтэй гарыг, тэр модны таван салаа навчаар хуруугий нь, дэлбээгээр хумсыг нь зүйрлэн хэлжээ. Өөрөөр хэлбэл залуу эмэгтэйн гар, хуруу, хумс зэрэг эрхтнийг ороонгон модны мөчир, салаа, навч дэлбээгээр төлөөлөн өгүүлснээр утга зохилдсон үлгэрийн дүрсийг үүсгэжээ (ДЗАТ. 1982. т.149).

**Ширүүн** (ca. parusha, тө. rtsub mo). Аливаа үгийн нийтэд илэрхий утгаар өөр зүйлийг далдуур доромжилсноор тэр нь ухаарахуй бэрх утгатай болсныг ширүүнээр нуусан үг хэмээнэ. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Дандин:

Тэнгэр нар тэнгэрийн ордонд  
Өөрийн гэрлээр алгуурхнаар бядмуй  
Сайхан үнэрт бүрдэнд согтсон  
Тэдгээр нь эдүгээ чавганц мэт

гэх энэ санскрит жишээ шүлэгт “тэнгэр нар нь тэнгэрийн байшиндаа алгуурхнаар ороод сайхан үнэрт бүрдэнд баясан согтуурсан нь чавганц

мэт” гэж тэнгэр нарыг согтуу чавганцтай зүйрлэн доромжилсон байна. Гэвч энэ нь уул шүлэгт хэлэх гэсэн бодтой утга бус, харин архичин эмс архины байшиндаа согтуураад гуйвж дайван тэнэж байгааг нуун хэлсэн утга ажээ. Сайхан үнэрт бүрд нь архин далай болно. Ийнхүү архичин эмсийн тухай хэлэхдээ тэнгэр нарыг хэлсэн мэт эндүүрэл төрүүлж байгаагаараа энэ нь ширүүнээр нуусан жишээ болжээ (ДЗАТ. 1982.149-150).

**Тоот** (ca. samkyāta, тө. grangs nyid). Өгүүлж буй зүйлийн утга, бас тэнд өгүүлж буй аливаа нэрийг тоогоор нууж ухаарахад бэрх болгосныг тоот гэнэ. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Дандин:

Хамарт нэрт балгадын дунд дөрвөн гийгүүлэгчээр  
Огоот сайтар чимсэн  
Нэгэн балгад буй, алимад түүнээ  
Найман үсэгт нэрт хүний эзэн буй (ТМДДЗАТ. 2017. т.602)

Энэ шүлэгт kancapuri хэмээх хотыг “дөрвөн гийгүүлэгчээр чимсэн балгад” гэж нэг нуугаад тэр балгадын хаан kancapuri bla wa-гийн нэрийг шууд хэлэлгүй “найман үсэгт” хаан гэж бас нууцалжээ. Нуухдаа нэрлэгдэгч юмны нэрд хэд хичнээн үсэг орсныг үндэс болгож хотын нэр k-c-p-r гэсэн дөрвөн гийгүүлэгч орсон учир “дөрвөн гийгүүлэгчээр сайтар чимсэн гэжээ”(ДЗАТ. 1982. т.150).

**Маш нэрийдэгч** (ca. vākyārtha, тө. rab brtags). Өгүүлбэрийн утга нь далдуур өөр юмыг заасан утгатай бол түүнийг маш нэрийдэгч гэнэ. Энэ нь үгийн олон утгаар эндүүрэл төрүүлэх найруулгын арга. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Дандин:

Алжаангуй харцтай, толгойгоо гудайсан  
Айж чичиргэнэсэн дуу хоолойтой  
Салганан зогсох намайг  
Сайтар өршөөхгүй юу, эмгээн.

Энэ санскрит жишээ шүлгийн утгыг нуугч гол vrdha хэмээх үг нь эмгэн, лакшмин (эд баялагийн охин тэнгэр) гэсэн хоёр утгатай. Иймд өнгөн утгандаа баян хүн ядуугийн дүрээр зүсээ урвуулж үгээ хувилган “юм хайрлаач, эд баялагийн охин тэнгэр ээ” гэж хэлж буй. Энд зүсээ урвуулсан баяныг ядуугийн байдлаар дүрслээд, эд баялагийн охин тэнгэрийг эмгэн болгон хошигнож утгыг нууснаар машид нэрийдсэн далдлахуй үгийн чимгийг бүтээжээ (ДЗАТ. 1982. т.151).

**Нэрээр хураагч** (ca. nāmantarita, тө. ming du `dus pa). Аливаа нэг нэр нь олон утгатайн улмаас эндүүрэл төрүүлж байвал түүнийг нэрээр хураагч гэнэ. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Дандин:

Бат бус нүдэт зарим газар төгөлдрийг  
Анхан раажа хэмээн дуурссанаар  
Санаатана бөгөөд энэ нь  
Хаан бус, Вишнү бус

Энэ шүлэгт “модны хаан” гэсэн нэрийг хурааж нуусан (ДЗАТ. 1982. т.152) байдал нь санскрит шүлгийн эхээс харагдана.

**Халхлагч** (ca. nibhṛita, тө. sgrib ma). Тухайн үгийн үндсэн утгыг өөр юмны нэрд давуулан гүтгээд улмаар утгыг нь халхалсан үгийг халхлагч нууц үг хэмээнэ. Энэ нь үгийн үндсэн утгыг үүргээр нь шилжүүлэн хэрэглэх нэгэн зүйл арга. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Дандин:

Эдээс ангижирсан хүнийг огоороод  
Эд төгөлдөр бүхэн рүү одогч алимад  
Элдэв зуун аргаар ертөнц дахиныг урхидагч  
Элэхүйеэ бэрх янхан эм мөн буюу

гэх энэ санскрит жишээ шүлэгт үгээгүй ядууг үл тоомсорлон баячуудын дэргэд одохдоо эд хөрөнгө олохын тулд зүсэн зүйлийн аргаар тэднийг биедээ татагч янхан эм гэснээр янхан эмийн бузар явдлыг доромжилсон мэт боловч чухамдаа түүний тухай хэлээгүй аж. Учир янхан эм гэсэн үгийг үндсэн утгаар нь бус шилжүүлсэн утгаар хэрэглэжээ. Элдвийн аргаар хөлжиж баяждаг хаан хүн бол янхан эм мөн болохыг энд хэлсэн байна. Иймд энэ шүлгийн утгын нуугдахуун нь хаан, нуугч нь янхан эм юм (ДЗАТ. 1982. т.152)

**Зохилдох аялгуугаар** (ca. samānaśabda, тө. mthun pa'i sgra). Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Дуудлага ондоо, утга ижил үгээр шүлгийн утгыг нууж өгүүлэх нэгэн зүйл найруулгын арга. Дандин:

Чиний дэлхий бус нэр лүгээ зохилдсон алин  
Сайтар болсон үс нэртээс ялгуусан  
Тэр бээр эдүгээ намайг асар  
Хурьцал төгөлдөр болгов, яруу аялгуут эх ээ!

Зохиолдох аялгуугаар нуусан нь санскрит эхээсээ тодорхой харагдана. Уг шүлгийн утгыг товч хэлбэл “үзэсгэлэнт эм чиний уруул нь шүрнээс ч хэтэрхий улаан тул би бээр хүсэл төгөлдөр болов, яруу

аялгуут эхээ” гэж болно. Өөрийн хүслийг ил хэлэхгүйн тулд ийнхүү ижил нэрийн тусламжтайгаар хэлэх гэсэн санаагаа нуужээ (ДЗАТ. 1982. т.153).

**Мунхруулагч** (ca. sammūthā, тө. rmongs pa). Алимад утгыг илэрхий үзүүлсэн ч гэлээ аяндаа будлиантай бол түүнийг мунхруулагч гэнэ. Далдлах үгийн нэг зүйл. Өгүүлэх гэсэн юмны утга тодорхой мэт боловч урьд хэлсэн нь хойно өгүүлсэнтэйгээ харшлан уншигчийг будлианд оруулах нэгэн зүйл найруулгын арга. Дандин:

Хүсэл төгөлдөр нар нь ор дэвсгэртээ /байхдаа О.С/  
Хилэгнэсний тулд эргэн хэвтэцгээх агаад  
Тачаалын эрхээр мөнхүү түүнчлэн хэвтэж  
Алгуураар хоёр амаа хавсарму (ТМДДЗАТ. 2017. т.607)

Энэ шүлгийн санаа нь “хоёр амраг бие биедээ хилэгнэн орон дээрээ буруу харан хэвтэх агаад тачаалын эрхээр тэр мэт хэвтэж байхдаа бие биеийн амыг озмуй” гэсэн байна. Энд харилцан бие биедээ хилэгнэсэн эр эм хоёр ар нуруугаа нийлүүлэн орон дээрээ хэвтнэ гэсэн атлаа тачаангуйгаараа тэрчлэн хэвтэнэ гэж хэлсэн байна (ДЗАТ. 1982. т.153)

**Огоот булаагч** (ca. pariḥārika, тө. yongs su 'phrog). Өгүүлбэрийн бүрэлдэхүүнд орсон нууц утгатай үгийн нэг нь нөгөөгөө тодотгосон, эсвэл урд өмнө гарсан утгыг дараа дараачийн утгаар булаалган бичих аргыг хэлнэ. Ингэж бичихэд илт өгүүлэх нэр чухал үүрэгтэй. Далдлах чимгийн нэг зүйл. Дандин:

Шувууны хааны идээнээс төрөгчийн дайсан бээр  
Ламын гэрлээр дарагдсан төрөлхтөн  
Цасаар дарагдагчийн нөхөр бусыг баригч бээр  
Түгсэн огторгуйд илтэд бөгөөд баясмуй (ТМДДЗАТ. 2017. т.608). Энд гарч буй илт өгүүлэх нэр нь шүлгийн санааг ойлгох түлхүүр болно. Үүнд шувууны хаан нь гарди, рашаан идээт нь хурмаст, цасыг дарагч нь гал, түүний нөхөр бус нь ус, усыг баригч нь үүлний ёгт нэрс болно. Энэ шүлэг нь “Энэ хүн нарны халуунаар энэлээд тэнгэрийг үүл бүрхэхүйд баясмуй” гэсэн утгатай байна (ДЗАТ. 1982. т.154).

**Гагцхүү халхлагч** (ca. ekaścannā, тө. gcig bsgribs). Шүтээнийг нь сайтар нуугаад шүтэгчийг нь гаргах найруулгын арга. Өөрөөр хэлбэл үйл нь тодорхой гарсан атлаа үйлдэгч нь халхлагдсан чимэг. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Дандин:

Хэзээ мэс хийгээд хатагтайн  
Хөхний мандалд эс хүрсэн  
Хүмүүн бус зарим нэгний  
Гар нь үргүй мөн буюу хэмээмүй.

Жишээ шүлгийн утга нь аливаа хүний гар нь мэсэнд хүрвэл байлдаанд орох, эхнэрийн хөхөнд хүрвэл хүсэл тачаал төрүүлдэг байхад тэр мэт үйл үүсгэдэггүй нь хүн бусын зарим нэгний гар болно гэсэн байна (ДЗАТ. 1982.154-155).

**Хоёр бүрийг халхлагч** (ca. ubhayacchannā, тө. gnyis bsgribs). Алинаа хоёуланг нуугч тэр нь хоёуланг халхлагч мөн гэх нь шүтээн, шүтэгч хоёрыг халхан бичиж найруулах арга. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Дандин:

Хэн бээр алин лугаа нөхөрлөснөөр  
Хамаг үйлсэд чухал хэрэгтэй больюу  
Харин идээний цаг өнөд дор  
Хэрвээ үзэгдвээс огоорон үйлдмүй.

Дээрх санскрит жишээ шүлэг нь “Төрөлхтөн хэн бээр үс хийгээд толгой лугаа нөхөрлөхийн цагт үс нь угаалга, номлол тэргүүтний хамаг үйлсэд чухал үүрэгтэй бөгөөд харин хооллохын цагт хоол унданд үсний нэгээхэн ширхэг унасан нь үзэгдвээс огт хэрэггүй зүйлд тооцогдоно. Өөрөөр хэлбэл үс толгойд байхдаа хэрэгтэй, унасан хойноо хэнд ч хэрэггүй юм гэсэн санаа. Энд шүтээн болох толгой, шүтэгч болох үс хоёрыг нуусан байна. Тэгэхдээ “хэн бээр алин лугаа нөхөрлөсөн” гэдэг нь үс, толгой хоёрыг халхалсан аж. Иймээс хэн хийгээд алин гэдэг үгсийг шүтээн толгой, шүтэгч үс гэж ухаарснаар энэ чимгийг ойлгоно (ДЗАТ. 1982. т.155-156).

**Огоот нийлэлдэх** (ca. samkīrna, тө. yongs su 'dres pa). Үсэг нь мэдэгдэвч үг байна гэж анзаарагдахааргүй чимэглэн бичих аргыг огоот нийлэлдэх, огоот холилдохуй нууц үг гэнэ. Далдлах үгийн чимгийн нэг зүйл. Дандин:

Ха яа га жа бха та-гийн  
Хамаг аймгийг хэрвээ эс ялгаваас  
Маатрика-г үл мэдэх бидний хүү нь  
Магад энэ үсгүүдийг мэдлээ ч мунхаг буюу

Санскрит жишээ шүлэгт гарах *Ха, яа, га, жа, бха, та* гэсэн цагаан

толгойн үсгүүд байвч утга мэдэгдэхгүй. Харин эдгээр үсгүүдийг хоёроор нь залгаж бүтээвэл нуугдахуун утга тодорно. *Ha ya* хоёр нийлбэл морь, *ga ja* хоёр нийлбэл заан, *bha ta* хоёр нийлбэл баатар гэсэн үг болно. Иймд энэ шүлэгт морин цэрэг, заант цэрэг болон баатруудыг нууж өгүүлсэн байна (ДЗАТ. 1982. т.156).

**Тав. НАЙРУУЛГЫН АРВАН ГЭМ** (тө. *snyan ngag gi skyon bcu*).  
Зохист аялгууг зохисгүй болгодог гэмүүд. Зохист аялгуунд эс зохилдох гэмийг Дандин дэс дараалан дурьджээ. Найруулгын арван гэм нь: 1.Утгаас ангижирсан, 2.Харш эсрэг утгат, 3.Нэгэн утгат, 4.Эргэлзээт утгат, 5.Дараалал дорой, 6. Үг аялгуу сул, 7.Зогсоц дорой, 8.Холбон найруулахын гэмтэй, 9.Адаг завсрын барилдлагаас ангижирсан. 10. Харшлах(орон, цаг, цог заль, ертөнц хийгээд эш ухаан лугаа) - энэ **арван гэмийг** зохист аялгуунд эрхбиш тэвчих хэрэгтэй гэж зохист аялгуучин нарт сануулсан байдаг. Эдгээр 10 зүйл гэм нь яруу сайхан найруулж чадаагүй найруулгын алдаа дутагдал болно (ДЗАТ. 1982. т.157). Гэхдээ эдгээр гэмийн зарим нь зарим тохиолдолд эргээд уран найруулахын эрдэм болдогийг Дандин бээр мөн жишээгээр үзүүлжээ.

**Утга буурахын гэм** (са. *apārtham*, тө. *don nyams pa'i skyon*).  
Өгүүлэгч этгээдийн үгс нь тодорхой нэгэн багц утгагүй бол түүнийг утгаас ангижирсан буюу утга дорой гэнэ. Тийм үгсийг галзуу согтуу хүн, учир мэдэхгүй нялхасын чалчаа үгээс ангид үзэх хэрэгтэй. Зохист аялгуунд тийм үгсийг хэрэглэх нь гэмтэй гэж Дандин тэмдэглэжээ. Найруулгын 10 гэмийн нэг зүйл.

**Утга харшлахын гэм** (са. *vyartham*, тө. *don 'gal ba'i skyon*).  
Өгүүлбэрийн эхэнд хэлсэн зүйл нь дараагийн зүйлтэйгээ харшлах нь “утгаас ангижирсан” буюу утга харшлах гэм болно. Найруулгын 10 гэмийн нэг зүйл. Дандины:

Дайсан язгууртан бүхнийг дарах ба

Элдэв үүрэг үүнээс ялах болтугай

Хамаг бүднэрээ, энэрэлт

Чамд дайсан хэн бээр ч үгүй буюу (ТМДДЗАТ. 2017. т.620)

гэх санскрит жишээ шүлэг нь “Чи бээр дайсан язгууртнаа дарах болтугай. Энэрхүй чамд эсэргүүцэх дайсан үгүй болой” гэсэн утгатай аж. “Дайсан язгууртан”, “дайсан үгүй” хоёр нь хоорондоо, “дарахуй”,



“энэрэхүй” хоёр нь бие биедээ тус тус харшилсан байна (ДЗАТ. 1982. т.158).

**Утга харшлахыг ариутгасан чимэг** (тө. don 'gal ba'i dmigs gsal). Утга харшилсан гэм нь найруулгад гэм болохгүй харин ч уран найруулгын эрдэм болж болох арга. Дандины жишээ:

Хутагтан нугууд бээр бусдын  
Хатагтайд хурьцах нь хаана зохих.  
Түүний хөдлөгч шүдний бүрхүүл нүгүүдийг  
Би нь хэзээ нэг уух болму уу (ТМДДЗАТ. 2017. т.622)

Энэ шүлэгт “Хутагтан хүн бусдын эхнэртэй хурьцах нь зохимжгүй гэсэн атлаа хэзээ нэгэн цагт түүнтэй хурьцан уруулыг нь шимнэ” гэсэн нь өмнөх хэсэг нь хойно өгүүлсэнтэйгээ харшилж байна. Гэхдээ энэ нь барьж дийлэхгүй хүсэл дурлалын гайхамшгийг үзүүлэх жишээ болж буй учир утга харшлахыг ариутгасан чимгийн жишээ болж байна (ДЗАТ. 1982. т.159).

**Нэгэн утгатын гэм** (са. ekartham, тө. don gcig pa'i skyon). Адил утгатай үгсийг ойролцоо газарт олон оруулбаас тэдгээр нь нэгэн утгатын гэм болно. Найруулгын 10 гэдийн нэг зүйл. Дандины:

Хурьцал хурцахуй охидууд  
Түүний хөхлийн гэрэлт  
Гилбэлгэн лүгээ төгөлдөр усан баригчаас  
Эдгээр гүн дуун дуурсвай (ТМДДЗАТ. 2017. т.624)

Энэ жишээ шүлэгт: “хурьцал”, “хурьцахуй” хоёр нь нэгэн утгатай. Мөн “усан баригч”, “гилбэлгэн лүгээ төгөлдөр”, “гүн дуун дуурсагч” гэсэн гурав нь “үүл” гэсэн нэг ижил утгатай үгс. Иймд ижил утгатай үгсийг шаардлагагүй газарт давтан оруулснаар энэ шүлгийн найруулга буурчээ (ДЗАТ. 1982. т.159).

**Нэгэн утгатыг ариутгасан чимэг** (тө. don gcig pa'i dmigs gsal). Нэгэн утгатай үгийг олон удаа давтваас зохист аялгууны найруулгад муугаар нөлөөлдөг боловч мөн нэгэн утгатай үгийг давтан хэрэглэх нь зарим үед сайн найруулгын чимэг болдог байна. Дандин:

Учиргүй таалан өшилснөөр  
Тэр эрхэн хатагтай дарагдах больюу  
Хамаг үзэсгэлэнт гишүүн нь дарагдах больюу  
Зөөлөн аялгуу нь дарагдах больюу (ТМДДЗАТ. 2017. т.626)

Энэ санскрит жишээ шүлэгт “дарагдах больюу” гэсэн хэллэг гурван удаа давтагджээ. Энд хүсэл хурьцлын үед догширч хилэгнэсэн хатагтай дарагдана, бас үзэсгэлэнт гишүүн болох бие эрхтэн нь дарагдана, мөн зөөлөн аялгуу нь дарагдана гэсэн байна (ДЗАТ. 1982. т.160).

**Түүдрэлтийн гэм** (ca. samaśayam, тө. the tshom can gyi sky-on). Магадтай буюу бодитой утгаар найруулсан үгс нь уг чанартаа тээнэгэлзэл төрүүлж, уг шүлэгт шаардлагагүй байх юм бол түүнийг эргэлзээтийн гэм гэнэ. Судлаачид тэгүүдрэлт-эргэлзээт (Ш.Бира), түүдрэлт (Л.Хүрэлбаатар), түгдрэлт (Гэлэгжалцан) гэж олон янзаар нэрлэж иржээ. Найруулгын 10 гэдийн нэг зүйл.

**Түүдрэлтийг ариутгасан чимэг** (тө. the tshom can gyi dmigs gsal). Эргэлзээ төрүүлж буй үгс нь эргээд чимэг болох тийм найруулгын арга. Дандин:

Дорой бус тэр нь биеэс төрсөн  
Аюулаар нэрвэгдээд мөнхүү  
Сэрүүний цагаар баримтлан үзмү  
Ба бүрэн чамд эгээрэх үгүй болой (ТМДДЗАТ. 2017. т.630)

Санскрит жишээ шүлгийн “Дорой бус буюу үзэсгэлэнт эм биеэс төрсний аюулд нэрвэгдэж” гэсэн нь хоёрдмол утгатай байна. “Биеэс төрсөн” хэмээх нь хүслээр нэрвэгдсэн, халуунд энэлсэн гэсэн хоёр утгатай. Биеэс хүсэл тачаал хийгээд халууны элч төрөх тул энэ шүлэгт чухам аль утгаар орсон нь эргэлзээ төрүүлнэ. Гэвч аль ч утгаар нь ухаарлаа гэхэд энэ нь урнаар илэрхийлсэн үгийн чимэг болох учраас найруулгад гэм болохгүй ажээ (ДЗАТ. 1982. т.161)

**Зэрэг буурахын гэм** (ca. aprakramam, тө. gim pa nyams pa'i skyon). Өгүүлж буй зүйлсийн утгын дараалал алдагдах гэм. Өөрөөр хэлбэл, эхэнд хураан тоочсон зүйлийн утга хойшид өгүүлэх юмтай дарааллын хувьд уялдаагүй болсон найруулгын алдааг зэрэг буурсан, дараалал доройтсон гэнэ. Найруулгын 10 гэдийн нэг зүйл. Дандин:

Амьтдыг оршуулагч хийгээд  
Хувилгагч ба эвдэгч шалтгаан эс төрсөн  
Жаргаланг гаргагч, хурьцал үгүй, уснаас ургагчийн  
Төрөл оронг бээр та бүхнийг сахитугай (ТМДДЗАТ. 2017. т.633).  
Энэ жишээ шүлэгт “амьтдыг оршуулагч, хувилгагч, төрүүлэгчийн

шалтгаан” гэж эхний хоёр шаднаа товчлон тоочоод, сүүлчийн хоёр шаднаа “Жаргалыг гаргагч” Шива, “Хурьцал үгүй” Вишнү, “уснаас ургагч” Брахмагийн нэрийг дараалуулсан нь зэрэг буурсны гэмтэй болсон ажээ(ДЗАТ. 1982. т.162).

**Зэрэг буурахыг ариутгасан чимэг** (тө. rim pa nyams pa'i dmigs gsal).  
Өгүүлж буй юмс үзэгдлийн зүй зохист дараалал алдагдах нь зарим тохиолдолд найруулгын чимэг болох тал бий. Энэ зэрэг дараалал буурах нь найруулгын чимэг болж болох үеийн эрдэм болох чимэг. Дандины:

Ураг элгэнээ огоорох, унаган биеэ огоорох,  
Улс орноо огоорох хэмээсэн гурванаа  
Анхны ба эцэс нь өнөдөд зовних бөгөөд  
Дундад нь агшин дор энэлэх болой.

Энэ шүлэгт уран элгэнээ болон эх орноо умартвал үүрд зовож, биеэ умартвал агшин төдий зовох гурван зовлон байдгийг өгүүлэхдээ эхний хоёр мөрт ургаа мартаж, биеэ умартах, орноо умартан гурваныг хураан номлоод сүүлийн мөрөнд анхны ба эцсийнх нь үүрдийн зовлон эдэлнэ, дундах нь агшны зовлонг эдэлнэ гэсэн санаа юм (ДЗАТ. 1982. т.162.)

**Аялгуу буурахын гэм** (са. śabdahīnam, тө. sgra nyams pa'i skyon).  
Өгүүлбэрт тааруулсан үгс нь журамлан тогтоосон хэл зүйн дүрэмтэй харшилсан бол аялгуу буурсан найруулгын гэм болно. Үүнийг бас үг аялгуу сул гэж нэрлэдэг. Найруулгын 10 гэрийн нэг зүйл. Дандины:

Далай бүст дэлхий их хаан чамайг  
Өмгөөр сахитугай хэмээснийг  
Мэдэн дурших үгүйн тулд  
Энэ аялгуунд нь буурсан буй бус (ТМДДЗАТ. 2017. т.637)

гэх жишээ шүлэгт санскрит хэлзүйн дүрмийг гажуудуулснаас “Бүслүүр мэт дөрвөн их далайтай энэ дэлхийн их хаан чамайг өмөг садан бээр сахитугай” гэсэн барилдлагагүй утгыг бий болгожээ. Зүй нь “Бүслүүр мэт дөрвөн их далайтай энэ дэлхийг их хаан чиний өмөг хүчин бээр сахитугай” гэж найруулбал зөв болох байжээ (ДЗАТ. 1982. т.163).

**Аялгуу буурахыг ариутгасан чимэг** (тө. sgra nyams pa'i dmigs gsal). Өгүүлбэрт найруулсан үгс нь хэлзүйн дүрэмтэй харшилж аялгуу буурсан мэт боловч зарим тохиолдолд эргээд өвөрмөц найруулгын

эрдэм бий болгох урлах арга чимэг. Дандины бичсэн жишээ санскрит шүлэг нь

Өмнийн уулнаас чухал хийссэнийг

Хий бээр хөлөөр уугч Зуда

Гишүү навчис цэнгэн хөдөлж

Үзэсгэлэнт ногоо лугаа төгсөн үйлдмүй (ТМДДЗАТ. 2017. т.638)

гэсэн энэ бадаг шүлэг нь санскрит хэлний 5-р тийн ялгалын оронд 7-р тийн ялгалын нөхцөлийг авч хэрэглэх ёстой байсан. Тэгэвч энэ хоёр тийн ялгал нь бие биеэ нөхөх боломжтой учир энэ нь найруулга бууруулаагүйн жишээ болжээ (ДЗАТ. 1982. т.163).

**Зогсоц доройн гэм** (ca. zatibhrashtam, тө. gcod mtshams nyams pa'i skyon). Шүлгийн түдлэг зогсоц байх газартаа байхгүй болсноор сонсоход чихнээ яруу бус болж эндүүрэл төрүүлэх найруулгын гэм. Зохист аялгууны найруулгын 10 гэмийн нэг зүйл (ДЗАТ. 1982. т.164).

**Холбон найруулахуй буурсан** (ca. bhinnavrittam, тө. sdeb sbyor nyams pa). Энэ нь үсэг илүү эсвэл дутуу хийгээд хүнд хөнгөн нь ёсоор эс орсон байваас түүнийг холбон найруулахуй буурсан гэнэ. Энэ нь маш доорд гэмт болой (ДЗАТ. 1982. т.165) гэжээ. Холбон найруулахын байдал буурсан гэм нь найруулгын 10 гэмийн нэг зүйл. Дандин:

“Сарны маш сэрүүн гэрлээр

Хүрэлцсэн” хэмээх нь үсэг дутуу бөгөөд

“Сахакаарын шинэ навч

Тустай” хэмээсэн нь үсэг илүү болмуй.

“Тачаангуйн хурц мэсээр гөрөөсөн нүдэтийг

Сайтар харвамуу” хэмээсэн нь хүнд ёсчлон бус буюу

“Үзэсгэлэнт нүдэт нүгүүдэд согтоон үйлдэгчийн

Хурц сум тусмуу” хэмээсэн нь хөнгөн ёсчлон бус

(ТМДДЗАТ. 2017. т.645-646)

Санскрит эхдээ энэ хоёр жишээний эхний шүлэг нь үсэг дутуу, дараагийн шүлэг нь үсэг илүүдсэн гэмтэй аж. Үсэг дутуудах буюу илүүдсэнээр шүлгийн хэмжээний тэнцэл алдагддаг ажээ. Тэрчлэн хүнд үсгийн орвол зохих газарт хөнгөн үсэг орох, хөнгөн үсгийн оронд

хүнд үсэг орсныг хүнд, хөнгөн үсэгт шүлэг гэх бөгөөд энэ нь холбон найруулах ёсонд харшилна(ДЗАТ. 1982. т.165).

**Завсрын барилдлагаас ангижирсан гэм** (ca. visandhikam, тө. mt-shams sbyor nyams pa). Энэ нь санскрит хэлний сандхийн дүрэм гэнэ. Энэ дүрэм нь өгүүлбэрт зэрэгцэн орсон хоёр үгийн эцсийн болон эхний үсэг бие биедээ ижилсэн татагдах нөхцөлд уул хоёр үгийг нийлүүлэн бичдэг арга юм. Ингэж нийлүүлэн бичсэн тохиолдолд уул үгсийн утга өөрчлөгдөхгүй. Зохист аялгууны найруулгын арван гэмийн нэг.

**Харшлахуйн гэм ба эрдэм** (ca. virodha тө. yul sogs drug dang 'gal pa'i skyon). Зохист аялгуучин бээр санаатай санамсаргүйгээр цаг улирал, орон байр, учир шалтгаан зэрэг зүй тогтолцоотой зүйлсийн зөв зүй тогтолцоог алдуулан харшуулан найруулах гэм. Харшлахуйн гэм 6 зүйл байна. Үүнд: Орон харшлах, цаг улирал харшлах, ид заль харшлах, ертөнц лүгээ харшлах, учир шалтгааны зүй лүгээ харшлах, эш лүгээ харшлах эдгээр болно.

Мөн аливаа үзэгдэл юмсын зүй тогтолтыг харшуулж найруулсан нь заримдаа эргээд уран найруулгын эрдэм болдог арга бас байна. Дандин бээр эдгээр харшлахуйн гэм ба эрдмийг тодорхой үзүүлжээ.

**Орон харшилсан** (ca. deśavirodha, тө. yul dang 'gal pa). Хоорондоо алс зайдуу орших хоёр газрыг нэг дор байдаг мэтээр дүрслэх, тухайн газарт байдаггүй зүйлийг байдаг мэтээр бичих нь орон харшилсны гэм болно. Орон гэдэгт ой мод, уул ус, орон улс хүрээлэн буй байгаль орчныг хамаатуулан хэлсэн байна. Дандин:

Хөлөөр уугчид хүрэлцсэн газрын  
Малаяагийн сайн үнэрт хий  
Калингагийн ойд төрсөн заанууд нь  
Гөрөөсөн язгуурт (ТМДДЗАТ. 2017. т.653)

Энэ шүлэг нь орон харшилсны жишээ юм. Малаяа ууланд гаврын мод ургадаггүй тул орон харшилжээ. “Калингагийн ойд төрсөн заанууд нь гөрөөсөн язгуурт болой” гэсэн нь мөн адил. Заан нь гөрөөсөн язгуурт бус тул мөн харш болно (ДЗАТ. 1982. т.167-168).

**Орон харшлахуйн эрдэм** (ca. deśavirodha asya guns, тө. yul dang 'gal ba'i dmigs gsal). Зарим тохиолдолд орон харшилсан ч тэр нь зохист аялгуунд гэм болохгүй, харин орон харшлах нь гэм үл болж, харин урлахын арга болохыг Орон харшлахуйн эрдэм гэнэ. Дандин:

Тэр хааны хүчээр үүсгэмэл цэцэрлэгт нь  
Тэнгэр нарын орны, гишүүн навчит  
Гал улаан хувцас лугаа төгөлдөр  
Галбарваасан модод орших болбай (ДЗАТ. 1982. т.173)

Галбарваасан мод нь тэнгэр нарын орны мод. Тэгтэл жишээ шүлэгт тэнгэрийн орны галбарваасан модыг гал улаан хувцас лугаа төгөлдөр хааны цэцэрлэгт оршин буй гэсэн нь хааны ихээхэн буянт, дээд хувьт болохыг өгүүлсэн жишээ болно.

**Цаг харшилсан** (ca. kālavirodha, тө. dus dang 'gal pa). Амьтан ургамлын амьдралын жам ёс, байгалийн элдэв юмс үзэгдлийн зүй тогтлыг зохих цаг улирлаас нь салган урвуулж бичсэнийг цаг харшлахуйн гэм гэнэ. Дандин:

Лянхуатан нь шөнөд дэлгэрээд  
Гүмдатан нь өдөрт гиймүй  
Ничүла нь хаварт сайтар дэлгэрмүй  
Дэгжлийн цагуудад үүлс бүрхмүй (ТМДДЗАТ. 2017. т.655)

Энэ шүлэг цаг улирал харшилсны жишээ байна. Энд лянхуан чуулган нь шөнө дэлгэрч, гүмдаагийн чуулган өдөр дэлгэрнэ гэсэн байна. Лянхуа бол наранд дэлбээгээ задалж, саранд хумьдаг тул цаг лугаа харшилж байна. Тэрчлэн гүмдаа цэцгийн дэлбээ нь сарны гэрэлд нээгдэх тул эсрэгээр үзүүлсэн нь мөн л цаг лугаа харшилсан. Ничүла цэцэг хаврын улиралд дэлгэрнэ гэснээрээ энэ шүлэг нь цаг улирал лугаа харшилжээ. Энэ цэцэг намрын улиралд дэлгэрдэг. Тэрчлэн гэжээлийн цагт өдөр нь их үүл гарна гэсэн нь мөн цаг харшилжээ. Тэжээлийн цаг гэдэг нь зуны нэр. Хурын улиралд болдог байгалийн үзэгдлийг зуны цагт болдог мэтээр үзүүлснээрээ цаг харшилж байна. Мөн Энэтхэгчүүдийн заншлаар бол галууны дууг намар сонсвоос тааламжтай ажээ. Намрын цагт тэнгэр дуугардаггүй атал тогос шувуу баясана гэсэн нь харшилжээ. Тогос нь гагцхүү үүл гарч бороо орох үес буюу хурын улиралд баясдаг ажээ. Мөн өвлийн улирал нь хүйтэн сэрүүн учраас зандан модыг магтан бичих нь зохимжгүй. Энд магтах биш нь харш болжээ (ДЗАТ. 1982. т.168-169).

**Цаг харшлахуйн эрдэм** (тө. dus dang 'gal ba'i dmigs gsal). Цаг харшлах гэм нь зарим үед буруу болохгүй харин өвөрмөц уран найруулгын эрдэм болдог арга. Дандин:

Хааны үхлийг урьдаас зөгнөх догшин салхи  
 Гаадамбын эр бэлгийн эс лүгээ нөхцөн  
 Долоон навчитаас ургасан нахиаг  
 Дор нь хөдөлгөн хийсгэж одном.

Долоон навчит модны нахиа намрын улиралд, гаадамбын цэцэг хурын улиралд тус тус дэлгэрдэг байтал нэгэн цагт зэрэгцэн оршиж байгаа мэтээр энд дүрслэгдсэн нь цаг зөрчилдөж байна. Гэвч энэ нь хааны үхлийн муу зөн болж чадахгүй юм. Долоон навчит, гаадамба хоёрын нахиалж, цэцэглэхийг тус тусын цагаас салган муу зөнгийн бэлгэдэл болгон бичсэн нь зөвхөн яруу найрагчийн уран саналга болох учир цаг харшилсны эрдэм болж байна (ДЗАТ. 1982. т.173-174).

**Ид заль харшилсан гэм** (ca. kalāvirodha, тө. sgyu rtsal dang 'gal ba). Урлахуй ухаанд багтдаг урлагийн салбаруудыг ид заль хэмээн ойлгож болно. Санскрит яруу найрагт хүний сэтгэлийн хөдөлгөөний гадаад илрэлийг илэрхийлэх аргуудыг рас гэдэг. Рас нь хээмсэглэхүй, инээдэм, оргилуун, баатарлаг, хилэгнэхүй, аймшиг, зэвүүцэх, гайхамшиг гэсэн найман янз байдаг. Расыг санскрит уран зохиолын онолд яруу найргийн сүнс гэнэ. Хэрвээ шүлэгт рас үгүй бол тэр нь уншигчдад цэнгэл төрүүлэхгүй гэж үзэж иржээ (ДЗАТ. 1982. т.169-170).

**Ид заль харшлахын эрдэм** (ca. kalāvirodhagūṇa, тө. sgyu rtsal dang 'gal ba'i dmigs gsal). Ид заль лугаа харшлавч зарим тохиолдолд тэр нь найруулгад гэмгүй харин ч эрдэм болох арга. Дандин:

Савлуур дүүжинд асар хөдөлж зүдсэн  
 Сайхан хатагтайн амнаас дуурсахуй дууны  
 Ая хэм нь тэгш бус байснаас  
 Амраг тачаангуйтны тачаалыг арвитгав.

Жишээ шүлэгт ид заль лугаа харшлахын эрдмийг гаргажээ. Дуулсан дууны ая нь хэмнэл үгүй, сонсоход зохистой бус боловч, янагийн хүчтэй сэтгэгдлийн улмаас зөвхөн авианы дуурслыг сонссон төдийгөөр дотоод сэтгэл ихэд татагдаж буйг үзүүлжээ (ДЗАТ. 1982. т.174).

**Ертөнц харшилсан гэм** (ca. lokavirodha, тө. 'jig rten dang 'gal pa). Ертөнцийн жам ёстой харшлах найруулгыг ертөнц харшилсан гэм гэнэ. Дандин:

Аварга заанууд дэлээ хөдөлгөнө  
Агт морины эвэр нь хурц  
Эрэнда хэмээхийн зүрх нь хүнд  
Гадира мод нь зүрхэн үгүй

гэх ертөнц харшилсэн жишээнд: заан дэл зогдоргүй тул дэлээ хөдөлгөнө гэсэн нь утгагүй юм. Морины эвэр хурц гэсэн нь зүй тогтлоос ангид зүйл. Эрэнда нь усанд ургадаг, тослог үртэй нэг төрлийн зэгс. Гадира маш хатуу модны тоонд багтдаг тул ертөнцийн зүй тогтолтой харшилж алдаа болж байна (ДЗАТ. 1982. т.171)

**Ертөнц лугаа харшлахын эрдэм** (ca. lokavirodhaguṇa, тө. 'jig rten dang 'gal ba'i dmigs gsal). Ертөнцийн жам ёстой харшилж байвч, тухайн тохиолдолд найруулгын уран арга болох үед гэм бус эрдэм болох арга. Дандин:

Сарны гэрэл маш сэрүүн бөгөөтөл  
Түлэгдэхүүнийг баригч(гал) хэмээн  
Хатагтайгаас хагацаж нисванисаар хутгалдсан  
Тачаангуйтан эд бээр тооцон үйлдмүй (ТМДДЗАТ. 2017. т.671)

Энэ жишээнд сарны гэрлийг сэрүүн бус, гал мэт халуун гэж үзэх нь ертөнцийн жам ёстой харшлавч энэ нь хагацалд нэрвэгдсэн хүмүүсийн үзэл болох тул зохист аялгууны гэм болохгүй эрдэм болж байна (ДЗАТ. 1982. т.174). Саран гарч шөнийн сэрүүн сайхан болоход амрагаасаа холдож хагацсан нэгэн бээр санасан сэтгэлийнхээ халуун энэллийг ийн өгүүлж болно.

**Ухаан харшилсан** (ca. hetuvidyavirodha, тө. rigs pa dang 'gal pa). Учир шалтгааны ухаан хийгээд сэтгэхүйн хууль зүй лугаа харшлахыг ухаан харшилсан гэнэ. Дандины жишээ:

Сайвар одсон хуран үүдсэнийг эвдэрмү хэмээн  
Номлосон нь үнэн амуй за тэр мэт боловч  
Чакорагийн нүдэт тэр нь  
Миний сэтгэлд эдүгээ оршин амуй (ТМДДЗАТ. 2017. т.662)

Энэ шүлэгт хуран үүдсэн юм бүхнийг Сайвар ажирсан гэх Бурхан багш мөнх бус гэсэн байтал чакорагийн нүдэт буюу сайхан нүдтэй үзэсгэлэнт эм тэр нь миний сэтгэлд мөнх оршино гэж хэлснээрээ энэ нь дотоод ухаан лугаа харшилжээ. Дотоод ухаан гэдэг нь Бурхны сургаал буюу түүний талынхны үзэл болой. Энэ үзлийг баримтлагчдыг



дотоод номтон гэнэ (ДЗАТ. 1982. т.171-172).

**Ухаан лугаа харшилсны эрдэм** (ca. nyāvirodhasya guṇa, тө. rigs dang 'gal ba'i dmigs gsal). Энэ нь сэтгэхүйн хууль зүй, учир шалтгааны ухааны үүднээс зөрчилдөж ухаан харшилсан боловч тухай үед уг зүйлээ сайн сайхан болгож үзүүлэх нь гэм бус харин эрдэм болох арга юм. Дандины жишээ:

Үзвээс хэмжигдэхүүн мөн боловч хэмжигдэхүүн бус  
 Үр төгөлдөр мөн боловч бас үр төгс бус  
 Үнэнхүү гагц мөн боловч ямагт гагц бус  
 Үйлсийн элдэв дүрст Вишнү чамд мөргөмүй.

Үйлсийн элдэв дүрст нь Вишнү тэнгэрийн олон үйлсийг заасан нэр. Ерөнхийдөө хэмжигдэхүүн мөн хийгээд хэмжигдэхүүн бус, үр төгөлдөр ба үр төгс бус, гагц мөн ба ямагт гагц бус нь нэгэн зэрэг орших аргагүй тул харшлах ойлголтууд юм. Гэвч эдгээр нь Вишнү тэнгэрийг дүрслэх үед харин ч түүний хүмүүн амьтанд туслах үйлс чадлыг элдэв олон өнгийг илэрхийлэх арга эрдэм болжээ. (ДЗАТ. 1982. т.175).

**Эш харшилсан** (ca. nyāyavirodha, тө. lung dang 'gal ba). Судар дандарын гол номыг багш нь шавьдаа уншин сонсгож улмаар мөрдөж явах зан үйлийг сайтар эзэмшүүлэх сургаалыг эш хэмээдэг. Ийн эш онол номлолоос зөрсөн гэмийг эш харшлах гэнэ. Дандин:

Галаа эс уугиулсан боловч  
 Хөвгүүн төрөхүй дор бярманы буурал үгүй  
 Явдлаар чимсэн эдгээрийг инү  
 Галын бурханд тахил өглөг үйлдмүй.

Энэ шүлэгт хүү төрөхийн цагт урьдаар зан үйлийг үйлдээд дараад нь судар унших ёстой адил энд зан үйлийг эс үйлдэн вед судар уншсан тухай өгүүлснээрээ эш харшилжээ (ДЗАТ. 1982. т.172-173) гэж зохист аялгуучид тайлбарлажээ.

**Эш лүгээ харшлахын эрдэм** (ca. āgamavirodhasya guṇa, тө. lung dang 'gal ba'i dmigs gsal). Энэ нь эш харшсан боловч тухайн шүлгийн санааг уран тод болгож байвал тэр нь эргээд гэм бус эрдэм болдог арга. Дандин:

Пандугийн таван хүүгийн гэргий  
 Панчаалын орны хааны охин нь

Ариун явдалтны дунд эрхэн болсон нь  
Арвис буяны хүчин болой.

Энэ жишээ шүлэгт Пандугийн таван хүүг нэг эхнэртэй болгож улмаар тэр нь ариун явдалтны дунд дээд нь болсон хэмээсэн нь ёсонд хазгай бөгөөд өөрөөр хэлбэл, эш лүгээ харшилж байгаа боловч их хөлгөний тарнийн ёсоор бол энэ нь харш бус ажээ (ДЗАТ. 1982. т.175)

Дандин бээр “Зохист аялгууны толь”-ийн III бүлгийнхээ эцэст Дууны чимэг, түүний эрдэм ба гэмийг товчлон хурааж сайтар өгүүлсэн тухайгаа бүлгийн төгсгөл шүлэг бичээд үүнийхээ араас “Зохист аялгуу”-ны эрдэмд хичээж шамдаж суралцваас оюуны гэгээрлийг олж хэн ч сайн хувьтан болж, төгс сайн зохиол бүтээл туурвиж болох тухайд:

Бүтээн үйлдэхийг үзүүлсэн энэ мөрөөр гэм, эрдмүүдийг  
Сайтар ухагч оюутан, сайн хувийн эрхт болсон  
Аялгуус лугаа илтэд нөхцүүлэн үйлдвээс

сэлмүүн харцат эхнэрүүд ба

Идэр настан мэт баясгалан хийгээд алдрыг олохуйяа больюу  
(ТМДДЗАТ. 2017. т.675)

гэж “Зохист аялгуу”-нд суралцсаны эрдэм ач тусыг зохиолынхоо төгсгөлд хураангуйлан өгүүлжээ. Ингээд “Зохист аялгууны толиос Үйлдэхүй бэрхийн гутгаар бүлэг” гэж бүлгээ төгсгөөд, араас нь “Зохист аялгууны толь хэмээгдэх Дандин багшийн зохиосон төгсвэй” (ТМДДЗАТ. 2017. т.676) гэж зохиогч зохиолоо төгсгөжээ.

**ГУРАВ. ДАНДИНЫ “ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛЬ”-ИЙН  
БАР ХЭВЛЭЛ, ЭХҮҮДИЙН СУДАЛГАА**

Дандины “Зохист аялгууны толь”-ийн бар хэвлэл, эхүүдийн тухайд. “Зохист аялгууны толь” хэмээх яруу найргийн онолын номыг санскритаар kāvyādarśa, төвдөөр snyan ngag me long, монголоор зохист аялгууны толь гэхээс гадна “Дандины гол”, “Дандины төр”, “Дандины үгийн чимэг”, Хятадаар “诗镜” буюу “诗镜论”, “诗意”, “诗鉴”, “修辞论诗镜”, “文镜论” гэх мэт олон янзаар нэрлэн орчуулж, хэвлэж, барлаж иржээ. “Зохист аялгууны толь”-ийн санскрит, төвд, хятад бар хэвлэлийн тоймыг танилцуулахдаа Ван Мандуга профессорын “Зохист аялгууны толь”-ийн товч агуулга ба бар хэвлэлийн тухай” (Төвд судлал. 2018. т.39-51) өгүүллийг гол эш болгон авч энд танилцуулж байна.

**“Зохист аялгууны толь”-ийн санскрит хэлний бар хэвлэл.** “Зохист аялгууны толь” анх Энэтхэг оронд гарч, соёлын өргөн хүрээн дотор ихэд дэлгэрч, эрдэмтэн мэргэдийн хүртээл болж иржээ. Тус ном МЭ-ий VII зууны үед зохиогдож, гар бичмэл эхээр уламжлагдан тархаж байв. Энэтхэгт хамгийн анх 1863 онд дармал дэвтрээр хэвлэгдэж харгуулагч Айюе Бянюй голлон бичсэн санскрит тайлбарыг хавсаргажээ. 1881 онд Дорж вожиш (多尔迦沃基希) найруулсан дэвтрийг Колкат (加尔各答) хотод хэвлэв. 1890 онд Германд Беделинке (波德林格) гэдэг хүний харгуулан орчуулсан уг эх жич герман хэлний орчуулгатай нь хамт хэвлэв. Үүнд 1863 оны дармал эхээр эх болгов. 1910 онд Лүнгециалие (伦格恰利耶)-ийн найруулсан дэвтрийг Маделас (马德拉斯) хотноо хэвлүүлэв. 1939 онд Энэтхэгийн Калькутта(Calcutta University) их сургуулийн Банажи (Banerjee 班纳吉) гэдэг хүний харгуулсан санскрит, төвд хэл хавсаргасан дэвтрийг хэвлэв. Энэ хэвлэл голдуу дэргэ барын “Данжуур” хийгээд төвд хуулмал дэвтрээр эх болгов. Бид энэ судалгааныхаа санскрит болоод төвд эхэд энэ 1939 оны Калькутта(-Calcutta University) их сургуулийн Банажи (Banerjee) эхийг 1985 онд фотогоор хэвлэсэн эхийг эш болгож авав.

**“Зохист аялгууны толь”-ийн төвд хэлний бар хэвлэл.** Төвд сурвалж бичгийн мэдээнээс үзвэл: Дандины зохиол VII-VIII зуунд Балбаас Төвдөд дэлгэрч эхэлсэн бөгөөд тэр нь манай үе хүртэл тус орны уран зохиолын онолын үндсэн судар нь болж байв. Үнэн хэрэг дээрээ

төвдийн эрдэмтэд Дандины онолоор Энэтхэг хүмүүсээс ч хавьгүй олон тайлбар зохиол бичиж, уг онолыг илүү удаан хугацаагаар, илүү өргөн хүрээнд туйлын нарийн чанд судлан баримталж, нэвтэрхий сайн мэдэж байсан учир тэд өөрийн оронд эртний Энэтхэгийн зохист аялгууны онолын гүн гүнзгий өвөрмөц уламжлалыг буй болгожээ. Тэдгээрийн бүтээл Дандины зохиолыг одоогийн шинжлэх ухааны үүднээс судлах, түүнийг дэлхийн орчин цагийн олон хэлрүү орчуулахад их тус дөхөм болсон.

Дандины “Зохист аялгууны толь”-ийг анх хэсэгчлэн орчуулж Төвдийн уншигчдад танилцуулсан хүн бол Сажа бандид Гунгаажалцан (1182-1251) юм. Тэр “Мэргэд орохын үүд хэмээх шастир” гэдэг зохиолдоо “Зохист аялгууны толь”-оос зарим зүйлийг төвдөөр орчуулан тайлбарласан байна.

“Зохист аялгууны толь”-ийн бүрэн бүтэн орчуулгыг төвдийн их хэлмэрч Шондон Доржжалцан Энэтхэгийн их зохист аялгуучин Лакшмикара (拉卡弥伽罗) хоёр, төвдийн Сажа бүлгийн тавдугаар үеийн их багш Пагва (1235-1280) хийгээд Шижээсамбуугийн дурдлагаар 1258-1280 оны хооронд хийжээ. Тус орчуулгыг төвдийн эрдэмтэй лам нар хэдэн удаа засан сайжруулжээ. Их хэлмэрч Лозойдамба (邦顿·洛卓旦巴 1276-1342) нэгэн удаа засвар оруулав. Их хэлмэрч Шияару Чойжисамбуу (夏鲁·却窘桑布 1444-1529) уг орчуулгад нямбай засвар хийснээр үл барам, нэлээд олон хажуугийн тайлбар хаджээ. “Зохист аялгууны толь”-ийн зарим орчуулгын гаргалгаанд нятан Лодошива (聂塘·洛旦希巴) мөн уг орчуулгад засвар оруулсан гэж тэмдэглэж буй. Хамаг чухал засвар оруулсан хүн бол Схитү Дамбийнинжээ (司徒·旦贝宁杰 1700-1774) юм. Тэр Шриланка (斯里兰卡) улсад төрж өссөн Ринченбай хийгээд өөр нэг эрдэмтэн Агваанжавын бичсэн хоёр иж “Зохист аялгууны толь”-ийн санскрит тайлбарыг харьцуулж, санскрит уг эхтэй нь харгуулан хянаж “Зохист аялгууны толь”-ийн орчуулгад чухал засвар оруулав. Тэгээд 1772 онд “Санскрит Төвд хоёр хэл хавсаргасан “Зохист аялгууны толь”-ийг бичиж, модон бараар хэвлүүлжээ. Одоогийн төвд “Данжуур”-т байгаа “Зохист аялгууны толь”-ийн орчуулга бол ийнхүү төвдийн их хэлмэрч мэргэдийн гараар дамжин засагдаж шалгарсан шилдэг орчуулгын нэг хувилбар юм.

Одоо бидэнд уламжлагдаж ирсэн “Зохист аялгууны толь”-ийн төвд хэлний гол болох бар хэвлэлд:

1. 1957 онд Японд гэрэл зургаар буулгасан их төвд сударт орсон “Зохист аялгууны толь”<sup>63</sup>
2. Дэргэ барын “Зохист аялгууны толь”<sup>64</sup>
3. Лавран барын “Зохист аялгууны толь”<sup>65</sup>
4. Лхас барын хуучин хэвлэлийн “Зохист аялгууны толь”<sup>66</sup>
5. Лхас барын шинэ хэвлэлийн “Зохист аялгууны толь”<sup>67</sup>
6. Шигазе Рашлхүмбэ хийдийн барын “Зохист аялгууны толь”<sup>68</sup>
7. Хөхнуурын Ардын хэвлэлийн хорооны 1957 оны нэгдүгээр хэвлэл ба Хөхнуурын Үндэстний хэвлэлийн хорооны 1981 оны хоёрдугаар хэвлэлээр хэвлэсэн “Зохист аялгууны толь” ба түүний тайлбар<sup>69</sup>
8. 1981 оны Энэтхэгийн Дарамсала барын “Зохист аялгууны толь”<sup>70</sup> зэрэг зүй ёсоор дурдагдана.

XX зууны наяд оноос XXI зууны арваад он хүртэлх хугацаанд орчин цагийн хэвлэлээр дээр дурдсан төвд хэлний баруудыг шинээр дахин барлаж хэвлэсэн зүйл мөн цөөнгүй бий, энд нэг бүрчлэн дурдахгүй товчилъё. Үүнээс “Зохист аялгууны толь”-д тайлбар хийж, шинэчлэн зассан төвд эрдэмтдийн төлөөлөх чанартай тайлбар зохиолоос хэдийг толилуулья:

Шондон Доржжалцан орчуулагчийн “Сарасвадийн хүзүүн чимэг”, Бан орчуулагч Лозойдамбын “Голын утгыг тодруулахуй”, Раднаасэдийн “Бан риг” гэж алдаршсан Ринбүн, тавдугаар далай лам Лувсанжамцын “Зохист аялгууны толийн бэрхийн тайлбар сарасвадийг баясгах яруу дуун” гэдэг ном байна.

Тавдугаар далай лам Лувсанжамц (1617-1682) тус “Зохист аялгууны толийн бэрхийн тайлбар сарасвадийг баясгах яруу дуун” (snyan ngag me long gi dka` `grel dbyangs can dgyes pa`i glu dbyangs zhes bya ba bzugs) тайлбарыг 1647 онд зохиосон, хятадаар “诗镜释难妙音欢歌” гэж орчуулдаг, монголоор “Зохист аялгууны толийн тайлбар эгшигтийг баясгах дуулал эгшиг”, “Сарасвади таалах лимбийн аялгуу”, “Зохист аялгууны толийн бэрхийг тайлсан-Янжинг баясгах дуулал эгшиг хэмээгдэх оршвой” гэх мэт хэдэн зүйлээр орчуулж байна. Тус

<sup>63</sup> 日本1957年影印之西藏大藏经中编入的诗镜版本.

<sup>64</sup> 德格印经院版本.

<sup>65</sup> 拉卜楞印经院版本.

<sup>66</sup> 拉萨雪印经院旧版本.

<sup>67</sup> 拉萨雪印经院新版本.

<sup>68</sup> 日喀则扎什伦布寺版本.

<sup>69</sup> 青海人民出版社, 1957年第一版, 青海民族出版社, 1981年再版的 “诗镜” 正文及注释中的正文.

<sup>70</sup> 1981年印度达让萨拉版本.

номын цаасны хэмжээ 60x9 сантиметр, 122 хуудас. Төвдөд хэдэн удаа барлагджээ. Тэрээр “Зохист аялгууны толь”-ийг санскрит хэлээр нь судалж, төвдөд гарсан тайлбаруудын алдаа мэдгийг шүүмжлэн ариутгажээ. Тэрээр зохиолдоо Дандины “Зохист аялгууны толь”-ийн бадаг бүрийг иш татаж үг, утгыг тайлбарлаад дараа нь шинэ жишээг тус бүрд нь нэмж бичсэн байна. V Далай ламын энэ Зохист аялгууны тайлбар зохиол нь зохист аялгууны сонгодог зохиол гэж алдаршсан тул Төвд, Монгол уран зохиолын онолыг судлах хүмүүст мөрдлөг болсоор иржээ (Ц.Дамдинсүрэн, 1962. т.13-14).

Мипагэлэгнамжилын “Зохист аялгууны толийн номлол найруулал Дандийн тааллын чимэг” (snyan ngag gi bstan bcos chen po me long la ‘jug pa’i bshad sbyar dañdi’i dgongs rgyan zhes byaba bzhugs so) гэдэг ном байна. Мипамгэлэгнамжилыг бас Бодхайв Гэлэгнамжил(1618-1685) гэдэг. 1678 онд тус номыг бичжээ. Хятадаар “诗学巨著诗镜之本释旦志意饰” 简称 “旦志意饰” гэж монголоор бас “Зохист аялгууны их шастирын тольд орохын номлол Дандины тааллын чимэг” гэж орчуулжээ.

Гүнчэн Жамъяншадавын “Зохист аялгууг тодотгогч шастир эгшигтийн зарлиг буман нарны гэрэлт” (snyan ngag gsal bar byed pa’i bstan bcos dbyangs can zhal lung nyi ma gyi `od can zhes bya ba) гэдэг ном байна. Гүнчэн Жамъяншадав (1648-1722) бол төвдийн зохиолч, гүн ухааны сурах бичгийг зохиосон. Дурдан буй номыг 1684 оны модон хулгана жил зохиосон болов уу гэж таамаглаж байна. Цаасны хэмжээ 55x9 сантиметр, 29 хуудастай. Тус зохиолыг бас “Зохист аялгууны толийг тодорхой үйлдэх шастир эгшигтийн сургаалын буман гэрэлт” гэж орчуулж буй (拉卜楞一世嘉木杨协巴多吉阿尊株 “妙音语数十万太阳之光华”).

Амдо хамын лам Данзанчойжинямын “Зохист аялгууны цэнгэл далай сайн номлолын чандмань эрдэнэ гарахын орон” (shar mdo khams kyi btzun pa bstan `dzin chos kyi nyi ma/. Тус зохиолыг Данзанчойжиням 1770 онд зохиосон. Цаасны хэмжээ 60x10 сантиметр, 353 хуудастай тайлбар ном юм. Монгол улсын номын санд хадгалагдаж бий. Хятадаар “妙音语之游戏海” буюу “妙音语海” гэж орчуулж буй, монголоор бас “Чимгийн шастир толийг банчин ламын зарлигийн ёсоор тайлсан эгшигт тэнгэрийн чандмань гарах орон” гэж нэрлэдэг.

Үржингүнсэнданзандоржийн “Эгшигтийн охины цэнгэл шинэ оюутны зөгийн цэнгэлт” (dbyangs can ngag gi rol mtso las don rgyan so

Inga`i snyin po bsdus pa blo gsar bung ba rol ba zhes bya ba), “Дандийн толийн их тайлбар эгшигтийн охины зөгийн цэнгэх цэцэрлэгт орох чухал хэрэгт мэргэдийн зарлигаас зарим шилдгийг эвлүүлсэн бүхэнд туст нарны гэрэл” (dbyangs can ngag gi rol mtso las don rgyan so lnga`i snyin po bsdus pa blo gsar bung ba rol ba zhes bya ba) гэдэг 1908-1909 оны хооронд зохиосон хоёр зохиол болно. “Эгшигтийн охины цэнгэлд шинэ оюутны зөгийн цэнгэх” зохиолын цаасны хэмжээ 13x9 сантиметр, 144 хуудастай. “Дандийн толийн их тайлбар эгшигтийн охины зөгийн цэнгэх цэцэрлэгт орох чухал гэрэгт мэргэдийн зарлигаас зарим шилдгийг эвлүүлсэн бүхэнд туст нарны гэрэл” гэх зохиолын цаасны хэмжээ 43x9 сантиметр, 60 хуудастай.

Агваанчойжигамцын (rje btzun ngag dbang chos kyi rgya mtso) “Зохист аялгууны толь”-ийн утгын 35 чимгийн тайлбар, жишээ хоёр номыг зохиожээ. Тайлбар зохиолын нэр нь “Зохист аялгууны толийн утгын чимгийн чанарыг тодруулагч хэмээх” (snyan ngag me long gi don rgyan gyi ngo bo gsal byed ces bya ba), жишээ зохиолын нэр нь “Зохист аялгууны толийн утгын 35 чимгийн жишээ” (snyan ngag me long gi don rgyan so lnga`i dper brjod). Цаасны хэмжээ 43x9 сантиметр, 28 хуудастай, хятад барын ном болно.

Лав Жамгон гэж алдаршсан Лувсандамбачойнпэлийн “Гол ёсныг үзэсгэлэн болгогч чимгийн их шастир “Зохист аялгууны толь”-ийн тайлбар галбарваасан модон” (snyan ngag me long gi dka`grel yongs`du`i ljon gzhung lugs mdzes par byed pa`i rgyan gyi bstan bcos chen po) гэж алдартай зохиол байгаа. Лувсандамбачойнпэл Архангайд сууж байхдаа 1866 онд тус зохиолыг зохиов. Бас “Гол ёсныг үзэсгэлэнтэйд үйлдсэн их зохист аялгууны бэрхийн тайлбар, найлзуур модон” гэж орчуулж буй. Цаасны хэмжээ 70x10 сантиметр, 104 хуудастай, төвд хэлээр Арвайхээрийн хүрээнд хэвлэгдсэн тус номд Дандины зохиолын бадаг, шүлэг, үг өгүүлбэрийг дэс дараалан нарийвчлан тайлбарласан байна. Жоо Кан аругай гар бичмэл эхийг эмхэтгэн дэглээд хэвлэлд шилжүүлээд байгаа, Схитү, Дамбийнинжээгийн шавь 崩热巴·才旺般巴-ийн зохиосон “诗注甘蔗树” гэдэг зохиол болов уу гэж таамаглаж буй.

Жамъян Хачэ Сономбаярын “Зохист аялгууны тайлбарын бие ба чимгийн чандмань хувилгаан үхэр” хэмээх зохиол буй. Жамъян Хачэ Сономбаяр бол бараг XIV-XV зууны үед амьдарч байсан хүн, тус ном түүний зохиосон яруу найргийн ухааны тухай ном юм. Нийт 214

хуудастай. 嘉米样喀切索南拜 “诗镜注释形体和修饰之如意神牛” гэж орчуулж буй.

Нартан Сангааширийн “Зохист аялгууны толийг тайлбарлан уншихын бүрэн утгын бүтэмж” зохиол. Нартан Сангаашири (纳塘巴桑 噶希日) бол бараг XV зууны үед амьдарч байсан хүн. Тус зохиол бол түүний бичсэн яруу найргийн ухааны тухай ном болно. Нийт 208 хуудастай, хятадаар “诗镜解说念诵之音全成就” гэж орчуулж буй.

Ринбүнба Агваанжижээгийн “Яруу найргийн ухааны гурван бүлгийн дэлгэрэнгүй тайлбар аюул үгүй арсланы хүрхрэл” гэсэн ном буй. Ринбүнба Агваанжижээ (仁崩巴·阿旺计扎) бол XV зууны үед амьдарч байсан хүн. Тус ном бол түүний бичсэн яруу найргийн ухааны тухай ном болно. Хятадаар “诗学三章之广释无畏狮子之吼声” гэж орчуулж буй.

Дунгар Лувсанпэрэнлэй (1927-1997)-гийн “Шүлгийн ухааны гэгээн толь” гэдэг алдартай зохиол байгаа. 东嘎·罗桑赤列 “诗学明鉴”, 青海民族出版社, 1982年版. Дунгар Лувсанпэрэнлэй (1927-1997) бол төвдийн алдарт яруу найргийн онолч, Төвийн Үндэстний Их сургуульд ажиллаж байсан. Профессор, төвд судлалын мэргэжилтэн.

Мөн Сэцан Лувсанбалдан Чойжидорж (1937-?) -гийн “Шүлгийн ухааны найруулга зүйн гэгээн толь” зохиол алдартай. 赛仓·洛桑华丹·却吉多吉 “诗学修辞明鉴”, 甘肃民族出版社, 1984年版. Сэцан Лувсанбалдан Чойжидорж (1937), одоо Хөхнуурын Хүжү шияны Үндэстний багшийн тусгай мэргэжлийн сургуульд ажиллаж буй. Профессор, сургуулийн дэд захирлаар ажиллаж байсан.

Ер нь Төвдийн утга зохиол судлалын хүрээнд одоо хүртэл зохист аялгуу судлал эрчимтэй хөгжсөөр байгаа учир зохист аялгууны тайлбар зохиол, зохист аялгууны судалгааны олон арван ном бүтээл гарсаар байна.

**“Зохист аялгууны толь”-ийн хятад орчуулгын бар хэвлэл.** Бээжингийн их сургуулийн эрдэмтэн Жин Ке Мү профессор “Зохист аялгууны толь”-ийн нэгдүгээр бүлгийн 105 шүлэг ба гуравдугаар бүлгийн шүлгийн арван гэм (бас арван зүйлийн эндүүрэл гэдэг) 63 шүлгийг орчуулав.<sup>71</sup> Энэ бол хамгийн анхны хятад орчуулга юм.

Төвийн үндэстний их сургуулийн Төвд судлалын салбарын төвдөч

<sup>71</sup> 金克木译：“古代印度文艺理论文选”·人民文学出版社·1980年.



эрдэмтэн Жоо Кан бээр Схитү Дамбийнинжээ (1700-1774)-ийн 1772 онд модон бараар хэвлүүлсэн “Санскрит-Төвд хоёр хэл хадмал Зохист аялгууны толь”-ийг гол эх болгож, Данзанчойжиням, Лувсанжамц, Мипамгэлэгнамжил нарын зохиосон тайлбарууд жич эрдэмтэн Жин Ке Мү-ийн хятад орчуулгыг лавлалт болгож “Зохист аялгууны толь”-ийн хятад бүрэн орчуулгыг 378 зурвас тайлбар зүүлтийн хамт “Дундад улсын цөөн тоот үндэстний эртний гоо зүйн үзэл санааны материалын анхны эмхэтгэл”<sup>72</sup> гэх номын 115-275-р нүүрт хэвлүүлжээ.

Цоо Шүн Чингийн эрхлэн найруулсан “Дорно дахины утга зохиолын онол шүүмжлэлийн сонгомол”<sup>73</sup> гэх номд Жин Ке Мү болон Жоо Кан хоёр эрдэмтний хятад орчуулгыг эвлүүлэн нийлүүлж, орчуулгын бүрэн эхээр хэвлүүлэв.

Төвийн үндэстний их сургуулийн Төвд судлалын салбарын төвдөч эрдэмтэн, ахмад профессор, Жоо Кан 2014 онд “Дөрвөн зүйлийн үсэг хадмал Зохист аялгууны толь”<sup>74</sup> номоо хэвлүүлэв. Тус номд Схитү Дамбийнинжээ (1700-1774)-ийн 1772 онд модон бараар хэвлүүлсэн “Санскрит төвд хоёр хэл хадмал Зохист аялгууны толь”-ийг гол эх болгож, санскрит, төвд, латин галиг болон өөрийн хятад орчуулгатай харгуулан тулгаж, дөрвөн зүйлийн үсэг хадмал “Зохист аялгууны толь”-ийг хэвлүүлж судалгааны хүрээнд оруулав.

**“Зохист аялгууны толь”-ийн англи орчуулгын бар хэвлэл.** Энэтхэгт, 1942, 1959, 1963 онуудад “Кавъяадарша” гэж санскрит нэрээр нь нэрлээд англи хэлээр нэгдүгээр бүлгийг бүхэлд нь орчуулж, хоёрдугаар бүлгээс өвөр төрхийг өгүүлэх чимэг, адилтгал чимэг, дүрст чимгийг орчуулж, утгын товч тайлбар хавсарган, жишээ шүлэггүйгээр сэтгүүлийн хуудсанд үргэлжлэн нийтэлжээ. Одоогоор англи хэлээр орчуулагдаж хэвлэгдсэн бар хэвлэл гурван зүйл бий.

1. Энэтхэгт 1952 онд “DANDINS KAVYADARSA” гэх нэрээр, эх зохиолынх нь англи орчуулгыг хавсарган санскрит тайлбар хийж нийтэлжээ.

2. 1956 онд Энэтхэгийн Колката хотноо зарим хэсэг англи хэлний орчуулгыг хавсаргасан дармал дэвтрийг хэвлүүлэв.

3. 1964 онд Маделас хотноо В.Нараяанын англи хэлний орчуулгын

<sup>72</sup> 中国少数民族古代美学思想资料初编编写组 “中国少数民族古代美学思想资料初编”, 四川人民出版社, 1989年.

<sup>73</sup> 曹顺庆主编 “东方文论选”, 四川人民出版社, 1996年.

<sup>74</sup> 赵康编译 “‘诗镜’四体合璧”, 中国藏学出版社, 2014年

ном “Зохист аялгууны толь”-ийг хэвлэн гаргажээ. Srimadacharya DANDI Mahakani, JEEVANANDA VIDYASAGARA BHATTACHARYA, V. NARAYANA AYER, “KAVYADARSA” (诗镜, V. RAMASWAMY Sastrulu & Sons-1(马德拉斯市)·1964年. Бид энэ судалгаандаа В.Нараянагийн англи хэлээр бүрэн орчуулсан орчуулгыг эх эш болгож авсан болно.

**“Зохист аялгууны толь”-ийн монгол орчуулгын бар хэвлэл.** Дандины “Зохист аялгууны толь”-ийг Халхын хэлмэрч гүүш Гэлэгжалцан төвд “Данжуур”-т байгаа Шондон Доржжалцан, Лакшмикара нарын төвд орчуулгаас XVIII зууны орчим монголчилж монгол “Данжуур”-т оруулан хэвлүүлжээ.

Гэлэгжалцаны монгол орчуулгыг “Зохист аялгууны толь”-ийн санскрит эх болон үүнээс хийсэн төвд, англи хэлний орчуулгуудтай нь тулган үзсэний үндсэн дээр доорх зүйлийг ажиглав. XIII дугаар зууны төвд орчуулга, XVIII зууны монгол орчуулга, XX зууны англи орчуулга эдгээр гурван орчуулга нь хэдийгээр он цагийн хувьд хоорондоо их зайтай, огт төрөл бус хэлээр, өөр орны хүмүүс орчуулсан боловч манай үед хүрч ирсэн санскрит уг эхтэйгээ ерөнхийдөө их дүйж байна. Энэ бол “Зохист аялгууны толь”-ийн эх эртнээс эхлэн одоо энэ үед хүрч иртлээ төдий л өөрчлөгдөж, олон янзын хувилбартай болоогүйг гэрчилж байна. Энэ учраас ч төвд, монгол, англи гурван өөр орчуулга хоорондоо төдий л их зөрөөгүй болжээ. “Бидний харьцуулан судалсны дүнгээс үзэхэд Шондон Доржжалцан, бандид Лакшмикара нарын төвд орчуулга бол “Зохист аялгууны толь”-ийн зөвхөн хамгийн эртний орчуулга төдийгүй, мөн бидэнд мэдэгдэж байгаа орчуулгуудын дотроос хамгийн сайн орчуулга нь болно гэж хэлж болно” (Бира нар, 1982. т.5) гэж “Зохист аялгууны толь”-ийг орчин цагийн монгол хэлнээ орчуулсан академич Ш.Бира үнэлжээ. Гэлэгжалцан “Зохист аялгууны толь”-ийг төвд орчуулгаас дамжуулан монголчилсон, төвд орчуулга нь санскрит эхээ сайн буулгаж чадсан учир монгол орчуулга ч санскрит эхтэйгээ тун тохирч буй. Гэвч Гэлэгжалцаны орчуулга хэтэрхий их үгчилж хийсэн орчуулга тул түүнийг одоогийн монгол уншигчид ойлгоход тун төвөгтэй байгаа юм.

Одоо өнөөдрийн байдлаар Монгол утга зохиолын судалгааны хүрээнд ашиглагдаж байгаа “Зохист аялгууны толь”-ийн монгол бар хэвлэл найман зүйл байна. Үүнд:

1. Монгол “Данжуур”-ын 205-р ботид орсон Гэлэгжалцаны

- орчуулсан “Зохист аялгууны толь”<sup>75</sup>
2. Б.Ринчений оршил бичиж, Х.Гаадан удиртгал бичиж хэвлүүлсэн Дандины “Зохист аялгууны толь”<sup>76</sup>
  3. Ш.Бира, Х.Гаадан, О.Сүхбаатар нарын шинэчлэн орчуулж тайлбар үйлдсэн “Дандины Зохист аялгууны толь”<sup>77</sup>
  4. Сүеэ оршил бичиж тайлбар зүүлт хадсан “Зохист аялгууны толь”<sup>78</sup>
  5. Ван Мандуга харгуулж тайлбарласан “Монгол хятад хоёр хэл хавсаргасан Дандины “Зохист аялгууны толь”<sup>79</sup>.
  6. Ван Мандуга, Л.Хүрэлбаатар, Д.Сумъяа харгуулж тайлбарласан “Таван зүйлийн үсэг хадмал “Зохист аялгууны толь”<sup>80</sup>
  7. Д.Цэдэв эмхэтгэж хэвлүүлсэн Дандин. “Зохист аялгууны толь”<sup>81</sup>
  8. “Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины Зохист аялгууны толь”<sup>82</sup>

гэх “Зохист аялгууны толь”-ийн эхүүд нь монгол бичгээр болон шинэ үсгээр Монголчуудын судалгааны хүрээнд байна. Ер нь Дандины “Зохист аялгууны толь”-ийн эхүүдийг орчин цагийн судалгааны хүрээнд зориулан 1970-аад оноос хэвлэж эхэлжээ.

**“Дандины Зохист аялгууны толь”.** - “Дурсгалт бичгийн чуулган” (Corpus Scriptorum Mongolorum. Tom. XVIII, fasc.1) цувралаар 1972 онд анх хэвлэж гаргасан. Академич Б.Ринчен оршил бичсэн.

Энэ ном нь гурван хэсгээс бүрдэж байна. 1.“Зохист аялгууны толь хэмээх зохиолын тухай” гэсэн дэлгэрэнгүй удиртгал, 2.Монгол Данжуурын “Зохист аялгууны толь”- ийн гэрэл зураг эх, 3.“Хуучин орчуулгын шинэ засвар” гэсэн гурван хэсгээс бүрдэж байна. Энэ ном

<sup>75</sup> Гомбожав, Билгүүндалай нарын орчуулан эмхэтгэж, 1749 онд Бээжинд хэвлүүлсэн 225 боть “Данжуур”, Монгол улсын Үндэсний номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байна. .

<sup>76</sup> БНМАУ-ын Шинжлэх ухааны академийн хэвлэл, 1972 он. Улаанбаатар хот, цаасны хэмжээ 70x108 1/8, нийт 170 хуудастай.

<sup>77</sup> БНМАУ-ын Шинжлэх ухааны академи, Хэл зохиолын хүрээлэнгийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн хэвлэл, 1982 он, Улаанбаатар хот. Цаасны хэмжээ 60x 90 1/8, нийт 169 хуудастай.

<sup>78</sup> Сүеэ оршил бичиж тайлбар зүүлт хадсан “Зохист аялгууны толь”, Өвөр монголын Соёлын хэвлэлийн хороо, 1986 он.

<sup>79</sup> Ван Мандуга харгуулж тайлбарласан “Монгол хятад хоёр хэл хавсаргасан Дандины “Зохист аялгууны толь”, Өвөр монголын Ардын хэвлэлийн хороо, 2000 он.


<sup>80</sup> Ван Мандуга, Л.Хүрэлбаатар, Д.Сумъяа харгуулж тайлбарласан “Таван зүйлийн үсэг хадмал “Зохист аялгууны толь”, Үндэстний хэвлэлийн хороо, 2012 он.

<sup>81</sup> Д.Цэдэв эрхэлж эмхэтгэсэн Дандин. “Зохист аялгууны толь”. Уб. 2014 он. 292х.

<sup>82</sup> Төвд эхтэй нь харгуулан монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хийсэн Д.Сумъяа. “Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины “Зохист аялгууны толь”. Уб. 2017 он. 679 нүүр..



нь “Зохист аялгууны толь”-ийн монгол орчуулгыг маш ховор болсон монгол “Данжуур”-ын 205 дугаар ботиос гэрэл зургаар буулгаж, дэлхийн санскрит, төвд, монголыг судлаачдын судалгаанд анх хүргэсэн чухал ач холбогдолтой болсон. Номд Х.Гаадан “Зохист аялгууны толь”-ийн төвд хэлээрх сурвалж бичгийн тойм, эх тайлбар хоёрын шүтэлцээ, зохист аялгууны толийн үндсэн агуулга, уг зохиолын судалгааны тухай, түүндээ төвд, монгол зохиогчдын тайлбаруудын нийтлэг болоод ялгаатай тал, мөн орчин үеийн судалгааны тоймоос дурдсан байна. Зохист аялгууч Ш.Иштавхай “Зохист аялгууны толь”-ийн орчуулгыг Нартан барын Данжуурын төвд эх, Агваанлуvsсанжамц, Жамъянгарав нарын тайлбар, өөрийн багш нарын аман уламжлал дагуу харьцуулан тулгаж, уламжлалт төвд, монгол орчуулгад байсан алдаа эндрүүрлийг зассанаас гарсан мэдгийг нягтлан шүүж жагсаасан байна.



**“Дандины Зохист аялгууны толь”** (Dandin's “Kāvya-dārsa” in Modern Mongolian And with commentaries). (Corpus Scriptorum Mongolorum). Tom. XX, fasc. IV. Уб., 1982. “Дурсгалт бичгийн чуулган” цувралаар Ш.Бира, Х.Гаадан, О.Сүхбаатар нар орчин цагийн монгол хэлнээ орчуулж тайлбар хийж, эдүгээ цагийн монгол уншигч судлаач нарт хүргэжээ. Энэ бүтээл нь санскрит эх, XIII зууны үеийн Шонтон Доржжалцан, бандид Лакшмикара нарын санскритээс төвд хэлэнд хийсэн орчуулга,


XVIII зууны үед Гэлэгжалцаны төвдөөс монгол хэлэнд хийсэн орчуулга, XX зууны үед санскритч В.Нараянагийн санскритээс орчин цагийн англи хэлэнд орчуулсан орчуулга болон “Зохист аялгууны толь”-ийн талаар төвд, монгол эрдэмтдийн хийсэн бусад олон тайлбар, хатуу нэрийн толь зэргийг ашиглаж харьцуулж судлаад, “Зохист аялгууны толь”-ийн шинэ орчуулгыг хийжээ.

Энэ ном эрдэм шинжилгээний удиртгал, “Зохист аялгууны толь”-ийн гурван бүлгийн орчуулга, тайлбар, “Зохист аялгууны тольд” гардаг санскрит, төвд, монгол, англи нэр томъёоны хэсгээс бүтэж байна. Эрдэм шинжилгээний удиртгалд, Энэтхэг, Төвд, Монголд “Зохист аялгууны толь”-ийн уламжлан ирсэн түүхэн мэдээ баримт, үеийн олон хүний хийсэн орчуулгын зөрөө, ялгаа, онцлог шинж, энэ судалгаанд баримталсан зарчим, арга зүйн холбогдолтой зүйлсийг өгүүлсэн монгол, англи хэлээр бичсэн удиртгалтай юм. Зохиолын гол гурван бүлгийн орчуулга тайлбарыг хийхдээ: 1.Үндсэн шүлгийг орчин цагийн хүмүүст ойлгомжтой болгохын тулд санскрит, төвд англи орчуулгууд, бусад тайлбартай харьцуулж үндсэн уг эхийн санааг нь гаргаж орчуулахыг зорьсон. 2.Зарим ойлгомжгүй нэр томъёо, үг илэрхийлэл, хэт хураангуй зүйлсийн утга санааг тайлбарласан. 3.Англи орчуулгын зарим алдааг засаж, утга тодорхойгүй зүйлийг төвд тайлбаруудыг ашиглан тайлбарласан. 4.Зохиолд гарч байгаа 337 зүйлийн нэр томъёог санскрит-төвд-монгол-англиар хавсаргасан.




**“Таван зүйл үсэг хадмал Зохист аялгууны толь”** (Бээжин., 2012. Үндэстний хэвлэлийн хороо. 754 х.)-ийг Л.Хүрэлбаатар, Ван Мандуга, Д.Сумъяа нар эрхлэн найруулжээ. Энэ ном нь “Зохист аялгууны толь”-ийн эхийг гэрэл зураг, орчуулгаар төдийгүй бусад олон зүйл эхийг зэрэгцүүлэн хэвлэж судалгааны хүрээнд хүргэхэд анхаарчээ. Үүнд Дандины “Зохист аялгууны толь”-ийг төвд хэл, төвд галиг, шинэ үсэг, хятад хэл, монгол бичиг гэсэн таван зүйлийн үсгээр, зүүлт тайлбар, удиртгалын хамтаар хийж хэвлэсэн байна. Энэ “Зохист аялгууны толь”

нь Төвд Данжуур, Гэлэгжалцаны уламжлалт монгол орчуулга Монгол Данжуурын эх, Ш.Бира нарын “Дандины Зохист аялгууны толь”, Ван Мандугагийн эрхэлсэн хятад, монгол хоёр хэлээр хавсарсан “Зохист аялгууны толь” зэрэг олон эхүүдийг харгуулан харьцуулж, судлаач болоод сонирхогч нарт “Зохист аялгууны толь”-ийн эхийг олон хэл, олон зүйл үсгээр хүргэжээ.



**Дандин. “Зохист аялгууны толь”** (Уб., 2014. 292 х) Энэ номыг Д.Цэдэв эрхэлж Дандины “Зохист аялгууны толь”-ийг сурах судлах хүмүүст толийн эх болон монгол судлаачдын гол гол өгүүллийг нэгтгэн хүргэх зорилгоор хэвлүүлжээ. Энэ ном нь товч оршлоос гадна үндсэн 3 хэсгээс бүрдэж байна. Нэгд, “Зохист аялгууны толь”-ийн шинэ орчуулга Ш.Бира, Х.Гаадан, О.Сүхбаатар нарын орчуулга, тайлбар. Хоёрт, “Зохист аялгууны толь”-ийн хуучин орчуулга. Энэ нь Данжуурын 205 дугаар ботиос Гэлэгжалцаны орчуулга. Үүнийг

гэрэл зургаар хэвлэжээ. Гуравт, “Зохист аялгууны толь”-ийн тухай Монголын орчин үеийн судлаач эрдэмтдийн гол гол өгүүллүүд. Үүнд: Ц.Дамдинсүрэнгийн “Зохист аялгууны толь ба түүний тайлбаруудын тухай товч мэдээ”, Sh.Bira. “Mongolian commentaries on Dandin’s Kāvyaḍarśa”, Ш.Бира. “Дандины “Зохист аялгууны толь”-ийг төвдөөр орчуулсан Лакшмикара, Шонтон Доржжалцантай холбогдох хоёр захиа” (Sh.Bira. Two letters written by pags-pa bla-ma to Lakśimākara and Shong-ston rdo-rje rgyal-mt- shan-the translators of the. Dandin’s “Kāvyaḍarśa”), Ш.Бира “Кавъядарша” Дандина в Монголии, Ч. Алтангэрэл “Монгол зохиолчдын төвдөөр бичсэн зохиолын онол. Л. Хүрэлбаатар “Зохист аялгууны шастир” гэсэн зохист аялгуу судлаачдын чухал гол өгүүллүүдийг сонгон хэвлэжээ.



**Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины “Зохист аялгууны толь”.** Төвд эхтэй харгуулан монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хийж удиртгал бичсэн Д.Сумъяа. 679 нүүр. Уб, 2017 он. Энэ ном нь Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины “Зохист аялгууны толь”-ийн эхийг хөрвүүлж төвд, монгол, шинэ үсгийн гурван эхийг хамтад нь хэвлэсэн. “Зохист аялгууны толь”-ийн төвд, монгол, шинэ үсгийн гурван зүйл эхийг бэлтгэхдээ Төвд, Монгол “Данжуур”-ын эхийг харгуулж, шүлэглэсэн хэлбэрээр

нь болгон бадаглаж, бадгаа дугаарлажээ. Мөн шинэ үсгийн хөрвүүлэгтээ 900 орчим үг утгын зүүлт тайлбар хийжээ. Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины “Зохист аялгууны толь”-ийн эхийг хэвлэхдээ бадгийн дугаарыг тавьсан нь зохист аялгууны гол гол нэр утгын тухай ойлголт тодорхойлт, жишээг ухаж ойлгоход тус дөхөм баримжаа болох бөгөөд энэ нь санскрит, төвд зарим эхүүд нь дугаартай хэвлэгдэж ирсэн уламжлалыг баримталсан байна. Мөн энэ хэвлүүлж буй эх, 1982 оны эх хоёр нь бадгийн дугаарын хувьд зарим нэг зөрөө гарч байгаа зэрэг анхаарч тодруулах зүйлүүдийг өмнөх оршилдоо тодорхой тэмдэглэсэн байна.

### **“Зохист аялгууны толь”-ийн эхүүдийг харьцуулсан зөрөө ялгааны байдлын тойм**

Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины “Зохист аялгууны толь”-ийн бадгуудыг дугаарлаад Ш.Бира нарын “Дандины зохист аялгууны толь”(1982)-ийн бадгийн дугаартай харьцуулвал энэ хоёр эхийн бадгийн дугаарын хувьд зарим зөрөө харагдаж байна. Үүнийг тодруулбал:

- 1982 оны эхэд II бүлгийн 56-р бадгийн эхний хоёр мөрийг /56/, дараагийн хоёр мөрийг /57/ гэж салгаж дугаарласан учир хойшид бадгийн дугаар 1-ээр зөрж байна.
- 1982 оны эхэд 65-р бадгийн эхний хоёр мөрийг /66/, дараагийн хоёр мөрийг /67/ гэж салгаж дугаарласан байгаа. Иймд үүнээс хойшхи бадгийн дугаар 2-өөр зөрнө.
- Мөн 1982 оны эхэд 183-р бадаг шүлгийн эхний 2 мөрийг /185/, дараагийн хоёр мөрийг /186/ гэж салгаж дугаарласан. Иймээс үүнээс хойшхи бадгийн дугаар 3-аар зөрнө.
- 1982 оны эхэд 309, 310-ыг нийлүүлж нэг дугаарласан тул үүнээс хойшхи бадгийн дугаар 2-өөр зөрөх болно.
- 1982 оны эхэд 362, 363 хоёрыг нэгтгэн дугаарласан байгаа. Иймд хойших тус бүлгийн үлдсэн хоёр бадгийн дугаар 1-ээр зөрж байгаа.

Гэхдээ энэхүү бадгийн дугаарын зөрөө нь зарчмын будлиан үүсгэхгүй. Бадгийн дугаарын зөрөө нь зөвхөн 2-р бүлэгт байх бөгөөд

1 ба 3-р бүлэгт зөрөө гарахгүй.

**Орчин цагийн монгол хэлээр шинэ үсгийн эхийг** бэлтгэх явцдаа Төвд “Данжуур”, Монгол “Данжуур”, Хятад-Монгол хоёр хэл хавсарсан Зохи́ст аялгууны толь, “Санскрит Төвд сурах” бичгийн “Зохи́ст аялгууны толь”-ийн эхийг Ш.Бира нарын шинэчилсэн орчуулга “Дандины Зохи́ст аялгууны толь” (1982)-ийн эхүүдийг харгуулан харьцуулсан зөрөө ялгаа:

1-р бүлэг:

- I бүлгийн төвд 23-р шүлгийн 4-р мөр нь Ш.Бира нарын шинэчилсэн орчуулгад 24-р мөрийн эхний мөрөнд орж орчуулагдаж байна.
- I бүлгийн 48-р бадгийн эхний мөрөнд буй шинэ үсгийн тайлбар, санскрит шүлэг нь төвд шүлэгт үгүй байна.
- Төвд “Данжуурын “ Зохи́ст аялгууны толь”-ийн II бүлгийн 67-р бадаг нь 6 мөр байна. 1-р мөр нь 3-р мөрд давтагдсан байна. Харин Төвд сурах бичигт 1, 2, 5, 6-рх мөрөөс бүтсэн 4 мөр байна. Голын 3, 4-р мөр нь үгүй байна.

2-р бүлэг:

- II бүлгийн 75-р шүлгийн 4-р мөр нь төвд эхээ баривал 75-ийн 4-р мөрд үлдэнэ. Ш.Бира нарын орчуулгыг дагавал 76-ийн эхний мөрд орчуулагдаж байна. Учир нь дараагийн бадаг нь “төгөлдөр” гэх утгаа тайлбарласан жишээ байна.
- II бүлгийн 309-р шүлэг Төвд сурах бичигт үгүй. Төвд “Данжуур”-т байна. Ш.Бира нарын номд 312-р шүлэг байна. Мөн Ван Мандугагийн найруулсан “Монгол Хятад хоёр хэл хавсарсан “Дандины “Зохи́ст аялгууны толь”-ийн Гэлэгжалцаны монгол орчуулгад байна.
- Төвд “Данжуур”-ын “Зохи́ст аялгууны толь”-ийн II бүлгийн 337, 338-р бадгуудын хооронд нэг бадаг байна. Энэ бадаг зөвхөн Төвд “Данжуур”-т байна. Монгол “Данжуур”-ын монгол орчуулга , Ш.Бирагийн ном, Төвд сурах бичиг, Ван Мандугагийн найруулсан “Зохи́ст аялгууны толь” зэрэг номд үгүй байна.

3-р бүлэг:



- III бүлгийн 96-р шүлгийн эхний хоёр мөр шүлгийн орчуулга нь Ш.Бирагийн номд үгүй тул Ван Мандугагийн найруулсан Хятад Монгол хоёр хэлний “Зохист аялгууны толь” номын 339-р хуудсанд буй Гэлэгжалцаны монгол орчуулгаас нөхөв.
- III бүлгийн 106-р шүлэг орчуулагдаагүй Ш.Бирагийн номд үгүй байна. Иймд Ван Мандугагийн найруулсан “Зохист аялгууны толь” номын 345-р нүүрт буй Гэлэгжалцаны монгол уламжлалт орчуулгаас нөхөж авав.

***Санскрит болон англи эхүүдийг төвд, монгол бичиг, шинэ үсгийн хөрвүүлэг эхүүдтэй харгуулж тохируулсан байдал:***

1. INDO-TIBETAN BUDDHIST LITERATURE SERIES - ээр хэвлэгдсэн SANSKRIT AND TIBETAN TEXTS - ээр гарсан KĀVYĀDARŚA - номын Санскрит, Төвд хоёр эхийн төвдийг Төвд “Данжуур”-ын эхтэй харгуулж, “Зохист аялгуу”-ны Санскрит- Төвд эхээ тодруулж дугаарлаж авав.
2. Энэ Санскрит - Төвд эхээ V.NARAYANA - гийн англиар орчуулж хэвлүүлсэн Санскрит - Англи эхтэй харгуулж дугаарлаж авав.
3. Энэ V.NARAYANA - гийн Санскрит - Англи эхээ Төвд, Монгол “Данжуур”-аас хөрвүүлсэн төвд, монгол, шинэ үсгийн эхтэй болон 1982 оны Ш.Бира нарын орчуулга болон бусад эхүүдтэй харгуулж бадаг бадгаар нь утга дүйлгэн барьж дугаарлаж жигдлэв.

***Нэгдүгээр бүлэг нь*** ерөнхий бүх бадгийн агуулга, дугаар тохирч байна. Гэхдээ

- 15-19-р гэсэн 5 бадгийн англи орчуулгыг нийлүүлж нэг болгож хийжээ. Үүнийг бадаг бадагт нь утга харгалзан хувааж байрлуулав.
- 23-24, 26-27, 41-42, 93-94-р бадгийн англи орчуулгыг хоёр хоёроор нийлүүлж хийсэнг тус тусад нь салгаж хуваав.
- 47-48-49-р энэ 3 бадгийн англи орчуулгыг нэгтгэн нэг дор санскрит англи хольж бичсэн учир 3 бадагт салгалгүй нийлээтэйгээр нь дээрхи гурван бадагт 3 дахин бичив.
- 53, 56, 57, 70, 77, 84-р бадгуудын жишээ голдуу шүлгүүдийг

англиар орчуулаагүй. Англи орчуулгадаа санскритаар нь товчлон бичсэн байна. Үүнийг тэр хэвээр нь авав.

- 59-60, 66-67, 81-82-р бадгуудын англи орчуулгыг нийлүүлж хийсэн. Үүнийг хоёр бадагт нь хуваалгүй тэр хэвээр бадаг бадагт нь бүтнээр нь авав.
- 1-р бүлгийн эцсийн санскрит, англи бичигдээгүй байхгүй байв.

**Хоёрдугаар бүлгийн** агуулга ерөнхийдөө тохирох боловч бадгийн дугаар нэлээд зөрнө. Учир нь зарим эхэд нэг бадгийг хоёр хувааж, зарим эхэд хоёр бадгийг нийлүүлэх, заримд эхэд аль нэг бадгийг орхих байдлаас болж хоёрдугаар бүлгийн бадгийн зөрөө эхүүд дээр гарсан байдаг. Гэвч санскрит, англи, төвд, монгол эхүүдийн бадаг бүрийг тулган жигдлэв.

- 4-7-р бадагт Утгын 35 чимгийн нэрийг англи орчуулгад нийлүүлж орчуулсан. Үүнийг 4, 5, 6, 7 гэсэн бадаг бадагт нь хувааж салгав.
- 56-65-р бадагт адилтган гийгүүлэгч холбоос 65 үгийг нэг дор багцлан орчуулжээ. Үүнийг бадаг бадгийн дугаарт тохируулан салгаж дугаарлав.
- 154-167-р бадагт байгаа Түртгэхийн чимэг нь хойно өмнөө нэлээд их холилдон орсон байна. Үүнийг төвд эхийг барьж, орчуулгыг нь дүйлгэн харьцуулан үзэж, бадаг бадагт нь оруулж жигдлэн тавив.
- 155, 156 дугаартай хоёр бадаг нь зөвхөн Нараянаны орчуулсан санскрит-англи эхэд байна. Бусад Төвд, Монгол “Данжуур”, Санскрит - Төвд эхүүдэд байхгүй байна.
- Хоёрдугаар бүлэг нь 154-р бадаг хүртэл бүр тохирч байна. Үүнээс хойшхи зөрөө нэлээд байна. Учир нь Адилтган гийгүүлэгчийг өгүүлэх бадгийг дугаарлахдаа заримд нийлүүлж, заримд салгасан учир.
- 170-171-р бадгийн Англи орчуулга хамт байна. Үүнийг салгав.
- 312-р дугаар дээр хоёр байдаг шүлэг байгаа. Эхний “Хаан язгуурын мөрт бас кша тра хаан язгуур...” гэсэн бадгийг өмнө

хэвлэсэн 5 зүйл үсэг хадмал болон Төвд Монгол “Данжуур”-ын Дандины “Зохист аялгууны толь”-ийн эхийг бэлтгэхдээ Төвд, Монгол “Данжуур”-аас авсан. 309 гэсэн дугаартай бадаг байгаа. Ш.Бира нарын 1982 оны эхэд 312 гэсэн дугаартай шүлэгт байгаа. Санскрит - Төвд эхэд энэ бадаг байхгүй байна. Санскрит - Англи эхэд санскрит нь үгүй, харин 312-рт байгаа хоёрдахь бадаг “Мөрт орсон битүү одод...” гэх бадаг нь бүх санскрит, англи, төвд, монгол эхүүдэд байна.

- 323 - 328-р дугаарын бадагтай хуудас нь дутуу ном бидэнд олдсон тул санскрит эхийг Санскрит - Төвд эхээс нөхөж авч англи орчуулгыг шинээр Д.Пүрэвжав хийв.
- Нараянагийн Санскрит - Англи эхийн 362-р бадагт байгаа эх нь Данжуур болон Санскрит - Төвд эх, “Таван зүйлийн үсэг хадмал Зохист аялгууны толь” зэрэг бидний өмнө гаргаж байсан эхүүдэд байхгүй. Энэ 362-р бадаг нь ганцхан Нараянаны орчуулсан Санскрит - Англи эхэд байна. Бусад Төвд, Монгол Данжуур, Санскрит - Төвд эхүүдэд байхгүй байна. Англиас нь монголоор орчуулав.

**Гуравдугаар бүлэг** нь мөн бадгуудын ерөнхий дугаар, агуулга нь тохирч байна. Гэхдээ

- 61 - 62, 65 - 66, 68 - 69, 76 - 77-р бадгуудыг нийлүүлж орчуулсанг түүгээр нь авч бадаг тус бүр дээр нь тэр нийлсэн байдлаар нь авав.
- 125-126 хоёр бадгийг нийлүүлж орчуулсанг салгав.
- 162, 163, 164 гэсэн 3 бадгийг нийлүүлж орчуулсан.
- 149, 150-р бадагт англиар орчуулаагүй санскритыг нь тавьсан байна. Түүгээр нь авав.
- 167, 173-р бадгуудын санскрит эхийн 1 мөрийг орхиж бичсэн
- 3-р бүлгийн төгсгөл санскрит эх үгүй байна.

Ийнхүү Дандины “Зохист аялгууны толь”-ийн олон зүйл эхүүдийг харгуулж харьцуулж, бадгийн агуулгыг барьж дугаарыг жигдлэв.

**Дандины “Зохист аялгууны толь”.** Монголын утга зохиол судлалын хүрээнд Дандины “Зохист аялгууны толь”-ийн санскрит, төвд, хятад, англи, монгол бичиг, орчин цагийн монгол хэлээр - гэсэн



зургаан зүйлийн эхүүдийг зэрэгцүүлж хавсарган 2 ботиор анх удаа хэвлэн гаргаж байна. Энэ ном хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. 1. Монголын орчин үеийн утга зохиолын судлалын хүрээн дэх “Зохист аялгууны толь”-ийн судалгаа гэсэн эрдэм шинжилгээний удиртгал, 2. Дандины “Зохист аялгууны толь”-ийн 6 зүйлийн эхийг шад мөр татаж бадаглаж, дугаарлаж, шүлэглэсэн эхээ бадаг бадгаар нь зэрэгцүүлэн хавсаргаж, үгийн болон утгын эрдэм шинжилгээний тайлбар бүхий “Зохист аялгууны толь”-ийн үндсэн эх.

Зургаан зүйл хавсармал Дандины “Зохист аялгууны толь”-ийн I боть нь эрдэм шинжилгээний Удиртгал, “Зохист аялгууны толь”-ийн нэгдүгээр бүлэг буюу Мөрийг сайтар ялгасан аймаг гэсэн хоёр хэсгээс, II боть нь “Зохист аялгууны толь”-ийн Утгын чимэг болох хоёрдугаар бүлэг, Дууны чимэг болох гуравдугаар бүлгийн эхүүдээс бүрдэж байна.

Энэ “Зохист аялгууны толь”-ийг хийх үндэслэл нь эртний Энэтхэгийн Дандины “Зохист аялгууны толь” гэх энэхүү утга зохиолын онол, арга зүйг Монголын эрдэмтэн туурвигч зохиолч яруу найрагчид өөрсдийнхөө утга соёлын хөрсөнд буулган идээшлүүлж, монгол хүний сэтгэлгээгээр баяжуулж, монгол ахуйгаа тусган 300 гаруй жилийн турш хөгжүүлсээр “Монгол утга зохиолын онол” болтол нь хөгжүүлж иржээ. Ер нь Монголчуудын бүтээсэн өв соёл нь нүүдэлчин малчин монголчуудын гэх өвөрмөц онцлог, тусгай өнгө төрхтэй атлаа бас дэлхий нийт, хөрш зэргэлдээ улс түмнүүдийн соёл иргэншилтэй харилцан холбоонд оршиж тэдгээрээс суралцаж, бас эргээд тэдэндээ нөлөөлсөн тийм шүтэлцээнд оршиж ирсэн байдаг. Тиймээс Монголчуудын бүтээсэн их соёлын харилцаа холбоо нь олон улс орон, даян дэлхийн эн бүхий тийм өргөн хүрээтэй хөгжиж ирсэн жишээг Дандины “Зохист аялгууны толь”-ийн олон зүйл хэлээр уламжлан ирсэн эхүүд дээр бодитоор судлан шинжлээд хэвлэн нийтлэж судалгааны ертөнц, зохион туурвигчид, уншигч бичигч, эрдэмтэн судлаач, олон нийтэд хүргэх нь зүйтэй юм гэсэн саналыг ЮНЕСКО-гийн дэргэдэх

Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн захирал агсан доктор Доржжүгдэрийн Пүрэвжав(1973-2019) анх гаргаж, төсөл болгож БСШУС-ын яаманд мэдүүлж энэ ажлыг эхлүүлсэн билээ.

Энэ судалгаа нь сүүлийн жилүүдэд хэт Өрнийн утга соёлын онол сэтгэлгээг барьж ирсэн хэтийдлийг тэнцвэржүүлэн, Дорно дахины өв соёл, Монголын утга зохиолын сонгодог өвийн уламжлал шинэчлэл, харилцан нөлөөлөл, туурвил зүйн онцлогийг илрүүлэх, тэр бүгдээсээ суралцахад чиглүүлэхийг зорьсон юм.

Зургаан зүйл хавсармал “Зохист аялгууны толь” ном шүлэглэсэн хэлбэртэй. Учир нь “Зохист аялгууны толь” анх шүлэглэсэн хэлбэрээр зохиогдсон тэр уламжлалыг нь барив. Үүнийг тулд эхүүдийг мөр шатаар татаж бадаглаад, санскрит төвд зарим эхүүдийн бадаг нь дугаартай хэвлэгдэж ирсэн уламжлалыг баримтлаж бадгуудыг мөн дугаарлав. Ийн дугаарлах нь “Зохист аялгууны толь”-ийн гол утга, онолын ойлголт, ялангуяа уран дүрслэлийн чимгүүдийг системтэй цэгцтэйгээр ухаж ойлгоход хялбар дөхөм болох ач холбогдолтой юм.

Санскрит, төвд, хятад, англи, монгол бичгийн болон орчин цагийн монгол хэлээрх “Зохист аялгууны толь”-ийн зургаан зүйл эхийг бэлтгэхдээ “Зохист аялгууны толь”-ийн олон эхүүдийг цуглуулж, түүнээ харгуулж харьцуулан шинжлэв. Ингэхдээ эхлээд Төвд “Данжуур”-ын төвд эх, Монгол “Данжуур”-ын монгол уламжлалт эхүүдийг харгуулж, шүлэглэсэн хэлбэрээр нь болгож мөр шад, бадаг болгож бадгаа дугаарлав. Түүнээ “Дандины Зохист аялгууны толь” (Шинэчилсэн орчуулга тайлбар хийж эрхлэн хэвлүүлсэн Ш.Бира, Х.Гаадан, О.Сүхбаатар. 1982), “Монгол Хятад хоёр хэл хавсарсан Дандины “Зохист аялгууны толь” (Ван Мандуга харгуулж тайлбар хийсэн. 2000), “Таван зүйл үсэг хадмал Зохист аялгууны толь” (Ван Мандуга, Л.Хүрэлбаатар, Д.Сумъяа нар харгуулж тайлбарласан. Үндэстний хэвлэлийн хороо, 2012), “Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины “Зохист аялгууны толь”(Төвд эхтэй нь харгуулан монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хийсэн Д.Сумъяа. 2017) эхүүдийг харгуулж, харьцуулж төвд, монгол, шинэ үсгийн эхүүдээ жигдлэв.

Дараа нь үүнээ санскрит болон англи эхүүдтэй харгуулж бадаг мөрийг тохируулж, жигдлэв. Үүнд: Indo-Tibetan buddhist literature series -ийн Sanskrit and Tibetan texts - ээр гарсан KĀVYĀDARŚA номын Санскрит-Төвд хоёр эхийн төвдийг Төвд “Данжуур”-ын эхтэй

харгуулж санскрит болон төвд эхээ тодруулж дугаарлав.

Энэ санскрит болон төвд эхээ V.Narayana - гийн англиар орчуулж хэвлүүлсэн Санскрит-Англи эхтэй харгуулж дугаараа жигдлэв. Мөн V.Narayana - гийн санскрит ба англи эхээ Төвд “Данжуур”, Монгол “Данжуур”-ийн эхээс хөрвүүлсэн төвд, монгол, шинэ үсгийн эхтэй тулгаж харьцуулах зэргээр бусад эхүүдтэй харгуулан бадаг бадгаар нь үг, утга, орчуулгыг харьцуулж эхүүдийг жигдлэв.

Мөн энэхүү зургаан зүйл хавсармал Дандины “Зохист аялгууны толь”-ийн эхэд нийт 1000 шахам (нэгдүгээр бүлэгт 189, хоёрдугаар бүлэгт 457, гуравдугаар бүлэгт 334) үгийн болон утгын эрдэм шинжилгээний зүүлт тайлбар хийв. Тайлбарыг хийхдээ “Дандины “Зохист аялгууны толь” (1972), “Дандины Зохист аялгууны толь” (1982), “Таван зүйлийн үсэг хадмал “Зохист аялгууны толь” (2012), “Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины Зохист аялгууны толь” (2017) зэрэг эхүүд ба доктор(Sc.D), профессор Л.Хүрэлбаатарын “Эсэруагийн эгшиг дуун” (1999), Л.Хүрэлбаатарын “Судар шастирын билиг” (2002), С.Жамъянгаравын “Цаглахуй санааны найлзуур мод” (2011), “Дандины “Зохист аялгууны толь”-ийн гол нэр утгын тайлбар” (Хамтын бүтээл. 2017) зэрэг “Зохист аялгууны толь”-ийн эхүүд, тайлбар зохиолууд холбогдох судалгааны ном бүтээлүүдийг гар дороо эх эш хэрэглэгдэхүүн болгон найруулав.

“Зохист аялгууны толь” номын эхэнд Монголын орчин үеийн уран зохиолын судалгааны хүрээн дэх “Зохист аялгууны толь”-ийн судалгааны тоймыг оруулав. Судалгааны энэ тоймд: 1.Монгол эртний болоод эдүгээгийн утга зохиолын хүрээн дэх Зохист аялгууны судалгааны тойм түүхийг өгүүлэв. 2.”Зохист аялгууны толь”-ийн агуулгыг дэлгэрэнгүй танилцуулав. Энэ агуулга нь олон зүйл “Зохист аялгууны толь”-ийн эхтэй танилцаж, түүний утга болоод жишээ тэргүүтнийг хүртэж хүлээж авахад дөхөм болгох юм. “Зохист аялгууны толь”-ийн агуулгыг танилцуулахдаа төвдөч эрдэмтэн Ч.Алтангэрэл “Монгол зохиолчдын Төвдөөр бичсэн бүтээл (I дэвтэр. 1967), “Дандины Зохист аялгууны толь” (Ш.Бира нар. 1982), Л.Хүрэлбаатар “Эсэруагийн эгшиг дуун” (1999), С.Жамъянгарав “Цаглахуй санааны найлзуур мод” (Жишээ шүлгийг төвд хэлнээс орчуулж, эрдэм судлалын боловсруулалт хийсэн Л.Хүрэлбаатар. 2011), ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс гаргасан “Дандины “Зохист аялгууны толь”-ийн гол нэр утгын тайлбар” (Хамтын бүтээл. Д.Сумъяа, Б.Няммягмар, П.Ням-

Очир, Ж.Ерөөлт, Б.Лхагважав. 2017) зэрэг бүтээлийг үндсэн гол эш эх болгож агуулгыг танилцуулав. 3. “Зохист аялгууны толь”-ийн олон эхийн бар хэвлэлийг, мөн энэ судалгааны хүрээнд ашигласан олон эхийг харгуулж харьцуулж байхад гарсан ялгаа зөрөөний байдлыг танилцуулав.

Монголын орчин үеийн уран зохиолын судалгаан дахь “Зохист аялгууны толь”-ийн судалгаа нь шинэ хуучны өв соёлыг холбох, шинжлэх ухаан шашны мэдлэгийг зангидах, Өрнө ба Дорнын онол ойлголтыг нэгтгэх, уламжлал шинэчлэлийн залгамжийг хөгжүүлэн баяжуулахад ач холбогдол өгсөн байдаг.

Дорно дахины болоод уламжлалт сонгодог өв соёл мэдлэгээ эргэн харж түүнээс суралцах болсон энэ үед, мөн их дээд сургууль, боловсролын салбарт зохист аялгууны онол, арга зүй туурвилын эрдэм мэдлэгийг хичээл хөтөлбөрөөр үзэж суралцах болсон хийгээд ерөөс утга зохиолд суралцах, бичих туурвих, сонирхогч хэн хүн бүхэнд энэхүү зургаан зүйл бүхий “Зохист аялгууны толь” нь сурах бичиг, судалгааны эх хэрэглэгдэхүүн, гарын авлагад өчүүхэн ч атугай хэрэг болох буй за хэмээн хичээнгүйлэн эрдэмт багш нар, эрхэм судлаачдынхаа ном бүтээлүүдийг нэгжин үзэж нэгтгэн найрууллаа. Ном эрдмийн цагаан буян мөнхөд дэлгэрч арвидан дэлгэрч байг ээ.

Орь залуу Эгшигт охин тэнгэр  
Оройн титэмд мөнхөд сүндэллэн залраг ээ  
Оюун билгийн мэлмий  
Осолгүй саруул тунгалаг гийн байг ээ

Доктор, дэд профессор  
Доржпаламын Сумъяа

2021.07/11

ТОВЧИЛСОН ҮГС

- БНМАУ - Бүгд Найрамдах Монгол Ард Улс  
БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс  
ДЗАТ - Дандины Зохиаст аялгууны толь. 1982.  
ДЗАТГНУТ - Дандины “Зохиаст аялгууны толь”-ийн гол нэр утгын  
тайлбар. 2017  
МУЗТ - Монголын уран зохиолын тойм  
ТМДДЗАТ - Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины “Зохиаст аялгууны  
толь”. 2017.  
О.С - О.Сүхбаатар  
Л.Х. - Л.Хүрэлбаатар  
Д.С. - Д.Сумъяа  
мо: - монголоор:  
са: - санскритаар:  
тө: - төвдөөр:  
хя: - хятадаар  
т. - тал. Хуудасны нүүрийн дугаар

ТАЙЛБАР.

- ( ) - толгой үгийн галиг  
- Ишлэл авсан ном  
- Ёгт үгийн утга  
( ) - Доктор Л.Хүрэлбаатар багш орчуулахдаа толгой  
тэгшилж нэмсэн үг



АШИГЛАСАН НОМ

1. Bira Sh. Mongolian commentaries on Dandin`s Kāvyaḍarsa. Problems of History, culture and Historiography of the MPR. (Selected works) Ub.1977 он.
2. Bira Sh. The Dandin`s Kāvyaḍarsa. In Tibet and Mongolia studies Mongolica, T.Y.F. 5. Ub. 1978 он.
3. KĀVYĀDARŚA by Srimadacharya DANDI Maharar`s and Commentary by JEEVANANDA VIDYASAGARA BHATTACHARYA WITH introduction and Notes in English by V.NARAYANA AYER. 316 нүүр. Printed at the `Vayilla` Press, Madras.1964 он.
4. KĀVYĀDARŚA. Edited by Anukul Chandra Banerjee, M.A .University of Calcutta. INDO-TIBETAN BUDDHIST LITERATURE SERIES -ээр хэвлэгдсэн SANSKRIT AND TIBETAN TEXTS. 286 нүүр. 1939 он.
5. Studia Mongolica. Ub.Tom. VI (14), fasc 1-18. 1980 он.
6. The Tibet journal. Vol. XV. №2, Dharmasala., 1990 он.
7. Агваандандар. Зохист аялгууны толийн гурван бүлгийн жишээ өгүүлэл оюун тодорхойн хоолойн чимэг үзэсгэлэнт сувд эрх. Агваандандарын сүмбүмийн “la” боть. Төвд модон барын хэвлэл. 34 х. A lag sha lha rams pa ngag dbang bstan tar. Snyan ngag me lon gi le`u gsum gyi dper brjod blo gsal mgul rgyan mu thig preng mtzes.
8. Алтангэрэл Ч. Монгол зохиолчдын Төвдөөр бичсэн бүтээл. I дэвтэр. Уб.107 х. 1967 он.
9. Алтангэрэл Ч. Дандины Зохист аялгууны толийн монгол тайлбарын тухай. ОУМЭ-ий II их хурлын эмхэтгэл. I боть. Уб. 1972 он.
10. Баясгалан Т. Баруун хойт тивийг эзлэн төрсөн Банчин Дайван хаан. Гонгорын хэлсэн үлгэр, туульс. (Монгол аман зохиолын чуулган. Т-XXXII) Уб. 2008 он.
11. Бира Ш. Түүвэр зохиолууд. Уб. 2007 он.
12. Бира Ш. Дандины Зохист аялгууны толийн тухай, 26 дугаар удаагийн Дорно дахиныг судлагчдын хуралдаан дээр монгол төлөөлөгчдийн бүлгэмийн хийсэн илтгэл, Уб, 1962 он.
13. Бодхайв Мипамлха. Зохист аялгууны их шастирын тольд орох тайлбар Дандины тааллын чимэг. snyan ngag gi bstan bcos chen po me long la `jug pa`i bshad sbyar dañdi`i dgongs rgyan zhes byaba bzhugs so. Dharmasala., Tibetan cultural printing press. 2000 он
14. Бүгд Найрамдах Монгол Ард улсын түүх. Гурван боть. (Дэд боть. 1604-1917). Уб.1968 он.
15. Бүрнээ Д, Энхтөр Д. Төвд Монгол илт өгүүлэх нэрийн толь. Уб. 2003 он.
16. Бүрнээ Д. Зая бандид Лувсанпэрэнлэйн нэгэн бүтээлийн тухайд, МУИС-ийн

- “Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг”, 19 боть, (193) 2003 он
17. Бүрэнбэх Б. Монгол шүлгийн гоо зүйн түүхчилсэн төлөв. Өвөр монголын Ардын хэвлэлийн хороо. 1991 он
  18. Ван Мандуга оршил бичиж харгуулан тайлбарласан “Монгол хятад хоёр хэл хавсаргасан Дандины Зохист аялгууны толь”, Өвөр монголын Ардын хэвлэлийн хороо, 2000 он.
  19. Ван Мандуга, Агваандандарын зохиол бүтээл ба жишээ шүлгийн тухай, Антон Мостаэрт монгол судлалын төвийн эрдэм шинжилгээний бичиг, Оюуны хэлхээ сэтгүүл, 2015 оны 1 дүгээр хугацаа
  20. Ван Мандуга, Зохист аялгууны толь ба монгол шүлгийн онол, Монгол хэл утга зохиол сэтгүүл, 1994 оны 4, 6 дугаар хугацаа
  21. Ван Мандуга, Лувсанцүлтэм ба түүний Зохист аялгууны тольд хийсэн тайлбар зохиолын тухай шинжлэл (хятад хэл), Ван Ли Зэнь найруулсан “Монгол үндэстэн жич Хөлөн буйр нутагт байгаа хэдэн үндэстний угсаа гарлын харьцааны судлал” өгүүллийн эмхтгэл, Дундад улсын нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо, 2014 он
  22. Ван Мандуга. Зая бандид Лувсанпэрэнлэй ба түүний тайлбар зохиол дахь зарим шүлгийн тухай, “Төвд судлал” сэтгүүл, Боть 03. 2014 он
  23. Ван Мандуга. Лувсанцүлтэм ба түүний Зохист аялгууны тольд хийсэн тайлбар зохиолын тухай шинжлэл(хятад хэлээр), Өвөр монголын Багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 2014 оны 5 дугаар хугацаа
  24. Ван Мандуга. Монгол уран зохиолын онол шүүмжлэлийн түүхэн найруулал, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1996 он
  25. Ван Мандуга. Монгол уран зохиолын онол шүүмжлэлийн хөгжлийн тойм, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 2008 он
  26. Ван Мандуга. Хөхнуурын сүмбэ хамба Ишбалжирын намтар бүтээл. Төвд судлал. Уб. 2015 он.
  27. Ван Мандуга. “Зохист аялгууны толь” жич Монгол тайлбаруудын тухай судалгааны тойм. “Төвд судлал” сэтгүүл. 2017 он.
  28. Гаадан Х. Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл (Төвд хэлээрх сурвалж бичгийг баримталсан судалгаа). Хэл бичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг горилж бичсэн нэг сэдэвт зохиол. Монгол улсын Төв номын сан. Гар бичмэлийн хөмрөг. 156 х., хавсралт 107 х. Уб. 1976 он.
  29. Гаадан Х. Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл. АБЯ-ны сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар. Уб. 1986 он.
  30. Гаадан Х. Мартуузай хэмээн өгүүлсэн элдэв зүйл. Уб. Өнгөт хэвлэл ХХК. 2000 он.
  31. Галбаатар Д. Уран зохиол. т.онол, түүх, шүүмжлэл - нэвтэрхий толь. Уб. 74 хх. 2012 он.
  32. Ганболд Д. Бат сүжигт бандид хамба Жамъянгарав, Уб. 2013 он
  33. Ганболд Д. Бат сүзэгт бандида хамба Жамъянгаравын тааллын шим “Дан-эй намжэд” хэмээх судрын тухайд. “Төвд судлал” сэтгүүл. 2015. Уб.

34. Гомбожав. Монголчуудын төвд хэлээр зохиосон зохиолын зүйл. ОУМХБЭ-ийн анхдугаар их хурлын эмхэтгэл. Том. I, fasc. 1-16. Уб., Шинжлэх Ухааны Академийн хэвлэх үйлдвэр. 1961 он.
35. Гэрэлт Б. Монгол зохиолын онол өгүүлэхүйн түүхэн шинжилгээ. Өвөр монголын Их сургуулийн хэвлэлийн хороо, 1998 он
36. Гэрэлт Б. Монгол зохиолын онолын чимэг. Өвөр монголын Соёлын хэвлэлийн хороо, 1985 он.
37. Гэрэлт Б. Нүднийг баясгахуй сувдын унжлага, Өвөр монголын Соёлын хэвлэлийн хороо. 1991 он
38. Дагвадорж Д. Монголын шашин суртахууны тайлбар толь. Уб. 1995 он.
39. Дагвадорж Л. Ухаарч амьдрах хорвоо. 1993 он.
40. Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм. I дэвтэр. Уб. 1957 он
41. Дамдинсүрэн Ц. Дандины “Зохист аялгууны толь” ба түүний тайлбаруудын тухай товч мэдээ (Монгол бичгээр). *Studia Mongolica*. Tom. IV, fasc. 1-7. Уб. 1962 он
42. Дамдинсүрэн, Ц. Монголын уран зохиолын харилцаа холбооны асуудалд. Уб. 1987 он.
43. Дандин. Зохист аялгууны толь. Сонгон эмхэтгэж, ариутган шүүж хэвлүүлсэн Д.Цэдэв. Уб. 2014 он
44. Дандины “Зохист аялгууны толь”-ийн гол нэр утгын тайлбар. (Хамтын бүтээл. Д.Сумъяа, Б.Няммягмар, П.Ням-Очир, Ж.Ерөөлт, Б.Лхагважав). Уб. 2017 он.
45. Дандины Зохист аялгууны толь. (Дурсгалт бичгийн чуулган. Боть XVIII, дэвтэр 1, хх 25,5). Оршил, тайлбар зүүлт хийж хэвлүүлсэн Х.Гаадан. Уб. ШУАХҮ. 1972 он.
46. Дандины Зохист аялгууны толь. (Дурсгалт бичгийн чуулган. Боть XX, дэвтэр 4, хх 24). Шинэчилсэн орчуулга тайлбар хийж эрхлэн хэвлүүлсэн Ш.Бира, Х.Гаадан, О.Сүхбаатар. ШУАХҮ. Уб. 1982 он.
47. Данзанчойжиням. Shar mdo khams gyi btzun pa bstan ‘dzin chos kyi nyi ma. Rgyan gyi bstan bcos me long pan chen bla ma’i gsung bzhin bkral pa dbyangs can ngag gi rol mtso legs bzhad nor bu’i byung khungs. Төвд модон барын хэвлэл. 353 хуудас.
48. Даш. Зохист аялгууны толийн өгүүлэгдэхүүн утга хийгээд амийн тухай шинжлэл. Дэд эрдэмтний зэрэг хамгаалсан өгүүлэл. Өвөр монголын Их сургуулийн Монгол судлалын дээд сургууль. 2008 он.
49. Дунгар Лувсанпэрэнлэй. Зохист аялгуунд орох ёс үг чимгийг ухаарах үүдийг нээгч. dung dkar blo bzang ‘phrin las. snyan ngag la ‘jug tshul tshig rgyan rig pa’i sgo ‘byed. Хөх нуурын үндэстний хэвлэлийн хороо. 1994 он.
50. Жамъянгарав С. Цаглахуй санааны найлзуур мод. Жишээ шүлгийг төвд хэлнээс орчуулж, эрдэм судлалын боловсруулалт хийсэн Л.Хүрэлбаатар. 174х. Уб. 2011 он.
51. Ишбалжир. Snyan ngag me lon las bzhad pa’i rgyan rnam gyi dper brjod rgyu

- dkaṅ preṅg mtzes. Ишбалжирын сүмбүмийн “ja” боть. Монгол модон барын хэвлэл. 46 хуудас.
52. Иштавхай Ш. Данзан-Одсэр Д. Энх тайвны цагаан лянхуа, Уб, 1966 он
  53. Лавайн эгшиг. Уб. 2014 он.
  54. М.С.Өлзий, Монголчуудын төвдөөр туурвисан уран зохиолын судлал. Үндэстний хэвлэлийн хороо. 1996 он
  55. Монгол “Данжуур”-ын 205-р ботид буй Монгол бичгийн эх
  56. Монгол ба Энэтхэг. Эмхэтгэсэн Ш.Бира. Уб. 1989 он.
  57. Монгол судлал . Боть IV. Уб, 1962 он
  58. Монгол хэл шинжлэлийн дурсгал, 1997 он.
  59. Монголын нэвтэрхий толь. I, II боть. Уб. 2000 он.
  60. Монголын уран зохиолын тойм. II дэвтэр. Редактор Ц.Дамдинсүрэн. Уб. 1977 он.
  61. Мөнгөнчимэг. Чимгийн онол Зохист аялгууны судлалд. Монгол хэл бичиг. 2001 он.
  62. Одончимэг. Агваандандарын зохион туурвих үзэл санаа - сайн номлолын нарны гэрлийн орчуулга шүүмж, тайлбар хийгээд судлал. Дэд эрдэмтний зэрэг хамгаалсан өгүүлэл. Өвөр монголын их сургуулийн Монгол судлалын дээд сургууль. 2007 он.
  63. Олон улсын монголч эрдэмтдийн II их хурлын эмхэтгэл. I боть. Уб. 1973 (1972) он.
  64. Олон улсын монголч эрдэмтдийн V их хурлын эмхэтгэл. III боть, Уб. 1992 он.
  65. Пүрэвжав Э. Их эрдэмтэн академич Цэндийн Дамдинсүрэн. Ред. Л.Хүрэлбаатар. Уб. 2008 он.
  66. Ринпүнба Жигдэнванчүгдагвадорж. mṅgon brjod kyī bstan bcos mkhas pa'i rna rgyan. Төвд бар.
  67. Сайн үгсийн сан. (Монголын уран зохиолын дээжис. I боть). Оршил, тайлбар лавламжийг хийж эрхлэн эмхэтгэсэн Л.Хүрэлбаатар. "Монгол уран зохиол" хэвлэлийн газар. Уб. 1995 он
  68. Сумъяа Д. Гэтэлгэгч Хорин нэгэн Дара эх. Уб. 2021 он.
  69. Сумъяа Д. Дара эхийн магтаалын нээх утга. Уб. 2002 он.
  70. Сүегэ “Зохист аялгууны толь”. Өвөр монголын Соёлын хэвлэлийн хороо. 1986 он
  71. Сүхбаатар О. Дандины зохист аялгууны толийн хос төгөлдөр чимэг. Хэл зохиол судлал. Том. XV, fasc 24. 1982 он.
  72. Сүхбаатар Ц. Монгол хэлний найруулгазүйн нэр томъёоны тайлбар толь. Уб. 2003 он
  73. Сүхбаатар Ц. Монгол хэлний найруулга зүй. Уб. 2009 он.
  74. Сэцан Лувсанбалдан. Эсэруагийн охиныг мөшөөлгөгч дуун эгшиг. Tsangṣ sras bzhad pa'i sgra dbyangs. Mtso sṅgon mi rigs dpe skrunḡ khang. 1996 он.
  75. Таван зүйлийн үсэг хадмал “Зохист аялгууны толь” (Ван Мандуга,

- Л.Хүрэлбаатар, Д.Сумъяа найруулав). Бээжин. Үндэстний хэвлэлийн хороо. 2012 он.
76. Төвд “Данжуур”. 205-р ботид буй Төвд эх.
  77. Төвд судлал. Боть 01, дэвтэр 1-19. Уб. 2012 он.
  78. Төвд судлал. Боть 02, дэвтэр 1-17. Уб. 2013 он.
  79. Төвд судлал. Боть 03, дэвтэр 1-23. Уб. 2014 он
  80. Төвд судлал. Боть 04, дэвтэр 1-20. Уб. 2015 он
  81. Төвд судлал. Боть 05, дэвтэр 1-16. Уб. 2016 он
  82. Төвд судлал. Боть 06, дэвтэр 1-17. Уб. 2017 он
  83. Төвд судлал. Боть 07, дэвтэр 1-16. Уб. 2018 он
  84. Төвд судлал. Боть 08, дэвтэр 1-14. Уб. 2019 он
  85. Төвд, Монгол “Данжуур”-ын Дандины Зохист аялгууны толь. Төвд эхтэй нь харгуулан монгол бичгээс хөрвүүлж тайлбар хийсэн Д.Сумъяа. Уб. 2017 он.
  86. Түвшинтөгс Б. Эрийн сайн Хан Харангуй тууль. 2016.
  87. Урсгал, С.Монгол шүлэг зүйн түүхэн тогтолцоо, Өвөр монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2000 он
  88. Ханчин хамба Жамъянгарав. Эсэруагийн дуун эгшиг. mkhan chen jam byangs dkar po. snyan ngag rtsa ‘grel gyi sbyi’i don nam par bzahag pa tshangs pa’i sgra byangs bzhes bya ba bzhugs so. Сайн ноён хан аймгийн Гандан-Гэмпэллин хийдийн бар.
  89. Хүрэлбаатар Л. Дандины Зохист аялгууны тольд Жамъянгаравын хийсэн бүтээлч шинэчлэл, Олон улсын монголч эрдэмтдийн V их хурал (3 дугаар боть) Уб. 1992 он.
  90. Хүрэлбаатар Л. Дуун, утгын яруу зохист. Уб. 2005 он.
  91. Хүрэлбаатар Л. Огторгуйн цагаан гарьд. Уб. 1996 он.
  92. Хүрэлбаатар Л. Судар шастирын билиг. Уб. 2002 он.
  93. Хүрэлбаатар Л. Эсэруагийн эгшиг дуун. Уб. 1999 он.
  94. Хүрэлбаатар, Л. Дорно дахины уран сайхны сэтгэлгээний сонгодог уламжлал ба монгол яруу найргийн онол. Хэл бичгийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл (Классическая традиция восточной художественной мысли и монгольская теория поэзии /Мелодичное пение Брахмы – памятник монгольской поэтики начала XX века/. Диссертация на соискание ученой степени доктора филологических наук) Монгол улсын Төв номын сан. Гар бичмэлийн хөмрөг. Уб., х.508. 1993 он.
  95. Хүрэлбаатар, Л. Огторгуйн цагаан гарди, (II дэвтэр) Уб, 2008 он
  96. Хэл зохиол судлал. 11 дүгээр боть, 1-24 дэвтэр. Уб. 1975 он.
  97. Хэл зохиол судлал. Боть XV. Уб., 1982 он.
  98. Хэл зохиол судлал. Уб. 1970 он.
  99. Цай Юнь. Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн үлгэр өгүүлэхүй одон мичдийн үзэсгэлэнт эрихэс ба илт өгүүлэхүй нэрийн товч хураангуй чандманийн унжлага хэмээгдэх оршвой хэмээх тайлбар зохиолын онцлогийн тухай мөчид өгүүлэх нь. “Төвд судлал” сэтгүүл. Боть 03. 2014 он

100. Цастын зуун ухааны үүдийг нээгч түлхүүр. gangs can rig brgya'i sgo 'byed lde mig ces by aba bzugs so. Tom. V. 1997 он.
101. Цогт Г. найруулсан “Алшаа лхаарамба Агваандандарын судалгааны чуулган” (3) Өвөр монголын хэвлэлийн бүлэглэл, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 2014 он
102. Цэдэндорж М. Бурхан буудайн хөх салхи. УБ. 1988 он.
103. Цэрэнсодном Д. Монголын бурханы шашны уран зохиол. Тэргүүн дэвтэр. УБ. 1997 он.
104. Цэрэнсодном Д. Монголын бурханы шашны уран зохиол. УБ. 2007 он.
105. Цэрэнсодном, Д. Монгол уран зохиол (XIII-XX зууны эх). УБ. 1987 он.
106. Чимид Ч.
107. Чоймаа, Ш., Тэрбиш, Л., Бүрнээ, Д., Чулуунбаатар, Д. 2000. Буддын шашин, соёлын тайлбар толь. I, II дэвтэр. УБ. 2015 он.
108. Чулуу. Цахар гэвш Лувсанцүлтэмийн утга зохиолын онолын үзэлтийг нарийвчлан шинжих нь. Цахар гэвш Лувсанцүлтэм судлалын эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл. Өвөр монголын Ардын хэвлэлийн хороо. 2009 он.
109. Чүлтэмжамц. “Хутагт сайн явдлын ерөөлийн хаан”-ы тайлбар ба түүний орчуулгын тайлбар судлал. Магистрын зэрэг горилсон зохиол. 2017 он.
110. Шү Лин. Зохист аялгууны гэмийн онолын ерөнхийлсөн судлал. Дэд эрдэмтний зэрэг хамгаалсан өгүүлэл. Өвөр монголын Их сургуулийн Монгол судлалын дээд сургууль. 2009 он.
111. Шү Линь. Агваандандарын утга зохиол тайлбарлах арга онолыг сүвэгчлэх нь. Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан. 2014 он. 6 дугаар хугацаа
112. Шү Линь. Агваантүвдэний бүжгийн есөн дүрийн онол үзэлтийг ажиглах нь. Дундад улсын монгол судлал. 2010 оны 4 дүгээр хугацаа
113. Шү Линь. Агваантүвдэний зохист аялгууны гэмийн онолыг шинжлэх нь. Морины шинж - монголын шашин соёлын өгүүллийн түүвэр, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 2009 он
114. Шү Линь. Зохист аялгууны гэмийн онол (нэг, хоёр). Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2010 оны 4 дүгээр хугацаа, 2011 оны 3 дугаар хугацаа
115. Шү Линь. Зохист аялгууны самадийн эрдэм (нэг, хоёр). Дундад улсын монгол судлал. 2008 оны 4 дүгээр хугацаа, 2009 оны 1 дүгээр хугацаа
116. Шү Линь. Саж бандид хийгээд Алшаа лхаарамбын туурвихуйн үзэл баримтлалын харьцуулал. Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухаан. 2013 он. 6 дугаар хугацаа
117. Эрдэнэбаяр А. Агваандандарын зохиол туурвих үзэлт. Өвөр монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 1999 оны 3 дугаар хугацаа
118. Эрдэнэбаяр А. Зая бандинд Лувсанпэрэнлэйн утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүйн чимгийн ялгалыг өгүүлэх нь. Өвөр монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 1999 оны 2 дугаар хугацаа

119. Эрдэнэбаяр А. Зохист аялгууны амь, бие, чимгийн онол. Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан, 2002 оны 4 дүгээр хугацаа
120. Эрдэнэбаяр А. Зохист аялгууны гэм. Монголын судлал сэтгүүл. 2004 оны 3 дугаар хугацаа
121. Эрдэнэбаяр А. Зохист аялгууны нийтийн чимгийн тухай. Өвөр монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2003 оны 6 дугаар хугацаа
122. Эрдэнэбаяр А. Сажа бандид Гунгаажалцаны Зохист аялгууны онол, үзэл баримтлал. “Төвд судлал сэтгүүл”. Боть 02. 2013 он
123. Явуухулан Б. Түүвэр зохиол. Уб. 559 х. 1985 он
124. 娜仁高娃 “ ‘诗镜论’ 对蒙古族诗论的影响”, “内蒙古师范大学学报”, 2003 年3 期。





॥काव्यादर्शः॥

KAVYADARSA

སྒྲུབ་ངག་མེ་ལོང་།།

诗 镜 论

SNYAN NGAG ME LONG

ДАНДИНЫ  
ЗОХИСТ АЯЛГУУНЫ  
ТОЛЬ

འཕྲིན་ལྗོངས་ཀྱི་ལོ་རྒྱུས་ལྟར་།།

ཚོག་རྒྱན་གྱི་བརྟན་བཅོས་སྟན་ངག་མེ་ལོང་མ།།

ཡ  
ཡ  
ཡ  
ཡ  
ཡ  
ཡ  
..

Уг чимгийн шастир Зохист аялгууны толь хэмээгдэх оршив<sup>1</sup>

ཨྲ། རྒྱ་གར་རྣམ་དུ། ཀུ་ལྷ་དུ། བོད་རྣམ་དུ། རྟན་ངག་མེ་ལོང་མ།།

ཨྲ  
ཨྲ  
ཨྲ  
ཨྲ  
..  
ཨྲ  
ཨྲ  
..

Энэтхэгийн хэлээр: Кавьядарша (kāvyādarśa),  
төвдийн хэлээр: нянаг мэлон (sñan íag me loń),  
монголын хэлээр: Зохист аялгууны толь<sup>2</sup> хэмээгдэх

ཨྲ། འཕགས་པ་འཇམ་དབལ་གཞོན་ལུང་རྒྱུ་བ་ལ་ཕྱག་འཚལ་ལོ།།

ཨྲ  
ཨྲ  
..

Залуу Манзушри<sup>3</sup> мөргөмүй.<sup>4</sup>

向圣者妙吉祥童子致敬！

<sup>1</sup> Энэ нэрийг орчуулагч өгсөн бололтой. ДЗАТ. 1982.т.11.  
<sup>2</sup> Хуучин монгол орчуулгад уг номын нэрийг уламжлал ёсоор санскрит, төвд, монгол гурван хэлээр бичсэн байна.  
<sup>3</sup> Манзушри-Билэг оюун ухааныг ивээгч бурхан.  
<sup>4</sup> Энэ нь залбирлын үг.

दीर्घ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
МӨРИЙН АЙМАГ**





चतुर्मुखमुखाम्भोजवनहंसवधूर्मम ।  
मनसेरमतांनित्यं<sup>1</sup>सर्वशुक्लासरस्वी ॥ १

གདོང་བཞི་གདོང་གི་པད་ཚལ་གྱི།  
ངང་བའི་སྤྱོལ་མོ་ཐམས་ཅད་དཀར།  
དབྱངས་ཅན་མ་ནི་ཁོ་བོ་ཡི།  
ཡིད་ལ་རིང་དུ་གནས་པར་མཛོད།།

愿四面神颜面的      莲池中的天鹅女，  
极纯洁的妙音天，      在我心中永栖息！

*May the lovely lady swan that sports among  
the lotus-mouths of Brahma, the all-white  
Sarasvati roam for ever in delight in the  
lotus-pool of my heart.*

Чатүрмүхагийн<sup>1</sup> нүүр дэх лянхуан цэцэрлэгт  
Галууны охин<sup>2</sup> мэт хамгаа цагаан өнгөт  
Сарасвати<sup>3</sup> чи нь миний  
Зүрхэнд насад суун соёрх<sup>4</sup>

ᠴᠢᠲᠤᠷᠮᠦᠬᠠᠭᠢᠨ ᠨᠢᠭᠦᠷ ᠳᠡᠬᠡ ᠯᠢᠶ᠋ᠬᠤᠨ ᠴᠡᠴᠡᠷᠯᠡᠭᠲᠡ  
ᠭᠠᠯᠠᠭᠤᠨ ᠣᠬᠢᠨ ᠮᠡᠲᠤ ᠬᠠᠮᠭᠠᠭ ᠴᠠᠭᠠᠨ ᠥᠨᠭᠡᠲᠤ  
ᠰᠠᠷᠠᠰᠠᠪᠠᠲᠢ ᠴᠢ ᠨᠢ ᠮᠢᠨᠢᠶᠢ  
ᠵᠦᠷᠬᠡᠨᠳᠡ ᠨᠠᠰᠠᠳᠤ ᠰᠤᠭᠤᠨ ᠰᠣᠡᠷᠬᠡ

<sup>1</sup> Чатүрмүха-Дөрвөн нүүрт. Ертөнцийн эзэн хэмээгдэх Брахма буюу Эсэрүн тэнгэрийн ёгт нэг нэр  
<sup>2</sup> Галууны охин-нь санскритаар Гандира, монголоор 1. Үнэр идэштэн, 2. Хөгжимчин, дуучин уран эгшигт тэнгэрийн нэр. Иймд яруу өгүүлэхүйн охин тэнгэр Янжинлхамын бүхнээс цагаан өнгө хийгээд машид яруу хоолойн эрдмийг магтжээ.  
<sup>3</sup> Сарасвати-Зохист аялгуу, хэлний шидийг соёрхдог эгшигт охин тэнгэрийн нэр, Янжинлхам.  
<sup>4</sup> Энэ нь Дандин багш Зохист аялгууны охин тэнгэр Сарасватид айлтгасан мөргөл шүлэг байна. Мөргөл нь бурхан болоод багшаа магтан мөргөж, хүндэтгэл айлтгасан шүлэг. Тухайн уран бүтээлч нь үйл хэргээ бүтээхэд хүч чадал хүссэн, зорилгоо хэрэгжүүлэхэд туслахыг гуйсан үг юм







इदमन्धंतमःकृत्स्नंजायेतभुवनत्रयम् ।  
यदिशब्दाह्वयंज्योतिरासंसारंनदीप्यते ॥ ४

གལ་ཏེ་སྣ་དོན་སྣང་བ་ནི།  
འཁོར་བའི་བར་དུ་མི་གསལ་ན།  
འཇིག་རྟེན་གསུམ་པོ་མཐའ་དག་འདི།  
སྣག་རུམ་ཐུན་བ་ཉིད་དུ་འགྱུར།།

如果称做词的光，            不去照亮轮回界，  
那么这全部三世间，        就将变得黑黢黢。

*These three worlds would be entierly dark and  
blind had not the light called “word” lit them up  
from the beginning.*

*Ээрэв аялгуугаар аялгуулан гийгүүлэгч үүнийг  
Орчлон дахинаа мандуулан эс үйлдвээс л  
Энэ гурван ертөнц<sup>1</sup> дахин бүгд  
Ямагт балай харанхуй болмуй<sup>2</sup>*

ᠠᠶᠢᠯᠭᠤᠭᠠᠷ ᠠᠶᠢᠯᠭᠤᠯᠠᠨ ᠭᠢᠶᠭᠦᠯᠡᠭᠴ ᠦᠦᠨᠢᠶ᠎ᠠᠭ  
ᠣᠷᠴᠢᠯᠠᠨ ᠳᠠᠬᠢᠨᠠᠭ ᠮᠠᠨᠳᠤᠭᠤᠯᠠᠨ ᠡᠰ ᠦᠶᠢᠯᠳᠦᠪᠡᠰ ᠯ  
ᠡᠨᠡ ᠭᠤᠷᠪᠠᠨ ᠡᠷᠲᠦᠨᠴᠢᠨᠠᠳᠢᠬᠢᠨ ᠪᠦᠭᠳᠦ  
ᠶᠠᠮᠠᠭᠲᠤ ᠪᠠᠯᠠᠢ ᠬᠠᠷᠠᠨᠬᠤᠢ ᠪᠣᠯᠮᠤᠢᠶᠡᠭ ᠡᠭᠦᠯᠡᠭᠡᠭ

<sup>1</sup> Гурван ертөнц-Тэнгэр, хүн, лусын гурван ертөнц  
<sup>2</sup> -Энэ бадагт шастрыг эс зохиосны гэмийг өгүүлжээ









तदल्पमपिनोपेक्ष्यंकाव्येदुष्टं कथंचन ।  
स्याद्वपुःसुन्दरमपिश्वित्रेणैकेन दुर्भगम् ॥ ७

д'эц'ир'нж'в'дг'дг'л'нж'в'  
 ку'д'в'р'г'у'р'г'у'д'э'в'и'г'л'н'с'  
 в'д'д'н'ж'в'с'л'и'в'у'л'у'с'л'д'д'с'г'у'д'г'  
 нж'в'г'э'и'г'и'с'л'и'д'в'д'г'л'г'у'с'г'г'

为此诗有小毛病， 决不可无动于衷，  
 即使身躯甚美丽， 疵疹一点毁艳容。

*Therefore, in a poem, no sort of blemish however trivial, should be allowed; even a lovely body may become loathesome because of a single defect (or leprous discoloration).*

*Миймийн тулд зохист аялгуунуудаа  
 Ямар нэгэн өчүүхэн гэм болвоос бээр  
 Эслэн огоорон<sup>1</sup> үл үйлдэх, бие гоо болбоос  
 Гагцхүү гэмээр муу хувьт больюу<sup>2</sup>*

<sup>1</sup> Эслэн огоорох-үл ойшоох, сул орхих

<sup>2</sup> -Энд зохиолд өчүүхэн төдий ч гэм гаргаж болохгүйг өгүүлжээ.

ᠠᠨᠳᠠᠨᠳᠢᠨᠢ ᠵᠣᠬᠢᠰᠢᠲᠤ ᠠᠶᠠᠯᠭᠤᠨᠤᠨᠤᠳᠠᠭ᠎ᠠ  
 ᠶ᠋ᠮᠠᠷ ᠨᠡᠭᠡᠨ ᠥᠴᠢᠭᠦᠬᠡᠨ ᠭᠡᠮ ᠪᠣᠯᠪᠣᠭᠣᠰ ᠪᠡᠭᠡᠷ  
 ᠡᠰᠯᠡᠨ ᠣᠭᠣᠣᠷᠣᠨ<sup>1</sup> ᠦᠯ ᠦᠶᠢᠯᠳᠡᠬᠦ, ᠪᠢᠡ ᠭᠣᠭᠣ ᠪᠣᠯᠪᠣᠭᠣᠰ  
 ᠭᠠᠭᠴᠢᠬᠦᠭᠦ ᠭᠡᠮᠡᠭᠡᠷ ᠮᠤᠤ ᠬᠤᠪᠦᠲᠦ ᠪᠣᠯᠢᠶᠣᠭᠦ<sup>2</sup>





















नगरार्णवशैलर्तुचन्द्रार्कादयवर्णनैः ।  
उद्यानसलिलक्रीडामधुपानरतोत्सवैः ॥ १६

शौच'सुख'सु'ख'के'रे'द'द'दु'खा  
शु'क्ल'अ'क'र'व'रि'व'सु'ख'व'स'द'द'  
सु'द'ह'क'स'कु'यि'र'स'सु'द'द'  
क'द'अ'सु'द'द'ग'अ'व'रि'द'ग'अ'सु'द'द'॥

还有城市和大海， 山岭、季节、日月的轮转，  
园林、水中的嬉戏， 饮酒和男女的合欢。

*Of cities, oceans, hills, the seasons, the moonrise,  
the sunrise, of sport in the garden and of sport  
in the waters, of drinking scenes, of festivals, of  
enjoyment (love),*

*Балгад, далай, уул хийгээд цаг  
Наран саран мандахын сайшаал ба  
Үүсгэмэл цэцэрлэг, усны цэнгэл наадан ба  
Дарсан уух, амраглахын баяр хурим ба*

ᠠᠨᠠᠷᠠᠨ ᠰᠠᠷᠠᠨ ᠮᠠᠨᠳᠠᠬᠢᠨ ᠰᠠᠶᠢᠰᠠᠭᠠᠯ ᠪᠠ  
ᠤᠦᠰᠦᠭᠡᠮᠡᠯ ᠴᠡᠴᠡᠷᠯᠡᠭ, ᠤᠰᠤᠨ ᠴᠡᠩᠭᠡᠯ ᠨᠠᠶᠠᠳᠠᠨ ᠪᠠ  
ᠳᠠᠷᠰᠠᠨ ᠤᠸᠤ, ᠠᠮᠢᠷᠠᠭᠯᠠᠬᠢᠨ ᠪᠠᠶ᠋ᠢᠷ ᠬᠤᠷᠢᠮ ᠪᠠ  
ᠰᠠᠨᠳᠠᠬᠢᠨ ᠰᠠᠶᠢᠰᠠᠭᠠᠯ ( ᠠᠨᠠᠷᠠᠨ ᠰᠠᠷᠠᠨ ᠮᠠᠨᠳᠠᠬᠢᠨ ᠰᠠᠶᠢᠰᠠᠭᠠᠯ )  
ᠤᠦᠰᠦᠭᠡᠮᠡᠯ ᠴᠡᠴᠡᠷᠯᠡᠭ ᠤᠰᠤᠨ ᠴᠡᠩᠭᠡᠯ ᠨᠠᠶᠠᠳᠠᠨ ᠪᠠ  
ᠳᠠᠷᠰᠠᠨ ᠤᠸᠤ, ᠠᠮᠢᠷᠠᠭᠯᠠᠬᠢᠨ ᠪᠠᠶ᠋ᠢᠷ ᠬᠤᠷᠢᠮ ᠪᠠ



























तत्कथारख्यायिकेत्येकाजातिःसंज्ञाद्वयाङ्किता ।  
अत्रैवान्तर्भविष्यन्तिशेषाश्चारख्यान्जातयः ॥ २८

དེ་ཕྱིར་གཏམ་དང་བཟོན་པ་ཞེས།  
མིང་གཉིས་དག་གིས་རིགས་གཅིག་མཚོན།  
ལྷག་མ་བཟོན་པའི་རིགས་རྣམས་ཀྱང་།  
འདི་ཉིད་ནང་དུ་འདུས་པར་འགྱུར།

因此故事和小说， 名称虽异类相同，  
其余有关散文的， 亦皆概括在其中。

Therefore, *katha* and *Akhyayika* form one class though stamped with two different names. Other forms of *Akhyayika* all fall within this class.

ᠮᠢᠶᠢᠮᠢᠶᠢᠨ ᠲᠤᠯᠤ ᠤᠭ ᠬᠢᠶᠭᠡᠳ ᠦᠭᠦᠯᠢᠯ ᠬᠡᠮᠡᠭᠦᠰᠢᠨ  
ᠬᠣᠡᠷ ᠨᠢᠷ ᠨᠦᠭᠦᠳᠡᠭᠡᠷ ᠨᠢᠭᠢᠨ ᠶᠠᠵᠦᠭᠤᠷᠢᠭ ᠦᠯᠢᠬᠦᠢ<sup>1</sup>  
ᠨᠦᠭᠦᠳᠡᠭᠦᠯᠢᠰᠢᠨ ᠵᠢᠶᠢᠯᠦᠳᠡᠭᠡᠷ  
ᠮᠦᠨᠬᠦᠭᠦ ᠶᠦᠨᠢᠶ ᠳᠣᠲᠣᠷ ᠪᠠᠭᠲᠠᠬ ᠪᠣᠯᠵᠣᠶᠤ

<sup>1</sup> Үлихүй-өгүүлэхүй, жишихүй, бэлгэдэхүй, илтгэхүй

ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ  
ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ  
ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ  
ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ

















शौरसेनीचगौडीचलाटीचान्याचतादृशी ।  
यातिप्राकृतमित्येवंव्यवहारेषुसंनिधिम् ॥ ३५

ਸ਼ੌ'ਰ'ਸੇ'ਨੀ'ਚ'ਗੌ'ਡੀ'ਚ'ਲਾ'ਟੀ'ਚ'ਾ'ਨ'ਯਾ'ਚ'ਤਾ'ਦ੍ਰ'ਸ਼ੀ' ।  
ਯਾ'ਤਿ'ਪ੍ਰਾ'ਕ੍ਰੁ'ਤ'ਮਿ'ਤ'ਯੇ'ਵੰ'ਵ'ਯ'ਵ'ਹਾ'ਰੇ'ਸ਼ੁ'ਸੰ'ਨਿ'ਧਿ'ਮ੍ ॥ ੩੫

梭罗塞尼语， 僑利语， 罗提语以及类似语，  
也都称之为俗语， 广泛用于诗， 剧里。

*Similar languages are Gouraseni, Goudi, Lati and the rest. In discussions, these are treated as Prakritam itself.*

Шаурасени<sup>1</sup>, Гауди<sup>2</sup> хийгээд  
Лати<sup>3</sup> бус бас тэр мэт хэл нь  
Мөнхүү пракрит хэмээгдэн  
Томъёоллууддаа чухал болъю.

<sup>1</sup> Шаурасени-гэж Муттрагийн ойролцоо оршдог нутаг

<sup>2</sup> Гауди-Бенгал нутгийн нэр

<sup>3</sup> Лати-Карнатана нутгийн нэг нэр

ਸ਼ੌ'ਰ'ਸੇ'ਨੀ'ਚ'ਗੌ'ਡੀ'ਚ'ਲਾ'ਟੀ'ਚ'ਾ'ਨ'ਯਾ'ਚ'ਤਾ'ਦ੍ਰ'ਸ਼ੀ' ।  
ਯਾ'ਤਿ'ਪ੍ਰਾ'ਕ੍ਰੁ'ਤ'ਮਿ'ਤ'ਯੇ'ਵੰ'ਵ'ਯ'ਵ'ਹਾ'ਰੇ'ਸ਼ੁ'ਸੰ'ਨਿ'ਧਿ'ਮ੍ ॥ ੩੫

















इतिवैदर्भमार्गस्यप्राणादशगुणाःस्मृताः ।  
एषांविपर्ययःप्रायोलक्ष्यतेगौडवर्त्मनि ॥ ४२

ཡོན་ཏུན་འདི་བཅུ་བེ་དལླའི།  
ལམ་གྱི་སློག་ཏུ་བཤད་པ་ཡིན།  
འདི་དག་པལ་ཆེར་བསྐྱོག་པས་ནི།  
གོ་ཁའི་ལམ་དག་མཚོན་པ་ཡིན།།

这十种诗的美德，           是南方派的命脉。  
与此大多相反的，         是东方派的文彩。

*These ten characteristics are considered to belong to the Vidarbha path. In the Gouda path, the opposite of thses characteristics is often found.*

Эдгээр арван эрдэм нь Вайдарбхагийн Мөрийн гол болгон өгүүлсэн мөн болой. Эдгээрээс нөгөө олонхийг Гауди-гийн мөр нүүгүүдээ өгөх мөн буюу.

ᠠᠮᠢᠨᠢ ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ  
ᠠᠮᠢᠨᠢ ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ  
ᠠᠮᠢᠨᠢ ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ  
ᠠᠮᠢᠨᠢ ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠢᠭᠤᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠤ













समंबन्धेष्वविषमंतेमृदुस्फुटमध्यमाः ।  
बन्धामृदुफुटोन्मिश्रवर्णविन्यासयोनयः ॥ ४७

खण्ठ'व'सुँर'व'ख'खण्ठ'द्वय  
दे'के'दख'कु'व'वर'ख'झे ।  
सुँर'व'दख'कु'व'वर'ख'यी  
यी'यो'सगे'द'व'दि'सुँ'ण'ख'ख'उ'ख॥

同一连缀无不同，            它分刚、柔和中音，  
刚、柔、中音的诗句，       就由它们来组成。

(Soft sequence as in) कोकिलालापवाचालोमामेतिमलयानिलः ।  
(Hard sequence as in) उच्चलचचीकराच्चाच्चनिर्झराम्भःकणोक्षितः । and  
(mixed sequence as in) चन्दनप्रणयोद्गन्धिर्मन्दोमलयमारुतः  
(want of evenness as in) स्पर्धतेरुद्धमद्ध्यैर्योवररामामुखानिलैः ।

Мэгш найруулагч нь тэгш бусаас ангижирсан  
Тэр хэмээвээс зөөлөн ширүүн дуль аму  
Зөөлөн, ширүүн, дуль найруулгын  
Үсгийг оршуулсан төрлийн орон бээр

खण्ठ'व'सुँर'व'ख'खण्ठ'द्वय  
दे'के'दख'कु'व'वर'ख'झे ।  
सुँर'व'दख'कु'व'वर'ख'यी  
यी'यो'सगे'द'व'दि'सुँ'ण'ख'ख'उ'ख॥



































कामंसर्वोऽप्यलंकारोरसमर्थेनिषञ्चतु ।  
तथाप्यग्राम्यतैवैतंभारंवहतिभूयसा ॥ ६२

дєс'вєр'к'у'к'к'а'с'г'у'к'а'л'а'п'д' |  
т'а'п'г'р'а'м'я'т'а'й'в'а'й'т'а'м'б'а'р'а'н'в'а'х'т'и'б'у'й'с'а' |  
д'є'к'к'у'к'а'п'д'ш'о'д'в'а'й'д' |  
к'а'м'с'а'р'в'о'а'п'я'л'а'н'к'а'р'о'р'а'с'м'а'р'т'х'е'н'и'п'а'н'ч'а'т'у' ||

诚然一切修饰上， 均已赋予了意味，  
然而只有不村俗， 方能大体负此任。

Granting that all arts of speech (*Alankara*), add delectableness to the idea (conveyed) it is the absence of vulgarity of expression alone that is mostly responsible for delectableness.

Магад хотол чимгүүдэд  
Утгын найруудыг өгөн үйлдэх  
Тийм болбоос балгад дахины үгс  
Бусын тулд<sup>1</sup> энэ үүргийг олонх бээр бариму<sup>2</sup>

.. ᠮᠠᠭᠠᠳ ᠬᠣᠲᠣᠯ ᠴᠢᠮᠭᠦᠦᠳᠦᠳ  
ᠤᠲᠦᠭᠦᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠳᠦᠭ ᠡᠭᠦᠨ ᠦᠶᠢᠯᠳᠡᠬᠡ  
ᠲᠢᠶᠢᠮ ᠪᠣᠯᠪᠣ᠎ᠠ ᠪᠠᠯᠭᠠᠳ ᠳᠠᠬᠢᠨᠠ ᠦᠭᠦᠰ  
ᠪᠤᠰᠤᠨ ᠲᠤᠯᠤᠳ<sup>1</sup> ᠡᠨᠡ ᠦᠦᠷᠭᠢᠶᠢᠭ ᠣᠯᠣᠨᠬᠡ ᠪᠡᠭᠡᠷ ᠪᠠᠷᠢᠮᠤ<sup>2</sup>

<sup>1</sup> Балгад дахины үгс бусын тулд-бүдүүлэг чанарт үгүй гэж ухах.  
<sup>2</sup> -Энд зохист аялгууг яруу сайхан зохиоход бүх төрлийн чимгийг хэрэглэсэн төдийгөөр бус, хамгийн чухал нь утгыг бүдүүлэг муухай бус аль болохоор зохистой сайхнаар илэрхийлэхийг эрхэмлэх ёстой гэж байна.































उत्कर्शवान्गुणःकश्चिद्यस्मिन्नुक्तेप्रतीयते ।  
तदुदारराह्वयंतेनसनाथाकाव्य(सर्व)पद्धतिः ॥७६

གང་དུ་འགའ་ཞིག་བཟོད་པ་ལ།  
ལྷན་འཕགས་ལྷན་པའི་ཡོན་ཏན་རྟོགས།  
དེ་ནི་རྒྱ་ཆེར་བཟོད་དེ་དེས།  
སྣན་ངག་ལམ་ཀུན་མགོན་དང་བཅས།

句中说了若干话，          高尚品德得领悟，  
这种诗风叫高尚，          两派以此为怙主。

*What is called Udara by which all sequence (of words) find their excellence when the sequence (of word) is uttered its excellent quality is clear.*

• *Алинаа зарим нэгэн өгүүлэлд  
Үлэмж хэтэрхий лүгээ төгссөн эрдмийг ухуулагч  
Тэр хэмээвээс агуу их өгүүлэл аму  
Тэрээр итгэл лүгээ сэлт зохист аялгууны мөр буюу*

ᠠᠯᠢᠨᠠᠭ ᠵᠠᠷᠢᠮ ᠨᠡᠭᠡᠨ ᠥᠭᠦᠯᠡᠯᠡᠳᠤ  
ᠦᠯᠡᠮᠵᠢ ᠬᠡᠲᠡᠷᠬᠢᠢ ᠯᠦᠭᠡᠭᠡ ᠲᠥᠭᠦᠰᠦᠨ ᠡᠷᠳᠮᠢᠶᠭ ᠤᠬᠤᠭᠤᠯᠠᠭᠴᠢ  
ᠲᠡᠷ ᠬᠡᠮᠡᠭᠡᠪᠡᠶᠡᠰ ᠠᠭᠤᠶᠤ ᠶᠡᠭᠦᠯᠡᠯᠡᠯ ᠠᠮᠤ  
ᠲᠡᠷᠡᠭᠡᠷ ᠶᠡᠳᠡᠭᠡᠰ ᠰᠡᠯᠲᠤ ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠠᠯᠭᠤᠨᠢ ᠮᠥᠷ ᠪᠤᠭᠤᠶᠤ









































अन्यधर्मस्ततोऽन्यत्रलोकसीमानुरोधिना ।  
सम्यगाधीयतेयत्रसमाधिःस्मृतोयथा ॥९३

གཞན་གྱི་ཚོས་དེ་གཞན་དག་ལ།  
འཇིག་རྟེན་ལུགས་ཀྱི་རྗེས་འབྲངས་ལས།  
གང་དུ་ཡང་དག་འཇིན་བྱེད་པ།  
ཉིང་དེ་འཇིན་དུ་བརྗོད་དེ་དཔེར།॥

把某事物的特征，           按照世间的常理，  
正确加于他物上，         这就称之为比拟。如：

Where the characteristic of one object is applicable to other objects without offen ding world usage, and is so applied thereto, that (embellishment) is Samadhi;

Бус ном<sup>1</sup> түүнээс бусдад  
Ертөнцийн ёсыг дагаж  
Алинаа үнэхээр баригч түүнийг  
Самади<sup>2</sup> хэмээн өгүүлмүй. Адилтгаваас:

<sup>1</sup> Ном-номыг энд шинж чанар буюу хэв намба гэх утгаар хэрэглэжээ

<sup>2</sup> Самади-амьтай юмын шинж чанарыг /номыг/ амь үгүй нөгөө юманд ердийн ёсыг дагаж шилжүүлэн найруулахыг самади гэнэ.

ཡེས་ཀྱི་ཚོས་དེ་གཞན་དག་ལ།  
.. འཇིག་རྟེན་ལུགས་ཀྱི་རྗེས་འབྲངས་ལས།  
གང་དུ་ཡང་དག་འཇིན་བྱེད་པ།  
.. ཉིང་དེ་འཇིན་དུ་བརྗོད་དེ་དཔེར།॥



कुमुदानिनिमीलानिकमलान्युन्मिषन्तिच ।  
इतिनेत्रक्रियाध्यासाल्लब्धातद्वाचिनीश्रुतिः ॥९४

гү'хү'д'к'э'г'и'а'а'х'а'а'д'д'а'  
в'д'д'а'а'а'а'а'а'а'а'а'а'а'а'  
и'и'и'и'и'и'и'и'и'и'и'и'и'и'  
д'д'д'д'д'д'д'д'д'д'д'д'д'д'

.. རྒྱལ་ལོ་ལྟོ་ལྟོ་ལྟོ་ལྟོ་  
.. རྒྱལ་ལོ་ལྟོ་ལྟོ་ལྟོ་ལྟོ་  
.. རྒྱལ་ལོ་ལྟོ་ལྟོ་ལྟོ་ལྟོ་  
.. རྒྱལ་ལོ་ལྟོ་ལྟོ་ལྟོ་ལྟོ་

“夜莲闭上了眼睛， 日莲便睁开了眼。”  
加上了眼的动作， 得到拟人化语言。”

As in “The water lilies (*Kumudas*) slumber” “the lotuses wake up.” In thses (sentence) by using verbs apt for the action (of the lotuses and lilies) the action (of the eyes) is conveyed to the hearer.

Түмда нь нүдээ аниад  
Лянхуа бээр нүдээ нээмү хэмээн  
Нүдний үйлдвэрийг оршуулснаар  
Түүний өгүүлэгч аялгуунууд хүртьюү<sup>1</sup>

<sup>1</sup> Амьтны нүдээ аних, нээх үйлийг амьгүй цэцгэнд шилжүүлэн хэрэглэсэн нь уран дүрслэл болж байна.





पद्मान्यर्काशुनिःष्ठ्यूताःपीत्वापावकविप्रुषः ।  
भूयोवमन्तीवमुखैरुद्गीर्णारुणरेणुभिः ॥ ९६

ᠪᠠᠨᠨᠢ ᠶᠡᠷᠦ ᠰᠢᠭᠤᠨᠢ ᠰᠤ ᠪᠢᠶᠢᠨᠠᠨᠢ ᠰᠤᠨᠢ  
ᠪᠡᠭᠡᠨᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ  
ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ  
ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ

“ 莲花饮了阳光中， 喷吐出来的火星，  
好像又从它嘴里 不断吐出花粉尘。 ”

*Lotus flowers having drunk of the sparks of fire  
spit by solar ray seem to vomit them again from  
their open mouths as red dust (pollen).*

*Жарны бөөлжсөн гэрлүүдийг  
Лянхуа цэцэг ууж, улаан тоосоор бөөлжин  
Амны ариутгагч сацралуудыг  
Маш бөөлжин үйлдэх мэт<sup>1</sup>.*

ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ  
ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ  
ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ  
ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ ᠪᠡᠮᠡᠨᠲᠡᠢ

<sup>1</sup> Энэ жишээ нь санскритаараа зохимжтой сайхны үлгэр жишээ байна.







उत्सङ्गशयनंसख्याःस्तननंगौरवङ्कमः ।  
इतीमेगर्भिणीधर्माबहवोप्य(न्य)त्रदर्शिताः ॥९९

Шөөгаш'хөв'и'хд'вар'гүл'в'дд'|  
ᠠᠯᠤᠰᠤᠨ'ᠳᠠᠨ'ᠰᠢ'ᠪ'ᠢᠳ'ᠳᠠᠨ'ᠳᠠᠯᠠ|  
ᠪᠡᠰᠠ'ᠪᠠᠳᠢ'ᠪᠢ'ᠰᠠᠨᠠ'ᠰᠤᠬᠤ'ᠰᠠᠳᠢ|  
ᠬᠡᠰᠠ'ᠰᠠᠨ'ᠰᠢ'ᠬᠤᠰᠠᠨ'ᠶᠠᠪᠢᠪᠠ'ᠠᠪᠠ'ᠪᠠᠨᠢᠪᠠ||

偎依在女友怀抱，            呻吟，沉重和疲劳，  
这些孕妇的特征，            同时在别处看到。

*S*leeping on the lap of a friend, moaning, weight and weariness all these many characteristic attributes of a pregnant woman are suggested here.

*Н*өхцөгч эмийн өврөө хэвтсэнээр  
Янцаглах ба мөнхүү хүндээр алжааму  
Хэмээсэн үүнээ жирэмсэн эхнэрийн  
Олон номуудыг бусдаа үзүүлсэн болой.

ᠠᠯᠤᠰᠤᠨ'ᠳᠠᠨ'ᠰᠢ'ᠪ'ᠢᠳ'ᠳᠠᠨ'ᠳᠠᠯᠠ |  
ᠪᠡᠰᠠ'ᠪᠠᠳᠢ'ᠪᠢ'ᠰᠠᠨᠠ'ᠰᠤᠬᠤ'ᠰᠠᠳᠢ |  
ᠬᠡᠰᠠ'ᠰᠠᠨ'ᠰᠢ'ᠬᠤᠰᠠᠨ'ᠶᠠᠪᠢᠪᠠ'ᠠᠪᠠ'ᠪᠠᠨᠢᠪᠠ ||







इतिमार्गद्वयंभिन्नंतत्स्वरूपनिरूपणात् ।  
तद्भेदास्तुनशक्यन्तेवक्तुंप्रतिकविस्थिताः ॥ १०१

དེ་ལྟར་རང་བཞིན་བརྟགས་པ་ལས།  
ལམ་ནི་འདི་གཉིས་རྣམ་པར་ལྟེ།  
དེ་དག་དགེ་བ་སྟན་ངག་མཁན།  
སོ་སོ་ལ་གནས་བརྗོད་མི་བྱས།

考察了它们的特性，                   划分了这两种风格。  
诗人们看法有差别，                   相异之处不能细说。

*Thus the schools are divided in the demonstration of the nature of truth. Their subdivisions as established by individual poets, it is not possible to state.*

*Мэр мэт өвөрчлөний шинжлэлээр  
Энэ хоёр мөрийг сайтар ялгаюу.  
Өөр өөр оршсон зохист аялгуучин  
Тэдгээрийн ялгалыг өгүүлэн үл чадмуй*

ᠮᠡᠷ ᠮᠡᠲᠦ ᠥᠪᠦᠷᠴᠯᠦᠨᠢ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠯᠡᠭᠡᠷ  
ᠡᠨᠡ ᠬᠣᠡᠷ ᠮᠥᠷᠢᠶᠭᠡ ᠰᠠᠶᠢᠲᠠᠷ ᠶ᠋ᠢᠯᠭᠠᠵᠤᠨ  
ᠥᠪᠦᠷ ᠥᠪᠦᠷ ᠣᠷᠰᠢᠨ ᠵᠣᠬᠢᠰᠢ ᠠᠶᠠᠯᠭᠤᠴᠢᠨ  
ᠲᠡᠳᠭᠡᠭᠡᠷᠢᠶᠢᠨ ᠶᠠᠯᠭᠠᠯᠢᠭ ᠥᠭᠦᠭᠦᠯᠡᠨ ᠦᠯ ᠴᠠᠳᠮᠤᠢ





नैसर्गिकीचप्रतिभाश्रुतंचबहुनिर्मलम् ।  
 अमन्दश्चाभियोगोऽस्याःकारणंकाव्यसंपदः ॥ १०३

ᠠᠨᠠᠰᠢᠷᠭᠢᠨᠢᠴᠢᠫᠤᠫᠤᠨᠢᠨᠢᠮᠤᠯᠤᠮᠤ ᠊  
 ᠠᠮᠤᠨᠳᠤᠰᠢᠬᠤᠠᠪᠢᠶᠢᠣᠭᠣᠰᠤᠶ᠋ᠠᠰᠤᠨᠠᠶᠢᠨᠢᠮᠤᠯᠤᠮᠤ ᠊  
 ᠠᠮᠤᠨᠳᠤᠰᠢᠬᠤᠠᠪᠢᠶᠢᠣᠭᠣᠰᠤᠶ᠋ᠠᠰᠤᠨᠠᠶᠢᠨᠢᠮᠤᠯᠤᠮᠤ ᠊  
 ᠠᠮᠤᠨᠳᠤᠰᠢᠬᠤᠠᠪᠢᠶᠢᠣᠭᠣᠰᠤᠶ᠋ᠠᠰᠤᠨᠠᠶᠢᠨᠢᠮᠤᠯᠤᠮᠤ ᠊

天生的才能智慧，            纯真无疵的听闻，  
 孜孜不倦的实践，            是出好诗的根本。

*Inborn intuitive intellectual power, listening to many pure compositions and assiduous application, all this is the cause of this wealth of poetry.*

ᠮᠥᠷᠥᠯᠬᠤ ᠪᠦᠳᠦᠰᠢᠨ ᠰᠠᠮᠪᠠᠭᠠ<sup>1</sup> хийгээд  
 Хир үгүй олон сонссон<sup>2</sup> ба  
 Мөхөс үгүй илтэд барилдах<sup>3</sup> нь  
 Зохист аялгууны хотол төгссөн шалтгаан<sup>4</sup> буюу

ᠠᠨᠠᠰᠢᠷᠭᠢᠨᠢᠴᠢᠫᠤᠫᠤᠨᠢᠨᠢᠮᠤᠯᠤᠮᠤ ᠊  
 ᠠᠮᠤᠨᠳᠤᠰᠢᠬᠤᠠᠪᠢᠶᠢᠣᠭᠣᠰᠤᠶ᠋ᠠᠰᠤᠨᠠᠶᠢᠨᠢᠮᠤᠯᠤᠮᠤ ᠊  
 ᠠᠮᠤᠨᠳᠤᠰᠢᠬᠤᠠᠪᠢᠶᠢᠣᠭᠣᠰᠤᠶ᠋ᠠᠰᠤᠨᠠᠶᠢᠨᠢᠮᠤᠯᠤᠮᠤ ᠊  
 ᠠᠮᠤᠨᠳᠤᠰᠢᠬᠤᠠᠪᠢᠶᠢᠣᠭᠣᠰᠤᠶ᠋ᠠᠰᠤᠨᠠᠶᠢᠨᠢᠮᠤᠯᠤᠮᠤ ᠊

<sup>1</sup> Төрөлх бүтсэн самбаа-гөрөлхийн ухаан  
<sup>2</sup> Хир үгүй олон сонссон-тээнгэлзээлгүй их мэдлэг  
<sup>3</sup> Мөхөс үгүй илт барилдах-мохошгүй хичээл зүтгэл  
<sup>4</sup> Зохист аялгууны хотол төгссөн шалтгаан-сайн бүтээл гарахын уг гарвал болно.





इति आचार्यदण्डिनः कृतौ काव्यादर्शे मार्गविभागो नाम प्रथमः  
परिच्छेदः ॥

ᠮᠠᠷᠭᠢᠪᠢᠭᠠᠳᠠᠷᠰᠠ ᠠᠶᠢᠯᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠢ

第一章《 辨別风格 》終

*Thus ends the First Section of Kavyadarsa.*

*ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠢᠯᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠢᠮᠤᠷᠢᠶᠭᠤ ᠰᠠᠶᠢᠲᠠᠷ  
ᠶᠠᠯᠭᠠᠰᠠᠨ ᠠᠨᠬᠠᠨ ᠪᠦᠯᠡᠭ<sup>1</sup> ᠪᠣᠯᠠᠶᠢ.*

<sup>1</sup> Нэгдүгээр бүлэг нь зохист аялгууны мөрийн аймаг(Т.lam gyi skor) юм. Энэ бүлэгт уран зохиолын ашиг тус, үүрэг зорилгыг тодорхойлж, төрөл зүйл, хэлбэр байгууламжийн ерөнхий зарчмыг гаргасан.

ᠠᠶᠢᠯᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠢ ᠵᠣᠬᠢᠰᠤ ᠠᠶᠢᠯᠭᠤᠨᠢ ᠲᠣᠯᠢ

## ГАРЧИГ

Дандины “Зохист аялгууны толь” номын өмнөх үг	3
Preface of the book “The Mirror of Poetry”	7
Предисловие книги “Лирическое Зеркало”	10
《檀丁〈诗镜论〉》前言	14
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠰᠤ ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ	17

### МОНГОЛЫН ТУУРГАТНЫ УРАН ЗОХИОЛЫН СУДАЛГААН ДАХЬ ДАНДИНЫ “ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛЬ”-ИЙН СУДАЛГААНЫ ТОЙМООС

Нэг. Монгол утга зохиолын судлал дахь “Зохист аялгууны толь”-ийн судалгаа	22
Монголын эртний уран зохиол дахь “Зохист аялгууны толь”-ийн судалгаа	22
Монголын орчин үеийн уран зохиолын судалгаан дахь “Зохист аялгууны толь”-ийн судалгаа	31
Дандины “Зохист аялгууны толь”-ийг тусгайлан судалсан эрдэмтэд	41
БНХАУ-ын Монгол үндэстний утга зохиол дахь зохист аялгууны судалгааны тойм	58
Хоёр. Дандины “Зохист аялгууны толь”-ийн бүтэц, товч агуулга	69
Мөрийг сайтар ялгасан бүлэг	70

Утгын чимэг	90
Дууны чимэг	219
Гурав. Дандины “Зохист аялгууны толь”-ийн бар хэвлэл, эхүүдийн судалгаа	275
Дандины “Зохист аялгууны толь”-ийн бар хэвлэл, эхүүдийн тухайд	275
“Зохист аялгууны толь”-ийн бар хэвлэлийн эхүүдийг зөрөө ялгааны байдлын тойм	287
Дандины “Зохист аялгууны толь”	291
Товчилсон үгс	296
Ашигласан ном	297
<b>ДАНДИНЫ ЗОХИСТ АЯЛГУУНЫ ТОЛЬ</b> (Санскрит, төвд, хятад, англи, монгол бичиг, шинэ үсгээр)	
Дандины Зохист аялгууны толь	305
Нэгдүгээр бүлэг. Мөрийн аймаг	307





“Жиком пресс” компанид хэвлэв.  
Утас: 7010-4224, 9908-4224

Захиалгын утас: 9194-0151

